МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ
The Asia Foundation

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА:

АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА:

АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ 2018 ОН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

The Asia Foundation

ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ТӨРИЙН ДЕПАРТМЕНТ

ХАМТРАН АЖИЛЛАСАН

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

Энэхүү сургалтын гарын авлагыг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департментын санхүүгийн дэмжлэгтэйгээр бүтээсэн. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департментын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Энэхүү сургалтын гарын авлагыг "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь" төслийн хүрээнд боловсруулсан. Сургалтын гарын авлагыг албан ёсоор хянан тохиолдуулаагүй бөгөөд ашигласан материал, гарын авлагын зориулалт зэрэг нь аливаа улс орны эрх зүйн орчин, газар нутагтай холбоотой аливаа үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

"Би Си Ай" ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл юм. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр иргэд гадаад улс руу чөлөөтэй зорчиж ажил эрхлэх, аялах боломж бүрдсэн. Нөгөөтээгүүр гадагшаа гарч ажил, хөдөлмөр эрхэлж орлого олох, амьдралаа дээшлүүлэх гэсэн иргэдийн хүсэл, хэрэгцээ, шаардлага нэмэгдэхийн хэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл ихэсдэг.

Монгол Улсын Засгийн газар хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд 2008 онд нэгдэн орж, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулан 2012 онд УИХ баталсан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын 148 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулан Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд чухал түлхэц болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам Азийн сантай хамтран "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь" төслийг хэрэгжүүлж байгаа билээ.

Төслийн хүрээнд боловсруулан гаргасан энэхүү сургалтын хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг илрүүлэх ажилд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдын чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нэгдсэн ойлголтод хүргэх ач холбогдолтой юм.

Цаашид энэхүү сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүн худалдаалах гэмт хэргийн бүхий л хэлбэрийг илрүүлэх, мөрдөн шалгах, прокурорын хяналтыг сайжруулах, шүүхээр шийдвэрлэх ажил илүү эрчимжинэ гэдэгт итгэлтэй байна.

Б.ЭНХБАЯР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ДЭД САЙД

ТАЛАРХАЛ

Энэхүү сургалтын гарын авлагыг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог шүүгч, прокурор болон хууль сахиулагч, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавхыг сайжруулах зорилгоор **"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь"** төслийн хүрээнд боловсруулсан.

Боловсруулсан:

Гийта Секон, Доктор (Ph.D), профессор, олон улсын зөвлөх

Ерөнхий редактор:

Д.Зүмбэрэллхам, Доктор (Ph.D), профессор, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ахлах зөвлөх

Зөвлөх:

Б.Бат-Орших, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга;

Б.Бат-Эрдэнэ, Доктор (Ph.D), профессор, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч асан;

М.Гантулга, Доктор (Ph.D), Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн захирал

С.Гантулга, Доктор (Ph.D), дэд профессор, Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор

Г.Оюунболд, Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн судлаач, хяналтын прокурор

Ё.Хадхүү, Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн Хилийн албаны тэнхимийн эрхлэгч;

Б.Энхболд, Доктор (Ph.D), Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч;

Б.Энхжин, Азийн сангийн үндэсний зөвлөх

Орчуулсан:

Ё.Лхамаа, Орчуулагч

Зураач:

Э.Жавхлантөгс

Техник редактор:

Г.Гантулга, Азийн сангийн төслийн менежер

С.Мөнхчулуун, Азийн сангийн төслийн зохицуулагч

Энэхүү сургалтын гарын авлагыг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжиж ажилласан Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль болон бусад холбогдох байгууллагуудад гүн талархал илэрхийлье!

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ v

ТАЛАРХАЛ vi

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА x

НЭГ: ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ, ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ (МОДУЛЬ 1-6) 1

МОДУЛЬ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ 2

Модулийн зорилго 3
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, онцлог 4
Сэдэв 2: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 12
Сэдэв 3: Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийн онцлог шинж 13
Сэдэв 4: Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэрэг болох нь 14
Сэдэв 5: Жендер ба хүн худалдаалах гэмт хэрэг 15

МОДУЛЬ 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 19

Модулийн зорилго 20
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт 21
Сэдэв 2: Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх үндэсний хууль тогтоомж 27

МОДУЛЬ 3: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ 45

Модулийн зорилго 46
Сэдэв 1: Хохирогчийг олж тогтоох анхан шатны ажиллагаа, анхаарах асуудал 47
Сэдэв 2: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж олох 52
Сэдэв 3: Нууц мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын үр дүнг үнэлэх, ашиглах 60
Сэдэв 4: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтооход учирч болзошгүй эрсдэл, түүнийг үнэлэх нь 62

МОДУЛЬ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧ 69

Модулийн зорилго 70
Сэдэв 1: Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалын тухай ойлголт, онцлог 72
Сэдэв 2: Хохирогчид үүссэн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, түүний ач холбогдол 74
Сэдэв 3: Хохирогчоос мэдүүлэг авах нь 82
Сэдэв 4: Гэрч, хохирогч хүүхэдтэй ярилцах, мэдүүлэг авах 90
Сэдэв 5: Гэрч, хохирогчоос мэдүүлэг авах нь 94

МОДУЛЬ 5: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ 97

Модулийн зорилго 98

Сэдэв 1: Хохирогчийг чөлөөлөх, эх оронд нь эргүүлэн авчрах ажиллагаанд хохирогчийн аюулгүй байдлыг хангах 100
Сэдэв 2: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн онцлог хэрэгцээ, шаардлагатай тусламж, үйлчилгээ 107
Сэдэв 3: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 110
Сэдэв 4: Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ 112
Сэдэв 5: Хууль зүйн туслалцаа 113
Сэдэв 6: Хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах нь 114

МОДУЛЬ 6: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА 115

Модулийн зорилго 116
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагааны төрөл, хэлбэр, ач холбогдол 117
Сэдэв 2: Үндэсний болон олон улсын байгууллагын хамтын ажиллагаа 127
Сэдэв 3: ИНТЕРПОЛ болон бусад улсын цагдаагийн байгууллагатай харилцах, хамтран ажиллах 128
Сэдэв 4: Бусад байгууллагуудтай хамтран ажиллах нь 130
Сэдэв 5: Олон талт хамтын ажиллагааг нэгтгэн дүгнэх нь 133

ХОЁР: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР (МОДУЛЬ 7-11) .. 137

МОДУЛЬ 7: ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ 138

Модулийн зорилго 139
Сэдэв 1: Мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогчийг чөлөөлөх, сэжигтнийг баривчлах 140
Сэдэв 2: Хэргийн газарт үзлэг хийх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх нь 152
Сэдэв 3: Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтний онцлог шинж 159
Сэдэв 4: Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах зүйл 162

МОДУЛЬ 8: ПРОКУРОРУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ 165

Модулийн зорилго 166
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог 168
Сэдэв 2: Хүн худалдаалах гэмт хэргийг яллахад анхаарах асуудал 169
Сэдэв 3: Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчөөс ял завшуулах зорилгоор хэрэглэдэг арга, прокурорын хариу арга хэмжээ 172
Сэдэв 4: Хүн худалдаалах гэмт хэргийн яллагдагчийн мэдүүлгийг үнэлэх, шалгах 178
Сэдэв 5: Гэрч, хохирогчийг шүүн таслах ажиллагаанд бэлтгэх 180
Сэдэв 6: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ 185
Сэдэв 7: Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэх хор уршгийг арилгах 190

МОДУЛЬ 9: ШҮҮГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ.....195

Модулийн зорилго 196
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийн шүүх хуралдааны үеэр анхаарах зүйл 197
Сэдэв 2: Шүүгдэгчийн өмгөөлөгчийн түгээмэл хэрэглэдэг арга, тактик, улсын яллагчийн хариу няцаалт 202
Сэдэв 3: Шүүн таслах ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь..... 208
Сэдэв 4: Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах.....210

МОДУЛЬ 10: ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ, АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ.....217

Модулийн зорилго 218
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэхэд суралцах нь..... 219
Сэдэв 2: Сэжиг бүхий зорчигчтой ярилцлага хийх 223
Сэдэв 3: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хуурамч бичиг баримт олж илрүүлэх 227
Сэдэв 4: Зорчигч, ачаа тээш болон тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийх..... 229
Сэдэв 5: Хилийн хяналтыг бэхжүүлэх, хил хамгаалах ажиллагааны шилдэг туршлагуудаас суралцах нь..... 230

МОДУЛЬ 11: ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ.....233

Модулийн зорилго 234
Сэдэв 1: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч байж болзошгүй хүнийг олж тогтоох, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийг илрүүлэх 235
Сэдэв 2: Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх хэлбэрээр хүүхэд худалдаалах нь 239
Сэдэв 3: Сэжигтэй зорчигчтой ярилцлага хийх..... 244
Сэдэв 4: Гадаадын иргэний бүртгэл, виз олгоход анхаарах асуудал 249

Хавсралт 251

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Хүн худалдаалах гэмт хэрэг хүний эрхийг ноцтойгоор зөрчдөг бөгөөд өөрөө маш нарийн ээдрээтэй асуудал юм. Уялдаа холбоо, харилцан шүтэлцээтэй арга барилаар ажиллах хэрэгцээ шаардлагад үндэслэн, олон улсын байгууллагууд болон улс орны Засгийн газрууд, төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллахад хүний эрхийг дээдэлсэн арга барил маш чухалд тооцогддог бөгөөд энэ талаар гүнзгий ойлголт, мэдээлэлтэй байж, үүнийг төр болон иргэний нийгмийн байгууллага анхаарч ажиллах шаардлагатай.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль, Азийн сан хамтран ***"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь"*** төслийг 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаанд гар бие оролцдог байгууллагуудын албан хаагчдын чадавхыг сайжруулах, хохирогчид шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх, гэмт хэрэгт өртсөн хохирогчийг нөхөн сэргээх ажлыг бэхжүүлэх зорилготой ажиллаж байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд зохион байгуулалттайгаар хүн худалдаалах гэмт хэргийн гаралт нэмэгдэх болсон бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг албадан хөдөлмөрлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртүүлэх эх үүсвэрийн болоод хүлээн авагч орон болоод байна. Монгол Улсын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хууль тогтоомжоо чангатгах, холбогдох байгууллагуудын албан хаагчдын дунд энэ гэмт хэргийн ойлголт, чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хүчин чармайлт тавин ажиллаж байна.

БАЙГУУЛЛАГУУДЫГ СУРГАХ, ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

2000 оны НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 10 дугаар зүйлд зааснаар (мэдээлэл солилцох, сургалт):

> 2. Оролцогч улсууд хууль сахиулагч, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар суулгах үүднээс сургалт зохион байгуулна.

Энэ төрлийн сургалтад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогчийг гэмт этгээдээс хамгаалах арга зүйд сургахад чиглэх төдийгүй хүний эрхийг дээдэлсэн, жендерийн болон хүүхэдтэй холбоотой асуудалд уян хатан хандсан, төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн холбогдох байгууллагатай хамтран ажиллахад чиглэсэн арга барилыг чухалчлан заах хэрэгтэй.

Уг гэмт хэргийн тархалт болон шинэ арга хэлбэрээр үйлдэгдэж байгаагаас улбаалаад эрүүгийн хэрэг үүсгэхэд оролцдог албан хаагчид, тодруулбал хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг хууль сахиулагч, прокурор, шүүгч, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлсэн сургалтад хамруулах хэрэгтэй.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэдийн энэ гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн бодит үр дагаврыг ойлгуулах зэрэг ажлууд хамгийн чухалд тооцогддог. Сайтар сургагдаж, бэлтгэгдсэн хууль сахиулагч, прокурор, шүүгч, хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн албан

хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх салшгүй чухал хэсэг нь болдог тул тэдэнд сургалт зохион байгуулах зайлшгүй хэрэгцээ байсаар байдаг. Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт этгээдийг яллаад зогсохгүй хүний эрхийг дээдэлж, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийн хэрэгцээг хангаж ажиллахад чиглэх шаардлагатай.

Олон салбарынхныг хамруулсан сургалт зохион байгуулах нь үйл ажиллагааны түвшинд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, гэмт хэрэг гарсан үед үр дүнтэй, түргэн шуурхай багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Сургалтад хамрагдсанаар дараах зорилтод хүрнэ:

- Хүн худалдаалах гэмт хэргийн талаар өргөн мэдлэгтэй болох.
- Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг түргэн шуурхай олж тогтоох, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах зэрэг мэргэжлийн чадварыг сайжруулах.
- Хуулийг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдэлсэн, жендерийн асуудалд уян хатан хандсан, хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй арга барилаар ажиллах.
- Мэдээллээ солилцож, туршлагаа хуваалцах.

ГАРЫН АВЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Энэхүү сургалтын гарын авлага нь прокурор, шүүгч, цагдаагийн албан хаагч, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн албан хаагчдад зориулан сургалт явуулдаг сургалтын байгууллагад сургалтын хэрэглэгдэхүүн байдлаар ашиглахад зориулан боловсруулагдсан. Сургалтын хөтөлбөрийн загварыг Сургагч багш бэлтгэх чиглэлээр боловсруулсан бөгөөд сургалт явуулах багшид шаардлагатай заавар, зөвлөгөөг бүрэн багтаасан.

- Сургалтыг зөвхөн **цагдаагийн байгууллагад** зориулан явуулж байгаа тохиолдолд 1-6 дугаар болон 7 дугаар модулийг ашиглана.
- Сургалтыг зөвхөн **прокуроруудад** зориулан явуулж байгаа тохиолдолд 1-6 дугаар болон 8 дугаар модулийг ашиглана.
- Сургалтыг зөвхөн **шүүгчдэд** зориулан явуулж байгаа тохиолдолд 1-6 дугаар болон 9 дүгээр модулийг ашиглана.
- Сургалтыг зөвхөн **хил хамгаалах байгууллагад** зориулан явуулж байгаа бол 1-6 дугаар болон 10 дугаар модулийг ашиглана.
- Сургалтыг зөвхөн **гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад** зориулан явуулж байгаа тохиолдолд 1-6 дугаар болон 11 дүгээр модулийг ашиглана.

Модуль бүрд сургалт явуулахад шаардлагатай агуулга багтсан бөгөөд ашиглахад бэлэн байдлаар боловсруулагдсан. Сургалт явуулах гэж байгаа байгууллага сургалтын агуулгыг дотоодынхоо хууль эрх зүйд нийцүүлэн, сургагч багш нарынхаа хэрэгцээнд тохируулан ашиглаж болно. Ингэхдээ модулиудын ерөнхий бүтэц, сургалтын зорилт, сэдвийн агуулгыг алдагдуулалгүй хэвээр хадгалахыг зөвлөж байна.

Сургалтаа явуулж байхдаа өгөгдсөн агуулгаар заахаас гадна өөрт байгаа сургалтын материалаа түшиглэн, баяжуулан ашиглах боломжтой. Сургагч багшид зориулж модуль тус бүрд сургалтын агуулга өгөгдсөнөөс гадна сургалт явуулах ерөнхий цагийн хуваарийг тусгасан.

СУРГАЛТЫН МОДУЛИЙН БҮТЭЦ

Энэхүү сургалтын хөтөлбөр дараах 11 модулиас бүрдэнэ. Үүнд:

Модуль 1: Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт

Модуль 2: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал

Модуль 3: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох

Модуль 4: Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч

Модуль 5: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ

Модуль 6: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон талт хамтын ажиллагаа

Модуль 7: Цагдаагийн албан хаагчдад зориулсан сургалтын модуль

Модуль 8: Прокурорууд зориулсан сургалтын модуль

Модуль 9: Шүүгчдэд зориулсан сургалтын модуль

Модуль 10: Хил хамгаалах байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын модуль

Модуль 11: Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын модуль

ДАСГАЛ АЖИЛ

Модуль бүрд интерактив сургалтын арга, багаар ажиллах, ярилцах дасгалууд багтсан. Сургагч багшид дасгал ажлыг хэрхэн удирдаж явуулах талаар зөвлөмжийг модуль бүрд оруулсан бөгөөд үүнд дасгал ажиллуулах арга хэлбэр, сэдэв, сургалтын материал, сургалтын зорилт, дасгал ажиллах хугацаа, суралцагч өөрийгөө үнэлэх асуулт, тухайн дасгалыг хэрхэн явуулах талаарх заавар, зөвлөгөө зэргийг багтаасан. Багаар ярилцах, хоорондоо хэлэлцэх, багаараа тохиолдол дээр ажиллах, дүрд тоглох зэрэг олон төрлийн аргуудыг багтааж оруулсан.

СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний хуудсыг хавсралтаар оруулсан. Ижил төрлийн асуултуудыг суралцагчдын олж авсан мэдлэг, чадвар болон сургалтын үр дүнг үнэлэх үед ашиглаж болно. Сургалт эхлэхээс өмнө суралцагчид сургалтын өмнөх үнэлгээний хуудсыг бөглөж, сургагч багшид хураалгана. Сургалтын сүүлийн өдөр яг адилхан асуултуудыг суралцагчдаар бөглүүлж авах бөгөөд сургалтын өмнө болон хойно ямар өөрчлөлт гарсан талаар сургалт явуулж буй байгууллага харьцуулалт хийнэ. Ингэхдээ суралцагчийн хэр сайн сурсныг үнэлэх бус хэр сайн оролцож байсан бэ гэдэгт тулгуурлаж үнэлгээгээ гаргах нь зүйтэй.

СУРГАЛТЫН АРГА

Энэхүү сургалтын гол зарчим нь олон талт оролцоонд суурилсан. Сургалтын үр дүнг нэмэгдүүлье гэвэл хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагч, хохирогчид дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллах мэдлэг, туршлагатай сургагч багш (төрийн бус байгууллага эсвэл төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төлөөлөл) зэрэг олон байгууллагын ажилтнууд сургалтыг заавал үр дүнтэй. Боломжтой бол сэтгэл зүйч, эмч, шүүх шинжилгээний мэргэжилтэн, эрдэмтэн судлаач, хөдөлмөрийн, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн албан хаагчдыг

оролцуулах нь сургалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлнэ.

Модуль бүрд сургалтын олон янзын арга хэрэглэгдэх бөгөөд үүнд презентац дээр суурилсан лекц, дасгал ажил, багаар ярилцах, туршлагаасаа хуваалцах зэрэг арга хэлбэр багтана. Сургагч багш удаан хугацаагаар лекц уншиж суралцагчдын анхаарлыг сааруулахаас аль болох зайлсхийхийг хичээх хэрэгтэй бөгөөд суралцагч бүр өөр өөрийн арга барилаар суралцдаг гэдгийг санах нь зүйтэй. Аль болох олон төрлийн сургалтын арга ашиглан сургалтаа сонирхолтой байдлаар явуулахыг зөвлөж байна.

СУРГАГЧ БАГШИЙН МЭДЛЭГ, ТУРШЛАГА

Сургалтыг амжилттай явуулахын тулд сургалт явуулж буй байгууллага сургагч багшид дараах шаардлагыг тавьж, сонголтоо хийх нь зүйтэй.

- Хичээл бүрд холбогдох үндсэн болон үйл ажиллагааны нарийн мэдлэгтэй байх.
- Хүн худалдаалах гэмт хэрэг, жендерт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг дээр ажиллаж байсан туршлагатай байх.
- Харилцааны чадвар сайтай, бусдыг сайн сонсдог байх.
- Насанд хүрэгчдэд сургалт явуулж байсан туршлагатай.
- Харьцааны соёл дутмаг, буруу ойлголттой, өрөвдөх энэрэх сэтгэл багатай зэрэг өөр өөр үзэл бодол, хандлагатай хүмүүстэй харилцах чадвартай байх.

Сургагч багш суралцагчдыг жигд хамруулж, асуулт асуух, тодруулах, санал нийлэхгүй байгаа зүйлээ гаргаж хэлэх, тухайн асуудлаар багаараа ярилцах, шийдэл олоход чиглэсэн сургалтыг явуулахаар чармайн ажиллах нь чухал.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалт явуулах байгууллага сургалтын нарийн хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Модуль бүрд санал болгосон сургалтын хугацааг тодорхой тусгаж оруулсан. Сургалтыг төлөвлөсөн хугацаанд нь багтаан, үр дүнтэй явуулахын тулд маш нарийн сургалтын хөтөлбөр гаргах нь чухал.

ХОЁР ӨДРИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургалт явуулах цаг 09:00-17:30 хүртэл буюу нийт 8 цаг 30 минут байна.

Сургалт явуулах байгууллагад зөвлөх нь: Сургалт явуулах хугацааг өөрсдийн үйл ажиллагааныхаа боломжид тулгуурлан гаргана уу. Нэг өдрийн сургалт хэр урттай байх нь тухайн улсын Хөдөлмөрийн хууль, бусад журмаар зохицуулагдана. Сургалтаа албан ёсоор эхлэхээс өмнө сургалтад хамрагдах хүмүүсээ бүртгэж, сургалтын материалыг тарааж өгсөн байх шаардлагатай.

ЭХНИЙ ӨДӨР		
Хугацаа	**Сургалтын үйл ажиллагаа**	**Хариуцагч**
09:00 – 09:30	Нээлт	Сургалтын зохицуулагч
09:30 – 10:15	Сургагч багш, суралцагчдын танилцуулга Хоорондоо танилцах тоглоом Сургалтын туршид баримтлах дүрмийг хэлэлцэж тохирох 2 өдрийн сургалтын товч танилцуулга	Сургалтын зохицуулагч
10:15 – 10:25	Сургалтын өмнөх мэдлэг шалгах тест	Сургалтын зохицуулагч
10:30 - 10:45	**Цайны завсарлага**	
10:45 – 12:15	**Модуль 1** – ХХГХ-ийн талаарх ойлголт (Хугацаа – 1 цаг 30 минут)	Модуль 1-ийн сургагч багш
12:15 – 13:00	**Модуль 2** – ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал (Хугацаа - 2 цаг)	Модуль 2-ын сургагч багш
13:00 – 14:00	**Өдрийн хоол**	
14:00 – 14:15	Баримтат кино үзэх	Сургалтын зохицуулагч
14:15 – 15:30	**Модуль 2** – ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал (Үргэлжлэл)	Модуль 2-ын сургагч багш
15:30 – 15:45	**Цайны завсарлага**	
15:45 – 17:15	**Модуль 3** –ХХГХ-ийн хохирогчийг олж тогтоох (Хугацаа – 1 цаг 30 минут)	Модуль 3-ын сургагч багш
17:15 – 17:30	Эхний өдрийн хичээлийг дүгнэж, дараагийн өдрийн төлөвлөгөөтэй танилцах	Сургалтын зохицуулагч
ХОЁР ДАХЬ ӨДӨР		
Хугацаа	**Сургалтын үйл ажиллагаа**	**Хариуцагч**
09:00 – 09:05	1 дэх өдрийн хичээлийг товч сануулж, 2 дахь өдрийн хичээлийн төлөвлөгөөг танилцуулах	Сургалтын зохицуулагч
09:05 – 10:30	**Модуль 4** – ХХГХ-ийн гэрч, хохирогч (Хугацаа – 1 цаг 30 минут)	Модуль 4-ийн сургагч багш
10:30 – 10:45	**Цайны завсарлага**	
10:45 – 11:45	**Модуль 5** – ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ (Хугацаа – 1 цаг)	Модуль 5-ын сургагч багш
11:45 – 12:45	**Модуль 6** – ХХГХ-тэй тэмцэх олон талт хамтын ажиллагаа (Хугацаа – 1 цаг)	Модуль 6-ийн сургагч багш
12:45 – 13:00	Бүх оролцогчид, сургагч багш нарын дунд Монгол Улсад ХХГХ-тэй тэмцэхэд тулгарч буй асуудлууд, боломжит шийдлүүдийн талаар чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх	Сургалтын зохицуулагч
13:00 – 14:00	**Өдрийн хоол**	
14:00 – 14:15	Баримтат кино үзэх	Сургалтын зохицуулагч
14:15 – 15:30	**Модуль 7 – 8 – 9 – 10 – 11** (Нийт хугацаа – 2 цаг 30 минут – нэг модульд зарцуулагдах хугацаа)	Тухайн модулийн сургагч багш
15:30 – 15:45	**Цайны завсарлага**	
15:45 – 17:00	**Модуль 7 – 8 – 9 – 10 – 11** (Үргэлжлэл)	Тухайн модулийн сургагч багш
17:00 – 17:30	Сургалтын дараах мэдлэг шалгах тест Хаалт Сургалтад оролцогчдод гэрчилгээ гардуулах	Сургалтын зохицуулагч

СУРГАЛТАД ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүн худалдаалах - "Хүн худалдаалах", "Хүний наймаа"/ "Хүүхэд худалдаалах" зэрэг нэр томьёог нэг утгаар ойлгоно.

Хохирогч - "Хохирогч" гэдэг нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхэд, эмэгтэй, эрэгтэй хүнийг хэлнэ. Гэвч "хохирогч" хэмээх нэр томьёо нь өөрөө ихээхэн маргаан дагуулдаг. Зарим нь хүч чадал, эрх мэдэлгүй хүнийг хохирогч гэж хэлдэг ба гэмт хэргийг эсэргүүцэх, даван туулах, амьд үлдсэн гэсэн утгаараа эерэг санаа илэрхийлдэг тул "даван туулсан хүн/ даван туулагч" гэсэн үгийг ашиглах нь илүү тохиромжтой гэж үзэх хүмүүс ч байдаг. Хүний эрх болон хамгааллын хүрээнд "хохирогч" хэмээх нэр томьёог тухайн хүн гэмт этгээдийн буруутай үйлдлээс болоод аливаа шударга бус зүйлтэй учирсан тохиолдолд хэрэглэдэг. Энэ нь эрх нь зөрчигдөж байгаа хүн хамгаалуулах, тусламж дэмжлэг авах, нөхөн төлбөр авах эрхтэйг харуулж байгаа нэг хэлбэр юм.

Хууль сахиулах, хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн энэхүү сургалтын агуулгын хүрээнд "хохирогч" гэх нэр томьёо хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийн эрхийг хамгаалах, шүүн таслах ажиллагааг шударга явуулах механизм бүрдүүлэх, гэмт этгээдийг яллах, хохирогчийг хамгаалж, нөхөн сэргээх зэрэг өргөн хүрээг хамарч байгааг харуулахад оршиж байгаа болно.

Биеэ үнэлэх – "Биеэ үнэлэх" хэмээх нэр томьёог ашиглахдаа Азийн сангийн зүгээс энэ төрлийн үйл ажиллагаанд хамаарал бүхий хүмүүсийн талаар үзэл бодол, байр суурь, эсвэл тэдний эсрэг аливаа сөрөг шүүмжийг илэрхийлээгүй болно.

Хүүхдийг садар самуун үзүүлбэрт ашиглах (порно кино) – Зарим ном товхимол, илтгэл, тайлан, байгууллага "хүүхдийг хүчирхийлсэн материал" эсвэл "хүүхдийг хүчирхийлсэн дүрслэл" зэрэг нэр томьёо хэрэглэхийг санал болгодог ч энэхүү сургалтын агуулгад хүүхдийг садар самуун үзүүлбэрт ашиглах гэсэн нэр томьёог олон улсын хууль тогтоомжид (тухайлбал, 1990 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенц болон 2000 онд баталсан Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах тухай конвенцийн нэмэлт протокол) нийцүүлэн ашиглалаа.

1

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ, ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ

(МОДУЛЬ 1-6)

МОДУЛЬ - 1

ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь шүүгч, прокурор, хууль сахиулах, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн ерөнхий ойлголт, гэмт хэрэг үйлдэх үе шатны талаар мэдлэг, чадвар олгоход оршино.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, онцлог;
Сэдэв 2 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч;
Сэдэв 3 Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийн онцлог шинж;
Сэдэв 4 Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэрэг болох нь;
Сэдэв 5 Жендер ба хүн худалдаалах гэмт хэрэг.

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хүн худалдаалах гэмт хэрэг нь эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчиж буй нийгэмд аюултай, гэм буруутай гэмт үйлдэл юм.
- Бүс нутгийн болоод олон улсын гэрээ, хэлэлцээр нь тухайн улс энэхүү гэмт хэрэгтэй тэмцэнэ гэсэн үүрэг, амлалтыг олон улсын өмнө хүлээсний илрэл юм.
- Хүн худалдаалах гэмт хэрэг нь мөлжлөгийн олон хэлбэрээр үйлдэгддэг.
- Хүн худалдаалах гэмт хэрэг нь нарийн зохион байгуулалттай, үйлдлийн олон арга, хэлбэрээр үйлдэгддэг.
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйл "Түлхэлт болон таталт" гэсэн хүчин зүйлээр тайлбарлагддаг.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг зөв тодорхойлох нь жинхэнэ хохирогчийг олж тогтооход нэмэр болдог.
- Гэмт хэрэг үйлдсэн хүн гэж хэн бэ гэдгийг бодитойгоор үнэлж, сайтар ухаж ажиллах нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг тогтоож, ял оногдуулахад тус болно.
- Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай, гэмт бүлэглэлийн сүлжээнд, хэд хэдэн хүний оролцоотойгоор үйлдэгддэг гэмт хэрэг юм.
- Жендерийн асуудлыг оруулаад бүх хохирогчийн хүний эрх зөрчигддөг нь хүн худалдаалах гэмт хэрэгт томоохон нөлөө үзүүлсээр байна. Энэхүү асуудлуудыг зөвөөр харж, гүнзгий ойлголттой байх нь уг гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнгээ өгөх болно.

Сургалтын хугацаа - 90 минут

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын танхимыг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлэн судлах эх сурвалжийн жагсаалт, холбогдох хууль тогтоомжийг олшруулж бэлтгэх.
- Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, компьютер, прожектор, дэлгэц, самбар, цаас, үзэг бэлтгэх.

Модуль 1: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой үндсэн нэр томьёо, түүний агуулга	Лекц / Хэлэлцүүлэг	15	Сэдэв 1.1
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын чиг хандлага, үйлдлийн арга	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 1.2
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго үйлдэх үе шат	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 1.3
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн “Түлхэлт-Таталт”-ын хүчин зүйл	Лекц / Хэлэлцүүлэг	8	Сэдэв 1.4
	Дасгал ажил – Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн шалтгаан, нөхцөл	Дасгал ажиллах	7	Дасгал ажил
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэргийн “хохирогч”	Лекц/ Хэлэлцүүлэг	10	Сэдэв 2
Сэдэв 3	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 3
Сэдэв 4	Хүн худалдаалах гэмт хэрэг зохион байгуулалттай гэмт хэрэг болох нь	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 4
Сэдэв 5	Хүн худалдаалах гэмт хэрэг хүний эрхийг зөрчиж, жендертэй холбогдох нь	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 5

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

1. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮНДСЭН НЭР ТОМЬЁО, ТҮҮНИЙ АГУУЛГА

Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын тодорхойлолт:

I. “Хүн худалдаалах гэмт хэрэг” хэмээх нэр томьёог 2000 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол)-ийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд тодорхойлсон. Энэхүү протокол нь олон улсын гэрээ бөгөөд гэрээнд нэгдэн орж, гарын үсэг зурсан бүх улс орон дагаж мөрдөх үүрэгтэй. Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3 дугаар зүйлд:

(а) “Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.

(б) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь (а) хэсэгт заасан байдлаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

(в) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь (а) хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно.

(г) Хүүхэд гэж 18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ.

Үндсэн шинж	**Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол**
Үйлдэл (аль нь ч байж болно) – Ямар үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцох бэ?	Хүнийг элсүүлэх тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, нуун далдлах, хүлээн авах
Үйлдлийн арга (аль нь ч байж болно) – Хэрхэн үйлддэг вэ?	Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулах, эмзэг байдлыг нь далимдуулан ашиглах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах
Зорилго (аль нь ч байж болно) – Ямар зорилгоор үйлддэг вэ?	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах
Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно. Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.	

Монгол Улс 2008 оны 7 дугаар сард "НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол"-д нэгдэн орсон.

II. Албадан хөдөлмөрийн тухай конвенц (№ 29)-ийн 2 дугаар зүйлийн (1) хэсэгт албадан хөдөлмөрийг дараах байдлаар тодорхойлсон.

Ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж, аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээг хэлнэ. "Үйлчилгээ" гэж өмчлөлд хүргэдэггүй эдийн засгийн шинжтэй ямар нэг үйл ажиллагааг хэлнэ. "Торгууль, шийтгэл" гэж тухайн нөхцөл байдлаас үүдэн гарсан хохирол эсвэл үр дагаврыг хэлнэ.

Монгол Улс "Албадан хөдөлмөрийг устгах тухай конвенц"-ийг 2005 оны 3 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталсан.

III. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын конвенцийн (182)3 дугаар зүйлд **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг** дараах байдлаар тодорхойлжээ.

(а) Хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрөөр барьцаалан боолчлох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, тэр дундаа зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг албадан оролцуулах зэрэг боолчлолын бүхий л хэлбэр, түүнтэй ижил төстэй үйлдэл;

(б) Хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуун сурталчилгаа хийхэд болон садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;

(в) Олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;

(г) Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө учруулж болзошгүй шинж чанартай хөдөлмөр эрхлүүлэх;

Монгол Улс "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах конвенц"-ийг 2001 оны 2 дугаар сарын 26-ны өдөр соёрхон баталсан.

IV. 1948 онд соёрхон баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "Боолчлол буюу эрх мэдэлгүй байдалд хэн ч нэрвэгдэх ёсгүй бөгөөд боолчлол, боолын худалдааны бүх хэлбэрийг хориглоно" гэжээ.

1956 онд баталсан НҮБ-ын нэмэлт конвенцэд "Мөлжих зорилгоор өрийн дарамтад оруулах, боолчлох, хүчээр гэрлүүлэх, хүүхдийг нь ашиглах зорилгоор хүүхэд гаргуулах зэрэг нь боолчлолын нэг хэлбэр бөгөөд халж устгах зайлшгүй шаардлагатай төдийгүй гэмт хэрэгт тооцох ёстой" гэжээ.

V. **Хүүхдийг хүчээр гэрлүүлэх** гэдэг нь 18 нас хүрээгүй хүнийг албан, албан бус байдлаар бусадтай гэрлүүлэхийг хэлнэ. Энэ тухай олон улсад албан ёсоор тодорхойлоогүй ч аль нэг буюу хоёр талын зөвшөөрөлгүйгээр бие махбодын болоод сэтгэл санааны дарамтад оруулж гэрлүүлэхийг ойлгоно.

18 насанд хүрээгүй хүн хүчин төгөлдөр зөвшөөрөл өгөх чадамжгүй тул 1962 онд баталсан "Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц"-д тодорхойлсны дагуу хүчээр гэрлүүлсэнд тооцно.

Монгол Улс 1991 оны 6 дугаар сарын 6-ны өдөр "Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц"-д нэгдэн орсон[1].

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Тодорхойлолт, тайлбарыг мэргэжлийн нэр томьёо бага хэрэглэж, аль болох энгийн үг хэллэгээр тайлбарлах;
Суралцагчдаар "Хүн худалдаалах", "Албадан хөдөлмөрлүүлэх" зэрэг нэр томьёог өөрсдийнх нь ойлголт дээр үндэслэн тайлбарлуулах. Хүн худалдаалах гэмт хэргийн дэлгэрэнгүй ойлголт, мэдээллийг Модуль 2-т гүнзгийрүүлэн заах талаар хэлэх;
Зааж буй сэдэв зөвхөн охид, эмэгтэйчүүдэд хамааралтай, эсвэл хэн ч энэ төрлийн гэмт хэрэгт өртөх боломжтой эсэх талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх;
Олон улсын гэрээ, конвенцэд нэгдэн орж, соёрхон баталснаар Монгол Улс олон улсын өмнө үүрэг хүлээж байгаа талаар тайлбарлах.

Хүн худалдаалах гэмт хэрэг болон хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн ялгаа

А. Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт-өмнөх хуудаснаас үзнэ үү.

НҮБ-аас баталсан "Хүнийг хуурай газар, тэнгис, агаараар хил нэвтрүүлэхийн эсрэг протокол"-ын (Нууцаар хил нэвтрүүлэхийн эсрэг протокол) 3 дугаар зүйлийн (а) хэсэгт Хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлжээ.

1 "Нэгдэн орох" гэдэг нь бусад улс орнуудад хэлэлцэгдэж, баталгаажсан олон улсын аливаа гэрээг тухайн улс хүлээн зөвшөөрөх үйлдэл юм. Гарын үсэг зурсантай ижил түвшинд хүлээн зөвшөөрөгдөнө. Эх сурвалж: http://ask.un.org/faq/14594

"Хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэдэг нь иргэний харьяалал, оршин суух хүчин төгөлдөр эрхгүй хүнийг аливаа улсад шууд болон дам байдлаар ашиг олох зорилгоор хууль бусаар хил нэвтрүүлэхийг хэлнэ."

Нууцаар хил нэвтрүүлэхийн эсрэг протокол нь дүрвэх, цагаачлахыг хууль бус гэж үзэх зорилго агуулаагүй. Энэ протоколын 5 дугаар зүйлд хүн хууль бусаар улсын хил нэвтэрснийхээ төлөө эрүүгийн болон хуулийн хариуцлага хүлээхгүй гэж заасан байдаг.

"Хууль бусаар улсын хил нэвтэрсэн хүн энэхүү протоколын 6 дугаар зүйлд зааснаар хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдлийн хохирогч болсны хувьд эрүүгийн хариуцлага хүлээхгүй."

Б. Хүн худалдаалах гэмт хэрэг болон хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн ялгаа[2]

Ялгаатай тал	Хүн худалдаалах гэмт хэрэг	Хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг
Хохирогчийн зөвшөөрөл	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хэзээ ч худалдаалагдахыг өөрөө хүссэн буюу зөвшөөрсөн байдаггүй. Хэрэв зөвшөөрсөн бол энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.	Хүнийг улсын хил нэвтрүүлэхэд хил нэвтрэх гэж байгаа этгээдийн зөвшөөрлийг ихэнх тохиолдолд авсан байдаг.
Үндэстэн дамнасан, улсын хил нэвтрүүлсэн байдал	Хүн худалдаалахад заавал улсын хил нэвтрүүлсэн байх шаардлагагүй. Хүнийг худалдаалахдаа улсын хилийг хууль бусаар нэвтрүүлсэн, хууль ёсны дагуу нэвтрүүлсэн эсэх нь хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.	Хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх нь хүнийг хууль бусаар аливаа улсад нэвтрүүлэх үйлдэл юм. Өөрөөр хэлбэл, хүнийг улсын хил нэвтрүүлэх үйлдэл улс үндэстэн дамнаж, улсын хил нэвтрүүлэн үйлдэгддэг.
Ашиг олох, мөлжих	Хүн худалдаалах нь гэмт хэрэг үйлдэгчдэд хууль бус аргаар ашиг орлого олж, хохирогчийг мөлжих боломж олгож байдаг. Хүн худалдаалагчийн зорилго нь мөлжиж буй хохирогчтой харилцах харилцаагаа тасралтгүй байлгаж, хил нэвтрүүлэхээс илүүтэйгээр мөлжихөд оршдог.	Хууль бусаар улсын хил нэвтэрсэн хүн, гэмт этгээд хоёрын харилцаа ихэнхдээ улсын хил нэвтрүүлснээр дуусгавар болдог. Хууль бусаар улсын хил нэвтрүүлэх төлбөр хил давахаас өмнө эсхүл хойно хийгддэг. Гэмт этгээд хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлсний дараа мөлжих зорилго агуулаагүй байдаг. Хууль бусаар улсын хил нэвтэрсэн хүн, гэмт этгээд хэн хэндээ ашигтай байхаар сайн дурааараа нэгдсэн хамтрагчид юм. Хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдэл хийхдээ гэмт этгээд улсын хил нэвтрүүлэхээр тохирсон хүнээ бусдад худалдаалах, тээвэрлэлтийн зардлыг нь төлүүлэх нэрийн дор өрийн дарамт учруулах, өрөө төл хэмээн хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эмзэг байдлыг далимдуулах арга хэрэглэх үед хүн худалдаалах гэмт хэрэг болох боломжтой.
Орлогын эх үүсвэр	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээд илүү их ашиг олохын тулд хохирогчийг байнгын хяналтдаа байлгадаг.	Хүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн этгээд хүмүүсийг өөр улс, оронд аваачсан төлбөрөөс ашиг олдог.

2 Модуль 1: Хүн худалдаалах болон цагаачдыг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх нэр томьёоны тодорхойлолт; Гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагад ажиллаж буй хүмүүст зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

2. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, ҮЙЛДЛИЙН АРГА, МӨЛЖЛӨГИЙН ХЭЛБЭР

НҮБ-аас баталсан 2016 оны Мансууруулах бодис, хүн худалдаалах гэмт хэргийн тайланд олон улсын чиг хандлагыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. *Дэлхийн аль ч улс хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхгүй гэсэн баталгаа байхгүй.* Дэлхийн улс орон бүр илгээгч, хүлээн авагч эсвэл дамжин өнгөрөгч орон болсон байна. Хохирогчдыг маш олон сувгаар дамжуулан улс дотроо, хил залгаа улсууд руу төдийгүй тив дамжуулан худалддаг. Хүн худалдаалах гэмт хэргийн ихэнх тохиолдол буурай улс орноос хөгжингүй улс орнууд руу чиглэж, мөн улсын хил давуулахгүйгээр улс орон дотроо хүнийг худалдаалах хандлага маш их болоод байна.

2. *Хохирогчдын тухай* – Сүүлийн 10 жилд хүн худалдаалах гэмт хэргийн мэдэгдэж, ил болсон хохирогчдын байдалд өөрчлөлт гарсан. Тэдний ихэнх нь хүүхэд, эмэгтэйчүүд байдаг байсан бол сүүлийн үед эрэгтэй хохирогчдын тоо өссөн үзүүлэлттэй байна. Мөн албадан хөдөлмөрлүүлсэн хохирогчдын тоо, улс дотор үйлдэгдэж байгаа хүн худалдаалах гэмт хэрэг мэдэгдэхүйц өссөн байна. Эндээс үзэхэд, хүн худалдаалах гэмт хэрэг хувьсан өөрчлөгдөж байгааг харуулж байна. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн, хохирогчид, мөлжлөгийн хэлбэрүүд болон хүн худалдаалах үе шатны талаар илүү ойлголт, мэдлэгтэй болсоор байна.

3. *Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн, хохирогчид төстэй зүйл олон бий.* Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн болон хохирогчид ихэвчлэн нэг газраас ирсэн, нэг хэлээр ярьдаг, нэг үндэстэн, ястан байдаг. Энэхүү байдал нь итгэл олж авах замаар гэмт хэрэг үйлдэх боломж болж өгдөг. Гэмт этгээд хохирогчийг элсүүлэхийн тулд гадаадын улс руу зорчдоггүй ба харин тэднийг мөлжихийн тулд гадаад улс руу авч явах нь бий. Ихэнхдээ гэмт этгээд хүн худалдаалах хэрэг үйлдсэн улсынхаа, эсвэл хохирогчтойгоо, үгүй бол хохирогчийг аваачиж худалдаалсан улсын иргэн нь байдаг. Хүйс адил байх нь мөн итгэл олж авах чухал хүчин зүйл болдог бөгөөд охид, эмэгтэйчүүдийг ихэвчлэн эмэгтэй хүн худалдаалдаг байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд, охид байдаг. Гэмт этгээдүүдийн дийлэнх нь эрэгтэй байдаг бол эмэгтэйчүүд эмэгтэй хохирогчийг элсүүлэхэд илүү үүрэгтэй оролцдог. Гэр бүлийн хэлхээ холбоо ч хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд хүргэх явдал бий.

4. *Мөлжлөгийн олон хэлбэрээр хүн худалдаалах хэрэг үйлдэгддэг.* Энэ төрлийн гэмт хэрэг бэлгийн мөлжлөг, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх байдлаар голчлон үйлдэгддэг ч өөр бусад олон хэлбэрээр үйлдэгдэх боломжтой. Хохирогчдыг гуйлга гуйлгах, хүчээр эсвэл хуурамчаар гэрлүүлэх, эд эрхтнийг нь авах, цэрэгт элсүүлэх зэрэг хэлбэрээр үйлдэгдэх боломжтой.

5. *Дайн болон зэвсэгт мөргөлдөөн нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх суурь нөхцөл болдог.* Дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс дайжсан иргэд энэ гэмт хэргийн хохирогч болох нь түгээмэл байдаг. Зэвсэгт бүлэглэлүүд хяналтаа тогтоосон бүс нутгийнхаа олон мянган хүүхдийг мөргөлдөөнд орох дайчид болгон ашигладаг. Охид, эмэгтэйчүүдийг хүчээр гэрлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулдаг бол хөвгүүд, эрчүүдийг уул уурхайд ажиллуулах, ачаа зөөлгөх, цэрэгт татах, боолчлох гэх мэтээр мөлждөг.

6. *Хүн худалдаалах гэмт хэргийн түгээмэл хохирогч нь хүүхдүүд* – 2014 оны байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн хохирогчийн дөрөвний нэг нь хүүхдүүд байв. Тухайн улсын хөгжлийн түвшин, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийн нас хоёр хоорондоо тодорхой хэмжээний хамааралтай байдаг. Ядуу буурай орнуудын хүүхдүүд хамгийн ихээр энэ гэмт хэрэгт өртсөөр байна.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Эрэмбэлсэн санаануудын (1-6) гол утга санаанд анхаарлаа хандуулна уу.
Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүйг Модуль 2-т заах талаар суралцагчдад хэлнэ үү.

3. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОРИЛГО, ҮЙЛДЭХ ҮЕ ШАТ

А. Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго

Хүн худалдаалах гэмт хэрэг буюу орчин үеийн боолчлол нь ихэвчлэн дараах зорилгоор үйлдэгддэг. Үүнд:

- Бэлгийн мөлжлөг (хүүхэд, эмэгтэйчүүд) – хүчээр биеийг нь үнэлүүлэх, секс аялал жуулчлал, порнографт ашиглах;
- Албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох, түүнтэй төстэй нөхцөлд байлгах (хүүхдийн хөдөлмөрийг оруулна);
- Бусад – эд, эрхтнийг авах, хүчээр гэрлүүлэх, гуйлга гуйлгах, хууль бусаар хүүхэд үрчилж авах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалуулах, тээвэрлүүлэх, гэмт хэрэг үйлдүүлэх, циркийн үзүүлбэр зэрэг зугаа цэнгэлд ашиглах.

Б. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх үе шат

Хүн худалдаалах гэмт хэргийн тайлан, мэдээнд энэ төрлийн гэмт хэрэг өргөн хүрээнд үйлдэгддэг болохыг онцолсон байдаг. Үүнд хот, хөдөөгөөс хохирогчийг элсүүлэх - ***Эх үүсвэрийн газар***; тухайлсан газартаа тээвэрлэж хүргэх - ***Дамжин өнгөрөх зам***; хохирогчийг аваачих - ***Эцсийн цэг*** гэсэн гурван үе шатыг туулдаг байна.

В. Эрхшээлдээ оруулах

Гэмт этгээд дараах байдлаар хохирогчийг эрхшээлдээ оруулдаг.[3] Үүнд:

- Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх;
- Хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлөх;
- Амлалт өгөх, айлган сүрдүүлэх, дарамтлах, хулгайлах;
- Өрийн дарамтад оруулах. Өрийн дарамтад оруулах гэдэг нь ихэвчлэн унаа тээврийн хөлс, хоол, байр, эрүүл мэндийн төлбөр, өдөрт хийж гүйцэтгэх ёстойгоо хийгээгүй учир төлөх торгууль гэх мэт цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нэмэгддэг ба хохирогч хэзээ ч барагдуулж дуусахааргүй байдаг.
- Гэр бүл, хамаатан саднаас нь хол байлгаж, бусадтай харилцахыг нь хориглож, хянаж цагдах;
- Иргэний үнэмлэх болон бусад баримт бичгийг нь хурааж авах;
- Хохирогч болон түүний гэр бүлийг нь дарамталж, заналхийлэх;
- Гэр бүл, олон нийтэд өөрийнх нь талаар илчилж, нэр төрийг нь гутаана гэж айлган сүрдүүлэх;
- Хууль сахиулах байгууллагад мэдэгдвэл шоронд орох эсхүл тухайн улсаас албадан гаргагдана гэж заналхийлэх;
- Хохирогчийн мөнгө, хувийн эд хөрөнгийг хяналтдаа байлгах;

3 Хүн худалдаалахтай холбоотой бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг мөрдөн байцаах стандарт, үйл ажиллагааны журам, НҮБ-ын Өмнөд Ази дахь Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, 2008.

- Хохирогчдын байрлах газрыг ойр ойрхон солих эсвэл нэгээс нөгөөд худалдаалдаг учир ямар газар байгаагаа мэдэхгүй, тусламж хүсэх боломжгүй болгох;
- Бие махбодын болон сэтгэл санааны дарамтад оруулах замаар өөрөөсөө хараат байдалтай болгох.

Дээрх аргыг ашиглаж, хохирогчдод айдас төрүүлэх нь чухал байдаг бөгөөд аль болох хоригдмол, нуугдмал байдалтай байлгаснаар тусламж авах боломжгүй болгодог.

САНАМЖ: Заавал зодуулж, хоригдож байж энэ гэмт хэргийн хохирогч болно гэсэн үг биш.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Албадан хөдөлмөрлүүлэх боломжтой салбаруудын (уул уурхай, барилга, зам, газар тариалан, хөдөө аж ахуй г.м) талаар суралцагчидтайгаа дэлгэрүүлж ярилцана уу. Эрхшээлдээ байлгах нь хохирогчийг мөлжих боломж олгоод зогсохгүй тухайн газраас зугтаж чадахгүйд хүргэдгийг тайлбарлана уу.

4. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН "ТҮЛХЭЛТ-ТАТАЛТ"-ЫН ХҮЧИН ЗҮЙЛ

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд дор дурдсан хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд:

Хувь хүний хүчин зүйл

Өөртөө итгэлгүй, бусдаас хараат, сул дорой хүмүүс энэ гэмт хэрэгт өртөх магадлал өндөртэй эмзэг бүлэгт тооцогддог бөгөөд бичиг үсгийн чадваргүй, мэдээлэл олж авах боломжгүй байдал нь мөн эрсдэлтэй бүлэгт оруулдаг. Санхүүгийн боломжгүй байх, үүнтэй холбоотой нөхцөл байдал нь уг гэмт хэрэгт өртөх том хүчин зүйл болдог. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь бага орлоготой хүмүүс байдаг. Ядуу байх тусмаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр болно гэсэн үг.

Гэр бүлийн таагүй орчин, гэр бүл салалт, байнгын хэрүүл маргаантай байх, бие махбодын, бэлгийн хүчирхийлэлд өртөх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэдэг орчинд байх, олуулаа амьдардаг, хүүхдийг эцэг, эхээс нь өөр хүн асардаг байх, гэр бүл дотор хүйсээр ялгаварлан гадуурхдаг байх, нөхөргүй байх зэрэг хүчин зүйл мөн адил нөлөөлдөг.

Нийгэм - эдийн засгийн хүчин зүйл

Амьжиргааны буюу эдийн засгийн боломжгүй байдал нь хүмүүсийг "амьд үлдэхийн төлөөх тэмцэл"-д татан оруулдаг. Үүнд үйлдвэржилт, даяаршил, эдийн засгийн уналт болон хямрал, буурай хөгжил, хувьчлал либералчлал зэрэг эдийн засгийн бодлогууд нөлөөлдөг.

Мөн зэвсэгт мөргөлдөөн, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, цагаачлалын бодлого, хүний эрх зөрчих зэрэг улс төрийн хүчин зүйлс ч нөлөөлнө. Муу засаглал, хууль сахиулах үйл ажиллагааны доголдол, хөдөлмөр, эрүүл ахуйн стандартыг хэрэгжүүлдэггүй зэрэг нь энэ гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг төдийгүй байгалийн гамшиг ч тодорхой хэмжээнд нөлөө үзүүлдэг.

Үндэсний цөөнх, харьяалалгүй иргэд, дүрвэгсдийг ялгаварлан гадуурхах явдал нь дээрх хүмүүсийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Улсын хил хууль бусаар нэвтэрсэн иргэд хүн худалдаалах хэргийн гаралт өсөхөд нөлөөлнө.

Амьдарч буй улсад нь ажлын байр хомсдолтойгоос болж хүүхэд, эмэгтэйчүүд "сайхан боломж" амлаж, гадаад улсад өндөр цалинтай ажиллах санал тавьж буй этгээдийн гарт амархан ордог.

Ядуурал, эмзэг байдал "Түлхэлт" болж, хэрэгцээ "Таталт" болох нь

Эрэлт, хэрэгцээ хүн худалдаалах гэмт хэргийн гол хүчин зүйл болдог. Ядуурал, гэр бүлийн анхаарал сул, хүчирхийлэл, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг нь "түлхэх" хүчин зүйл болж, хүмүүс хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байдалд ордог. Бусдын биеийг үнэлүүлэх, албадан хөдөлмөрлүүлэх, эд, эрхтнийг авах зах зээлийн эрэлт байсаар байгаа нь "татах" хүчин зүйл болж, хүн худалдаалагчдад ашиг олох таатай нөхцөл болж өгдөг. "Түлхэлт"-гүй бол "таталт" байхгүй. Хүн өөртөө болон гэр бүлдээ үндсэн хэрэгцээ болох хоол хүнс, орон байр зэргийг хангаж чадахгүйд хүрч "Түлхэх" хүчин зүйлд автвал, "Татах" хүчин зүйл тэр хүнийг мөлжих боломж бүрддэг. "Түлхэлт" хэдий чинээ их байна, "таталт" төдий чинээ хүчтэй байна.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хүн худалдаалах гэмт хэргийн хүчин зүйлийг суралцагчдад сайтар ойлгуулахын тулд доорх дасгалыг тайлбарлаж өгөх хэрэгтэй.

ДАСГАЛ – "АСУУДЛЫН МОД"

Хугацаа: 5 -7 мин

Шаардлагатай материал: Самбар, самбарын үзэг



Дасгал ажил – Үндэс, мөчир, жимстэй том мод зураад "Асуудлын мод" гэж нэрлэнэ. Суралцагчдын хэлсэн гэмт хэргийн хүчин зүйлийг модны үндэс тус бүр дээр бичиж, тэдгээр нь ямар үр дагаварт хүргэж болохыг хэлүүлнэ. Биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох, эд, эрхтнийг авах зэрэг хүн худалдаалах мөлжлөгийн хэлбэрийг модны мөчир тус бүр дээр бичүүлнэ. Хохирогчийн зөрчигдөж болох эрхүүдийг жимсэн дээр бичиж болно.

Хүн энэхүү гэмт хэрэгт олон хүчин зүйлийн улмаас өртөж, хүний эрхээ ноцтойгоор зөрчүүлдэг ба үүнд нөлөөлөх хүчин зүйлс нь хоорондоо холбоотой байдаг тухай "Асуудлын мод"-ыг ашиглан харуулах зорилготой.

Дасгалаас хүлээгдэж буй үр дүн – Хүн худалдаалах гэмт хэрэг нь өөрөө маш ээдрээтэй, ярвигтай зүйл бөгөөд олон талыг хамруулан нэгдсэн байдлаар тэмцэх нь чухал гэдгийг ойлгуулахад оршино.

СЭДЭВ 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ

"Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын шударга ёсыг тогтоох үндсэн зарчмын тухай тунхаглал"-д (1985) гэмт хэргийн хохирогчийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

"Хохирогч" гэж ганцаараа эсхүл олуулаа бие махбод, сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хохирол амсаж, тунхаглалд нэгдэн орсон улс орнуудын Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үндсэн эрх нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.

Энэхүү тунхаглал ёсоор буруутай этгээдийг тогтоосон, баривчилсан, гэм бурууг нь илчилсэн эсэх болон хохирогч, буруутай этгээд хоёр хоорондоо цусан төрлийн холбоотой эсэхээс үл хамааран тухайн хүнийг хохирогч гэж үзэж болно. Шаардлагатай гэж үзвэл хохирогчийг гэмт хэргийн золиос болгуулахгүйн тулд өмгөөлж хамгаалж байсан гэр бүлийн гишүүд, хохирогчоос хамааралтай байдаг хүмүүсийг "хохирогч" гэх нэр томьёонд оруулж болно.

Хохирогч болон гэрч хүүхдэд шударгаар хандах тухай удирдамжид хохирогч хүүхэд, гэрчийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.[4]

"Хохирогч болон гэрч хүүхэд" гэж тухайн гэмт хэргийн сэжигтэн, бүлэг этгээдүүдийг яллахад гүйцэтгэсэн үүргээс үл хамааран гэмт хэргийн хохирогч буюу гэрч болсон 18-аас доош насны хүнийг хэлнэ.

Монгол улсын хуулиудад хохирогчийг дараах байдлаар тодорхойлдог:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасны дагуу Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг **"хохирогч"** гэнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.2 дугаар зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг **"хохирогч"** гэж заасан.

4 2005 оны 7 дугаар сарын 22-ны өдөр баталсан НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 2005/20 дугаар тушаал

СЭДЭВ 3: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИЙН ОНЦЛОГ ШИНЖ

Хүн худалдаалах гэмт хэргийг ихэвчлэн зохион байгуулалттай гэмт бүлэг үйлддэг. Зохион байгуулалттай үйлдэгддэг, их хэмжээний ашиг эргэлдэж байдаг тул шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас илрүүлж, ял оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг тогтоох нь бусад төрлийн хэрэгтэй харьцуулахад хүндрэлтэй байдаг. Дэлхийн олон улсад хүнийг бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, эд, эрхтнийг авах зорилгоор үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэрэг нь ашиг орлого хамгийн өндөртэй хууль бус бизнест тооцогдсоор байна. Энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэг тул нэлээдгүй олон хүн оролцож, (а) Хохирогчоо олж авах газар, (б) Дамжин өнгөрүүлэх газар, (в) Хохирогчийг мөлжиж ашиг олох газар зэргээр хамрах хүрээ өргөнтэйгөөр үйлдэгддэг.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн гэдэг нь :

- Хүн худалдаалах үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцсон;
- Хохирогчийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах хүртэлх бүхий л үйл ажиллагаанд болон хохирогчийг мөлжиж ашиг олох үйл явцад оролцсон этгээдүүдийг хэлнэ.

Жишээ байдлаар доорх жагсаалтыг гаргалаа. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн нь доорх жагсаалтад дурдагдсан аль ч хүн байх боломжтой. Үүнд:

- Элсүүлэгч;
- Худалдаалагч;
- Худалдан авагч;
- Тээвэрлэгч;
- Орогнуулагч;
- Дамжуулагч;
- Хүлээн авагч;
- Бие үнэлэхийг зохион байгуулдаг газар, тэндээс ашиг хүртэгч, цэнгээний газар, гоо сайхны болон массажны газар зэрэг хохирогчийг ашиглан ашиг олдог газруудыг ажиллуулдаг этгээд;
- Төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг хүлээсэн хүний хувьд хүүхдээ санаатайгаар худалдсан, худалдахад хүргэсэн, шилжүүлэн өгсөн эцэг эх, асран хамгаалагч;
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх үе шатанд хохирогчийг нуун далдалж, хорьж байсан этгээдүүд;
- Ажил олгогч (гол ажил олгогч болон гэрээ байгуулагчид).

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дараах зүйлсийг суралцагчдад тайлбарлана уу.
Хохирогч болж болзошгүй хүн болон жинхэнэ хохирогч хэн бэ гэдгийг мэдэх нь тэднийг мөлжлөгөөс чөлөөлөхөд тус нэмэр болно.
Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийн талаар мэдээлэл цуглуулсан байх нь баривчлах үйл ажиллагаанд тустай.

СЭДЭВ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ НЬ ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГ БОЛОХ НЬ

Энэ төрлийн гэмт хэрэг нь ашиг, орлогоороо мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, зэвсгийн хууль бус худалдааны дараа дэлхийд гуравт ордог зохион байгуулалттай гэмт хэрэг болохыг олон улсын тайлан мэдээ, статистикт олонтоо дурдсан байдаг.

Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүд нь овсгоотой, зальжин, хэрцгий, балмад хүмүүс байдаг бөгөөд өндөр хөгжсөн харилцаа холбоо, мөнгө угаах арга ашиглан дэлхий даяар үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг бол зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд байнгын шинжтэй, давтамжтайгаар үйлдэгддэг. Мөрдөн байцаалтын ажиллагаа нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдэгдсэн, үргэлжилж байсан газар болох биеэ үнэлэх газар, зочид буудал, шөнийн цэнгээний газар зэрэг хохирогчийг мөлжлөгт ашиглаж буй тухайн газарт хийгддэг. Гэмт хэрэг үйлдэх хүрээ, хохирогч олж авах эх үүсвэрийн газар, дамжин өнгөрөх, тээвэрлэх маршрут, аваачихаар товлосон газар зэрэг нь хэмжээний хувьд тэлж байдаг ба хохирогчийг хүлээн авч буй хүмүүсийн гүйцэтгэх үүргийг тодорхой гаргасан байдаг. Үүнд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон хүн бүрд тохирох ялыг оногдуулах нь зүйтэй.

Зохион байгуулалтад орж, сүлжээ байдлаар олон улс дамнан үйл ажиллагаагаа явуулдаг шинжийг нь харгалзаж, улс орон дотроо төдийгүй өөр улс орнуудад мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах чадвартай мэргэжлийн мөрдөгчдийг энэ төрлийн хэрэг дээр ажиллуулах нь зүйтэй. Уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажилд хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудын идэвхтэй оролцоо чухал үүрэгтэй.

2000 оны 12 дугаар сард Италийн Палермо хотноо НҮБ-ын "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц"[5]-ийг баталснаар, олон улсад тулгараад байгаа энэхүү асуудалтай тэмцэх улс төрийн хүсэл зориг бүгдэд байгааг харуулсан юм. Аливаа гэмт хэрэг хил дамнан үйлдэгдэж байгаа бол хууль, тогтоомж, эрх зүйн актын үйлчлэл ч мөн хил дамнан үйлчлэх учиртай. Хууль, эрх зүйн акт улс дамнасан байдлаар зөрчигдөж байвал түүнийг сахиулахаар ажиллаж буй байгууллага, албан хаагч зөвхөн тухайн улсын хуулиар өөрсдийнхөө үйл ажиллагааг хязгаарлах боломжгүй юм.

Дээрх конвенцийн гол зорилго нь 1 дүгээр зүйлд зааснаар үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хамтын ажиллагаа чухал гэдгийг харуулахад оршиж байгаа юм.

2 дугаар зүйлийн (а) хэсэгт дараах байдлаар тодорхойлсон байдаг.

"Зохион байгуулалттай гэмт бүлэглэл гэж гурав буюу түүнээс дээш хүнээс бүрдэн зохион байгуулалтад орсон, тодорхой хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа, Конвенцэд зааснаар шууд буюу дам байдлаар эдийн засгийн болон материаллаг ашиг олох зорилгоор нэг буюу түүнээс олон тооны хүнд гэмт хэрэг үйлдэхээр чиглэсэн бүлгийг хэлнэ".

5 Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 55/25 дугаар Тогтоол

Монгол Улс 2008 оны 6 дугаар сарын 27-нд "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц"-д нэгдэн орсон.[6]

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчдад дараах зүйлсийг нэмж хэлнэ үү.
Бусад хэрэгтэй харьцуулахад хүн худалдаалах гэмт хэргийг хэд хэдэн хүн хамтран үйлддэг тул гэмт хэргийн зохион байгуулалттай шинж чанарын талаар мэдээлэлтэй байх нь мөрдөн шалгах ажиллагааны үед тус болно. Дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн модулиудад заана.

СЭДЭВ 5: ЖЕНДЕР БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

А. Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрхийн зөрчил

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний халдашгүй чөлөөтэй байх, бүх төрлийн боолчлолоос ангид байх гэсэн хүний жам ёсны эрхийг зөрчдөг. Хүүхэд худалдаалах нь хүүхдийг баталгаатай орчинд өсөж, бүх төрлийн хүчирхийлэл болон мөлжлөгөөс ангид байх эрхийг нь зөрчиж байгаа явдал юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд иргэний эдлэх эрх, эрх чөлөөг дараах байдлаар хуульчилсан байдаг. Үүнд:

1. Амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;
2. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
3. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;
4. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;
5. Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;
6. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;
7. Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

6 https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XVIII12&chapter=18&clang=_en

8. Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
9. Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;
10. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
11. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
12. Төрийн байгууллага, албан хаагчдад өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан хаагч нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;
13. Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;
14. Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;
15. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;
16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;
17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;
18. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг

хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд:

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна гэж заасан байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, эрх чөлөө уг гэмт хэргийн мөлжлөгийн бүхий л шатанд зөрчигдөж байдаг.

Б. Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендерийн асуудал[7]

Жендерийн үүднээс авч үзвэл:

"Хүйс" (биологийн ялгаа), "жендер" (нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүст тохирсон нийгмийн ялгаатай үүрэг, онцлог чанар, зан байдал) гэсэн хоёр нэр томьёог хооронд нь ялгах;

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх байр суурь харьцангуй, эмэгтэйчүүд биологийн төдийгүй нийгэмд эзлэх үүргийнхээ хувьд гадуурхагдах нь олон улс оронд түгээмэл байдаг талаар мэдлэгтэй байх;

Эмэгтэйчүүдийг үнэлэхгүй, гадуурхдаг байдал нь тэднийг өмчтэй байх боломжгүй болгож, материаллаг зүйл (газар, аливаа эх үүсвэрээс орлого олох), материаллаг бус зүйл (улс төрийн оролцоо, цаг) зэргийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй байлгадаг;

Биеэ үнэлэгч, садар самуун үйлчилгээ авах эрчүүдийн эрэлт, хэрэгцээ байсаар байгаа нь энэ талбарт эмэгтэйчүүдийг мөлжих үндэс суурь болж байгаа тул асуудлын эрэлт, хэрэгцээнд анхаарлаа хандуулан ажиллах;

Жендерийн тэгш бус байдал нийгмийн хүчин зүйлээс хамаардаг тул энэ байдлыг хувь хүн дор бүрнээ цаашлаад нийгэм даяараа шударга ёс, тэгш байдал, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцааны түвшинд чиглүүлж байж өөрчлөх боломжтой;

Жендерийн нарийн асуудлыг мэдэрч, хүний эрхийг дээдлэн ажиллах асуудал эмэгтэйчүүдэд хандан хийгддэг ч хөвгүүд, эрчүүд хүн худалдаалах гэмт хэрэгт өртдөгийг ялгаагүй санаж, тэднийг урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт өртсөн бол чөлөөлөх ёстойг санаж ажиллах;

Энэхүү гэмт хэрэг үүдэн гарах эрэлт, хэрэгцээг бий болгож байгаа нь эрэгтэйчүүд гэсэн хандлага, зан байдлыг өөрчлөх үүднээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд эрэгтэй өмгөөлөгчдийг түлхүү оролцуулах.

Хүний эрхийг дээдэлсэн арга замаар ажиллах нь чухал алхам. Охид, эмэгтэйчүүдийг жендерийн үүднээс ялгаварлан гадуурхах нь хүний эрхийг үгүйсгэж байгаатай адил юм. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх стратегийн цөм нь эмэгтэйчүүдийн эрх байх ёстой. Жендер, хүний эрхэд суурилсан арга ажиллагаа нь хүний тэгш байдлыг хангахад чиглэж улмаар эмэгтэй, эрэгтэй хүмүүст адил хүрч ажиллах боломжийг олгоно.

---

7 Эх сурвалж: Хүн худалдаалах гэмт хэрэг дэх хүний эрхийн болон жендерийн асуудал, товхимол; НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн Зүүн өмнөд азийн бүсийн төлөөлөгчийн газар, Мекongийн дэд бүс нутаг дахь хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаарх Бангкок болон НҮБ-ын хамтарсан төсөл, 2002

МОДУЛЬ - 2

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь шүүгч, прокурор, хууль сахиулах, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг олгоход оршино.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт;

Сэдэв 2 Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх үндэсний хууль тогтоомж.

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколд тодорхойлсны дагуу хүн худалдаалах хэмээх нэр томьёонд хамаарагдаж буй хэрэг, зөрчлүүдийг оролцогч улсууд өөрийн хууль тогтоомжид нийцүүлэн, шүүхээр шийдвэрлэх бөгөөд энэхүү протоколыг үндсэн зарчим болгон ажиллах юм.
- НҮБ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн тухай протоколд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, эх оронд нь эргүүлэн авчрах, эргэн нийгэмшүүлэх, гэмт этгээдийг яллахад чиглэсэн хүний эрхэд суурилсан, нийгэм эдийн засаг, улс төр, хууль зүйн арга хэмжээ авах талаар тусгасан байдаг.
- Хүн худалдаалах гэмт хэрэг нь зөвхөн нэг улсад үйлдэгддэг гэмт хэрэг биш учраас улсуудын Засгийн газар иргэнээ хамгаалахын тулд олон улсын хууль тогтоомжийн хүрээнд тодорхой үүрэг хүлээдэг.
- Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал улс бүрд харилцан адилгүй байдаг. Зарим улс энэ гэмт хэргийн эх үүсвэр нь болж байхад, зарим нь дамжуулагч, хүлээн авагч болж мөлжлөгийг олон арга, хэлбэрээр үйлддэг.
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд тухайн орны хууль тогтоомжийн боловсронгуй байдал хамгийн хүчтэй зэвсэг болдог бөгөөд энэ нь мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанд нөлөөлж байдаг.

Сургалтын хугацаа - 120 минут

ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ

- Сургалтын танхимыг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилан бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлэн судлах эх сурвалжийн жагсаалт, холбогдох хууль тогтоомжийг бэлтгэх;
- Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, компьютер, прожектор, дэлгэц, самбар, цаас, самбарын үзэг бэлтгэх.

Модуль 2: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт	Лекц / Хэлэлцүүлэг	15	Сэдэв 1
Сэдэв 2	Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага	Лекц / Хэлэлцүүлэг	15	Сэдэв 2.1
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хууль тогтоомж	Лекц/ Хэлэлцүүлэг	45	Сэдэв 2.2
	Дасгал ажил 1 – Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар баталсан хууль тогтоомжийг хэрэглэх чадвар эзэмших	Дасгал ажиллах	45	Дасгал ажил 1

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

А. НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д "Хүн худалдаалах" хэмээх нэр томьёог дараах байдлаар тодорхойлсон:

Гэмт хэргийн үндсэн шинж	НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол
Үйлдэл (аль нь ч байж болно) – Хүн худалдаалагчид юу хийдэг вэ?	Хүнийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах
Үйлдлийн арга (аль нь ч байж болно) – Хэрхэн үйлддэг вэ?	Заналхийлэх, хүч хэрэглэх, албадах, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх
Зорилго (аль нь ч байж болно) – Яагаад үйлддэг вэ?	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах
Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэх нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй. Хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцоход энэ зүйлд заасан арга хэрэглэсэн байхыг шаардахгүй.	

"Хүн худалдаалах" гэсэн ойлголтыг тодорхойлоход дараах хэд хэдэн шинжийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэрэг гэдгийг зөвхөн бэлгийн мөлжлөгөөр хязгаарлалгүй бусад төрлийн мөлжлөгийг хамруулан ойлгохоор заасан. Үүнд: албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах зэрэг орно.
- Зөвхөн охид, эмэгтэйчүүд төдийгүй хөвгүүд, эрэгтэйчүүдийн аль нь ч хохирогч болох боломжтойг дурдсан байдаг.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг заавал улсын хил давуулан худалдаалсан байх шаардлагагүй, тухайн улс дотроо нэг газраас нөгөө газарт дамжуулан худалдаалж болзошгүйг анхааруулсан.
- НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколд 18, түүнээс доош настай хүмүүсээс бусад тохиолдолд хүч хэрэглэх, хуурч мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах аргаар хохирогчоос зөвшөөрлийг нь авсан байж болзошгүй тул тэдний сайн дурааараа өгсөн зөвшөөрлийг зөвшөөрсөн гэж үзэхгүй тухай дурдсан.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколын 2 дугаар зүйлд уг баримт бичгийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

(а) Хүүхэд, эмэгтэйчүүдэд онцгой анхаарал хандуулах замаар хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх;

(б) Хүний эрхийг хүндэтгэн дээдэлж, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод туслах, тэднийг хамгаалах;

(в) Эдгээр зорилтдоо хүрэхийн тулд нэгдэн орсон улс орнуудтай хамтран ажиллах.

Хүн худалдаалахын эсрэг протоколын гол онцлог:

- Хууран мэхэлж, хүнийг мөлжих зорилготой үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлсон;
- Хүнийг мөлжих зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах, хүлээн авах зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хүрээ тэлэх хандлагатай байгааг дурдсан;
- Зөвшөөрлийг нь авахын тулд эмзэг байдлыг нь ашиглаж нарийн аргаар элсүүлэхээс гадна хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэрэг аргыг тусгасан;
- Дурдсан аргуудаас аль нэгийг нь ашигласан л бол хохирогч ямар нэг байдлаар зөвшөөрсөн эсэхээс үл хамааран гэмт хэрэгт тооцохоор тодорхойлсон;
- Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг ч эрэгтэйчүүд ч мөн адил өртдөгийг сануулсан;
- Бэлгийн мөлжлөгөөс гадна олон төрлийн зорилготой байдгийг хүлээн зөвшөөрсөн;
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг хамгаалах, туслах, нутагт нь буцаах, нийгэмшүүлэх, гэмт этгээдүүдэд тохирсон ялыг оногдуулахын тулд авбал зохих хүний эрхэд суурилсан, нийгэм эдийн засаг, улс төр, эрх зүйн арга хэмжээг агуулсан;
- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал шаардлагатай болохыг анхааруулсан.

Б. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой олон улсын хүний эрхийн стандартууд (хэм хэмжээ)

Хүн худалдаалах нь зөвхөн нэг улсад үйлдэгддэг гэмт хэрэг биш учраас улс орнуудын Засгийн газар иргэнээ хамгаалахын тулд олон улсын тэмцэлд нэгдэж, олон улсын өмнө тодорхой үүрэг, хариуцлага хүлээдэг.

Гадаадын иргэний эрх

Олон улсын хууль тогтоомж нь аливаа улс өөрийн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэний хүний эрхийг хамгаалахыг шаарддаг. Энэ нь тухайн улсын иргэн биш бол (онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд) үндсэн эрхийг нь зөрчиж болно гэсэн үг огт биш юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (1966) хэрэгжилтийг хангаж ажилладаг НҮБ-ын Хүний эрхийн хороо дараах байдлаар тодорхойлсон байдаг.

"Гадаадын иргэд амьд явах, хуулиар хамгаалуулах эрхтэй. Тэднийг боол болгож, аливаа төрлийн боолчлолд оруулж болохгүй, тэд эрх чөлөөтэй, аюулгүй амьдрах эрхтэй. Мөн тэд хуулийн өмнө тэгш эрхтэй, хуулиар тогтоосон эрх бүхий, хараат бус, бие даасан шүүхээр шүүлгэх, олон нийтийн хэлэлцүүлэг хийх эрхтэй. Хуулиар адил тэгш хамгаалуулах эрхтэй ба тухайн улсын иргэн биш хэмээн ялгаварлан харьцаж болохгүй. Эдгээр эрх, эрх чөлөө нь энэхүү пактад зааснаар хуулийн хүрээнд тусгайлан тусгагдсан тохиолдолд л хязгаарлагдах боломжтой."[8]

Боолчлолыг халах тухай

Зарим тохиолдолд хүн худалдаалахыг боолчлолтой адилтгаж үздэг. Олон улсын хууль тогтоомжид боолчлол, боолын худалдааг хуульчлан хориглосон байдаг. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенцэд (1956 оны Боолчлолын тухай конвенц) дараах хоёр нэр томьёог тодорхойлсон байдаг.

Өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүнээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцөлийг "боолчлол", мөн ийм байдал буюу нөхцөлд байгаа хүнийг "боол" гэж тус тус ойлгоно. [7 дугаар зүйлийн (a) хэсэг]

"Боолын худалдаа" гэж хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна. [7 дугаар зүйлийн (c) хэсэг]

Албадан хөдөлмөрийг хориглох тухай

Албадан хөдөлмөрлүүлэх нь хүн худалдаалах гэмт хэргийн нэг мөлжлөгийн зорилго байдаг. Олон улсын хууль тогтоомжид албадан хөдөлмөрийг маш хатуу, онцгой нөхцөл байдалд зөвшөөрснөөс (цэргийн алба, иргэний үүргийн хууль г.м) бусад тохиолдолд хориглодог.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцүүд

Албадан хөдөлмөрийн тухай конвенцэд (No. 29) "Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр" гэж ямар нэг шийтгэл ногдуулахаар заналхийлж, аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээг хэлнэ"гэж тодорхойлсон байдаг [2 дугаар зүйлийн (1)].

"Үйлчилгээ" гэж өмчлөлд хүргэдэггүй эдийн засгийн шинжтэй ямар нэг үйл ажиллагааг хэлнэ. Шийтгэл гэж тодорхой үйлдэл, нөхцөл байдлаас үүдэн гарсан хохирол эсвэл сөрөг үр дагаврыг хэлнэ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182

8 Иргэний ба улс төрийн эрхийн төв, Ерөнхий тайлбар № 15: Пактад тусгагдсан гадаадын иргэдийн байр суурь. 1986 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Хүний эрхийн хорооны хорин долоодугаар чуулганаар баталсан. Эх сурвалж - http://www.refworld.org/pdfid/45139acfc.pdf

дугаар конвенцийн 3 дугаар зүйлд "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр"-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

(а) боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй бүхий л үйл ажиллагаа;

(б) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;

(в) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;

(г) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.

Өрийн дарамтад оруулахыг хориглох тухай

"Өрийн дарамтад оруулах" гэдэг нь худалдаалагдсан хүнийг хүчирхийлэл дор ажиллуулан, тасралтгүйгээр мөлжих үйлдлийг хэлнэ. 1956 онд баталсан "Боолчлолын тухай конвенц"-д өрийн дарамтыг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

"Өрөнд орж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус байдалтай байвал өрийн дарамтад орсон гэж үзнэ." [1 дүгээр зүйлийн (а) хэсэг].

Олон улсын хууль тогтоомжийн хүрээнд өрийн дарамтад оруулахыг хууль бус гэж үздэг. Өрийн дарамтад оруулахад чиглэгдсэн, шаардсан аливаа гэрээ ч хууль бус бичиг баримтад тооцогдоно гэсэн үг.

Хүчээр биеийг нь үнэлүүлэх, бусдын биеийг үнэлж мөлжлөг үйлдэхийг хориглох тухай

1979 онд баталсан Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцэд хүчээр биеийг нь үнэлүүлэх, бусдын биеийг үнэлүүлж мөлжлөг үйлдэхийг хориглосон байдаг. Энэхүү конвенцэд нэгдэн орсон улс орнууд эмэгтэйчүүдийг худалдаалах, тэдний биеийг үнэлүүлж мөлжих бүхий л хэлбэрийг устгах хууль зүйн арга хэмжээ авах үүрэг хүлээсэн.

Хүүхдийн эрхтэй холбоотой тусгай заалт

Дээр дурдсан хэм хэмжээ, стандартад хүүхэд шууд хамаарч байгаа бөгөөд олон улсын хууль тогтоомжид хүүхдийн эмзэг байдал, онцлог хэрэгцээ, шаардлагад үндэслэн тусгайлсан эрхийг нь онцлон тусгасан байдаг. Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх, худалдаалах, садар самуунд уруу татах зэрэг асуудлууд нь хүүхдэд чиглэсэн хууль зүйн тусгай бие даасан баримт бичиг байх ёстойг сануулж байсан учраас 1956 онд баталсан Боолчлолын тухай конвенц олон улсад хүүхдийг тусгайлан хамгаалах анхны олон улсын баримт бичгүүдийн нэг болсон юм.

Тус конвенцэд "Хүүхдийн мөлжлөг"-ийг (хүн худалдаалах хэлбэрүүдийг оруулан тодорхойлсон) нэгдэн орсон улс орнууд аль болох хурдан халж, устгах шаардлагатай боолчлол, түүнтэй ижил төстэй нөхцөл байдал гэж тодорхойлсон байдаг.

1979 онд баталсан **Хүүхдийн эрхийн тухай конвенц** нь хүүхдийн эрх, нэр төрийг хамгаалах

болон тэдэнд эрх мэдэл олгох талаар цогц бодлогыг тодорхойлж өгсөн.

Тийм ч учраас энэ конвенцийг бүхэлд нь хүүхдийг худалдаалах, мөлжиж ашиг олохтой холбоотой гэмт үйлдлийг тогтоож, хариу арга хэмжээ авахад чиглэсэн олон улсын баримт бичиг гэж ойлгох хэрэгтэй. Нэгдэн орсон улс орнууд шууд холбогдох зүйл заалтын хүрээнд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Аливаа зорилго, хэлбэрээр хүүхэд хулгайлах, худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бүхий л арга хэмжээг улс дотроо, улс хооронд болон олон улсад авах;
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах, бүх төрлийн эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах;
- Хүүхдийн нэр төрийг хамгаалсан, өөрийгөө хүндэтгэх боломжтой, мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдийг эрүүл аюулгүй орчинд нийгэмшүүлэх, бие махбодын болон сэтгэл санааны хувьд эдгээх, эмчлэхтэй холбоотой бүхий л арга хэмжээг авах.

34 дүгээр зүйлд оролцогч улсууд хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд ашиглах бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээх талаар дурдсан байдаг. Энэ зорилгын хүрээнд оролцогч улс орнууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна. Үүнд:

(а) Хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;

(б) Хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;

(в) Хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах.

Олон улсын бусад баримт бичигт 2000 онд баталсан Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас 1999 онд баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах конвенцүүд тус тус орно.

Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протоколд хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд сурталчлахын эсрэг тусгайлан арга хэмжээ авахыг оролцогч орнуудад үүрэг болгосон байдаг. Протоколд хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд сурталчлах хэмээх ойлголтыг өргөн хүрээтэйгээр тодорхойлсон.

Конвенцийн удиртгал хэсэгт "Хүн худалдаалах, биеийг нь үнэлэх, садар самууныг сурталчлан дэлгэрүүлж байдаг секс жуулчлал тасралтгүй явагдаж, түгэн дэлгэрч байгаа бөгөөд үүнд эмзэг бүлэг болох хүүхдүүд өртөж, хохирогч болсоор байгаа нь сэтгэл зовоож байна" хэмээсэн байдаг.

1 дүгээр зүйлд хүүхдийг худалдах, биеийг нь үнэлүүлэх, садар самуунд сурталчлахыг оролцогч орнууд хориглох ёстой талаар тодорхой өгүүлсэн байдаг.

2 дугаар зүйл	Протоколд:
Хүүхэд худалдах	Аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу ямар нэг төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх бүх төрлийн үйлдэл буюу хэлцэл юм.
Хүүхдийн биеийг үнэлүүлэх	Шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бусадтай бэлгийн харьцаанд оруулахыг хэлнэ.
Хүүхдийг садар самуун сурталчлахад ашиглах	Хүүхдийг бэлгийн харьцаанд бодитоор буюу бодит бусаар оруулж байгааг аливаа арга, хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харьцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ.

В. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг:

Олон улсын болон бүс нутгийн хэмжээний баримт бичиг	Гарын үсэг зурсан, соёрхон батлсан, нэгдэн орсон
Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2000 он	2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр (нэгдэн орсон)
Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын протокол, 2000 он	2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр (нэгдэн орсон)
Цагаачдыг хил дамнуулан хуурай газар, тэнгис, агаараар хил давуулахын эсрэг протокол (Нууцаар хил нэвтрүүлэхийн эсрэг протокол), 2000 он	2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр (нэгдэн орсон)
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979	1980 оны 7 дугаар сарын 17-ны өдөр (гарын үсэг зурсан) 1981 оны 7 дугаар сарын 20-ны өдөр (соёрхон батлсан)
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенц, 1989 он	1990 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр (гарын үсэг зурсан) 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр (соёрхон батлсан)
Хүүхдийг худалдаалах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол, 2000 он	2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр (гарын үсэг зурсан) 2003 оны 6 дугаар сарын 27-ны өдөр (соёрхон батлсан)
Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай конвенц (№ 29)	2005 оны 3 дугаар сарын 15-ны өдөр (соёрхон батлсан)
Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай конвенц (182)	2001 оны 2 дугаар сарын 26-ны өдөр (соёрхон батлсан)
Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц	1991 оны 6 дугаар сарын 6-ны өдөр (нэгдэн орсон)

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Олон улсын гэрээгээр оролцогч улсуудын хүлээсэн үүргийн талаар суралцагчидтай ярилцана уу.

Тухайн улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ үл биелүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврын талаар ярилцана уу.

СЭДЭВ 2: МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

1. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ[9]

Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго: Монгол Улс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг албадан хөдөлмөрлүүлэх, бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор худалдаалах илгээгч болон хүлээн авагч улсад тооцогдож байна. Монгол Улсын иргэд Турк, Казакстан, Израйл, Норвеги, Швед улсад хөдөлмөр эрхэлдэг бөгөөд Өмнөд Солонгос, Япон, Хятад, Хонконг, Макао, Малайз, Герман, Швед, Бельги, Турк, Америк зэрэг улсад бэлгийн мөлжлөгт өртөж байна. Охид, эмэгтэйчүүд ихэвчлэн массажны газар, зочид буудал, шөнийн цэнгээний газар болон караоке клубүүдэд бэлгийн мөлжлөгт өртөж байна.

Мөн эмэгтэйчүүд зуучлалын сүлжээгээр дамжуулан Хятад, Өмнөд Солонгосын эрэгтэйчүүдтэй гэр бүл болж байгаа нь тэднийг боолчлолд (гэрийн үйлчлэгч) өртөх, хүчээр биеийг нь үнэлүүлэх эрсдэлд оруулж байна.

Монгол Улсын өмнөд хэсэгт уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа нь дотоодын шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлээд зогсохгүй гадагшаа, ялангуяа Монгол-Хятадын улсын хил нэвтрүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улсын хилээр нүүрс тээвэрлэн гаргадаг том оврын автомашины жолооч нар унаж яваа машиныхаа барьцаанд баримт бичгээ хураалгадаг бөгөөд залуу эмэгтэйчүүд улсын хил нэвтрэх ээлжээ хүлээж байгаа жолооч нарт биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгт өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын ихээхэн хэсгийг 18 нас хүрээгүй хүн буюу хүүхдүүд эзэлж байна. Тэдгээр бага насны хүүхдүүд хүчээр гуйлга гуйх, хулгай хийх, хөдөлмөрийн мөлжлөгт ихээр өртөж байна. Мөн тэднийг эдийн засгийн албан ёсны бус салбар болох хурдны морь унуулах, уул уурхай болон барилга дээр ажиллуулах, зарим тохиолдолд бэлгийн мөлжлөгт оруулах үйл ажиллагаа гэр бүлийн хүмүүсийнх нь оролцоотойгоор үйлдэгдэх явдал ч байсаар байна.

Монгол Улсад ажиллаж байгаа Хойд Солонгос, Хятад Улсын иргэд ажлын байраа болон хүссэн үедээ хаа нэгтээ зорчих эрх чөлөөгүйгээр эсхүл ямар нэг цалингүй эсвэл маш бага цалинтайгаар барилга, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мод үржүүлэх, бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин засварын газар, болон уул уурхайн салбарт ажиллах тохиолдол байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн арга: Гэмт этгээдүүд хохирогчдыг бэлгийн мөлжлөгт оруулахын тулд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлэх, нийгмийн сүлжээ ашиглах, онлайн ажлын санал тавих болон гадаад хэлний сургалтад хамрагдахыг санал болгох зэргээр эрхшээлдээ оруулж байна. Хөдөө орон нутгаас шилжиж ирсэн иргэд Улаанбаатар болон улсын хилийн ойролцоо аймаг, сумдад бэлгийн мөлжлөгт өртөж байна. Монгол Улсад ирсэн Япон, Өмнөд Солонгосын жуулчид хүүхэд оролцуулсан секс аялал жуулчлалыг ихэд сонирхох болсон байна.

---

9 АНУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн тайлангаас авав, 2017; Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг: эрсдэл, эмзэг байдал, гэмт хэргээс үүдэлтэй сэтгэцийн эмгэг, Азийн сан, 2006; Ли Жюлак, Ким Хюнсок, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн ерөнхий байдал: Өнөөгийн нөхцөл байдал, хууль тогтоомж, Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны олон улсын сэтгүүл, 2 дахь хэвлэл, Дугаар 2, 2015 оны 3-4 дүгээр сар.

Гэмт этгээдүүдийн тухайд: Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ихэвчлэн 20-50 насны, эрэгтэй хүмүүс байсан бол хохирогч элсүүлэгч нь ихэвчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж байсан эмэгтэйчүүд байсан. Хохирогчийг ажиглаж, тэдний тухай мэдээлэл дамжуулагч нар нь ихэвчлэн өсвөр насны хүүхдүүд байгаа бөгөөд энэ тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэх аргаа тогтмол өөрчилж, зохион байгуулалтаа улам нарийсгаж байдаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчдад дараах мэдээллийг өгнө үү.

- *Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн тухай нэмэлт мэдээлэл өгнө үү.*
- *Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой сүүлийн үеийн мэдээлэл, статистик танилцуулна уу. Үүнд:*
  - *Хохирогчдын тоо;*
  - *Хохирогчийн талаарх мэдээлэл – нас, хүйс, гэр бүлийн байдал гэх мэт.*

Хэлэлцүүлэг *– Дараах сэдвээр хэлэлцүүлэг хийх боломжтой.*

- *Өөрсдийнхөө мэдлэг, туршлагад үндэслэн хүн худалдаалах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа "халуун цэг"-үүдийг нэрлэх.*
- *"Халуун цэг"-үүдэд ажиллаж байсан бол туршлагаасаа бусадтайгаа хуваалцах.*
- *Монгол Улсад шинээр бий болсон/болзошгүй "халуун цэг"-ийн талаар ярилцах, жагсаалт гаргах.*

2. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Энэхүү хэсэгт хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан Монгол Улсын хууль тогтоомжийн агуулга, үзэл баримтлалыг судална. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд иргэний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан.

ХУУЛИУД

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга), 2017 он
4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 1997 он
6. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он
7. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он
8. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он
9. Хөдөлмөрийн тухай хууль, 1999
10. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2010 он
11. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
12. Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга), 2017 он
13. Нийгмийн халамжийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2012 он
14. Эрүүл мэндийн тухай хууль, 2011 он
15. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, 2001 он
16. Дипломат албаны тухай хууль, 2000 он
17. Зар сурталчилгааны тухай хууль, 2002 он

18. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998 он
19. Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2017 он
20. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (шинэчилсэн найруулга), 2017 он
21. Хувийн хамгаалалтын тухай хууль, 2001 он

А. Монгол Улсын Үндсэн Хууль (1992 он)

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 14-19 дүгээр зүйлд иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхийг Арван зургаа дугаар зүйлд заасан ба үүнд амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, төрийн байгууллага, албан хаагчд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, халдашгүй, чөлөөтэй байх зэрэг эрхүүд багтдаг. Түүнчлэн, хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заажээ.

Арван дөрөвдүгээр зүйлд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан ба арван есдүгээр зүйлд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар тусгасан байна.

Б. Эрүүгийн хууль (2015 он)

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд УИХ-аас Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн. Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд "Хүн худалдаалах гэмт хэрэг"-ийг хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга				
Зүйл, хэсэг	**Гэмт хэргийн ангилал**	**Гэмт хэрэг**	**Ялын доод хэмжээ**	**Ялын дээд хэмжээ**
13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Хүнд гэмт хэрэг	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан	2 жил хорих	8 жил хорих
13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Хүнд гэмт хэрэг	Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн	5 жил хорих	12 жил хорих
13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Хүнд гэмт хэрэг	Байнга тогтвортой зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	12-20 жил хорих	Бүх насаар хорих

Тайлбар:

» Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр

зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

» Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хохирогчид ээлтэй зохицуулалтууд орсон. Үүнд:

» Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхгүй байхаар тусгасан байна (Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг харна уу).

» Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. (7.5 дугаар зүйлийн 1 дэх заалт)

» Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн бичиг баримтгүйгээр, хуурамч бичиг баримтаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй (19.14 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг харна уу)

Хүн худалдаалах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх тухай

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах	12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг
1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор ***хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан*** элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; 2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; 2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга тогтвортой; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. **Тайлбар:** Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.	1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас **эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан** бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 2.1.арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүүхдийг албадан оруулж; 2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; 2.3.хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; 2.4.хохирогчийг жирэмсэн болгож; 2.5.хоёр, түүнээс олон хүний эсрэг; 2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийн улмаас: 3.1.ураг зулбасан; 3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 4.1.бага насны хүүхдийг албадан оруулж; 4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй

ЗҮЙЛЧЛЭЛ:

"Хүн худалдаалах" гэмт хэргийн хувьд ***биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих*** нь зорилго байхыг шаардаж байгаа бол "Бэлгийн мөлжлөг" гэмт хэргийн хувьд энэ нь тусдаа гэмт хэргийн шинж байна. Хэрэв бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэргийг шалгах явцад эсхүл гомдол, мэдээллийг шалгахад хохирогчийг ***элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан*** буюу "trafficking" шинжтэй нэг газраас нөгөө газар руу зөөсөн, баримт бичгийг нь барьцаалсан, зорчин явах эрхийг хязгаарласан шинжтэй байх нь тогтоогдвол энэ хүн худалдаалах гэмт хэрэг болно. Өөрөөр хэлбэл энэ байдлаар хүнийг эрхшээлдээ оруулахдаа ***хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдах аргыг хэрэглэсэн байж болно.***

Хяналтдаа байлгаж байгаа хүн гэдэг нь: Гэмт хэргийн хохирогч биш харин хохирогчийг хяналтдаа байлгаж байгаа хүнийг ойлгоно. Хохирогчийг хяналтдаа ямар ч хэлбэрээр байлгаж болох бөгөөд албан тушаал, эрх мэдэл, бусад байдлаар тухайн хүний хяналтад байхыг шаарддаг.

2002 оны Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэргийн шинжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцэд заасны дагуу "Бэлгийн мөлжлөг" үйлдэх гэмт хэрэг хэмээн шинээр хуульчлан тодорхойлсон болно. Практикт биеэ үнэлэхийг зохион байгуулах, биеэ үнэлэхэд бусдыг татан оруулж байгаа үйлдэл нь бэлгийн мөлжлөгийн шинжтэй эсэхийг шалган тогтоосны үндсэн дээр зөрчил, гэмт хэрэг гэдгийг ялгах шаардлага үүснэ.

Бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэрэг нь:

а) хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж;

б) эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдэл нь обьектив талын шинж болно. Энэ гэмт хэргийн хүн худалдаалах гэмт хэргээс ялгагдах онцлог нь **зорчин явах эрхийг хязгаарлаагүй** байх явдал юм. Хэрэв бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэргийг хохирогчийн зорчин явах эрхийг хязгаарлаж, хяналтдаа байлгаж үйлдсэн бол энэ нь дотоодод үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хангана.

"Хүч хэрэглэх" гэж бие махбодын хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг хэлнэ.

"Хууран мэхэлсэн" гэж үгээр буюу үйлдлээр бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ. Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах зэрэг хэлбэрээр илэрнэ.

"Эмзэг байдлыг далимдуулсан" гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.

"Эрх мэдлээ урвуулан ашигласан" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.

"Элсүүлэх" гэдэгт хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх,

тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.

"Тээвэрлэх" гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно.

"Дамжуулах" гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.

"Орогнуулах" гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.

"Хүлээн авах" гэдэгт худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.

Зорилго	+	Үйлдлийн арга	+	Үйл явц
Биеийг нь үнэлүүлэх эсхүл **Хүчирхийлэл/Бэлгийн мөлжлөг** эсхүл **Эд эрхтнийг авах** эсхүл **Албадан хөдөлмөрлүүлэх/ мөлжих** эсхүл **Боолчлол/түүнтэй төстэй нөхцөлд байлгах**	Б О Л О Н	**Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж** эсхүл **Хууран мэхэлж** эсхүл **Хулгайлж** эсхүл **Итгэл эвдэж** эсхүл **Эрх мэдлээ урвуулан ашиглаж** эсхүл **Эмзэг байдлыг нь далимдуулж** эсхүл **Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж**	Б О Л О Н	**Элсүүлсэн** эсхүл **Тээвэрлэсэн** эсхүл **Дамжуулсан** эсхүл **Орогнуулсан** эсхүл **Хүлээн авсан**

В. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Энэ хуульд зааснаар гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ (8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана (8.1 дүгээр 2 дахь хэсэг).

Хохирогч энэ хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно (8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн эдлэх эрх, хүлээх үүргийг энэ хуулийн 8.2 дугаар зүйлд зааснаас гадна хохирогчийн мэдээллээр хангуулах, аюулгүй байдлаа хамгаалуулах зохицуулалтыг 8.3 дугаар зүйл болон 8.4 дүгээр зүйлд хуульчилсан.

Энэ хуулийн 1.12 дугаар зүйлд зааснаар "Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна".

Хүн худалдаалах хэргийн хохирогчдын хувийн амьдрал, бие хүний хувьд хүн худалдаалахтай холбогдох хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "Гэрч хохирогчийг хамгаалах бүлэг"-т энэ талаар анх удаа хуульчилсан.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэлийг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг энэ хуулийн 42 дугаар бүлэгт хуульчилсан.

Г. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012 он)

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд "Хүн худалдаалах" гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдэл хэмээн заажээ (3 дугаар зүйлийн 3.1.1).

"Хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн (3 дугаар зүйлийн 3.1.2). Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид (үүнд хүүхэд багтана) нэр төр, аюулгүй байдал, хувийн нууцаа хамгаалуулах, мөн халамж, үйлчилгээ авах эрхтэй бөгөөд үүнд эрүүл мэнд болон сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байр, мэргэжлийн сургалт, хууль зүйн туслалцаа багтана (12 дугаар зүйлийн 12.1). Энэ хуулийн 9.3-д заасны дагуу хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна.

Энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаар хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй бөгөөд 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу сэтгэл санааны хохирлоо мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлнэ.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно (11 дүгээр зүйлийн 11.1).

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн албан хаагч, хувь хүн, хуулийн этгээдэд дараах хариуцлагыг хүлээлгэнэ:

» Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (17 дугаар зүйлийн 17.1).

» Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ(17 дугаар зүйлийн 17.2).

Д. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997 он)

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн (3 дугаар зүйлийн 3.1).

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчмыг энэ хуулийн 4 дүгээр зүйлд тусгасан ба үүнд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим багтсан байна.

Хуулийн 10 дугаар зүйлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн эрх, үүргийг тусгасан. Харин 13, 14 дүгээр зүйлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах болон гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс цагдаагийн байгууллага төлбөртэй авах зохицуулалтуудыг тус тус заажээ.

Цаашлаад, иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэх баталгааг хангасан байна. Иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар энэ хуульд заасан эрх үүргээ хэрэгжүүлэх явцад бусдад учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцахгүй байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлсэн иргэнд өөрт нь эд хөрөнгийн хохирол учирсан бол түүнийгээ төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү болон зардлыг олгох зэрэг баталгаа багтсан байна (22 дугаар зүйлийг харна уу).

Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (23 дугаар зүйлийн 23.1). Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (23 дугаар зүйлийн 23.2).

Е. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013 он)

Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.

«Гэрч, хохирогч» гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг хэлнэ (4 дүгээр зүйлийн 4.1.1).

Гэрч, хохирогч нь аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалт авах эрхтэй. Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд (тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин багтана)-ийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно (5 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг харна уу).

Түүнчлэн, гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно (5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг харна уу).

Хуулийн 7 дугаар зүйлд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хэлбэрүүдийг заасан ба үүнд урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт,

мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх багтана. Гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

Хуулийн 17 дугаар зүйлд гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах, гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх, шүүгч хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч, шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авахыг заажээ.

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх ба хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ. Харин гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг мөн үнэ төлбөргүй үзүүлнэ. (18 дугаар зүйлийн 1, 2 хэсгийг харна уу). Энэ хуулийн зохицуулалтад хамаарах этгээдүүдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ (19 дүгээр зүйлийн 19.1).

Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна (20 дугаар зүйлийн 20.1). Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ (23 дугаар зүйлийн 23.1).

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална (3 дугаар зүйлийн 3.1):

- Хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- Нууцлалыг хамгаалах;
- Шуурхай байх;
- Хамтран ажиллах.

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй (3 дугаар зүйлийн 3.2). Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй (3 дугаар зүйлийн 3.3).

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана (24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг харна уу). Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ (24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг).

Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21^3 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно (26 дугаар 26.1 дэх хэсэг).

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг).

Ё. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016 он)

Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлнэ (3 дугаар зүйлийн 3.2). Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно (3 дугаар зүйлийн 3.3).

Хүүхэд хамгаалал нь олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаа байх ёстой бөгөөд гэр бүл, боловсролын салбар, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл, мэдээлэл, цахим орчин болон олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын асуудлуудыг авч үзнэ. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа нь хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой.

"Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг (4.1.1 дэх заалт).;

"Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг (4.1.3 дахь заалт). Гэхдээ энэхүү хороо нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулна (15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт).

"Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ" гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг (4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт);

"Хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг (4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт).

Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллагын албан хаагч холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ (11 дүгээр зүйлийн 11.10 дахь хэсэг).

Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно (24 дүгээр зүйлийн 24.1дэх хэсэг).

Ж. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016 он)

Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ (3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг). Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна (3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг).

Хуулийн 7 дугаар зүйлд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй болохыг заажээ.

З. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)

"Албадан хөдөлмөр" гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг хэлнэ (3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт). Түүнчлэн, хуулийн 7.1 дэх хэсэгт зааснаар хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.

И. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010 он)

Энэ хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн /цаашид «гадаадын иргэн» гэх/, гадаадын иргэнийг уригчид хамаарна (3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг). Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэнд хамаарах энэ хуулийн зохицуулалт нь харьяалалгүй хүнд нэгэн адил үйлчилнэ (3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг).

"Гадаадын иргэн" гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт)

"Уригч" гэж гадаадын иргэнийг Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг гаргаж түүнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон тус улсад хууль ёсоор 90 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт).

"Дамжин өнгөрөгч" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт).

"Түр ирэгч" гэж Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт).

"Хувийн хэргээр оршин суугч" гэж суралцах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүлийн шалтгаан болон хувийн бусад ажлаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт).

"Албан хэргээр оршин суугч" гэж төрийн байгууллагын урилгаар болон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллахаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт).

"Харьяалалгүй хүн" гэж аль ч улсын харьяат бус хүнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалт).

"Цагаач" гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ (5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт).

Гадаадын иргэн энэ хуулийн 7.1 (Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хязгаарлалт тогтоож болно)-д заасны дагуу хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний нэгэн адил эрх, эрх чөлөөг

эдэлж, үүрэг хүлээнэ.

Гадаадын иргэн Монгол Улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэхийг хориглоно (8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол гадаадын иргэнийг хуульд заасан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ (34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт).

Гадаадын иргэнийг саатуулж болох нэг үндэслэл бол тэрээр паспорт буюу паспортыг орлох бичиг баримтгүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байх явдал юм (36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалт).

К. Гэр бүлийн тухай хууль (1999 он)

Энэ хуульд заасан харшлах шалтгаангүй бол[10] 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно (6 дугаар 6.1 дэх хэсэг)

Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна (6 дугаар 6.2 дахь хэсэг).

Энэ хуулийн 27.1 дэх хэсэгт зааснаар хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болно.

Л. Цагдаагийн албаны тухай хууль (2017 он)

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн (4.1 дэх хэсэг).

"Гэмт хэрэгтэй тэмцэх" гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг (3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт),

"Нийтийн хэв журам хамгаалах" гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг (3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт),

"Олон нийтийн аюулгүй байдлыг хангах" гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг (3 дугаар зүйлийн 3.1.3 дах заалт) тус тус ойлгохоор заасан

Энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт цагдаагийн байгууллагын чиг үүрэг, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг заасан болно (10-13 дугаар зүйл).

10 Гэрлэхэд харшлах шалтгааныг Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй холбоотой заалтууд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах (10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт);
- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх (10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт);
- Гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах (10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт);
- Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах (10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт);
- Хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах (10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт);
- Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах (10 дугаар зүйлийн 10.1.6 дах заалт);
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах (10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт);
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах (10 дугаар зүйлийн 10.1.8 дах заалт);
- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах (10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалт);
- Гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах (10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт);
- Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татан оролцуулах (10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт).

Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна.

Хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор террор үйлдэх, хүн худалдаалах, хүнийг алах, авлига, хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны хувийн эрүүл мэндийн нууцад хамаарах бие эрхтний гажиг, халдварт өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг хуульд заасны дагуу олон нийтэд мэдээлж болно (38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг).

М. Нийгмийн халамжийн тухай хууль (2012 он)

Энэ хуулийн 18.2.4-т заасны дагуу хүчирхийлэлд өртсөн иргэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдана. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн олон төрлийн үйлчилгээ байдаг ба үүнд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээнд хамруулах болон хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах зэрэг үйлчилгээ багтдаг.

Н. Эрүүл мэндийн тухай хууль (2011 он)

Хуулийн 24.6.8-д заасны дагуу бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна.

О. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (2001 он)

Энэ хуульд зааснаар дараах тохиолдолд гадаадад хөдөлмөр эрхлүүлэхээр зуучлахыг хориглоно:

- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, 18 насанд хүрээгүй хүнийг (3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт);
- Химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодистой харьцах, хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд (3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт)

Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон гадаадаас Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчийн нийгмийн хамгааллын талаар гэрээнд заасан үүргийн биелэлтэд хяналт тавьж, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах эрхийг ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ (4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт).

Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрөл авсан байгууллага нь иргэнийг хууран мэхэлсэн, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн болон эрүүл мэндийн баталгаа алдагдахад хүргэсэн, зуучлах зөвшөөрөлд заагдаагүй оронд дур мэдэн ажиллах хүч гаргасан, зуучлах үйл ажиллагаанаас өндөр ашиг олох зорилгоор үндэслэлгүй үнэ тогтоосон зэргээр иргэний эрх ашгийг хохироосон ноцтой зөрчил гаргасан тохиолдолд уг байгууллагын зуучлах зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана (6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг).

Тухайн оронд суугаа Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газар нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа монгол иргэд, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэдийн талаар үүрэг хүлээх ба үүнд Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэх тухай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих үүрэгтэй (10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтыг харна уу).

Ө. Дипломат албаны тухай хууль (2000 он)

Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар тус тус хамаарна (6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг).

Дипломат төлөөлөгчийн газрын чиг үүрэгт суугаа болон хавсран суугаа оронд нь амьдарч буй Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх үүрэг багтдаг (7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт).

П. Зар сурталчилгааны тухай хууль (2002 он)

Энэ хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар зар сурталчилгаа нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон бол иргэн, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг).

Р. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль (1998 он)

Энэ хуулиар бусдын биеийг үнэлүүлэхийг хориглодог (4 дүгээр зүйлийг харна уу)

С. Зөрчлийн тухай хууль (2017 он)

Шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, хохирогч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно (15 дугаар зүйлийн 15.7.1 дэх заалт)

6.18 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих

1. Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах замаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах зорилгоор улсын хилээр оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Эротик сурталчилгаа, эсхүл үйлчилгээнд тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Эротикын сурталчилгаанд хяналт тавих журам, эсхүл эротик тоглолт явуулах журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдсэн эд зүйлийг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Т. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017 он)

Хуулийн 6.2.5 дахь заалтын дагуу шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулна.

У. Хувийн хамгаалалтын тухай хууль (2001 он)

Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн болон гэрээт харуул хамгаалалттай холбогдсон харилцаанаас бусад хувийн хамгаалалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна (4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг).

"Хувийн хамгаалалт" гэж хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахын тулд энэ хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулахыг (3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт).

Сургагч багшид зориулсан тэмдэглэл: Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын ажиллагаа болон шүүн таслах ажиллагаатай холбоотой зохицуулалтын талаар Модуль 7-ийн Сэдэв 1, Модуль 8-ын Сэдэв 1, Модуль 9–ийн Сэдэв 1-т тус тус өгүүлнэ.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2.3 хэсэгт бичсэн хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийг бүгдийг нь оруулаагүй, жишээ байдлаар оруулсныг анхаарна уу. Сэдвийнхээ хүрээнд сургагч багш холбоотой гэж үзэж байгаа бусад хуулийн зүйл заалтын талаар суралцагчидтайгаа харилцан ярилцах үедээ хэлж болно.
Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын үндэсний эрх зүйн зохицуулалтын талаарх хичээлийн дараа дасгал ажиллаж, хууль зүйн үүднээс дүн шинжилгээ хийлгэх замаар хууль хэрэглэх чадварыг шалгаж болно.

ДАСГАЛ АЖИЛ 1

1. Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ үндэсний хууль тогтоомжийг ашиглах нь

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дасгалыг ойлгомжтой, хялбар байлгах үүднээс хүмүүсийн нэр (хохирогч, гэмт этгээд) болон гэмт хэрэг үйлдсэн газар зэргийг суралцагчдаар зохиолгоно.

Зорилго: Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн зохицуулалтын талаар мэдлэг олгох, тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой хууль тогтоомжийг ашиглаж сургахад оршино.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Тараах материал, самбар, самбарын үзэг

Дасгалыг хэрхэн яаж ажиллах: Сургалтад хэдэн хүн хамрагдаж байгаагаас шалтгаалан, суралцагчдыг хэдэн багт хуваахаа шийдвэрлэж болох бөгөөд баг бүрд өөр өөр тохиолдол өгч шинжлүүлнэ. Эсвэл бэлтгэсэн нэг тохиолдлоо бүх оролцогчид уншуулж, өөрийгөө үнэлэх хэсэгт оруулсан асуултуудаас асууж, дунд нь харилцан яриа өрнүүлэх байдлаар явуулж болно.

Хугацаа: 45 минут (30 минутын хугацаанд багийн гишүүдээр тохиолдлыг шинжлүүлж, үлдсэн 15 минутын хугацаанд баг бүрийн төлөөллөөр танилцуулга хийлгэх)

ТОХИОЛДОЛ

Болормаа 15 настай, Архангай аймгийн Тариат суманд аав, ээж, 5 дүүгийн хамт амьдардаг. Тэрээр айлын том нь бөгөөд аав, ээж нь малчид. Нэг өдөр хамаатных нь хүн болох Чимгээ тэднийд айлчлан ирсэн бөгөөд Болормаагийн аав, ээжид охиноо Улаанбаатар хот руу явуулж, гэрийн үйлчлэгч хийлгэх хэрэгтэй гэж хэлэв. Чимгээ охиныг Улаанбаатарт очвол, сургуульд явуулж, ажил олж өгнө, охинд нь анхаарал халамж тавьж, харж хандана хэмээн сэнхрүүлэв. Ингэснээр охин нь орлоготой болж, гэр рүүгээ тодорхой хэмжээний мөнгө явуулна, тэр мөнгө

нь дүү нарынх нь амьжиргаа болон сургалтын зардалд нэмэр болно гэлээ.

Болормаа Чимгээтэй хамт автобусаар Улаанбаатар хотыг зорив. Очсон даруйдаа 7 ам бүлтэй нэгэн айлд үйлчлэгчээр ажиллаж эхэлсэн бөгөөд тэр айлын бүхий л ажлыг өдөрт 16-18 цагийн турш хийх боллоо. Гэвч гар дээрээ цалин авсангүй. Өөрийнх нь хоол, хэрэглээний зардлыг суутгаад сарынх нь цалинг гэр рүү нь явуулж байгаа гэж хэлж байв. Түүнийг сургуульд сургаагүйгээр барахгүй алдаа гаргах бүрд нь гар хүрдэг байлаа. Нэгэн өдөр гэрийн эзэгтэй түүнийг халуун хайруулын тавгаар түлэв. Гүнзгий түлэгдэлттэй яахаа мэдэхгүй уйлан, гадаа зогсож байсныг нь харсан сайхан сэтгэлтэй хөрш нь түүнийг эмнэлэгт хүргэв. Эмнэлгийн удирдлагууд энэ хэргийн талаар цагдаад мэдэгдсэн байна.

Өөрийгөө үнэлэх асуулт

1. Дээр дурдсан тохиолдол хүн худалдаалах гэмт хэрэг мөн үү? Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан нэр томьёоны дагуу тайлбарлана уу.
2. Энэхүү гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн хэддүгээр бүлэг, зүйлийн дагуу зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх вэ?
3. Дээрх тохиолдолд хууль зүйн үүднээс дүгнэлт хийж, энэхүү харилцааг зохицуулах холбогдох хууль тогтоомжийн жагсаалтыг гаргана уу?
4. Чимгээ болон гэрийн эзэгтэйн үйлдлийг холбогдох хуулиудын дагуу зүйлчилнэ үү?

МОДУЛЬ - 3

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь шүүгч, прокурор, хууль сахиулах, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох талаар шаардлагатай мэдлэг олох чадвар эзэмшүүлэхэд оршино.

Сэдэв 1 Хохирогчийг олж тогтоох анхан шатны ажиллагаа, анхаарах асуудал

Сэдэв 2 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, олох нь

Сэдэв 3 Нууц мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын үр дүнг үнэлэх, ашиглах

Сэдэв 4 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтооход учирч болзошгүй эрсдэл, түүнийг үнэлэх нь

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох үйл явц тун ярвигтай байдаг. Энэхүү үйл явцыг үр дүнтэй байлгахын тулд олон байгууллага хамтран ажиллах шаардлагатай.
- Хохирогчийн талаарх мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллага зэрэг олон сувгаар дамжуулан хууль сахиулах байгууллагад ирүүлэх боломжтой.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ямар ч газраас, бүр нийтийн эзэмшлийн зам талбайгаас ч олж тогтоож болох бөгөөд хохирогчийг олж тогтоох ажлыг ажил үүргийнхээ хүрээнд олон байгууллага санаачилж хэрэгжүүлэх боломжтой.
- Тухайн нөхцөл байдалд илэрч буй шинж тэмдгүүд нь хууль сахиулах байгууллагын албан хаагчид болон хил хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтооход тусалдаг.
- Хүн худалдаалах гэмт хэргийн сүлжээ нь бусад гэмт хэрэгтэй харьцуулахад хохирогч, тэдний гэр бүл, хууль сахиулагч олон талаар эрсдэлд оруулж байдгаараа ялгаатай байдаг.
- Хуулийн дагуу хүлээсэн ажил үүргийн болон хүмүүнлэгийн үүргээ хослуулан, чанартай боловсруулсан эрсдэлийн үнэлгээ нь цогцоороо хэргийг амжилттай мөрдөн шалгах, шийдвэрлэх үндэс болно.
- Хохирогчид учирч болох эрдлийг тогтоож, төлөвлөгөө гаргаж ажиллаад зогсохгүй мөрдөгч, прокурорууд хохирогчийг аврахаас эхлээд, хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх явцад төдийгүй шүүхийн шийдвэр гарсны дараа ч баримталж ажиллах зарчим болгон мөрдөж ажиллах ёстой.

Сургалтын хугацаа - 2 цаг (120 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилан бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх;
- Сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх.

МОДУЛЬ 3: ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургалтын зорилт	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох анхан шатны ажиллагаа	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 1
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бодитой олж тогтооход анхаарвал зохих шинж тэмдгүүд болон шалгуур үзүүлэлтүүд	Лекц / Хэлэлцүүлэг	30	Сэдэв 2
Сэдэв 2	Дасгал ажил 2 – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох ажиллагаа Дасгал ажил 3 - Хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх	Дасгал ажиллах	60	Дасгал ажил 2, Дасгал ажил 3
Сэдэв 3	Хохирогчийг олж тогтооход гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны гүйцэтгэх үүрэг	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 3
Сэдэв 4	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох анхан шатны ажиллагааны үед учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ	Лекц / Хэлэлцүүлэг	10	Сэдэв 4

СЭДЭВ 1: ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ АНХАН ШАТНЫ АЖИЛЛАГАА, АНХААРАХ АСУУДАЛ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ АЖИЛЛАГАА

Энэхүү модуль[11] нь эрхэлдэг ажлынхаа хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүнтэй хамгийн анх нүүр тулдаг хүмүүст зориулагдсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг мөн байж болзошгүй шинж тэмдгүүд илэрч байгаа эсэхийг сайтар анзаарч, ямар арга хэмжээ авбал хохирогчийг тухайн нөхцөл байдлаас аварч, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлж болох эсэхийг мэдэхэд чиглэгдэнэ. Ихэнх тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийн үйл явцад хамгийн түрүүнд хохирогчтой нүүр тулан уулзах боломжтой хүмүүс нь цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон хөдөлмөрийн улсын хяналтын байгууллагын албан хаагчид байдаг. Хохирогчийг олж тогтоох ажиллагааг үр дүнтэй явуулахад олон талын оролцоо шаардлагатай. Үүнийг өргөн цар хүрээнд үр дүнтэй явуулж, сэжиг таамгаа баталгаажуулан, хохирогчийг гэмт хэрэгт өртөхөөс нь өмнө аварч, гэмт этгээдүүдэд хуулийн дагуу ял шийтгэл оногдуулах асуудал нь байгууллага хоорондын хамтын ажиллагаа, тэдгээрийн мэдээлэл солилцооны шуурхай байдлаас хамаардаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох нь амар ажил биш бөгөөд гэмт этгээдүүд үйлдсэн гэмт хэргийнхээ ул мөрийг баллаж, мөрдөн шалгах ажиллагааг төөрөгдүүлэхийн тулд ихээхэн хугацаа зарцуулдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг бүр харилцан адилгүй, онцлог шинжүүдтэй байдаг. Өөрөөр хэлбэл хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгүүд хэрэг болгонд ихэвчлэн өөр өөр байдлаар илэрдэг гэсэн үг юм.

11 Хүн худалдаалах гэмт хэрэгт илрэх шинж тэмдгүүд, Эрүүгийн байцаан шийтгэх албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг гарын авлагын Модуль 2-оос авав. НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

Шинж тэмдэг – нотлох баримт биш

Энэхүү модульд өгүүлж байгаа шинж тэмдгүүд бол нотлох баримт биш бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэнийг нотлох нотолгоо болохгүй. Харин тэрхүү шинж тэмдгүүдийг гярхай анзаарч, ажиглах нь дараа дараагийн алхмуудын эхлэл болох боломжтой.

1. ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД

НҮБ-ын Хүний эрхийн дээд комисс 2002 онд Хүний эрх болон хүн худалдаалах гэмт хэргийн талаар баримтлах зарчмуудыг зөвлөмж болгон гаргасан.

Энэхүү зарчимд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох явдал нь хохирогчдын эрхийг хамгаалж буй анхны алхам юм гэдгийг онцлон тусгасан байдаг. Аливаа улс орон бичиг баримт, бүртгэлгүй бүх хүнийг "хууль бус", "нууцаар хил давагсад" гэсэн ангилалд оруулаад орхих нь хялбар мэт санагдаж болох юм. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүнийг олж тогтооход хууль сахиулах албан хаагчид, тэдэнтэй хамтран ажилладаг байгууллагуудаас ихээхэн хүчин чармайлт, мэргэжлийн чадвар шаарддаг. Хохирогчийг таних, олж тогтоох үйл явц, түүний ач холбогдлыг ойлгох нь уг гэмт хэрэгт өртсөн хүн, гэмт этгээдийн аль алинд нь хуулийн нэрийн өмнөөс шударгаар хандахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Зарчим 2: Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүнийг болон гэмт этгээдийг олж тогтоох нь

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүнийг зохион байгуулалттайгаар мөлжихөөс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Хүн худалдаалах гэмт хэргийг хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдлээс ялгадаг бас нэг чухал хүчин зүйл нь уг гэмт хэргийн туршид эсвэл аль нэг шатанд тухайн хүнийг мөлжиж, ашиг олохын тулд хүч хэрэглэж, хууран мэхэлж буй байдал илрэх явдал юм. Дээрх хоёр хэргийг хооронд нь ялгах бусад элементүүд заримдаа нэлээд тодорхой, ойлгомжтой байдаг ч мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр хэргийг нотлох амаргүй байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эрт илрүүлж чадаагүйгээс шалтгаалан, тухайн хүний эрх ашиг зөрчигдөх бусад нөхцөл, бололцоог бий болгодог. Ийм учраас улс орнууд энэ тал дээр анхаарал хандуулан ажиллах үүрэгтэй.

Мөн түүнчлэн хохирогчийг эрхшээлдээ байлгаж, мөлжлөг үйлдэж байсан гэмт этгээдүүдийг шалгаж, тохирох ял шийтгэл оноох үүрэгтэй.

Улс орнууд, шаардлагатай тохиолдолд засгийн газар хоорондын төрийн болон төрийн бус байгууллагууд дараах зүйлийг анхааралдаа авч ажиллах нь зүйтэй. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг аль болох эрт, түргэн шуурхай олж тогтоох асуудлаар цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид мөн мөрдөн шалгах ажиллагаа, хорих, цагдан хорих асуудал хариуцдаг албаны албан хаагчид, төрийн бусад холбогдох албаныханд зориулсан гарын авлага, журам боловсруулах.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох үүрэг бүхий албан хаагчид, холбогдох төрийн албаныханд дээр дурдсан гарын авлага, журмыг хэрхэн оновчтой, үр дүнтэй хэрэглэх талаар сургалт зохион байгуулах.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг илрүүлж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэхийн тулд холбогдох байгууллага, албан хаагч, төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагааг бий болгох. Энэхүү хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн

тулд зохион байгуулалт, үйл ажиллагааг албан ёсны болгох.

- Цагаачид, цагаач болох магадлалтай хүмүүст хүн худалдаалах гэмт хэрэг, түүний үр дагаврын талаар анхааруулах, шаардлагатай тохиолдолд хэрхэн туслалцаа авах талаар мэдээлэл хүргэх ажлыг тогтмол зохион байгуулах.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байх хугацаандаа аргагүй байдлын улмаас үйлдсэн гэмт хэрэг болон цагаачлалтай холбоотой хууль, тогтоомж зөрчсөн аливаа үйлдэлд гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял оногдуулахгүй байх.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ямар ч нөхцөлд аль ч хэлбэрээр цагдан хорихгүй байх.
- Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүн болон улс төрийн орогнол хүссэн цагаачдын аль алинаас цагаачлалын хүсэлт хүлээж авахдаа шийдвэрлэх үйл явц нь журмын дагуу явагдаж байгаа эсэхийг магадлахаас гадна non-refoulement буюу үл буцаах зарчмыг[12] баримталж, зөвшөөрөл олгох эсэхээ шийдвэрлэж байх.

2. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ НЬ

Хүн худалдаалах гэмт хэрэг болон хохирогчийг олж тогтоох үйл явц удаан хугацаанд үргэлжилдэг. Тухайн нөхцөл байдал нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэж байгааг тодорхой илэрхийлж болох ч ихэнх тохиолдолд ганц хоёр шинж тэмдэг л мэдэгддэг.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх, бэлгийн хүчирхийлэл болон бусад хүчирхийлэл үйлдэх гэх мэт гэмт хэргүүдийн шинжийг өөртөө агуулдаг тул эдгээр гэмт хэргээс ялган шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэл зүйн хүнд байдалд орсноосоо болоод хэдэн долоо хоногоор бүр цаашилбал хэдэн сараар ч гэмт хэргийн талаар ямар нэг мэдээлэл өгөхгүй байх нь бий.

А. Хохирогч болон бусад хүмүүс хэргийн талаар шууд мэдээлэх нь

Хохирогч (бүх төрлийн хүн худалдаалах гэмт хэрэг) хэв журмын цагдаа, цагдаагийн хэлтэст өөрөө шууд хандан өөрийнхөө нөхцөл байдлын талаар мэдээлж болно. Мөн мөлжлөгт өртөж байгаа хохирогчийн талаар ямар нэг байгууллагаас хууль сахиулах байгууллагад мэдээлэл өгөх явдал бий. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд ч уг гэмт хэргийн талаар цагдаад мэдээлэл өгөх тохиолдол цөөнгүй байдаг.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчийг аврахын тулд цагдаагийн байгууллагаас "аврагч үйлчлүүлэгчээр" дамжуулан аврах ажиллагаа зохион байгуулах нь бий. Тухайлбал, эрэгтэй "аврагч үйлчлүүлэгч" биеэ үнэлэх газарт эсвэл мөлжлөг үйлдэж байгаа хаа нэг газарт очиход нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охид/эмэгтэй түүнд гэмт хэргийн талаар мэдээлэл хүргэсэн бол "аврагч үйлчлүүлэгч" хохирогчийг цагдаагийн газарт мэдээлэх, эсвэл холбогдох төрийн бус байгууллагад хүргэж өгч, тэр талаар мэдээлэл өгдөг.

Хүн худалдаалах хэргийн улмаас албадан хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрт өртсөн хүний талаарх мэдээллийг хөдөлмөрийн улсын хяналтын байгууллагын албан хаагчид цагдаагийн байгууллагад хүргэх боломжтой.

Гадаадын иргэнтэй зуучлалаар гэрлэн, хүчээр биеийг нь үнэлүүлэх болон боолчлолын мөлжлөгт өртсөн хохирогчдыг тэдний гаргаж буй үйлдэл, байгаа байдал дээр нь үндэслэн хилийн боомтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын

12 Үл буцаах зарчим гэдэг нь "хүний арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн байх эсвэл улс төрийн үзэл бодол"-оосоо болж, иргэншил бүхий улс орондоо гадуурхагдах магадлалтай тохиолдолд орогнол хүсэж буй хүнийг улс орон руу нь буцаахгүй байх олон улсын эрх зүйн үндсэн зарчим юм.

албан хаагчид олж тогтоох боломж бас байдаг.

Аль ч төрлийн хүн худалдаалах гэмт хэргийн үед хохирогчийг Монгол улсаас гаргах эсвэл гаднаас хэн нэгнийг манай улсад хил нэвтрүүлэн оруулж ирэхэд, нисэх буудал болон хилийн ойр орчимд ажилладаг хилийн боомтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид сэжигтэй шинж тэмдэг анзаарвал, цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөх нь чухал юм.

Б. Хууль сахиулах ердийн үйл ажиллагаа

Хууль сахиулах байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгтэй шууд холбогдолгүй хулгай, зам тээврийн осол, хэв журмын зөрчил зэргийг шалгах зэрэг өдөр тутмын тогтмол үйл ажиллагааныхаа явцад хүн худалдаалах гэмт хэргийг олж тогтоох болон хохирогчийг олж тогтоох боломж гарч байдаг.

Үүнд дараах тодорхой ажиллагаануудыг жишээ татаж болно. Үүнд:

- Хилийн боомт болон шалган нэвтрүүлэх цэг дээр хяналт, шалгалт хийх өдөр тутмын ажиллагаа;
- Гэрч болж байгаа этгээд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох тухай мэдээлэл;
- Гэмт хэрэг үйлдчихээд байгаа этгээд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох тухай мэдээлэл;
- Өөр гэмт хэргийн хохирогч нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох тухай мэдээлэл;
- Цагдаагийн болон бусад хууль сахиулах чиг үүргийн хүрээнд хувь хүн болон тээврийн хэрэгслийг саатуулан ердийн хяналтын журмаар шалгах үйл ажиллагаа;
- Биеэ үнэлэх газар, зочид буудал, үйлдвэр, барилгын талбай болон хөдөө аж ахуйн газар зэрэг хүний биеийг үнэлүүлж болзошгүй газруудад үзлэг, шалгалт хийх тогтмол ажиллагаа;
- Интернет болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тавигдаж буй зар сурталчилгаанд хяналт тавих тогтмол ажиллагаа;
- Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа;
- Элчин сайдын яамд болон консулын газруудын өдөр тутмын үйл ажиллагаа;
- Сураггүй алга болсон хүүхэд, эмэгтэйчүүдийг эрэн сурвалжлах ажиллагаа;
- Хөдөлмөрийн улсын хяналтын байгууллагын албан хаагчдаас ажлын байруудад шалгалт хийх тогтмол ажиллагаа.

В. Хууль сахиулах тусгай ажиллагаа

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эрт илрүүлж, тэднийг мөлжлөгөөс авран хамгаалахад тусгай ажиллагаа маш чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн бөгөөд үүнд ихэвчлэн гүйцэтгэх ажлын арга хэрэгслийг ашигладаг. Үүнд дараах тодорхой ажиллагаануудыг жишээ татаж болно. Үүнд:

- Биеэ үнэлэх газар, зочид буудал, гоо сайхан, массажны газрууд, шөнийн цэнгээний газар, караоке клуб, үйлдвэр, барилга барьж буй болон хөдөө аж ахуйн эдлэн газар зэрэг сэжигтэй газруудад чиглэсэн гэнэтийн үзлэг, шалгалт хийх;
- Сэжигтэй газарт гэнэтийн шалгалт явуулж, нөхцөл байдлын талаар үнэлгээ хийхдээ хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй байдлын зэрэг холбогдох бусад байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулах;
- Тээвэрлэлтийн замын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөлтийн баримт зэргийг тээврийн болон холбооны байр, хэрэгслүүдэд үзлэг хийх замаар олж тогтоох;

- Ажиглалт хийх зэрэг тусгай ажиллагааны бусад арга хэрэгслийг ашиглах;
- Хил орчимд төлөвлөгөөт тусгай арга хэмжээ зохион байгуулах.

Г. Бусад байгууллагын оролцоо, тусламжтайгаар хохирогчийг тодорхойлох нь

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаарх мэдээллийг олон сувгаар авах боломжтой бөгөөд олон нийтэд хандан үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд үүрэг хариуцлагынхаа хүрээнд энэхүү ажлыг хийж болно. Бусад байгууллагын оролцоо нь эргээд хууль сахиулах байгууллагад хохирогчийн болон тухайн гэмт хэргийн талаар хамгийн анхны мэдээллийг өгдөг. Доорх төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах боломжтой.

- Дотоодын хууль сахиулах байгууллагууд
- Замын цагдаа
- Хилийн шалган нэвтрүүлэх алба
- Гаалийн байгууллагын албан хаагчид
- Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид
- Элчин сайдын яам, консулын газруудад байрладаг тухайн улсын хууль сахиулахын албан хаагчид
- Төрийн бус байгууллагын төлөөллүүд
- Нийгмийн халамжийн ажилтнууд
- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын төлөөлөл – аялал жуулчлалын агентлаг, зочид буудал, худалдааны тээврийн хэрэгсэл г.м
- Эмнэлгийн ажилтнууд
- Багш нар
- Эцэг эх/ Асран хамгаалагчид
- Иргэд/ Олон нийт
- Интернет үйлчилгээ үзүүлэгч
- Хэвлэл мэдээлэл

САНАМЖ:

Хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгийг нотлохдоо дараах зүйлсийг анхаарна уу.

Шинж тэмдэг бүрийг хэдэн ч янзаар тайлбарлаж болно.

Тухайн хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн гэдгийг дан ганц шинж тэмдэг нотолж чадахгүй.

Шинж тэмдгүүдийг бүхэлд нь шинжилж, үнэлэлт хийж байж хохирогч мөн эсэхийг тодорхойлох нь чухал.

Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, өөрийн нутаг орны нөхцөлөө сайн мэдэх дотоодын мөрдөн байцаагчид илэрсэн шинж тэмдгүүд дээр бодол санаагаа нэмэрлэж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн үед л дээрх ажил илүү үр дүн үзүүлнэ.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дээрх сэдвийн хүрээнд харилцан ярилцлага хийлгэнэ үү.
Хүн худалдаалах гэмт хэргийн талаар дээр дурдсан аль нэг байдлаар мэдээлэл авч байсан хувийн туршлага байгаа бол түүнээсээ бусадтайгаа хуваалцах.
Монгол улсад хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээлэл ихэвчлэн ямар байдлаар ирдэг вэ?
Монгол улсад хохирогч өөрөө хүн худалдаалах гэмт хэрэг, хүчирхийлэл, эсвэл мөлжлөгт өртөж байгаа талаараа цагдаад мэдэгдэх нь хэр түгээмэл үзэгдэл вэ? (Байгаа нөхцөл байдал, мөлжүүлж байгаа хэлбэр нь хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно гэдгийг ойлгож, мэдээгүй байх үеийг ч оруулж ярилцаарай.)
Хүн худалдаалах гэмт хэргийг мэдээлэх талаар холбогдох хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СЭДЭВ 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ТАНЬЖ ОЛОХ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД

Хууль сахиулах, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрийгөө хохирогч болчихлоо гэж мэдээлж, хэлсэн тохиолдолд л аливаа арга хэмжээ авч эхэлнэ гэдэг бол өрөөсгөл ойлголт юм. Цагдаагийн ажилтантай тааралдсан анхны мөчид өөрийнхөө нөхцөл байдлын талаар хэлж чадсан хохирогч маш цөөхөн байдгийг баримт нотолгоо харуулдаг. Ийм учраас хууль сахиулах, хил хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид сэжигтэй санагдсан хүний нөхцөл байдал, байгаа байдлыг маш нарийн ажиглаж, мэдэгдэж байгаа хүчин зүйлд үндэслэн тэнцвэртэй үнэлгээ хийх нь маш чухал юм.

Хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүйг тодорхойлох зарим шинж тэмдгүүдийн талаар доор өгүүлэх болно. Эдгээр шинж тэмдгийг ерөнхийд нь гаргаж тайлбарлаж байгаа тул хүн худалдаалах гэмт хэрэг бүрд ашиглах боломжгүй байж болохыг анхаарна уу.

Хүн худалдаалах гэмт хэрэг олон хэлбэр, арга барилаар үйлдэгддэг бөгөөд хохирогч ч янз бүр байдаг. Ижил төрлийн гэж болохоор хүн худалдаалах гэмт хэрэг ч байршлаасаа шалтгаалан ихээхэн ялгаатай байх нь бий. Гэмт хэргийн дараах шинж тэмдгүүдийг тухайн улс орны онцлогт тулгуурлан ашиглаж байж үр дүнгээ өгнө.

Нас

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй хүмүүсийн насны ангилал уг гэмт хэргийн мөн чанар, мөлжлөгийн эрэлт хэрэгцээнээс хамаарч янз бүр байдаг. Зарим тохиолдлыг эс тооцвол, тухайн хүний нас хэдий чинээ өндөр байна уг гэмт хэрэгт өртөх магадлал төдий чинээ бага байдаг. Гэмт этгээдүүд хөгшин, настай хүмүүсийг бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор худалдаалах сонирхолгүй байдаг учир нь тэд "үйлчлүүлэгчийн хэрэгцээ"-нд нийцдэггүй.

Албадан хөдөлмөр эрхлүүлэх үед ч мөн адил нас өндөр байх тусам хөдөлмөрийн бүтээмж багатай байдаг тул тэднийг боолын хөдөлмөр эрхлүүлэх, түүнтэй ижил нөхцөл байдалд байлгаж мөлжих явдал бага байдаг.

Хүүхдүүд хүн худалдаалах гэмт хэргийн хамгийн түгээмэл хохирогч болж, бэлгийн мөлжлөгт өртөх, гуйлга гуйх, гэрийн үйлчлэгч болох зэрэг хууль бус хөдөлмөр эрхлэх, олон төрлийн мөлжлөгт өртөх өндөр магадлалтай эмзэг бүлэгт тооцогдож явдаг.

Жендер

Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт эмэгтэйчүүд ихэвчлэн өртдөг бол албадан хөдөлмөр эрхлүүлж, хүний хөдөлмөрийг мөлжихөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь өртдөг. Ямар төрлийн хөдөлмөр эрхлүүлэх гэж байгаатай уялдан аль хүйсийн хүмүүс илүү өртдөг вэ гэдэг үзүүлэлт өөр өөр гардаг.

Сүүлийн үеийн байдлаар хүүхдүүдийг тухайн улс дотроо эсвэл гадаад улсад аваачиж, бэлгийн мөлжлөгт оруулах, арилжааны болон арилжааны бус садар самуун сурталчилгаанд ихээр оруулах болсон хандлага ажиглагдаж байна. Энэ гэмт хэрэгт эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн аль аль нь өртөж байна.

Хохирогчдын үндсэн харьяалал

Хохирогч нийлүүлэлтийн сүлжээ нь ядуурал, ялгаварлан гадуурхалт, аливаа боломж хязгаарлагдмал байх зэрэг хүчин зүйлсийн нэгдэл дээр түлхүү тулгуурладаг .

Хүн худалдаалах гэмт хэрэг улс дотроо, хил дамнасан байдлаар төрөл бүрийн зорилготойгоор үйлдэгддэг. Сүүлийн үеийн судалгаа, гэмт хэргийн тайлангаас харахад хөгжингүй орнуудын хүмүүс ч албадан хөдөлмөрлүүлэх зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж байна. Гэвч энэ тохиолдолд ч гэсэн хохирогч нь тухайн улсын эмзэг бүлгийн иргэн байдаг.

Бичиг баримт

Бичиг баримт бол нотолгоо болгоход хамгийн эргэлзээтэй зүйлсийн нэг бөгөөд болгоомжтой хандах ёстой асуудал юм. Хүн худалдаалах гэмт хэргийн сүлжээний газар зүйн цар хүрээнээс хамаарч бичиг баримт ашиглах эсэхэд нөлөөлнө. Ерөнхийдөө хэдий чинээ хол зорчино, төдий чинээ бичиг баримт, биеийн байцаалт ашиглах шаардлагатай болдог.

Хил нэвтрэх үедээ бусдын биеийн байцаалт, аяллын бичиг баримт ашиглах нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэж буйг харуулах үндсэн шинж тэмдэг болдог. Үүнээс гадна, биеийн байцаалт, аялж жуулчлах ямар ч бичиг баримтгүй байх эсвэл хуурамч бичиг баримттай байх нь хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүй томоохон шинж тэмдэг болж өгдөг. Бичиг баримтыг нь өөр хүн хурааж авсан, барьцаанд авсан байх зэрэг нь тухайн хүн бусдын хяналт, дарамтад байгааг илэрхийлж байдаг бөгөөд хохирогч бичиг баримтгүй байх явдал бол хүний наймаанд өртсөн байх өндөр магадлал байна гэсэн үг.

Хохирогчийн сүүлийн байршил

Биеэ үнэлэх газар, массажны газар, гоо сайхны салон, караоке баар, мөн хөдөлмөрийг нь мөлжиж байж болзошгүй айлын гэр, ресторан гал тогоо, уурхай, карьер, хөдөө аж ахуйн болон барилга байгууламжийн талбай зэрэг хохирогч олдсон тэр газар нь өөрөө гэмт хэрэг үйлдэгдэж байж болзошгүй тул хууль сахиулах байгууллагынхан анхааралдаа авах нь зүйтэй.

Тээвэрлэлт

Тухайн хүнийг хэрхэн тээвэрлэж, дамжуулж байгаа нь мөн л уг гэмт хэргийн гол шинж тэмдэг болдог. Хүргэх ёстой газраа хүргэж, мөлжлөгөө эхлүүлж байж, үр шимийг нь хүртдэг учраас гэмт этгээдүүд хохирогчийг элсүүлэхээс эхлээд зорьсон газраа аваачих хүртэлх бүхий л тээвэрлэх үйл явцыг хяналтдаа байлгахыг ихээхэн чухалчилдаг. Анхаарах ёстой өөр нэг шинж тэмдэг бол хохирогчийг хил нэвтрүүлэх үедээ байнга хүн дагалдуулах хандлагатай байдаг ба цөөн тохиолдолд тэднийг олон тооны хүнээр харгалзуулж, зорьсон газраа ойртох тусам хараа хяналтаа илүү ихээр чангатгаж байдаг.

Хүчирхийллийн шинж тэмдэг

Хохирогчийн бие махбодод хүчирхийллийн ул мөр илэрсэн шинж тэмдэг нь хүн худалдаалах гэмт хэрэг мөн байж болзошгүйг илэрхийлэх боломжтой бөгөөд үүнийг гэмт этгээд, үйлчлүүлэгч нь учруулсан байх магадлалтай байдаг. Энэ нь хохирогч бие махбоддоо ямар нэг гэмтэл бэртэл аваагүй, шарх сорвигүй харагдаж байгаа бол хүн худалдаалах гэмт хэрэгт өртөөгүй гэсэн үг биш юм. Айлган сүрдүүлэх, хүчирхийлэх, бичиг баримтыг нь хураасан байх нь мөн гэмт хэргийн шинж тэмдэгт орж болно.

Зан байдал

Асуултад хариулахдаа зайлсхийх, булзааруулах, айсан, уурласан, сэтгэлээр унасан, гутарсан

байдалтай харагдах эсвэл урьдчилан бэлтгэсэн, давтсан байдлаар асуултад хариулах зэрэг сэжигтэй үйлдэл гаргаж байгаа эсэхийг хууль сахиулах албан хаагч, хил гаалийн болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид маш анхааралтай ажиглах хэрэгтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог шинж тэмдгүүд

Доор дурдсан шинж тэмдгүүд хүн худалдаалах гэмт хэрэг бүрд илэрнэ гэсэн үг биш юм. Эдгээрийн аль нэг нь илрэх эсвэл илрэхгүй, анзаарагдахгүй байх нь хүн худалдаалах гэмт хэрэг болсон эсэхийг нотлохгүй мөн үгүйсгэхгүй ч илэрсэн тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг эхлүүлэх нь зүйтэй гэдгийг сануулж байгаа юм.[13]

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй хүмүүст илрэх шинж:

- Өөрсдийнхөө хүсэл сонирхлоор бус хүчээр ажиллаж байгаа гэж боддог;
- Ажиллаж байгаа газраа орхих боломжгүй;
- Тэдний үйл хөдөлгөөнийг хянаж байгаа байдал ажиглагдсан;
- Орхин явж чадахгүй гэж боддог;
- Айдас, санаа зовнилтой;
- Хүчирхийлэлд өртсөн эсвэл өөрт нь, гэр бүлийнхэнд нь, хайртай хүмүүст нь хүч хэрэглэнэ хэмээн заналхийлсэн;
- Хүчирхийллийн улмаас биед нь бэртэл гэмтэл үүссэн;
- Бусдын эрхшээлд байхдаа эсвэл тодорхой ажил үүргээс үүдэж авсан бэртэл, гэмтэлтэй байх;
- Эрхшээлдээ байлгахын тулд авсан арга хэмжээнээс үүдсэн байх магадлалтай гэмтэл анзаарагдах;
- Хууль сахиулах ажилтнуудад итгэхгүй байх;
- Хууль сахиулах ажилтнуудад шилжүүлэн өгөх үед айсан байдалтай байх;
- Цагаачлан орчин суух статусынхаа талаар мэдээлэл өгөхдөө айдастай байх;
- Биеийн байцаалт, бичиг баримт нь өөрт нь биш бусдын гарт байх гаа;
- Хуурамч биеийн байцаалт, бичиг баримттай байх;
- Хүнийг мөлжиж ашиг олдог газар, байршилд байх;
- Тухайн газар нутаг, улс орны хэлээр ярьдаггүй байх;
- Гэрийнхээ болон ажлын газрынхаа хаягийг мэдэхгүй байх;
- Нэрийг нь цохон асуулт асуух үед өөрөө биш бусдаар төлөөлүүлэн яриулах;
- Хэн нэг хүн зааварчилгаа өгөөд байгаа мэт байх;
- Тодорхой нөхцөл байдалд ажиллуулахаар хүчилсэн байдалтай байх;
- Шийтгэлээр дамжуулж үгэндээ оруулдаг байх;
- Ажиллах нөхцөл байдлынхаа талаар хэлэлцэж, тохиролцох боломжгүй байх;
- Бага хэмжээний цалинтай эсвэл огт цалин хөлс авдаггүй байх;
- Олсон орлогоо захиран зарцуулах мэдэлгүй байх;
- Урт хугацааны турш хэтэрхий олон цагаар ажилладаг байх;
- Амралтын өдөр байхгүй байх;
- Стандартын бус, тааруу орон сууцанд амьдардаг байх;
- Эрүүл мэндийн аливаа үйлчилгээ авах эрхгүй байх;
- Нийгэмтэй харилцах боломжгүй, байсан ч маш хязгаарлагдмал хүрээнд байх;

13 Хүн худалдаалах гэмт хэрэгт илрэх шинж тэмдгүүд, Эрүүгийн байцаан шийтгэх албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг гарын авлагын Модуль 2, хуудас 9-13-аас авав. НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

- Гэр бүлийнхэнтэйгээ болон гаднын хүмүүстэй бараг харилцаагүй байх;
- Бусадтай чөлөөтэй харьцах боломжгүй;
- Бусдад өрөө барагдуулж байгаа хүн шиг харагддаг байх;
- Бусдаас хамааралтай амьдардаг байх;
- Хүн худалдаалах гэмт хэргийн эх үүсвэрт тооцогддог газраас ирсэн байх;
- Тээвэрлэгдэж ирсэн зардлаа төлөхийн тулд тухайн газар ажил хийх эсвэл үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болсон байх;
- Хуурамч амлалтад итгэн, хуурцсан байх.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд илрэх шинж тэмдэг.

- Эцэг эхтэйгээ болон асран хамгаалагчтайгаа уулзах боломжгүй байх;
- Айлгаж, сүрдүүлсэн байж магадгүй харагдаж, үеийнх нь хүүхдүүдээс гарамгүй ааш, үйлдэл гаргаж байх;
- Ажлаасаа гадуур үеийн найз нөхөдгүй байх;
- Сургуульд явдаггүй байх;
- Тоглож наадах цаг байдаггүй байх;
- Стандартын бус орон байранд бусад хүүхдээс салангид нь байлгадаг байх;
- "Гэр бүл"-ээсээ тусдаа хооллодог байх;
- Үлдэгдэл хоолоор л хооллодог байх;
- Хүүхдэд тохиромжгүй ажилд оролцдог шинжтэй байх;
- Насанд хүрсэн хүнгүйгээр зорчдог байх;
- Хамаатан садан нь биш огт хамааралгүй цуг явдаг байх.

Дараах шинж тэмдгүүд хүүхэд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүйг харуулна:

- Хүүхдэд таарах хэмжээтэй садар самууны зориулалттай хувцас, хэрэглэл байх;
- Биеэ үнэлэх газар, үйлдвэр зэрэг хүүхэд байх ёсгүй газарт тоглоом, хүүхдийн ор, жижиг хувцас байж таарах;
- Дагалдаж яваа насанд хүрэгч хүн хүүхдийг ганцаараа явж байхад нь олсон мэтээр тайлбарлах;
- Такси дуудах утасны дугаар барьсан, харж хандах байгаа хүнгүй хүүхэдтэй тааралдах;
- Хууль бусаар хүүхэд үрчилж авсан талаар мэдээлэл ирэх.

Айлын гэрт боолын хөдөлмөр эрхэлж байж болзошгүй хүмүүст илэрч болох шинж тэмдгүүд:

- Ямар нэгэн айлд амьдардаг байх;
- Гэр бүлийн бусад гишүүдтэй хамт хооллодоггүй байх;
- Өөрийн гэсэн өрөө гэх зүйл байхгүй байх;
- Хэн нэгэнтэй хамт эсвэл тохиромжгүй, тухгүй өрөөнд амьдардаг байх;
- Ажил олгогчийнхоо гэрт амьдарсан хэвээр байгаа ч ажил олгогч нь түүнийг сураггүй алга болсон гэж мэдээлсэн байх;
- Хүнтэй уулзахаар гэрээсээ маш ховор гардаг эсвэл огт гардаггүй байх;
- Ажил олгогчгүйгээр гэрээсээ огт гардаггүй байх;
- Хоолны үлдэгдлээр л хооллодог байх;
- Доромжлол, хүчирхийлэл, заналхийлэлд өртдөг байх.

Бэлгийн мөлжлөгт өртсөн байж болзошгүй хүмүүст илрэх шинж тэмдгүүд:

- Байршил болон зах зээлийнхээ хэрэгцээнээс насны хувьд шалтгаалах боловч ямар ч

насны хүн байх боломжтой;
- Нэг биеэ үнэлэх газраас нөгөө рүү шилжих байдлаар эсвэл нэг газраа суурин биш өөр өөр газар ажилладаг;
- Ажилдаа явах болон ирэхдээ, гадуур ямар нэг байдлаар гарах шаардлага гарсан зэрэг үед харгалзах хүнтэй явдаг байх;
- Ихэвчлэн уртасгасан цагаар ажилладаг, маш цөөн өдрөөр амардаг байх;
- Ажилладаг газраа байрладаг байх;
- Бөөнөөрөө амьдардаг, ийш тийшээ явахдаа олуулаа явдаг бөгөөд нэг хэлээр ярьдаггүй эмэгтэйчүүдтэй хамт байдаг;
- Үйлчлүүлэгч татахад зориулсан хувцас, хэрэглэлийг ихэвчлэн хэрэглэдэг байх;
- Биедээ бэлэн мөнгө авч явдаггүй ;
- Биеийн байцаалт, бичиг баримт байхгүй байх.
- Тухайн хүнийг худалдсан, худалдан авсан талаар ямар нэгэн баримт, нотолгоо байх;
- Хэсэг бүлэг эмэгтэйчүүд бусдын эрхшээл, хараа хяналт дор байгаа нь илэрхий байх;
- Биеэ үнэлэх газар болон түүнтэй ижил үйл ажиллагаа явуулдаг газрын зар сурталчилгаанд аль нэг үндэстэн ястан, улс орны эмэгтэйчүүд танд зориулж үйлчилгээ үзүүлнэ хэмээн онцгойлон сурталчилсан байх.

Хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор худалдаагдсан хүмүүсийн шинж тэмдэг (Хөдөө аж ахуй, барилга, зугаа цэнгэл, үйлчилгээний байгууллага болон үйлдвэрлэл явуулдаг газруудад ихэвчлэн ажиллуулдаг):

- Ажил эрхэлдэг тухайн газраа бөөнөөрөө амьдардаг, тэр газраасаа хэр баргийн бол гарахгүй эсвэл огт гардаггүй байх;
- Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн гэх зэрэг зориулалтын бус, тав тухгүй, муу нөхцөлд амьдардаг байх;
- Хийж байгаа ажилдаа тохирсон хувцас, хэрэглэлгүй байдаг. Тухайлбал: Зориулалтын хамгаалах хэрэгсэл, зузаан хувцасгүй байх;
- Хоолны үлдэгдлээр л хооллодог байх;
- Орлогоо хянан зарцуулах эрхгүй байх
- Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байх;
- Маш олон цагаар ажилладаг байх;
- Юу хийх, хаагуур явах, хаана амьдрах зэрэг нь ажил олгогчоос бүрэн хамааралтай байх;
- Хаана, юунд амьдрахаа сонгох эрх байхгүй байх;
- Ажил олгогчгүйгээр гэрээсээ огт гардаггүй байх;
- Чөлөөтэй зорчих эрх мэдэл байхгүй байх;
- Ажлын байран дээр нь байлгах зорилготой харуул хамгаалалтын арга хэмжээ авсан байх;
- Торгуулах, шийтгүүлэх замаар сахилга баттай байдаг;
- Доромжлол, хүчирхийлэл, заналхийлэл, айлган сүрдүүлэг дор байх;
- Анхан шатны ямар нэг сургалтад хамрагдаагүй, мэргэжлийн үнэмлэх гэрчилгээгүй байх.

Дараах шинж тэмдгүүд ч мөн адил тухайн хүн хөдөлмөрөө мөлжүүлж буйг илэрхийлж болно:

- Тавигдсан мэдээлэл, зар зэрэг нь тухайн орон нутгийн хэлнээс өөр байх;
- Түүнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэдээлэл тусгагдаагүй байх;
- Ажил олгогч эсвэл хариуцсан менежер нь өөр орноос авчран ажиллуулж байгаа хүмүүсийнхээ бичиг баримтыг үзүүлэхгүй байх;

- Ажил олгогч эсвэл хариуцсан менежер нь ажилчдынхаа цалингийн бүртгэлийн мэдээллийг үзүүлэхгүй байх;
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж байхгүй, эсвэл байгаа нь чанарын хувьд шаардлага хангахгүй байх;
- Тухайн тоног төхөөрөмжийг хүүхдэд зориулан гаргасан эвсэл хүүхэд ажиллахад тохируулан өөрчилсөн байх;
- Хөдөлмөрийн тухай хууль зөрчиж байгаа нь илэрхий байвал;
- Авах ёстой цалин, хөлснөөс нь хөдөлмөрийн багаж хэрэгсэл, хоол, орон байрны мөнгө суутгаж авч байгаа баримт байгаа тохиолдолд.

Гуйлга гуйлгах, хөнгөн гэмт хэрэг үйлдүүлэх зорилгоор худалдагдсан байж болзошгүй хүмүүст илрэх шинж тэмдгүүд:

- Олон нийтийн газар, зорчигч тээврийн газруудад ихэвчлэн гуйлга гуйж тааралддаг хүүхэд, настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байх;
- Хууль бус мансууруулах бодис авч яваа/зарж байгаа хүүхдүүд байх;
- Зодож, тамлах байдлаар бие махбодыг нь эрэмдэг болгосон байж болзошгүй байх;
- Нэг үндэстэн, ястнаас гаралтай олон хүүхдийг насанд хүрсэн цөөн хүн харгалзаж явах;
- Хохирогчтой нэг үндэстэн эсвэл нэг улсаас гаралтай насанд хүрэгч тухайн хүүхдийг "олсон" гэж мэлзэх;
- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо бөөнөөрөө явдаг байх;
- Зохион байгуулалттай бүлэг гэмт этгээдүүдийн үйл ажиллагаанд оролцдог байх;
- Насанд хүрсэн нэг харгалзагчийн хараа хяналтад байгаа бүлэг хүүхдүүдийн нэг хэсэг нь болсон байх;
- Хангалттай хэмжээнд мөнгө олж, хулгайлж чадахгүй бол шийтгүүлдэг байх;
- Гэмт бүлэглэлийн гишүүдтэйгээ хамт амьдардаг байх;
- Гэмт бүлэглэлийн гишүүдтэй хамт хүлээн авагч улс оронд очсон байх;
- Эцэг, эх нь биш насанд хүсэн хүмүүстэй гэмт бүлэглэлийн гишүүний хувиар хамт амьдардаг байх;
- Өдөр бүр бүлгээрээ тодорхой замыг туулж зорчдог байх.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчидтай дараах сэдвээр ярилцлага өрнүүлнэ үү.
Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг амжилттай олж тогтоож байсан шинэ содон арга, туршлагаасаа бусадтайгаа хуваалцах.
Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байх үед хохирогчийг олж тогтоох үед тохиолдож байсан хүндрэл, бэрхшээлийнхээ талаар хуваалцах.
Хохирогч тодорхойлох шинж тэмдгүүдтэй хамаатай дасгал ажил дээр үндэслэж богино хэмжээний яриа өрнүүлэх.
Өгөгдсөн сэдвээр яриа өрнүүлснийхээ дараа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илэрч буй шинж тэмдэгт үндэслэн тогтооход чиглэгдсэн дасгал ажил ажиллуулна. Суралцагчдаас дээр өгүүлсэн шинж тэмдгүүдээс аль аль нь илэрч байгааг гаргуулна.

ДАСГАЛ АЖИЛ 2 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс дасгал ажил ажиллах үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол байх хэрэгтэйг анхаарна уу.

Зорилт: Хүн худалдаалах болон хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох .

Сургалтын хэрэглэгдэхүүн: Тараах материал, самбар, самбарын үзэг

Дасгал ажил: Суралцагчдыг хоёр баг болгон хувааж, хоёр өөр дасгал ажил дээр ажиллуулна. Багууд бэлтгэсэн дасгал ажлаа уншаад, өөрийгөө үнэлэх хэсэгт өгсөн асуултын дагуу багийн ярилцлага хийнэ. Багийн гишүүд ярилцаж дуусаад, аль нэг гишүүн нь баг дотроо ярилцсан зүйлээ бусадтайгаа хуваалцана. Дасгал ажил дууссаны дараа хоёр багийн ярьсан зүйлийг товчлон дахин ярина. Хүн худалдаалах болон хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн гол ялгаануудыг дахин сануулж ярих бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг зөв тодорхойлох нь тухайн гэмт хэргийг хууль ёсны дагуу шударгаар шийдвэрлүүлэх анхны алхам болох талаар онцолж тайлбарлаарай.

Хугацаа: 60 минут (30 минут баг дунд нь яриулаад, үлдсэн 30 минутад нь баг бүрээс төлөөлөл гарган юу ярилцсан талаар бусадтай нь санал солилцуулна.)

ТОХИОЛДОЛ

Баатар 28 настай, эрхэлсэн ажилгүй хүн. Их сургууль төгссөн боловч өөрийн төрж өссөн Чойбалсан хотдоо ажил олж чадаагүй. Эцэг, эх нь Баатарыг удаан хугацаанд мөнгө санхүүгээр дэмжсээр байх боломжгүй тул ажил олж хий гэж байнга үглэдэг байлаа. Шальдар булдар ажил хийдэг ч арай дээр ажил хайсаар л байв. Нэг өдөр найзынх нь найз болох Гансүх түүн дээр ирж, Шведэд байрлах гадаадын компанид нягтлан бодогчоор ажиллах санал тавив.

Баатар Швед рүү цагаачлах тал дээр шийд гаргаж чадахгүй байсан ч гурван жилийн гэрээтэй, өндөр цалинтай нягтлан бодогчоор ажиллах боломжтой гэсэн Гансүхийн үг түүний эргэлзээг арилгаж, явахаар сэтгэл шулуудлаа. Түүнд Шведийн нэгэн компанид тогтмол ажлын цагтай, жилийн 1 сар амрах эрхтэй ажлын саналыг тавьсан байв. Тэр Швед рүү цагаачлахаар болж, Гансүхэд бүх бичиг баримтаа өгсөн бөгөөд Гансүх энэ бүгдэд тусалсныхаа хариуд тодорхой хэмжээний мөнгө авахаар тохирсон байлаа.

Баатар 2017 оны 3 сард Шведэд очлоо. Түүнийг нисэх буудалд буунгуут ажиллахаар болсон компанийнх нь төлөөлөгч бичиг баримтыг нь хураан авч, энэ үйлдлээ "аюулгүй газар бичиг баримтыг нь хадгалах", "захиргааны ажил хэрэгт зориулж" гэж тайлбарлав. Маргааш нь ажиллах газраа очоод, нягтлан бодогч биш "хар" ажилд тооцогддог барилгын ажил хийхээр болж байгаагаа ойлгов.

Тэр ажиллахгүй гэж эсэргүүцэл үзүүлсэн боловч өдөрт 16 цаг хүчээр ажиллахаас өөр аргагүй болов. Сарын цалин гэж маш бага зүйл гар дээрээ авсан нь хоол хүнс, орон байр зэрэг амьдрах өртгөө төлж дийлэхгүй шахуу байлаа. Бодож байсан шигээ гэр лүүгээ мөнгө явуулж чадсангүй. Бичиг баримтыг нь хурааж авсан тул ажлаасаа гарах, ийш тийшээ өөрийн дураар явах боломжгүй байв. Өөрийг нь ахлан ажиллаж байсан Швед ажилтан хэлэхдээ ажил олгогч нь нэр нөлөө бүхий хүн учраас цагдаад мэдэгдээд нэмэргүй гэж түүнд сануулав. Бүтэн жил ийм байдалтай ажилласны эцэст Баатар Шведийн цагдаагийн газар зориглон очиж, нөхцөл байдлынхаа талаар үнэнийг хэллээ. Хууль дүрмийн дагуу Баатарыг Монгол руу буцаасан бөгөөд тэр Гансүхийн эсрэг гомдол гаргасан байна.

Өөрийгөө үнэлэх асуултууд

1. Баатар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж, албадан хөдөлмөр эрхэлсэн эсэхийг тодорхойлох ямар ямар шинж тэмдэг байна вэ? Жагсаалт гаргана уу.

2. Монгол улсын хууль тогтоомжид хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсны дагуу ямар ямар гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэх вэ?
3. Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу Баатар Гансүхийн эсрэг ямар нэг арга хэмжээ авах боломжтой юу? Хэрэв тийм бол хуулийн дагуу ямар арга хэмжээ авах вэ?
4. Баатар Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд Швед дэх ажил олгогчийнхоо эсрэг ямар нэг арга хэмжээ авхуулах боломжтой юу?
5. Яг ижил нөхцөл байдалд орж, хохирогч болсон өөр хүмүүс Шведэд байгаа бол Монголын хууль сахиулах байгууллагын ажилтнууд ямар арга хэмжээ авах боломжтой вэ?

ДАСГАЛ АЖИЛ 3 – ХҮНИЙГ/БУСДЫГ ХИЛ НЭВТРҮҮЛЭХ

ТОХИОЛДОЛ

Мөнхбат 20 настай, сургуулиа дүүргэсэн залуу бөгөөд гэр бүлийн хамт Алтайд амьдардаг. Тэр цахилгаанчин гэх мэт олдсон ажлаа л хийдэг бөгөөд гадаадын оронд ажилладаг хүмүүс өндөр цалин авдаг гэж олонтоо сонсжээ. Тэрээр Канад руу явж ажиллахыг хүссэн бөгөөд зуучлах компаниар дамжуулан виз мэдүүлсэн боловч материал нь дутуу байсан тул хоёр удаа татгалзсан хариу авчээ.

Зуучлалын байгууллага түүнийг Одбаяртай холбож өгөв. Одбаяр өөр арга хэрэглэн Мөнхбатыг Канад руу гаргаж чадна гэж амлаад, ингэснийхээ хариуд 10,000 ам.доллар авна гэж хэллээ. Мөнхбат аваасаа үе дамжин ирсэн тариалангийн талбайгаа зарж, Канад явахад шаардлагатай мөнгө олж өгөхийг дахин дахин гуйж байв.

Одбаяр Мөнхбатад Туркийн визтэй паспорт гаргуулж Турк рүү явуулав. Түүнийг Туркээс өөр нэг хүн тосож аваад, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэдэг том оврын машинаар Грек рүү авч явжээ. Грекээс Канад руу гаргахыг завдах үед хил дээр шалгалт явагдаж машинаас Мөнхбатыг өөр таван хүний хамт олжээ. Шаардсан бичиг баримт болон Грек рүү нэвтрэх виз байгаагүйгээс Мөнхбат баривчлагдаж, одоо шоронд хоригдож байгаа юм байна.

Өөрийгөө үнэлэх асуултууд

1. Хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг байж болзошгүйг илтгэх ямар ямар шинж тэмдгүүд байна вэ? Энэхүү хэрэг хүн худалдаалах гэмт хэрэг биш гэдэгт итгэлтэй байна уу? Хүнийг/бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг гэдгийг илтгэх шинж тэмдгүүдийг жагсааж бичнэ үү.
2. Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу Одбаяр болон зуучлалын байгууллагад ямар нэгэн хэрэг үүсгэх боломжтой юу?
3. Мөнхбат Монгол улсын хууль тогтоомжийг үндэслэн Одбаяр болон зуучлалын байгууллагад ямар нэгэн арга хэмжээ авхуулах боломжтой юу? Хэрэв тийм бол Одбаярт хуулийн дагуу ямар ямар арга хэмжээ авах вэ?
4. Яг ижил нөхцөл байдалд орж, Мөнхбат шиг хохирогч болсон өөр хүмүүс байвал Монголын хууль сахиулах байгууллагын ажилтнууд ямар арга хэмжээ авах боломжтой вэ?

СЭДЭВ 3: НУУЦ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, АШИГЛАХ

ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХОД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ[14]

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоож, гэмт хэргийн сүлжээ, гинжин хэлхээг таслахын тулд гүйцэтгэх ажлын болон энэ төрлийн гэмт хэрэг дээр ажиллах үүрэгтэй байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо чухалд тооцогддог. Сурталчилгаа хийх, хөлслөх, тээвэрлэх, хоорондоо харилцах, санхүүгийн гүйлгээ хийх зэрэг үйлдлийг хийхгүйгээр зохион байгуулалттай сүлжээг бий болгон, үйл ажиллагаа явуулах боломжгүй юм. Эдгээр үйлдлүүдээр нь дамжин гүйцэтгэх ажил явуулах боломж хууль сахиулах байгууллагын ажилтнуудад байдаг.

Сүүлийн хэдэн жилд хурдацтайгаар тархсан интернетийн хэрэглээний тэсрэлт нь гэмт этгээдүүдэд санхүүгийн хувьд олз олох боломжийг бий болгоод байна. Өндөр технологи ашиглан гэмт хэрэг үйлдэх явдал өссөн нь хууль сахиулах байгууллагын хувьд харьцангуй шинэ үзэгдэл бөгөөд сорилт болж байгаа юм. Гэмт бүлэглэлүүд, гэмт этгээдүүд өмнөхөөсөө илүү арга барилаар ажилладаг болсон. Хууль сахиулах байгууллагын өмнө тулгарч буй асуудал нь ийм төрлийн гэмт хэргийн нөлөөллийг бууруулахын тулд илүү ухаалаг байдлаар өөрсдийнхөө үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага тулгарч байгаад оршино.

Гэмт этгээдүүдтэй холбоотой гүйцэтгэх ажил зохион байгуулах нь хохирогчдыг олж тогтооход тус болохоос гадна тэдний дотоод үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болгож, хохирогчдыг хамгаалах цаашлаад гүйцэтгэх ажлаар баримжаалсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад ашиг тусаа өгдөг. Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байх үед, гүйцэтгэх ажлыг дараах асуудлуудад чиглүүлэх шаардлагатай:

- Ямар аргаар хохирогчийг элсүүлж байна вэ? (хуурч залилах, айлган сүрдүүлэх, хулгайлах, хүч хэрэглэх г.м)
- Гэмт этгээдүүд хаанаас гаралтай хүмүүс байна вэ? (тухайн улсынх, гаднын хүн г.м.)
- Тээвэрлэх үйл явц нь ямар байсан бэ? (тусгайлсан маршрут ашигладаг, төмөр зам, автобус г.м ашигладаг тээврийн хэрэгсэл)
- Ямар төрлийн мөлжлөг давамгайлж явагдаж байгаа талаар (албадан хөдөлмөр, бэлгийн мөлжлөг г.м)
- Мэдээллийн ямар сувгаар сурталчилгаагаа хийж байна вэ? (хэвлэмэл материал, аман байдлаар, утсанд мессеж илгээх, интернетээр г.м)
- Ямар төрлийн бичиг баримт болон виз (хил дамнуулан худалдаалах үед) түлхүү ашиглагдаж байна вэ? Түүнийг хэрхэн, яаж бэлтгэж, олж авдаг талаар мэдэж авах.
- Ямар төрлийн орон байранд байрлуулдаг вэ? (хаана байрладаг, хэн байрлуулдаг талаар)
- Харилцаа холбооны ямар аргуудыг ашиглаж байна? (и-мэйл, гар утас, факсын машин г.м)
- Санхүүгийн үйл ажиллагаа нь ямар байдлаар явагдаж байна? (дээр дурдагдсан бүх үйлдэлтэй холбогдуулан шилжүүлэг хэрхэн хийж байгаа зэрэг)
- Гадаад болон дотоодод хүн худалдаалах хамгийн сүүлийн үеийн чиг хандлага ямар

14 Эх сурвалж: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, Нэгдсэн Үндэсний Байгууллагын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, 2006; Хууль сахиулах албан хаагчдад зориулсан эрүүгийн тагнуулын гарын авлага, Нэгдсэн Үндэсний Байгууллагын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, 2010.

байна вэ? (онлайнаар элсүүлэх, гар утас ашиглах, биеийг нь үнэлүүлэх хэрэгцээ шаардлага, онлайнаар санхүүгийн үйл ажиллагаагаа явуулах г.м)

- Гүйцэтгэх ажил явуулахаар шийдвэрлэсэн бол хохирогчид ямар эрсдэл учирч болох, түүнийг зохицуулж болох эсэх талаар мэдээлэлтэй байх.
- Хил, гааль, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчидтай хамтран илүү их мэдээлэл олох боломж байгаа эсэх талаар судлах. (Эдгээр байгууллагуудын гадаад дахь төлөөллөөр дамжуулан мэдээлэл солилцох гэх мэт.)
- Мөлжлөгт өртөж, гэмт хэргийн хохирогч болсон хүмүүсээс уг гэмт хэргийн хохирогч болж болзошгүй бусад хүмүүсийн талаарх мэдээллийг авч болох эсэх.

Хүн худалдаалах гэмт хэргийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ, тойрогт нөлөө үзүүлж байдаг ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин зэрэг нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд (ялангуяа эмэгтэйчүүдийн), цагаачлалын хэв маяг, хэзээ ихэвчлэн тохиолдож байгаа талаар болон холбогдох бусад хүчин зүйлсийг мэдэж байх нь энэ хэргээс урьдчилан сэргийлэхэд маш их тус нэмэр болдог.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад шаардлагатай мэдээлэл өгч чадах олон эх сурвалж байдаг. Тухайлбал:

- Гэмт хэрэгт өртсөн хохирогч
- Гэмт хэрэгт өртсөн хохирогчийн гэр бүл, ойр дотнын хүмүүс, хөрш, найз нөхөд
- Гэмт хэрэгт өртсөн хохирогчтой ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд
- Орон нутгийн цагдаагийн байгууллагын ажилтнууд
- Хилийн хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид
- Цагдаагийн туслах ажилтан, мэдээлэгчид
- Сум, аймаг, хотын төрийн албаны ажилтнууд
- Нисэх, төмөр зам, автобус зэрэг үйлчилгээний байгууллагын ажилтнууд
- Таксины жолооч нар
- Зочид буудлын ажилтнууд
- Гудамжинд худалдаа эрхлэгчид, ТҮЦ-ний худалдаа эрхлэгчид
- Хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчид, эрэн сурвалжлах сэтгүүлчид
- Олон нийт.

ТЭМДЭГЛЭЛ: Дээрх жагсаалтыг жишээ байдлаар гаргасныг анхаарна уу.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчидтай дараах сэдвээр ярилцлага өрнүүлнэ үү.
Хүн худалдаалахаас өөр гэмт хэрэгт гүйцэтгэх ажил явуулж байсан туршлагаасаа хуваалцах. Энэ нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй хамааралтай байсан эсэх.
Гүйцэтгэх ажлыг чанартай явуулснаар хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадах уу?
Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд гүйцэтгэх ажлын явцад үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллах нь ямар ач холбогдолтой вэ?

СЭДЭВ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХОД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ НЬ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ[15]

Хүн худалдаалах гэмт хэргийн сүлжээ бусад гэмт хэргийн сүлжээг бодвол хохирогч, тэдний гэр бүл, ойр дотнын хүмүүс болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудад тодорхой хэмжээний эрсдэлийг олон талаар учруулж байдгаараа онцлогтой байдаг. Хохирогч хуулийн байгууллагуудтай хамтран гэм буруутай этгээдийг тогтоож ял, шийтгэл оногдуулах, хэргийг мөрдөн шалгах, гүйцэтгэх ажил лагаа явуулах, баривчлах, ярилцлага хийх, байцаалт явуулах эсхүл гэмт бүлэглэлийн дотор ажиллах үед цагдаагийн ажилтнууд өндөр эрсдэлтэй тулгарч байдаг. Тулгарч болзошгүй эдгээр эрсдэлийг урьдчилж харах, төлөвлөхөөс гадна хохирогчийг аварсан тэр даруйдаа болон мөрдөн байцаалтын туршид тодорхой стратеги боловсруулан ажиллах хэрэгтэй. Тухайн хэрэг дээр ажиллаж байгаа мөрдөгч ажил үүргийнхээ хүрээнд гэмт хэргийн хохирогч болон бусад хүмүүст учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийж, энэхүү эрсдэлийг бууруулахын тулд боломжит бүх арга хэмжээг авах нь зүйтэй юм.

"Эрсдэл"-ийн тухай ойлголтыг энгийнээр тайлбарлавал тулгарч болзошгүй аливаа аюул, осол бодитой хэрэгжих боломж бөгөөд ямар нэг үр дагаврыг учруулах явдал юм. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээ нь тухайн аюул занал бодит болох магадлал хэр зэрэг байх вэ, учрах аюулыг багасгах, бүрэн арилгах, хохирогчийг тусгаарлах ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ гэдгийг шийдвэрлэх алхам болдог. Үйлдэгдсэн хэрэг бүр өөр өөрийн онцлогтой, сорилттой байдаг учраас тэдгээр онцлог байдлыг мэдэрч ажиллах явдал чухал юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн тухайд **"эрсдэл"**-д дараах зүйлсийг оруулж тооцдог. Үүнд:

Хувь хүн болон өмч хөрөнгийн аюулгүй байдал эсвэл үнэн зөв болон найдвартай байдалд заналхийлж байгаа бол:

- Нотлох баримтын аюулгүй байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал (Жишээлбэл, тухайн гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нотлох, үгүйсгэх аливаа зүйл);
- Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шударга, ёс зүйтэй хэрэглэх байдал;
- Байгууллагын дотоод дүрэм, журмыг шударга, ёс зүйтэй хэрэглэх байдал;

Эрсдэлийг буруу тодорхойлох болон эрсдэлийг дутуу үнэлэх нь дараах үр дагаврыг бий болгодог. Үүнд:

- Хохирогч, түүний гэр бүл, ойр дотнын хүмүүс, найз нөхдийг нь гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, хүчирхийлэх бүр цаашлаад амь насыг нь хохироох (гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох эсвэл тухайн гэмт хэргийг олж тогтоохын өмнө, олж тогтоох ажиллагааны үеэр, илрүүлсний дараа гэмт этгээд, тэдэнтэй холбоотой хүмүүсийн зүгээс);
- Бие махбод болон сэтгэл зүйн хохирол учруулах;

15 Эх сурвалж: Модуль 5: Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах эрсдэлийн үнэлгээ, Эрүүгийн мөрдөн байцаагч нарт зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009; Мөрдөн байцаагчдад зориулсан гарын авлага, Эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх, хамгаалах ажлын Интерполын ажлын хэсэг, INTERPOL, 2002.

- Мөлжих, мөлжлөгөө цааш нь лавшруулах;
- Гэмт буруугүй хүнийг хилсээр яллах, гэм буруутай этгээд ял шийтгэлээс зайлсхийх;
- Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чадамж буурах;
- Нотлох баримт болон түүнтэй холбоотой баримт сэлт алга болох, нотлох чадвараа алдах.

Эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц дараах зарчмаар явагдана. Үүнд:

- Мөрдөгч нар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх хүмүүнлэгийн үүрэг хүлээсэн байдаг;
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох Хүн худалдаалах гэмт хэргийн тухай протокол, олон улсын бусад хууль тогтоомжууд, ихэнх тохиолдолд тухайн улсын үндэсний хууль тогтоомжид хуульчлан заасан ёсоор бол мөрдөн байцаагчид мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хуулийн үүднээс туслалцаа үзүүлэх үүрэгтэй байдаг. Энэ үүргээ биелүүлэхэд хамгийн чухал хэсэг нь тогтоогдсон хохирогч эсвэл хохирогч болж болзошгүй хүмүүстэй холбоотой эрсдэлийн үнэлгээг хийх явдал байдаг.
- Хуулийн дагуу хүлээсэн хүмүүнлэгийн болоод ажил үүрэгтэй холбогдсон үүрэг, чанартай эрсдэлийн үнэлгээ зэрэг нь мөрдөн шалгах ажиллагааг амжилттай болгодог.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг анзаарсан даруйдаа эрсдэлийн үнэлгээг эхлүүлэх нь зүйтэй бөгөөд үүний дараа бусад арга хэмжээг авах хэрэгтэй;
- Мөрдөгч юу мэдэж байгаа, юуг нэмж олж мэдэх шаардлагатай байгаа вэ гэдэгт үндэслэн эрсдэлийг үнэлэх хэрэгтэйг анхаарах нь зүйтэй.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол

6-р зүйл – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх

5. Оролцогч улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч тухайн улс оронд байх үед нь бие махбодын аюулгүй байдлыг нь хангахын тулд хүчин чармайлт тавьж ажиллана.

8-р зүйл - Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эх оронд нь буцаах

2. Оролцогч улс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүнийг эх оронд нь буцаах үед хүлээн авч буй улсын нутаг дэвсгэрт орсон цагаас эхлэн, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирогч болсонтой холбоотой хуулийн ажиллагааны статус болон аюулгүй байдлыг харгалзан үзэж, тухайн хүн тус улсад оршин суух эрхээ эдлэх эсэхээ өөрөө шийднэ.

Энэхүү заалтыг хэрэгжүүлж ажиллахын тулд мөрдөн шалгах бүх шатанд хохирогчид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх шаардлагатай байдаг.

Эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц

Хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдол бүрд доорх дөрвөн чухал асуултыг асууж, эрсдэлийн үнэлгээг хийнэ. Үүнд:

- Хэн эсвэл юу эрсдэлтэй байдалд байна вэ?
- Эрсдэл нь юу байж болох вэ?
- Эрсдэлийн түвшин нь ямар байна вэ?
- Ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?

Эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн менежментийг доорх 3 үе шатуудаар дамжуулан тайлбарлаж болно.

1 дүгээр үе шат	Одоо байгаа эрсдэлийн цар хүрээг тодорхойлж, үнэлэх
2 дугаар үе шат	Тохирох арга хэмжээг тодорхойлж, гарч ирж болзошгүй шинэ эсвэл нэмэгдэх магадлалтай эрсдэлийн үнэлгээг хийх
3 дугаар үе шат	Шийдвэр гаргах, эрсдэлийн менежмент хийх

Хэн эсвэл юу эрсдэлтэй байдалд байна вэ?

- Олж тогтоогдсон болон олж тогтоогдоогүй хохирогчид, хууль сахиулах албан хаагчидтай бүрэн эсвэл ямар нэг байдлаар хамтран ажиллаж байгаа гэрч, хохирогч эсвэл огт хамтраагүй хохирогч;
- Хохирогчийн гэр бүл, ойр дотнынхон, найз нөхөд;
- Гэрчүүд;
- Хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурорууд, хамтран ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд, орчуулагчид;
- Шударгаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахад эрсдэл үүсэх.

Эрсдэл нь юу байх вэ?

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой холбоотой эрсдэл томоохонд тооцогддог бөгөөд олон төрөл байдлаар илэрч болно. Энэхүү гэмт хэргийн мөн чанар нь албадаж хүчлэх байдлаар мөлжлөг үйлдэхэд чиглэдэг тул эрүүл мэндтэй холбоотой төдийгүй бусад эрсдэлийг дагуулж байдаг. Гэмт этгээдээс гарч болох авир, мөн хохирогч гэмт этгээдээс хэр айж байгааг хохирогчийн гаргаж байгаа зан авираас олж мэдэх, нутагтаа эргэж ирээд эсвэл гэртээ байх үед нь тухайн газар нутгийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг, иргэний харьяалалд нь байгаа улс ямар нөхцөлд гэмт хэргийн хохирогчийг бие махбодын хувьд хамгаалж, хууль дүрмийг ном журмынх нь дагуу баримтлах сонирхолтой байгаа талаарх эрсдэлийн үнэлгээг цогц байдлаар хийх шаардлагатай. Энэхүү үүрэг хариуцлагыг хууль сахиулах байгууллагын албан хаагчид хамгийн түрүүнд хариуцах ёстой бөгөөд цаашид үйл явцыг хяналтдаа байлгах хэрэгтэй .

Гэмт хэргийн хохирогч хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай хамтран ажиллахад хохирогчид өөрт нь төдийгүй гэр бүлд нь үргэлж эрсдэлтэй алхам болж байдаг. Хамгийн чухал нь гэмт хэргийн хохирогч болсон хүн болж байгаа бүх асуудлын талаар мэдээлэлтэй байж, гарч болзошгүй эрсдэлийн талаар ойлголттой болох нь мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах боломжийг олгодог.

Аливаа хэргийн эрсдэлийн түвшин гэмт хэргийн хохирогч болсон хувь хүн, гэмт хэрэг үйлдэгдсэн арга барил, гэмт хэргийн сүлжээ, хууль сахиулах байгууллагын чадамж зэрэг олон зүйлээс шалтгаалж өөр өөр байдаг.

Хохирогч мөлжлөгийн нөхцөл байдал, гэмт этгээдийн эрхшээлд байх үедээ хүчирхийлүүлдэг байсан зэргээс шалтгаалж, бие махбодын болоод сэтгэл санааны хохирол амссан байх магадлалтай байдаг. Мөлжлөгийн газраас холдож, хууль сахиулах байгууллагаас анхан шатны арга хэмжээ авагдсаны дараа ч эрүүл мэндийн эрсдэл нь байсаар л байдаг. Энэ нь гэмт хэрэг үйлдэж, хүн худалдаалж байх үед эсвэл хууль сахиулах байгууллагад хандуулахгүй, гэрт нь хариулахаас сэргийлэх зорилгоор санаатай үйлдсэн гэмт этгээдийн хүчирхийллээс үүдэлтэй үүссэн өвчин эмгэгийн үр дагавар байж болно.

Гэрч, хохирогчийг хүчирхийлж, доромжлох нь тэднийг хууль сахиулах байгууллагын албан хаагчдын мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа үзүүлэн, мэдүүлэг өгүүлэхгүй байх хэмжээнд хүргэх өндөр эрсдэлтэй байдаг.

Хохирогчийг эх оронд нь буцаах нь өөрөө эрсдэл дагуулж байдаг. Ийм үед нэр төрийг нь гутаах, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн суурь шалтгаан болсон хуучин орчиндоо дахин очих, тусламж дэмжлэг авах боломжгүй шахам газар очих зэрэг эрсдэлүүд гарч ирэх магадлалтай. Эдгээр нь бүгд эрүүл мэндэд чиглэсэн үр дагавартай бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгт дахин өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байдаг.

Хохирогчийг эрхэндээ оруулахын тулд, тэдэнд юу тохиолдсон тухай мэдээлэл олж авах, цаашлаад эрх бүхий албан хаагчидтай хамтарч байгаа эсэхийг мэдэхийн тулд гэмт этгээдүүд хохирогчийн гэр бүл, ойр дотнынхон, найз нөхдөд заналхийлэх, хүчирхийлэлд өртүүлэх эрсдэл бий.

Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгалт явуулж байгаа цагдаагийн албан хаагчид болон хууль сариулах чиг үүрэг бүхий бусад ажилтнууд (хил гаалийн байгууллагын албан хаагчид, хилийн хяналтын ажилтан, мэргэжлийн хяналтынхан г.м) баривчилгааны үеэр эсвэл мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийхийн тулд айлган сүрдүүлэлтэд өртөх магадлалтай байдаг.

Прокурор, шүүгчид ч ялгаагүй айлган сүрдүүлэх, заналхийлэх, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдалд байдаг.

Төрийн бус байгууллагын ажилтнууд, хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг албан хаагчдад ч мөн адил гэмт этгээдүүд хохирогчид халдахаар чармайж байх үедээ айлган сүрдүүлж, заналхийлэх эрсдэл байдаг. Мөн хохирогчдоос тэдэнд элдэв төрлийн өвчин халдах, гэмт хэргийн хохирогч болсондоо шаналж буй хүмүүстэй удаан хугацаанд ажилласаар стресст өртөх эрсдэлтэй байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа ч өөрөө эрсдэлтэй тулгардаг. Дээр дурдсан хүмүүс хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсний улмаас мэдүүлгээсээ буцах, авлигад өртөх, эрүүгийн хэргийг шүүх тогтолцоо сулрах, хууль, дүрэм журмыг гажуудуулан хэрэглэх зэрэг асуудал тулгарах нь бий.

Эрсдэлийн түвшин нь ямар байна вэ?

Мөн чанараасаа шалтгаалж, хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчдодоо илүү эрсдэлийг дагуулж байдаг. Эрсдэл нь ямар түвшинд байгааг нарийн тодорхойлоход хэцүү байдаг бөгөөд тухайн хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэрэгт холбогдсон хүмүүсийн онцлог, гэмт этгээд хохирогч хоёрын аль алийнх нь соёлын ялгаа зэрэг олон зүйлээс шалтгаалж байдаг.

Эрсдэлийн түвшний үнэлгээ хийж байхдаа асуух шаардлагатай асуултууд:

Хэн нэг хүн шууд аюул заналд өртөхөөр байна уу? Эдгээр хүмүүсийн жагсаалтад хохирогчийн гэр бүл, хамаатан садан, найз нөхөд эсвэл бусад хохирогчид багтана. Хохирогч маш ихээр хүчирхийлүүлж, зодуулж, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нөхцөлд бие махбоддоо хүнд бэртэл гэмтэл авсан байх нь түгээмэл байдаг бөгөөд сэтгэлзүйн хувьд маш хэцүү байдалтай болсон байдаг. Хүнд үйлдвэрт боолын хөдөлмөр эрхэлж байсан хүн мөн адил бие махбодын гэмтэл бэртэлтэй байх нь олон.

Улдсэн өвөр хохирогч байгаа юу? Тухайн хэргийн газар аврагдаагүй үлдсэн хохирогчид зарим талаар эрсдэлийн түвшнийг нэмэгдүүлнэ. Аврагдаагүй үлдсэн хохирогчдод эрсдэлтэй байдал үүсдэг. Яг ямар түвшний эрсдэл байгаа нь энд байгаа асуултуудад хэрхэн хариулахаас

хамаарна.

Гэмт этгээдүүд өмнө нь хүчирхийлэл үйлдэж, заналхийлж байсан уу? Эрсдэлийн үнэлгээнд нөлөөлдөг хүчин зүйлст хүчирхийллийн шинж чанар (ноцтой байдал) болон давтамж (давтагдах магадлал) ордог. Өмнө нь хүчирхийлж, айлган сүрдүүлж, заналхийлж байсан бол эрсдэлийн түвшин өндөр байх магадлал ихтэй байна.

Гэмт этгээд ямар мэдлэг, мэдээлэлтэй хүн бэ? Гэмт этгээдэд хохирогчийн гэрийн хаяг, байршил, мөн хохирогчийн гэр бүлийнхний утасны дугаар зэрэг мэдээлэл бий юу? Хохирогчид эдгээр мэдээлэл байгаа бол эрсдэл тулгарах магадлал өндөр байна.

Хоргодох байр зэрэг хамгааллын ямар үйлчилгээ үзүүлэх боломжтой вэ? Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, найдвартай хамгаалах байр зэрэг хохирогч хамгааллын үйлчилгээ нь гэрч, хохирогчид халдах, мэдүүлгээ буцаах зэрэг эрсдэлийг бууруулдаг төдийгүй эрсдэлийн ноцтой байдлыг ч бас бууруулдаг. Тухайлбал, эрүүл мэндийн байдал нь хурдан сайжрах, түргэн эдгэрэх боломжтой.

Хохирогчийн гэр бүлийн нөхцөл байдал ямар вэ? Хохирогч гэрлэсэн үү? Хүүхэдтэй юу? Нийгмийн сүлжээ хохирогчийг хэвийн байдалд нь оруулахад (эрсдэлийн ноцтой байдлыг бууруулах) тус болдог бөгөөд хохирогчийг албан бусаар хамгаалалтдаа авах нь (эрсдэлийн магадлалыг бууруулах) бас эрсдэлийн түвшнийг багасгахад нөлөөлдөг. Зарим тохиолдолд гэмт этгээдүүд хохирогчийн гэр бүл эсвэл нийгмийн сүлжээг ашиглан айлган сүрдүүлж, эрсдэлийн ноцтой байдал (тухайлбал гэрч, хохирогчийг мэдүүлэг өгөхгүй байхыг шаардах) болон мэдүүлэг өгөхгүй байх магадлалыг өндөрсгөдөг.

Гэмт этгээдүүд хохирогчийн байрлаж байгаа хамгаалах байр, гэр бүлийнхнийх нь гэрийн хаяг зэргийг мэдэх үү? Гэмт этгээд энэхүү мэдээллийг үнэхээр мэдэж байвал хохирогчид учирч болох эрсдэлийн түвшин нэмэгдэнэ. Мэднэ хэмээн хэлж байгаа нь худлаа байсан ч эрсдэлд тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг. Хэдийгээр гэмт этгээд энэхүү мэдээллийг үнэхээр мэдэж байгаа эсэхийг үнэлэхэд хэцүү боловч гэрчийг айлган сүрдүүлэх магадлалтай тул эрсдэлийн түвшин нэмэгдэж байдаг.

Гэмт этгээд хэн рүү халдах магадлалтай вэ? Тэд хохирогч, тэдний гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн байгаа газарт тэдэн рүү халдаж болох холбоо сүлбээтэй бол тэдний хэн нэгнийг гэмтээх эрсдэлтэй бөгөөд гэрчийн мэдүүлэг өгүүлэхгүй байх эрсдэлийн магадлалын түвшин мөн л адил нэмэгдүүлж байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа хэр "найдвартай" вэ? Мөрдөн шалгах ажиллагааны шударга байдал, аюулгүй байдалд төрөл бүрийн заналхийлэл гарч ирэх магадлалтай. Төрийн албаны албан хаагчийг хахуульдаж байсан гэмт этгээд эрсдэлийн түвшин нэмэгдүүлж, мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулдаг. Гэмт этгээдүүд мөнгөтэй байх нь хахуулдах магадлал өндөр байгааг харуулна. Шударга, аюулгүй байдалд нөлөөлөх бусад асуудал нь эд мөрийн баримтын менежментийн сул тогтолцоо, гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээлэл алдагдах боломж зэрэг юм.

Ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Ямар арга хэмжээ авахаа шийдэхээсээ өмнө асуух асуултууд:

- Мөрдөн шалгах ямар тактик тохиромжтой вэ? Энэхүү ажиллагаа хохирогч, төрийн бус байгууллага, хохирогчид үйлчилгээ үзүүлдэг газар эсвэл хууль сахиулах албан хаагчдад ямар эрсдэлийг дагуулах магадлалтай вэ?
- Гэмт хэргийн жинхэнэ хохирогч, олж тогтоогдоогүй байгаа бусад хохирогч, хохирогч

болох магадлалтай хүмүүс, тэдгээрийн гэр бүлд нь дээрх эрсдэлүүд шууд тулгарч байгаа бол яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна уу?

- Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай бол сэжиглэгдэж буй этгээдүүдэд хууль сахиулах албан хаагчид өөрсдийнх нь үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байгаа талаар мэдэгдүүлэхгүйн тулд ямар арга хэмжээ авч болох вэ?
- Яаралтай арга хэмжээ авах шаардлагагүй бол мөрдөн шалгах тусгай ажиллагааг тасралтгүй, идэвхтэй явуулах явцад эрсдэлийн түвшин аюулгүйгээр бууруулж болохоор байна уу?
- Мөрдөн шалгах тусгай ажиллагаагаа явуулах боломжгүй бол тохирсон саармагжуулах стратеги боловсруулан эрсдэлийг аюулгүйгээр зохицуулж болох уу?

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш суралцагчдыг өмнө гарсан дасгал ажил 2, 3-ыг үндэслэн хооронд нь ярилцуулна.
Баатар, Мөнхбат хоёрт болон тэдний гэр бүлд ямар эрсдэл учирч болох вэ?
Баатар, Мөнхбат болон тэдний гэр бүлд учирч болзошгүй эрсдэлийг хэрхэн багасгах боломжтой вэ?

МОДУЛЬ - 4

ХҮН ХУДАЛДААЛАХ

ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь хууль сахиулагч болон прокурорууд хуулиар хүлээсэн чиг үүргийнх нь хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчоос мэдүүлэг авах чадвар олгох, орчин үед хэрэглэгдэж байгаа сайн туршлагыг мэдүүлэг авахдаа ашиглах, хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдад хохирогчтой ярилцах байдлаар энэхүү гэмт хэргийн хохирогчийг тогтоох мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

Сэдэв 1 Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалын тухай ойлголт, онцлог
Сэдэв 2 Хохирогчид үүссэн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, түүний ач холбогдол
Сэдэв 3 Хохирогчоос мэдүүлэг авах нь
Сэдэв 4 Гэрч, хохирогч хүүхэдтэй ярилцах, мэдүүлэг авах
Сэдэв 5 Гэрч, хохирогчоос мэдүүлэг авах нь

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хохирогч төвтэй аргачлал нь гэмт хэргийн хохирогчийг ямар нэгэн байдлаар буруутгах, шүүмжлэлтэй хандахгүйгээр тэдэнд энэрэнгүй, мэдрэмжтэй хандан, өөрт нь шаардлагатай байгаа хэрэгцээ, санааг нь зовоож байгаа зүйлсийг системтэйгээр анхаарах явдал юм.
- Мөрдөн шалгах ажиллагаа, гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах явц хэр зэрэг амжилттай байх нь өөрт нь юу тохиолдсон талаар нарийн, дэлгэрэнгүй мэдээлэл өгч чадах хохирогчийн чадвар болон шүүхийн өмнө амьд гэрч болох чадамжаас хамаарна.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ярилцахад олон хүчин зүйлсээс шалтгаалсан бэрхшээл тулгардаг. Хангалттай, баримт нотолгоотой мэдээлэл өгч чадах эсэх нь хохирогчийн бие махбодын болоод сэтгэл санааны байдлаас шалтгаалдаг бөгөөд зарим асуудал тэднийг итгэлгүй, айдастай, чимээгүй байхад хүргэдэг.
- Үүрэг хариуцлага хүлээсэн албан хаагчид мөрдөн шалгах, гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах ажиллагаанд хохирогчийн үзүүлж буй хариу үйлдэл, гаргаж байгаа сэтгэл зүйн эмгэгүүд нь цаанаа юу илэрхийлж байгааг сайтар ойлгох хэрэгтэй бөгөөд хохирогчийг “дахин хохирогч” болгохгүйн тулд чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Ярилцлагын үе шат бүрд хохирогчийн эрх (хувийн нууцаа хамгаалуулах эрх г.м)-ийг хамгаалах хэрэгтэй бөгөөд мөрдөгч, прокурор нар тэдний хэрэгцээг (эрүүл мэнд, сэтгэл зүйн г.м) хангах талаар анхааран ажиллах шаардлагатай.
- Мөрдөгч/прокурор нар хүүхдийн хөгжлийн үе шатуудын талаар маш сайн ойлголттой байж, мэдүүлэг авах хамгийн тохиромжтой аргачлалыг сонгож, мэдүүлэг өгөх хүнээ болон ярилцлагыг бичлэгт буулгах арга техникээ тодорхойлох шаардлагатай. Нас болон хүүхдийн хөгжлийн байдалд тохирсон байдлаар энэ ажил явагдах нь чухал.

Сургалтын хугацаа - 2 цаг 30 минут (150 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх
- Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзэг бэлтгэх.

Модуль 4: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлал	Лекц / хэлэлцүүлэг	10	Сэдэв 1
	Дасгал ажил 4 – Хүн худалдаалах гэмт хэрэг хүний эрхийн зөрчил болох нь	Дасгал ажиллах	10	Модуль 2-ын дасгал ажил 1
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үүссэн сэтгэл зүйн эмгэгийг тодорхойлох, мөрдөн шалгах, прокурорын хяналтын явцад түүнээс учирч болох сөрөг үр дагаврын талаар мэдэж авах	Лекц / хэлэлцүүлэг	30	Сэдэв 2
Сэдэв 3	Хүний эрхийг дээдэлж, хохирогчийг нэн тэргүүнд тавьсан байдлаар мэдүүлэг авах төлөвлөгөө боловсруулах	Лекц / хэлэлцүүлэг	40	Сэдэв 3
Сэдэв 4	Тусгай чадвар ашиглан хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч болох хүүхдээс мэдүүлэг авах	Лекц / хэлэлцүүлэг	30	Сэдэв 4
Сэдэв 5	Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчоос мэдүүлэг авах чадварыг хөгжүүлэх ба хэрэгжүүлэх	Лекц / хэлэлцүүлэг	10	Сэдэв 5
	Дасгал ажил 5 – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны дүрд тоглох нь	Дасгал ажиллах	20	Модуль 2-ын дасгал ажил 1

СЭДЭВ 1: ХОХИРОГЧ ТӨВТЭЙ МӨРДӨН ШАЛГАХ АРГАЧЛАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

1. ХОХИРОГЧ ТӨВТЭЙ МӨРДӨН ШАЛГАХ АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь энгийн гэмт хэрэг биш, хохирогчийг хүчирхийлж, мөлжих замаар хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн үйлдэл байдаг учраас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүмүүстэй хохирогч (эрэгтэй, эмэгтэй) төвтэй болон хүүхэд төвтэй аргачлалаар ажиллах нь төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг юм.

Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлал

Энэхүү арга нь гэмт хэргийн хохирогчийг ямар нэгэн байдлаар буруутгаж, шүүмжлэлтэй хандахгүйгээр тэдэнд энэрэнгүй, мэдрэмжтэй хандан, тэдний хэрэгцээ, санааг нь зовоож байгаа зүйлд системтэйгээр анхаарах явдал юм. Энэхүү аргачлал нь хохирогчийг мөрдөн шалгах явцад сэтгэл санааны цочрол, гутралд дахин орох эрсдэлийг бууруулж, мөрдөн шалгах ажиллагаанд аль болох оролцохыг нь дэмжих зорилготой.

Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг ашиглах үед хохирогчийн хүсэл сонирхол, аюулгүй байдал болон эрүүл мэндийн байдлыг нэн тэргүүнд тавих ёстой. Энэхүү аргачлалын гол цөм нь хохирогчоор дамжуулан, тэдний туслалцаатайгаар гэмт хэргийн халуун мөрөөр орж, шуурхай олж тогтоох явдал юм. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хэрэгцээ, шаардлагыг хууль тогтоомж, бодлого журамтай нийцүүлэх байдлаар дэлхий нийтээрээ хохирогч төвтэй энэхүү хандлага руу чиглэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь өөрөө хүний эрхийг зөрчиж буй асуудал буюу хохирогч төвтэй гэмт хэрэг учраас ялангуяа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд онцгой анхаарал хандуулах ёстой. Энэ дагуу хүүхдийг зөвхөн хохирогч гэдэг талаас нь авч үзэж хандана. Өөр хандлага байж таарахгүй.

2. ХОХИРОГЧ ТӨВТЭЙ МӨРДӨН ШАЛГАХ АРГАЧЛАЛЫГ АШИГЛАХ НЬ

Хүний эрхийн дээд комисс 2002 онд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэхүү гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг хамгаалах үүднээс *Хүний эрх, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зарчим, зөвлөмж* гаргасан.

Зөвлөмж 1 - "Хүний эрхийг зөрчих нь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, үр дагавар юм. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох аливаа арга хэмжээ авахад хүний эрхийг нэн тэргүүнд тавьж ажиллах нь чухал. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хийгдэж буй аливаа арга хэмжээ хүний эрхэд ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч, цагаачид, улс орон дотроо нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүс, дүрвэгчид, улс төрийн орогнол хүссэн хүмүүст сөргөөр нөлөөлөх ёсгүй".

Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг ашиглах ойлголт, түүнийг практикт ашиглах талаар *НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн (2000) нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд* ("НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол") анх онцлон дурдсан байдаг. Энэ талаар гурван Пи /P/ загвар буюу доорх байдлаар тусгажээ. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үүнтэй тэмцэхэд хүүхэд эмэгтэйчүүдэд онцгойлон анхаарал хандуулах;
- Энэ гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүмүүсийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэхдээ хүний эрхийг нь хүндэтгэх;
- Гэмт этгээдүүдийг яллах.

Урьдчилан сэргийлэх – Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж буй дэлхийн хөдөлгөөн ерөнхийдөө хүчин чармайлт дээр суурилдаг. Урьдчилан сэргийлэх уламжлалт хүчин чармайлт нь тус гэмт хэргийн нийлүүлэгч болон хүлээн авагч улсын талаар олон нийтэд мэдээлэл түгээх, цагаач болон эрсдэл бүхий иргэдэд анхааруулах, хохирогчийг олж тогтоох, сургахад чиглэгдсэн компанит ажлууд байдаг. Харин өнөөдөр, урьдчилан сэргийлэх ажлыг ихэвчлэн хууль тогтоомж, бодлого журам боловсруулах, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль (ялангуяа Хөдөлмөрийн тухай хууль)-ийн хэрэгжилт зэрэг ажил руу чиглүүлж байгаа төдийгүй албадан хөдөлмөр эрхлүүлдэг мөлжлөгийн сүлжээг таслан зогсоохын тулд хувийн салбарт хариуцлага, ёс зүйтэй бизнесийн стандартыг мөрдүүлж, хэвшүүлэх мөн хувийн салбарыг оруулаад хууль сахиулах байгууллага, Засгийн газар, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэж байна.

Хамгаалах – Үүнд гэмт хэргийн хохирогчийг цаг алдалгүй олж тогтоох, тэдэнд олон төрлийн цогц үйлчилгээ үзүүлэх, ямар нэгэн байдлаар буруушааж, шүүмжлэлтэй хандахгүйгээр, аливаа болзол нөхцөлгүйгээр үйлчилгээндээ хамруулах, тэднийг хуучин амьдралдаа эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх зэрэг ажил багтдаг. Хамгийн чухал нь хохирогч, түүний гэр бүл, ойр дотнын хүмүүс гэмт этгээдийн заналхийлэлд өртөх магадлалтай байдаг тул аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Яллах – Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар Засгийн газрын зүгээс хуулиар хүлээсэн чухал ажлуудын нэг бол хууль сахиулах үр дүнтэй үйл ажиллагаа юм. Хуулийг нэг мөр дагаж мөрдөх, хохирогчдын эрхийг хангах, тэдний ашиг, сонирхлыг хамгаалах байдлаар шүүх хуралдаан явуулах, үйлдсэн гэмт хэргийнх нь нийгмийн аюулын шинж чанар, үйлдлийн аргад нь тохирсон ял шийтгэлийг шударгаар оногдуулах зэрэг нь гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хүчин чармайлтад тооцогддог.

Гурван Пи загвар болох "Яллах, Хамгаалах, Урьдчилан сэргийлэх" нь хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг. Эдгээрийн үр дүнтэй байх нь хоорондоо хэр уялдаа холбоотой, нэгнийгээ нөхөж ажиллаж чадсан эсэхээс хамаарна. Жишээлбэл, эрүүгийн хэрэг үүсгэж сэжигтнээр татаж, мөрдөн шалгах ажлыг сайн хийж чадвал, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой болно. Үүнтэй нэгэн адил хохирогчийг сайн хамгаалж чадвал, мөлжлөгт өртсөн хүнд итгэл найдвар төрүүлж, нийгэмд гарсан хойноо ижил төрлийн гэмт хэргийн хохирогч болохгүй байх боломж бүрдэхээс гадна энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлөх боломжтой. Хохирогчийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахын тулд хохирогч төвтэй арга барилаар зохион байгуулах нь хамгаалах арга хэмжээний салшгүй нэг хэсэг болдог.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш суралцагчдад хүн худалдаалах гэмт хэргийн "үндсэн шалтгаан"-ыг илүү сайн ойлгуулахын тулд доорх дасгалыг хэрхэн ажиллах талаар тайлбарлаж болно.

ДАСГАЛ АЖИЛ 4 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ БОЛОХ НЬ

Хугацаа: 10 минут

Шаардлагатай материал: Модуль 2-ын дасгал ажил 1, ханын цаас, самбарын үзэг

Дасгалаас хүлээгдэж буй үр дүн: Суралцагчид хүн худалдаалах гэмт хэрэг хүний эрхийг зөрчдөг талаар ойлголттой болох төдийгүй өгөгдсөн дасгалыг ажиллаж, хохирогч төвтэй арга хэрэглэх хэрэгцээ шаардлагын талаар мэдлэгтэй болно.

ДАСГАЛ

Сургагч багш сургалтад хамрагдаж буй бүх хүнд Модуль 2-ын Дасгал ажил 1-ийг тарааж өгнө. Суралцагчид материалыг сайтар уншаад, өөрсдийнхөө ойлголтод үндэслэн зөрчигдөж байна гэж үзэж байгаа бүх хүний эрхийг жагсааж бичнэ. Үүний дараа суралцагчдыг нэг нэгээрээ ямар эрх зөрчигдсөн гэж үзэж байгааг нь хэлүүлж, ханын цаасан дээр бичүүлнэ (суралцагчдын нэг нь бичсэн ч болно). Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүний нэг биш хэд хэдэн эрх ноцтойгоор зөрчигдөж байгаа нь энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчид хохирогчид анхаарал хандуулан ажиллахын чухлыг харуулж байна гэсэн байдлаар дасгалыг дуусгана.

СЭДЭВ 2: ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

1. УДИРТГАЛ

Хохирогчийг буруу тогтоох нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, энэхүү гэмт хэрэгт өртсөн хүмүүст туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг учраас хохирогчоос мэдүүлэг авах үе шат нь зайлшгүй хийх ёстой ажлуудын нэг болдог.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цагдаа, хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албаны албан хаагчид хохирогчоос мэдүүлэг авч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг үнэн зөв тогтоохоос эхэлдэг. Үүний дараа тухайн хэрэг хэр амжилттай шийдвэрлэгдэх нь хохирогч юу болсон талаар хэр дэлгэрэнгүй нарийн мэдүүлэг өгч, шүүх хуралдааны үеэр хэр сайн гэрч байж чадахаас ихээхэн шалтгаалдаг.

Тийм учраас, хохирогчид тохирсон нөхцөл байдал үүсгэх замаар нотлох баримт цуглуулахыг гол зорилгоо гэж үзвэл энэ үйл ажиллагаа нь мөрдөгч, прокуроруудаас өндөр мэдрэмж, мэргэжлийн чадварыг (ялангуяа хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хохирогчийг хамгийн анх тогтоох үед) шаардаж байдаг.

Мэдүүлэг авах чадвар яагаад чухал вэ?

Хүчирхийлүүлж мөлжлөгт өртсөн хохирогчид, ялангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүүхэд, эмэгтэйчүүдээс мэдээлэл цуглуулж авах нь маш хэцүү байдаг. Хохирогчид анхаарал хандуулах, хамгаалалтад авах, гэр бүлийнхнийг нь олж тогтоох (ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдтэй холбоотой хэрэг дээр), сэжигтнийг баривчлах, шийтгэх, тухайн хохирогч аль ч зорилгоор мөлжлөгт өртсөн байсан **Чөлөөлөх – Эрүүл мэнд, сэтгэл санааг нь хэвийн байдалд оруулах - Нутагт нь эргүүлэн авчрах – Эргүүлэн нийгэмшүүлэх** гэсэн үйл ажиллагааг цогцоор нь

удирдан явуулахад мэдээллийг нягт намбай цуглуулсан байх шаардлагатай байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ярилцахад олон хүндрэл, бэрхшээл тулгардаг. Ихэвчлэн хохирогч мэдээлэл өгөх хүндрэлтэй үед мэдээллийг яаралтай олж авах шаардлага тулгардаг. Хангалттай, баримт нотолгоотой мэдээлэл өгч чадах эсэх нь хохирогчийн бие махбодын болоод сэтгэл санааны байдлаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд зарим асуудал тэднийг үл итгэх байдалтай, айдастай, дуугүй байхад хүргэх нь бий. Үүний улмаас олж авсан мэдээлэл хангалттай биш эсвэл буруу ташаа байх тохиолдол гардаг төдийгүй ярилцах буруу арга тактик ашигласны улмаас хохирогчийн биеийн байдал, хүний эрхэд сөргөөр нөлөөлөх нь бий.

Энэ хэсэгт[16] хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод мөлжлөг, гэмт хэрэгт өртөх явдал нь өөрөө хэрхэн нөлөөлдөг талаар тусгайлан авч үзнэ. Хохирогч сэтгэл зүйн ямар хариу үйлдэл үзүүлж байна, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөсөө өмнө болон өртөж байхдаа ямархуу байдалд орж байсан талаарх ерөнхий ойлголтыг олгоно. Мөрдөгч, прокурор хохирогчийн зүгээс гаргаж, үзүүлж буй хариу үйлдэл ямар шалтгааны улмаас гарч байгаа, цаанаа юу илэрхийлж байгаа, хэргийг мөрдөн шалгах болон хянах явцад ямар байдлаар нөлөөлж болох талаар ухаж ойлгох нь чухал юм. Түүнчлэн, тэднийг дахин хохирогч болохоос сэргийлэх, хэвийн байдалдаа эргэн орох зэрэгт энэ хандлага чухал үүрэг гүйцэтгэж байдаг.

"Дахин хохирох" гэдэг нь тухайн гэмт хэргийн улмаас шууд хохирохыг бус харин аливаа байгууллага болон хүний хариу арга хэмжээнээс шалтгаалан хохирохыг хэлнэ. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шалтгаалан хохирох асуудал эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад ихэвчлэн тохиолддог. Цагдаагийн байгууллага эсвэл эрүүгийн хэрэг дээр ажилладаг албан хаагчдын тохиромжгүй, эв дүйгүй, залхааж хашраасан байдалтай арга барилын улмаас тухайн хүн дахин хохирогч болох магадлалтай байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л үйл явц болон шүүх ажиллагаа, мөрдөн шалгахаас эхлээд, сэжигтэн этгээдийг эрүүгийн хэрэгт татах эсэх, шүүх хуралдаан, гэмт этгээдийг яллах, цаашлаад цагаатгах зэрэг бүхий л үйл ажиллагаа нь өөрөө тухайн хохирогчийг дахин хохирогч болгох боломжтой гэсэн үг.

Дахин хохирох асуудал нь хохирогчийн болоод гэмт этгээдийн эрхийг тэнцвэртэй барихаас үүдэлтэй аливаа хүндрэл, бэрхшээлээс шалтгаалан бий болж болно. Гэвч ихэвчлэн хэргийг хянан шийдвэрлэх үүрэг бүхий албан хаагчид хохирогчоо анхаарсан байдлаар үйл ажиллагаагаа явуулаагүйгээс шалтгаалж дахин хохироход хүргэж байдаг.

(Гэмт хэргийн болон хүчирхийллийн хохирогчдод зориулсан шударга ёсны зарчмуудыг хэрэглэх НҮБ-ын гарын авлага, 1999 он)

2. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ИЛРЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ЭМГЭГ ШИНЖ ТЭМДГҮҮД

Хүн худалдаалах гэмт хэргийн ихэнх хохирогчид нэг буюу хэд хэдэн сэтгэл зүйн эмгэгт хүргэхүйц гэмт үйлдэлд өртсөн байдаг бөгөөд хохирогчийн сэтгэл зүйн байдлыг засах, хэвийн

16 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн сэтгэл зүйн хариу үйлдэл; Эрүүгийн байцаан шийтгэх алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг гарын авлагын Модуль 3-аас авав. НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009. Гарын авлагыг дараах холбоосоор орж харах боломжтой. http://www.unodc.org/unodc/en/human-trafficking/2009/anti-human-trafficking-manual.html

байдалд нь оруулахад сэтгэл зүйн тактик ашиглах шаардлагатай. Гэмт хэрэг үйлдэгдэх явцад хохирогчийн үзсэн, туулсан зүйлс түүнээс улбаатай сэтгэл зүйн эмгэг ихээхэн нарийн түвэгтэй асуудал бөгөөд удаан хугацаанд үргэлжилж, хохирогчийг сэтгэл санаанд хямралд оруулах нь их байдаг. Мөрдөгч, прокурор, хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид шаардлагатай үед мэдүүлгийг нь зогсоож, аливаа тусламж дэмжлэгийг цаг алдалгүй үзүүлэхэд бэлэн байх хэрэгтэй. Зарим тохиолдолд эхэн үедээ хүчтэй сэтгэл хөдлөлтэй байсан хохирогч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эсвэл мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа авсныхаа дараа гэрчийн үүргийг маш сайн гүйцэтгэх нь бий.

Доор дурдагдах хүчин зүйлсээс шалтгаалан, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 50 орчим хувь нь насан туршийн сэтгэл зүйн эмгэгтэй үлддэг. Үүнд:

- Бие махбодын хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Эрх чөлөөг нь хязгаарлах
- Сонголт хийх, өөрийн дураар ямар нэг зүйл хийхийг нь хязгаарлах
- Хүнлэг бус нөхцөлд амьдруулж, ажиллуулах
- Урт хугацаанд мөлжлөгт байлгах

Хам шинж тэмдэг – Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн даруйдаа ихэнх хохирогчдод бие махбодын болоод сэтгэл зүйн шинжтэй олон таагүй асуудлуудтай тулгарсан байдаг.

Бие махбодын шинж тэмдэг – Ядарсан, турж эцсэн байдалтай, мэдрэл, ходоод гэдэстэй холбоотой шинж тэмдэг илэрсэн байх нь түгээмэл байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн ихэнх хохирогч урт удаан хугацааны туршид албадлага дор хүнд ажил хийж, маш бага унтдаг байсан байдаг. Удаан хугацаагаар нойр дутмаг, нойргүйдэлтэй явсан нь хохирогчийн анхаарлаа төвлөрүүлж, эрүүл саруулаар сэтгэн бодох чадварт нөлөөлөөд зогсохгүй бие махбодынх нь дархлааны системийг доройтуулж, өвчин даах чадварыг бууруулдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн шинж тэмдэг – Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүст сэтгэл гутрал, санаа зовнил, өширхөх шинж тэмдэг түгээмэл ажиглагддаг. Хохирогчийг ихэвчлэн уйлсан, айсан, гомдсон байдалтайгаар төсөөлсөн зарим мөрдөгч, прокурорт хохирогчийн өширхөж байгаа байдал гайхал төрүүлж магадгүй юм. Гэвч өширхөх нь баримтаар нотлогдсон, маш түгээмэл илэрдэг шинж тэмдэгт тооцогдсоор ирсэн. Мөн хохирогч "амархан уурлаж, уцаарлах", "бүх зүйлд ундуюцдаг", "түргэн ааш гаргах" нь олонтоо тохиолддог. Түүнчлэн эхлээд уур омогтой, түрэмгий зан авир гаргаж байсан хохирогч түүндээ харамссан, яахаа мэдэхээ байж тээнэгэлзсэн, өөрийнхөө гаргаж буй ааш авираас ичсэн байдалтай болох нь бий. Бэлгийн мөлжлөгт өртөж байсан хохирогч хана цохих, юм шидэх, бусдыг цохиж авах зэрэг хэвийн бус балмад үйлдэл гаргах нь цөөнгүй.

Гэмтлийн дараах стрессээс үүдэлтэй эмгэг (PTSD) – гэдэг нь нэг буюу хэд хэдэн гэмт үйлдэлд өртсөний улмаас үүссэн сэтгэцийн эмгэгийг тодорхойлдог нэр томьёо юм. Амь насанд нь заналхийлсэн олон зүйлийг үзэж туулснаар хохирогчид сэтгэцийн олон төрлийн хавсарсан эмгэг үүсдэг бөгөөд энэ нь янз бүрийн шинж тэмдгээр илэрдэг. Үзэж туулсан зүйл нь хэр ноцтой, хэрцгий балмад байснаас шалтгаалан хохирогч өөрт нь тийм зүйл огт тохиолдоогүй гэж үгүйсгэх явдал гардаг бөгөөд үүнийг сэтгэл зүйн "диссоциаци буюу тусгаарлах" нөхцөл байдалд орсон гэж үздэг. Диссоциаци нь хохирогч өөрийг нь хүчирхийлэлд байлгаж байсанд хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болгоод зогсохгүй өөр бусад шинж тэмдгүүд илрэх эхлэлийг тавьдаг. Үүнд:

- Хүчирхийлэл, мөлжлөг өөрт нь биш өөр хүнд тохиолдсон мэтээр өөрөөсөө зайлуулж ярих.
- Цаг хугацааны баримжаа алдагдаж, юу тохиолдсон талаараа санахгүй байх.
- Тохиолдсон зүйлдээ маш өөрөөр хариу үйлдэл үзүүлэх эсвэл хайхрамжгүй, өөрт нь хамаагүй мэтээр хандах зэрэг нь өөрийг нь хүчирхийлж байсныг ухамсарлаагүй байж болзошгүйг харуулах баримт байж болно.
- Ойлгох, мэдрэх, ухамсарлах, санах ойгоо хэсэгчлэн алдах.
- Өөрт нь тохиолдсон хүчирхийлэл дахин тохиолдох гэж байгаа мэт төсөөлөн санах. Гэмт хэргийн талаар, үзсэн туулсан зүйлийнхээ талаар ам нээж ярихгүй байгаагаас шалтгаалж энэ шинж тэмдэг ихэвчлэн үүсдэг. Онцгой үнэр, дуу чимээ, зарим нэг мэдрэмж, зураг дүрс зэрэг өчүүхэн зүйлээс энэ шинж тэмдэг илрэх боломжтой.

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөний дараах сэтгэл зүйн эмгэгүүд олон жил үргэлжлэх боломжтой, зарим тохиолдолд насан туршид нь үргэлжилдэг. Айдас түгшүүртэй байх, харамсах, гашуудах, цөхрөх зэргээр сэтгэл зүйн дарамтад орж байсан хүмүүс туулсан аймшигт зүйлээ ургуулан бодож, хар даран зүүдэлж, дахиад тохиолдох гээд байгаа мэт төсөөлөн санах зэргээр үргэлжлэх явдал байдаг.

3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБАН ХААГЧДАД НӨЛӨӨЛӨХ НЬ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ялангуяа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүмүүсээс мөрдөгч, прокурорууд мэдүүлэг авахдаа тэднийг цаашид гэмт этгээдийг мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллахад татан оролцуулах үүднээс тэдэнд илэрдэг шинж тэмдгүүдэд мэдлэгтэй, ойлгомжтой хандах хэрэгтэй. Хохирогч гадаадын оронд худалдаалагдахаас өмнө өөрийнхөө улс оронд байхдаа мөлжлөгт өртсөн байх магадлалтай тул хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид ч мөн ялгаагүй эдгээр шинж тэмдгийн талаар мэдлэгтэй байх нь зүйтэй.

Хохирогчийн зан байдал:

- Мэдүүлэг авч байгаа албан хаагчид руу таагүй байдлаар харьцах. Гэмт этгээдэд эсэргүүцэл үзүүлбэл тэр нь хүчирхийлэлд өртөхөд хүргэдэг гэдгийг өмнө нь хохирогч өөрийн биеэр мэдэрсэн байж болох талтай. Энэ байдлаасаа болоод шүүгч, хууль сахиулагчтай аливаа харилцаа тогтоохоос зайлсхийж байх боломжтой
- Мэдүүлэг авахаар ирсэн хүнтэй харилцахгүй байх;
- Ой санамж муудсан байх, мэдүүлгээсээ буцах, хоорондоо зөрчилдсөн мэдээлэл өгөх зэрэг нь дараах үр дагаварт хүргэнэ. Үүнд:
  - Цаг хугацааны хувьд зөрүүтэй зүйл ярих
  - Болсон үйл явдлын талаар нарийн тодорхой санахгүй байх
  - Тохиолдсон зүйлийнхээ гол бүрэлдэхүүн хэсгийг санаж байгаа ч гэмт этгээдийн гадаад байдал болох хувцас, өрөөний зохион байгуулалт, тээврийн хэрэгслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй байх
  - Амь насанд нь заналхийлж байсан зүйлийнхээ талаар ам нээхгүй байх (Жишээлбэл, диссоциаци)
- Уур уцаар нь хөдөлж "тэсрэх";
- Бусдын эрхшээлээс гарч, гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэгээсээ ангижирсныхаа дараа болсон зүйлээ хольж, хутган ярих;
- Харахад "хэвийн, зүгээр" мэт боловч дотроо сэтгэл нь зовж, шаналсан хэвээрээ байх;

- Бодож байснаас илүү ихээр амрах, унтах, завсарлах;
- Болсон зүйлээ санаж эхлэх. Ихэнх хохирогч хэсэг хугацааны дараа юу болоод өнгөрсөн талаар санах үе байдаг. Тэд бодит байдлын талаар дахин тунгааж, юу болсныг тайлбарлахын зэрэгцээ болсон зүйлд үнэлэлт дүгнэлт өгч чадахаар болдог.

Мэдүүлэг авч байгаа хүн юу хийх хэрэгтэй (юу хийж болохгүй) вэ?

- Хохирогчийг гэмт этгээдүүд болон гэмт хэрэгт холбоотой хүмүүсээс хол, аюулгүй газар байрлуулах. Гэмт этгээдийг газар дээр нь таних, тодорхойлох боломжгүй бол тухайн хохирогчид (бүлэг хохирогч хүмүүс) ямар хүн давуу байдалтайгаар хандаж харьцаж байгааг анзаарах.
- Ямар ч тохиолдолд мэдүүлэг авах ажиллагааг яаран хийхгүй байх. Хэт яаравчлах нь ихэнх тохиолдолд хохирогчийг үзэж, туулсан аймшигт зүйлээ эргэж санахад өөрийгөө хүчлэхэд хүргэж, улмаар мэдүүлгийн үнэн бодит байдалд нөлөөлж болно.
- Ярилцлага хийхээс өмнө хохирогч тогтвортой байдалд орсон байх ёстой.
- Тогтвортой байдалд оруулах нь эмнэлгийн мэргэшсэн ажилтан (эрүүл мэндийн үнэлгээ, бие махбодын гэмтэл авсан байгаа бол эмнэлгийн тусламж шууд үзүүлэх), нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлдэг ажилтан, хоргодох байраар хангах үүрэг бүхий ажилтан болон зөвлөгөө өгөх ажилтан зэрэг олон салбарын хүмүүсийн оролцоотойгоор бүтдэг.
- Мэдүүлэг авах үедээ аль болох даруухан хувцаслаж, ярилцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Юун түрүүнд хэт олон асуулт асуулгүйгээр юу санаанд нь бууж байна түүнийг нь чөлөөтэй яриул. Хохирогчид өөрт нь болоод бусдад аюул занал учрахаас сэргийлэх үүднээс баримт нотолгоо, илүү гүнзгий шалгах шаардлагатай мэдээлэл өгч магадгүйг санахад илүүдэхгүй.
- Заналхийлэлд өртөж болзошгүй гэр бүл, ойр дотнын хайртай хүмүүсийг нь хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчдаар дараах зүйлсийг хийлгэнэ үү.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ярилцаж байсан бол тухайн хүн энэхүү гэмт хэргээс үүдэлтэй сэтгэл зүйн ямар ямар эмгэгтэй байсан, түүнд ямар шинж тэмдэг илэрч байсан талаар яриулах.

Гэмт хэргээс үүдэлтэй сэтгэл зүйн эмгэгтэй хохирогчид туслахын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан бэ?

4. ХОХИРОГЧ ГЭРЧ БОЛОХ НЬ

Хэргийн талаар болон өөрт нь юу тохиолдсон талаар хамгийн сайн мэдэж байгаа хүн бол хохирогч өөрөө гэдгийг мэдүүлэг авах гэж байгаа хүн ямагт санаж байх хэрэгтэй. Тухайн хохирогч гэмт этгээдийг мөрдөн шалгах ажиллагаанд гэрчээр оролцоход бэлэн болох нь мөрдөгч, прокурор нарт хамгийн чухал нотолгоог хэлэх хүн гарч ирлээ гэсэн үг. Хохирогчийг гэрчээр оролцуулахгүйгээр гэмт этгээдийг хүний эрхийг зөрчсөн ноцтой үйлдэлд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй юм. Ийм учраас эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны аль ч үе шатанд хохирогчийг оролцуулж, мэдүүлэг авах нь маш чухал байдаг. Хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид ч мөн ялгаагүй хүн

худалдаалах гэмт хэргийн хохирогчийг зөв олж тогтоосны үндсэн дээр гэмт этгээдүүдэд тохирсон ял оногдуулах үйл явцад оролцох боломжтой тул чухалд тооцогдоно.

Туршлагатай албан хаагчдын хэлдгээр үнэн зөв мэдүүлэг олж авах нь хамгийн бэрхшээлтэй хэсэг байдаг. Өөрт нь ямар зүйл тохиолдсон талаар бүрэн мэдээлэл авч, илүү дэлгэрэнгүй мэдүүлэг өгүүлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд хохирогчоос мэдүүлэг авах үед ямар ямар хүндрэл тулгарч болох талаар мэдэж байх нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авах үед тулгарах бэрхшээлүүд

1. Хохирогч хүн худалдаалах гэмт хэргийн бүхий л үйл явцад хууран мэхлэгдэх замаар мөлжлөгт өртсөн байдаг тул хамгийн том асуудал нь хүнд итгэх явдал байдаг. Энэ гэмт хэрэгт өртсөнөөр гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэгт орох зэрэг сөрөг үр дагаврууд гарч ирдэг нь бусад төрлийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаатай харьцуулахад үнэн зөв мэдүүлэг авахад хүндрэл учруулаад зогсохгүй ярилцлага хийхэд илүү их цаг зарцуулдаг. Мөн хохирогч танил биш, мэдэхгүй газар мөлжлөгт өртөж байснаас шалтгаалан үйл явдал нэг бүрийг нарийвчлан санахгүй байх, тус гэмт хэргийн үйлдэгдсэн газар, байршил нь яг хаана байсныг сайн ялгахгүй байх тохиолдол бий.
2. Хохирогчийн зүгээс хууль сахиулагч болон хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдад итгэхгүй байх, тэднийг маш ихээр сэжиглэж, харддаг бөгөөд тэдгээр хүмүүст ямар нэгэн байдлаар таагүй хандлага үзүүлдэг. Тийм ч учраас мэдүүлэг авах гэж/авч буй хүн хохирогчийн итгэлийг олоход анхаарлаа хандуулах хэрэгтэй.
3. Гэмт этгээдүүд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн эрэгтэйчүүдэд (албадан хөдөлмөр эрхэлж байсан) тухайн оронд байгаа нь эсвэл ажиллах нь хууль бус үйлдэлд тооцогдоно гэж итгүүлсэн, биеийн байцаалт, бичиг баримтыг нь эхнээсээ л хураагаад авчихсан, хууль сахиулагч, хил, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид ямар нэг байдлаар мэдэгдвэл өөрт нь аюултай гэж заналхийлсэн эсвэл өөрсдийгөө хууль бус цагаач тул гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно гэж итгэсэн байдаг тул мэдүүлэг өгөхгүй байх тохиолдол гардаг.
4. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүс ялангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогч сэтгэл зүйн хувьд шаналж, юу үзэж туулснаа, яаж тарчилж байсан талаарх ичгүүртэй байдал, өөрөө гэм буруутай эсхүл гутаан доромжлогдсон мэт санагдсанаас эсвэл гэр бүлийнхэн нь өөрийнх нь нөхцөл байдлын талаар мэдчих вий гэж айснаасаа болоод хэргийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй дэлгэж ярихгүй байх нь бий.
5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн санааг хамгийн ихээр зовоодог хоёр зүйл байдаг нь тэдний аюулгүй байдал, гэр бүл, амьдардаг газарт нь өөрийнх нь талаар дуулдах мэдээлэл юм. Хохирогч сэтгэл санаагаа цэгцэлж, дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөр болсон тохиолдолд эдгээр хоёр зүйлийг анхааралдаа авах нь зүйтэй.
6. Аль ч гэмт хэргийн байцаалтын үе шатанд хохирогч мэдүүлгээсээ буцах явдал байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авч байхад энэ үзэгдэл илүү түгээмэл ажиглагддаг бөгөөд энэ нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд нөлөөлдөг. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч дахин дахин мэдүүлгээ өөрчилж байгаа гэрчийг худлаа ярьж байна, ярьсан зүйл нь нотолгоо болж чадахгүй гэж баримт нотолгоог хялбархан няцаах боломжтой. Гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэг, заналхийлүүлсэн, айлгаж дарамтлуулсан зэрэг олон нөхцөл байдлаас шалтгаалан хохирогч мэдүүлгээ өөрчилж байдаг. Тиймээс хохирогчоос мэдүүлэг авч байгаа албан хаагч хохирогч мэдүүлгээсээ буцаж байгаагийн цаад учир шалтгааныг ойлголгүйгээр,

түүнийг худал ярьж байна хэмээн дүгнэх эсвэл нэг хэсэг нь худал байвал үлдсэн бүх зүйл нь худал гэж дүгнэх хандлагатай байдгийг санах шаардлагатай. Иймд мэдүүлэг болгоны үнэн зөвийн магадлалыг бусад арга хэрэгслээр аль болох сайтар шалгаж байх хэрэгтэй.

7. Тухайн хохирогчийн зан заншил, соёлд нийцүүлэн харилцах нь тэдэнд таатай, дотно, аюулгүй мэдрэмж төрүүлж, хамтрах хүслийг нь нэмэгдүүлж өгдөг талтай. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт байлгасан гэмт хэргийн тухайд зарим хохирогчийн гэр бүл тэднийг хүчээр биеэ үнэлсэн явдал нь гэр бүлийнх нь нэр хүндийг гутаасан ичгэвэртэй явдал гэж үзэх явдал байдаг. Хууртагдаж, айлган сүрдүүлэлтэд өртөж энэ гэмт хэргийн хохирогч болсон хэдий ч гэр бүл, найз нөхөд нь өөрт нь юу тохиолдсон талаар олж мэдэх вий гэхээс маш их санаа зовдог.
8. Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байх үед хохирогч хэд хэдэн шалтгааны улмаас жинхэнэ насаа хэлэлгүй нуух явдал байдаг. Насаа үнэн зөвөөр хэлэхгүй байх нь хохирогчийг зөв тогтоох ажиллагааг хүндрүүлдэг төдийгүй шүүхийн өмнө зөрүүтэй мэдээлэл өгч, үүнийг нь эсрэг тал овжиноор ашиглах явдал гардаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчдаар дараах зүйлсийн талаар яриулна уу.

Гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэгт орсон хохирогчтой ярилцлага хийж байсан туршлага, тулгарсан бэрхшээл.

Тулгарсан бэрхшээлээ хэрхэн даван туулсан бэ?

Мэдүүлэг авах нөхцөл байдал, хохирогчоос мэдүүлэг авах албан хаагч

Хохирогчоос мэдүүлэг авах арга, ямар нөхцөл байдалд уг ажиллагааг явуулах вэ гэдгээс хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт олж авах эсэх нь хамаардаг учраас онцгой ач холбогдол өгөх хэрэгтэй. Ярилцлага хийх албан хаагч дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Орчин тойрноо болон мэдүүлэг авах аргаа албаны бус энгийн байлгах нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлнэ.
- Нөхцөл байдал тохирч, хохирогч өөрөө хүссэн тохиолдолд хохирогчийг өмгөөлөгч эсвэл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нь байлцуулан (ялангуяа хохирогч нь хүүхэд, эмэгтэйчүүд байвал) мэдүүлэг авна. Энэ нь санаа зовох, хардаж сэрдэх байдлыг намжааж, тайвшруулахад тусалдаг. Хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын хувьд хохирогчийг тогтоохдоо аль болох эмэгтэй ажилтныг байлцуулах нь оновчтой.
- Боломжтой бол хохирогчтой ижил хүйсийн ажилтнаар мэдүүлэг авах ажиллагааг явуулах хэрэгтэй. Хохирогч ямар нэгэн зүйл хүсвэл (ялангуяа хохирогч нь хүүхэд, эмэгтэйчүүд байвал), аль болох биелүүлэхийг чармайх шаардлагатай.
- Мэдүүлэг авч буй албан хаагч нь хүн худалдаалах гэмт хэрэг болон гэмт этгээдүүдийн үйлдлийн аргын талаар гүнзгий мэдлэгтэй байж, хохирогчоос оновчтой асуултууд асуух чадвартай байх ёстой.
- Мэдүүлэг авч байгаа албан хаагч мөрдөн шалгах ажиллагааны туршид болон шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаа дуустал тухайн хохирогчтой ажиллавал, нэг нэгнийгээ ойлгох ойлголцол нэмэгдэж, итгэлцэл үүсдэг.

- Хохирогч гэрч болж байгаагийн хувьд өөрийнхөө эдлэх эрх, үүргийн талаар бүрэн мэдээлэл авах ёстой. Тэд хуулийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа талаараа бүрэн ойлголт, мэдээлэлтэй байгаа тохиолдолд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үнэнчээр хамтран ажилладаг. Боломжтой бол хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллага, зөвлөх зэрэг хүмүүс хохирогчид туслах зорилгоор мэдүүлэг авах үед байлцаж болно.
- Мэдүүлэг авах, эрүүл мэндийн үзлэгт оруулах, сэжигтнийг таньж олуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийг оролцуулахдаа заавал "шаардлагатай мэдээллийг хангалттай өгсний үндсэн дээр зөвшөөрлийг нь авах зарчим"-ыг баримтлан ажиллах шаардлагатай.
- Хохирогч мэдүүлэг өгч буй тэр улсын хэлийг мэддэггүй бол орчуулагч, хөгжлийн бэрхшээлтэй бол хэлмэрчээр дамжуулан харилцана.

САНАМЖ:

Мэдүүлэг авах ажиллагаа албадлагын шинжтэй байж болохгүй. Мэдүүлэг авах эхний зорилго нь хохирогчийг олж тогтоох, удаах зорилго нь хохирогчийг үнэн зөв мэдүүлэг өгөхөд туслалцаа үзүүлэх, сүүлийнх нь мөрдөн шалгах ажиллагаа болон гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татахад түүнтэй хамтран ажиллах боломжит нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Гэрч, хохирогчийн хувийн нууцаа хамгаалуулах эрх, мэдээллийг нууцлах тухай

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид (ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд) өөрсдийг нь хэн гэдгийг бусад хүмүүс мэдэхээс маш их санаа зовж, айж шаналдаг. Ингэтлээ айх хоёр шалтгаан тэдэнд байдаг. Нэгдүгээрт, гэмт этгээдүүд өөрийг нь гэрч болж, цагдаагийн байгууллагатай ажиллаж байгааг мэдэхээс айх, хоёрдугаарт гэр бүл, ойр дотнын хүн, найз нөхөд нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрсдийнх нь талаар мэдэхээс айдаг. Энэ хоёр хүчин зүйлийг мөрдөгч, прокурорууд анхааран ажиллах нь зүйтэй.

НҮБ-аас 2000 онд баталсан Хүн худалдаалахын эсрэг протоколын II хэсэгт "хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах" талаар тусгасан байдаг. 6 дугаар зүйлд энэхүү гэмт хэрэгт өртсөн хүнд туслалцаа үзүүлэх, хамгаалах талаар заасан бөгөөд "Оролцогч улс бүр үндэснийхээ хууль тогтоомжид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг оролцуулсан аливаа ажиллагаандаа хувийн нууцыг хамгаалж, гэмт хэргийн талаарх мэдээллийг нууцална" гэж заасан байдаг.

Гэрч, хохирогчдын хувийн нууцаа хамгаалуулах эрх, мэдээллийг нууцлах тухай холбогдох хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СЭДЭВ 3: ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ НЬ

1. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ

Мэдүүлэг авах зорилтууд

Дараах зорилтуудыг хангахын тулд хохирогчоос мэдүүлэг авна. Үүнд:

1. Болсон үйл явдлын нарийн дэс дарааллыг тогтоох.
2. Гэрч, хохирогчийн хэлсэн зүйл, мэдүүлгийг нотолгоо болгон ашиглах.
3. Нотлох баримтаар сэжигтэн этгээдийг олж тогтоож, баривчилж, эрүүгийн хариуцлагад хүлээлгэх.
4. Хохирогчийн гэр бүл, бусад хохирогч болон хохирогч болох магадлалтай хүмүүст учирч болзошгүй эрсдэлийг үргэлжлүүлэн тооцох.
5. Хэргийг хянан шалгах, шийдвэрлэх явцдаа нэмэлт байдлаар эсвэл "Б" хувилбар болгон урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гүйцэтгэх ажил явуулж болох боломж, хувилбаруудыг тодорхойлох.

Эмзэг байдалд орсон, айж эмээсэн, түгшүүртэй байдалд байгаа гэрчүүд (хүүхэд, насанд хүрэгчид)-ээс мэдүүлэг авахдаа сайн туршлагаас аль болох ашиглавал, нотолгоо болж чадахуйц мэдээлэл олж авдаг. Цагдаагийн албан хаагч, нийгмийн ажилтан, прокурор, өмгөөлөгч, шүүгч нар гээд бүхий л албан хаагчид гэрчийн нөхцөл байдал, хүсэл сонирхлыг харгалзан үзэх явдал чухал юм.

2. ЯРИЛЦЛАГА ХИЙХ "PEACE" ЗАГВАР

Дэлхийн олон улс оронд гэмт хэргийн хохирогч, гэрчтэй ярилцлага хийх мөн сэжигтнийг байцаахад PEACE[17] ярилцлага хийх загварыг ашигладаг.

PEACE гэсэн товчлол дараах ойлголтыг илэрхийлдэг.	
P	Төлөвлөх, бэлтгэх
E	Харилцан ойлголцлоо бэхжүүлэх, тайлбарлах
A	Мэдүүлэг авах
C	Дуусгах
E	Үнэлгээ хийх

P – Ярилцлагыг төлөвлөх ба бэлтгэх шат

Гэрч, хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны гол найдлага тавих зүйл нь аудио эсвэл дүрс бичлэг зэрэг техник, технологи биш харин хүн хоорондын харилцаа юм. Тэдгээр техник, технологи нь (ярилцлага, байцаалт зэргийг бичиж, шүүх хурлын үеэр ашигладаг) ярилцлагыг хялбар байдлаар явуулах, шүүх хуралдааны үеэр гардаг хүндрэлийг бууруулах, гэрчийн мэдүүлгийн чанартай, нотолгоотой байдалд нөлөөлдөг эерэг талуудтай ч хамгийн чухал зүйлд тооцогддоггүй бөгөөд харин ярилцлага авч буй албан хаагчаас хамгийн гол үр дүн шалтгаална.

Энд заах аргачлалыг ашиглахад ямар нэг тоног төхөөрөмж шаардлагагүй, ямар ч орчин нөхцөлд ашиглах боломжтой. Эмзэг, хүнд нөхцөлд байдалд байгаа гэрч, хохирогчоос мэдүүлэг

17 "Хууль сахиулах албан хаагчдад зориулсан Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага"-ын Модуль 8-Хохирогчтой ярилцлага хийх нь хэсгээс авав. НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Вена, 2009.

авах ажиллагааг урьдчилан сайтар төлөвлөх хэрэгтэй. Төлөвлөгөөндөө хэдий хэмжээний цаг зарцуулна тэр хэмжээгээр сайн мэдээлэл цуглуулж, хожим мэдүүлгээсээ буцах, алдаа гарах зэрэг эрсдэлийг бууруулна.

Хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг төлөвлөх үед хэрэг болох дараах зөвлөгөөг харна уу.

- Хохирогчийг гэмт хэргийн газраас чөлөөлөгдөж ирсний дараа буюу мэдүүлэг авч эхлэхээс өмнө эрүүл мэндийн анхан шатны үзлэгт оруулж, эхний үнэлгээ хийлгэх хэрэгтэй бөгөөд эрүүл мэндэд нь ямар нэг ноцтой асуудал байгаа эсэх эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай эсэх талаар хохирогчоос өөрөөс нь асуух хэрэгтэй. Үнэлгээг хохирогч цагдаагийн байгууллагын анхааралд өртсөний дараа, мэдүүлэг авч эхлэхээс өмнө хийх шаардлагатай.
- Хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хохирогч байж болзошгүй гэж үзэж байгаа хүнээсээ асуулт асуух байдлаар анхан шатны үнэлгээ хийж болно.
- Мэдүүлэг авч эхлэхээс өмнө, мэдүүлэг авах ажиллагааны төлөвлөгөөг бичгээр гаргасан байх ёстой. Хүн худалдаалах гэмт хэргийн мөн чанар, худалдаалах үйл явц, гэмт хэрэгт оролцсон хүмүүс, очсон байршил, өөрт нь нөлөөлсөн байдал зэргээс шалтгаалан, хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаа ихэнхдээ хүндрэлтэй тулгардаг.
- Хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид (Модуль 3-т үзсэн шинж тэмдгүүдэд үндэслэн) хохирогч байж болзошгүй эсвэл жинхэнэ хохирогчтой анхан шатны ярилцлага хийх асуултуудыг урьдчилан бэлтгэсэн байх шаардлагатай.
- Тухайн хүний талаар ил байгаа бүхий л мэдээллийг цуглуулах. Ямар улсын иргэн/үндэстэн гэдгээ хэлсэн үү? Ямар хэлээр ярьж байсан бэ? Хохирогчийг анх хаанаас илрүүлсэн бэ?, Биеэ үнэлэх газар, албадан хөдөлмөр эрхэлж байсан ямар нэг газар эсвэл тээврийн хэрэгслээс (галт тэрэг, усан онгоц, автобус гэх мэт) илрүүлсэн үү? Өөрийгөө хэдэн настай гэж хэлсэн бэ? Хэдэн настай харагдаж байна?
- Хохирогчдыг бие биеэс нь тусгаарлах, сэжигтнийг ч тусад нь байлгах хэрэгтэй. Хохирогчдыг нэг дор байлгах нь ярих зүйлээ, үгээ нэгтгэх боломж олгож болзошгүй. Мөрдөн шалгах ажиллагааны эхэн үед хэн нь хохирогч, хэн нь сэжигтэн гэдгийг ялгах амаргүй байдаг. Хохирогч сэжигтнийг харахаараа ихэвчлэн айдаст автдаг.
- Хохирогчийг олж тогтооход өөр хүмүүс байсан бол хамт байсан хүмүүс нь хэн болох, хаанаас ирсэн, ямар хэлээр ярьдаг талаар олж мэдэх, дотоодын болон олон улсын мэдээллийн сангаас хайж үзэх, тэдгээр хүмүүсийн талаар боломжтой бүхий л мэдээллийг олж цуглуулах (боломжтой нөхцөлд, шаардлагатай гэж үзвэл).
- Хууль сахиулагч, хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтан эсвэл хэн нэг гэрч тухайн хохирогчийг анхлан тогтоож илрүүлсэн бол тухайн хэрэг дээр ажиллаж байгаа мөрдөгч тэдгээр анхлан илрүүлсэн хүнтэй холбогдож хохирогч анх ямар нөхцөл байдалд байсан талаарх мэдээллийг авах хэрэгтэй. Худалдагдсан байсан газар нь өөр хүмүүс хамт байсан бол хэн нэг нь давамгай эрхтэй эсвэл захиран тушаах байдлаар харьцаж байсан эсэх, хохирогчийг анх илрүүлсэн хүнд юу ярьж хэлсэн талаар мэдэж авах хэрэгтэй.
- Мөрдөгч дээрх байдлаар олж авсан мэдээлэл дээрээ тулгуурлан гэмт хэргийн ерөнхий дүр зургийг гаргана. Зарим тохиолдолд хохирогчийн гэр бүл болоод түүнтэй холбоотой хүмүүс эрсдэлд орсон нь тодорхой гэж үзвэл мэдүүлгийн эхэн үед зарим асуултыг шууд асуух хэрэгтэй. Мөрдөгч тухайн хохирогч болоод гэр бүлийнхнийх нь нөхцөл байдалд

эрсдэлийн үнэлгээг нэн даруй хийх шаардлагатай.

» Ил мэдээлэл дээрээ тулгуурлан мөрдөн шалгах ажиллагааг цаашид хэрхэн үргэлжлүүлэх, мэдүүлэг авсны дараа ямар арга хэмжээ авах зүг чиг тодорхой болно. Үүнд хохирогчийн хувийн мэдээллийг нарийвчлан судлах, хаашаа худалдаалагдсан болох, тухайн хохирогчийн мөлжлөгт өртөж байсан талаар гэрчлэх хүн олох зэрэг ажил багтана. Хохирогч тухайн орны иргэн биш, тус улсын хэлээр ярьдаггүй бол цагдаагийн албан хаагч, хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч, прокурорууд мэдүүлэг авах ажиллагааг төлөвлөх үедээ бүхий л шатанд орчуулагч, хэлмэрчийг оролцуулах нь чухал.

Мэдүүлэг авах газар

Бэлтгэл хангаж байх үед мэдүүлгийг хаана авах нь илүү үр дүнтэй гэдгийг бодолцох нь зүйтэй. Мэдүүлэг авах газрыг сонгоход дараах зүйлийг анхаарна уу.

» Мэдүүлгийг хохирогчийн хувьд танил бус орчинд авбал хохирогч сандарч, тэвдэх болов уу?

» Танил орчинд мэдүүлэг авбал мэдүүлэгт нь сөргөөр нөлөөлөх магадлал байгаа эсэх

» Мэдүүлэг авахаар сонгосон газарт туслалцаа, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (Жишээ нь: хэлмэрч, эрүүл мэндийн тусламж үзүүлэх хүн г.м) бэлэн байгаа эсэх. Ялангуяа сэтгэл зүйн хүчтэй эмгэг байдалд орсон хохирогчтой ярилцах үед маш чухал.

» Ярилцлага хийх газар аюулгүй, цэвэрхэн, саад болох зүйлсээс хол, хохирогчийн ярьж байгааг өөр хүнд харахааргүй, сонсохооргүй байх.

Хохирогчтой хэн ярилцах вэ?

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тусгай алба/нэгжийн (хэрэв байдаг бол) албан хаагч мэдүүлэг авах, эсвэл мэдүүлэг авах үеэр байлцаж мөрдөгчид туслах хэрэгтэй. Ийм тусгай чиг үүрэг бүхий алба байхгүй бол гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байсан туршлагатай ажилтан гэрч, хохирогчоос мэдүүлэг авах нь зүйтэй.

Хүүхэд, эмэгтэйчүүдээс мэдүүлэг авах үед төрийн бус байгууллагыг оролцуулах хуулийн зохицуулалттай байдаг бол энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын туршлагатай хүнийг мэдүүлэг авах ажиллагаанд оролцуулна.

Мэдүүлэг авах албан хаагч хохирогчоос мэдүүлэг авах үедээ нийгмийн ажилтан эсвэл төрийн бус байгууллагыг оролцуулахаар шийдвэрлэсэн бол ярилцлагад оролцох бүх талуудтай өмнө нь уулзаж, ямар зорилгоор тухайн мэдүүлэг авах ажиллагааг хийж байгаа, ямар арга хэлбэрээр явуулах талаар урьдчилан зөвлөлдөж ярилцсан байна.

Е – Тайлбарлаж ойлголцлоо бэхжүүлэх шат

Мэдүүлэг авах ажиллагааны энэ үе шатанд хохирогчтой харилцан итгэлцэл бүхий холбоо тогтоох хэрэгтэй. Энэ нь мэдүүлэг өгөх гэж буй хүнтэйгээ ойлголцож, ойртох явц юм. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой үйл явцыг тайлбарлаж, ойлгуулах нь маш өргөн хүрээг хамарна. Ерөнхийдөө мэдүүлэг авах ажиллагааны үеэр ямар үйл явц явагдах, өгсөн мэдээллийг нь хэрхэн ашиглах болон хохирогчийн эрхийн талаар тайлбарлаж хэлнэ.

Мэдүүлэг авах баг болон хохирогчийн хамгийн анхны уулзалт, түүнээс төрөх анхны сэтгэгдэл нь мэдүүлгийг амжилттай болох эсэх, цаашдын харилцаа ямар байхыг шийдвэрлэдэг бөгөөд мэдүүлгийн эхлэл зөв байх нь маш чухал. Мэдүүлгийн энэ үе шат нь хохирогчид мэргэшсэн, тусгай хүмүүс энэ хэрэг дээр ажиллаж байгаа тул итгэж болно гэсэн ойлголтыг төрүүлж, итгэл олоход чиглэгдэнэ.

Сэдэв 2.2-т дэлгэрэнгүй өгүүлсэнчлэн, ихэнх хохирогч сэтгэл зүйн дарамтад орж, сэтгэл санаа нь хямрах өндөр магадлалтай байдаг. Ярилцлага авч буй хүн хохирогчийн гаргаж болох зан авир, итгэл төрүүлэх оролдлогын үеэр учирч болох бэрхшээлийн талаар мэдээлэл сайтай байх хэрэгтэй.

Мэдүүлгийн үеэр байлцах хүмүүс өөрсдийгөө танилцуулж, хаана юу хийдгээ хэлснээр мэдүүлгийг эхлүүлнэ. Тэнд байх бүх хүмүүс ашиглах үг хэллэгээсээ гадна дохио зангаандаа онцгой анхаарч, хохирогчийг тайвшруулж, санааг нь зовоосон, эвгүй байдалд оруулсан, ичээсэн аливаа үйлдэл гаргахгүй байхад анхаарах хэрэгтэй.

Ярилцлага хийж буй хүмүүс дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд :

- Эмзэг байдалд байгаа гэрч, хохирогчоос үнэн зөв мэдээлэл авахын тулд гэрч ямархуу байдлаар харилцах хүсэл, сонирхолтой байгаа болон мэдүүлэг хохирогчид ямар байдлаар нөлөөлж болохыг маш мэдрэмжтэйгээр анзаарч ажиллах шаардлагатай. Анхаарал хандуулах ёстой гол зүйл нь гэрчийн эмзэг байдал, нотлох баримт гаргаж өгөх эх сурвалж гэхээсээ илүүтэйгээр тэднийг хүн гэдэг талаас нь харж, хохирогч төвтэй арга барилаар ажиллах нь чухал.
- Боломжтой бүхий л үед гэрч, хохирогчид ямар шалтгааны улмаас тухайн асуултыг өөрөөс нь асууж байгааг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Яагаад асууж байгаа цаад учир шалтгааныг ойлгосон хохирогч хамтран ажиллах хүсэлтэй болж, айх эмээх байдал нь багасдаг.
- Мэдүүлэг авч буй албан хаагч ярьж байгаа байдал, хандлагадаа анхаарч, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй, аливаа ялгаварлан гадуурхсан хандлага гаргахгүй байхад анхаарч ажиллах нь чухал.
- Мэдүүлгийг эхлүүлэхээс өмнө мэдүүлэг авч буй албан хаагч хохирогч мэдүүлэг өгөхөд бэлэн болсон эсэх, мэдээлэл өгч эхлэхэд асуудалгүй байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй. Ямар нэг өвдөлт, таагүй мэдрэмж төрж байгаа эсэхийг тусгайлан заавал асуух хэрэгтэй. Бие нь өвдөх зэрэг эрүүл мэндийн асуудал гарсан бол эмнэлгийн туслалцаа үзүүлж, мэдүүлгийг түр хойшлуулна.
- Мэдүүлэг авч буй албан хаагч хохирогчийг тухайн гэмт хэргийг хянан шалгах ажиллагаанд хамтран ажиллах эсэхээ "мэдээлэлд үндэслэн зөвшөөрсөн" эсэхийг нягталж үзсэний дараа мэдүүлгийг эхлүүлнэ.

Ярилцлагын хурд

Эмзэг байдалд байгаа ихэнх хохирогч мэдүүлгийг аажуу тайван байдлаар явуулахыг хүсдэг. Судалгаа болон сайн туршлагуудаас харвал, мэдүүлэг авч буй албан хаагч дараах зүйлийг мөрдөж ажиллах нь үр дүнтэй байдаг. Үүнд:

- Тайван, удаан ярих;
- Хэлсэн зүйлийг ойлгох, дотроо тунгаан бодох цагийг хохирогчид олгох;

- Хариултдаа бэлтгэх хугацаа өгөх;
- Хохирогч асуултад удаанаар хариулбал тэвчээртэй байх, ялангуяа хэн нэгнээр дамжуулж харилцаж байгаа үед;
- Асуултаа ар араас нь угсруулж тавихаас зайлсхийх;
- Хохирогчийг ярьж байх үед яриаг нь таслахгүй байх;
- Удаан анхаарал төвлөрүүлэх боломжгүй байж мэдэх тул завсарлага авах боломжоор хангах.

Тухайн хэргээс шалтгаалан мэдүүлэг авах ажиллагааг хэд хэдэн удаа хийж болох бөгөөд удаан хугацаанд үргэлжлэх магадлалтай. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн өгсөн мэдүүлэг үнэн бодитой эсэхийг шүүх хуралдааны үеэр ихэнхдээ сорьж асуудаг учраас өгсөн мэдээлэл бүрийг нэг бүрчлэн шалгаж, нягталсан байх нь хохирогчийн өгсөн мэдээлэл үнэн гэсэн магадлалыг нэмэгдүүлж өгдөг.

САНАМЖ:

Зарим гэрч, хохирогч гэмт этгээдтэй анх уулзаж хэрэгт холбогдсондоо өөрийгөө буруутай гэж үздэг. Эмзэг байдалд байгаа гэрч өөрийгөө буруу, хууль бус зүйл хийсэн болохоор л байцаагдаж, асуугдаж байна гэж хүлээж авдаг тул мэдүүлэг авч буй албан хаагч үүнийг анхааралдаа авч ажиллах хэрэгтэй. Мэдүүлэг авч буй албан хаагч энэ тал дээр гэрчийг санаа зовох шаардлагагүй хэмээн тайвшруулж болох ч ярилцлагын үр дүн ямар байх талаар таамаглах, ямар нэг амлалт өгөх хэрэггүй.

Мэдүүлэг авч буй албан хаагч хохирогчоос хэтэрхий хувийн шинж чанартай асуулт (жишээ нь секс)-ыг шулуухан, эрээ цээргүй асууж, дэлгэрэнгүй хариулахыг шаардаад байвал хохирогч хариулахаас аль болох зайлсхийх болно. Өөрөө сонирхож байгаа учраас биш гэмт хэргийн нөхцөл байдлыг мэдэх шаардлагатай байгаа учир зарим асуултыг тавьж байгаагаа тайлбарлах нь зүйтэй. Энэ шалтгаанаар дэлгэрэнгүй мэдээлэл авах нь ямар нэг дүрмийг зөрчиж байгаа хэрэг биш юм.

Зарим гэрч асуултад ялангуяа хүний хувийн шинж чанартай холбоотой зүйлд хариулж байгаадаа гутрах, ичих, дургүй нь хүрэх явдал бий. Энэхүү хохирогчтой итгэлцэл үүсгэх шаардлагатай байгаа үе шатанд мэдүүлэг авч буй албан хаагч нь хохирогчийг хүндэтгэж, хүнлэг харьцаж, ямар санагдаж байгааг нь ойлгож байгаагаа илэрхийлэх ёстой.

Мэдүүлэг авч буй албан хаагч хохирогчид аливаа амлалт эсхүл баталгаа гаргахаас болгоомжлох хэрэгтэй. Мэдүүлэг авах багийн үүрэг бол болсон хэрэг явдлын талаар нотлох баримт олж, гэмт хэргийг шударгаар хууль ёсны дагуу шийдвэрлэх боломжийг олгох явдал гэдгийг хохирогчид тайлбарлан хэлэх хэрэгтэй. Эцсийн шийдвэрийг ярилцлага авч буй баг биш шүүх гаргадаг учраас гэмт этгээдүүд ял шийтгэгдэнэ гэсэн баталгаа өгөх боломжгүй гэдгийг мөн ойлгуулах нь чухал.

А - Үндсэн мэдүүлэг

Хамгийн эхний үе шат бол хохирогчийн яриаг тасалдуулалгүйгээр яриулах явдал юм. Үүнийг заримдаа "санаж байгаа бүхнээ ярих" гэж нэрлэдэг. Мэдүүлэг авч буй албан хаагч хохирогчийн яриаг дэлгэрүүлж яриулах, тодруулж асуух зэргээр энэ аргыг ашигладаг. Ихэвчлэн ярилцлага хийсний дараагаар хохирогчийн ярьсан зүйлд зөрүүтэй мэдээлэл гарвал эцсийн шатанд мэдээллийг нягталж асуулт асуудаг.

PEACE загварыг ашиглахдаа мэдүүлэг авч буй албан хаагч хохирогчоор болсон явдлыг өөрөөр нь яриулж, оносон асуултууд асуух замаар мэдээллээ баяжуулж, дэлгэрүүлж авдаг.

Чөлөөтэй яриулах

Эмзэг байдалд байгаа хүмүүсээс тохиромжгүй, оновчгүй асуулт асуух нь болсон зүйлээ сайн санахгүй байгаагаас илүүтэйгээр хохирогчийн өгөх мэдээллийг гуйвуулах боломжтойг судалгаа харуулдаг. Ийм учраас мэдүүлгийн эхнээс л яг оносон, тохиромжтой асуулт асуух нь чухал юм. Гэрчийг өөрөөр нь чөлөөтэй яриулахын тулд бүх хүчээ дайчлан ажилла.

Чөлөөтэй яриулах үе шатанд мэдүүлэг авч буй албан хаагч гэрчийг хэлэх гэсэн зүйлээ өөрийнхөө үгээр илэрхийлэн хэлэх боломжоор хангахын сацуу "Өөр юу болсон бэ?," "Нэмж хэлэх зүйл байна уу?", "Илүү ойлгомжтой болгохын тулд та хэлсэн зүйлээ арай өөр байдлаар тайлбарлаж болох уу?" зэрэг асуулт асуух байдлаар нэмэлт мэдээлэл авч болно. "Тайлбарлах", юу болсныг "хэлэх" зэрэг үйл үгийг яриандаа ашиглавал үр дүнтэй байдаг.

Сөрөг, муу зүйлийн талаар ярихдаа эмзэг байдалд байгаа гэрч, хохирогч чухал биш зүйлийн талаар эхэлж яриад, ярьж болно гэж үзсэн тохиолдолд илүү нарийн, хэрэгтэй мэдээллийг өгч эхлэх магадлалтай. Ярихыг хүсэхгүй байгаа зүйлсийнх нь талаар ярихыг шахаж шаардаж болохгүй.

Гэрчийн ярьж байгаад анхаарлаа хандуулж байгаагаа харуулж, сайн сонсох нь маш чухал. Гэрчийн хэлсэн зүйлд ямар нэг байдлаар хариу үйлдэл үзүүлэх нь анхааралтай сонсож байгаагаа илэрхийлэх боломж олгоно. Ярилцлага авч буй хүн хохирогчийг ярьж байх үед толгойгоо дохих, "аан за, тийм", "та цааш нь яриач", "та үргэлжлүүлж ярихгүй юу" зэргээр дэмжиж үргэлжлүүлэн яриулах хэрэгтэй.

САНАМЖ:

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, эмзэг байдалд байгаа хүнээс мэдүүлэг авахдаа тухайн хүнд эхнээсээ л маш их анхаарал, халамжийг тавих нь чухал. Учир нь энэ гэмт хэрэгт өртсөн ихэнх гэрч аливаа санал хүсэлтэд нээлттэй байдалтай болсон байдаг. Туршлагаас харахад хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байгаа эсрэг талын өмгөөлөгч, хохирогчоос мэдүүлэг авсан албан хаагч гэрчээс мэдээлэл авсан аргад үндэслэн, өөрийнхөө талд ашигтайгаар эргүүлэхийг чармайдаг.

Хуульд нийцэж буй эсэх

Эмзэг байдалд байгаа зарим хохирогч ярилцлагын үеэр өөртэй нь ярилцаж байгаа хүний хэлсэн бүхнийг биелүүлэх хандлага ажиглагддаг бөгөөд ялангуяа ярилцахаар ирсэн хүн төрийн албан хаагч гэж бодвол энэ хандлага бүр ч илүү анзаарагдана. Зарим гэрч төрийн албан хаагч харахаараа айж, эмээх байдал нь нэмэгддэг. Олон гэрч, хохирогч өөрсдийгөө хэрхэн хамгийн сайнаараа илэрхийлэх вэ гэж санаа нь зовж байдаг. Юу асууж байгааг ойлгохгүй байсан ч, би ойлгосонгүй гэж хэлэхийн оронд хариулт өгөхийг хичээж эхэлдэг. Асуултыг ойлгохгүй байна гэдгээ хэлэхээр нь мэдүүлэг авч буй албан хаагч эсвэл гэрчийн аль нэгний буруугаас болсон гэсэн ойлголт төрүүлэхээс эмээдэг. Эмзэг байдалд байгаа зарим хүн иймэрхүү сэтгэгдэл төрүүлэхээс аль болох зайлсхийж байдаг. Тийм болохоор мэдүүлгийн үед иймэрхүү асуудал гаргахгүйн тулд гэрч тухайн асуултад хариулж мэдэхгүй байгаа тохиолдолд "би мэдэхгүй байна" гэсэн хариулт өгөхөд асуудалгүй гэдгийг ойлгуулах нь чухал. Энэ нь гэрчийг хараагүй, мэдэхгүй зүйлийнхээ талаар таамгаар ярих эсвэл санахгүй байгаа зүйлээ

ярих хэмжээнд дарамтад оруулахаас сэргийлж буй явдал болно.

Асуулт асуух хэв маяг

Судалгаа болон туршлагаас харахад мэдүүлэг авч буй албан хаагч хэдэн гол дүрмийг асуулт асуух үедээ хэрэгжүүлбэл үр дүнтэй байх бололцоотой. Үүнд:

- Асуултууд энгийн байх;
- Цагдаагийн эсвэл хуулийн нэр томьёо, этгээд үг хэллэг хэрэглэхгүй байх;
- Асуултууд хийсвэр үгс эсвэл хийсвэр утга санааг илэрхийлээгүй байх;
- Дагалдах олон асуултгүй, энгийн, богинохон байх;
- Асуултууд далд утга агуулаагүй, зааварласан шинжгүй байх.

Хохирогчийн яриаг чиглүүлэх олон төрлийн асуулт байдаг гэдгийг ойлгох нь чухал. Мэдүүлэг авч эхлэхдээ боломжтой бол нээлттэй асуултуудаар эхэлж, яваандаа нарийвчилсан асуулт болон хаалттай асуулт руу шилжинэ. Шууд, тулгасан асуултууд сүүлчийн найдвар байдлаар хамгийн шаардлагатай үед л ашиглагдах нь зүйтэй.

Нээлттэй асуулт

Нээлттэй асуулт гэдэг нь гэрч тухайн асуултад ямар нэг сэдэвт баригдалгүй хариулахад чиглэгдсэн асуултуудыг хэлнэ. Ийм төрлийн асуултууд гэрчийг өгөх мэдээллээ хянах боломж олгохын зэрэгцээ ерөнхий сэдвийн дор хэрхэн хариулахаа өөрөө сонгох эрхийг өгдөг. Нээлттэй асуултыг асуулт асууж байгаа хүн ямар нэг таамаг дэвшүүлэхгүй, тодорхой нэг хариулт авах зорилгогүйгээр асуудаг. Хохирогчтой чөлөөтэй ярилцлага хийж байхад дутуу орхигдуулсан нарийн мэдээлэл хэрэгтэй байвал нээлттэй асуулт асууж яриулах боломжтой байдаг.

Нээлттэй асуултын жишээ дурдвал: "Та .....-ны талаар ярихгүй юу?; Та.....-ны талаар арай дэлгэрэнгүй хэлбэл?; Таны хэлсэн ..... хэсгийг илүү сайн ойлгох хэрэгтэй байна" г.м. Эмзэг, хэцүү байдалд байгаа хохирогчид өөрсдийг нь буруутгаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж болзошгүй тул тэднээс "яагаад" гэдэг үг орсон асуулт асуухаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Зарим гэрч, хохирогчийн хувьд болсон явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөсөө өмнө ерөнхий үйл явдлын талаар ярьж эхлэх нь илүү амар байдаг. Ингэж ерөнхий байдлаар ярьж эхэлснээр үүнтэйгээ холбоотой нарийн үйл явдлуудаа эргэн санахад нь нэмэр болдог. Ярилцлагын эхэнд буюу хохирогч бэлэн болоогүй байхад нарийн асуултууд руу яаран орохгүй байхыг анхаарна уу.

Нарийвчилсан асуулт

Нарийвчилсан асуултыг хохирогчийн өгсөн мэдээлэлд үндэслэн, тодруулах, лавлах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор таамаг дэвшүүлэхгүй байдлаар асууж болно. Зарим хохирогч чөлөөтэй яриулах хэсэгт эсвэл нээлттэй асуултад сайн хариулж чадахгүй байсан бол нарийвчилсан асуулт асуух үед сайн хариулах тохиолдол байдаг. Гэхдээ ийм төрлийн асуулт асуух үедээ хэтэрхий нарийн мэдээлэл шаардсан асуулт асуухгүй байхыг хичээх хэрэгтэй. Үүнд хаана, хэзээ, юу, хэн, яагаад гэсэн асуултууд ордог.

Хаалттай асуулт

Хаалттай асуулт нь хохирогчид асууж буй асуултад хязгаарлагдмал хариултаас сонгож хариулах боломж олгодог. Эмзэг, хүнд байдалд байгаа зарим хохирогч хаалттай асуултад хариулахад амар санагдаж магадгүй. Гэвч ийм төрлийн асуулт асууж эхлэхдээ хоёрхон хариулттай (ялангуяа тийм/үгүй гэсэн хариулт шаардсан асуултууд) асуултаас эхлэхгүй байхад анхаарах хэрэгтэй. Тийм/ үгүй хариулт шаардсан асуултын хариуг хэлж мэдэхгүй, эргэлзэж байгаа

хохирогч тааж хариулах эрсдэлтэй байдаг. Ялангуяа гэмт хэрэгт өтсөнийхөө дараа сэтгэл зүйн эмгэгт орсон хохирогч эсвэл хүүхэдтэй ярилцаж байх үед энэ эрсдэл тулгарах магадлал өндөр.

Хаалттай асуулт ашиглан ярилцаж байх үедээ "Би мэдэхгүй байна," "Сайн ойлгохгүй байна," "Санахгүй байна" зэргээр хариулж болно гэдгийг хохирогчид сануулж хэлэх нь зүйтэй.

Тулгасан асуулт

Тулгасан асуулт нь "Тэр чиний бүх мөнгийг авчихсан юм байна, тийм үү?" гэсэн байдлаар хариулт нь ойлгомжтой байдлаар тавигддаг асуулт юм. Сэтгэл зүйн судалгаанаас харахад тулгасан асуултын хариулт тухайн хүн юу санаж байгаагаас илүүтэйгээр гэрчээс ямар байдлаар асуултаа асууснаас хамаардгийг батлан бичсэн байдаг.

Гэрчийн хараахан гаргаж хэлээгүй байгаа чухал баримт нотолгоог хэлүүлэхийн тулд тулгасан асуултыг асуусан бол, эсрэг талын өмгөөлөгч үүнийг нотлох баримт гэж үзэх ёсгүй хэмээн эсэргүүцэж, улмаар шүүх дээр уг баримтыг гаргаж тавих боломжгүй болгох тохиолдол байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт "Мэдүүлэг авах үед хөтөлж, эсхүл тулгаж асуулт тавихыг хориглоно." гэж заасан тул энэхүү хориглосон хэлбэрээр асуулт тавьж авсан мэдүүлэг нотлох чадваргүйд тооцогдоно гэдгийг анхаарч хохирогчоос мэдүүлэг авахдаа түүнийг урамшуулан зоригжуулж үнэн зөв мэдүүлэг өгөхөд нь туслах арга хэлбэрээ эдгээр хориглосон аргаас өөрөөр хэрэгжүүлэх чадварыг эзэмшсэн байх нь чухал.

Эмзэг, хүнд байдалд байгаа гэрчээс мэдүүлэг авахад маш өндөр чадвар, ярилцлагын үе шатуудын талаар сайн ойлголт шаардагдана. Мэргэжлийн бус, туршлагагүй албан хаагч хохирогчоос мэдүүлэг авахдаа зарим тохиолдолд уг мэдүүлгийг шүүхэд нотлох баримт гэж хүлээн зөвшөөрөгдөхгүй байдалд хүргэх эрсдэл бий. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой хэрхэн харилцах талаар туршлагатай хүн хохирогчид өөрт нь яг юу тохиолдсон талаар бодитой ярих боломжийг нь гаргаж өгдөг.

С - Дуусгах

Мэдүүлэг авч буй хүн ярилцлагаа огцом биш, дуусаж байгаа нь мэдэгдэхүйц байдлаар төгсгөх хэрэгтэй. Энэ үе шатанд мэдүүлгийн туршид хэлсэн, ярьсан зүйлийг дүгнэх бөгөөд хохирогч нэмж хэлэх зүйл байвал түүнийгээ хэлж, мэдүүлгийн дараа ямар үйл явц болох талаарх мэдээллийг өгнө.

Дараагийн үйл ажиллагаанд юу хийгдэх талаар ямар нэг амлалтыг өгч болохгүй, тэгэх хэрэггүй юм. Ялангуяа оршин суух статус, гэмт этгээдийг яллах шийтгэхтэй холбоотой баталгаа өгөхгүй байхад онцгой анхаарах шаардлагатай.

Мэдүүлэг авсан албан хаагч гэрчид цаг, хүчин чармайлт гарган ярилцсанд талархлаа илэрхийлж, бусад байдлаар харилцаж, холбогдох сонирхол байгаа эсэхийг асууна. Мэдүүлгийн дараа хийх, зохион байгуулах ажиллагаа байгаа бол тэр талаараа хохирогчид тайлбарлан хэлнэ.

Мэдүүлгийн төгсгөлд хохирогчид асуух асуулт байгаа эсэхийг заавал асуух бөгөөд байгаа тохиолдолд хариулах хэрэгтэй. Туршлагаас харахад мэдүүлэг авсан албан хаагч гэрчид өөртэй нь холбогдож болох утасны дугаараа үлдээх нь зөв алхам болдог бөгөөд гэрч ярилцсан хүнтэйгээ дахин ярихаар шийдсэн үед хэрэг болдог.

Гэрчид хаанаас хамгийн шуурхай тусламж дэмжлэг авах боломжтойг хэлж өгөх шаардлагатай

бөгөөд холбогдох хүмүүс, байгууллагын нэрсийн жагсаалт, хаяг, утасны дугаарыг хэвлэмэл байдлаар өгч болно. Шаардлагатай гэж үзвэл хууль сахиулагч дээрх тусламж дэмжлэгийг хэрхэн авч болох талаар үзүүлж, зааж өгч болно.

Е – Дүгнэлт үнэлгээ хийх

Мэдүүлэг дууссаны дараа ярилцлагын зорилго, зорилт биелсэн эсэхийг үнэлж, хэрхэн явагдсан, сайжруулах шаардлагатай зүйлс байсан эсэхийг дүгнэнэ. Мэдүүлгийг багаараа авсан бол үнэлгээг ярилцлагад байлцсан бүх хүнийг оролцуулан хийнэ.

Энэхүү үе шатанд мэдүүлэг авсан албан хаагч ярилцлагын зорилго биелсэн эсэх, олж авсан мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагаанд хэрхэн нөлөөлж болох, мэдүүлэг авах ажиллагаагаа хэр сайн хийсэн болон цаашид юуг нь сайжруулах шаардлагатай талаар ярилцана.

СЭДЭВ 4: ГЭРЧ, ХОХИРОГЧ ХҮҮХЭДТЭЙ ЯРИЛЦАХ, МЭДҮҮЛЭГ АВАХ

НҮБ-ын "Эдийн засаг, нийгмийн зөвлөл" 2005 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 2005/20 дугаар тогтоолоор гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдийн эрхийн талаар тусгайлан заасан "Гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдэд шударгаар хандах зөвлөмж" баталсан

Зөвлөмжийн 5 дугаар бүлэгт: Нэр төртэй, хүндэтгэлтэй, энэрэнгүй хандуулах эрх (Зөвлөмж 10–14) хэсэгт гэрч, хохирогч болсон хүүхдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны турш бүх талаар анхаарал тавьж, тэдний хувийн нөхцөл байдал, нэн шаардлагатай байгаа хэрэгцээт зүйлс, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх болон бие махбод, оюун санаа, ёс суртахууны байдлыг хүндэтгэн мэдрэмжтэй байдлаар ажиллах шаардлагатай талаар дурдсан байдаг. Мөрдөн шалгах ажиллагааг шударга, тэнцвэртэй үр дүнтэй байлгахын тулд хүүхдийн хувийн амьдралд хамгийн бага хэмжээгээр нөлөөлөх, түүний зэрэгцээ өндөр стандартын нотлох баримт цуглуулах хэрэгтэй болдог. Гэрч, хохирогч хүүхдэд цаашид хүнд хэцүү байдал үүсгэхгүйн тулд ярилцлага, мөрдөн шалгах бүх ажиллагааны турш мэдрэмжтэй, хүндэтгэлтэй, хүүхдэд тохирсон аргаар ажилладаг, туршлагатай, бэлтгэгдсэн албан хаагч оролцуулах нь чухал. Хүүхдийн чадвар, нас, оюуны чадамж, тэдний өсөж өөрчлөгдөж буй чадавхад тохирсон орчинд хүүхдэд ээлтэй байдлаар гэрч, хохирогч болсон хүүхдүүдтэй харилцах ёстой. Мөн ярилцлага тухайн хүүхдийн ярьдаг, ойлгодог хэлээр явагдах нь зүйтэй.

Зөвлөмжийн 11 дүгээр бүлэгт мөрдөн шалгах ажиллагааны турш хүүхдийг хүнд, хэцүү байдлаас хамгаалагдах эрхийн талаар тусгасан байдаг. Энэ нь гэрч/хохирогч хүүхдүүдтэй нарийн мэдрэмжтэй ажиллахыг мэргэжилтнүүдээс шаардаж байгаа хэрэг юм. Үүнд: хүүхдэд зориулан тохижуулсан ярилцлага авах өрөөтэй байх, ярилцлагын тоог багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ингэхийн тулд тусгайлсан байдлаар ярилцлага болон мэдүүлгийн тоог багасгах, ялангуяа шаардлагагүй тохиолдолд тэднийг зарим ажиллагаанд оролцуулахгүй байх, видео бичлэг хийх зэрэг хүүхдэд ээлтэй байдлаар зохион байгуулж ажиллана.

Хүүхдээс ярилцлага авах мөрдөгч/прокурор дараах зүйлийг онцгойлон анхаарах шаардлагатай. Үүнд:

Аюулгүй байдал: Хохирогч болсон хүүхэдтэй ярилцах эсвэл уулзахдаа тухтай, аюулгүй орчныг сонго. Тийм орчин бүрдүүлэх боломжгүй бол аль болох тухтай, хүүхдэд тохирсон байгааг нь сонго.

Нас: Гэрч/хохирогч хүүхдүүд сэтгэл зүйн хямралд өртсөн үедээ сэтгэл зүйн хувьд доройтох хандлагатай байдаг. Наснаасаа бага хүүхдүүдийн хийдэг үйлдлийг хийж, тэдэн шиг аяглах нь бий. Жишээлбэл, 8 настай хохирогч хүүхэд эрхий хуруугаа хөхдөг.

Тохирсон хэлээр ярих: Хүүхдийн насанд тохирсон хэлээр ярих. "Нялхамсуу, хэтэрхий бага насны хүүхдийн яриа"-аас татгалзах.

Тоглох: Бага насны гэрч, хохирогчийг шаардлагатай тохиолдолд том болсон хүүхдүүдийг ч тоглуул. Юу болсон талаар тоглоомын аргаар хэлүүлэхэд анхаар. Жишээлбэл, хүүхэлдэй, амьтны чихмэл тоглоом, будах, зурах г.м.

Соёлын асуудал: Тухайн хүүхдийн соёлд ойрхон хэлээр ярих. Хохирогч хүүхэдтэй болон асран хамгаалагчтай нь ярилцах гэж байгаа мэргэжилтнүүд "нэрээр нь дуудах", "бэлгийн амьдралын талаар яриулах зорилгоор бие эрхтнүүдийн нэрийг шууд хэлж болох эсэх" зэрэг зүйлсийн талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй.

Хүйс: Хүйсийн асуудалд мэдрэмжтэй хандаж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэдэг шиг охид, хөвгүүд гэж ялгах бөгөөд энэ нь хүйс, жендерийн аль алиных нь хувьд ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ихэнх улсад эрх мэдлийн асуудал тэнцвэргүй байдаг тул охид, эмэгтэйчүүд ерөнхийдөө мэдээллээс хол, эрх мэдэл багатай байдгийг санаж, тэдэнд туслах, тэднийг хамгаалахын тулд үйлчилгээ үзүүлэх. Ялангуяа хүүхэд бэлгийн дарамтад байсан бол түүнтэй харилцах, туслалцаа үзүүлэхийн тулд хохирогчтой ижил хүйсийн хүнийг сонгох хэрэгтэй.

Оюун санаа, өсөлт хөгжил: Хүүхдийн оюун санаа, өсөлт хөгжлийн үе шатуудыг сайн мэдэж, үүнд нарийн мэдрэмжтэй хандах хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдэнтэй харилцахад туслах хэрэгслийг ашиглах: Мөрдөгч/прокурорууд гэмт хэргийн хохирогч/гэрч хүүхдийг олон зорилгын үүднээс зураг зуруулж болно. Жишээ нь, хүүхэдтэй харилцаагаа бэхжүүлэх, нотлох баримт цуглуулах, хэлсэн зүйлийг нь тодруулах, болсон хэрэг явдлын нарийн зүйлийг санууулах, мэдээллийг бататгах, хүүхдэд итгэж болно гэдгийг харуулах, мөрдөн шалгах үйл явцын түгшүүртэй байдлыг намжаах г.м.

- **Тоглоом, хүүхэлдэй, чихмэл тоглоом:** Хүүхдүүд янз бүрийн тоглоомоор тоглодог. Тоглож байхдаа тэд өөрсдийгөө илэрхийлж, сэтгэл хөдлөл, туршлага, өөрийгөө илэрхийлэх байдлаа хөгжүүлж байдаг. Мөрдөн шалгах ажиллагаанд тоглоомыг хүүхэдтэй харилцаагаа бэхжүүлэх, хүүхдийг чөлөөтэй байлгах, ярилцлага авч буй хүний алдааг засах, илэрхийлэхэд хэцүү ойлголтыг гаргах (жишээ нь, хэцүү зүйл тайлбарлах шаардлага гарсан үед хүүхэлдэй эсвэл чихмэл тоглоомыг "харилцагч" болгож, түүнтэйгээ харилцах байдлаар хүмүүсийг тайлбарлуулах, гэмт хэргийн газар, хэрэг явдал болсон цаг хугацаа зэргийг яриулж болно); мөрдөн шалгах ажиллагааны турш чөлөөтэй байлгах зэрэг зорилгоор тоглуулдаг. Хүүхдийг өөрт таалагдсан тоглоомоо сонгоод, мөрдөн шалгах ажиллагаа дуустал өөртэй нь хамт байлгаж болно. Ярилцлага хийх ажилтан энэ аргыг хэрэглэхдээ маш сайн бэлтгэгдсэн байх ёстой, өөрөөр хэлбэл мэргэжлийн, өндөр туршлагатай хүн л энэ аргыг ашиглах хэрэгтэй.
- **Үзүүлэн, диаграм ашиглах:** Гэмт хэргийн хохирогч/гэрч хүүхдүүдээс ярилцлага авахад олон янзын үзүүлэн, диаграм ашиглаж болно. Онцгой нөхцөл байдалд мэргэжлийн туршлагатай хүмүүс л энэ аргыг хэрэглэх нь зохимжтой. Тухайлбал, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн анатомийн үзүүлэн харуулж, бие эрхтнийг нэрлүүлэх байдлаар юу болсон талаар яриулж болно. Нүүрний элдэв хувирлыг үзүүлсэн пиктограм харуулж, тухайн үед юу мэдэрч байсныг нь хэлүүлж болно. Дээрх аргуудыг ашиглахад анхаарах ёстой зүйл

бол тухайн хүүхэд иймэрхүү зүйлийг ойлгодог, тодорхой хэмжээнд мэддэг байх эсэх асуудал юм. Ялангуяа пиктограм ашиглах үед сэтгэлийн хөдлөлөө илэрхийлэхэд улс орон, үндэстэн, соёлын ялгаанаас үүдээд өөр өөр байж болохыг анхаарах шаардлагатай.

1. ХҮҮХДИЙГ ХЭРХЭН СОНСОХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

- Анхааралтай сонсох: Хүүхдэд хэлмээр байгаа, санаа зовж байгаа зүйл байвал түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх боломж олго. Анхаарлаа бүрэн хандуулж сонс. Ямар нэг зүйлд сатааралгүйгээр бүх анхаарлаа түүнд хандуул. Хүүхэд ярилцаж буй хүн нь үнэхээр өөрийг нь сонсож байна уу эсвэл сонсож байгаа дүр эсгэж байна уу гэдгийг маш сайн мэдэрдэг.
- Өөрийгөө орлуулж үз: Хүүхдийн хэлж ярьж байгаа зүйлийг өөрийнх нь өнцгөөс харахыг хичээ. Хүүхдийн оронд өөрийгөө тавьж, маш анхааралтай сонс. Хүүхдийн хэлсэн зүйлс, байгаа байдлыг ажиглаж зөв тайлбарлаж ойлгож байгаа эсэхээ нягтал.
- Давтаж хэл: Хүүхдийн хэлснийг, юу мэдэрснийг давтаж хэлж үз. Хүүхдийг зөв ойлгосон эсэхээ шалга.
- Хүндэл: Хүүхдэд өөрийг нь сонсож байгаагаа харуулж, үзэл бодол, санаа зовж байгаа зүйлд нь хүндэтгэлтэй хандаж байгаагаа илэрхийл. Хэлснийг нь бүрэн биелүүлэх боломжгүй бол тайлбарлан хэл.
- Татгалзах эрх: Хүүхдэд мөрдөн шалгах ажиллагааны талаар, гарч болох хүндрэл эрсдэлийн талаар, үзүүлж болох тусламж дэмжлэгийн талаар тодорхой мэдээлэл өг. Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй болохыг тайлбарлаж хэл. Гэрч/хохирогч хүүхдийг мэдүүлэг өгүүлэхээр ятгаж хэзээ ч болохгүй.
- Аман бус харилцаа:Хүүхдэд садаа болох, эргэлзээ төрүүлэх магадлалтай тул хөмсгөө өргөх, санаа алдах зэрэг бусад үйлдлийг бүү хий. Гаргаж байгаа биеийн хэл чинь ярьж байгаа зүйлтэйгээ, нөхцөл байдалтайгаа тохирсон байх ёстой.
- Нүд рүү нь харах: Хүүхдийн нүд рүү нь харж ярь, гэхдээ цоо ширтэж болохгүйг анхаар. Нөхөрсөг, найрсаг байдлаар инээмсэглэ.
- Хүүхэд талаас нь хар: Завсарлага ав. Хүүхэд ядарсан, залхсан харагдвал амрах, тоглох боломж олго. Өөрийнхөө үгээр, өөрийнхөө байгаагаар үзэл бодол, санаа зовж байгаа зүйлээ гаргаж хэлэх боломжийг ч бас өг. Гайхсан, үл зөвшөөрсөн, эргэлзсэн байдал бүү үзүүл. Үзэл бодол, хүсэл сонирхол, айдас, мэдрэмжийг нь бусад хүүхдийнхтэй харьцуулж болохгүй.

2. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТУУДЫГ ОЙЛГОХ НЬ

Хүүхэд бүр өвөрмөц онцлогтой бөгөөд нийгмийн байдал, боловсрол, соёл зэрэг хүчин зүйлүүд тэдний оюуны чадамж, хөгжлийн түвшинд нөлөөлж байдаг. Хүүхдийн хөгжлийн үе шат хүүхэд аль насандаа ямар чадвар, чадамжтай байдгийг харуулдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж буй албан хаагч гэмт хэрэгт өртсөний улмаас эсвэл шинэ орчинд ирсэн, таагүй байдлаасаа болоод тухайн хүүхэд наснаасаа доогуур түвшнийх мэт харагдаж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Хүүхэд өгч байгаа мэдээлэл болон асуултыг ойлгохгүй эсвэл үнэн зөв хариулж чадахгүй байгаа бол илүү тайван, айдасгүй, тухтай орчинд хэвийн ойлгох боломжтой байж болох юм.

Цэцэрлэгийн насны хүүхдүүд (4-6 нас)

- Хүүхдүүд ялангуяа цэцэрлэгийн насныхан тоо, цагийг сайн ойлгодоггүй. Тоолж сурахаасаа өмнө тоонуудыг хэлдэг бөгөөд ой санамжид нь байгаа үйл явдлуудыг тоочихоос түрүүлж, юу юу байсныг тоочин хэлнэ. Тийм учраас "тухайн зүйл хэрхэн

өрнөсөн" талаар асуухад санаандаа орсон дурын тоог хэлж болох бөгөөд ярилцлагаас ярилцлагын хооронд үүнийгээ өөрчлөх нь бий. Энэ нь өөр өөр, зөрүүтэй мэдээлэл бий болоход хүргэдэг. Гэвч хүүхэд худал хэлж байгаа учраас өөр өөр зүйл яриагүй, тоо сайн мэдэхгүйгээсээ болж ингэж байгаа хэрэг юм.

- Дээрхтэй нэгэн адил хүүхэд цаг, өдөр, сарыг зөв ашиглаж сурахаасаа түрүүлж, нэрээр нь, тоогоор нь цээжилсэн байдаг. Ярилцлага авч буй хүнд цаг хугацаатай холбоотой асуулт асуухад ийм насны хүүхэд нэлээд зөв хариулаад байгаа мэт сонсогдож болох ч хүүхэд үнэндээ санаанд орсноо л хэлчихсэн байх нь олонтоо байдаг.
- Бага насны хүүхдүүд аливаа зүйлийн учир шалтгааныг насанд хүрэгчдээс өөрөөр ойлгодог бөгөөд үүнтэй холбоотой өгсөн хариулт нь этгээд сонин эсвэл тодорхой биш байж болно.
- Бага насны хүүхдүүд тухайн цаг хугацаанд нэг л зүйл дээр төвлөрөх чадамжтай. Тийм учраас тэднээс нэг л утгыг агуулсан асуултыг маш энгийн байдлаар асуух нь чухал.

Сургуулийн насны хүүхдүүд (6-13 нас)

- Цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй харьцуулахад сургуулийн насны хүүхдүүдийн хэл яриа, учир шалтгааныг ойлгох чадвар нь илүү хөгжсөн байдаг. Гэсэн хэдий ч хүнд өгүүлбэрийг ойлгохгүй байх нь элбэг. Мэргэжлийн нэр томьёо хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Хамгийн сайн арга нь хүүхдийн өөрийнх нь ашиглаж буй үгээр ярих, асуултыг ойлгохгүй бол амархан болгож асуух шаардлагатай.
- Сургуулийн насны хүүхдүүд энэ насандаа танин мэдэхүйн болон ёс суртахууны хөгжлийн томоохон хэсгийг олж авдаг. Тэд хүний үзэл бодлын ялгааг ойлгодог болсон байдаг нь өөр олон санаануудыг тунгаан бодох боломжтой болгодог. Тэдний логик сэтгэлгээ хөгжихийн хэрээр аливаа зүйлийн учир шалтгаан, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар төдийгүй болох үйл явдлыг таамаглаж, түүний үр дагаврыг ч урьдчилан харах чадвартай болсон байдаг.

Өсвөр нас (13-18 нас)

- Өсвөр насны эхэн үед хүүхдүүд хэл, ярианы түвшний хувьд насанд хүрэгчидтэй бараг ижил болсон байдаг. Гэвч хуулийн болон этгээд үг хэллэгийг ойлгохгүй хэвээр байна.
- Өсвөр насны хүүхдүүдэд шударга ёсны талаарх мэдрэмж маш хүчтэй хөгжсөн байдаг. Тэдэнд ёс зүйн талаар ойлголт суусан байдаг бөгөөд тухайн зүйл буруу, зөв эсэхтэй холбоотой асуултад хариулж чаддаг.
- Өсвөр насны хүүхдүүд цаг хугацаа, орон зай, бие махбодын үзүүлэлттэй холбоотой зүйлсийг нарийн хэлж чаддаг. Бага насны хүүхдүүдийг бодвол цаг хугацааны талаар маш өндөр мэдрэмжтэй.
- Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийн болон нийгмийн хөгжил нөгөөтэйгүүр тэдний юманд өртөмтгий эмзэг байдлыг давхар бодолцож ажиллах нь маш чухал байдаг. Тэд өөрийгөө хувь хүн талаас нь хөгжүүлэх, хэн болох вэ гэдгээ тодорхойлоход ихээхэн анхаардаг тул өөрийнх нь талаар бусдын бодож, хэлж байгаа зүйлст эмзэг ханддаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дээр дурдагдсан хэсгүүдэд заасан мэдүүлэг авах арга тактикийн талаар илүү сайн ойлголттой болохын тулд дүрд тоглох дасгал ажиллуулна. Мэдүүлэг авах арга тактикийн талаар мэдлэг олгох зорилгоор суралцагчдыг дүрд тоглуулж, PEACE загвар, түүнтэй холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлбарлуулж болно.

СЭДЭВ 5: ГЭРЧ, ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ НЬ

ДАСГАЛ АЖИЛ 5 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ ДҮРД ТОГЛОХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дүрд тоглох дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс жүжиглэх үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол байх хэрэгтэйг анхаарна уу.

Зорилт: Дүрд тоглох дасгалын гол зорилт нь PEACE загвар (P – Төлөвлөх, бэлтгэх; E – Тайлбарлаж, ойлголцлоо бэхжүүлэх; A – Үндсэн ярилцлага; C – Дуусгах; E – Үнэлэлт дүгнэлт хийх)-ыг ашиглан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ярилцах дадлага хийхэд чиглэгдэнэ.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Модуль 2-ын дасгал ажил 1-ийг тараах материал байдлаар бэлтгэх, сандал, ширээ, үзэг, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажиллах хугацаа: 20 минут

Ашиглах материал: Модуль 2-ын дасгал ажил 1

Дүрд тоглох оролцогчид

Сургагч багш дараах дүрүүдийг суралцагч дундаас гаргана. Үүнд:

1. Хохирогч хүүхэд –Болормаагийн дүрд тоглоно.
2. Цагдаагийн албан хаагч эсвэл прокурор. Гэмт хэрэг дээр ажиллаж буй энэ ажилтан хүүхдээс ярилцлага авна. Дүрд тоглох дасгалын үед мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа албан хаагч эсвэл прокурор ярилцлага хийж байгаагаар үзүүлж болно. (Сургагч багш дасгал ажлыг бага зэрэг өөрчилж, Болормааг хил давуулан Хятад улс руу худалдаалж, улмаар биеэ үнэлэх газарт аваачсан болгож болно. Хэсэг хугацааны дараа Болормаа тухайн газраас чөлөөлөгдөх бөгөөд Улаанбаатарт эргэн ирнэ. Болсон явдлыг дээрх байдлаар өөрчилсөн бол хилийн хяналтын болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийг хохирогчоос ярилцлага авах хүн болгож болно).
3. Зөвлөгөө өгөх хүн – Хохирогчид туслалцаа дэмжлэг үзүүлдэг мэргэжлийн байгууллага/ төрийн бус байгууллагын сэтгэл зүйн зөвлөх хүүхдэд "туслах" зорилгоор мэдүүлэг авах ажиллагаанд оролцоно.

ДҮРД ТОГЛОХ ДАСГАЛ АЖИЛЛАХ

Дасгалын 1 дүгээр хэсэг – Танилцуулах хэсэг

- Дасгал ажлыг суралцагчдад тарааж өгнө.
- Дүрд тоглох дасгалын гол зорилтыг суралцагчдад тайлбарлаж өгнө.
- Дүрүүдэд хэн хэн орж тоглохыг танилцуулна.

Дасгалын 2 дугаар хэсэг – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй тэдэнд ээлтэй аргачлал ашиглан харилцаж, анхан шатны ярилцлага хийх нь

- Дүрүүдэд сонгогдсон хүмүүс хохирогч хүүхдээс мэдүүлэг авч байгаа мэтээр жүжиглэнэ.
- "Буруу" аргачлалын жишээнээс оруулж, үүнийгээ "сайн" туршлага, аргачлалтай

харьцуулж, хүүхэдтэй харилцахад аль нь дээр байх талаар ярилцаж ойлголцоно. Жишээ нь: Мэдүүлэг авч байгаа албан хаагч эхний асуултдаа хуулийн үг хэллэг оруулан асуух дараа нь энгийн, ойлгомжтой хэлээр нөгөө асуултаа тавих зэргээр. Үүгээр дамжуулан зохистой, зохимжгүй харилцааны аргачлал, асуулт асуух хэв маягийг харьцуулан харуулах боломжтой.

Дасгалын 3 дугаар хэсэг – Багаараа ярилцах

- Жүжиглэлтийн турш гарсан "зөв", "буруу" ярилцлагын арга тактикийг харьцуулах байдлаар ханын цаасан дээр бичсэнийг нэг суралцагч уншиж өгнө. Үүгээр дамжуулан сайн туршлага, түүний аргачлалын талаар дүгнэн ярилцах боломжтой.
- Хохирогч хүүхэдтэй харилцсан бүх үйл явцын талаар ярилц. Дүрд тоглосон хүмүүс, суралцагчид бүгдээрээ жүжиглэх явцад юу олж харсан, анзаарснаа хуваалцана.
- Дүрд тоглосон хүмүүсийг дараах асуултын дагуу яриулна. Авсан дүрдээ орж тоглоход ямар сэтгэгдэл төрсөн бэ? Яагаад дүрд тоглуулах дасгалыг сонгож авсан гэж бодож байна? Хохирогч охины дүрд тоглосон хүн юу мэдэрч байсан бэ?

МОДУЛЬ - 5

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Шүүгч, прокурор, хууль сахиулагч, хилийн хамгаалах болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хэрэгцээ шаардлагыг мэдэрч, ойлгож ажиллах чадварыг нь хөгжүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийг хамгаалах баталгааг сайжруулахад чиглэгдэнэ.

Сэдэв 1 Хохирогчийг чөлөөлөх, эх оронд нь эргүүлэн авчрах ажиллагаанд хохирогчийн аюулгүй байдлыг хангах

Сэдэв 2 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн онцлог хэрэгцээ, шаардлагатай тусламж, үйлчилгээ

Сэдэв 3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Сэдэв 4 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ

Сэдэв 5 Хууль зүйн туслалцаа

Сэдэв 6 Хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах нь

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хохирогч, тэдний гэр бүл, ойр дотнын хүмүүсийн аюулгүй байдалд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л үе шатанд анхаарч ажиллах нь чухал бөгөөд энэ нь хууль сахиулагч, шүүгч, прокурорын үүрэг юм.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч, тэдний гэр бүл (шаардлагатай тохиолдолд хохирогчид дэмжлэг үзүүлэх ажилтнуудын) аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг байнга хийх байдлаар аюулгүй байдлыг нь хамгаалах явдал хууль сахиулагч, шүүгч, прокурорын гол үүрэг хариуцлага юм.
- Гэмт хэргийн шинж чанараас шалтгаалаад чөлөөлөх ажиллагааны өмнөх үеэс эхлээд эх орондоо буцах, хуучин байдалдаа эргэн орох хүртэлх бүхий л үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод онцгой хэрэгцээ шаардлага бий болж байдаг.
- Хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх нь олон улсын хүмүүнлэгийн стандартад нийцэхийн зэрэгцээ хохирогч хуучин байдалдаа эргэн орж, эргэн нийгэмшихэд нь хууль сахиулагчийн зүгээс гүйцэтгэх хамгийн үр дүнтэй арга юм.
- Хууль сахиулах байгууллагын ажилтан хамаарал бүхий хэд хэдэн байгууллагатай хамтарч хохирогч тус бүрийн хэрэгцээ, шаардлага бүрд үнэлгээ хийж, тохирох шийдлийг хамтран тодорхойлно.
- Хохирогчийн хэрэгцээ, шаардлагыг хангаж ажиллахад хэд хэдэн байгууллага өөрийн чиг үүргийн дагуу оролцох бөгөөд үүнд цагдаагийн албан хаагч шууд оролцох шаардлага байдаггүй. Гэхдээ цагдаагийн албан хаагч хохирогчийг чиг үүргийн дагуу тэдгээр байгууллагуудад шилжүүлж, хохирогчид үзүүлж буй тусламж, үйлчилгээг давхардалгүй уялдуулан хүргэхэд анхаарч ажиллана.

Сургалтын хугацаа - 1 цаг (60 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх;

» Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх

Модуль 5: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа / мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдал	Лекц /Хэлэлцүүлэг	10	Сэдэв 1
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн онцлог хэрэгцээ, шаардлага, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх механизм	Лекц /Хэлэлцүүлэг	10	Сэдэв 2
Сэдэв 3	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ Дасгал ажил 6 – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хэрэгцээнд үнэлгээ хийж, шийдэл олох	Лекц /Хэлэлцүүлэг Дасгал ажиллах	10	Сэдэв 3 Дасгал ажил 6
Сэдэв 4	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг	Багаар ярилцах	10	Сэдэв 4
Сэдэв 5	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх	Лекц /Хэлэлцүүлэг	10	Сэдэв 5
Сэдэв 6	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах ажиллагаа	Лекц /Хэлэлцүүлэг	10	Сэдэв 6

СЭДЭВ 1: ХОХИРОГЧИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХ АЖИЛЛАГААНД ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш модуль 3-ын Сэдэв 3-т заасан эрсдэлийн үнэлгээний хэсгийг эргэн сануулна. Энэ хэсэгт хохирогчийг анхлан тогтоох, тогтоож чадаагүй тохиолдолд ямар үр дагавар гарч болох эсэх, чөлөөлөх ажиллагааны эхний үе шатанд ямар эрсдэлийн үнэлгээ хийх талаар дурдсан. Сургагч багш суралцагчдад эрсдэлийн үнэлгээ хийх талаар сануулах байдлаар товч ярих бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг чөлөөлөх ажиллагаанаас эхлээд эх оронд нь эргүүлэн авчрах хүртэлх хохирогч хамгааллын ажиллагааны илүү өргөн хүрээний хувилбарт тооцогддогийг хэлнэ.

Энэхүү модуль нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч ямар мөлжлөгт өртсөн эсэхээр нь ялгалгүй бүх хэлбэрийн мөлжлөгт өртсөн хүмүүсийн талаар ерөнхийлж заана гэдгийг сургагч багш урьдчилан мэдсэн байх шаардлагатай.

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчид хохирогчийг зөв тогтоож, чөлөөлөх ажиллагааг эхлүүлэхээс өмнө хохирогчид учирч болох эрсдэлийг үнэлэх, хохирогчийг аварсны дараа мөрдөн шалгах ажиллагааны үе шат, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх эмчилгээ хийж эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зүйн хэвийн байдалд оруулсны дараа төдийгүй эх оронд нь буцаасны дараа ч тулгарч болзошгүй эрсдэлүүдийг олж тогтоох хэрэгтэй.

Энэ нь гэрч болохыг зөвшөөрсөн хохирогчдыг хамгаалах, тэдэнтэй хамтран ажиллах цагдаагийн албан хаагчдын гүйцэтгэх ёстой хамгийн чухал үүрэг юм. Мөрдөн шалгах бүхий л ажиллагааны туршид, түүнээс цааш зохион байгуулагдах бусад ажиллагааны үе шатанд ч хохирогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэйгээр ажиллаж буй алба хаагчдын үндсэн үүрэг байдаг. Ялангуяа мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирч болзошгүй эрсдэлүүдийг дутуу үнэлж болохгүй.

Гэрчээр тогтоогдсон хохирогчийн мэдүүлэг нь гэмт этгээдийн хууль бус үйлдлийг илчлэх,тэдний эрх, эрх чөлөөнд заналхийлж байдаг учраас гэмт этгээдүүдийн зүгээс хохирогчийн болон тэдний гэр бүлийн гишүүд, ойр дотнын бусад хүмүүсээс өшөө авах эрсдэл байнга оршиж байдаг. Сүүлийн үеийн практик туршлагаас үзэхэд гэмт этгээдүүд гэрч, хохирогчийг мэдүүлэг өгүүлэхгүй байх, мэдүүлгээс нь татгалзуулах зорилгоор тэдэнд нөлөөлөх (хохирогч, түүний гэр бүлийнхэнтэй нь холбогдож мэдүүлэг өгөх нь "сайхан санаа огт биш" гэж "зөвлөгөө өгөх")-өөс эхлээд бодитоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, шүүхийн өмнө ямар нэг мэдүүлэг өгүүлэхгүй байх бүхий л арга хэмжээг идэвхтэйгээр авч эхэлдэг. Тийм учраас мөрдөгчийн зүгээс онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой зүйл нь гэрч, хохирогчийн аюулгүй байдал юм.

Эрсдэлийг урьдчилан тооцож, бүгдийг нь арилгах боломжгүй гэдгийг мөрдөгч байнга анхаарах

нь зүйтэй бөгөөд гэмт этгээдийн эсрэг мэдүүлэг өгөх нь ямар ч тохиолдолд эрсдэлтэй алхам юм гэдгийг хохирогч хүлээн зөвшөөрч, мэдэж байх ёстой.

1. ХОХИРОГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД ОЛОН УЛСАД ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Гэрч, хохирогч хамгаалал гэдэг нь зохион байгуулалттай гэмт бүлэг, эсхүл тодорхой сүлжээ бүхий этгээдүүдээс үйлдэж буй гэмт үйлдлийг таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэгдсэн чухал мэдээллээр хангаж буй (зохион байгуулалттай гэмт бүлэг, сүлжээ, гэмт үйлдлийн эсрэг) гэрч эсвэл мэдээлэл өгч буй хүнийг хамгаалалтад авч байгаа үйлдлийг хэлнэ.

Энэхүү хамгаалалт тухайн гэрч, мэдээлэл өгч буй хүнийг хэн гэдгийг нь бусдад мэдэгдүүлэхгүй, чухал мэдээллийг нь нууцлах байдлаар өөр газар шилжүүлэн байрлуулах зэрэг арга хэмжээг оруулсан гэрч хамгааллын цогц хөтөлбөрийг мөрдөн шалгах ажиллагаанаас эхлээд шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүртэл хэрэгжүүлэхтэй холбогдоно[18].

Энэхүү хамгаалалт тухайн гэрч, мэдээлэл өгч буй хүнийг хэн гэдгийг нь бусдад мэдэгдүүлэхгүй, чухал мэдээллийг нь нууцлах байдлаар өөр газар шилжүүлэн байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг оруулсан гэрч хамгааллын цогц хөтөлбөрийг мөрдөн шалгах ажиллагаанаас эхлээд шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүртэл хэрэгжүүлэхтэй холбогдоно[19].

Олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын тухай товчхон:

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцэд оролцогч Улс бүр "Мэдүүлэг өгөхөөр зөвшөөрсөн гэрчийг айлган сүрдүүлэх, тэднээс өшөө авах зэрэг үйлдлээс үр дүнтэйгээр хамгаалахын тулд бололцоотой бүхий л арга хэмжээг авах..." үүрэгтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл хохирогчийн төрөл садан, ойр дотнын хүмүүсийг хамгаалалтад авна" (24 дүгээр зүйл).

Оролцогч улс бүр "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ялангуяа заналхийлэл, өшөө авалтад өртөх эрсдэлд байгаа хүмүүст хамгаалал, туслалцаа үзүүлэх шаардлагатай бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй"(25 дугаар зүйл).

"Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол"-д "Оролцогч улсууд хуулийн аливаа үйл ажиллагаа явуулахдаа тухайн гэмт хэргийн талаар нууцлах байдлаар хохирогчийн хувийн нууцыг хамгаална" гэж заасан байдаг (6 дугаар зүйл) Шаардлагатай тохиолдолд доор дурдсан өргөн хүрээний дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Үүнд:

(а) Холбогдох шүүх болон захиргааны үйл ажиллагааны мэдээлэл;

(б) Мөрдөн шалгах ажиллагааны шаардлагатай үе шатуудад эсрэг талын өмгөөллийн

18 Эх сурвалж: Хууль сахиулах алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч-хохирогчид дэмжлэг үзүүлж, хамгаалалтад авах нь, Модуль 12,НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

19 Эх сурвалж: Хууль сахиулах алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч-хохирогчид дэмжлэг үзүүлж, хамгаалалтад авах нь, Модуль 12,НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

эрхийг хөндөлгүйгээр тухайн хохирогч гэмт этгээдийн эсрэг өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх боломжоор хангах, үзэл бодлыг нь харгалзан үзэхэд туслалцаа үзүүлэх.

Хүн худалдаалахын эсрэг протоколд заасан ёсоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод бие махбод, сэтгэл зүй болоод нийгэмд дасан зохицох, нийгэмшихэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэйг дурдсан байдаг.

Энэ төрлийн туслалцааг үзүүлэхийн тулд төрийн бус байгууллага бусад холбогдох байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан хамтран ажиллах нь чухал шаардлагатай талаар зөвлөмж болгон оруулсан байдаг. Энэхүү арга хэмжээнд дараах зүйлс багтана. Үүнд:

(а) Тохиромжтой орон байраар хангах;

(б) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн ойлгох хэлээр өөрсдийнх нь хуулиар олгогдсон эрх зэрэг хэрэгцээтэй мэдээллээр хангаж, зөвлөгөө өгөх;

(в) Эрүүл мэнд, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа үзүүлэх;

(г) Ажлын байраар хангах, сургалтад суух, боловсрол эзэмших боломж олгох.

НҮБ-аас гаргасан Хүний эрх, хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөмж, зарчим (2002)

- Төрийн бус байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй орон байраар хангах. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг аливаа саатуулах байр болон цагдаагийн түр саатуулах байранд байлгаж болохгүй.
- Төрийн бус байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид анхан шатны эмнэлгийн тусламж, зөвлөгөөг өгсөн байх.
- Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч өөрийн харьяалагдах улс орныхоо дипломат болон консулын газарт хандах эрх байгаа талаар мэдээлэл өгөх.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн оролцож буй мөрдөн шалгах аливаа ажиллагаа нь түүний эрх, нэр төр, бие махбод болон сэтгэл зүйд нь сөргөөр нөлөөлөхгүй байхад анхаарах.
- Гэмт этгээдийн эсрэг хийгдэж буй эрүү, иргэний болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан тухайн хохирогчид хуулийн болон бусад шаардлагатай туслалцаа үзүүлэх. Хохирогчийн ойлгох хэлээр бүх мэдээллийг өгөх.
- Гэмт этгээд, түүний хамтрагч этгээдүүдээс учруулж болох аливаа хохирол, заналхийлэл, айлган сүрдүүлэлтээс хохирогчийг хамгаалах. Ингэхийн тулд, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн мэдээллийг боломжит бүх байдлаар нууцалж, хувийн нууцад нь хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Мөн шүүхийн шударга үйл ажиллагааг хангах үүднээс сэжигтэн этгээдийн эрхийг ч хөндөхгүй байх шаардлагатай.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өөрийнх нь талаарх мэдээллийг хамгаалахад тулгардаг бэрхшээлийн талаар урьдчилан хэлж, анхааруулах. Хууль сахиулах байгууллагын хүчин чадал, нөөц бололцооны талаар худал, бодит бус хүлээлтийг хохирогчид үүсгэхгүй байх.

- Аюулгүйгээр, боломжтой бол сайн дурааараа эх орондоо буцаж очих боломжоор хангах. Нэн шаардлагатай тохиолдолд гуравдагч орон эсвэл өөр аль нэг оронд суурьшуулах боломжийг судлах (Жишээ нь: гэмт этгээдийн зүгээс өс хонзон авагдах эрсдэлд байгаа, хүн худалдаалах гэмт хэрэгт дахин өртөх магадлалтай үед).
- Хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллагатай хамтран ажиллах байдлаар эх орондоо эргэн ирсэн хохирогчийн эрүүл мэндийн байдал, эргэн нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлж, уг гэмт хэрэгт дахин өртүүлэхгүй байхаас урьдчилан сэргийлэх.
- Эх орондоо эргэн ирсэн хохирогчийн бие махбод, сэтгэл зүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, боловсрол эзэмших, орон байр болон ажлын байраар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Их Хурлаас 2013 онд баталсан "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай" хууль бол хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн чухал хууль юм. Энэ хуулийн 25.1.1-д "Засгийн газар гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх талаар хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ" гэж заасан. Тиймээс Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор баталсан бөгөөд хөтөлбөрийг 2016 оноос 2024 он хүртэл гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгагдсан. Энэ хөтөлбөрийн зорилго нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нь нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, тэдэнд төрөөс нийгмийн халамж, туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгоход оршино. Энэ хуулийг хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалахдаа бүрэн дүүрэн ашиглах нь чухал.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцийн Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай Нэмэлт Протоколд манай улс нэгдэн орсноор олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор "Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах тухай" үндэсний хөтөлбөрийг батлан 2006-2015 он хүртэл хэрэгжүүлэхээр тогтоосон бөгөөд энэ хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад буюу 2012 онд Монгол Улсын Их Хурал "Хүн худалдаалахтай тэмцэх тухай" хуулийг баталсан бөгөөд тус хууль энэ чиглэлийн харилцааг зохицуулсан гол эрх зүйн баримт бичиг болон үйлчилж байна. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д зааснаар Засгийн газар хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах үүрэг хүлээсэн.

Хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улсын Засгийн газар 2017 оны 148 дугаар тогтоол гаргаж "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж эхлэх шатандаа байна. Энэ хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахтай холбоотой тодорхой чиглэлүүдийг тусгаж, тэдгээрээр дамжин хүрэх үр дүнгийн талаар төсөөлөл хийсэн.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчдад Гэрч, хохирогч хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр болон бусад холбогдох хууль, хөтөлбөрийн талаар мэдээлэл өгнө үү.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зүйл заалт, Гэрч хохирогч хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүнгийн талаар Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

3. ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ҮЙЛ ЯВЦ

Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах үед хэрэгжүүлэх боломжтой гэрч, хохирогч хамгааллын хоёр арга байдаг. Үүнд:

Гэрчийг дагнаж хамгаалах – Засгийн газрын үйл ажиллагаагаар дамжуулан гэрчийг бүрэн хамгаалдаг хөтөлбөр.

Гэрчийг хамтарч хамгаалах – Цагдаагийн байгууллага, хохирогчид дэмжлэг үзүүлж ажилладаг байгууллагууд хамтран гэрчийн аюулгүй байдлыг хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлдэг хөтөлбөр.

Гэрч хамгааллын дээрх хоёр төрөл нь тухайн орны хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөнөөс хамаардаг. Гэрч хамгааллын аль ч хэлбэр байсан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ дараах ерөнхий үйл явцтай байна.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮЙЛ ЯВЦ

ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖИЛ

Мөрдөгчийн үүрэг хариуцлага

Эрсдэлийн түвшин нэмэгдсэн тохиолдолд, нэн даруй нарийвчлсан байдлаар эргэн харна. Гэрч, хохирогчийн аюулгүй байдал мөрдөгчөөс хамаарна. Эрсдэлийн гол хүчин зүйлийг тодорхойлох.

Гэрч, хохирогчид зөвлөгөө өгөх

Гэрч, хохирогчид өөрийг нь хамгаалах ямар нөөц, бололцоо байгаа талаар шударга, бодит мэдээлэл өгөх

Гэрч, хохирогчид ерөнхий ойлголт өгөх

Мөрдөгдөх дүрэм журмыг танилцуулах, аюулгүй байдалтай холбоотой зөвлөгөө өгөх, гэрчийн үүрэг хариуцлага, анхаарах зүйлсийн талаар мэдээлэл өгөх.

Хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллага

Хамгаалах ажиллагаанд оролцож байгаа бол эрсдэлийн үнэлгээ хийх, зөвлөх ажиллагааны үед байлцуулах.

Бичиг баримт бүрдүүлэх, бичлэг хийх

Өндөр мэдрэмж шаардсан ажил учраас бүрдүүлсэн бичиг баримт, бичлэг зэрэг нь шаардлагатай түвшинд хийгдэж, аюулгүй найдвартай газар хадгалагдаж байх.

4. ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид оршин суух зөвшөөрөл олгох, түүнийг эх оронд нь буцаахтай холбогдсон дараах заалтууд орсон байдаг.

7 дугаар зүйлд зааснаар оролцогч улс бүр шаардлагатай тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тухайн улсдаа түр болон байнга оршин суух зөвшөөрөл олгох талаар хууль тогтоомжийнхоо хүрээнд эсвэл шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх байдлаар ажиллана. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхдээ Оролцогч улс бүр хүмүүнлэг, энэрэнгүй байх хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

8 дугаар зүйлд зааснаар хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах арга хэмжээ нь тухайн хүний аюулгүй байдал, хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа ажиллагаатай холбогдсон байна. Эх орондоо буцаж очих эсэхээ тухайн хүн сайн дураараа шийднэ.

Эрүүгийн хэрэг дээр ажиллаж буй хууль сахиулагч тухайн хохирогчтой холбоотой эрсдэлийн үнэлгээг хохирогч эх орондоо очсоны дараах үеийг ч оруулан хийх шаардлага тулгарах магадлалтай. Тухайлбал, хохирогчийг буцаахтай холбоотой хийгдэх ажлуудыг зохицуулах, хохирогчид шаардлагатай байгаа дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйлчилгээг тодорхойлох, эх орондоо буцаж ирсний дараа гэр бүл, ойр дотнын хүн, найз нөхдөд нь учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох гэх мэт.

8-р зүйлд зааснаар хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах арга хэмжээ нь тухайн хүний аюулгүй байдал, хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа ажиллагаатай холбогдсон байна. Эх орондоо буцаж очих эсэхээ тухайн хүн сайн дураараа шийднэ.

Эрүүгийн хэрэг дээр ажиллаж буй хууль сахиулах алба хаагч тухайн хохирогчтой холбоотой эрсдэлийн үнэлгээг хохирогч эх орондоо очсоны дараах үеийг ч оруулан хийх шаардлага тулгарах магадлалтай. Тухайлбал, хохирогчийг буцаахтай холбоотой хийгдэх ажлуудыг зохицуулах, хохирогчид шаардлагатай байгаа дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйлчилгээг тодорхойлох, эх орондоо буцаж ирсний дараа гэр бүл, ойр дотнынхон, найз нөхдөд нь учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох гэх мэт.

Дээр дурдсан зөвлөмжүүдийн дагуу ажиллахад зарим бэрхшээл тулгарч болно. Үүнд:

- Нэг хэлээр ярьдаггүй байх;
- Улс орнуудын хооронд эрх зүйн талаар хамтран ажиллах асуудал;
- Өөр улсын нутаг дэвсгэрт орон нутгийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийх нь чанар, үр нөлөөний талаар үнэлэхэд хүндрэл учрах;
- Зарим тохиолдолд эрсдэлийг бууруулах зорилгоор хойшлуулшгүй арга хэмжээ авах хэрэгтэй болдог.

Хохирогчийг эх оронд нь буцаахтай холбоотой ихэнх асуудлууд тухайн хүн улс орондоо очоод ямар түвшний дэмжлэг, хамгаалалт авах эсэхтэй холбогдон гарч ирдэг. Ерөнхий зарчим нь хохирогчид хэдий хэмжээний дэмжлэг, туслалцаа үзүүлнэ тэр хэмжээгээр дахин хохирох магадлал буурч, эрүүл мэндэд нь гарч болзошгүй сөрөг үр дагавар багасна гэсэн үг. Эх орондоо буцаж буй хохирогчид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргээс шалтгаалсан сэтгэл зүйн, эрүүл мэндийн үр дагавар нь тухайн хохирогчийг эх орондоо буцаж ирсэн хойно ч шаналгаж, зовоосоор байх;
- Хохирогчийг мөлжиж байсан гэмт этгээд өс хонзонгоо авах боломжийг эрэлхийлсээр байх;

- Хохирогч эх орондоо эргэн ирсэн ч нөхцөл байдал урьдын хэвээр байж, хүнд хэцүү амьдрал нь гэмт хэрэгт түлхэх хүчин зүйл хэвээр байх;
- Гэр бүл, ойр дотнын хүн, оршин суудаг тухайн газрын хүмүүс хохирогчийг гутаан доромжилж, үл тоомсорлосноор өөрөөр амьдрах сонголтгүй болгож, хүн худалдаалах гэмт хэргийн илүү хүнд хэлбэрийн хохирогч дахин болох.

Эдгээр асуудлуудаас сэргийлэх үүднээс энэ төрлийн хэрэг дээр ажиллаж буй мөрдөгч, прокурорууд хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахаас өмнө тусгайлан эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай байдаг. Эрсдэлийн үнэлгээг хийхэд дараах асуултад хариулт олох шаардлагатай. Үүнд:

- Эх орондоо эргэн ирсэн гэмт хэргийн хохирогчийг хуучин байдалд нь оруулахын тулд дэмжлэг үзүүлэх боломжтой нийгмийн ямар дэмжлэг, үйлчилгээ байдаг вэ?
- Хохирогчийг хүлээн авч буй улсын Засгийн газарт хохирогчийн аюулгүй байдлыг гэмт этгээдүүдээс хамгаалах ямар түвшний үйлчилгээ байдаг вэ?
- Эх оронд нь буцаах ажиллагаа нийгэм, соёл, шашны хүчин зүйлээс шалтгаалан хохирогчид аюултай байж болох эсэх. Тухайлбал, өөрийг нь худалдаалсан гэр бүлд буцаж очиж байгаа эсэх, мөлжлөгт өртөж байсан хэлбэр нь (бэлгийн мөлжлөг) шашны үүднээс хохирогчийг эрсдэлтэй байдалд оруулж байгаа эсэх?
- Хохирогчийг аваачих гэж буй эсвэл харьяалагдах улс нь хохирогчийг эх орондоо/тухайн улсад ирэхэд нь эсвэл ирэхээ түр хойшлуулах, бүрмөсөн ирэхээргүй тохиолдолд ямар төрлийн төрийн бус байгууллага болон үйлчилгээ үзүүлдэг байгууллага байдаг вэ?
- Хохирогчийг эх оронд нь аваачих нь аюулгүй байж чадах уу эсвэл хүчирхийлэлд өртөж, дахин хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байна уу?
- Хэрвээ аюултай бол, эрсдэлийг хэрхэн бууруулж, арилгах боломжтой вэ? Харьяалагдах улс орондоо биш гадаад оронд байгаа бол тухайн оронд түр оршин суух эрх авах боломжтой эсэх?

Эрүүгийн хэрэг дээр ажиллаж буй хууль сахиулагч харьяалал хоорондын хамтын ажиллагааг хөнгөвчлөх ямар бүтэц, механизм ашиглагдаж байна түүнийг дагаж ажиллах нь зүйтэй.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын хуульд хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахтай холбоотой ямар зохицуулалт байдаг талаар суралцагчдад ерөнхийлөн хэлнэ.

Хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СЭДЭВ 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ОНЦЛОГ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

ХОХИРОГЧИЙН ХЭРЭГЦЭЭ

Хохирогчийг мөлжлөгөөс гаргаж авсны дараа хуучин байдалд нь эргэж оруулахын тулд хамгийн түрүүнд хийх ёстой алхам бол тэдний хэрэгцээг үнэлэх явдал юм. Үүнийг насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд гэж ялгалгүй ижил түвшинд хийх шаардлагатай.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколын 6, 7 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, тэдний хэрэгцээний талаар заасан байдаг бөгөөд Чөлөөлөх-Хамгаалах-Гэмт этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаа явуулах-Хуучин байдалд нь оруулах- Эх оронд нь эргүүлэн авчрах гэсэн үе шатуудад хохирогчийн эрхийг хүндэтгэж, тэдний хэрэгцээг хэрхэн хангаж ажиллах талаарх санал, зөвлөмжүүдийг тусгасан байдаг.

Хуучин байдалд нь буцааж оруулах, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь хохирогчийн аюулгүй байдал хангагдсан, хэвийн амьдралд нь буцаан оруулж, нэр төрийг нь дээдлэн ажиллах замаар нийгэмшүүлэх гол зорилготой байдаг[20]. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг нийгэмшүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамгаалах байранд байлгах, амьдрах орон байраар хангах, хохирогчид нийгэмшихэд нь зориулж буцалтгүй тусламж үзүүлэх, сургуульд сургах, мэргэжлийн боловсрол олгох зэрэг асуудлуудтай холбоотой эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгэм, хуулийн зөвлөгөө өгөх ажлууд багтана. Зарим тусламж, дэмжлэгийг хохирогчийг хүлээн авч буй байгууллага үзүүлдэг бол зарим тохиолдолд хохирогчтой эхнээсээ ажиллаж эхэлсэн байгууллага нийгэмшүүлэх ажлыг гардан зохион байгуулдаг. Ихэнх тохиолдолд энэ төрлийн үйлчилгээг хохирогчийн харьяалагдах улс эсвэл хохирогчийг хүлээн авах гэж буй улс орны төрийн бус байгууллага, Засгийн газрын харьяа байгууллага гардан зохион байгуулдаг.

1. ОРОН БАЙР

Хохирогчийг мөлжлөгөөс аварсны дараа хамгийн түрүүнд үүсэн гардаг хэрэгцээ бол аюулгүй газар, орон байрны асуудал юм. Хамгаалах байранд байлгах гол зорилго нь хамгаалалттай орчинд хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлэх явдал байдаг. Итгэл төрүүлсэн, найдвартай орчинд хамгаалалт дор байгаа нь тэдэнд илүү биеэ даасан байдалтай байх боломж олгодог. Энэ нь ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд илүү тод анзаарагддаг. Хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн эрэгтэй хохирогчдыг эх оронд нь эргүүлэн авчрахаас өмнө иймэрхүү төрлийн хоргодох байранд байлгах хэрэгцээ байх нь бий.

2. ЭМНЭЛГИЙН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Ямар хэлбэрийн мөлжлөгт өртсөнөөсөө үл хамаарч, албадан хөдөлмөр эрхлэх, бэлгийн мөлжлөг болон бусад бүх хэлбэрийн мөлжлөгт өртсөн хүмүүст олон төрлийн эрүүл мэндийн асуудал үүссэн байдаг. Бусдын эрхшээлд байх үедээ бие махбодын хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, сэтгэл зүйн дарамтад байх, таагүй орчинд амьдрах, элдэв төрлийн өвчин туссан байх зэрэг нь хохирогчийн бие махбод, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндэд удаан хугацааны

20 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нэн яаралтай тусламж, дэмжлэг гарын авлага, 3-р бүлэг, Шаардлагатай мэргэжилтэнд шилжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагаа, Женев, 2007; Хууль сахиулах алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллахад хохирогчийн хэрэгцээ, шаардлагыг хангах нь,Модуль 11-ээс авав.НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена, 2009.

үр дагавар, хор уршиг үзүүлсээр байдаг. Шаардлагатай тохиолдолд, мөлжлөгөөс аварсан даруйдаа хохирогчид эмнэлгийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нь чухал бөгөөд энэ ажлыг Засгийн газар эсвэл хүн худалдаалах гэмт хэрэг дээр дагнан ажилладаг туршлагатай төрийн бус байгууллагууд гүйцэтгэнэ.

3. ХУУЛИЙН ТУСЛАЛАА ҮЗҮҮЛЭХ

Мөрдөн шалгах ажиллагааны үеэр гэрчээр ажиллахаар болсон хохирогчид энэхүү үйл ажиллагааг дуустал нь туслалцаа үзүүлэх шаардлагатай. Шүүх хурлын явцад прокурор үүргээ гүйцэтгэж байхтай зэрэгцээд төрийн бус байгууллагууд хохирогч болон үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын (прокурор, цагдаа, эрүүл мэндийн байгууллага, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон нийгмийн үйлчилгээний байгууллагууд) хооронд холбогч, зуучлагч маягаар ажиллах шаардлагатай. Зарим тохиолдолд төрийн бус байгууллагууд хохирогчийг загвар шүүх хуралд оролцуулж, жинхэнэ шүүх хурлын талаар ойлголттой болгох, шүүхийн танхимд аваачих, шүүх хурлын талаар мэдээлэл өгөх зэрэг шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулах ажилд гар бие оролцдог.

4. ХУУЧИН БАЙДАЛД НЬ ОРУУЛЖ, ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ

Хохирогчийг хуучин байдалд нь оруулж, эргэн нийгэмшүүлэх үйл явцад энэ төрлийн үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа байгууллага, агентлаг, төрийн бус байгууллагууд оролцох бөгөөд хохирогчид дараах байдлаар дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд:

- Гэр бүлтэй нь нэгтгэх/зөвлөгөө өгөх (хэрэв гэр нь хохирогчийг байлгахад аюулгүй бол);
- Засгийн газрын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- Ойрын хугацаанд амьжиргаагаа дэмжих чадамжтай болгохын тулд боловсрол/мэргэжлийн сургалтад хамруулах;
- Тусад нь орон байр сууцаар хангах.

5. ЭХ ОРОНДОО САЙН ДУРААРАА ИРЭХЭД НЬ ЭСХҮЛ ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХАД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

Улсын хил давуулан худалдаалагдсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэртээ аль болох түргэн харихыг хүсэж байдаг. Холбогдох яамд, Засгийн газрын харьяа байгууллагууд тухайн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахтай холбоотой ажлыг хийдэг ч, төрийн бус байгууллагууд ч мөн адил энэ ажиллагаанд оролцож, гадаадын иргэнтэй ажиллаж болно. Төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээрээ хөрш зэргэлдээ улс оронд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай холбогдож, тухайн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахын тулд гэр орных нь нөхцөл байдлыг тандан мэдээлж болно.

6. НҮБ-ЫН ХҮН ХУДАЛДААЛАХЫН ЭСРЭГ ПРОТОКОЛД ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХ ТАЛААР ЗААСАН БАЙДАЛ

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколд (8-р зүйл) улс орнууд хохирогчийг буцаах үйл ажиллагаанд хамтарч ажиллах үүрэгтэй талаар онцолсон байдаг. Хүлээн авч буй улс орны хүсэлтэд үндэслэн, хохирогчийн харьяалал бүхий улс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч тухайн улсын иргэн мөн эсэх эсвэл байнгын оршин суух зөвшөөрөлтэй байсан эсэхийг лавлаж шалгана. Тухайн хохирогчид албан ёсны ямар нэг бичиг баримт байхгүй бол иргэншил бүхий

улс орон өөр улсын хил давахад эсвэл өөрийн хилээр нэвтрэн ороход шаардлагатай бичиг баримтыг гаргаж өгнө. Хүлээн авч буй улс орон хохирогчийг улсдаа нэвтрүүлж байгаа нь түүний аюулгүй байдал болон хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөнтэй нь холбогдуулан хийгдэж буй хуулийн ажиллагаатай холбоотой гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш Монгол Улсын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжид дурдсантай адил мөлжлөгөөс аврагдсан хохирогчийн хэрэгцээнд чиглэсэн зүйлс дурдагддаг эсэхийг суралцагчдад хэлнэ.

Хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч гэртээ аль болох түргэн харихыг хүсэж байдаг. Холбогдох яамд, засгийн газрын харьяа байгууллагууд тухайн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахтай холбоотой ажлыг хийдэг ч, төрийн бус байгууллагууд ч мөн адил энэ ажиллагаанд оролцож, гадаадын иргэнтэй ажиллаж болно. Төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээрээ хөрш зэргэлдээ улс оронд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай холбогдож, тухайн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрахын тулд гэр орных нь нөхцөл байдлыг тандан мэдээлж болно.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш Монгол улсад мөрдөгддөг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн аливаа заалтад дээр дурдсантай адил мөлжлөгөөс аврагдсан хохирогчийн хэрэгцээнд чиглэсэн зүйлс дурдагддаг эсэхийг суралцагчдад хэлнэ.

СЭДЭВ 3: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Энэ хэсгийг эхлүүлэхээсээ өмнө сургагч багш модуль 4-ийн Сэдэв 2-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хүчирхийлэл, мөлжлөг хэрхэн нөлөөлдөг талаар дахин авч хэлэлцэхийг суралцагчдаас хүснэ. Доорх тараах материалыг суралцагчдад тараан өгч, нэгдүгээрт хохирогчийн хэрэгцээг тодорхойлох, хоёрдугаарт тухайн хэрэгцээг ямар байдлаар хангах талаар шийдэл олуулна.

ДАСГАЛ АЖИЛ 6 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ХЭРЭГЦЭЭНД ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ШИЙДЭЛ ОЛОХ

Хугацаа: 20 минут

Шаардлагатай материал: Тараах материал (доороос үзнэ үү), ханын цаас, самбарын үзэг

Дасгалаас хүлээгдэж буй үр дүн: Суралцагчдыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нэн шаардлагатай байдаг хэрэгцээний талаар ойлголт өгч, шийдэл олуулахад чиглэгдэнэ.

Дасгал

1. Сургагч багш бэлтгэсэн тараах материалаа тараан өгч, хохирогчийн хэрэгцээнд үндэслэн суралцагчдыг 5 багт хуваана. Баг бүрд хохирогчийн нэг, нэг хэрэгцээг бичсэн ханын цаас хуваарилан өгнө. Тухайлбал, 1 дүгээр багт Хохирогчийн аюулгүй байдлын хэрэгцээг хуваарилсан бол 2 дугаар багт хохирогчийн эрүүл мэндийн хэрэгцээг өгөх гэх мэт.

БАГ 1 - Хохирогчийн аюулгүй байдлын хэрэгцээ		
Ямар хэрэгцээ байх вэ?	Ямар байдлаар шийдвэрлэж болох вэ? Холбогдох хууль тогтоомжид үүнтэй холбоотой зохицуулалт байгаа эсэх?	Цагдаагийн байгууллага бусад ямар байгууллагатай хамтарч ажиллах боломжтой вэ?

2. Баг бүр дотроо хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нэн шаардлагатай байж болох хэрэгцээг хэлэлцэж, түүнд тохирсон шийдэл олох бөгөөд хохирогчийн хэрэгцээг хангахын тулд цагдаагийн байгууллага бусад ямар байгууллагуудтай хамтарч ажиллах боломжтойг гаргаж ярина.
3. Дээр байгаа хүснэгтэд үзүүлсэн 3 хүснэгтийг баг бүр бөглөнө.
4. Таван багаас нэг нэг хүн гарч ирж, баг дотроо ярилцсан зүйлээ бусдадаа танилцуулна.
5. Дасгалаа дүгнэж, нэг хохирогчид хэр олон төрлийн хэрэгцээ гардгийг, ямар байдлаар шийдэх боломжтойг, энэ нь хохирогчтой олон талт, хохирогч төвтэй байдлаар ажиллахыг сануулж буйг хэлнэ. Хүчирхийллийн өөр өөр хэлбэрүүд, эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг харуулсан тараах материал нь гэмт хэргийн дараа хохирогчид илрэх сэтгэл зүйн эмгэгийг дахин сануулахад чиглэгдэнэ. Сургагч багш модуль 3-ын сэдэв 3 болон 5 хэсгүүдэд гарсан мэдээллүүдээс нэмэлт байдлаар ашиглах боломжтой.

Хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх нөлөө, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хэрэгцээ

Хүн худалдаалах гэмт хэргийн нөлөө	
Хүчирхийллийн хэлбэр	**Эрүүл мэндэд гарах үр дагавар**
Бие махбодын хүчирхийлэл » Амь насыг хохироох » Бие махбодод гэмтэл учруулах » Тамлах, тарчлаах » Хоол хүнс, нойргүй байлгах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхгүй байх » Хууль бусаар хорих	Бие махбодод учрах хохирол » Амь насаа алдах » Бие махбодод гэмтэл учрах » Хоол тэжээлийн дутагдалд орох » Хууч өвчин, гэмтэл нь ужгирах, даамжрах
Бэлгийн хүчирхийлэл » Хүчээр бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх » Хүчээр биеийг нь үнэлүүлэх » Хамгаалалтгүй бэлгийн хавьталд оруулах » Хүсээгүй жирэмслэлт » Хүчээр үр хөндөлт хийх	Бэлгийн эрүүл мэндэд учрах хохирол » ДОХ-ын халдвар авах » Бэлгийн замын халдварт өвчин тусах » Нөхөн үржихүйн эрхтэнд гэмтэл учрах
Сэтгэл зүйн хүчирхийлэл » Нийгмээс тусгаарлах » Эрх мэдэлтэн, албан тушаалтнаас айхад хүргэх, туслалцаа авах боломжгүй болгох » Эрх чөлөөг нь хязгаарлах » Хүч хэрэглэхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх » Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос хамааралтай болгох » Сэтгэлийн хөдөлгөөнийг нь удирдах	Сэтгэцийн эрүүл мэндэд учрах хохирол » Гэмт хэргийн дараа сэтгэл зүйн эмгэг шинжүүд илрэх » Амиа хорлох » Хүнд хэлбэрийн сэтгэл гутралд орох » Тусгаарлагдсан мэдрэмжтэй байх, хүнд итгэхээ болих » Ой санамжаа алдах » Маш их ядарч, нойргүйдэлд орох » Сэтгэлийн хөдөлгөөний доголдолд орох » Хүнтэй харилцаа тогтоох чадамжгүй болох » Гэмших, шившигтэй ичгэвтэр байдалд орсон мэт санагдах
Хохирогчид нэн түрүүнд шаардлагатай хэрэгцээ	
Аюулгүй байдал	БАРИВЧИЛЖ БОЛОХГҮЙ – Нэн тэргүүнд учирч болзошгүй аюулаас холдуулж, цагдаагийн газар, хохирогчид зориулсан хоргодох/хамгаалах байр, эмнэлэг зэрэг аюулгүй газар аваачих.
Эрүүл мэнд	Бие махбодод учирсан гэмтэл, өвчний шинж тэмдэг, хоол тэжээлийн дутагдал, эрүүл мэндийн үзлэгт оруулах.
Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	Гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэг шинж илэрсэн эсэхэд анхан шатны үнэлгээ хийж, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.
Хуулийн зөвлөгөө	Хуулийн ямар боломжууд өөрт нь байгаа, үүрэг хариуцлага нь юу байх, түр оршин суух эрх авах болон эх орондоо буцахад шаардлагатай дэмжлэг авах эрхтэй талаар тайлбарлаж өгөх.
Туслалцаа үзүүлэх	Санхүү, нийгмийн халамжтай холбоотой мэдээлэл өгөх. Санууулах нь: Цагдаагийн ажилтны гүйцэтгэх үүрэг бол үйлчилгээг гардан үзүүлэх бус тусламж, дэмжлэг авахад нь чиглүүлэх явдал юм.

Цагдаагийн ажилтан хохирогчийг эрүүл мэндийн үзлэгт оруулахын тулд улсын харьяаллын эмнэлэг, эрүүл мэндийн төвд хандах ёстой. Хохирогчийн эрүүл мэндийн хэрэгцээнд үнэлгээ хийж, шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх үйл явцад дараах зүйлийг анхаарч ажиллах

шаардлагатай[21]. Үүнд:

- Хохирогчид бүрэн, тодорхой мэдээлэл өгч, өөрийнх нь зөвшөөрлийг авсны үндсэн дээр эрүүл мэндийн үзлэг хийнэ. Энэхүү үзлэгийг хийлгэхгүй байх эрх өөрт нь байгаа талаар мэдэгдэнэ. Хохирогч нь хүүхэд байгаа тохиолдолд хүүхдийн эцэг, эх эсвэл асран хамгаалагчаас дээрх зөвшөөрлийг авна.
- Хохирогч гадаадын иргэн бол эрүүл мэндийн үзлэг хийхдээ нийгэм, соёлын үүднээс анхаарах шаардлагатай, эмзэг асуудал байж болзошгүйг санаж ажиллах. Ялангуяа хохирогч нь хүүхэд эмэгтэйчүүд бол бүр илүү анхаарал хандуулах ёстой.
- Эрүүл мэндийн үзлэгийг хоёр зорилгоор хийдэг. Нэгдүгээрт, хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмчилгээ хийх (шаардлагатай тохиолдолд); Хоёрдугаарт, нотлох баримт олж авах.
- Эрүүл мэндийн ноцтой асуудал үүссэн хохирогчид хамгийн түрүүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлнэ.
- Аль болох ижил хүйсийн, эмч, эрүүл мэндийн мэргэжилтнээр эмнэлгийн үзлэг хийлгүүлэх хэрэгтэй. Тийм боломж байхгүй бол хохирогчид тайван, санаа зовох зүйлгүй мэдрэмж төрүүлэхийн тулд тэдний эцэг эх/асран хамгаалагч/нөхөр/ төрийн бус байгууллагын ажилтныг байлцуулан үзлэг хийж болно.
- Хохирогчийн нэр төр, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах.
- Төрийн бус байгууллагын ажилтан, нийгмийн ажилтнуудыг хохирогчтой хамт байлгах.
- Засгийн газраас гаргасан дүрэм журам, зөвлөмжийг мөрдөх.
- Энэ асуудлыг зохицуулдаг засгийн газраас гаргасан дүрэм журам, зөвлөмжийг дагах.

СЭДЭВ 4: СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Цагдаагийн ажилтан хүчирхийлэл, мөлжлөгийн улмаас тухайн хохирогчид үүссэн сэтгэл зүйн нөлөөллийн үнэлгээг хийлгэхийн тулд мэргэжлийн зөвлөх эсхүл сэтгэл зүйчид хандах шаардлагатай. Сэтгэл зүйн хэрэгцээнд үнэлгээ хийж, хохирогчид туслалцаа үзүүлэхэд дараах зүйлсийг анхаарч ажиллах хэрэгтэй[22]. Үүнд:

Хохирогч мөрдөгчийн хараа хяналтад орсон цагаас эхлэн, цагдаагийн ажилтан хохирогчийн сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн нөхцөл байдлын үнэлгээг мэргэжлийн хүнээр нэн даруй хийлгүүлэх шаардлагатай.

Үнэлгээг хохирогчид яаралтай хэрэгтэй байгаа хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хохирогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход сэтгэл зүйн хувьд боломжтой эсэхийг тодорхойлох шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх явцад маш хурц сэтгэл зүйн эмгэг байдалд орсон эсвэл мөрдөн шалгах ажиллагаанд оролцох боломжгүй болгож болзошгүй бусад зүйлс хохирогчид байгаа эсэхийг мөн үнэлгээ хийх байдлаар тодорхойлж болно. Эдгээр үнэлгээний үр дүнд

21 Эх сурвалж: Модуль 12: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалж, тусламж дэмжлэг үзүүлэх; Хууль сахиулах алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена 2009; Мөрдөн байцаагчдад зориулсан гарын авлага, Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдтэй ажилладаг Интерполын ажлын алба, 2002; Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах алба хаагчдад зориулан гарын авлага, Цагаачлалын бодлогын хөгжлийн олон улсын төв, Вена, Австри, 2006; Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогч шилжүүлэх үндэсний механизм дадлагын гарын авлага, Хүний эрх, ардчиллыг бэхжүүлэх хэлтсийн аюулгүй байдал, Европын хамтын ажиллагааны байгууллага, Польш, 2004.

22 Дээрх дурдсан эх сурвалж

авах шаардлагатай арга хэмжээ, гаргах шийдвэрийн хувилбаруудыг боловсруулах боломжтой болдог. Хохирогч гаднаасаа эрүүл мэт харагдах нь үнэлгээ хийх шаардлагагүй гэсэн үг огт биш.

Цагдаагийн хэлтэст энэ төрлийн үнэлгээ хийх мэргэжлийн хүн байхгүй тохиолдолд, хохирогчид үйлчилгээ үзүүлдэг туршлагатай төрийн байгууллага, нийгмийн ажилтан, төрийн бус байгууллагыг оролцуулж болно. Байгууллага, хохирогчтой ажиллах ажилтныг сонгохоосоо өмнө тэдний чадамж, найдвартай, итгэлтэй ажиллаж чадах эсэхийг сайтар харгалзан үзнэ.

Сэтгэл зүйн үнэлгээ хийж дууссаны дараа үнэлгээг эмнэлгийн үзлэгийн хариу, шүүхийн сонсгол зэрэгтэй нэгтгэх шаардлагатай. Энэ төрлийн тусламж, зөвлөгөө хохирогчийг сэтгэл зүйн эмгэгээсээ гарч эдгэрэхэд болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслах эрмэлзэлтэй болгодог.

Хуульд заасны дагуу цагдаагийн ажилтан хохирогчид мөрдөн шалгах ажиллагаа, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад ч тусламж дэмжлэгээ үзүүлсээр байх ёстой. Оролцох шаардлагатай гэж үзсэн үедээ нийгмийн ажилтан, зөвлөгөө өгөх хүнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

СЭДЭВ 5: ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Цагдаагийн ажилтан өөрөө хохирогчид хууль зүйн зөвлөгөө өгөх эсвэл прокурор, өмгөөлөгч, төрийн бус байгууллагын ажилтан хохирогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох байгууллагууд ямар үүрэгтэй (цагдаа, прокурор, шүүх), мөн хохирогчийн эрх, үүргийн талаар мэдээлэл өгнө.

Цагдаагийн ажилтны хохирогчид өгөх хуулийн зөвлөгөө дараах байдлаар явагдана. Үүнд:

- Хохирогчийн бие махбод, сэтгэл зүйн хувьд хууль зүйн зөвлөгөө авааxад бэлэн эсэх талаар үнэлгээ хийх
- Хууль зүйн зөвлөгөө өгөхдөө хохирогч нь хүүхэд байгаа тохиолдолд тэдний нас, сэтгэхүйн хөгжлийн байдлыг харгалзан үзнэ. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцохтой холбоотой хуулийн зөвлөгөөг өгнө.
- Хууль зүйн зөвлөгөө өгөхөд хамгийн сайн тохирох хүнийг сонгоно.
- Шаардлагатай тохиолдолд ялангуяа гадаадын иргэн хохирогч болсон бол орчуулагч ажиллуулах.
- Хохирогч хөгжлийн бэрхшээлтэй бол хэлмэрч ажиллуулах.
- Хэрэг дээр ажиллах явцад ямар нэгэн худал амлалт өгөхгүй байх.
- Сэжигтэн этгээдтэй холбоотой хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх.
- Хууль зүйн зөвлөгөөг ганцхан удаа өгөөд орхих нь учир дутагдалтай. Зөвлөгөө өгөхөөр сонгогдсон хүн хэргийн талаар тогтмол мэдээлэл өгч байх хэрэгтэй.
- Тухайн улсын хууль тогтоомжид хохирогчийн эрх, үүргийг хуульчилсан талаар мэдээлэл өгөх, ялангуяа шүүхийн шийдвэр гарсны дараах асуудал хэрхэн зохицуулагдах, нөхөн төлбөр авах боломжтой эсэх (үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хуулийн заалт байдаг бол) талаар мэдээлэл өгөх хэрэгтэй.

СЭДЭВ 6: ХОХИРОГЧИЙГ ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХ НЬ

Цагдаагийн ажилтан тухайн хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах бүх үйл явцад оролцох шаардлагагүй. Эх оронд нь эргүүлэн авчрах тухай шийдвэрийг шүүх гаргах бөгөөд Гадаад хэргийн яам, хохирогчийн өөрийнх нь харьяалагдах улсын Элчин сайдын яам, Засгийн газрын холбогдох газрууд, хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллага зэрэг газартай хамтран ажиллана.

НҮБ-аас 2000 онд баталсан Хүн худалдаалахын эсрэг протоколд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг дараах хоёр тохиолдолд эх оронд нь эргүүлэн авчирч болно гэж заасан байдаг.

1. Эрсдэлийн үнэлгээнээс үл хамааран хохирогч гэртээ харихыг өөрөө хүссэн. Гэрч, хохирогч гэр бүлдээ эргэн очихыг хүссэн бол эх орондоо буцах эрхтэй. Эрсдэлийн түвшин өндөр байгаа нөхцөлд тэднийг хэрхэн урьдчилан сэргийлэх нь хэцүү асуудал хэвээр байдаг. Хохирогчид эрсдэлийн талаарх бүх мэдээллийг өгөх бөгөөд ингэсний дараа ч гэртээ харихыг хүсэж байгаа тохиолдолд тэдний энэ үйлдлийг хориглох боломжгүй юм. Энэ тохиолдолд, хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллагатай хамтран хохирогч эх орондоо хэрхэн хүрэх, очиход нь ямар тусламж хэрэгтэй болох, очсоны дараа ямар дэмжлэг, хамгаалалтад байх боломжтой эсэх талаар судалж үзнэ. Дэмжлэг үзүүлдэг байгууллагуудтай сайн хамтарч ажиллавал үр дүн нь төдий чинээ сайн гарна.
2. Эх орондоо буцах нь аюулгүй гэж үнэлгээгээр гарсан байж болно. Харин хоёр дахь категори илүү асуудалтай байдаг. Дээр дурдсан ёсоор хохирогч гэмт этгээдийн эсрэг мэдүүлэг өгөхөөс өмнө өндөр эрсдэлтэй байдалд байна гэж үнэлэгдэж байсан бол мэдүүлэг өгсний дараа эрсдэл нь бага байж болно. Гадаад улсын хохирогчийн хувьд хамгийн чухал асуудал нь ямар улсад аваачвал аюул багатай байхыг нь тогтоох явдал юм.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хууль тогтоомжид гадаад улсын хохирогчийг эх оронд нь эргүүлэн авчрах эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгнө. Холбогдох яам, агентлаг, байгууллагуудыг жагсааж бичнэ.

МОДУЛЬ - 6

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Хууль сахиулагч, прокурор, шүүгч, хил хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд үндэсний болон олон улсын байгууллагуудтай хэрхэн хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хамтран ажиллахын ач холбогдлын талаар мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагааны төрөл, хэлбэр, ач холбогдол

Сэдэв 2 Үндэсний болон олон улсын байгууллагын хамтын ажиллагаа

Сэдэв 3 ИНТЕРПОЛ болон бусад улсын цагдаагийн байгууллагатай харилцах, хамтран ажиллах

Сэдэв 4 Бусад байгууллагуудтай хамтран ажиллах нь

Сэдэв 5 Олон талт хамтын ажиллагааг нэгтгэн дүгнэх нь

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэгт гадаадын иргэн өртсөн, үйлдсэн тохиолдолд олон улсын хамтын ажиллагаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын гол үндэс суурь нь болж байдаг.
- Эрүүгийн хэргийн асуудлаар олон улстай хамтран ажиллах нь маш нарийн түвэгтэй асуудал бөгөөд хүсэлт тавьсан болон түүнийг хүлээн авч байгаа аль аль талаас өндөр мэдлэг, чадвар, туршлага, нарийн төлөвлөгөөтэй ажиллахыг шаардаж байдаг.
- Гэмт этгээдүүд олон улс дамжин орогнож, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхдээ цахим гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл хийдэг зэрэг нь хууль сахиулагч, прокуроруудыг өмнөхөөсөө илүү хамтын ажиллагаагаа бэхжүүлж, гадаадын иргэний үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхээр ажиллаж буй улс оронд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллах шаардлагатайг харуулж байна.
- Хууль сахиулах байгууллагын ажилтнууд/прокурорууд бусад байгууллагаас мэдээлэл олж авахын тулд өөрсдөө маш их санаачилгатай, идэвхтэй ажиллах шаардлагатай бөгөөд гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажилласнаар гэмт этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах боломж бүрдэнэ.
- Хууль сахиулагч/прокурорууд гэмт хэргийн хохирогчийг засгийн газрын харьяа байгууллага, төрийн бус байгууллага зэрэг тохирох байгууллагад нь шилжүүлснээр тэднийг мэргэжлийн байгууллагаас шаардлагатай тусламж, дэмжлэг авах боломжийг бүрдүүлж байгаа хэрэг юм.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай дэмжлэг туслалцаа, үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд олон байгууллагуудыг оролцуулан, хамтран ажиллах нь хууль сахиулах байгууллага/прокурор, Засгийн газрын харьяа холбогдох алба, хэлтэс, төрийн бус байгууллагуудын хамгийн үр дүнтэй, уялдаа холбоотой ажиллах цорын ганц арга зам юм.

Сургалтын хугацаа - 1 цаг (60 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн жагсаалт, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх;
- Сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзэг бэлтгэх.

Модуль 6: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа / мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Олон улсын хамтын ажиллагааны төрөл, хэлбэрүүд	Лекц/ хэлэлцүүлэг	10	Сэдэв 1
Сэдэв 2	Үндэсний болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах нь	Лекц/ хэлэлцүүлэг	10	Сэдэв 2
Сэдэв 3	ИНТЕРПОЛ болон хоёр улсын цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа	Лекц/ хэлэлцүүлэг	10	Сэдэв 3
Сэдэв 4	Холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой, хамтран ажиллахын ач холбогдол	Багаар ярилцах	10	Сэдэв 4
Сэдэв 5	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа **Дасгал ажил 7** - Хамтран ажиллах байгууллагуудын матрицыг гаргах; тэдний гүйцэтгэх үүрэг; хамтран ажиллах цар хүрээг тодорхойлох	Дасгал ажиллах	20	Сэдэв 5 Дасгал ажил 7

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР, АЧ ХОЛБОГДОЛ

Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэхэд ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэгт гадаадын иргэн хохирсон, эсхүл уг хэргийг үйлдсэн хүн нь гадаадын иргэд байх тохиолдолд хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны гол үндэс нь олон улсын хамтын ажиллагаа байдаг.[23] Хохирогчийг өөр улс орон дамжуулан худалдаалсан эсвэл гэмт этгээд нь гадаадын иргэн байгаа тохиолдолд тус хэрэг нь хоёр буюу түүнээс дээш улсад хамаарах асуудал болдог учраас олон улсын гэмт хэрэгт тооцогдож явдаг.

23 Модуль 6-Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улс хамтран ажиллах нь;Хууль сахиулах алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Вена 2009; Эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт өртөж, худалдаалагдахын эсрэг Интерполын ажлын хэсэг-Мөрдөн байцаагчдад зориулсан гарын авлагаас (2002) тус тус авав,

Хүн худалдаалах гэмт хэрэг цахим гэмт хэргийн шинж агуулдаг болох нь

Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгардаг бэрхшээлтэй асуудал нь интернет, гар утасны өргөн хэрэглээ, үүнийг ашиглан хялбархан байдлаар хохирогчийг элсүүлэх, жинхэнэ гэмт этгээд, мөлжлөг үйлдэгчийн царайг хэзээ ч харахгүй байх, хохирогчийг элсүүлж буй цахим хуудсыг өөр улсаас удирдан ажиллуулж байх зэрэг нь хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хувьд ихээхэн хүндрэл үүсгэдэг.

Ийм учраас гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд мөрдөн шалгах болон, прокурорын байгууллагын ажилтан нь олон улсын хэмжээнд энэ асуудлыг хэрхэн зохицуулдаг талаар ойлголт, мэдлэг сайтай байх шаардлага урган гардаг. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улстай хамтран ажиллах нь маш нарийн түвэгтэй асуудал бөгөөд хүсэлт тавьсан болон түүнийг хүлээн авч байгаа аль аль талаас өндөр мэдлэг, чадвар, туршлага, нарийн төлөвлөгөөтэй ажиллахыг шаардаж байдаг.

Олон улстай дараах байдлаар хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх;
- Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх;
- Эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын дагуу шилжүүлэх;
- Ялтан шилжүүлэх;
- Мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагааг хамтран явуулах зэргээр хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ажиллах;
- Мөрдөн шалгах ажиллагааг хамтран гүйцэтгэх;
- Тусгай аргаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа хамтран ажиллах зэрэг болно.

Олон улсын хамтын ажиллагааны харилцааны нөхцөл (хэнтэй холбогдох вэ гэдэг асуудал нь тухайн улс орнууд хоорондоо ямар төрлийн хамтын ажиллагаатай байгаа, хүсэлт гаргасан талаас тавьж буй хууль, эрх зүйн шаардлага, ямар байдлаар хамтран ажиллах болно гэж зөвшилцсөн зэрэг улс хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс шалтгаална):

- Дотоодын эрх бүхий байгууллага эсвэл энэ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн төв байгууллага;
- Дипломат албаны хүмүүс;
- Хууль сахиулах албан хаагчид.

Хууль сахиулах хүрээнд илүү албан ёсны байдлаар хамтран ажиллах боломжтой. Тухайлбал:

Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд хүлээн авч буй улсын засгийн газрын харьяа хууль сахиулах байгууллагын холбогдох ажилтнуудыг хооронд нь холбох үүрэгтэй ажилтныг томилох;

Хууль сахиулахтай холбоотой мэдээллээ хуваалцах зорилгоор тухайн улс орны хуулийн байгууллагууд хэрхэн хамтарч ажиллах талаар хоёр болон олон талт гэрээ хэлэлцээр, эрх зүйн зохицуулалтыг хийх;

Энэ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага буюу ИНТЕРПОЛ-той хамтран ажиллах.

А. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. 2000 онд батлагдсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын протокол[24]

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколын 3 дугаар хэсэгт "урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах болон бусад арга хэмжээ"-ний талаар тодорхойлсон байдаг. Тус протоколын 9 дүгээр зүйлийн, 4 дэх хэсэгт "Оролцогч улс орнууд ядууралтай, хөгжил дэвшлээс хол газар голчлон амьдардаг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх өндөр магадлалтай эмзэг бүлгийн хүмүүс, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдэд хандсан хоёр буюу олон талт хамтын ажиллагаанд суурилсан арга хэмжээ авах, түүнийгээ бэхжүүлэн ажиллах шаардлагатай" талаар дурдсан байдаг.

Протоколын 10 дугаар зүйлд мэдээлэл солилцох, сургалт явуулах эрх зүйн үндэслэлийг голчлон тусгасан. Тус протоколын 1 дэх хэсэгт "Оролцогч улс орнуудын хууль сахиулах байгууллага, хил, гааль болон холбогдох бусад эрх бүхий байгууллагууд шаардлагатай тохиолдолд үндэсний хууль тогтоомжтойгоо уялдуулан хоорондоо мэдээлэл солилцох бөгөөд дараах зүйлсийг тогтооход хамтран оролцох боломжоор хангана"гэж заасан байдаг. Үүнд:

(а) Гадаад улсад хил зөрчиж байгаа эсвэл нэвтрэхээр завдаж байгаа этгээд бусдын бичиг баримтыг ашиглаж байгаа эсхүл ямар нэг бичиг баримтгүй байгаа тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч эсвэл энэ гэмт хэргийг үйлдэж буй этгээд байх боломжтой;

(б) Хүн худалдаалж, мөлжих зорилгоор гадаад улсын хил нэвтрүүлэхдээ тухайн этгээдийн ашиглаж байгаа эсвэл ашиглахаар завдаж байгаа бичиг баримтын төрлийг тодорхойлох;

(в) Хүн худалдаалж, мөлжих зорилгоор зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс хохирогчийг элсүүлдэг, тээвэрлэдэг арга барил болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хувь хүн, бүлэг этгээдийн үйл ажиллагаа явуулдаг маршрут, харилцаа холбоо барьдаг арга хэлбэрийг тогтоож, илрүүлэх арга хэмжээ авах.

11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Оролцогч улс орнуудын хилийн хяналт шалгалт явуулах чиг үүрэг бүхий байгууллагууд хоорондоо шууд харилцах боломжит сувгийг үүсгэж, түүнийгээ сайжруулах байдлаар үйл ажиллагааг бэхжүүлэх үүрэгтэй"-г онцлон тэмдэглэсэн байдаг.

2. Хүүхдийн эрхийн тухай конвенц[25]

1990 онд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 34 дүгээр зүйлд "Оролцогч улс орнууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ" гэж заасан байдаг. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна:

(а) Хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;

(б) Хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;

(в) Хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах.

3. 2000 онд батлагдсан Хүүхэд худалдаалах, биеийг нь үнэлүүлэх, садар самуун сурталчилгаанд ашиглахын эсрэг нэмэлт протокол[26]

24 Монгол улс Хүн худалдаалахын эсрэг протоколд 2008 оны 6-р сарын 27-нд нэгдэн орсон.
25 Монгол улс тус конвенцийг 1990 оны 7-р сарын 5-нд соёрхон баталсан.
26 Монгол улс нэмэлт протоколыг 2003 оны 6-р сарын 27-нд соёрхон баталсан.

Нэмэлт протоколд хүүхдийг ашиглаж бэлгийн мөлжлөг үйлдсэн гэмт этгээдүүдийг оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээгээр шилжүүлэх тухай (5 дугаар зүйл); гэмт этгээдийг илрүүлэх буюу эрүүгийн хэрэгт шалгах, түүнийг шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар харилцан бие биедээ бүхий л бололцоогоор туслах (6 дугаар зүйл); хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх болон садар самуунд сурталчлах, бэлгийн дур хүслээ хүүхдээр хангах аялал зэрэг үйл ажиллагаанд оролцсон этгээдийн үйлдлийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах , эрүүгийн хэрэгт татах болон шийтгэх зорилгоор олон талт, бүс нутгийн болон хоёр талт тохиролцоо байгуулах замаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах (10-р зүйл)талаар дэлгэрэнгүй заалтуудыг тусгасан байдаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүрэг ямар ач холбогдолтой талаар товч тайлбарлана. Мөрдөгчид, прокурорууд үүнтэй холбоотой зохицуулалтын талаар дэлгэрэнгүй ойлголт авах бөгөөд хүнийг дамжуулан худалдаалах гэмт хэрэг дээр ажиллах үедээ сурсан зүйлээ ашиглах боломжтой.

Б. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор гадаадын улс оронд орогнох, гадаад руу зугтах нь бий. Энэ тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй улс оронд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн авчрах шаардлагатай болдог. Энэ нь хууль ёсны, ихэнхдээ гэрээгээр хүлээсэн үйлдэл байдаг бөгөөд эрэн сурвалжилж байсан гэмт этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл боломжийг бүрдүүлдэг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нь тэдний хаана байгаагаас үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг олгож байгаа юм. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсвэл ял оногдуулах зорилгоор гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн авах хүсэлт гаргадаг. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхтэй холбоотой онцлох зарчим, шаардлагуудаас дурдвал:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх. Ингэхийн тулд зарим улс орон олон улсын гэрээ байгуулахыг шаарддаг бол зарим нь байх шаардлагагүй гэж үздэг. Олон улсын гэрээгээр зохицуулахыг шаардаж байгаа тохиолдолд улс хоорондын болон олон улсын гэрээ байгуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчноо бүрдүүлэх нь зүйтэй.
- Гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар хангалттай нотлогдсон байх.
- Хоёр улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж тооцогдсон байх – Хүсэлт тавьж буй улс гэмт этгээдийн үйлдэл нь тухайн улсын болон хүсэлт хүлээн авч буй улс орны эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдсон үйлдэл, эс үйлдэхүй байх ёстой гэдгийг нотлох ёстой. Гэвч энэхүү байр суурь зарим оронд өөрчлөгдсөн бөгөөд давхар гэмт хэрэгтэй холбоотой шаардлага тавигдахгүй болсон.
- Онцлог байдал - Энэхүү зарчим нь улс орнууд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн авах хүсэлтэд тусгайлан заагдсан гэмт хэргийн хүрээнд л тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээлгэдэг.

- Давхар аюул занал – Эрэн сурвалжлагдаж байгаа этгээд хүсэлтэд дурдсан гэмт хэргийг тухайн улс оронд дахин үйлдсэн байгаа тохиолдолд хүсэлт тавьж буй орны хүсэлтэд татгалзсан хариу өгөх боломжтой.
- Харьяат иргэнээ шилжүүлэн өгөхөөс татгалзах – Өөрийн улсын харьяат иргэнээ бусад улсын хүсэлтээр шилжүүлэн өгөхөөс татгалздаг улс орны тоо нэлээдгүй буурах хандлагатай байна. Гэмт этгээд тухайн улсын харьяат иргэн учраас өөр улсад шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу өөрийнхөө улсын хууль, тогтоомжийн дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулж, тохирох ял, шийтгэлийг шударгаар оноох шаардлагатай. Энэ нь "Гэмт этгээдийг өөр улсад шилжүүлж өгөх эсвэл өөрийнхөө улсад эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял оноох" зарчмын хэрэгжилт юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх явцад тулгарах бэрхшээл

Дараах шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхэд зарим хүндрэл, бэрхшээл үүсдэг. Үүнд:

- Нарийн түвэгтэй байдал – Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нэг улсаас нөгөө улс руу аюулгүй байдлыг нь ханган шилжүүлэх нь өөрөө хууль зүйн нарийн түвэгтэй ажиллагаа байдаг.
- Харилцан адилгүй байдал – Нэг улсаас нөгөө рүү аливаа этгээдийг шилжүүлэх хуулийн заалтууд дараах зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Үүнд:
  - Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах гэрээ, зөвшилцлийн нөхцөл
  - Шилжүүлэх хүсэлт тавигдаж буй этгээдийн иргэншил
  - Гэрээнд нэгдэн орсон улс орон
  - Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авахад дурдагдсан гэмт хэргүүд
- Асуудлын эмзэг байдал – Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх асуудал улс төрийн хувьд ихээхэн эмзэг асуудалд тооцогддог.
- Мэргэшсэн байдал – Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх хүсэлтийг шийдвэрлэхэд холбогдох улсын Дотоод болон Гадаад хэргийн яамд, Хууль зүйн яам, прокурор зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд энэ ажиллагааны үе шат болгонд гадаад хэргийн яамны болон дипломат төлөөлөгчийн газрын ажилтны оролцоо шаардлагатай болдог.

Мөрдөгч, прокурор нарт мэдээлэх гол зүйл нь эрүүгийн хэрэг дээр олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд улс орон бүр холбогдох яамны харьяа гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх асуудал хариуцсан "төвлөрсөн нэг хэлтэс" байгуулж, энэ чиглэлээр мэргэшсэн хуулийн ажилтнуудыг ажиллуулах нь зүйтэй.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж

Улс бүр гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэхдээ үндэсний эрх зүйн хэм хэмжээг хэрэглэдэг. Энэ талаар олон улсын гэрээ, конвенцэд туссан байдаг. Үндэсний эрх зүйд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд тухайн улсын Үндсэн хууль чухал байр суурьтай. Монгол Улсын хувьд гэмт хэрэгтнийг шилжүүлэх асуудал нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Олон Улсын гэрээний тухай, Дипломат албаны тухай, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэнийн эрх зүйн байдлын тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай,

Харьяатын тухай, Шүүхийн тухай, Тагнуулын байгууллагын тухай, Цагдаагийн байгууллагын тухай, Прокурорын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Хилийн тухай хуулиудаар зохицуулагдаж байна.[27]

Монгол Улсын Үндсэн хуулийн арвантавдугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно" гэж заасан нь иргэний хувьд улсынхаа бүрэн эрхтэй байдлыг төлөөлөгч болдгийг, төрийн хувьд харьяат иргэнийхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалагч байдгийн хууль зүйн гол баталгаа болдог. Монгол Улсын иргэн гэдэг нь 1921 оны 07 дугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монгол Улсын харьяат байсан бөгөөд Монгол Улсын харьяатаас гараагүй хүмүүс болон хуульд заасны дагуу Монгол Улсын харьяат болсон хүмүүсийг хэлдэг.[28] Иргэн Монгол Улсын харьяат байх явдал бол тухайн хүний туйлын эрх учраас түүний Монголын иргэн гэдэг эрхийг хэн ч, ямар ч хуулиар хасах, эх орноосоо хөөн гаргах эрх байж болохгүй.[29]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар бүлэг "Тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэх, шилжүүлэн авах" гэж шинээр тусгасан.

Монгол Улстай байгуулсан бусад орнуудын гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх тухай гэрээ, онцлог

Дээрх гэрээ нь бүтэц болон агуулгын хувьд дараах нийтлэг шинжтэй байна. Үүнд:

Шилжүүлэн өгөх үүрэг

Хэлэлцэн тохирогч талууд нь гэрээний дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийн тулд нэг талын хүсэлтийг нөгөө тал хүлээн авч шилжүүлэх үүргийг харилцан хүлээх явдал юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг

Талуудын хууль тогтоомжид шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэдэг нь нэг жилээс дээш хугацаатай хорих, эсхүл өөр хүнд ял оногдуулах гэмт хэрэг юм.

Шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл

Шилжүүлэн өгөхийг хүссэн этгээд нь тус улсын иргэн, эсхүл хүсэлт хүлээн авсан талын хууль тогтоомжийн дагуу улс төрийн орогнол олгосон, хүсэлт хүлээн авсан талын хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан, ялаа эдэлсэн, өршөөгдсөн, үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт татсан зэрэг эрх зүйн үндэслэл байгаа, шилжүүлж өгөхийг хүссэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн талаар хуулийн хүчин төгөлдөр тогтоол гарсан, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Шилжүүлэн өгөх тухай хүсэлт

Шилжүүлэн өгөх хүсэлтийг бичгээр үйлдэх бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана.

А. Хүсэлт гаргасан байгууллагын нэр

Б. Үйлдсэн гэмт хэрэг болон хор уршгийн талаар

В. Шилжүүлэн өгөх этгээдийн овог, нэр, түүний иргэний харьяалал, байнга оршин суудаг газар, хаяг, хувийн байдлын тухай бусад мэдээ, боломжтой бол түүний гадаад төрхийн талаарх тодорхойлолт, гэрэл зураг, хурууны хээ

27 Ганболд.Б. "Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй /тусгай анги/". УБ., 2010 он, 552-553 дахь тал
28 Харьяатын тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1995 он
29 Совд.Г, Жанцан.Н, Амарсанаа.Ж нар. "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар". УБ., 2000 он, 81 дэх тал

Шилжүүлэн өгөх хүнийг баривчлах, цагдан хорих

Хүсэлт хүлээн авсан тал гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзахаас бусад тохиолдолд баривчлах, цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна. Хэрэв шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хүлээн аваагүй бол суллах үүрэгтэй. Баривчлах, цагдан хорих хугацааны хувьд харилцан адилгүй.

Шилжүүлэн өгөхийг хойшлуулах, түр шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгөхийг хүссэн тал нь хүсэлт хүлээн авсан талын нутаг дэвсгэр дээр өөр гэмт хэрэгт холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа, эсхүл ял эдэлж байгаа зэрэг тохиолдолд шилжүүлэн өгөхийг хойшлуулж болдог. Хэрэв шилжүүлэн өгөхийг хойшлуулахад хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар буюу гэмт хэргийг мөрдөн шалгах явцад ноцтой бэрхшээл учруулахаар байвал тодорхой үндэслэл бүхий хүсэлтээр түр шилжүүлэн өгдөг.

Хэд хэдэн улсын хүсэлт

Аль нэг гуравдагч улс тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлж өгөх хүсэлт гаргавал хүсэлт хүлээн авагч тал өөрөө шийдвэрлэнэ. Гэхдээ үйлдсэн гэмт хэргийн ангилал (хүнд хөнгөн), гэмт хэрэг үйлдэгдсэн газар, шилжүүлэн өгөх хүсэлт зэргийг харгалзана.

Шилжүүлэн өгөх тухай нэмэлт мэдээ

Хүсэлт хүлээн авсан нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт гэрээний шаардлагыг хангахгүй байна гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардаж болно. Хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 1 сарын дотор хариу өгөх ёстой бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаан байвал энэ хугацааг 15 хоног сунгаж болохоор байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх тухай мэдэгдэл гарсны дараа талууд шилжүүлэн өгөх газар, цаг хугацаа зэргийг зөвлөлдөж, шилжүүлэн өгөхөөр тохиролцсон өдрөөс хойш 15 хоногийн дотор шилжүүлэн өгнө. Хэрэв энэ хугацаанд хүлээж аваагүй бол хүсэлтээ цуцалсан гэж үзэж тухайн цагдан хоригдсон этгээдийг суллана. Гэхдээ дахин харилцан зөвлөлдөж болно.

Бичиг баримт болон эд зүйлс шилжүүлэн өгөх

Хэлэлцэн тохирогч талууд өөрийн хууль тогтоомжийн дагуу гуравдагч талын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөхгүйгээр гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэгдсэн бичиг баримт, эд мөрийн баримт буюу гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, хэрэгсэл, эд зүйлсийг шилжүүлэн өгнө. Ингэхдээ эрүүгийн өөр хэрэгт хэрэгцээтэй бол буцаан өгөхийг түр хойшлуулж болно.

Дамжуулан өнгөрүүлэх, зардал

Гуравдагч улсаас аль нэг талд шилжүүлэн өгч буй этгээдийг нөгөө талын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрнө. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөхтэй холбоотой зардлыг уг зардал гаргагч тал хариуцна. Харин тээврийн болон дамжуулан өнгөрүүлэх зардлыг хүсэлт гаргагч тал хариуцна.

Харилцах эрх бүхий байгууллага, хэл

Хэлэлцэн тохирогч талуудын Хууль зүй, дотоод хэргийн яам, Ерөнхий Прокурорын газраар дамжуулан харилцана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол талуудын тус тусын томилсон эрх бүхий байгууллагаар дамжин харилцана. Мөн дипломат шугамаар харилцаж болно. Талуудын байгууллага хоорондоо харилцахдаа өөрийн улсын хэлээр харьцах бөгөөд англи, орос хэлийг хэрэглэж болно.

Тусгай нөхцөл, журам

Шилжүүлэн өгөх этгээдийг тухайн гэмт хэргээс өөр ямар нэг гэмт хэрэгтэй холбогдуулан хүсэлт хүлээн авсан талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял шийтгэх болон гуравдагч улсад шилжүүлж болохгүй. Гэхдээ тухайн этгээд хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрээс чөлөөтэй гарах боломжтой болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор гараагүй, тухайн нутаг дэвсгэрийг орхин гарсны дараа сайн дурааараа эргэж ирсэн бол хүсэлт хүлээн авсан талын зөвшөөрлийг авах шаардлагагүй.

Маргааныг шийдвэрлэх

Гэрээг тайлбарлах болон хэрэгжүүлэх явцад үүссэн маргааныг холбогдох байгууллагын хооронд буюу дипломат шугамаар шийдвэрлэнэ.

Гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү гэрээг хүчин төгөлдөр болгоход шаардагдах үндэсний хууль тогтоомжийнхоо бүх шаардлагыг биелүүлсний дараа дипломат шугамаар харилцан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тухай батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээ хугацаагүй бөгөөд талуудын аль нэг нь дипломат шугамаар гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрмөгц гэрээний үйлчлэх хугацаа дуусгавар болно.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулсан улс орнууд

№	Гэрээний нэр	Улс	Батлагдсан огноо	Харилцагч байгууллагууд
1	Гэмт хэрэг үйлдэгсдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай	Бүгд Найрамдах Казакстан Улс	1993.10.22	Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газар
2	Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх	Бүгд Найрамдах Солонгос Улс	1999.05.31	Дипломат шугам
3	Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	2001.01.03	Улсын Ерөнхий прокурорын газар
4	Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1997.08.19	Хуулийн төв байгууллага, Дипломат шугам

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх талаар мөрдөгч, прокурор ямар үүрэгтэй талаар дэлгэрэнгүй мэдээллийг суралцагчдад өгнө. Тухайлбал:

Мөрдөгч хамгийн түрүүнд дүүрэг, аймаг, улсын хэмжээнд цагдаагийн ямар хэлтэс, тасаг, албатай энэ асуудлаар холбогдох хэрэгтэй вэ?

Гадаадын иргэн холбогдсон эсвэл уг гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй талаар хүн худалдаалах гэмт хэргийн мэдээлэл авмагцаа мөрдөгч прокурор руу холбогдох нь зөв үү?

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

В. ХОЁР ТАЛЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх арга хэмжээг ерөнхийдөө улс хооронд эсвэл олон улсын гэрээгээр зохицуулж явуулдаг ч үндэсний хууль тогтоомжоор зохицуулан хэрэгжүүлэх боломж ч мөн бий. Гэмт этгээдүүд олон улс дамжин шилжиж, орчин үеийн өндөр үзүүлэлттэй технологи ашиглаж байгаа нь улс орнуудын хууль сахиулах болон шүүх байгууллагын алба хаагчдын хамтын ажиллагаагаа сайжруулж, нэгдэн ажиллахыг шаардаж байгаа бөгөөд гадаадын иргэний үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхээр ажиллаж буй улс оронд туслалцаа үзүүлэн ажиллах хэрэгтэй.

Хүсэлт гаргах албан бичиг

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх ажиллагаатай адилаар хүсэлт гаргах албан бичгийг улс орон бүрийн хууль сахиулах төв байгууллагын мэргэжлийн алба хаагчид хариуцаж гаргадаг.

Хоёр улсын эрх зүйн харилцан туслалцааны асуудалд хэд хэдэн албан байгууллага, эрх бүхий газрыг оролцуулах шаардлагатай байдаг тул хүсэлт гаргах албан бичиг үйлдэхдээ мөрдөгчид дараах хоёр гол зарчмыг дагаж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Тухайн хэрэг дээр ажиллахаар томилогдсон прокурортой зөвшилцөлгүйгээр ямар нэг арга хэмжээ авахгүй байх.
- Засгийн газрын харьяа эрх бүхий байгууллагад тухайн хэрэгтэй холбоотой мэдээллийг өгч, зөвлөлдөлгүйгээр ямар нэг арга хэмжээ авахгүй байх.

Хоёр улсын эрх зүйн харилцан туслалцааг хүсэх хүсэлт дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын нэрийг тодорхой бичих
2. Хэргийн товч утга, холбогдох хуулийн заалт зэргийг оруулан гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татах үйл явц, мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл хүсэлтэд хамаарах гэмт хэргийн тайлбар, нотлох баримтын талаар мөн оруулан бичнэ;
3. Эрүүгийн гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан этгээдийн хэн болох, ямар улсын иргэн, хаана байгаа талаарх мэдээлэл;
4. Явуулж буй хүсэлтийн зорилго, хүсэж буй мэдээлэл, туслалцаа;
5. Нууцлалын зэргийн талаар мэдээлэл, үүний ач холбогдол
6. Хүсэлтийг биелүүлэх хугацаа;
7. Хүсэлт хүлээн авч буй улс орны үндэсний хууль, тогтоомжийн дагуу шаардагдах мэдээлэл эсвэл хүсэлтийг биелүүлэхэд шаардагдах мэдээлэл;
8. Нотлох баримт олж авах, нэгжлэг хийх болон баривчлах, гэмт хэрэг үйлдэж олсон орлого эсвэл түүнийг санхүүжүүлдэг санхүүгийн эх үүсвэрийг зогсоох буюу хураах хүсэлт, хүсэлт хүлээн авч буй орноос нотлох баримт олно гэж үзэж байгаа үндэслэлээ илэрхийлэх;
9. Эрүүгийн хэрэгт шаардлагатай мэдээлэл болон хэрэгт холбоотой дараах зөвшөөрлүүд:
   (а) мөрдөх, шалгах, хадгалах, нотолгоо болгон зургийг нь авах, хувилж олшруулах эсвэл дамжуулах шаардлагатай бичиг баримт, бичлэг, аливаа өмч эсвэл компьютерт байгаа мэдээлэл;
   (б) Шинжилгээнд зориулан авч явах, шалгах, дамжуулах шаардлагатай аливаа эд зүйлсийн дээж эсвэл компьютерт байгаа мэдээлэл;
   (в) үзэж шалгах эсвэл баримтжуулах шаардлагатай газар, байршил;

(г) хэн нэг хүнээс нотлох баримт авах хүсэлт гаргасан тохиолдолд түүнийхээ үнэн зөвийн талаар баталгаа гаргасан буюу амлалт өгсөн утгатай мэдээлэл, мөн олж авах шаардлагатай байгаа нотлох баримт эсвэл мэдүүлгийн талаарх тайлбар;

10. Таньж олуулах ажиллагаанд зориулан үзүүлэх эд юмс, үзүүлэнг түр ашиглах тохиолдолд хүсэлтийг хүлээн авагч орон дахь тухайн зүйлийн байршил, түүнийг эзэмшиж буй этгээдийн талаарх мэдээлэл, хурааж авч болох байршил, туршилт хийх хугацаа болон тухайн эд зүйлийг буцааж хүлээлгэн өгөх хугацааг дурдах;
11. Саатуулагдсан болон хоригдож буй хүнийг байлгах шаардлагатай тохиолдолд тухайн этгээдийг хүлээлгэн өгөх үед харгалзах хүн/хүмүүс, хүлээлгэн өгөх газар байршил болон тухайн этгээдийг буцааж ирүүлэх хугацаа;
12. Туслалцаа хүсэх талаар хүсэлт гаргаж буй орны шүүхийн шийдвэр болон тухайн шийдвэрийг гүйцэтгэсэн талаарх мэдэгдэл.

Практик зөвлөмж: Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлтийг гаргах нь

Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлтийг гаргахад тухайн улс орон бүрийн хууль эрх зүй, онцлог шаардлагын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх хэрэгтэй болдог. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан Эрх зүйн харилцан туслалцаа авах зааварчилгаа нь энэ төрлийн хүсэлт гаргах ажлыг ихээхэн хөнгөвчилдөг төдийгүй хүсэлт хүлээн авч буй оронтой ойрхон ажиллах боломжийг олгодог.

Энэхүү зааварчилгаа нь эрх зүйн харилцан туслалцаа авах хүсэлтийг хэрхэн гаргах талаар нарийн дэлгэрэнгүй зааварчилсан бөгөөд холбогдох хууль, тогтоомжтой нь холбосон ашиглахад хялбар зүйл юм. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын энэ зааварчилгаанд эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлтийг тухайн улсын ямар байгууллагад хандаж гаргах талаар зааврыг мөн өгсөн байдаг.[30]

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургагч багш эрх зүйн харилцан туслалцаа хүсэхтэй холбоотой асуудлаар мөрдөгч, прокурор нар ямар арга хэмжээ авч ажиллах талаар Монгол Улсын Засгийн газрын тогтоолд хэрхэн тусгасныг хэлнэ. Тухайлбал:

Эрх зүйн харилцан туслалцаа хүсэхтэй холбоотой асуудлыг ямар төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг хариуцдаг вэ?

Монгол Улсад ямар нэг тусгай журам, хүсэлт гаргах тусгай аргачлал байдаг уу?

30 Дараах хаягаар орж, хоёр зааварчилгааг онлайнаар авах боломжтой. www.unodc.org/mla/index.html

СЭДЭВ 2: ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Эрх бүхий байгууллагаас явуулж буй мөрдөн шалгах ажиллагааны үе шат бүрд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийн талаарх мэдээллийг хил хамгаалах алба, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, төрийн бус байгууллага болон бусад эх сурвалжаас олж авах шаардлагатай болж болно. Ийм учраас мөрдөн шалгах ажиллагаагаа үр дүнтэй, амжилттай байлгахын тулд хууль сахиулагчид тэдгээр байгууллагуудтай байнгын холбоо харилцаатай байх нь чухал. Ямар байгууллагатай холбоо харилцаатай байх нь тухайн улсад мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм журмаас хамаарна.

Дотоодын хууль сахиулах ажиллагаа

Дотоодын хууль сахиулах байгууллага бусад байгууллагуудтайгаа хамтран ажилласны үндсэн дээр, Интерполын үндэсний товчоо эсвэл гадаад улс орны чиг үүрэг нэгтэй ажилладаг байгууллагатайгаа хамтран Ногоон анхааруулга гаргах замаар гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон гэмт этгээдийг гадаадын оронд зорчин, хүн худалдаалах гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлж болно.

Хууль тогтоомжид харшлахгүй бол тухайн улсын хууль сахиулах байгууллагын алба хаагч, мөрдөгч нь гадаадын улс орнуудаар зорчиж, хүн худалдаалах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор бусад улсын холбогдох байгууллагатай хамтарч нууц ажиллагаа зохион байгуулах боломжтой. Гадаад үндэстэн дамнасан мөрдөн шалгах ажиллагаа зохион байгуулахад маш их хүндрэл бэрхшээлтэй, мөн зардал өндөртэй байдаг тул ижил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагатай харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа сайжруулахгүйгээр энэ төрлийн ажлыг явуулах нь бэрхшээлтэйд тооцогддог.

Засгийн газар

Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий яам, агентлаг, түүний харьяа газар, хэлтсийн (Хууль зүй, дотоод хэргийн яам, болон гадаад хэргийн яам, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага) албан хаагчдын тусламж, дэмжлэг нь гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татах, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардлагатай болдог. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, түүнийг шүүхийн хэлэлцүүлэгт танилцуулахын тулд туслалцаа, дэмжлэг үзүүлэх олон улсын гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөх ёстой.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд тухайн хэрэгтэй холбогдуулж гадаад улс оронд мөрдөн шалгах ажиллагаа явуулж болзошгүй гэж тооцоолж, шаардлагатай холбоо барих байгууллагуудын мэдээллийг авсан байх хэрэгтэй.

Элчин сайдын яамд/ Консулын газрууд

Гадаад улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай тохиолдолд элчин сайдын яамны болон консулын газрын холбогдох ажилтан өөрийн орны мөрдөгч, цагдаагийн байгууллагын албан хаагчдыг гадаад улсын мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагын ажилтантай холбон өгөх, өөрийн улсад байгаа гэрчээс мэдүүлэг авах, төрийн бус байгууллагатай холбож өгөх, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулахад туслалцаа үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллах боломжтой.

Гадаад улс орнуудыг холбох чиг үүрэг бүхий ажилтан нь гадаадын иргэн, оршин суугч, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд оролцсон эсвэл энэ шалтгаанаар баривчлагдсан тухай мэдээлэл авсан тохиолдолд өөрийн улс орны мөрдөн шалгах ажиллагаа явуулах төв байгууллагад зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажиллах хэрэгтэй. Энэхүү мэдээлэл нь гадаадын хууль сахиулах төв байгууллагад мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх, тухайн

хэрэгтэй холбоотой нөхцөл байдлыг өөрийн улс орныхоо хэмжээнд үнэлэхэд хэрэг болдог.

Төрийн бус байгууллагууд

Төрийн бус байгууллагуудаас алслагдсан газар нутагт зохион байгуулдаг ажлын онцлогтой уялдаад, тэд хүн худалдаалах гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээд, эмзэг байдалд байгаа хохирогч болох өндөр магадлалтай хүмүүсээс мэдээллийг хурдан хугацаанд олж авч, үүнийгээ хамгийн ойр орших цагдаагийн газарт өөрсдийн сувгаараа дамжуулан хүргэх боломжтой байдаг. төрийн бус байгууллагууд шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэх, хохирогчийг хамгаалахтай холбоотой асуудлаар найдвартай эх сурвалж болж чаддаг.

Хил хамгаалах байгууллага

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хил хамгаалах, гаалийн албан хаагчид ямар хүнийг сэжигтэй гэж үзэх, зорчигчийн юу нь хүн худалдаалах гэмт хэрэгт оролцсон эсвэл өртсөн шинж тэмдэг байж болох талаар сургалтад хамрагдаж, мэдлэгтэй болсон байх хэрэгтэй. Аяллын маршрут, хуваарь, зочид буудлын захиалга, аяллын зорилго, гадаад паспорт дээрх дардас, хаана хэр удаан байсан эсэх, хувцаслалт зэргээс тухайн этгээд нэвтрэх гэж буй улстаа хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж болзошгүйг мэдэх боломж байж болно.

Сэжигтэн этгээд гэмт хэргийн хохирогчийг хууран мэхлэх эсвэл хулгайлах замаар хил дамнуулан худалдаалж байж болно. Хил, гаалийн ажилтан нь хохирогч болсон байж болзошгүй сэжиг бүхий хүнээс дагалдан яваа хүнтэйгээ ямар холбоо хамааралтай болох талаар нь асууж тодруулах шаардлагатай.

Олон улсын туршлагаас үзэхэд хил, гаалийн олон байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон гэмт этгээд болон сэжигтэн этгээдийг таньдаг хилийн сэрэмжлүүлэх систем байдаг. Үндэсний болон гадаадын гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагууд зохион байгуулалттай гэмт хэрэгт ямар нэг байдлаар оролцсон нь мэдэгдсэн эсвэл энэ төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй гэмт этгээдийн талаар хилийн сэрэмжлүүлэх системээс мэдээлэл авахыг дэмжиж ажиллах шаардлагатай юм.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага аливаа сэжигтэй этгээдийг мөрдөн шалгах арга хэмжээг нэн даруй авч болох бөгөөд тухайн этгээдийн визийг цуцлах, албадан гаргах, түр саатуулах хүртэл арга хэмжээ авах боломжтой юм. Энэ тохиолдолд протоколын дагуу шаардлагатай арга хэмжээ авсан болон холбогдох мэдээллийг хүргэсэн тухай ИНТЕРПОЛ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлэл хүргүүлэх ёстой.

СЭДЭВ 3: ИНТЕРПОЛ БОЛОН БУСАД УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

ИНТЕРПОЛ-оос нэлээд олон тооны баримт бичиг хэвлэгдэж, гишүүн орнуудын цагдаагийн төв байгууллагуудад тараагдсан байдаг. ИНТЕРПОЛ хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой этгээдийн тухай мэдээллийг тухай бүрд мэдээлэл, анхааруулга байдлаар явуулдаг.

Тэдгээр анхааруулга нь тухайн этгээдийн гаднах төрх, онцлог байдлын талаарх мэдээлэл, таних тэмдэг, онцгой содон шинж тэмдэг, зураг, хурууны хээ зэргийг агуулсан байдаг.

1. “Эрэн сурвалжлагдаж байгаа” буюу улаан анхааруулга нь тухайн гэмт хэрэгтнийг баривчилж, шилжүүлэн өгөх шаардлагатай бөгөөд үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө баривчлах зөвшөөрөлтэй гэсэн утга агуулдаг.
2. “Лавлагаа шаардлагатай” буюу хөх анхааруулга нь тухайн этгээдийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай, үүнийг нь гэмт этгээдийг олоход туслах зорилгоор ашиглана

гэсэн утгатай.

3. "Анхааруулга, сэрэмжлүүлэг" буюу ногоон анхааруулга нь тухайн гэмт этгээд хэд хэдэн улс оронд гэмт хэрэг үйлдсэн талаарх мэдээллийг агуулна.

» Ногоон анхааруулгын гол зорилго нь тухайн гэмт этгээд өөр бусад оронд дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүйг илэрхийлсэн мэдээллийг бусад улс орнуудад түгээхэд оршино.
» Тухайн этгээдийн оршин суудаг улсаас гадна хамгийн багадаа гурван улсад гэмт хэрэг үйлдсэн эсвэл гэмт үйлдэл нь лавлагаа шаардлагатай анхааруулгад орсон тохиолдолд энэ төрлийн анхааруулгад тооцогдоно.

Дээрх анхааруулгуудыг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд зориулан гаргаж болох бөгөөд хил давуулан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чухал арга хэрэгсэлд тооцогддог.

Ногоон анхааруулга, сэрэмжлүүлгээр ирсэн мэдээллийг хэрхэн ашиглаж, дагалдах ямар арга хэмжээ авах нь тухайн улсын хууль эрх зүйн зохицуулалтаас хамаардаг.

Зарим улс орон дараах арга хэмжээг авдаг:

» Гэмт этгээд тухайн улсад нэвтрэхээс урьдчилан сэргийлэх
» Гэмт этгээдийг маш хянамгай ажиглалт дор байлгах
» Мэдээллийг бүртгэж аваад мэдээллийн сандаа хадгалах[31].

Албан бус хамтын ажиллагаа

Албан бус хамтын ажиллагаа гэдэг нь эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлт гаргалгүйгээр хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллагууд болон гадаадын ижил төстэй байгууллага хоорондоо мэдээлэл солилцох явдал юм. Үүнийг цагдаагийн байгууллага цагдаадаа, агентлаг агентлагтаа туслах гэж хэлдэг бөгөөд хоёр улсын цагдаагийн байгууллагын ажиллах зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг хэлнэ. Албан бус хамтын ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаа албан ёсоор эхлэхээс өмнө, шүүхээр хэргийг хэлэлцэхээс өмнө эхлүүлж болох бөгөөд энэ хүрээнд нарийн ажиглалт явуулах, гэрчээс сайн дурын үндсэн дээр мэдүүлэг авах зэрэг үйл явцад ашиглаж болно. Албадлагын шинж чанартай арга хэмжээ авах шаардлагагүй тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлт албан ёсоор гаргаж үйл ажиллагаа эхлүүлснээс илүүтэйгээр албан бус байдлаар харилцаж мэдээлэл олж авах, гүйцэтгэх ажиллагаа явуулах нь хурдан бөгөөд, зардал багатай, шуурхай байдаг.

Аливаа албан бус хамтын ажиллагаа тухайн улсынхаа хууль тогтоомжид нийцэж байх ёстой. Холбоо тогтоох төв нэгж (байгуулагдсан бол) эсвэл хамтран ажиллах үүрэгтэй албан хаагчаар дамжуулан хүсэлтээ гаргаж ажиллана. Яаралтай тохиолдолд "ажилтан-ажилтан"-тайгаа шууд холбогдож ажиллаж болох бөгөөд энэ тохиолдолд холбогдсон талаараа Холбоо тогтоох төв нэгж эсвэл хамтран ажиллах үүрэгтэй албан хаагчид мэдэгдэнэ.

Энэ төрлийн хамтын ажиллагаа ихэвчлэн ИНТЕРПОЛ-ын шугамаар хийгддэг. Хүсэлт гаргаж буй мөрдөгч өөрийн улсын ИНТЕРПОЛ–ын төв байгууллагаар дамжуулан нөгөө улсын ИНТЕРПОЛ–ын төв байгууллагад дэлгэрэнгүй мэдээллээ өгөх бөгөөд хүсэлт хүлээн авсан улсын мөрдөгч уг хүсэлт дээр ажиллаж эхэлдэг. Туршлагаас харахад, мөрдөгчид өөр улс орны ИНТЕРПОЛ–той шууд холбогдсон тохиолдолд өөрийнхөө улсын ИНТЕРПОЛ–ын төв байгууллагад заавал мэдэгдэх шаардлагатай байдаг бөгөөд бусад орны цагдаагийн байгууллагын анхаарлыг татаж байсан эсэхийг шалгах үүднээс гэмт этгээдийн нэр ИНТЕРПОЛ–ын мэдээллийн сангийн хайлтад бичигдсэн эсэхэд анхаарлаа хандуулан ажиллах хэрэгтэй.

ЦЕГ-ын Интерполын үндэсний төв товчооны ажлын алба[32] дараах бүрэлдэхүүнээр ажилладаг:

» Интерполын үндэсний төв товчооны дарга-1;

31 Эх сурвалж: Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг дээр ажиллаж буй мөрдөн байцаагчдад зориулсан гарын авлага; ИНТЕРПОЛ-ийн Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн ажлын хэсэг; 2003

32 https://www.interpol.int/Member-countries/Asia-South-Pacific/Mongolia

- Ажлын албаны дарга-1;
- Ахлах мэргэжилтэн-2;
- Мэргэжилтэн-1.

Гүйцэтгэх үүрэг:

- ИНТЕРПОЛ–ын гишүүн байгууллагууд болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэрэгтэнтэй холбоотойгоор тухайн улсын хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн хүсэлт дээр ажиллах;
- ИНТЕРПОЛ–ын гишүүн байгууллагууд болон дотоод, гадаадын хууль сахиулах байгууллагаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэрэгтэнтэй холбоотой мэдээлэл шаардлагатай болсон үед мэдээлэл солилцох;
- Монголын цагдаагийн байгууллагад гадаадын улс орнууд дах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх, эрэн сурвалжлагдаж байгаа гэмт этгээдүүд, тэдний гэмт хэрэг үйлдэгч арга барилын талаар мэдээллийг мөн дамжуулах;
- Монголын хууль сахиулах байгууллагад үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улс хэрхэн хамтран ажиллах талаар мэдээлэл өгөх;
- ИНТЕРПОЛ–ын гишүүн орнуудаас гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагынхаа нь талаар зөвлөгөө хүсэх;
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх бичиг баримтыг солилцох ажлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэгтэн шилжүүлэх ажилд оролцох.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дараах мэдээллийг суралцагчдад өгнө үү.

ИНТЕРПОЛ-ын үндэсний товчооны хаяг, холбогдох утас.

Цагдаагийн байгууллага-цагдаагийн байгууллагатайгаа албан бусаар харилцаж хүсэлт гаргах үйл ажиллагааг зохицуулдаг засгийн газрын бодлого, дүрэм журам, цагдаагийн байгууллагын удирдамж.

Энэхүү аргыг байнга хэрэглэдэг үү эсвэл онцгой тохиолдолд л ашигладаг уу?

Албан бус хүсэлт дээр ажиллах холбоо тогтоох төв нэгж байгуулагдсан эсэх мөн хамтран ажиллах үүрэгтэй алба хаагч томилогдсон эсэх?

СЭДЭВ 4: БУСАД БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

А. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА/УЯЛДАА ХОЛБООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл бөгөөд хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад багагүй хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Гэвч хүн худалдаалах гэмт хэрэг нь өөрөө нарийн түвэгтэй шинж чанартай, олон арга хэлбэрээр үйлдэгддэг тул энэхүү гэмт хэрэгт өртсөн хохирогчийг нөхөн сэргээж, хуучин байдалд нь оруулах зэрэг ажилд нарийн зохион байгуулалттайгаар, оролцогч байгууллагууд санаа нийлсэн байдлаар ажиллах шаардлагатай болдог. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг зөвхөн нэг байгууллагад хүлээлгэх үйл ажиллагаа нь зөвхөн тэр байгууллагад хамаатай мэтээр хандах нь өрөөсгөл юм. Тийм учраас шүүх эрх

мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчид, нийгмийн халамжийн ажилтан, иргэний нийгмийн болон, хэвлэл мэдээллийн байгууллага, эрдэмтэн судлаачид гэх зэрэг олон байгууллага, хувь хүн хамтран ажиллаж байж энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийн нарийн түвэгтэй шинж чанар, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогч эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон бага насны хүүхдийн хэрэгцээний цар хүрээ зэрэг нь уг гэмт хэрэг дээр ажиллахад нэгдмэл, олон талын оролцоотойгоор хамтран ажиллах хэрэгтэй болдог. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч нийгэм, бие махбод, сэтгэл зүй, сэтгэцийн хувьд их хохирол амсдаг. Энэ нь хамтран ажиллаж буй байгууллагууд шаталсан, цогц хариу арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байгаа юм. Шүүх эрх мэдлийн болон засгийн газрын харьяа байгууллага (цагдаа, хил хамгаалах, гааль, гадаадын иргэн, харьяатын газар, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, мэргэжлийн хяналт) төрийн бус байгууллагууд хоорондоо сайтар харилцаатай, уялдаа холбоотой ажиллах нь зайлшгүй чухал.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг байгууллагууд тус гэмт хэрэгт өртсөн хохирогчтой шүүх хурал хүртэл ажиллаад зогсохгүй тэднийг нөхөн сэргээж, хуучин байдалд нь эргүүлэн оруулах болон аюулгүй байдлыг нь ханган ажиллахдаа байгууллага хоорондын хамтын ажиллагааг чухалчлан үзэх хэрэгтэй. Өөр өөр чиг үүрэг бүхий яамд, засгийн газрын харьяа агентлагууд, ТББ-ууд хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, нөхөн сэргээлт, эргэн нийгэмших болон нийгмийн халамжийн хэрэгцээг ханган ажиллах тал дээр хамаагүй илүү байдаг бөгөөд хохирогчтой шүүх хурлаас өмнө, шүүх хурлын явцад болон дараа нь холбоотой ажиллаж чаддаг тул сайн туршлагад тооцогддог. Хоорондоо мэдээлэл солилцох, ур чадвар, туршлагаа хуваалцах нь тухайн хүн дахин хохирогч болох эрсдэлийг мэдэгдэхүйц бууруулдаг төдийгүй нотлох баримт болон гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татах ажиллагаа амжилттай явагдахад эергээр нөлөөлдөг.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол-ын 9 дүгээр зүйлд (3): Энэхүү зүйлд заасан бодлого, хөтөлбөр, бусад арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг оруулна гэж заасан байдаг.

2005 онд батлагдсан Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдүүдтэй холбоотой асуудлыг зохицуулах зөвлөмжийн 43-т: Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх, өмгөөлөл хийх, эдийн засгийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, боловсрол, эрүүл мэнд, хууль, нийгмийн үйлчилгээ зэрэг өргөн хүрээний тусламж, дэмжлэг үзүүлэх явцад энэхүү үйл ажиллагаанд оролцож буй мэргэжилтнүүд хамтарч, хоорондоо уялдаа холбоотой ажиллахын тулд бүхий л хүчин чармайлтыг тавих ёстой талаар онцгойлон заасан байдаг. Ингэхийн тулд хохирогч эсвэл гэрч болсон хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэн ажилладаг байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих байдлаар гэмт хэрэг дээр ажиллах үйл ажиллагаа бүрэн дуустал дагаж мөрдөх протоколыг бий болгох, мөн байршлын хувьд ойролцоо орших цагдаагийн байгууллага, прокурор, эмнэлэг, нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий байгууллагын ажилтнуудын хамтарч ажиллаж болох бусад хэлбэрүүдээр үйл ажиллагаагаа нэгтгэж болно.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ***Урьдчилан сэргийлэх, Гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татан шалгаж, шүүхээр шийдүүлэх, болон Хамгаалах үйл ажиллагаа*** буюу "3 Пи" загварыг ашиглан ажиллах үед хамтран уялдаа холбоотой ажиллах зайлшгүй шаардлагатай болдог бөгөөд үүнийг НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол ёсоор оролцогч улс орны биелүүлэх ёстой үүрэг хэмээн заасан байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, энэ гэмт хэрэгт өртөөд байгаа эмзэг бүлгийн хүмүүст нөлөөлж буй хүчин зүйлстэй нь нүүр тулж ажиллах зэрэг үйл ажиллагаанд засгийн газрын харьяа байгууллагууд, хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бизнесийн байгууллагууд хамтран ажилласнаар тодорхой үр дүнд хүрэх боломжтой. төрийн бус байгууллагууд бизнесийн байгууллагуудтай хамтарч, тухайн хохирогчид эдийн засаг, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэгт дахин өртөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тухайн гэмт хэрэг үйлдэгдэх үндэс суурь болж буй хүний биеийг үнэлүүлэх, хямд ажиллах хүчин олох, хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх зэрэг эрэлтийн хүчин зүйлстэй тэмцэж ажиллах нь зүйтэй.

Гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, тохирсон ял шийтгэлийг оноох ажил дан ганц шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үүрэг биш, харин энэ үйл ажиллагаанд оролцож буй бүх байгууллагын хамтын хүчин чармайлтаар амжилтад хүрдэг зүйл юм. Тухайлбал, төрийн бус байгууллагууд (хохирогчийг шүүх хуралд бэлтгэх гэх мэт олон үүрэгтэй оролцдог) болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл (шүүх хурлын явцын талаар тогтмол мэдээлж, тухайн хэрэг үнэн зөв, шударгаар шийдэгдэж байгааг олон нийтэд хүргэх) чухал үүрэгтэй байдаг.

Хохирогчийн эрхийг хамгаалахад мөрдөн шалгах ажиллагаа болон шүүх хурлын үеэр тухайн хэрэг дээр ажиллаж буй бүхий л байгууллагууд хамтран ажиллах боломжтой байдаг. Гэмт хэргийн хохирогчийг олж илрүүлж туслалцаа үзүүлсэн хүнд анхаарал хандуулан, тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг дотор нь хоёр хувааж үздэг. Нэгдүгээрт, зөвлөгөө өгөх, гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэгийг эмчлэх, сэтгэл зүйн болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх. Хоёрдугаарт, амьжиргаагаа залгуулж, орлогын эх үүсвэртэй болгох сургалт, хөтөлбөрүүдэд хамруулах. Энэ ажлын хүрээнд хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бизнесийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хүний эрхийг хамгаалахтай холбоотой ажилладаг бүх хүн хувь нэмрээ оруулах боломжтой.

Гурван Пи загвар (Урьдчилан сэргийлэх – Хамгаалах – Гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял шийтгэл оноох)

Б. ХОХИРОГЧИЙГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД НЬ ШИЛЖҮҮЛЭХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй (эрэгтэй, эмэгтэй) болон хүүхэд төвтэй арга уг гэмт хэргийн хохирогчийн туулсан хүчирхийлэл, мөлжлөг нь эрүүгийн хэрэг төдийгүй хохирогчийн эрхийг ноцтойгоор зөрчиж буй үйлдэл гэдгийг харуулдаг. Засгийн газрын харьяа байгууллагууд болон төрийн бус байгууллагууд үүнтэй тэмцэж ажиллах үүрэгтэй байдаг. Олон улс оронд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоож, тэдэнд шаардлагатай нийгмийн халамж үйлчилгээг үзүүлдэг үндэсний механизмтай байдаг.

Хууль сахиулах байгууллага хохирогчид хамгийн анх тусламж үзүүлж, холбогдох байгууллагад шилжүүлэх бөгөөд энэ нь тухайн хохирогч мэргэшсэн байгууллагаар дамжуулан шаардлагатай тусламж, үйлчилгээг цогц байдлаар авахад нь чиглүүлж буй явдал юм.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дараах мэдээллийг сургалцагчдад өгнө үү.

- *Хууль сахиулах байгууллага/бусад хамтрагч байгууллагуудтай ялангуяа төрийн бус байгууллагатай хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохицуулах аливаа гэрээ (хэрэв байдаг бол)-ний талаар дэлгэрэнгүй мэдээлэл .*
- *Хууль сахиулагч, прокурор тухайн төрийн бус байгууллагын хаяг байршил, 24 цаг бэлэн байдалд ажиллагаатай байдаг ямар дугаар байдаг, холбогдох ажилтантай хэрхэн холбогдож болох асуудлыг зохицуулдаг цагдаагийн байгууллага/ Засгийн газрын харьяа байгууллагын бодлого, дүрэм журам (хэрэв байдаг бол).*

СЭДЭВ 5: ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭГТГЭН ДҮГНЭХ НЬ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд цагдаагийн байгууллагаас гадна бусад олон байгууллага хуульд заасан чиг үүргийн дагуу үйл ролцдог. Энэ төрлийн гэмт хэрэгтэй ганц байгууллага дангаараа тэмцэх боломжгүй юм. Гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэж, хохирогчийг мөлжихдөө маш нарийн зохион байгуулалттай ажилладаг. Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд оролцдог байгууллагууд ч мөн адил "нарийн зохион байгуулалттай ажиллаж", тухайн гэмт хэрэг дээр ажиллахдаа хохирогчийг чөлөөлөхөөс өмнөх үе, чөлөөлөх үе шат болон чөлөөлсний дараа ч хамтран ажилласан хэвээр байх шаардлагатай.

Холбогдох яам, агентлаг дотооддоо бүтэц зохион байгуулалтын механизм үүсгэн, бусад байгууллагуудтайгаа хэрхэн хамтарч ажиллах талаар цар хүрээгээ тодорхойлж, нэг удаагийн бус байнгын уялдаа холбоотой ажиллах тал дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хамтран ажиллах байгууллагуудаа нэг зорилгын дор нэгтгэхийн тулд холбоо харилцаа үүсгэх, үл итгэх байдал болон хоорондоо харилцаа холбоотой ажиллахгүй байгаа асуудлаа арилгах, гэмт хэргийн хохирогчид шаардлагатай тусламж дэмжлэгийг давхардуулж үзүүлэх эсвэл огт дэмжлэг туслалцаа үзүүлэхгүй байхаас урьдчилан сэргийлэх, аль байгууллага нь ямар үүрэг

хариуцлага хүлээж ажиллахыг тодорхой болгох шаардлагатай.

Монгол улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцогч байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, хамтын ажиллагааны матрицыг доор үзүүлэв.

Оролцооны үе шат	Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэг
Хохирогчийг олж тогтоох, энэ талаар мэдээлэл цуглуулах	Цагдаагийн Ерөнхий газар, түүний харьяа газар, хэлтэс, тасаг Хуулиар харьяалуулсан, өөрсдөө илрүүлсэн гэмт хэрэгт Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар	Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар гэмт хэргийн талаар мэдээлэл ирүүлсэн тохиолдолд хохирогчийг олж тогтоох, мөрдөн шалгах арга хэмжээ авна. Хохирогчийг олж илрүүлэх чиглэлээр нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэгтэй. Хууль сахиулах бусад байгууллагатай мэдээллийн сан үүсгэн хамтран ажиллах, мэдээлэл солилцох
	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны холбогдох газар, хэлтэс, харьяа агентлаг	Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар мэдсэн, эсхүл илрүүлсэн бол цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх үүрэгтэй
	Гадаадын иргэн харьяатын газар, түүнд хамаарах нэгж, Хил хамгаалах ерөнхий газар түүнд хамаарах нэгж	Хилийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар мэдсэн, эсхүл илрүүлсэн бол холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэх үүрэгтэй Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж таних үүнтэй холбоотой мэдээллийн сан үүсгэх, ашиглах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах
	Төрийн бус байгууллага	Төрийн бус байгууллага нь хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлэх явцдаа өөр бусад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж мэдсэн тохиолдолд Хүн худалдаалахтай тэмцэх хууль сахиулах байгууллагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд боломжит туслалцаа үзүүлэх эрхтэй.
Хохирогчийг чөлөөлөх	Цагдаагийн Ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий газар, хэлтэс, тасаг, Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Хуулиар харьяалуулсан, өөрсдөө илрүүлсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар	Дээрх хууль сахиулах байгууллагууд нь өөрсдөө болон бусад байгууллагатай хамтран илрүүлсэн, олж тогтоосон хохирогчийг ЭХХШТХ болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, бусад хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх арга хэмжээ авна. Гадаад улсад байгаа хохирогчийг чөлөөлөх арга хэмжээ авахдаа гадаад улсын хууль сахиулах байгууллагаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хүрээнд даалгавар өгч гүйцэтгүүлэх эсхүл хамтран хохирогчийг чөлөөлөх арга хэмжээ авна.
Чөлөөлсний дараа мэдүүлэг авах	Хууль сахиулах байгууллагын харьяа газар хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Төрийн бус байгууллагууд / нийгмийн ажилтнууд	Хууль сахиулах байгууллага нь ЭХХШТХ, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг тодорхойлох, цаашид учрах эрсдэлийг бууруулах үүднээс хохирогчтой чөлөөт ярилцлага хийнэ. Төрийн бус байгууллага болон нийгмийн ажилтнууд нь хохирогчтой чөлөөт ярилцлагыг тодорхой журмын дагуу хийж болох бөгөөд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцоно.

Оролцооны үе шат	Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэг
Үйлчилгээнд хамруулах	Хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагууд нийгмийн ажилтнууд, Эрүүл мэндийн яам	Хууль сахиулах байгууллага нь ЭХХШТХ, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хохирогчийг сэтгэл зүйн болон аюулгүй байдлын хамгаалалтын бусад үйлчилгээнд хамруулна. Төрийн байгууллага нь төрийн бус байгууллагын дэмжлэг туслалцааг хохирогчийг үйлчилгээнд хамруулахад авч болох бөгөөд зарим ажлыг төрийн бус байгууллагын тухай хуульд заасны дагуу гэрээгээр гүйцэтгэдэг.
Гэмт хэргийг мөрдөн шалгах	Авлигатай тэмцэх газар болон Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн байгууллагын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий газар, хэлтэс нь хамтарч болон(бэлгийн мөлжлөгтэй холбоотой гэмт хэргүүд), Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар болон Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтарна.	Цагдаа, тагнуул, АТГ нь хуулиар харьяалуулсан хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгана. Мөрдөн шалгах ажиллагааг ЭХХШТХ-д заасан үндэслэл журмын дагуу явуулна. Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газрын эрх бүхий алба хаагчийн хуульд заасан үндэслэл журмын дагуу хийсэн ажиллагааг ЭХХШТХ-д заасны дагуу нотлох баримтаар үнэлэх боломжтой.
Хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээ, хохирогчийг хамгаалах	Цагдаагийн Ерөнхий газрын Гэрч хохирогчийг хамгаалах газар, Түр хамгаалах байр, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, төрийн бус байгууллагууд , Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар (Албадан хөдөлмөр эрхлүүлэх, гадаадын ажилчидтай холбоотой хэргүүд), Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, тэдгээрийн харьяа газар хэлтэс Төрийн бус байгууллага	ЭХХШТХ, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллана. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх журмын дагуу гүйцэтгэнэ. Хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ЭМЯ, Боловсролын яам, ХНХЯ зэрэг төрийн захиргааны төв байгууллагын харьяа нэгж, хэлтэс, хамгаалах байр, үйлчилгээ туслалцааны төвүүд нь голлох үүрэгтэй. Төрийн бус байгууллагаар сэтгэл зүйн болон хууль зүйн зарим туслалцааг үзүүлж болно.
Гэмт этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх	Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, тэдгээрийн харьяа нэгж хяналтын прокурор, Цагдаагийн байгууллагын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөрдөгч	ЭХХШТХ-д заасны дагуу ЦЕГ, ТЕГ, АТГ-ын мөрдөн шалгасан эрүүгийн хэргийг прокурор хянаж, шүүхээр хянан шийдвэрлэнэ. Энэ хэргийн харьяаллыг Улсын Ерөнхий прокурор тогтоох бөгөөд Нийслэлийн Прокурорын газар одоогийн байдлаар хяналт тавина.
Эх оронд нь эргүүлэн авчрах	Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар холбогдох элчин сайдын яамд/консулын газрууд	ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ нь хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шийдвэрлэдэг. Үүнд тухайн оронтой байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ голлох үүрэг гүйцэтгэнэ.

ДАСГАЛ АЖИЛ 7 – ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРГИЙН МАТРИЦЫГ ГАРГАХ ТЭДНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ ХАМТРАН АЖИЛЛАХ ЦАР ХҮРЭЭ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дүрд тоглох дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс жүжиглэх үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол

байх хэрэгтэйг анхаарна уу.

Зорилт: Өгөгдсөн дасгалд үндэслэн, хамтран ажиллах боломжтой байгууллагуудыг тодорхойлж, тэдний гүйцэтгэх үүргийг жагсааж бичих бөгөөд хэрхэн хамтран ажиллах талаарх дүр зургийг гаргана.

Хугацаа: 20 минут

Сургалтын хэрэглэгдэхүүн: Тараах материал, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажиллах: Суралцагчдад тараах материалыг тарааж өгнө. Сургагч багш ханын цаасыг байрлуулж, суралцагчдаар дараах дасгалыг ажиллуулна. Үүнд:

- Өгөгдсөн дасгалын хүрээнд, хамтран ажиллах байгууллагуудаа тодорхойлж, хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлэх байгууллагыг нэрлэнэ. Суралцагчдын нэрлэсэн (тухайлбал цагдаагийн байгууллага) байгууллага бүрийг ханын цаасанд тэмдэглэж авах байдлаар тухайн хэрэг дээр хамтарч ажиллах байгууллагуудыг гаргаж ирнэ. Байгууллага бүрийг тусдаа ханын цаасан дээр бичнэ.
- Суралцагчдын нэрлэсэн байгууллага бүрийн дор гүйцэтгэх үүргийг нь бичүүлнэ. (Тухайлбал, цагдаагийн байгууллагыг нэг ханын цаасан дээр бичсэн байгаа бол түүн дээр тэдний гүйцэтгэх үүргийг бичүүлнэ гэсэн үг).

Цагдаа	Төрийн бус байгууллага	Прокурор
Хохирогчийг олж тогтоох xxx xxx	xxx xxx xxx	xxx xxx xxx

Тохиолдол

Нарангэрэл 21 настай, Ховд аймгийн төвд аав, ээж, 2 эрэгтэй дүүтэйгээ амьдардаг охин. Тэрээр айлын том охин бөгөөд аав нь төрийн албан хаагч. Нарангэрэл их сургуульд суралцдаг бөгөөд бусадтай эв зүйтэй харилцдаг, нөхөрсөг зантай охин. Тэр шинэ техник технологийг ихэд сонирхдог ба ухаалаг утас хэрэглэж, олон нийтийн сүлжээнд их идэвхтэй байдаг. Тэр Facebook-т 450 гаран найзтай, тэдэндээ нэлээд танигдсан охин байлаа. Нэгэн өдөр Нарангэрэл Билгүүн нэртэй аятайхан залуугаас найзын хүсэлт хүлээж авав. Тэр Билгүүний талаар юу ч мэдэхгүй ч хүсэлтийг нь хүлээн авч, түүнтэй байнга харилцах боллоо. Билгүүн өөрийгөө Хятадад амьдардаг, өөрийнх нь байгаа газар ямар сайхан, том хот болох тухай мөн Нарангэрэл шиг үзэсгэлэнтэй, боловсролтой охин ажилд ороход хялбар байдаг талаар бичдэг байлаа. Нарангэрэлийн аав түүнийг Билгүүнтэй Facebook-ээр харилцаж буйг нь мэдээд, аюултай гэж анхааруулаад, хичээл номдоо анхаарлаа хандуул гэж хэлсэн боловч тэр өөрийнх нь байгаа аймгийн төв хүсэл мөрөөдлөө биелүүлж, сайхан амьдрахад нь хэтэрхий жижиг мэт санагдаж, Билгүүнтэй хамт хүсэл мөрөөдлөө даган Хятад руу явахаар шийдсэн байлаа. Тэр нууцаар төлөвлөж эхэлсэн бөгөөд Билгүүн түүнийг Зоригт гэдэг нэртэй Facebook-ийн найзтайгаа танилцуулав. Зоригт Нарангэрэлд Хятад руу зорчих хуурамч бичиг, баримт, виз гаргаж өгөхөд туслав.

Нарангэрэл гэр бүлийнхэндээ хэлэлгүй нууцаар явж, Бээжин хот хүрлээ. Тэр тэнд Билгүүнтэй анх удаа нүүр тулж уулзсан боловч Билгүүн Facebook-д тавьсан зураг шигээ залуу хүн огт биш харин 55 настай хүн байж таарав. Тэр бичиг баримт, гар утас, компьютер зэрэг бүх зүйлээ Билгүүнд хураалгаж, нэгэн байшинд цоожлогдсон бөгөөд өдөрт арав гаран хүнд хүчээр биеэ үнэлдэг боллоо. Тэр үйлчилсэн бүх хүнээсээ гэр лүүгээ залгаж өгөхийг гуйдаг байлаа. 4 сарын дараа нэгэн эр түүнийг өрөвдөж, утсаараа яриулав. Тэр ээжтэйгээ ярьж, өөрт тохиолдсон бүхнээ ярьснаас хойш сарын дараа өөр дөрвөн охины хамт уг газраас чөлөөлөгдөж гарлаа. Тэр одоо гэртээ харихаар хүлээж байгаа.

2

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР

(МОДУЛЬ 7-11)

МОДУЛЬ - 7

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг чөлөөлөх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон чөлөөлөх ажиллагааны дараа хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар мэдлэг чадвар эзэмшүүлэхэд оршино.

Сэдэв 1 Мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогчийг чөлөөлөх, сэжигтнийг баривчлах
Сэдэв 2 Хэргийн газарт үзлэг хийх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх нь
Сэдэв 3 Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтний онцлог шинж
Сэдэв 4 Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах зүйл

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хууль сахиулах албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай мэдээлэл авмагцаа хариу арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан мэдээлэлдээ үндэслэн чөлөөлөх ажиллагааг зохион байгуулна.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг чөлөөлөх, гэмт этгээдийг баривчлах ажиллагааг хохирогч төвтэй, хүүхэд эмэгтэйчүүдэд илүү анхаарал хандуулсан байдлаар зохион байгуулагдах шаардлагатай.
- Баривчилгааны үед хохирогчийн болон сэжигтний аль алийнх нь эрхийг хөндөлгүй тэнцвэртэй байдлаар ажиллах хэрэгтэй. Сэжигтний эсрэг авч хэрэгжүүлж байгаа бүх ажиллагаа Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх шаардлагатай.
- Мөрдөн шалгах ажиллагааны үед хууль сахиулах албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хүүхэд / насанд хүрээгүй хүмүүстэй ажиллах шаардлагатай болж болно. Энэ тохиолдолд хүүхдэд хамааралтай үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.
- Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогчийг чөлөөлөх, гэмт этгээдүүдийг баривчлах, гэмт хэргийн газрыг хамгаалах зэрэгт PEACE загварыг ашиглах нь үр дүнтэй байдаг.
- Гэмт хэргийн газрыг хамгаалах ажил тухайн газрыг анхааралдаа авсан цагаас эхэлж, шалгах ажиллагаа дуустал үргэлжилнэ.
- Нотлох баримтыг устгаж, гэмтээхгүй байх үүднээс маш хянуур болгоомжтой ажиллах шаардлагатай. Тухайн нотлох баримт анх ямар байдалтай байсан тэр хэвээрээ шүүхэд очих ёстой.
- Нэгжлэг хийх, эд хөрөнгийг нь хураан авахдаа нотлох баримтын бүрэн бүтэн байдалд анхаарч ажиллах нь гэмт этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай нотлох баримт цуглуулахтай адил чухалд тооцогддог.
- Мөрдөгч нар яллагдагч өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэдгийг мэдэж байх шаардлагатай бөгөөд шүүхийн үе шатанд хэрэг болох мэдүүлэг авахын тулд хохирогч, яллагдагчийг аль алиныг нь байцаахдаа бэлтгэл сайтай байх хэрэгтэй.
- Хүн худалдаалах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт хэрэг талаас нь шалгаж, гэмт хэрэг үйлддэг санхүүгийн сүлжээг нь мөрдөх нь тэдний бүлэглэл, сүлжээг таслан зогсоох төдийгүй цаашлаад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Сургалтын хугацаа - 3 цаг (180 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх
- Суралцагчдад тараах материал, урьдчилан бэлтгэсэн дасгал ажил, лавшруулж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийг бэлтгэх
- Сургалтад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх.

Модуль 7: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогчийг чөлөөлөх, сэжигтнийг баривчлах	Лекц/ хэлэлцүүлэг	60	Сэдэв 1
Сэдэв 2	Хэргийн газрыг хамгаалж, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх	Лекц/ хэлэлцүүлэг	40	Сэдэв 2
	Дасгал ажил 8 (Модуль 2-ын дасгал ажил 1) – Хэргийн газрыг хамгаалалтанд авч, нотлох баримт цуглуулах, ашиглах	Дасгал ажиллах	40	Модуль 2-ын дасгал ажил 1
Сэдэв 3	Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтний онцлог шинж	Лекц/ Хэлэлцүүлэг	20	Сэдэв 3
Сэдэв 4	Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах зүйл	Багаар ярилцах, хэлэлцүүлэг	20	Сэдэв 4

СЭДЭВ 1: МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД ХОХИРОГЧИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, СЭЖИГТНИЙГ БАРИВЧЛАХ

1. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, сэжигтнийг олж тогтоох

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Модуль 3-ын Сэдэв 3-т *заасан "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоох" болон "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээлэх" хэсгүүдийг суралцагчдад эргэн сануулна уу.*

Цагдаагийн байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид болон хил хамгаалах албаны ажилтнуудад хүн худалдаалах гэмт хэрэг, аливаа мөлжлөг, хохирогч (бодит болон хохирогч болох магадлалтай хүмүүс)-той холбоотой мэдээлэл хэрхэн ирдэг талаар суралцагчдад сануулна.

Модуль 1-ийн Сэдэв 3-т *заасан "Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийн талаар ойлголттой болох" хэсгийг эргэн харж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хэн байж болох талаар дахин ярилцана. Ингэснээр "сэжигтнийг тогтоох нь" дэд сэдвийг илүү сайн ойлгуулах боломжтой болно.*

Сэжигтнээр тооцож, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэхтэй холбогдуулан 2017 оны Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ашиглах. Энэ хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл журмыг нарийвчлан зохицуулсан тул сургалтад хамрагдаж буй цагдаагийн албан хаагчид энэ хуулийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Сургагч багш хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан талаар суралцагчдад мэдээлэл өгнө.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар иргэн, байгууллагаас өгсөн мэдээллийг цагдаагийн байгууллагад шууд шилжүүлнэ. Гэмт хэргийн талаарх мэдээлэлд гэмт хэрэг үйлдэгдсэн байж болох шинж тэмдэг, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн талаарх үндэслэл бүхий мэдээлэл байвал цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажиллагааг нэн даруй эхлүүлнэ.

> Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, сэжигтэн баривчлах тухай хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын практикаас үзэхэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлэл авч, мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлснээс хойш буюу чөлөөлөх ажиллагааг явуулахаас өмнө гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээлэл нь чөлөөлөх ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, гэмт этгээдүүдийг баривчлахад хамгийн их үүрэг гүйцэтгэдэг.

Чөлөөлөх ажиллагаа явуулахын өмнө гүйцэтгэх ажлын шугамаар мэдээлэл цуглуулахын ач холбогдол, түүний шалгуур үзүүлэлт:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулалттай бүлэг, тэдний сүлжээг түргэн шуурхай илрүүлж, үйлдлийг нь таслах зогсоох.
- Гүйцэтгэх ажлын мэдээлэлд үндэслэж, мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөө гаргах, хохирогчийг хамгаалалтад авах, гэмт үйлдлийг таслан зогсоох.
- Цугларсан мэдээ, баримтыг нууц ажиллагаа эсвэл хэв журам сахиулах ажлаар халхавчлан нягтлах.
- Гүйцэтгэх ажлын явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн чөлөөлөх ажиллагаа зохион байгуулах хугацааг товлох.
- Чөлөөлөх ажиллагааны төлөвлөгөөг холбогдох байгууллагуудыг оролцуулан боловсруулах.
- Чөлөөлөх ажиллагаа явуулахаас өмнө гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан бүх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, чөлөөлөх ажиллагааг найдвартай зохион байгуулах төлөвлөгөө гаргахад бэлтгэх.
- Чөлөөлөх ажиллагаа явуулахаас өмнө гүйцэтгэх ажлын шугамаар үнэн бодитой мэдээлэл цуглуулж чадвал, цагдаагийн алба хаагчид чөлөөлөх ажиллагааг ямар цар хүрээнд зохион байгуулах, чөлөөлөх багийг ямар бүрэлдэхүүнтэй гаргах, түүнээс өмнө ямар ажлуудыг хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай, ямар байгууллагуудыг оролцуулах, чөлөөлөх ажиллагааны дараа ямар зүйлс шаардлагатай болох, үүнийг хэрхэн бэлтгэх талаар олон хариултыг олж авч чадна.
- Интернетийн өргөн хэрэглээний өсөлт ялангуяа Whatsapp, интернет ашиглан утсаар ярих зэрэг технологи ашиглаж байгаа нь гэмт этгээдүүд өөрсдийгөө танигдуулахгүйгээр хууль бус үйлдлээ олон хүнийг хамруулан үйлдэх боломж олгож байна. Интернет ашиглан утсаар ярих нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөн биеэ үнэлж буй хүн, секс үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийн аль аль нь гэмт этгээдийг нэг ч удаа харахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд "нэр, царай зүс нь тодорхойгүй" үйлдэгддэг гэмт хэргийн шинжийг агуулж байдаг.
- Гэмт хэргийн хохирогч гэмт этгээдтэй байнга утсаар холбогдож, нүүр царайг нь огт хараагүй байдаг нь сэжигтний талаар тодорхой мэдээлэл авч чадахгүй мухардмал байдалд оруулах хандлагатай байдаг. Гэмт бүлэглэлийн сүлжээнд нэвтрэх, нууц ажиллагаа явуулахдаа маш болгоомжтой хандах хэрэгтэй.

» Цахим сүлжээгээр эсвэл гар утас ашиглан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж байгаа үед гэмт этгээдийг олж тогтоох, хэргийг илрүүлэх ажил хүндрэлтэй байдаг. Уламжлалт арга барил ашиглан гүйцэтгэх ажиллагаа явуулах нь цахимаар үйлдэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй байдаг. Тийм учраас гүйцэтгэх ажил явуулах арга барилаа тохиромжтой сонгох шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг чөлөөлөх ажиллагаа явуулахаас өмнө гүйцэтгэх ажлын шугамаар мэдээлэл цуглуулахад дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн арга ямар байсан бэ? Мөлжлөгийн ямар хэлбэрт ашиглагдсан байсан бэ?
2. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо
3. Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн насны байдал
4. Мөлжлөг үйлдэгдсэн газрын байршил нь хаана вэ? Хохирогч нь хаана байгаа вэ?
5. Мөлжлөг үйлдэж буй гэмт этгээдүүд болон тэдний гол сүлжээ нь ямар байна вэ?
6. Ойролцоо эсвэл тухайн газарт өмнө нь чөлөөлөх ажиллагаа явагдаж байсан эсэх талаар нэмэлт мэдээлэл байгаа эсэх?

Чөлөөлөх ажиллагаа зохион байгуулахаас өмнө гүйцэтгэх ажлын шугамаар дээрх мэдээллийг цуглуулахад аливаа нууц ажиллагаа зохион байгуулж эсвэл зохион байгуулахгүйгээр явуулах боломжтой. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан нууц ажиллагаа зохион байгуулах шаардлагатай тохиолдолд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

Нууц ажиллагааг явуулахдаа Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн явуулах ёстой. Цагдаагийн албан хаагчид нууц ажиллагааг явуулах талаар ерөнхий ойлголт мэдлэгтэй байдаг ч дараах зүйлсийг анхаарч ажиллах нь чухал. Үүнд:

» Шаардлагатай мэдээллээ олж авахын тулд гэмт бүлэглэлд өөрийн хүнийг нэвтрүүлэх ажиллагаа зохион байгуулах .
» Нууц ажиллагаа явуулах цаг хугацаа богино, ажиллах хүчний боломж бага байдгаас шалтгаалан тухайн сүлжээнд ажиллаж байгаа аль болох олон хүнийг элсүүлэх замаар мэдээлэл олж авах төлөвлөгөөтэй ажиллах.
» Нууц ажиллагааг нэг объект дээр төвлөрөхгүйгээр тухайн гэмт хэрэг, гэмт бүлэглэлтэй холбоотой цаашдын эрэн сурвалжлах ажилд шаардагдах мэдээлэл олж авах зорилгоор явуулах хэрэгтэй.
» Нууц ажиллагааг гэмт хэргийн газрыг тогтооход ашиглаад зогсохгүй хүн худалдаалах гэмт хэрэг үйлдээд байгаа сүлжээ, зохион байгуулалтын талаар мэдээлэлтэй болоход мөн ашигладаг.
» Нууц ажиллагааг хохирогчдын тоог барагцаалах үүднээс мөлжлөг үйлдэж буй газарт (бэлгийн мөлжлөг үйлдвэр засварын газар мөлжлөг үйлдэж байж болзошгүй бусад газрууд) нэвтрэн орохоосоо өмнө бэлтгэл ажил хангах, шаардлагатай тээврийн хэрэгслийг бэлтгэх, эмнэлгийн тусламж бэлэн байлгах, чөлөөлсөн хохирогчоо хамгаалах газраа тодорхойлох зэрэг чөлөөлөх ажиллагааны цогц төлөвлөгөө гаргахад зориулж явуулдаг.
» Нууц ажиллагаа явуулах баг өөрсдийгөө танигдуулалгүй, аюулгүй байдлаа бүрэн хангах, дүрэм журмын дагуу хэрхэн ажиллагаагаа гүйцэтгэх талаар мэдээлэл авсан байх ёстой.
» Гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон этгээдийг олж тогтоохын тулд хуульд заасан бүхий л арга хэмжээг авах.

- Нууц ажиллагааг хохирогчийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох арга, хэлбэрээр явуулж болохгүй .
- Хүн худалдаалах гэмт хэргийг цахим сүлжээ, гар утсаар болон аливаа аппликейшн ашиглах зэрэг технологийн давуу талыг ашиглан танигдахгүй хэвээр үйлдсээр байгаа гэмт этгээдийн "царайг" харах нь хамгийн бэрхшээлтэй ажлын нэг болдог бөгөөд нуугдмал байдалд байгаа гэмт этгээдийг гаргаж ирэхийн тулд цагдаагийн албан хаагчийг худалдан авагч/үйлчлүүлэгч байдлаар явуулдаг ч тэднийг барих нь бэрхшээлтэй, хэцүү хэвээр байсаар байдаг.

Нууц ажиллагаа/гүйцэтгэх ажиллагааг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны мөрдөгч бие даан явуулах эрхгүй бөгөөд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий албан хаагч гүйцэтгэх ажлын хууль тогтоомжид нийцүүлэн явуулах эрхтэй. Энэхүү ажиллагааг Цагдаагийн ерөнхий газрын тусгай ажиллагааны газар, түүний албан хаагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх нь түгээмэл байдаг.

Харин шаардлагатай тохиолдолд Мөрдөн байцаах албаны мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1-26.6 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй.

2. Хохирогчийг чөлөөлөх, сэжигтнийг баривчлах ажиллагаа – PEACE загвар

Хохирогчийг чөлөөлөх, сэжигтнийг баривчлах ажиллагааны практик туршлагаас харахад PEACE загварыг үр дүнтэй ашиглах явдал чухалд тооцогддог.

P – Төлөвлөх, бэлтгэх үе шат
E – Нэвтрэх, гүйцэтгэх үе шат
A – Баривчлах
C – Гэмт хэргийн газрын менежмент
E – Нотлох баримтыг хурааж авах

Хохирогчийг чөлөөлөх "P" – Төлөвлөх, бэлтгэх үе шат; **"E"** – Нэвтрэх, гүйцэтгэх үе шат;

Сэжигтнийг баривчлах "P" – Төлөвлөх, бэлтгэх үе шат; **"E"** – Нэвтрэх, гүйцэтгэх үе шат, **"A"** – Баривчлах гэсэн утгыг тус тус илэрхийлнэ.

2.1 Хохирогчийг чөлөөлөх ажиллагаа

Гүйцэтгэх ажлын шугамаар мэдээлэл цуглуулж, нууц ажиллагаа явуулсны дараа чөлөөлөх ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргах шаардлагатай.

"P" – Төлөвлөх, бэлтгэх үе шат

1. Чөлөөлөх ажиллагаа үргэлжлэх хугацаа – Чөлөөлөх ажиллагаа явуулах ерөнхий зарчим нь өгөгдсөн хугацаанд дараах зорилтуудыг боломжийнхоо хэрээр биелүүлэхэд оршино. Үүнд:

- Аль болох олон хохирогчийг чөлөөлөх, чөлөөлөх ажиллагааны дараа тэднийг шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах.
- Гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэжигтэн нэг бүрийг баривчлах.
- Хохирогч болон чөлөөлөх багийн аль алинд нь чиглэсэн эрсдэлийн үнэлгээг хийж, тодорхойлогдсон эрсдэлийг хэрхэн бууруулах талаар төлөвлөгөө гаргах.
- Хэрэгт хамаарал бүхий бүх баримт сэлт, мэдээллийг хамгаалалтад авах.

2. Чөлөөлөх багийн бүрэлдэхүүн – Олон улс оронд хэрэгжүүлсэн сайн туршлагаас харахад бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг илрүүлэхээр ажиллаж буй чөлөөлөх болон дайчлан баривчилгааны багийн бүрэлдэхүүн ямар байх нь тухайн улс орны хууль тогтоомжоос хамаардаг. Түүнчлэн чөлөөлөх багт дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах хүмүүс бэлэн байдалд ажиллаж болно.Үүнд:

- Хэргийн газрын үзлэгийн бүрэлдэхүүн – гэмт хэргийн газраас нотлох баримт цуглуулна.
- Мэдээллийн сүлжээний мэргэжилтэн/цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ажилтан – компьютерээс цахим баримт олж авах.
- Гэрэл зураг авах мэргэжилтэн/дүрс бичлэгээр баримтжуулах мэргэжилтэн/
- Зөвлөгөө өгөх мэргэжлийн хүмүүс – хохирогчид яаралтай тусламж үзүүлж, зөвлөгөө өгөх
- Төрийн бус байгууллагын төлөөлөл – хохирогчийг олж тогтоох, бусад шаардлагатай арга хэмжээг авах
- Хэлмэрч – сонсголгүй, хэлгүй хохирогчтой ойлголцох
- Орчуулагч–хохирогчтой өөрийнх нь хэлээр ярилцах (тухайн хохирогч гадаадын иргэн гэдэг нь илэрхий болсон тохиолдолд)
- Эмнэлгийн ажилтан – хохирогчид яаралтай эмнэлгийн тусламж хэрэгтэй болсон үед, бие махбодын гэмтэл бэртэлтэй байгаа тохиолдолд.

3. Чөлөөлөх ажиллагааны бэлтгэл - Гүйцэтгэх ажлын шугамаар цуглуулсан мэдээлэлдээ үндэслэж, чөлөөлөх ажиллагаанд дараах зүйлсийг бэлтгэсэн байх шаардлагатай.

Хохирогчид тусламж үзүүлэх – Шаардлагатай хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эм, хоол хүнс (ялангуяа хүүхдүүдэд).

Бусад шаардлагатай зүйлс – Нууц ажиллагаагаар тогтоосон тухайн газрын байршлын бүдүүвч зураг; чөлөөлөгдсөн хохирогч болон сэжигтнийг тусад нь тээвэрлэхэд хүрэлцэхүйц тээврийн хэрэгсэл; зураг авах, дүрс бичлэг хийх төхөөрөмж; нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, тээвэрлэхэд зориулсан хайрцаг сав; анхны тусламжийн хайрцаг; гар чийдэн, алх, таслагч (ялангуяа биеэ үнэлэх газруудад гэмт этгээдүүд хохирогчдыг (ихэвчлэн хохирогч хүүхдүүдийг) бусдаас нууж далдалж байдаг учраас нэвтрэн орохдоо ашиглана).

4. Үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтайгаа хамтран ажиллах–Цагдаагийн байгууллагын албан хаагчдаас гадна бусад хамтрагч байгууллагууд ч өөр өөрсдийн үүрэгтэйгээр оролцоно. Цагдаагийн албан хаагчид эдгээр байгууллагуудыг чөлөөлөх ажиллагаа явагдахаас өмнө, ажиллагааны дундуур, ажиллагааны дараа тэднийг өөр хоорондынь холбож, хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ. Чөлөөлөх баг ч мөн адил өндөр зохин байгуулалт дор ажиллах бөгөөд хэн ямар үүрэгтэй оролцох нь тодорхой байх ёстой. Багийн ахлагч ажиллагааг удирдаж, гадаах орчныг хэн хамгаалах, хэн түрүүлж орох, хэн хохирогчийг олж тогтоох, хэн гэмт этгээдийг олж тогтоох гэх зэрэг бүх үүрэг хариуцлага тодорхой болсон байна. Чөлөөлөх ажиллагаа явуулах газар ирсэн хойно багийн дунд ямар нэг эргэлзээ, тээнэгэлзээ байх ёсгүй.

Олон улсын туршлагаас харахад цагдаагийн байгууллага хамтран ажилладаг байгууллагуудтайгаа хэрхэн ажиллах талаар ойлгомжтой бүтэц тогтолцоо үүсгэж, нэг удаа хамтраад зогсохгүй байнга хамтарч ажилладаг байх шаардлагатай байдаг. Цагдаагийн албан хаагчид байгууллага хоорондын үл итгэлцэл, уялдаа холбоогүй байдал, үүрэг хариуцлага давхардах, хохирогчид үйлчилгээ үзүүлэхгүй байх зэргээс сэргийлж хамтардаг байгууллагуудтайгаа холбоотой ойр ажиллах хэрэгтэй.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Чөлөөлөх ажиллагааны өмнөх үе шатанд ямар ямар байгууллагууд, ямар үүрэгтэйгээр оролцож болох талаар суралцагчдаар яриулна уу.

Суралцагчдын хэлсэн байгууллагын нэрийг ханын цаасан дээрх зурсан хүснэгтийн нэг талд бичиж, нөгөө талд нь ямар үүрэгтэйгээр оролцох талаар ярилцаж бичнэ. Холбогдох байгууллагуудыг аль болох бүгдийг нь бичүүлнэ.

Хамтрах байгууллага	Гүйцэтгэх үүрэг
Төрийн бус байгууллага	Өөрсдийн сүлжээгээр дамжуулан хохирогч (хохирогч болох магадлалтай хүмүүс) гэмт этгээдүүдийн талаарх мэдээллийг олж өгөх Чөлөөлөх багт багтаж, гадаадын иргэнд орчуулга хийж өгөх Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдын тусгайлсан зөвлөх, туслах нь болох Чөлөөлөх ажиллагааны үеэр яаралтай зөвлөгөө туслалцаа үзүүлэх үүрэг гүйцэтгэх

“Е” – Нэвтрэх, гүйцэтгэх үе шат

1. Хохирогч болон гэмт этгээдийг олж тогтоох

Чөлөөлөх баг гэмт хэрэг үйлдэгдэж буй газар очмогцоо дотор байгаа бүх хүнийг гаргахгүйгээр хамгаалалтыг чангатгана. Гэмт этгээдийг оргон зайлахаас сэргийлж бүх гарцыг хамгаалах нь чухал. Чөлөөлөх баг хамгийн түрүүнд гэмт этгээдүүдийн нуун далдалсан хохирогчдыг олж тогтоох шаардлагатай. Шилдэг туршлагаас үзвэл, чөлөөлөх ажиллагааны үед цагдаагийн албан хаагчид гэмт хэрэгтнүүдийг, төрийн бус байгууллагууд хохирогчдыг олж тогтоовол илүү үр дүнтэй байдаг. Бэлгийн мөлжлөгийн хохирогчид болон гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй этгээдийг гэмт хэргийн газар дээр олж тогтооход дараах шинж тэмдгүүдийг сайтар анзааран ажиллах шаардлагатай. Үүнд:

- Хохирогчийн нас – хүүхэд эсвэл залуухан эмэгтэй байх
- Чөлөөлөгдсөн хүүхдүүд/залуу эмэгтэйчүүд/эмэгтэйчүүдийг нуун далдалсан байх
- Хэсэг бүлэг, бөөнөөр нь байлгадаг байх
- Ихэнхдээ яахаа мэдэхгүй, төөрөлдсөн байдалтай харагдах
- Гэмт этгээдүүд тэдний өмнөөс ихэвчлэн хариулт өгөх.

Гэмт этгээдүүдэд илрэх шинж:

- Залуухан эмэгтэйчүүд байж болно
- Бусдыг эрхшээж, захирсан байдлаар харьцах
- Бусдыгаа дуугүй, чимээгүй байлгах дохио зангаа хэрэглэх
- Тухайн хүн байгаа үед бусад нь чимээгүй болох
- Зан байдал, биеийн хэл нь өөртөө итгэлтэй байдлыг илтгэх.

Албадан хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч, үйлдсэн гэмт этгээдүүдэд мөн дээрхтэй адил төстэй шинж тэмдэг илэрнэ.

Хохирогч, гэмт этгээд хоёрыг зөв тогтоохын тулд тэдний хоорондын эрх мэдлийн харилцан хамаарлыг мэдэрч, гярхай ажиглах нь чухал.

2. Гэмт этгээд, хохирогч хоёрыг нэн даруй тусгаарлах - Гэмт этгээд болон хохирогчийг зөв олж тогтоосны дараа гэмт этгээд хохирогчийг үгээр болон үйлдлээрээ заналхийлэх, дарамт шахалт үзүүлэх, аливаа мэдээлэл дамжуулах зэргээс сэргийлж, тэднийг нэг нэгнээ харж, сонсохооргүй нөхцөлд байлгах буюу нэн даруй тусгаарлах хэрэгтэй. Энэ нь чөлөөлөгдсөн хохирогчийн аюулгүй байдал, түүнийг хамгаалахад чиглэсэн хамгийн анхны алхам юм.

Хохирогчдын дунд хүүхэд хүүхэд шиг харагдаж байгаа хүн байвал 2016 оны "Хүүхэд хамгааллын тухай хууль" болон 2016 онд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу тэднийг тусад нь байлгаж, дараа дараагийн шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлнэ.

Гадаадын иргэн хохирогч болсон тохиолдолд – Бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхэлж байгаа хохирогчдыг чөлөөлөх ажиллагааны үеэр хохирогч нь гадаад иргэн, харьяалалгүй хүн байх бүрэн боломжтой байдаг. Эдгээр хохирогчдыг хамгаалалтад авч, 2012 онд батлагдсан "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" тухай хуулийн дагуу тохирох арга хэмжээг авна. Олон улсын туршлагаас үзэхэд тэдгээр гадаадын иргэдийг (тухайн улсад нэвтрэх, оршин суух хуулийн заалтыг зөрчсөн байсан ч) гэмт хэрэг үйлдсэн гэж үздэггүй. Учир нь тэднийг хулгайлах, хууран мэхлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эрх мэдлээ ашиглах замаар дээрх үйлдлийг хийхэд хүргэсэн байдаг. Чөлөөлөх ажиллагааны үеэр тогтоогдсон гадаадын иргэнийг Монгол улсын хуулийг санаатайгаар зөрчсөн гэж шууд дүгнэх нь учир дутагдалтай. Гэмт этгээд тухайн хүнийг авчирч, мөлжлөг үйлдэж байсан байж болно. Ерөнхийдөө хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн гадаадын иргэд ямар нэг бичиг баримт, визгүй байдаг.

> Монгол улсын Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлд "Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн бичиг баримтгүйгээр, эсхүл хуурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж заасан байдаг. Гэхдээ тайлбараар "Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн бичиг баримтгүйгээр, хуурамч бичиг баримтаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй." гэж заасан байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр тухайн хүн Монгол улсад нэвтрэн орохдоо аяллын журмаар ирсэн үү8 худалдаалагдаж ирсэн үү гэдэг нь тодорхой болно. Мөрдөн шалгах ажиллагааны явцад авсан мэдүүлгээр тухайн хүнийг хохирогч эсвэл гэмт этгээд үү гэдгийг ялгах боломжтой болно.

> Монгол улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд хамгаалахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

3. Хохирогчийг хүүхдээ болон эд зүйлсээ олж авахад нь туслах – Нөхцөл байдал намжиж, тайвширсан үед цагдаагийн албан хаагч хохирогчоос (ялангуяа бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч) хүүхэдтэй эсэх талаар лавлаж асуух хэрэгтэй. Байрлаж байсан газарт нь эсвэл түүнээс өөр газар гэмт этгээдүүд өөрийнх нь хүүхдийг нуун далдалж байгаа эсэхийг асууж хохирогчид хүүхдээ олж авахад нь туслах шаардлагатай. Түүнчлэн өөрийнхөө эд зүйлс (хувцас хэрэглэл, үнэт эдлэл, бэлэн мөнгө, бичиг баримт гэх мэт)-ийг авахыг хүсэж байгаа эсэхийг асууж, шаардлагатай бол цагдаагийн албан хаагч тусална.

4. Шаардлагатай эмнэлгийн яаралтай тусламж – Чөлөөлөх ажиллагааны явцад хүний биед гэмтэл учирсан, амь насанд нь аюул учирсан бол эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ёстой.

5. Хохирогч болон гэмт этгээдийг тусад нь зөөвөрлөх – Гэмт этгээд болон хохирогчийг олж тогтоосны дараа урьдчилан бэлтгэсэн байр руу тус тусад нь тээврийн хэрэгслээр авч явна. Гэмт хэргийн газраас хохирогчийг авармагцаа цагдаагийн хэлтэс, түр хамгаалах байр болон эмнэлэг зэрэг аюулгүй газарт аваачна.

Мөлжлөг үйлдэгдэж байсан газраас гэмт этгээд, хохирогч хоёрыг нэг тээврийн хэрэгслээр хэзээ ч авч явж болохгүй. Гэмт этгээд, хохирогч нарыг тээвэрлэх явцад тэдний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай.

Хохирогчийг чөлөөлөх ажиллагааны үеэр анхаарах асуудлууд

Хохирогчийг чөлөөлөх ажиллагааны өмнө хийгдэх болон хориглох зүйлс	
Хийж болох зүйлс	**Хориглох зүйлс**
Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан мэдээлэлдээ үндэслэн цогц байдлаар төлөвлөгөөгөө гаргах.	Баривчлах, чөлөөлөх ажиллагааг нэг дор бөөнөөр явуулахгүй байх.
Гэмт хэрэгт өртсөн хүн (чөлөөлөх ажиллагааны төлөвлөгөө) чөлөөлөх ажиллагааны байршилтай холбоотой мэдээллийг нууцлах.	Нууц ажиллагаанд оролцох хүн, хохирогч болон чөлөөлөх багийн гишүүдийг эрсдэлд оруулж болохгүй.
Чөлөөлөх ажиллагаанд оролцох багийн бүх гишүүдэд гүйцэтгэх үүргийнх нь талаарх чиглэлийг өгөх.	Чөлөөлөх баг хохирогч төвтэй арга барил ашиглахаас зайлсхийж болохгүй.
Чөлөөлөх ажиллагаа явуулах газарт байрлах хамгаалах байруудад хэдэн хүн чөлөөлөгдөж, хэзээ аваачиж байрлуулах талаар мэдээллийг өгөх.	Хохирогчийг түр байлгах газар, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлаа төлөвлөлгүйгээр чөлөөлөх ажиллагаа явуулахгүй байх.
Чөлөөлөх ажиллагааны талаар мэдэгдэх шаардлагатай байгууллага, албан хаагчдад шаардлагатай мэдээллийг хүргэх.	
Хохирогчийн талаар болон чөлөөлөх ажиллагаатай холбоотой мэдээллийг байнга нууцын зэрэглэлд байлгах.	Чөлөөлөх ажиллагаанд хэвлэл мэдээллийн ажилтнуудыг оролцуулахгүй байх. Чөлөөлөгдсөн хүмүүс ялангуяа хүүхдүүдийн талаарх мэдээллийг задруулахгүй нууцлах.
Хохирогчийг чөлөөлөх ажиллагааны үеэр хийгдэх болон хориглох зүйлс	
Хийж болох зүйлс	**Хориглох зүйлс**
Бэлгийн мөлжлөгийн хохирогчдыг аварч байгаа тохиолдолд хамгийн түрүүнд тэднийг буруутгахгүй байх талаар мэдээлэх.	Чөлөөлөгдсөн хохирогчидтой өөрсдийнх нь буруугаас болж ийм байдалд орсон мэт хандлага, харьцаа гаргахгүй байх.
Бүх хохирогчид хүндэтгэлтэй хандаж, нэр төрийг нь хамгаалах (ялангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүмүүст).	Хохирогчдыг буруутгасан, хүч хэрэглэсэн, доромжилсон шинжтэй үйлдэл гаргахгүй байх.
Хохирогчдыг аварч, мөлжлөг үйлдэж байсан газрыг ажиллуулж байсан, энэ үйлдэлтэй нь холбоотой бүх хүнийг баривчлах.	Хохирогчийг гэмт хэргийн газар дээр хамгийн түрүүнд зөв олж тогтоолгүйгээр эсвэл хийсэн үйлдлийг нь гэмт буруутай мэтээр харьцаж, тухайн хүнийг дахин хохирогч болгохгүй байх. Гэмт этгээдүүдэд хохирогчийг харах, уулзах боломж олгохгүй байх хэрэгтэй.
Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод зөвлөгөө өгч, тайван байдлыг бүрдүүлэх зорилгоор чөлөөлөх ажиллагаанд эмэгтэй ажилтан оролцуулах.	

Жирэмсэн/ бага насны хүүхэдтэй эмэгтэй хохирогчдод онцгой анхаарал хандуулан ажиллах.	
Хүүхдээ хайж байгаа хохирогчдод тусалж, эрлийн ажиллагаанд байлцуулах.	Гэмт этгээдүүд хохирогчийг буцааж ирүүлэх, өөрсдийнх нь эсрэг мэдүүлэг өгүүлэхгүй байх үүднээс хүүхдийг нь нуух, хохирогчийг сүрдүүлэх зэрэг үйлдэл гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.
Өөрийнхөө эд зүйлсийг авах боломжийг хохирогчдод олгох.	Өөрийнх нь эзэмшилд буй хөрөнгө, эд зүйлсээ авахыг нь хориглох.
Хохирогчийн талаар болон чөлөөлөх ажиллагаатай холбоотой мэдээллийг байнга нууцын зэрэглэлд байлгах.	Чөлөөлөх ажиллагаанд хэвлэх мэдээллийн ажилтнуудыг оролцуулахгүй байх. Чөлөөлөгдсөн хүмүүс ялангуяа хүүхдүүдийн талаарх мэдээллийг задруулахгүй нууцлах.

2.2 Гэмт этгээдийг баривчлах

Баривчлах ажиллагааны үе шат тодорхой хугацаанд явагдахаар төлөвлөгдөж, аль болох олон сэжигтнийг баривчилж, аль болох олон хохирогчийг чөлөөлөх зорилгоор зохион байгуулагдах хэрэгтэй. Түүнчлэн баривчилгааны өөр нэг зорилго нь төлөвлөсөн хугацаанд явуулж дууссанаар, нэмэлт нотлох баримт олж авахад чиглэгдэнэ.

“Р” – Төлөвлөх, бэлтгэх үе шат – Мөрдөгч дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. Хууль тогтоомж

- Олж авсан мэдээллүүд нь тухайн газрын байршлыг тогтоож, нэвтрэн орох, сэжигтнийг баривчлах хууль тогтоомжийн дагуу ашиглах хангалттай үндэслэл болж байгаа эсэх.
- Шүүхийн тогтоол/захирамжийн хуулбарыг нь биедээ авч явах.

2. Байршил

- Байршлыг нарийн тогтоож, объектын гадна, дотор талын бүдүүвч зургийг тоймлон гаргахыг хичээх.
- Тухайн байршилд хүрч очих хамгийн зөв зам нь аль байж болохыг тодорхойлох.

3. Шаардагдах бие бүрэлдэхүүн

- Хэдэн сэжигтэн байх магадлалтай гэж тооцсон бэ? Сэжигтнийг баривчлах болон баривчилсны дараа тэднийг зохих газар аюулгүй ажиллагааг ханган хүргэхэд хэр олон хүн шаардлагатай болох вэ?

4. Эрсдэл, эрсдэлийн менежмент

- Олж авсан мэдээллээс харахад ямар эрсдэл учирч болохоор байна вэ?
- Сэжигтэн–хэр олон сэжигтэн байгаа вэ, хэр зэрэг зэрлэг балмад авирладаг хүмүүс вэ, зэвсэглэсэн эсэх?
- Байршил–байршлын хувьд ямар нэг аюултай зүйл бий юу? Тухайлбал, давхар өрөөнүүдтэй эсэх, ил задгай цахилгааны утас, ямар нэг аюултай бодис, галын аюулын эрсдэл байгаа юу?
- Эрсдэлүүдийг хэрхэн бууруулж болох вэ?

5. Техник хэрэгсэл

- Аюулгүй ажиллагааны хэрэгсэл – тусгай зориулалтын хувцас, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, гав, бороохой хэрэгтэй эсэх?
- Тээврийн хэрэгсэл – Тухайн байршилд чөлөөлөх багийн бие бүрэлдэхүүн хэрхэн очих вэ?

» Гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх техник хэрэгсэл авч явах.
» Нэгжлэгийн хэрэгсэл – гар чийдэн, халив, нэгжлэг хийх бүртгэлийн бичиг баримт, үзэг.
» Харилцаа холбоо – Чөлөөлөх ажиллагааны багийнхан хоорондоо хэрхэн холбоо барих вэ? Жишээлбэл, радио, гар утсаар гэх мэт.

6. Чөлөөлөх багт танилцуулга хийх

» Бие бүрэлдэхүүнийг дотор нь баг болгон хувааж, баг тус бүрд өөр өөр үүрэг ноогдуул. Тухайлбал, нэг хэсэг нь байршилд нэвтэрч байхад, бусад нь сэжигтнүүдийг баривчлах, нэгжлэг хийх, хохирогчийг чөлөөлөх, аюулгүй байдлыг хангах, хэргийн газрыг хамгаалах зэрэг өөр өөр үүрэгтэйгээр оролцоно.
» Танилцуулгыг хийж, ажиллагаанд оролцох албан хаагчид энэхүү ажиллагааныхаа зорилго, өөрийн гүйцэтгэх үүргээ сайтар ойлгож авсан эсэхийг нь магадална.

"Е"– Нэвтрэх, гүйцэтгэх үе шат - Мөрдөгч дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. Нэвтрэх

» Байршилд нэвтрэн орох хамгийн зөв арга барил нь юу байх вэ?
» Хүч хэрэглэн нэвтрэх шаардлагатай юу эсвэл өөр бусад байдлаар нэвтрэх үү?
» Байршлын ойр орчмыг хамгаалалтад авах болон хамгийн түрүүнд объект руу нэвтрэн орох багуудыг нэгэн зэрэг хөдөлгөх хэрэгтэй.
» Боломжтой бол хамгийн түрүүнд нэвтрэн орох багийнханд зураг авах болон дүрс бичлэг хийх камерыг өгч хэргийн газар нэвтрэн орсон даруйдаа ажиллуулахаар зохион байгуулна.
» Төөрөгдөлд оруулахгүйн тулд нэвтрэн орох багуудаас хамгийн багадаа нэг багийг нь цагдаа хувцастай байлгах.
» Хэргийн газрыг аль болох түргэн шуурхай хяналтдаа авах.

2. Сэжигтэн

» Баривчилгааны баг сэжигтнүүдийг өөр бусад хүмүүст хохирол учруулахгүй байлгахын тулд түргэн хугацаанд саатуулан хорих шаардлагатай.
» Сэжигтэн эзэмшилдээ байгаа аливаа эд зүйлээ хаяж, үрэгдүүлэхээс сэргийлэх.
» Сэжигтнүүдийг хяналтдаа оруулмагцаа тэднийг хохирогчдоос тусгаарлаж, үг хэлээр болон үйлдлээрээ айлган сүрдүүлэх боломжгүй болгох.
» Сэжигтнүүдийг нэг нэгнээс нь тусгаарлаж, хоорондоо харилцах боломжгүй болгох.

"А"– Баривчлах - Мөрдөгчид дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. Аюулгүй байдал болон хүч хэрэглэх тухай

» Сэжигтэн этгээдийг олж илрүүлэн, баривчлах.
» Сэжигтэн этгээд өөртөө болон бусдад хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор баривчилгааны үед л хүч хэрэглэнэ.
» Бусад хүний аюулгүй байдлыг хангах үүднээс гэмт этгээдийг гавлах.
» Сэжигтэн этгээдийг хохирогчтой ярих болон бусад байдлаар харилцаанд оруулахгүй байх.
» Сэжигтэн этгээдүүдийг хоорондоо харилцахыг зөвшөөрөхгүй байх.
» Энэ үе шатанд сэжигтэн этгээдэд гар болон суурин утас ашиглахыг зөвшөөрөхгүй байх.

2. Сэжигтэнд мэдээлэл өгөх

» Сэжигтэнд дараах мэдээллийг нэн даруй өгнө. Үүнд:

- Баривчилгаа явуулсан албан хаагчийн нэр, цол
- Баривчлагдаж байгаа талаар нь мэдээлэх
- Ямар хэрэг үйлдсэний улмаас баривчлагдах болсон
- Баривчилгааны үндэслэл
- Хуулийн дагуу сэжигтний эдлэх эрх, дуугүй байх эрх
- Энэ үе шатанд сэжигтний өгсөн аливаа хариултыг бичлэг хийж хадгалах.

Баривчлах, цагдан хорихтой холбоотой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг

Улаан загалмайн нийгэмлэгийн олон улсын хороо "Цагдаагийн албан хаагч, аюулгүй байдлыг сахин хамгаалах хүчнийхэнд зориулсан хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүй: Үйлчлэх нь, хамгаалах нь" (1998) гэсэн гарын авлагадаа хууль сахиулах албан хаагчдын хүнийг баривчлахтай холбоотой үүрэг, хариуцлагын талаар тусган оруулсан байдаг. Тухайлбал:

- Хуулийн дагуу, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд л баривчилгаа явуулах
- Хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хүч хэрэглэх;
- Баривчлагдаж буй этгээдэд ямар шалтгааны улмаас баривчлагдаж байгаа талаар товч мэдээлэл өгөх;
- Ямар гэмт хэрэг үйлдсэний улмаас баривчлагдаж байгаа талаар хэлэх;
- Баривчлагдаж буй этгээдэд түүний ямар эрхтэй, энэхүү эрхээ хэрхэн эдлэх боломжтойг хэлнэ;
- Баривчлагдсан хүн бүртэй холбоотой дараах мэдээллийг бүртгэж авах шаардлагатай:
  - Баривчлагдсан шалтгаан;
  - Баривчлагдсан цаг;
  - Баривчлагдсаны дараа цагдан хоригдсон байр;
  - Шүүх эрх мэдлийн болон бусад албан тушаалтнуудтай хийсэн анхны уулзалт;
  - Холбогдох хууль сахиулах албан тушаалтны тодорхойлолт;
  - Цагдан хорьсон байрны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- Бүртгэж авсан дээрх мэдээллээ баривчлагдсан хүнд эсвэл өмгөөлөгчид нь танилцуулна;
- Тухайн баривчлах ажиллагааг хуулийн дагуу хийгдсэн эсвэл баривчлах зайлшгүй шаардлагатай байсан эсэхийг нотлох шүүх эрх мэдлийн эсвэл ижил түвшний албан тушаалтны өмнө гэмт этгээдийг нэн даруй авчрах;
- Баривчлагдсан хүнд хуулийн зөвлөгөө өгч, тэдэнд хоорондоо харьцах хангалттай цаг олгох;
- Баривчлагдах үед болон баривчлагдсаны дараа эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр тухайн хүнд хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг нь гутаасан байдлаар хандах эсвэл шийтгэхээс зайлсхийх;
- Баривчлагдсан хүний эдлэх эрхүүд олгогдож байгаа эсэхийг анхаарах;
- Эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүмүүсийн онцлог байдлыг харгалзаж, тэднийг хамгаалах дүрэм журмыг чанд сахих.

Өсвөр насны хүнийг баривчлах, цагдан хорих

Мөрдөн шалгах ажиллагааны үед цагдаагийн албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдсон эсвэл тухайн улс оронд хууль бусаар ирж, гэмт хэргийн хохирогч болсон, шаардлагатай бичиг баримтгүйн улмаас саатуулагдсан өсвөр насны хүмүүстэй нүүр тулах магадлалтай.

1989 оны "Хүүхдийн эрхийн конвенц"-д хүүхдэд хуулийн хамгаалал үзүүлэхийг оролцуулаад тэднийг асран хамгаалах, эрх ашгийг хамгаалах тусгай хэрэгцээ байдаг талаар онцлон

дурдсан байдаг. Конвенцийн 37-р зүйлд зааснаар:

- Өсвөр насны хүнд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус хандахын хориглоно (Цаазаар авах, суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ялыг оногдуулахгүй байх);
- Өсвөр насны хүний эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй.
- Өсвөр насны хүнийг баривчлах, цагдан хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх;
- Эрх чөлөөгөө хасуулсан өсвөр насны хүнд тухайн насны хүмүүсийн онцлог хэрэгцээ шаардлагыг харгалзан, нэр төрийг нь хүндэтгэж, хүнлэг энэрэнгүй хандана. эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд гэр бүлтэйгээ харилцаатай байх, уулзах боломжоор хангах;
- Эрх чөлөөгөө хасуулсан өсвөр насны хүнийг насанд хүрэгчдээс тусад нь цагдан хорино;
- Эрх чөлөөгөө хасуулсан өсвөр насны хүнийг гэр бүлтэйгээ харилцаатай байлгаж, уулзах боломжоор хангах бөгөөд тэдэнд хууль эрх зүйн туслалцаа авах боломжийг нэн даруй олгоно. Тэдний эрх чөлөөгөө хасуулсан нь хуулийн үндэслэлтэй эсэхийг шүүх буюу эрх бүхий хараат бус, аль нэг талын эрх ашигт үйлчлэхгүй байгууллагаар тогтоолгох, шуурхай шийдвэрлүүлэх эрхтэй.

Баривчлах, цагдан хорихтой холбоотой дотоодын хууль тогтоомж

Гэмт хэргийг мөрдөн шалгаж байх явцад сэжигтэн этгээдийг баривчлах, хорих тухай дотоодын хууль тогтоомжийн заалт нь хүн худалдаалах гэмт хэрэгт ч мөн адил үйлчилнэ. Аливаа гэмт хэрэгт холбогдуулан хэв журам сахиулах шалгалт хийх зэрэг нь хүн худалдаалах гэмт хэрэгт ч ялгаагүй нөлөөлнө. Учир нь хүн худалдаалах гэмт хэрэгт тусгайлан гаргасан дүрэм журам байхгүй тул бусад гэмт хэрэгтэй адил байдлаар хуулийг мөрдөж ажиллана.

Сэжигтнийг баривчлах, түр цагдан хорихтой холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан сэжигтнийг шалгахдаа дотоодын хууль тогтоомжтой нийцүүлж ажиллах шаардлагатайг суралцагчдад хэлнэ үү. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хүүхдийг шалгахдаа насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдохтой холбоотой хууль тогтоомжийн талаар товч дурдана. Ингэхдээ тухайн хуулийг нэг бүрчлэн дэлгэрэнгүй ярих шаардлагагүй харин холбогдох хэсгүүдийг л дурдаж ярина уу. Сургагч багш тухайн зүйл заалтыг дээр дурдсан дэд сэдвүүдийг ярилцаж байх үед ашиглана.

Дээрх сэдвүүдийн хүрээнд ярилцаж байх үед суралцагчдаар дараах зүйлийг хийлгүүлнэ үү.

- *Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан чөлөөлөх, баривчлах ажиллагаа зохион байгуулах үед тулгарч байсан бэрхшээлүүдээсээ хуваалцах.*
- *Тэдгээр бэрхшээлүүдээ хэрхэн шийдвэрлэж байсан тухайгаа бусадтайгаа хуваалцах.*

Өсвөр насны хүнийг баривчлах, цагдан хорихтой холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СЭДЭВ 2: ХЭРГИЙН ГАЗАРТ ҮЗЛЭГ ХИЙХ, НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ, БЭХЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ НЬ

1. Хэргийн газрын үзлэг хийх (“С” – Гэмт хэргийн газрын менежмент)

Хэргийн газрын үзлэгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу чанартай явуулах нь хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт олж авахад олон талын ач холбогдолтой. Хүн худалдаалах гэмт хэрэгт ганцхан хэргийн газар байдаггүй. Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг чөлөөлөх ажиллагаа явагдсан газраар хязгаарлаж болохгүй бөгөөд гэмт хэрэг үйлдэж эхэлсэн газар буюу эх үүсвэрийн газар – дамжин өнгөрсөн, тээвэрлэсэн газар, – гэмт хэрэг үйлдэгдсэн төгссөн газар буюу эцсийн зогсоол зэрэг гэмт хэрэг үйлдэгддэг бүх маршрутыг хамруулах нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгахад гэмт хэргийн газар нь дараах байдлаар тодорхойлогдож болно. Үүнд:

- Эх үүсвэрийн газар – Төрөл бүрийн сэдлээр хохирогчийг элсүүлсэн газар.
- Дамжин өнгөрөх зам – Шөнө хоноглох газар зэргийг оруулаад хохирогчийг тээвэрлэждэг маршрут.
- Эцсийн зогсоол - Хохирогчийг аваачиж мөлжих эцсийн зогсоол бөгөөд гэмт хэрэг үйлддэг гол газар. Ихэнх тохиолдолд чөлөөлөх ажиллагаа энд явагддаг. Тухайлбал:
  - Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үед эцсийн зогсоол нь биеэ үнэлэх газар, орон сууц, массажны газар/гоо сайхны газар, зочид буудал, клубийн барилга байшин, нөхөрлөл холбооны клубүүд, айлын гэр, хамгаалах үйлчилгээний газрууд байж болно.
  - Албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн үед үйлдвэрийн газар, үйлдвэрлэл

үйлчилгээ явуулдаг газар, хөдөө аж ахуйн ферм, айлын гэр, зуучлах агентлагууд гэх мэт газрууд байж болно.

» Хохирогч болон гэмт этгээдүүдийг зөөвөрлөж, тээвэрлэсэн, дамжуулсан тээврийн хэрэгсэл.
» Хохирогчийг оролцуулан садар самуун дүрс бичлэг хийж байсан газрууд.
» Гэмт хэрэг үйлдэхдээ iPod, iPad, CD, DVD, үзгэн флаш, камер, гар утас болон үүнтэй төстэй бусад дижитал техник хэрэгслүүд эсвэл компьютер ашигласан тохиолдолд эсвэл сэжигтэн этгээдийн эзэмшилд дээрх зүйл байгаа, гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байсан тохиолдолд тэдгээрийг хэргийн газар гэж үзнэ.

Хэргийн газрын үзлэгийн менежмент

Гэмт хэргийн газарт ажиллах хатуу дүрэм журам, тогтсон цаг хугацаа тавих боломжгүй байдаг. Гэмт хэргийн шинж чанар (юу, яаж?), үйлдэгдсэн цаг хугацаа (хэзээ?), үйлдэгдсэн газар (хаана?), гэмт хэргийн газарт байгаа хохирогч, гэрч, гэмт этгээдүүдийн тоо (хэн?), гэмт хэргийн талаарх мэдээлэл хэзээ ирж, тодорхой болсон зэргээс ихэвчлэн хамаарч байдаг. Ерөнхий зарчмаа мөрдөж ажиллахаас гадна гэмт хэргийн газар анхлан очсон мөрдөгч өөрийнхөө үзэл бодол, итгэл үнэмшлээр мөрдөн шалгах ажиллагаанд нэмэр болж, гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд ямар байдлаар хэргийн газрыг хамгаалах хэрэгтэй вэ гэдгээ шийдвэрлэнэ.

» Чөлөөлөх ажиллагааны үед гэмт хэргийн газрын менежмент хийж, гэмт этгээдүүдийг баривчлахад дараах асуудалд анхаарлаа хандуулна уу. Үүнд:
» Гэмт хэргийн газрын жагсаалтыг гаргах.
» Гэмт хэргийн газрыг хамгаалах
» Тухайн байршил руу нэвтрэх орц тодорхой болмогц, тухайн газрыг гэмт хэргийн газарт тооцож эхэлнэ.
» Гэмт хэргийн газрыг нэн даруй хяналтдаа ав, тэгвэл нотлох баримт устах, үгүй болгохоос сэргийлж чадна.
» Хохирогчийг олж тогтоон, аюулгүй газар аваачсаны дараа, мөн гэмт этгээдийг хяналтдаа авсны дараа гэмт хэргийн газрыг хамгаалалтад авч, зөвшөөрөгдсөн албаны хүмүүс л тухайн газарт нэвтрэх эрхтэйг анхаарах.
» Хэргийн газарт үзлэг хийх.
» Үзлэг хийх төлөвлөгөө гаргах.
» Үзлэг эхлэхээс өмнө гэмт хэргийн газрын зургийг авч, дүрс бичлэг хийх.
» Зурагчин/бичлэг хийх хүнд хэрхэн ажиллах талаах товч мэдээлэл өгнө. Гэмт хэргийн газрын бүхий л хэсгийг баримтжуулж авахын тулд хэд хэдэн зураг авах, бичлэг хийх хүн авч явах.
» Гэмт хэргийн газрын бичлэгийг хийж байхдаа гэрчүүдийн хэд хэдэн зургийг дарах.
» Дараагийн зүйлсийг багтааж, гэмт хэргийн газрын дотоод байршлыг тоймлон гаргах төлөвлөгөө гаргахад бэлтгэх. Үүнд:
    » Гэмт хэргийн газрын хамрах талбай (хэмжээ).
    » Орц, гарц, бусад газруудыг тэмдэглэх.
    » Байгууламжийн үл хөдлөх цэгийн байршил, тэдгээрийн хэмжээ, хоорондын зай.
    » Нотлох баримтын байршил, овор хэмжээ, тэдгээрийн хоорондын зай.
    » Өрөө болон хаалттай бусад хэсгүүдийг дээрээс харсан байдлаар тоймлон үзүүлж болно.
    » Бүдүүвч зурагт тохирох товчилсон үгс, тоо зэргийг ашиглана.

    - Эд зүйлсийн хоорондын зайг хамгийн ойр орших, хөдөлгөөнгүй бэхлэгдсэн болон перпендикуляр байрлалд байх хоёр зүйлийг хэмжих байдлаар гаргана.
    - Бүдүүвч зурагт хойд зүгийг ямагт тэмдэглэнэ.
    - Гэрчийн гарын үсгийг авна.
- Тойм зургийг мэргэжлийн хүний тусламжтайгаар нарийвчлан зуруулах хэрэгтэй ч анхны тойм зургийг байнга хадгалж байх шаардлагатай.
- Гэмт хэргийн газрыг хамгаалалтад авсан цагдаагийн албан хаагч нөхцөл байдал нь өөрчлөгдөх боломжтой дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Тухайлбал:
    - Өвөрмөц үнэр
    - Цонх, хаалганы байршил (онгойх, хаагдах)
    - Бэртэж гэмтсэн хүний байдал (байгаа тохиолдолд)
    - Өрөөнүүдэд байгаа гэрэл асаалттай эсвэл унтраалттай байгаа эсэх
    - Зурагт асаалттай эсвэл унтраалттай байсан эсэх; зурагтаар гарч байсан зүйл
    - Компьютер асаалттай эсвэл унтраалттай байсан эсэх
    - Ямар нэгэн вэб хуудсанд нэвтрэн орсон байсан эсэх?

Сэжигтний эрх – Нэгжлэг эхлэхээс өмнө сэжигтэнд дараах зүйлсийг мэдээлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Ямар эрх мэдлийн хүрээнд нэгжлэг явагдаж байгаа.
- Нэгжлэг хийх зөвшөөрлийн дагуу явагдаж байгаа тохиолдолд сэжигтэнд хуулбарыг нь үзүүлэх.
- Сэжигтэн нэгжлэгийн үеэр байлцах эрхтэй талаар.
- Шаардлагатай тохиолдолд нэгжлэгийн үеэр бие даасан, хөндлөнгийн гэрч байлцуулах эрхтэйг нь сануулж, нотлох баримт болгон хурааж авсан эд зүйлийн бүртгэлийн хуулбарыг авах.

САНАМЖ:

Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах эцсийн зорилго нь эх үүсвэрийн газар-дамжин өнгөрөх газар- эцсийн зогсоол зэрэг өргөн хүрээг хамарсан гэмт хэргийн газруудаас хэргийн бүрэлдэхүүн хэсгүүдийг олж тогтоох явдал юм. Эдгээр гэмт хэргийн сүлжээний хэсэг бүрд хүрч, нотлох баримт цуглуулах нь чухал юм.

2. Нотлох баримт цуглуулах (“E” – Нотлох баримтыг хурааж авах)

Нотлох баримт цуглуулах ажлыг хэргийн газарт эхний байдлаар үзлэг хийсний дараа эхлүүлэх бөгөөд үүнд эд зүйлс, объект зэрэг бүх зүйлсийг олж тогтоох ажил багтана.

- Ямар нэг ажил эхлүүлэхээсээ өмнө хэргийн газрыг бичлэгт буулгаж хадгална.
- Эхний байдлаар шалгасныхаа дараа хэргийн шинж чанар, нөхцөл байдлыг үнэлж, нэгжлэгийн стратегийг тодорхойлно.
- Хэргийн газраас олдсон нотлох баримтууд өөр бусад газраас нэмэлт нотлох баримт олж авах сэжүүрийг гаргаж болно гэдгийг санах хэрэгтэй.

Юуг нотлох баримт гэж үзэх вэ?

Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго нь мөлжлөг үйлдэхэд оршиж байдаг тул гэмт хэргийн газарт байгаа хохирогчийн бие махбод, бэлгийн, сэтгэл зүйн болон санхүүгийн мөлжлөг үйлдэж байсныг илэрхийлэх бүх нотлох баримтыг олж авах нь зүйтэй.

Эд мөрийн баримт/эд зүйлс – Бэлгийн мөлжлөг үйлдэгдсэн үед – амьдарч байсан нөхцөл байдал, хохирогчийг нуун далдалж байсан газар, хувцас, алчуур, матраас, цагаан хэрэглэл, зэвсэг, зураг, альбом, видео бичлэг, мэдээллийн хэрэгсэлд оруулсан зар сурталчилгаа, хохирогчдыг тээвэрлэдэг байсан тээврийн хэрэгсэл гэх мэт.

Албадан хөдөлмөр эрхлүүлж байсан үед – Ажлаа явуулах багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийн материал, тухайн хүний хувийн эд зүйлс болох хувцас, алчуур, матраас, цагаан хэрэглэл, ажиллаж байсан газрынх нь нөхцөл, цалин хөлс авч байсан талаарх мэдээлэл, бүртгэл, ажлын хуваарь, ажил олгогч хүмүүстэй хийсэн гэрээ, төлбөр төлсөн баримт, хохирогчдыг тээвэрлэдэг байсан тээврийн хэрэгсэл гэх мэт.

Бэлгийн хүчирхийллийн баримт – Бэлгийн мөлжлөгийн үед болон албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн үед бэлгийн хүчирхийлэл, бусад хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд:

- Биологийн нотолгоо – хүний биеийн шингэн (цус, үрийн шингэн, үтрээнээс ялгарах шингэн, шүлс эсвэл шээс);
  - Бусад эд эс (арьсны эс, булчин, яс, шүд, үс, хумс, хурууны хээ г.м);
  - Бэртэл гэмтэл, түлэнхийн сорви, цохиж зодсоноос үүссэн гэмтэл г. м.
- Бэлгэвч, бэлэг эрхтний тос, чийгшүүлэгч, чичирхийл өгөгч хэрэглэл, Виагра зэрэг эм бэлдмэл, зүү, тариур, садар самуун сэтгүүл/зураг, гав, бүс г.м.

Сэтгэл зүйн нотлох баримт

(1) Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, зодох, хүнд хэлбэрийн хүчирхийлэл, гэмт этгээдүүд хяналтдаа байлгадаг байсан, өдөрт үйлчилдэг үйлчлүүлэгчийн тоо, жирэмслэлт, үр хөндөлт, айлын гэр болон аливаа газарт ажилладаг байсан цаг хугацаа зэргийн талаар хохирогч/гэрчийн цагдаа, шүүхэд өгсөн мэдүүлэг нь нотлох баримтын гол эх сурвалж болж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тус болдог.

(2) Сэжигтнийг хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэлд хамааралтайг илтгэх тухайн этгээдийн мэдүүлэг дэх мэдээлэл.

(3) Гэрчийн мэдүүлэг – хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн өөрийнх нь болон гэрчээр дуудагдсан хүмүүсийн гэрчилсэн мэдүүлэг.

Санхүүгийн нотлох баримт – Холбогдох бичиг баримт (бүх хэлбэрийн хүн худалдаалах гэмт хэрэг) – Түрээсийн гэрээ, түрээсийн төлбөрийн баримт, байшин, орон сууцны татвар төлсөн баримт, паспорт, цахилгаан/утас/ус/гар утасны төлбөр, утасны дугаарууд бичсэн дэвтэр, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн бүртгэлийн бичиг баримт, даатгалын бичиг баримт, шатахуун худалдан авсан баримт, машины зогсоолын баримт, хөрөнгө оруулсан зүйл, бэлэн мөнгө, зээлийн карт, банкны чек, өдрийн тэмдэглэл, тэмдэглэлийн дэвтэр, банкны дэвтэр, ажлын газрын бүртгэл болон ажлын хуваарь, тараах материал, аяллын бичиг баримт, газрын зураг, автобус/галт тэрэг/онгоцны билет, аялал жуулчлалын агентлагаар зорчих карт, аяллын операторууд болон бусад зүйлс.

Дижитал нотлох баримт – Чөлөөлөх ажиллагаа явагдсаны дараа мөрдөн шалгах ажиллагааны үед дараах эд зүйлсийг дижитал нотлох баримт болгон хураан авч болно.

- Дүрс болон дуу бичлэгийн материал/кино;
- Компьютер, компьютерийн гар, компьютерийн хулгана, диск, санах ойн карт, зөөврийн флаш, зөөврийн хатуу диск, шилжүүлэгч, модем, CD, DVD;

- Компьютерт холбож болох бусад төхөөрөмжүүд;
- Бичиг цаас болон наалддаг цаас (нууц үгийг ихэвчлэн ойрхон бичиж, тэмдэглэсэн байдаг);
- iPad, iPod, камер, "hard disc"-ийн бусад хэрэгслүүд, гар утас.
- Дижитал камер, зургийн аппарат, зургийн хальс, нэг удаагийн зургийн аппарат;
- Жижиг халаасны хэмжээтэй тэмдэглэлийн дэвтэр;
- Факсын машин;
- Утасны дуудлагыг бичиж авсан хальснууд;
- Хэвлэсэн и-мэйл, онлайнаар хийсэн банкны гүйлгээ, цахим зар сурталчилгааны материал, ширээний компьютер, зөөврийн компьютер болон бусад зөөврийн хэрэгсэл;
- Утсан дээр хадгалсан утасны жагсаалт, гар болон суурин утаснаас залгасан хүлээж авсан дуудлага;
- Сэжигтний утас, компьютер зэрэгт нээлттэй орхисон Whatsapp дах харилцан яриа, Facebook хуудас, бусад нийгмийн сүлжээний орчин, аппликэйшнууд.

Компьютер, мэдээллийн технологийн (МТ) хэрэгслүүдийг хурааж авах - Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд интернет, гар утас болон бусад МТ-ийн хэрэгслүүдийг түлхүү ашиглах болсон нь дээрх эх сурвалжаас нотлох баримтыг зохих журмын дагуу авч, түүний үнэн зөв, баримттай байлгахад анхаарах шаардлагатайг харуулж байна. Гэмт этгээдүүдийн гэмт хэрэг үйлдэх, ялангуяа бэлгийн мөлжлөг үйлдэх шинэ арга барил аажмаар цахим, интернет, гар утас вэбсайт, олон нийтийн сүлжээ, Whatsapp зэрэг аппликэйшн руу шилжиж, садар самуун үйлчилгээ, биеэ үнэлэх, бусдыг уруу татах, өдөөх, энэ төрлийн үйлчилгээг авах, санхүүгийн гүйлгээ хийх зэрэг олон үйлчилгээг санал болгож байна. Онлайн сүлжээ ашиглан эзэн холбогдогч нь тодорхойгүй байдлаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж байгаа нь мөрдөн шалгах, нотлох баримт цуглуулах ажлыг илүү хүндрэл бэрхшээлтэй болгож байдаг.

Тийм учраас чөлөөлөх ажиллагаа бүрд зохих дүрэм, журмын дагуу гэмт хэргийн газраас бүх төрлийн дижитал зүйлсийг хурааж авах нь чухал ач холбогдолтой байдаг. Хүн худалдаалдаг гэмт хэрэгтний цахим сүлжээг ашиглаж байгаа мэдээллийг урьдчилж авсан бол гэмт хэргийн газраас тухайн техник хэрэгслийг хэрхэн салгаж, авч явах талаар туршлагатай МТ-ийн мэргэжилтнийг байлцуулахыг зөвлөдөг. Чөлөөлөх болон баривчилгааны ажиллагааны үеэр техникийн туслалцаа авах боломжгүй тохиолдолд, дараах зүйлсийг анхааран ажиллах шаардлагатай. Үүнд:

- Гэмт хэргийн газар нэвтрэн ормогцоо тухайн газрыг нэн даруй хяналтдаа авч, хэн нэгэн хүн МТ-ийн техник хэрэгсэлд хүрэхээс сэргийлэх.
- МТ-ийн ямар нэг техник хэрэгслийг унтрааж болохгүй.
- МТ-ийн ямар нэг техник хэрэгсэл, компьютерийн дэлгэц дээр гарч байгаа дүрсийг баримтжуулж авах. Ингэхдээ тухайн техник хэрэгслийн ар талаас нь зураг эсвэл бичлэг хийж авах бөгөөд ингэснээр тухайн хэрэгслийг холбосон утас, оролт гаралт, шилжүүлэгч зэргийг мэргэжлийн хүнээр дахин холбуулах боломжтой болно.
- Шүүх шинжилгээнд зориулж тухайн техник хэрэгслээс хурууны хээ авч болох бөгөөд ингэснээр тухайн мэдээллийн эзэн холбогдогчийг нь олж тогтооход хэрэг болдог.

МТ-ийн аливаа хэрэгслээс олдсон нотлох баримтыг ашиглах үед сэжигтэн этгээд уг зүйлийг өөрийнх нь биш гэж ихэнхдээ мэлздэг. Тийм учраас аль хүн ямар техник хэрэгслийг эзэмшдэг, бусад эд зүйлсийн яг хаанаас нь олдсон, хэний эзэмшлийнх вэ гэдгийг сайтар бүртгэж авах нь чухал байдаг.

Компьютерийг хурааж авах – Чөлөөлөх баг гэмт хэргийн газар байгаа компьютерийг хурааж авах шаардлагатай тохиолдолд дараах зүйлсийг мөрдөж ажиллана уу.

- Хэзээ ч компьютерийг шинээр ачаалж болохгүй.
- Сэжигтэн болон бусад этгээдийн хэнийг ч компьютерт гар хүргэж болохгүй.
- Компьютер хэрхэн холбогдож байгааг харуулсан ерөнхий тойм зураг зурах эсвэл зургийг нь аппаратаар авах.
- Компьютер асаалттай байгаа бол дэлгэц дээр юу гарч байгааг баримтжуулж авах.
- Компьютерийн дэлгэц асаалттай биш бол компьютерийн хулганыг хөдөлгөж, дэлгэцэн дээр юу байгааг харж доор дурдагдах байдлаар цааш үргэлжлүүлнэ. Хэрэв дэлгэц асвал дэлгэцэн дээр нь юу байгааг дээр дурдсан ёсоор баримтжуулж авах.
- Хэрэв компьютер асаалттай байгаа бол компьютерээс цахилгаан тэжээлийн залгуурыг нь салгана. Хананд байх залгуурыг салгахгүй.
- Компьютер унтраалттай байсан бол унтраалттай чигээр нь үлдээнэ.
- Компьютерт гаднаас нь ямар байдлаар тохиргоо хийснийг баримтжуулж авах (компьютерийн хэсгүүд, кабелд тэмдэглэгээ хийх).
- Компьютер утас/модем эсвэл ямар нэг сүлжээнд холбогдсон эсэхийг баримтжуулж авах.

3. Нотлох баримтыг цуглуулах, хадгалах

Нотлох баримтыг устгах, гэмтээхгүй байх

- Хэргийн газрыг хамгаалалтад авах ажиллагаа хэргийн газарт цагдаагийн албан хаагч ирснээр эхэлнэ.
- Гэмт хэргийн газар болон нотлох баримтыг байгалийн (бороо, салхи), хүний болон амьтны хүчин зүйлээс шалтгаалан бохирдуулж, гэмтээхгүй байх шаардлагатай.
- Гэмт хэргийн газарт баримтжуулах бичлэг хийгдээгүй байгаа цагт юунд ч хүрч, хөдөлгөж, юун дээр ч гишгэж болохгүй.
- Ажиглагдсан бүх зүйлээ тэмдэглэж авах ёстой. Тэмдэглэл товч тодорхой байх шаардлагатай ч хэрэгтэй гэсэн бүх мэдээллийг агуулж байх ёстой. Энэхүү тэмдэглэл гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг нэгтгэхэд эсвэл шүүх хурлаас өмнө гэрчид аливаа зүйлийг санах шаардлагатай үед ашиглагдаж болно.
- Тэмдэглэл хийж, зураг авах болон бичлэг хийгдээгүй байгаа үед эд зүйлст хүрэх, байрлалыг солих зэрэг үйлдэл хийхийг хориглоно.
- Нотлох баримтыг ашиглах, сэргээх боломжгүй байдалд хүргэх, аливаа шаардлагагүй үйлдэл гаргахаас болгоомжлох.
- Гэмт хэргийн газарт ажиллаж байхдаа цэвэрхэн нэг удаагийн хэрэглэл, тоног төхөөрөмж ашиглах
- Гэмт хэргийн газрыг боломжтой үе гармагц баримтжуулах ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Ингэхдээ аль болох дүрс бичлэгээр баримтжуулахыг хичээх хэрэгтэй ч, тийм боломжгүй тохиолдолд гэрэл зургийн аппарат ашиглаж болно. Баримтжуулж авсан зураг, бичлэгээ гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх баримт болгон хавтаст хэрэгт хавсаргаж болно.
- Нэгжлэгийг хаана ч явуулж байсан (сэжигтний гэр гэмт хэргийн газар биш байсан ч) тухайн газраас олдох магадлалтай нотлох баримтыг устгах, гэмтээхээс урьдчилан сэргийлж, уг газрыг хамгаалалтдаа авах нь чухал. Ажиллагаанд хамааралтай, эрх бүхий хүн л тухайн газарт нэвтрэх бөгөөд гэмт хэргийн газрыг хамгаалалтад авах, нотлох баримтыг гэмтээхгүй байх дүрэм журмыг дагаж ажиллана.

Нотлох баримт устахаас хамгаалах нь[33]

» Нотлох баримт устахаас сэргийлсэн арга хэмжээг боломжтой цаг тухай бүрд авах. Нотлох баримтыг шүүх болон шүүх шинжилгээний лабораторид анхны байдлаар нь хүргэх ёстой.

Ингэхийн тулд дараах зөвлөмжийг мөрдөж ажиллах шаардлагатай. Үүнд:

» Нотлох баримтыг устгахгүй байх үүднээс тэдгээрийг цуглуулах, тэдэнтэй харьцах үедээ бээлий өмсөх.

» Гэмт хэргийн газрын өөр хэсэгт хуваарьтай ажиллаж байгаа эсвэл сэжигтэн, хохирогч нарыг хариуцаж байгаа албан хаагчийг өөр хэсэгт очихыг зөвшөөрөхгүй байх. Энэ нь гэмт хэргийн газрыг хөндлөнгөөс хамгаалах зорилготой.

» Нойтон/чийгтэй эд зүйлс (хувцас, орны цагаан хэрэглэл зэрэг хүний биеийн шингэнийг агуулсан зүйлс)-ийг нарны гэрэлд гаргалгүйгээр өрөөний температурт хатаах шаардлагатай. Энэ төрлийн зүйлсийг гялгар уутанд хийж болохгүй (урвал явагдах эрсдэлтэй) мөн эвхэж болохгүй (тухайн эд зүйл өөр зүйлтэй холилдох, нэгдэх эрсдэлтэй).

» Бүх зүйлийг эвхэж боолгүй, сул байдалтай орхино. Тус тусад нь цэвэр цаасанд боох эсвэл цэвэрхэн цаасан уутанд хийж болно.

» Шингэнийг хамгаалалттай саванд авах бөгөөд түүнийгээ сайтар таглаж (гоожихоос сэргийлнэ), мэргэжлийн шинжээчид нэн даруй шилжүүлж өгнө. Шүүх шинжилгээний шинжээч ирсэн байгаа тохиолдолд нотлох баримтыг шинжээчид тэр даруй хүлээлгэж өгнө. Мөрдөгчид дангаараа ажиллаж байгаа тохиолдолд тухайн нотлох баримтыг шүүх шинжилгээний дүрэм журмын дагуу хадгалах нь нэн чухал. Тухайлбал хүний биеийн шингэнийг бохирдуулах, муутгахаас сэргийлж хөргүүрт хадгална.

» Бичиг баримтыг дугтуйнд хийж, дотор нь юу байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тухайн бичиг баримт дээр ямар нэг бичилт, тэмдэглэгээ хийж болохгүй мөн эвхэж нугалж болохгүй.

Гадаадын улсын иргэн хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдсон эсвэл мөрдөн шалгах ажиллагааны тодорхой ажиллагаа гадаад оронд явагдах шаардлагатай байгаа тохиолдолд хэрхэн ажиллах талаар Модуль 6 – "Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад байгууллагуудын хамтын ажиллагаа"–д тодорхой өгүүлсэн.

33 ИНТЕРПОЛ-ын Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсгээс гаргасан Мөрдөн байцаагчдад зориулсан хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх гарын авлага; 2003

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дасгал ажил 8 (1) *– Суралцагчдыг бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн газраас олж авах боломжтой, нотлох баримт болохуйц эд зүйлсийн жагсаалтыг гаргах, нэрлүүлэх дасгал ажиллуулж болно.*

Сургагч багш суралцагчдыг багт хувааж, өөр өөр чиглэлийн нотлох баримт олуулах даалгавар өгч болно. Үүнд бие махбод, бичиг баримт, цахим, гэмт этгээдийн мэдүүлэг, бусад зэрэг байдлаар хуваах боломжтой. Баг бүр ямар нотлох баримт олж болохоо ханын цаасан дээр жагсааж бичнэ.

Багууд дасгалаа ажиллаж дууссаны дараа сургагч багш доор дурдсан мэдээллийг өгч, багуудын гаргасан жагсаалтаас дутуу зүйл байвал нэмж хэлнэ.

ЭСВЭЛ

Дасгал ажил 8 (2) *– Энэ модулийг зааж байхдаа цагийн баримжаа, өрөөний боломж, хэрэглэгдэх зүйлс зэрэгтээ үндэслэн, Модуль 2-ын дасгалыг ашиглан хүн худалдаалах гэмт хэргийн газрыг ангид бүрдүүлж болно. Дараах ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар суралцагчдаар дүрд тоглож үзүүлнэ.*

- *Гэмт хэргийн газрыг хамгаалах*
- *Гэмт этгээдийг баривчлах*
- *Хохирогчийг чөлөөлөх*
- *Нотлох баримт цуглуулах*
- *Нотлох баримтыг устахаас сэргийлж, бүрэн бүтэн байдлыг нь хангах*

Баг бүр дүрээ гаргасны дараа сургагч багш энэхүү ажлыг гүйцэтгэхэд "сайн болон муу туршлага" нь юу байж болох талаар суралцагчидтай ярилцана.

СЭДЭВ 3: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СЭЖИГТНИЙ ОНЦЛОГ ШИНЖ

1. ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭГДДЭГ ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ АРГА

Дэлхийн олон оронд хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгаж байх явцад гэмт этгээдүүд баригдахаараа өөрийгөө хамгаалах олон янзын арга хэрэглэдэг. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд доор дурдагдах хамгаалах аргуудыг ихэнхдээ хэрэглэдэг. Мөрдөгч нар энэ талаар мэдлэг, мэдээлэлтэй байх нь илүү сайн бэлтгэлтэй байхад нэмэр болоод зогсохгүй сэжигтнийг байцаах үед ч хэрэг болдог.

Зөвшөөрөл – Хамгийн түрүүнд мөн хамгийн түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь хохирогчийг хүчлээгүй мөн хууран мэхлээгүй гэж хэлэх байдаг. Өмнө нь тохиролцсон ажиллах нөхцөлийн хүрээнд тухайн хүн ажиллаж байсан. Иймэрхүү мэдүүлэгт хүч хэрэглэж, заналхийлсэн шинж тэмдэг харагдахгүй, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг олж тогтооход хүндрэлтэй байдаг. Зөвшөөрлийг нь авсан эсэхтэй холбоотойгоор сэжигтэн дараах зүйлсийг ихэвчлэн хэлдэг. Үүнд:

- Хохирогч тухайн газраас оргож, зугтаагүй;
- Хохирогчийг гав, гинжээр хүлээгүй байсан. Тийм учраас ямар ч гэмт хэрэг үйлдэгдээгүй;
- Хохирогч энэ талаар хэн нэгэнд хэлж огт гомдол гаргаж байгаагүй.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд хохирогч болсон тохиолдолд гэмт этгээдүүд тухайн хүүхдийн эцэг эх/асран хамгаалагч нь "сайн дурааараа" хүүхдээ ажил хийлгэхээр урьдчилан ярилцаж тохиролцсон гэж хэлдэг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2012 оны Хүн худалдаалах гэмт хэргийн тухай хуулийн 3-р бүлэгт хүн худалдаалах гэсэн нэр томьёог хэрхэн тодорхойлсон байдаг, зөвшөөрөл авах гэдэгт юуг хамруулж ойлгох талаар өгүүлсэн талаар суралцагчдад дахин сануулж хэлнэ.

Хохирогчоос зөвшөөрөл авахтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Ойлголцлын зөрүү – Хоёр дах түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь болж өнгөрсөн бүх зүйл нэгнийгээ буруу ойлгож, ойлголцлын зөрүүтэй байснаас боллоо гэсэн тайлбар юм. Сэжигтэн этгээд хохирогчид "туслахыг" л хүсэж байсан "сайн хүн" мэтээр аашилна. Энэхүү үйлдэл нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Хохирогч өөрийн улс олон эсвэл гэртээ байхдаа маш хүнд хэцүү амьдралтай байсан бөгөөд одоо хамаагүй дээр нөхцөл байдалд байгаа;
- Яллагдагч этгээд хохирогчид туслахыг л хүсэж байсан бөгөөд түүнд ажил олж өгч, амьдрах байраар ханган, хийсэн ажлынх нь хөлсийг төлж байсан, түүнд сайхан сэтгэлээр хандаж, тусалдаг байсан;
- Хохирогч болсон хүүхэд эсвэл эцэг эх нь тухайн хүүхдийн насыг үнэн зөвөөр нь хэлээгүй, хуулийн дагуу насанд хүрсэн гэж бодоод ажлаар хангаж байсан.

Итгэл, үнэмшилтэй байдал - Гурав дах түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь үнэн ярьж байгаа хүн нь хохирогч биш, сэжигтэн өөрөө гэж зүтгэх. Хохирогч худлаа ярьж байгаа эсвэл юу ярихаа мэдэхгүй байгаа. Тухайн хохирогч ажил хийнэ гэж өөрөө хүлээн зөвшөөрсөн, гадаад улс оронд өөрөө ирсэн, мөн хууль тогтоомжийг ч зөрчсөн үйлдэл хийсэн. Яллагдагч этгээд хохирогчийн мэдүүлэгт итгэх боломжгүй гэсэн санааг дараах байдлаар илэрхийлдэг. Үүнд:

- Өмнө нь зөрүүтэй мэдүүлэг өгч байсан;
- Мэдүүлэг авч байх үед өөр хоорондоо зөрчилдсөн мэдээлэл өгч байсан;
- Хохирогчийн мэдүүлгийг няцаах биет нотлох баримт гаргаж ирэх;
- Хохирогч худлаа хэлэх шалтгаантай байсан: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид л үзүүлдэг Засгийн газрын тусламж дэмжлэгийг авахыг хүссэн;
- Хохирогч гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь баримт нотолгоотойгоо байгаа учраас түүнд итгэж болохгүй;
- Хохирогч өөрөө гадаад улсын хилийг хууль бусаар нэвтэрч ирсэн бөгөөд яллагдагч этгээдээс ажил олгохыг хүссэн, хохирогчийг өөрийгөө аваад явах орлогын эх үүсвэртэй байлгахын тулд л ажил олгосон.

Ажлын хөлс – Хохирогчийг ажиллуулсныхаа хөлсийг өгч байсан гэж хэлэх нь өөрийгөө

өмгөөлөх дараагийн аргад тооцогддог. Хохирогчид цалин хөлс төлж, байр хоолоор хангаж байсан. Ямар мөлжлөг явагдсан гэж үзэж байгаа юм бэ гэж асуудаг. Үүнийгээ дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

- Хохирогчийн цалин хөлс авч байсан баримт, гарын үсэгтэйгээ;
- Бусад ажиллаж байгаа хүмүүстэй адилхан нөхцөл байдалтай байсныг нотлохоор бүртгэлийн дэвтэрт байгаа гарын үсгийг нь үзүүлэх.

Дээрх байдлаар өөрийгөө хамгаалдаг талаар мөрдөгч урьдчилан мэдэж байх шаардлагатай. Гэмт хэргийн нөхцөл байдал, баримт нотолгооноос хамаарааД өөр өөр байж болох ч яллагдагч этгээд ихэнхдээ л өөрийгөө өмгөөлж, хамгаалахад энэ аргуудаас ашигладаг. Мөрдөгч энэ талаар мэдлэг, мэдээлэлтэй байх нь хохирогч, яллагдагч хоёроос мөрдөн шалгах ажиллагааны үед зөв асуулт асуух цаашлаад гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг нотлох баримт олж авахад чухал байдаг.

2. МӨРДӨГЧИЙН ХИЙХ ХАРИУ АЛХАМ

Хохирогчийг мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдаанд оролцуулах, энэ бүх хугацааны туршид гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэгт орсон хохирогчтой хамтран ажиллах нь маш их ажил байдаг. Айж балмагдсан, яахаа мэдэхээ больсон охид, эмэгтэйчүүд мөрдөн шалгах ажиллагааны явцад цагдаагийн албан хаагч, шүүгч, прокурорт ихэвчлэн буруу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй мэдүүлэг өгдөг учраас шүүх хурлын үед гэрчийн мэдүүлэг, нотлох үе шатанд унах тохиолдол байдаг.

Шүүх хурлаас өмнө яллагдагч өөрийгөө хамгаалсан мэдүүлэг өгөхөд мөрдөгч урьдчилж бэлтгэсэн байдлаар хариулт өгөхдөө дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

- Гэмт хэргийн зарим хэсэгтэй холбогдуулан нэмэлт нотлох баримт олж авах. Жишээлбэл, мөрдөгч гэмт этгээд хохирогчийг элсүүлэх явцдаа хохирогч болон түүний гэр бүлийнхэнд хуурамч амлалт өгч байгааг сонссон гэрчийн мэдүүлгээр дамжуулан хохирогчийг хууран мэхлэгдсэн гэсэн мэдүүлгийг баталгаажуулах .
- Хохирогчоос зөвшөөрлийг нь аваагүй талаар хангалттай нотлох баримт цуглуулах.
- Хохирогчийн зөрүүтэй мэдүүлэгт анхаарлаа хандуулах. Тухайлбал, гэмт этгээд хохирогчийг заналхийлж, хүчирхийлэл дор байлгадаг байсан эсвэл гэр бүлийнхэнд нь ямар нэг хохирол учруулж байсан талаар мөрдөн шалгах ажиллагааны эхэнд цагдаагийн албан хаагчид хэлээгүй бол яагаад энэ тухайгаа үнэнээр нь хэлээгүй талаар олж мэдэх хэрэгтэй. Хохирогчийн хариулт нь эргэлзсэн, айж эмээсэн, цагдаагийн албан хаагч туслахгүй байх гэж бодсон, итгэж болохгүй гэж бодсон гэх мэт байдаг.
- Мөрдөгч хохирогчоос яагаад зугтах боломж байсаар байтал гэмт хэргийн газраас зугтаагүй, эрх бүхий байгууллагад нь мэдэгдээгүй шалтгааны талаар тайлбар авсан байх хэрэгтэй бөгөөд үүнийг яллагдагчийн өөрийгөө хамгаалсан мэдүүлгийн эсрэг ашиглах боломжтой. Хохирогчид дараах байдлаар ихэвчлэн хариулдаг. Өөртөө болон гэр бүлийнхэндээ аюул учруулж эсвэл амь насаа алдах эрсдэлтэй гэж айсан, гэр бүл, амьдардаг тухайн газар нь өөрийнх нь одоогийн нөхцөл байдлын талаар мэдэгдэж, нэр төрийг нь гутаана гэж сүрдүүлэх байх гэж бодсон, гэмт этгээдүүд бичиг баримтыг нь хурааж авсан байх, эсвэл цалин хөлсийг нь өгөхгүй байх, байгаа орондоо хууль бус статустай байх, хүчин төгөлдөр бичиг баримтгүй байх (“ажил” хийх зорилгоор тухайн улс оронд хууль бусаар очсон), шинэ газар хаана хэнд хандаж, тусламж эрэх талаар мэдлэг, мэдээлэлгүй байсан, тухайн орны хэлийг ойлгохгүй, мэдэхгүй байсан зэрэг

олон байдлаар хариулдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтнийг байцаахдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Гэмт хэргийн сүлжээнд сэжигтэн этгээдийн гүйцэтгэх үүрэг нь юу байсныг тодорхойлох;
- Сэдлийг нь төрүүлэх;
- Хохирогчийн өнгөрсөн, одоотой холбож шалгах;
- Гэмт хэргийн газар, эх үүсвэрийн болон дамжин өнгөрүүлэх газар зэргээс баривчлагдсан бусад сэжигтнүүдтэй холбож шалгах;
- Хэд хэдэн хүн оролцсон зохион байгуулалттай гэмт хэргийн шинж чанар гэмт этгээдүүдийн гүйцэтгэж байсан үүрэг, үйлдсэн гэмт хэргийг тодорхой болгож, хүн худалдаалах гэмт хэргээр дамжуулан мөлжлөг үйлдэх зорилгоор гар бие оролцож ажилласан бүх хүнийг шалгана;
- Гэмт хэргийн хохирогч нь гадаад хүн бол гадаадын улс орон руу хэдэн удаа зорчсоныг нь олж тогтоох;
- Яллагдагч этгээд болон гэрч, хохирогчийн мэдүүлгийн үнэн зөв эсэхийг тогтоох;
- Гэмт этгээдүүдийг хохирогч/ажил олгогч/үйлчлүүлэгч нар мэддэг эсвэл огт танихгүй эсэх;
- Боловсрол, эд хөрөнгийг нь шалгах. Гэмт этгээдүүдийг боловсролгүй, эд хөрөнгөгүй, бүдүүлэг хүмүүс байдаг гэж урьдчилан дүгнэхгүй байх шаардлагатай. Эсрэгээрээ тэд өндөр боловсролтой, хууль бусаар нэлээдгүй хөрөнгө хураасан, соёлтой хүмүүс байх боломжтой;
- Сэжигтний онлайн/олон нийтийн сүлжээг ямар байдлаар ашигладаг талаар болон эрхэлж явуулдаг нууц нэрийг нь шалгах;
- Олон нийтийн сүлжээн дэх "холбоо барих хүмүүс", "найзууд" зэрэг хэсгүүдийг нь шалгаж, мэдээлэл олж авах;
- Эцэг эх, ах дүү нар гэх мэтчилэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг олж авах;
- Гэр бүлийн гишүүдээс нь уг гэмт хэрэгт холбоотой хүн байгаа эсэх, худалдаалагдахад нь эхнэр эсвэл нөхөр нь оролцсон эсэх, найз охид, нууц амраг зэрэг хүмүүс холбоотой эсэхийг тодруулах;
- Өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг нь шалгах;
- Эмнэлгийн үзлэгтэй холбоотой бичиг баримтыг нь шалгах (эмчилгээ хийлгэж байсан талаарх баримт);
- Банкны мэдээлэл, данс, өмч хөрөнгө, хувьцаа, тээврийн хэрэгсэл, гар утас, болон бусад эд хөрөнгийг нь шалгаж, мөлжлөгөөс олсон орлого эсэхийг тодруулах санхүүгийн шалгалт хийх.

СЭДЭВ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛ

1. Зохион байгуулалттай гэмт хэргийн үүднээс мөрдөн шалгах нь

Хүн худалдаалах гэмт хэргийн нэг л бүрэлдэхүүн хэсэгт хамаарах олон оролцогчтой гэмт үйлдэлд оногдуулах хуулийн зүйл заалтууд өөр өөр хуульд байж болно. Гэмт хэргийн сүлжээгээр дамжин нэг удаагийн хүн худалдаалах гэмт хэрэгт олон гэмт үйлдэл үйлдэгдсэн байж болох бөгөөд үүнийг мөрдөн шалгаж, ял шийтгэлийг шударгаар оноох хэрэгтэй бөгөөд

хамгийн чухал нь аймаг, хот, улс дамнан үйл ажиллагаагаа явуулдаг гэмт хэргийн сүлжээг таслах явдал юм. Ийм учраас үйлдсэн гэмт хэргүүд, оролцсон гэмт этгээдүүдийн холбоог тогтоож, газарзүйн байршил, санхүүждэг арга замыг нь нарийн шалгасны дараа гэмт хэрэг үйлдэгдэж эхлэх газраас эхлээд дамжин өнгөрүүлэх болон эцсийн зогсоолыг холбосон сүлжээ, үүнд холбоотой ажилладаг бүх гэмт этгээдүүдийг мөрдөн шалгах шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэргийг зохион байгуулалттай хэргийн үүднээс дараах зүйлсийг оролцуулан шалгана. Үүнд:

- Хохирогчийг элсүүлж авдаг эх үүсвэрийн газар, хүн худалдаалдаг маршрут, замдаа буудалладаг газар зэргүүдийн зураглалыг нарийн гаргаж авах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамаарах гэмт үйлдэл үйлдэхэд оролцсон элсүүлэгч, тээвэрлэгч, худалдан авагч, мөлжлөг үйлдэгч нарыг нарийн судлах;
- Гэмт этгээдүүдийн цахим сүлжээг шалгаж, олон нийтийн сүлжээ болон аппликэшнүүдийг нь хариуцаж ажиллуулдаг этгээдүүдийг шалгах;
- Гэмт хэргийн үе шат бүхэнд ашиглагдаж байсан санхүүгийн сүлжээ, ашиг орлого хэрхэн олдог байсан талаар нь шалгах.
- Аймаг орон нутаг хооронд болон улс дамнан үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тархалтыг судлах.
- Гадаадын харьяат гэмт этгээд оролцсон эсэх болон гадаадын улс оронд хүрч байгаа газарзүйн байршлыг нь судлах (боломжтой бол).

2. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд ашиглагдсан эд зүйлд үзлэг хийх, битүүмжлэх, хураан авах

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1-21.5 дугаар зүйлүүдэд хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээг маш нарийн тодорхой заасан байдаг бөгөөд эдгээр зааltыг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, хохирогчийг мөлжиж байсан аливаа газрыг хаахаар зэхэж буй цагдаагийн албан хаагч болгон мөрдөж ажиллах шаардлагатай. Мөлжлөг үйлдэж байсан газрыг хаах нь гэмт этгээд баривчлагдсаныхаа дараа батлан даалтад гарч тухайн газраа эргэн очин, дахин хэн нэгний биеийг үнэлүүлэх, албадан хөдөлмөрлүүлэхгүй байхад чиглэдэг. Мөрдөгч шалгаж байгаа зүйлийнхээ цар хүрээг тэлж, хуулийн хүрээнд яллагдагчийн хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж олж авсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, санхүүгийн сүлжээг сайтар шалгах шаардлагатай байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх замаар олсон хууль бус орлогыг нь хураах нь гэмт хэргийн бүлэглэлийн сүлжээг тасалж, гэмт үйлдлээ үргэлжлүүлэн явуулахыг таслан зогсоох боломжтой болгодог.

МОДУЛЬ - 8



ПРОКУРОРУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү модулийн зорилго нь прокурорыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн тулд мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны явцад хэрхэн оролцох талаар мэдлэг, чадвар олгоход оршино.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог

Сэдэв 2 Хүн худалдаалах гэмт хэргийг яллахад анхаарах асуудал

Сэдэв 3 Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчөөс ял завшуулах зорилгоор хэрэглэгдэг арга, прокурорын хариу арга хэмжээ

Сэдэв 4 Хүн худалдаалах гэмт хэргийн яллагдагчийн мэдүүлгийг үнэлэх, шалгах

Сэдэв 5 Гэрч, хохирогчийг шүүн таслах ажиллагаанд бэлтгэх

Сэдэв 6 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

Сэдэв 7 Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол, хор уршгийг барагдуулах

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хохирогчийн эрх, хэрэгцээ, шаардлагыг хэргийг мөрдөн шалгах үед, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө болон шүүх хурлын үеэр нэмэлт байдлаар хангаж ажиллах бус гэмт хэргийг шийдвэрлэх бүхий л явцад нэн тэргүүнд анхаарч ажиллах нь чухал юм.
- Эрүүгийн хэргийг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой мөрдөгдөж буй бүх хуулийн холбогдох заалтууд хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд мөн адил ашиглагдана. Яллагдагч этгээд мөлжих зорилгоор хүний биеийг үнэлүүлэх, албадан эсвэл боолын хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хэргийг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг бусад хэргийг хэрхэн шийдвэрлэдэгтэй адилаар явуулна.
- Гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татах, мөрдөн шалгах, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулахдаа яллагдагч этгээдийн эрхийг хөндөлгүй явуулдгийн адилаар хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд ч мөн адил дагаж мөрдөнө.
- Прокурор тухайн хохирогч шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэлтэй байгаа эсэх, үүнээс шалтгаалан шүүх хурлыг үл тоомсорлох эсвэл айж эмээж байгаа эсэхэд хамгийн түрүүнд гол анхаарлаа хандуулан ажиллах үүрэгтэй бөгөөд шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих мэдээллийг цаг тухайд нь өгснөөр айж эмээх, болгоомжлох байдлаас нь салгах боломжтой.
- Хүн худалдаалах гэмт хэргийн үед яллагдагчийн өмгөөлөгч үйлчлүүлэгчээ хамгаалах ямар ямар арга хэрэглэхийг бүгдийг нь тааварлах, тооцоолох боломжгүй боловч түгээмэл хэрэглэгддэг аргуудын талаар мэдээлэлтэй байх бүрэн боломжтой.
- Мөрдөгчийн нэгэн адил прокурорууд ч гэрч, хохирогчийг хамгаалах үүрэгтэй бөгөөд цагдаагийн албан хаагч, шүүгчийн дэмжлэгтэйгээр тэднийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод гэмт хэргийн онцлог шинж чанараас шалтгаалан тусгай хэрэгцээ шаардлагатай болдог бөгөөд аюулгүй байдлыг хангах, тэднийг нөхөн сэргээж, нийгэмшүүлэхэд эсвэл эх оронд нь буцаахад онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.
- Ял оногдуулах үндсэн зарчимд үндэслэн прокурор тухайн гэмт хэргийг хэрхэн

шийдвэрлэж болох талаар өөрийн зураглалаа гаргаж, шүүгчдийн анхаарлыг татахаар ил болсон, олж авсан баримтууд ял шийтгэл оноох шийдвэрт хэрхэн нөлөөлж болохыг тооцоолно.

» Нөхөн төлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөлжлөгөөс улбаатай сэтгэл зүйн эмгэгээсээ гарахад шууд нөлөөлөхгүй ч нөхөн сэргэж, эргэн нийгэмшихэд нь ороход нь хохирогчид үүссэн хорсол, цөхрөлийг намжаах нэг боломж нь болж өгдөг төдийгүй ижил төрлийн гэмт хэрэгт дахин өртөх магадлалыг бууруулж, эдийн засгийн хувьд тодорхой хэмжээнд биеэ даасхад нь нэмэр болдог.

Сургалтын хугацаа - 3 цаг (180 минут)

Хичээлийн бэлтгэл

» Сургалтын өрөөг бэлтгэх
» Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн тохиолдол, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх
» Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх.

Модуль 8: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог	Лекц/хэлэлцүүлэг	10	Сэдэв 1
Сэдэв 2	Хүн худалдаалах гэмт хэргийг яллахад анхаарах асуудал	Лекц/хэлэлцүүлэг	20	Сэдэв 2
Сэдэв 3	Яллагдагчийн өмгөөлөгч түгээмэл хэрэглэдэг арга, прокурорын хариу арга хэмжээ	Лекц/хэлэлцүүлэг	15	Сэдэв 3
	Дасгал ажил 9 – Хүн худалдаалах гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны үеэр яллагдагч тал өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэхийг тооцоолж, тохирсон хариу арга ажиллагааг урьдчилан бэлтгэх нь	Багаар ярилцах, дасгал ажиллах	45	Дасгал ажил 9
Сэдэв 4	Хүн худалдаалах гэмт хэргийн яллагдагчийн мэдүүлгийг үнэлэх, шалгах	Лекц/хэлэлцүүлэг	15	Сэдэв 4
Сэдэв 5	Гэрч, хохирогчийг шүүн таслах ажиллагаанд бэлтгэх	Лекц/хэлэлцүүлэг	30	Сэдэв 5
Сэдэв 6	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	Лекц/хэлэлцүүлэг	30	Сэдэв 6
Сэдэв 7	Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол, хор уршгийг барагдуулах	Лекц/хэлэлцүүлэг	15	Сэдэв 7

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ОНЦЛОГ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд (2017) хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад өгөх прокурорын зөвшөөрлийн талаарх зүйл заалтыг сургалтын энэ хэсэгт ашиглана уу. Бусад бүх төрлийн гэмт хэрэгт адилхан ашигладаг учраас сургалтад хамрагдаж буй прокурорууд эдгээр зүйл заалтын талаар гүнзгий мэдлэгтэй байх ёстой. Сургагч багш энэхүү бүлгийн туршид суралцагчдад Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгтэй холбогдох зүйл, заалтын талаар тусгайлан ярина.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад Прокурор дараах зүйлсийг шалгаж тогтоосон эсэхийг анхаарвал зохино. Үүнд:

- Гэмт хэргийн хамтран оролцогч, гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр, гэмт хэрэгт хамаарагсад, зөрчин гүйцэтгэгсдийн талаар анхаарч шалгах.
- Хүн худалдсан болон худалдан авсан этгээдүүд нь хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн, бэлгийн хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгасан, эд эрхтнийг нь авч ашиглах зэрэг ямар санаа зорилгоор гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоох.
- Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хандсан, хүний халдашгүй байдалд хууль бусаар халдаж хүнийг эд бараа мэтээр үнэлсэн байгааг анхаарах.
- Хохирогчийг өөрийн эрхшээлд байлгасан, зорчих эрхийг хязгаарласан эсэхийг тогтоох.
- Хохирогчийг хууран мэхлэхдээ ашигласан бичиг баримт, гэрээ, олон нийтэд тараасан зар мэдээ зэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.6 дугаар зүйлд заасны дагуу хураан авч хэрэгт хавсаргах.
- Хохирогчийг хил давуулан худалдаалсан бол улсын хил нэвтэрсэн талаарх лавлагааг авах.
- Хохирогчийн биед учирсан гэмтлийн зэрэг, хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдаасан эсэх, түүнийг мансууруулсан, согтууруулсан эсэхийг мөн бие махбод, сэтгэцийн болон хүнд өвчинтэй болгосон эсэхийг шинжээч томилж дүгнэлт гаргуулах.
- Насанд хүрээгүй хохирогч байгаа тохиолдолд хүүхдийн төрсөн он, сар, өдрийг иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газраас олгосон төрсний гэрчилгээгээр тогтооно. Хэрэв төрсний гэрчилгээ байхгүй бол шүүх эмнэлгийн дүгнэлтээр насыг тогтоох бөгөөд энэ тохиолдолд насны доод хэмжээг баримтална.
- Насанд хүрээгүй хохирогчийг урьдчилан амлах, хууран мэхлэх, заналхийлэх, хүч хэрэглэсэн зэрэг аль аргаар гэмт хэрэгт оролцуулсан эсэхийг шалгах.
- Насанд хүрээгүй хохирогчийн байнга оршин суудаг хаяг болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг олж тогтоон, тэдгээрийг мөн эсэхийг нотолсон баримт бичгийн хэрэгт хавсаргана.
- Гэмт хэрэг үйлдэгдэх явцад Эрүүгийн хуульд заасан бусад төрлийн гэмт хэргүүд давхар

үйлдэгдэх тохиолдол гардаг учир нийлмэл гэмт хэрэг байгаа эсэхийг шалгаж мөн ойролцоо төрлийн гэмт хэргээс ялгагдах онцлогийг тодорхойлж, давхар зүйлчлэхэд анхаарах.

» Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн холбогдох заалтыг анхаарч шалгах.

Гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээдтэй холбоотой мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлуудтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Түүнчлэн энэ гэмт хэргийн хохирогч хүүхэд байгаа тохиолдолд Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэхийг тодорхойлох, хэрэв мөн бол тухайн хуульд заасан тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

Гэмт хэргийн хохирогч хүүхэд байгаа тохиолдолд эрсдэлийг тодорхойлох, тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр

Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр нь прокурорын бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд хууль зөрчсөн үйл баримтыг арилгах, урьдчилан сэргийлэхэд шийдвэр гаргахад чиглэгддэг. Хүн худалдаалах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн хамгаалах арга хэмжээг тухай бүрд нь авч чаддаггүйгээс гэрч, хохирогч мэдүүлгээсээ буцах, мэдүүлгийн ач холбогдол буурах, нотлох баримтын хүчин чадлаа алдах, гадаад улсад үйлдэгдсэн хэрэгт нотлох баримт цуглуулах боломж хязгаарлагдах гэх мэт хүндрэлтэй асуудлууд гардаг. Иймд прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрийг үйлдэхдээ мөрдөгддөг журам, аргачлал, зааврын дагуу үйлдэх, мэдрэмжтэй байх, мөрдөгчийн саналтай сайтар танилцах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зарим ажиллагаанд зөвшөөрөл өгөхдөө санаачилгатай байх зэрэг тодорхой ур чадварыг шаарддаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж, тухайн хэрэгт яллагдагчаар татах тогтоол баталсан, бусад яллах дүгнэлт үйлдсэн прокурор анхан шатны шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцдог боловч эрүүгийн хэрэгт хяналт тавьсан прокурорууд тодорхой шалтгаанаар өөрчлөгддөг, энэ нь хэргийн шийдвэрлэлт, хугацаанд нөлөөлдөг. Хүн худалдаалах гэмт хэргийн тухайд энэ хэрэгт хяналт тавьж байгаа прокурор шүүхийн шатаар эцэслэн шийдвэрлэгдтэл оролцож байх нь ач холбогдолтой.

СЭДЭВ 2: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

Мөрдөн шалгах ажиллагааны явцад болон дуусах үед прокурор нь гэмт үйлдлийг нотлох ач холбогдол бүхий баримт сэлт, гэмт хэргийн зүйлчлэл үнэн зөв хийгдсэн эсэхийг сайтар хянах бөгөөд бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэрэг болон бусдын биеийг үнэлүүлэхтэй холбоотой

зөрчлийн шинж байгаа эсэхийг хянан үзнэ. 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх шатанд эрүүгийн хэрэгт оролцогч талууд тэгш эрхтэй оролцох зарчимтай.

Тухайн хүн, хуулийн этгээдийг яллагдагчаар татсан гэмт хэргийн зүйлчлэл, оногдуулж болох эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ нь хэрэгт авагдсан нотлох баримтаар хангалттай тогтоогдсон эсэхийг прокурор анхааран үзнэ. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчилж чадахгүй байх, ял завшуулах нөхцөл үүсэж болзошгүй учраас мөрдөгчийн мөрдөн шалгах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл ач холбогдол багатай нотлох баримтаас авхуулаад цаашид дам нотлох баримт мэдээллийг логик холбоотой цуглуулах, бэхжүүлэхэд мөрдөгчийг чиглүүлэх хэрэгтэй байдаг.

2015 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн хүнийг нотлох баримтаар үндэслэн яллагдагчаар татахдаа тухайн этгээдийн гэмт хэрэг үйлдсэн хугацаа, газар, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг тогтоосон эсэхийг хянах ёстой. Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, заалт, хэсэгт зааснаар яллагдагч нэг буюу түүнээс олон гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд түүнийг Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалт, хэсэг бүрээр нэг буюу хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах, хэд хэдэн таслан шийдвэрлэх тогтоолоор ял оногдуулах боломжийг харгалзан үзнэ.

1. ЯЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗҮЙЛ

1.1. Хохирогчийг гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгаж харьцахгүй байх – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирсны улмаас үйлдсэн гэмт хэргийн шинжтэй зарим үйлдэлд буруутгагдахгүй байх, энэ байдлаар буруутгаж харьцахгүй байх талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ мөрдөгддөг. Тухайлбал, биеэ үнэлэх, хууль бусаар хил нэвтрэх, хууль бусаар ажил хөдөлмөр эрхлэх гэх зэрэг үйлдэлдээ буруутгагдах ёсгүй. Энэхүү гэмт хэрэгт хүүхэд өртөж, хохирогч болсон тохиолдолд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол улсын 2016 онд батлагдсан Хүүхэд хамгаалллын тухай хууль, 2016 оны Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу тэдний эрхийг хамгаалж, гэрч хохирогчийг хамгаалах талаар хуульд заасан зохицуулалтын дагуу аюулгүй байдлыг ханган ажиллахад анхаарлаа хандуулах ёстой.

2002 онд батлагдсан "НҮБ-ын Хүний эрх, хүн худалдаалах гэмт хэрэгт баримтлах зарчим, зөвлөмж"-ийн дагуу гэмт хэргийн хохирогч дараах үйлдлийнхээ төлөө буруутгагдахгүй байх талаар тусгасан байдаг. Үүнд:

- Дамжин өнгөрсөн болон эцсийн цэгт хүрэх зорилгоор аль нэг улс оронд хууль бусаар нэвтэрсэн.
- Дамжин өнгөрсөн болон эцсийн цэг болох улс оронд хууль бусаар оршин сууж байсан.
- Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас аливаа хууль бус үйлдэлд холбогдож байсан.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд гадаад болон дотоодын хохирогч ямар статустай байхтай холбогдох зүйл заалтыг сургалтын энэ хэсэгт ашиглана уу. Мөн хохирогч хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөний улмаас үйлдсэн хууль бус үйлдэлдээ аливаа ял шийтгэл хүлээхгүй байхтай холбоотой хуулийн зүйл заалтын талаар суралцагчдад мэдээлэл өгнө.

1.2. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах – Энэ төрлийн гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурор гэмт хэргийн нотлох үйл баримт, факт, тэдгээрийн шалтгаант холбоо зэргийг тодорхойлж, цугларсан нотлох баримтыг үнэлэх үүрэгтэй. Тухайн гэмт хэргийн шинжийн нэг хэсгийг нотлох баримт хангалттай биш байна гэж прокурор үзвэл нотлох баримт нэмж цуглуулах, таслан сэргийлэх арга хэмжээ авах, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зэрэг шаардлагатай ажиллагаа хийлгэхээр яллагдагчаар татах саналыг буцаах эрхтэй.

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Хохирогч нь 18 насанд хүрсэн хүн байгаа тохиолдолд 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу энэ гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг ямар үйл баримтаар нотлохыг анхаарах. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн нийтлэг болон тусгай онцлох шинжийг илэрхийлэх, дамжмал байдлаар нотлох баримт, сэлтийг цуглуулах, бэхжүүлэхэд зөвшөөрөл өгөх, тогтоол үйлдэх, даалгавар бичихдээ анхаарах.
- Хохирогч нь 18 насанд хүрээгүй хүн буюу хүүхэд байгаа тохиолдолд хуульд зааснаар энэ гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг нотлох үйл баримтыг бэхжүүлэх, үнэлэх. Тухайлбал Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан тайлбарын дагуу хүүхдийн тухайд энэ гэмт хэргийн үйлдлийн аргыг заавал шаардахгүй бөгөөд энэ нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй гэдгийг анхаарах.
- 18 насанд хүрсэн хүн эсвэл хүүхдийн биеийг үнэлүүлсэн, садар самуунд холбогдох сурталчилгаанд ашигласан, оролцуулсныг нотлох баримтыг үнэлэх. Өөрөөр хэлбэл давхар зүйлчлэх шаардлагатай гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгаж тогтоох эсхүл энэ хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн арга болсон эсэхийг тодорхойлох.
- Мөн мөлжих зорилгоор албадан хөдөлмөр эрхлүүлсэн, гуйлга гуйлгуулсан, хүчээр гэрлүүлсэн эсэх нотлох баримыг үнэлэх.

Хүн худалдаалах гэмт хэргийн явцад өөр гэмт хэрэг давхар үйлдэгддэг онцлогтой бөгөөд прокурор нь Эрүүгийн хуульд зааснаар хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хүн хулгайлах, хууль бусаар хорих, заналхийлэх, хүчиндэх, насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйн шинж байгаа эсэхийг тогтоох нь зүйтэй.

Мөн мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгч нь хохирогчид хууль бусаар нөлөөлөх гэж оролдсон, заналхийлсэн үйл баримт тогтоогдвол прокурор хохирогчийг хамгаалах арга хэмжээг авахаас гадна таслан сэргийлэх арга хэмжээг хүндрүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжтэй эсэхийг мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоосон нотлох баримтыг үнэлэн нэмж ял сонсгож болно.

Мөн энэ төрлийн гэмт хэргийг шалгах явцад хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хөрөнгө, орлогыг нуухыг, бусад арга хэрэгслээр хууль ёсны мэт харагдуулахыг оролддог тул мөнгө угаах гэмт хэргийн шинж байгаа эсэхийг эдийн засаг, санхүүгийн мэдлэг шаардсан мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулж нотолсон эсэхийг хянана.

СЭДЭВ 3: ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИЙН ӨМГӨӨЛӨГЧӨӨС ЯЛ ЗАВШУУЛАХ ЗОРИЛГООР ХЭРЭГЛЭДЭГ АРГА, ПРОКУРОРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

1. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧ ЯЛ ЗАВШИХ ЗОРИЛГООР ХЭРЭГЛЭДЭГ АРГА

Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч түүний өмгөөлөгч ял завших зорилгоор хэрэглэдэг аргуудыг урьдчилан таах аргагүй. Гэхдээ энэ төрлийн гэмт хэрэгт ихэвчлэн хэрэглэдэг дараах арга байдаг. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн шинжид заасан нэг эсвэл хэд хэдэн шинжийг үгүйсгэхийг оролдох, эсхүл хохирогчийн буруутай үйлдэл байсан тул түүнд итгэж болох эсэхэд эргэлзэх баримтыг гаргаж тавьдаг. Ихэнх тохиолдолд дээр дурдсан аргуудыг дараах байдлаар дангаар болон хамтад нь ашигладаг. Үүнд:

Хохирогч өөрөө зөвшөөрсөн гэж харагдуулах: Нэн түрүүнд мөн түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь хохирогчид хүч хэрэглээгүй мөн хууран мэхлээгүй гэж итгүүлэх явдал бөгөөд энэ ихэвчлэн элсүүлэх шатанд ажиглагддаг. Өмнө нь хохирогч өөрөө санал болгосон, эсхүл урьдчилан тохиролцсон ажиллах нөхцөлийн хүрээнд тухайн хүн ажиллаж байсан гэх мэт баримтыг сөргүүлэн гаргаж тавьдаг. Иймэрхүү баримтад хүч хэрэглэж, заналхийлсэн шинж тэмдэг илэрхий харагдахгүй, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг олж тогтооход хүндрэлтэй байдаг. Зөвшөөрлийг нь авсан эсэхтэй холбоотойгоор дараах зүйлсийг дурддаг:

- Хохирогч тухайн газраас оргож, зугтаагүй;
- Хохирогчийг түгжиж, гав, гинжээр хүлээгүй байсан. Тийм учраас ямар ч гэмт хэрэг үйлдэгдээгүй;
- Хохирогч энэ талаар хэн нэгэнд хэлж огт гомдол гаргаж байгаагүй.
- Өөрөө явах боломжтой байсан гэх мэт.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд хохирогч болсон тохиолдолд тухайн хүүхдийн эцэг эх/асран хамгаалагч/ нь "сайн дурааараа" хүүхдээ "ажил" хийлгэхээр урьдчилан ярилцаж тохиролцсон мэтээр харагдуулах баримт сэлтийг гаргаж тавьдаг.

Ойлголцлын зөрүү байсан гэж итгүүлэх: Болж өнгөрсөн бүх зүйл нэгнийгээ буруу ойлгож, ойлголцлын зөрүүтэй байснаас боллоо гэсэн баримт, түүнийг илэрхийлэх мэдүүлэг юм. Гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж буй хүн хохирогчид "туслахыг" хүсэж байсан "сайн хүн" мэтээр аашилна. Энэхүү үйлдэл нь дараах байдлаар илэрнэ:

- Хохирогч өөрийн улс орон эсвэл гэртээ байхдаа маш хүнд хэцүү амьдралтай байсан бөгөөд одоо хамаагүй дээр нөхцөл байдалд байгаа;
- Яллагдагч этгээд хохирогчид туслахыг л хүсэж байсан бөгөөд түүнд ажил олж өгч, амьдрах байраар ханган, хийсэн ажлынх нь хөлсийг төлж байсан, түүнд сайхан сэтгэлээр хандаж, тусалдаг байсан;
- Хохирогч болсон хүүхэд эсвэл эцэг, эх нь тухайн хүүхдийн насыг үнэн зөвөөр нь хэлээгүй, хуулийн дагуу насанд хүрсэн гэж бодоод ажлаар хангаж байсан.

Гэмт хэрэг үйлдээгүй гэсэн итгэл, үнэмшил төрүүлэх: Үнэн ярьж байгаа хүн нь хохирогч биш, шалгагдаж буй хүн өөрөө юм гэж мэлзэх. Хохирогч худлаа ярьж байгаа эсвэл юу ярихаа мэдэхгүй байх тохиолдолд энэ аргыг хэрэглэх ба мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдсэнийг нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж, баталгаажуулж чадаагүйгээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болох тохиолдол гардаг. Дараах тохиолдолд хохирогчийн мэдүүлэгт эргэлзээ төрдөг:

- Өмнө нь зөрүүтэй мэдүүлэг өгч байсан;
- Мэдүүлэг авч байх үед өөр хоорондоо зөрчилдсөн мэдээлэл өгч байсан;
- Хохирогчийн мэдүүлгийг няцаах биет нотлох баримт гаргаж ирэх;
- Хохирогч худлаа хэлэх шалтгаантай байсан: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид л үзүүлдэг хууль сахиулах байгууллагын тусламж дэмжлэгийг авах зорилгоор ингэж мэдүүлж байгаа;
- Хохирогч гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь нотлох баримттай учраас түүнд итгэж болохгүй;
- Хохирогч өөрөө гадаад улсын хилийг хууль бусаар давж ирсэн бөгөөд яллагдагч этгээдээс ажил олгохыг хүссэн, хохирогчийг өөрийгөө аваад явах орлогын эх үүсвэртэй байлгахын тулд л ажил олгосон.

Хөдөлмөрийн харилцаа гэж харагдуулах: Хохирогчийг ажиллуулсныхаа хөлсийг өгч байсан гэх нь баримтыг гаргахдаа цалин хөлс төлж, байр хоолоор хангаж байсан ба мөлжлөгийн шинж байхгүй гэж харагдуулахыг оролддог. Үүнийг дараах байдлаар тайлбарлана:

- Хохирогчийн цалин хөлс авч байсан баримт, гарын үсэгтэйгээ байх;
- Бусад ажиллаж байгаа хүмүүстэй адилхан нөхцөл байдалтай байсныг нотлохоор бүртгэлийн дэвтэрт байгаа гарын үсгийг нь үзүүлэх.

Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал нь түүнийг нотлох баримтаас хамааранд өөр өөр байж болох ч гэмт хэрэг үйлдсэн хүн ихэнхдээ өөрийгөө өмгөөлж, хамгаалахад дээр дурдсан аргуудыг хэрэглэдэг. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн, түүнд оролцсон этгээдийн өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэхийг урьдчилан тооцоолоход нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлсэн байдал чухал үүрэгтэй. Нотлох баримтын тоо, чанарт нарийн үнэлэлт дүгнэлт хийж, сул тал байгааг олж харах нь прокурорын гол үүрэг. Энэхүү нотлох баримтын сул талыг ашиглаж, гэмт этгээд өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэж болохыг урьдчилан таамаглах шаардлагатай.

2. ПРОКУРОРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Прокурор нь хүн худалдаалах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад шүүгдэгч ял завшихын тулд дээр дурдсаны аргын дагуу өөрийгөө хамгаалах магадлалыг урьдчилан тооцоолж шүүх хуралдаан эхлэхээс өмнө түүнд өгөх хариулт няцаалтыг тооцсон байх шаардлагатай. Үүнд дараах зүйлийг анхаарна:

Хохирогчид яллагдагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн эрх, үүргийг тайлбарлаж өгөх: Прокурорын нэн түрүүнд хийх ёстой зүйл бол шүүх хурал болохоос өмнө хохирогчид яллагдагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн эрх, үүргийн талаар тайлбарлах явдал байдаг. Шүүх хуралдааны үеэр прокурор байлцдагтай адил яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийн гүйцэтгэх үүрэг нь үйлчлүүлэгчээ өмгөөлөхөд чиглэдгийг сайтар ойлгуулах хэрэгтэй байдаг. Яллагдагч талын өмгөөлөгч хохирогчийн мэдүүлгийг эргэлзээтэй гэдгийг шүүгчдэд нотлох тактик хэрэглэж болох талаар тайлбарлах нь зүйтэй. Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдааны үеэр хохирогч руу дайрсан, түүнийг буруушаасан үйлдэл гаргаж болно. Прокурорын яллах дүгнэлтийг няцаахын тулд хохирогчоос хариулахад хэцүү асуултууд асуудаг. Үүний цаад гол зорилго нь гэмт этгээд/яллагдагчийг гэмт хэрэгт холбоогүй, буруугүй гэдгийг шүүхийн өмнө батлахад оршдог.

Хохирогчийн эрх, үүргийг тайлбарлах: Прокурор тухайн гэмт хэргийн хохирогчид шүүх хуралдааны өмнө өөрт нь тохиолдсон зүйлийг үнэнээр нь өгүүлэх үүрэгтэй талаар тайлбарлаж өгнө. Гэмт хэрэг яаж шийдэгдэх эсвэл өөрийнх нь өгөх мэдүүлэг хэрэг шийдвэрлэхэд ямар

нөлөө үзүүлэх талаар хохирогчийг хамгаалах боломжуудын талаар тайлбарлаж өгнө. Тухайлбал, хохирогчийн үүрэг яллагдагчид ял шийтгэл оногдуулахад чиглэгддэггүй харин болсон хэрэг явдлыг дэс дарааллын дагуу, үнэн зөв гарган хэлж, бодит шийдвэр гаргахад чиглэдэг гэдгийг ойлгуулбал зохино.

Шүүх хурлын явцад хохирогч болон шүүгдэгч талын өмгөөлөгч нь прокурор, бусад оролцогчийн нэгэн адил шүүхийн хэлэлцүүлэгт асуултад хариулах замаар нотлох баримт гаргаж, аливаа асуултад үнэн зөв хариулах хэрэгтэйг сануулах нь чухал. Үнэн зөв мэдүүлэг өгөхөө шүүх хурлын үеэр баталдаг талаар ойлгуулж, үүний зорилго, үр дагаврыг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Хохирогч нь аливаа асуултад үнэн шударгаар хариулахгүй бол хуульд заасан баталгаагаа зөрчиж буй хэрэг болох талаар сануулна.

Прокурорын хариу арга тактик

Нотлох баримт гаргаж тавих: Шүүгдэгчийн өөрийгөө хамгаалсан аливаа мэдүүлгийг няцааж, хохирогчийн ярьсан зүйл үнэн, яллагдагчийнх үндэслэлгүй гэдгийг нотлохын тулд няцаах боломжгүй нотлох баримтыг логик дэс дарааллалтайгаар гаргаж тавих олж авах явдал юм. Прокурор нь нотлох баримт хангалтгүй гэмт хэргийн шинжийг тогтоохын тулд мөрдөгчийг удирдан чиглүүлж дэс дараатай, шалтгаант холбоотойг нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь чухал. Тухайлбал, прокурор нь хохирогчийг эмзэг байдлыг далимдуулан хууран мэхлэх замаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гэсэн баримтыг "элсүүлэх" үедээ хохирогчид хуурамч амлалт өгч байсан талаар сонсож байсан гэр бүлийн гишүүдээр шүүх хурлын үеэр гэрчийн мэдүүлэг өгүүлж болно.

Хохирогчтой хамтарч ажиллах: Яллах ажиллагааны үед хохирогчийн мэдүүлгийн итгэл үнэмшилтэй байгаа эсэх нь эргэлзээтэй бол яг юунаас шалтгаалж байгааг прокурор тодорхойлно. Дараах шалтгааны улмаас хохирогчийн мэдүүлэг эргэлзээтэй санагдаж болно. Үүнд:

- Өмнө нь зөрүүтэй мэдүүлэг өгч байсан;
- Хэргийн нотлох баримтыг үгүйсгэх мэдүүлэг өгсөн;
- Хохирогчийн үйлдэл гэмт хэргийн шинжийг үгүйсгэж байгаа;
- Хохирогч өөрөө гэмт хэрэг үйлдсэн эсвэл хууль бус үйлдэл гаргаж байсан (Жишээлбэл, хохирогч оршин сууж байсан газраасаа өөр хоёр хүнийг өндөр цалинтай ажилд оруулна гэж үнэмшүүлж, үйлдвэрт албадан хөдөлмөр эрхлүүлэхэд гар бие оролцсон).

Хохирогчийн мэдүүлгийг үнэмшилгүй, эргэлзээтэй санагдуулах дээр дурдсан шалтгааныг шийдвэрлэхийн тулд прокурор өгсөн мэдүүлгийн зөрүү, ингэх болсон шалтгааныг олж тогтоохын тулд хохирогчоос шалгаж болно. Хохирогч яллагдагч, шүүгдэгч өөрийг нь болон гэр бүлийнхнийг нь заналхийлсэн, хууран мэхэлсэн учраас болсон явдлыг мөрдөн шалгах ажиллагааны үеэр өөрчилсөн шалтгааныг нь олж тогтоох шаардлагатай. Хохирогч шүүх хурлын өмнө эргэлзэж, яахаа мэдэхээ больсон, айж эмээсэн, прокурорт итгэж болохгүй, өөрт нь туслахгүй гэж бодсон учраас тийм үйлдэл гаргадаг.

Дээрх бэрхшээл нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих, яллах ажиллагааны үед түгээмэл тохиолддог бөгөөд хэргийн газраас зугтсан, хэргийн талаар мэдээлэх боломж байсаар байтал яагаад ингээгүйг асуудаг. Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч хохирогчоос өөрийнх нь зөвшөөрлийг авсны үндсэн дээр энэ үйлдэл хийгдсэн мөн ямар нэг хүч хэрэглээгүй гэж нотлохыг оролддог.

Иймд Прокурор хохирогчоос боломж байсаар байтал яагаад хэргийн газраас зугтаагүй талаар

мэдэж байх хэрэгтэй. Хохирогч нь ихэвчлэн өөрийн болон ойр дотнын хүн, гэр бүлд нь ирэх эрсдэл, заналхийлэл, буруутгалаас айдаг. Өөрийнх нь талаар мэдээлэх, хууль бусаар оршин сууж байсан, хуурамч бичиг баримттай байсан, хилийн дэглэм, журам зөрчсөн, хууль бусаар хил нэвтэрсэн, хаана хэнд хандахаа мэдэхгүй байсан, тухайн орны хэлийг мэдэхгүйгээс болж хэл нэвтрэлцэхгүй байсан зэрэг тайлбарыг өгдөг.

Нотлох баримт нэмж цуглуулах, бэхжүүлэх: Прокурор нь хохирогчийн мэдүүлэг илтэд зөрүүтэй бол дээр дурдсаны дагуу заналхийлэл, эрхшээлд байгаа, түүнд нөлөөлсөн байж болох эсэхийг нэмэлт нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхээр мөрдөгчид даалгаж болно. Хохирогчийн мэдүүлэг бодитой эсэхийг нь тодруулахын тулд зайлшгүй хийх энэхүү ажиллагааг хохирогчийг хамгаалах бусад арга хэмжээтэй хослуулан хийх, тодорхой зөвшөөрлийг өгч биечлэн хянах зэргээр мэдүүлгийн ач холбогдлыг нэмэгдүүлж болно.

Шүүх хуралдаанд бэлтгэх: Хохирогчийн тайлбар итгэл төрүүлэхүйц, баримт болж чадахуйц гэж прокурор үзэж байвал шүүх хуралдааны үеэр гарч ирж болзошгүй асуудлыг шийдвэрлэх тактик боловсруулна. Прокурор хохирогчтой холбоотой мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд биечлэн оролцох нь нотлох баримтын ач холбогдлыг нэмэгдүүлдэг бөгөөд хохирогчийг шүүх хурлын өмнө сэтгэл зүйн болоод бусад байдлаар бэлтгэх нь хуулиар хориглоогүй арга юм. Ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг шүүх хурлын өмнө бэлтгэж, тэдний аюулгүй байдлыг хамгаалж чадна гэсэн итгэл үнэмшил төрүүлж, бодит байдлаар харуулах нь хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөө үзүүлдэг. Практикт прокурор нь хохирогчтой зөвхөн шүүх хурлын үеэр нүүр тулан уулзаж, тэднийг бэлтгээгүйгээс мэдүүлгээсээ буцах тохиолдол гардаг ба энэ нь шүүгдэгчид ял завшуулах боломж олгох талтай.

Мөн прокурор шүүх хуралдааны үед хохирогчид нөлөөлсөн асуудлыг баримтаар гаргаж тавихгүй, яллагдагч талын өмгөөлөгчид давуу тал олговол хохирогчийн мэдүүлгийг эргэлзээтэй болгодог. Иймэрхүү байдал нь шүүх бүрэлдэхүүнд хохирогч, прокурор нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, хэт нэг талыг барьсан мэт сэтгэгдэл төрүүлэх магадлалтай. Иймээс шүүх хурлын явцад зарим мэдүүлгийг нотлох баримтын бүрдэл хангаагүй гэж үзэн шийдвэрлэх эрсдэлтэй.

Шинжээч, мэргэжилтнийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах: Дээр дурдсан гурав дахь асуудалд хандсан хариу арга хэмжээ авахад тактикийн хувьд шүүх хуралдааны үед дэмжлэг үзүүлэх шинжээч, мэргэжилтний туслалцаа шаардлагатай эсэхийг харгалзаж үзэх хэрэгтэй. Шүүх хуралдаанд ирсэн сэтгэл зүй, сэтгэц гэм судлалын талаар мэргэшсэн шинжээч, мэргэжилтэн нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч удаан хугацаанд хүчирхийлэлд байх онцлог, шинжийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт өгдөг. Тухайлбал, хохирогчийн сэтгэл зүйн байдал хам шинжийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар ач холбогдолтой.

Шинжээч, мэргэжилтний ийм мэдүүлэг, оролцоо үр дүнтэй байдаг. Прокурорын анхаарах гол зүйл нь тухайн хүн үнэхээр мэргэшсэн ажилтан мөн эсэхийг баталгаажуулах явдал юм. Мөн прокурор нь шинжээч, мэргэжилтний энэ төрлийн мэдүүлэг үр дүнтэй байх эсэхийг урьдчилан тооцоолсон байх шаардлагатай. Шүүх хуралдаанд мэргэжилтнийг оролцуулах хэрэгцээ шаардлага байна уу? Итгэл үнэмшил төрүүлэхүйц мэдээлэл өгч чадах уу? Шинжээч, мэргэжилтэн шинжлэх ухааны нарийн ойлголтыг бусдад ойлгомжтойгоор тайлбарлаж чадах эсэхийг нягтлах нь зүйтэй. Мөн прокурор шүүгдэгч, түүний өмгөөлөгч нь тухайн мэргэжилтнээс ямар асуулт асууж болохыг урьдчилан тооцоолж бэлтгэсэн байх ёстой.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хичээлийн энэ хэсэгт 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мэргэжилтнийг томилох тухай хэрхэн зохицуулсан байдгийг суралцагчдад хэлнэ.

Хохирогчийн үйлдсэн хууль бус үйлдэл болон гэмт хэргийг ялгах: Дээр дурдсан тохиолдолд прокурор нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хохирогчийн үйлдсэн буруутай байж болох үйлдэл болон гэмт хэргийг хооронд нь ялгах шаардлагатай. Олон улсын стандарт болон практикт хохирогч байх явцдаа үйлдсэн аливаа үйлдэлдээ буруутгахгүй гэж тодорхой заасан байдаг[34]. Хохирогч гэмт этгээдийн албадлага, шахалт дор ажиллаж, мөлжигдөж байхдаа өөрийн хүслээр, дур сонирхлоор ямар нэг үйлдэл хийх эрхгүй байдаг. Тийм учраас хохирогчийг хүчилж, айлган сүрдүүлж, албадаж хийлгүүлсэн аливаа буруу үйлдэлд хохирогч биш түүнийг үйлдүүлсэн гэмт этгээд хариуцлага хүлээх учиртай.

Хохирогч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байх үедээ үйлдсэн аливаа үйлдэлдээ хариуцлага хүлээхгүй ч гэмт хэргийн өмнө болон дараа нь хууль бус үйлдэл хийсэн бол үүнийг тусад нь авч үзнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн хүрээнээс гадуур үйлдсэн аливаа гэмт үйлдэлдээ хохирогч хариуцлага хүлээх үүрэгтэй бөгөөд үүнийг тухайн улс орны хуулиар зохицуулна.

Прокурор тухайн хохирогч өмнө нь ял шийтгэл эдэлж байсан эсэхийг тогтоох шаардлагатай бөгөөд ямар нэг ял шийтгэлтэй байсан бол энэ талаар шүүх хуралдаанаас өмнө бэлтгэлийн үе шатанд уулзаж ярилцаад, шүүх хуралдааны үеэр энэ тухай асуувал ямар хариулт өгөх талаар зөвлөлдөх хэрэгтэй. Өмнөх ял шийтгэлийг нь сөхсөн асуултыг яллагдагчийн өмгөөлөгч гэнэт асуувал сандарч, санаа зовохдоо худал хариулт өгөх тохиолдол байдаг. Хэрэв худал хариулбал хохирогчид итгэх магадлал мэдэгдэхүйц буурна.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хичээлийн энэ хэсэгт сургагч багш доорх дасгалын хүрээнд яллагдагчийн өмгөөлөгч ямар асуулт тавьж болох вэ, үүнд хэрхэн хариулт өгөх талаар ярилцана. Энэ модулийн туршид дэд сэдвүүдийн хүрээнд ижил дасгал ажиллуулна.

ДАСГАЛ АЖИЛ 9 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ҮЕЭР ЯЛЛАГДАГЧ ТАЛ ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ЯМАР АРГА ХЭРЭГЛЭХИЙГ ТООЦООЛЖ, ТОХИРСОН ХАРИУЛТЫГ УРЬДЧИЛАН БЭЛТГЭХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дүрд тоглох дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс жүжиглэх үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол байх хэрэгтэйг анхаарна уу.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Тараах материал, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажиллах хугацаа: 45 минут

Дасгал: Сургагч багш суралцагчдыг хоёр багт хуваажа, баг бүрд шинжлэх тохиолдлыг өгнө. Нэг баг нь "гэмт этгээд"-ийг яллагдагч талын өмгөөлөгчийн дүрээр, нөгөө баг нь "хохирогч"-ийг төлөөлж буй прокурорын дүрээр тус тус гаргана. Эхний баг яллагдагч талын өмгөөлөгч

34 НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол; Хүний эрх, хүн худалдаалахтай тэмцэх зарчим зөвлөмж.

болж, яллагдагчийг хамгаалах аргуудаа жагсааж бичих бөгөөд хоёрдугаар баг прокурорыг төлөөлж, ямар хариулт өгөхөө гаргаж ирнэ. Хоёр баг тохиолдолтойгоо танилцсаны дараа шүүхийн танхимд яллагдагчийн өмгөөлөгч, прокурор болж мэтгэлцэнэ.

Тохиолдол

Ариунаа19 настай охин, Улаанбаатар хотод сурч, амьдардаг. Эцэг, эх хоёр нь хоёулаа төрийн албан хаагчид бөгөөд 15 настай эрэгтэй дүүгийн хамт амьдардаг. Ариунаа сурлага сайтай, бизнес удирдлагын чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, олон улсын компанид ажиллах хүсэлтэй охин. Тэрээр Англи хэлээ сайжруулахаар ярианы клубт явдаг байсан бөгөөд инженерийн чиглэлээр суралцдаг Зоригт гэгчтэй танилцав. Тэд нэг нэгэндээ таалагдаж, хичээлийн дараа гадуур болзож эхэллээ. Зоригт бэлгийн харилцаанд оръё гэж Ариунаагаас хүсэх болсон бөгөөд хэдэн жилийн дараа гэрлэх учраас асуудалгүй гэж ятгасаар байв. Ариунаад мэдэгдэлгүйгээр Зоригт бэлгийн харилцаанд орж байгаагаа бичлэг хийж хадгалсан байлаа. Дотно харилцаанд хэд хэдэн удаа орсны дараа Зоригт хийсэн дүрс бичлэгээ үзүүлж, бизнес эрхэлдэг өөр нэг хүнтэй бэлгийн харилцаанд оруулмаар байгаагаа хэлэв. Ариунаа бичлэгийг үзээд ихэд айж, ичсэн бөгөөд Зоригтын ийн тавьж буй саналд цочирдов.

Зоригт дүрс бичлэгийг дахин ашиглахгүй гэж амлан, хамтран амьдрахад хэрэглэгдэх мөнгөө олохын тулд хамгийн амархан арга нь энэ хэмээн тайлбарлаж байлаа. Тэрээр ганцхан л удаа үүнийг хийхэд болох бөгөөд түүний найз болох Болд хэдхэн цаг "ажилласныхаа" төлөө нэлээдгүй их мөнгө авах боломж байгаа талаар ятгаж гарлаа. Ариунаа яахаа мэдэхээ больж, Зоригтод байгаа бичлэг дээр тод гарч байгаа өөрийнхөө царайг санаж, Зоригтод үнэн сэтгэлээсээ хайртай, гэрлэнэ гэж бодож явдаг тул гарцаагүй байдалд орлоо. Зоригт ятгасаар байгаад Ариунаа ганцхан удаа хийнэ гэсэн нөхцөлтэйгөөр зөвшөөрөв. Тэр хоёр айлын гэрт очиж Болдтой уулзсан бөгөөд томоохон зочид буудалд шөнийг өнгөрөөх болов.

Энэ явдлаас хойш сарын дараа Зоригт Ариунаад өөр нэгэн том бизнес эрхэлдэг хүнтэй хамт байх хэрэгтэй талаар хэлэв. Уйгагүй ятгасны эцэст Ариунаа зөвшөөрөв. Энэ явдал долоо хоног бүр давтагдах болж, Ариунааг дургүйцэх болгонд хийсэн бичлэгээ эцэг, эхэд нь болон сургуулийнханд нь тараана гэж сүрдүүлэх боллоо. Ариунаа яах учраа мэдэхээ байж, хаана хэнд хандахаа ч мэдэхгүй байв. Тэр Зоригтод хайртай хэвээр бөгөөд өөрсдийнхөө ирээдүйн төлөө мөнгө хураахын тулд ийм үйлдэл хийж байгаа гэж боддог байсан ч үнэндээ гар дээрээ нэг ч төгрөг авч байсангүй. Дотоод сэтгэлдээ зөрчилдөж, Зоригтыг хайрлах, хийж байгаа зүйлээ үзэн ядах хоёрын дунд эргэлзэж, хаашаа ч хөдөлж чадахгүй байсаар байлаа.

Нэг өдөр цагдаа нар зочид буудлыг шалгах үеэр Ариунаа үйлчлүүлэгчийн хамт байж байгаад баригдав. Мөрдөн шалгалтын үеэр тэр Зоригт, Болд нар хүчээр биеийг нь үнэлүүлж байсан тухай хэлжээ. Эрүүгийн хэрэг үүсэж, шүүхийн шатандаа явж байна.

Өөрийгөө үнэлэх нь:

1. Зоригтын өмгөөлөгч түүнийг хамгаалах ямар арга шүүх хуралдаан дээр хэрэглэхийг тодорхойлж бичнэ үү.
2. Болдын өмгөөлөгч түүнийг хамгаалах ямар арга шүүх хуралдаан дээр хэрэглэхийг тодорхойлж бичнэ үү.
3. Прокурор яллагдагч/шүүгдэгчийн эсрэг ямар хариу арга, ажиллагаа хэрэглэж болох вэ?

СЭДЭВ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЛАГДАГЧИЙН МЭДҮҮЛГИЙГ ҮНЭЛЭХ, ШАЛГАХ

Эрүүгийн гэмт хэрэгт прокурор яллагдагч, шүүгдэгчээс мэдүүлэг авахад байлцах, түүнийг үнэлэх нь үндсэн хоёр зорилго байдаг. Үүнд:

- Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага оногдуулахад ач холбогдолтой
- Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд эргэлзээ төрүүлэхүйц мэдүүлгийг няцаах.

Үр дүнтэй мэдүүлэг авах: Гэмт хэрэгт шалгагдаж буй хүн нотлох баримтын тодорхой хэсгийг хүлээн зөвшөөрөх тохиолдол бий. Тухайлбал, гэмт этгээд хохирогчийг мөлжиж, ашиг олж байснаа хүлээн зөвшөөрөхгүй байсан ч хохирогчийг ядуу амьдралтай, ажил хайж байсан талаар нь мэдэж байсан гэж мэдүүлэх тохиолдол байдаг. Энэ баримт нь яллагдагч, хохирогч хоёрын хооронд ямар нэг холбоо хамаарал байсан, хохирогчийн эмзэг байдлыг гэмт этгээд мэддэг байсныг нотолно. Прокурор яллагдагчийн хүлээн зөвшөөрсөн баримтыг бусад баримтаар дам байдлаар нотолж шүүх хуралдааны үеэр дэс дараатайгаар ашиглах нь зүйтэй.

Үндэслэл муутай мэдүүлгийг няцаах: Үүний гол зорилго нь шүүгдэгч мэдүүлгээрээ өөрийгөө зөвтгөн ярьж байгаа зүйл нь итгэл үнэмшилгүй юм гэдгийг няцаах явдал юм. Дараах байдлаар няцаах боломжтой. Үүнд:

1. Мэдүүлгийн зөрүү;
2. Зөрчилдсөн мэдүүлэг;
3. Өмнө нь ял шийтгэл эдэлж байсан;
4. Зорилго, сэдэлт.

1) Мэдүүлгийн зөрүү: Шүүгдэгч аливаа үйл явдлын талаар удаа дараа өөрчлөн мэдүүлсэн нь түүнийг худал ярьж байна гэх хүчтэй нотолгоо болдог. Тухайлбал, яллагдагч хохирогчийг огт таньдаггүй байсан гэж өмнө нь хэлж байгаад дараа нь хохирогчтой нэг аймаг, сумынх гэж хэлбэл түүнд итгэх итгэлийг сулруулж, ямар нэг зүйл нуугаад байна гэсэн хардлага төрүүлдэг.

Зөрүүтэй мэдүүлгийнх нь талаар асуулт асуухаасаа өмнө гэмт этгээд өмнөх мэдүүлгээ өгөхдөө юу ярьж байгаагаа сайн мэдэж байсан, мөн сайн дураараа өгсөн харин дараа нь яг ижил зүйлийг өөр байдлаар мэдүүлсэн бөгөөд энэ үедээ ч юу ярьж байгаагаа мэдэж байсан талаар нь онцлон дурдах хэрэгтэй.

2) Зөрчилдсөн мэдүүлэг: Шүүгдэгч өөрийгөө гэм буруугүй гэж мэдүүлж байгаа ч аливаа үйлдэлтэй нь зөрчилдөж байгааг нотлох баримтаар няцааж болно. Тухайлбал, цагдаагийн газраас зугтахыг оролдох, гэрчийн мэдүүлэгт нөлөөлөхийг оролдох, гэрчийг заналхийлэх, нотлох баримтыг устгах зэрэг үйлдлийг дурдаж болно. Прокурор бусад тухайн үед баривчилсан цагдаагийн албан хаагчийн мэдүүлэг, нөлөөлөхийг оролдсон гэрч зэрэг хүмүүсийн мэдүүлгээр үүнийг нотлох боломжтой.

3) Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, өмнө нь ял шийтгэл эдэлж байсан: Шүүх хурлын үеэр шүүгч гэмт хүний хувийн байдал, тухайлбал, өмнө нь ял шийтгэл эдэлж байсан эсэхийг (зарим тохиолдолд ялын төрөл, нас зэргийг нь харгалзан хязгаарладаг) анхаарч үздэг бөгөөд үүгээр дамжуулан тухайн этгээдэд хэр зэрэг итгэж болох вэ гэдгээ бодолцдог. Тухайлбал, хөнгөн гэмт хэрэг үйлдэж байсан, насанд хүрээгүй байхдаа эсвэл олон жилийн өмнө гэмт хэрэгт холбогдож

байсан бол тэр бүр анхаарал хандуулж авч үзэхгүй.

Яллагдагчийн хувийн байдал, эсхүл өмнө нь ял шийтгэл эдэлж байсныг шүүх хуралдааны үеэр ашиглаж болох эсэхийг дотоодын хууль тогтоомжийн дагуу шалгах шаардлагатай бөгөөд шүүх хуралдаанаас өмнө ямар ямар ял шийтгэл эдэлж байсан талаар мэдээллийг прокурор цуглуулсан байх хэрэгтэй. Ингэхдээ ижил нэртэй хүнтэй андуурч, буруу мэдээлэл цуглуулахгүйн тулд яллагдагчийн мэдээлэл зөв эсэхийг сайтар хянах шаардлагатай. Тухайн этгээд ял эдэлж байсныг баталгаажуулж, холбогдох шүүхээс баталгаа гаргуулж авна. Шүүх хуралдааны үеэр яллагдагчаас асуулт асуух үедээ өмнө нь ял шийтгэлтэй байсан эсэх талаар нь тодруулж, ижил төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан бол шүүхээс эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн үзэх нөхцөл байдалд тооцож ял оноох хүсэлт тавих хэрэгтэй.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хичээлийн энэ хэсэгт Монгол Улсын хууль тогтоомжид хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллах үед өмнө нь эдэлж байсан ял шийтгэлийг ашиглаж болох эсэх талаар юу гэж заасан байдаг талаар суралцагчдад тайлбарлана.

4) Зорилго, сэдэлт: Яллагдагч гэмт хэрэг үйлдэх болсон сэдэлт, зорилгыг илэрхийлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн үед гэмт хэргийн сэдэл нь хохирогчийг мөлжиж, ашиг орлого олоход чиглэж байдаг. Гэмт этгээдүүд энэхүү мөлжлөгөөрөө өдөр болгон эсвэл долоо хоног бүр нэлээдгүй хэмжээний бэлэн мөнгө олдог тодийгүй янз бүрийн байдлаар тогтмол мөнгө угаах ажиллагаанд оролцож байдаг. Энэхүү үйлдлийг нь санхүүгийн шинжтэй мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэх боломжтой. Санхүүгийн мөрдөн шалгалтаар яллагдагчийн ашиг олох зорилго, сэдэлтийг нотлох боломжтой.

Яллагдагч өөрийнх нь овог нэр бичигдсэн баримтыг няцааж, үгүйсгэхэд хэцүү байдаг тул үүнтэй холбоотой асуулт тавих нь байдлыг нааштайгаар эргүүлэх магадлалтай. Үүнийг асуух гол зорилго нь яллагдагчийн нэр дээр байгаа эд хөрөнгө, эх үүсвэр нь тодорхойгүй, их хэмжээний орлогыг зарцуулсан зэрэг санхүүгийн баримтуудыг нотлоход чиглэгдэнэ.

Мөнгөний урсгалын талаар тайлбар авахаар цуглуулсан баримт эдгээрт шууд чиглэж байвал зохино. Яллагдагчаас цуглуулсан бүх баримтын талаар асуувал цаг их шаардагдах тодийгүй эргэлзээ төрүүлж эхэлдэг. Хоёрдмол утгатай эсвэл тодорхой бус баримтад үндэслэн асуулт асуухгүй байх шаардлагатай.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хичээлийн энэ хэсэгт хэр их хугацаа үлдсэнээс хамааралд сургагч багш суралцагчдаас Дасгал ажил 9-д гарсан гэмт этгээдээс шүүх хуралдаан дээр прокурорын үүднээс ямар асуулт асууж болох талаар жагсаалт гаргуулж болно.

СЭДЭВ 5: ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД БЭЛТГЭХ

Хохирогчтой ойр хамтран ажиллах нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг мөрдөн байцаалтыг амжилттай явуулах үндэс суурь болдог. Гэмт хэргийн хохирогч байхгүй бол шүүх хуралдаан гэж байхгүйтэй адил. Гэвч хуулийн дагуу хэргийг шийдвэрлэх явцад хохирогчид үзүүлэх тусламж, дэмжлэг, хамгаалалт тухайн хохирогчийн нөхцөл байдал болон хууль сахиулагчидтай хэр сайн хамтарч ажиллаж байгаагаас шалтгаалан ялгавартай байж болохгүйг анхаарах хэрэгтэй.

Хохирогч хууль сахиулагчидтай хамтран ажиллаж, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр мэдүүлэг өгөхөөр хүлээн зөвшөөрсөн гэдэг нь хохирогчтой ажиллаж дууслаа гэж хэрэг биш. Хохирогч урьдчилсан бэлтгэлгүйгээр шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр мэдүүлэг өгөх чадамжтай гэж хэзээ ч найдаж орхиж болохгүй. Бусад хохирогчдын адил хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр мэдүүлэг өгөхдөө прокурорын тусламжтайгаар бэлтгэл хийж байж амжилттай болно. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийг бэлтгэнэ гэдэг нь тэдэнд заавар өгөхөд чиглэдэггүй харин шүүгч, прокурор, яллагдагчийн өмгөөлөгч нарын асуултад хэрхэн бэлтгэлтэй хариулах вэ гэдэгт чиглэж байх ёстой.

Прокурор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шүүх хуралдааны өмнө сэтгэл зүйн хувьд бэлтгэх нь хохирогчийн зүгээс итгэлтэй, тайван байж, шүүх хуралдаанд оролцох, хэргийг үнэн зөв шийдвэрлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах, нөхөн сэргээхэд ач холбогдолтой.

1. ШҮҮХЭЭС ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХОХИРОГЧИЙГ БЭЛТГЭХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн шүүх хуралдаан хэрхэн явагддаг талаар ямар нэг мэдээлэлгүй байдаг. Хангалттай ойлголт, мэдээлэлгүйн улмаас гэмт этгээдийн үл тоомсорлосон байдал, худал мэдүүлэг зэрэг нь хохирогчийг шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэл алдарч, айдаст автахад хүргэж, ямар ч үнээр хамаагүй үүнээс зайлсхийх хэрэгтэй гэж бодож эхэлдэг. Энэхүү айдас хил дамжуулан худалдаалагдсан хохирогчид илүү ихээр төрдөг бөгөөд тухайн улс орны хууль тогтоомжийг сайн мэдэхгүй, тэдний хэлээр нь ярьдаггүй бол бүр ч илүү айх шалтгаан болдог.

Айдастай байгаа хохирогч гэрчийн үүргээ сайн гүйцэтгэж чаддаггүй бөгөөд бодох, илэрхийлэх, харилцах чадварт нь сөргөөр нөлөөлдөг. Тийм учраас прокурорын хамгийн түрүүнд хийх ёстой хамгийн ажил нь энэхүү үйл явцад оролцож байгаа хохирогчид эрүүгийн хэргийг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас айх айдсаас нь салгахад туслах явдал юм. Үүнийг хамгийн зөв шийдвэрлэх арга нь шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар боломжтой бүх мэдээллээр хангах юм. Шүүх үйл ажиллагааны талаар хохирогч хэдий чинээ мэдээлэлтэй байна, төдий чинээ өөртөө итгэлтэй, айж сандрах зүйлгүй оролцдог.

Олон улс оронд хүн худалдаалах гэмт хэргийг амжилттай шийдвэрлэсэн туршлагаас харвал прокурор гэмт хэргийн хохирогчийг шүүх хуралдаанд бэлтгэхдээ дараах зүйлийг анхааран ажилласан байдаг. Үүнд:

1. Хохирогчид шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрхэн явагддаг талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх. Ингэхдээ ямар ямар хүмүүс оролцдог, ямар үүрэг

гүйцэтгэдэг, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зорилго, нотлох баримтыг ямар байдлаар баталгаажуулдаг, ямар дарааллаар хэн хэн асуулт асуудаг, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэр удаан үргэлжилдэг, яллагдагчийн гэмт буруутай эсэхийг хэн шийддэг зэрэг нарийн мэдээллүүдийг өгөх нь зүйтэй.

2. Шүүх хуралдаан болохоос хангалттай хугацааны өмнө шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэзээ явагдахаар болсныг хохирогчид дуулгах.
3. Хохирогчид гэмт этгээд хаана байгаа талаар мэдээллийг өгөх. Тухайлбал, хорих газар байгаа эсвэл батлан даалтад гарсан зэрэг мэдээлэл багтаж болно.
4. Хохирогчид өөрт нь тусламж, дэмжлэг үзүүлэх байгууллага шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө, дундуур, дараа ч бэлэн байхыг хэлэх. (Хүн худалдаалахын эсрэг протоколын 6 дугаар зүйлийн 3-т бий).
5. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр олон нийтийн өмнө эсвэл хэвлэл мэдээллийнхний өмнө гарах магадлалтай эсэх талаар нарийн дэлгэрэнгүй мэдээл өгөх. (Хүн худалдаалахын эсрэг протоколын 6 дугаар зүйлийн 5-т бий).
6. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өмнө шүүхийн танхимыг хохирогчид үзүүлж, шүүгч, яллагдагчийн өмгөөлөгч, прокурор болон хохирогч өөрөө яг хаана суухыг нь зааж өгөх. Шүүхийн танхимын талаар ойлголттой болсноор хохирогчийн айдсыг тодорхой хэмжээгээр багасгадаг.
7. Хохирогчид үнэн зөв мэдүүлэг өгнө гэж баталгаа гаргах үйл явцын талаар ойлголт өгөх. Ямар зорилгоор үүнийг заавал хийлгэдэг, яагаад чухал ач холбогдолтой гэх мэт. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр бүх асуултад үнэн, зөвөөр хариулах нь л түүний гүйцэтгэх үүрэг юм гэдгийг сануулж хэлэх нь чухал.
8. Хохирогч мэдүүлэг өгөхөөр дуудагдах хүртлээ шүүхийн хүлээлгийн танхимд байх ёстой тайлбарлах хэрэгтэй бөгөөд шүүхийн танхимд хэрхэн дуудагдаж ордог талаар хэлж өгнө.
9. Прокурор хохирогчоос асуух асуултын жагсаалтыг бэлтгэсэн байх.
10. Хохирогчоос асууж магадгүй шүүгчийн асуултуудыг тооцоолж, хохирогчид тоймлон хэлэх.
11. Хохирогчоос асууж магадгүй яллагдагчийн өмгөөлөгчийн асуултуудыг тооцоолж, юу юу асууж магадгүй талаар хохирогчид тоймлон хэлэх.
12. Боломжтой бол дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа төрийн бус байгууллагын тусламжтайгаар шүүх хуралдааны үйл явцыг дүрд тоглох байдлаар бэлтгэж, давтаж үзэх
13. Эдгээр мэдээллийг хохирогчийг ойлгох түвшинд хүргэх (Хүн худалдаалахын эсрэг протоколын 6 дугаар зүйлийн 2, 3-т бий).

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дээрх зүйлсийг зохицуулах хуулийн заалт байхгүй тохиолдолд прокурор ямар байдлаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй, гэмт этгээдэд тохирох ял шийтгэлийг нь оногдуулахын тулд гэрч, хохирогчийг бэлтгэх нь яагаад ач холбогдолтой болох, мөн ямар бэрхшээл тулгарч болзошгүй бөгөөд тэдгээр бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэж болох талаар суралцагчидтайгаа ярилцана уу. Энэ тохиолдолд "хохирогч төвтэй арга барил"-ын талаар суралцагчдад мэдээлэл өгөх ёстой.

2. ПРОКУРОРООС ШҮҮХИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД АСУУХ АСУУЛТ

Прокурор шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хохирогчоос асуух асуултын жагсаалтаа бэлтгэнэ. Хохирогчоос асуулт асуухаасаа өмнө прокурор дараах хоёр зүйлийг анхаарах нь чухал. Үүнд:

- Нотлох баримтад тулгуурлан хохирогчид юу тохиолдсоныг шүүгчид хангалттай сайн ойлгосон эсэхийг баталгаажуулах.
- Аливаа зөрүүтэй, тодорхой бус нотлох баримтдаа хангалттай тайлбар өгч чадсан эсэхийг баталгаажуулах.

Прокуророос тавих асуултууд цаг хугацааны хувьд дарааллын дагуу, болсон хэрэг явдлыг бүхлээр нь харуулахуйц байдлаар тавигдах нь зүйтэй. Зөрүүтэй, хариу нь тодорхойгүй асуултыг хохирогч хариулахаар зориуд бэлтгэж, чадвараа гаргах нь чухал. Ингэснээр прокурор хохирогчийн мэдүүлгийг цогц байдлаар авах боломжтой болох бөгөөд үүнийг нь хохирогч шүүх хуралдааны үеэр гаргаж тавих нь чухал байдаг.

Прокурорын тавих асуултад хариулт өгөхөд хохирогчийг бэлтгэх үйл явц доор өгүүлэх шүүгчийн асуултад тэднийг хэрхэн бэлтгэхтэй яг адилхан байдлаар явдаг. Нэг л сэдвийнхээ хүрээнд ярих шаардлагатай болдог тул үүнд нэг арга барилаар л хохирогчийг бэлтгэнэ. Хохирогчийн мэдүүлгийн үр дүнг хэрхэн нэмэгдүүлж, ашигтай тал руу нь эргүүлэх вэ гэсэн стратеги, тактиктаа үндэслэн тэднээс асуух асуултаа бэлтгэх хэрэгтэй.

Асуултын төрөл (Тактик): Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хоёр асуулт асуудаг: шууд асуулт ба зөрүүлсэн асуулт. Зөрүүлсэн асуултад тийм/үгүй гэсэн сонголтоор хариулдаг бөгөөд гэрчид өөр байдлаар хариулах боломж олгодоггүй. Зөрүүлсэн асуултын үед тухайн асуулт өөртөө хариултыг нь агуулж түүнд үгүйсгэсэн, эсхүл зөвшөөрсөн хариулт өгөхөөр байдаг. Шууд асуулт гэрчид дээрх байдлаар хариулахыг тулгадаггүй, харин өөрийнхөө үгээр чөлөөтэй хариулах боломж олгож байдаг.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед прокурор хохирогчоос шууд асуулт асуух нь тохиромжтой. Учир нь энэ үе шатанд хохирогч өөрт нь яг юу тохиолдсон талаар өөрийнхөө үгээр тайлбарлан гаргах боломж гарч ирдэг. Асуултыг тулгасан байдлаар асуух нь хохирогч өөрт нь юу тохиолдсоныг тайлбарлах боломжийг хязгаарлаж байдаг бөгөөд тийм/үгүй гэхээс хэтэрдэггүй. Ийм байдал үүсгэх нь хохирогчид итгэж, үнэмших итгэлийг бууруулж, прокурор хохирогчид итгэхгүй байгаа учраас мэдүүлгийг нь хянаад байгаа мэт сэтгэгдэл шүүгчдэд төрүүлдэг.

Төлөвлөгөө боловсруулах (Стратеги): Прокурор шүүгчдэд нотлох баримтыг аль болох итгэл үнэмшил төрүүлэхүйц байдлаар гаргаж тавихыг зорьдог. Энэ зорилгодоо хүрэхийн тулд дараах байдлаар төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлагатай.

- Хэрэг явдал болсон цаг хугацааны дарааллаар мэдүүлгийг авах.
- Гол нотлох баримтдаа үндэслэн шүүгчдэд итгэл төрүүлэх төдийгүй үнэмштэл нь ажиллах.
- Шаардлагатай гэж үзсэн цагтаа мэдүүлгийг хүчтэй болгох гэрэл зураг, тойм зураг зэрэг зүйлсийг шүүгчдэд танилцуулах.

Хохирогч болон шүүгдэгчээс мэдүүлэг авах: Хоёр янзын арга ашиглаж, гэрчээс мэдүүлэг авч болдог. Эхнийх нь асуух асуултуудаа урьдчилан бэлтгээд хохирогчоос түүнийгээ асуух. Хохирогчоос өгсөн бүх чухал мэдээллийг нотлох баримт болгох зорилгоор энэхүү тактикийг ашигладаг. Энэ төрлийн бэлтгэл шаардсан арга барил гэмт хэргийн талаарх чухал мэдээллийг

хохирогч өөрөө өгөхөд чиглэдэг.

Хоёр дахь арга нь тасралтгүй яриулах. Мэдүүлэг авах энэхүү арга нь хохирогч өөрийнхөө үгээр юу тохиолдсон талаар ярих бөгөөд энэ үед нь яриаг нь таслахгүй. Хохирогчийг ярьж дууссаны дараа ярьсан зүйлд нь дурдагдаагүй эсвэл нэмэлт тайлбар шаардлагатай зүйл байвал нарийвчлан асууна. Гэмт хэргийн хохирогч ярианы чадвар сайтай, юу болсон талаар дэлгэрэнгүй өгүүлэх чадвартай бол энэ арга үр дүнгээ өгнө. Энэ аргыг ашиглахад гардаг нэг эрсдэл нь хохирогч үргэлжлүүлэн ярьж байх үедээ хэргийн чухал хэсэг эсвэл баримтыг санаандгүй орхигдуулах явдал юм. Үүнийг санаж ажиллах нь маш чухал. Прокурор хохирогчийн дурдаж хэлээгүй тэрхүү чухал зүйлийг гаргаж ирэх шаардлагатай. Урьдчилан асуултуудаа бэлтгэсэн тохиолдолд аль хэсэг нь дутуу, аль хэсгийг дурдаагүй байгааг олж харах боломжтой байдаг тул нэмэлт асуултын үеэр тодруулж асууж болдог.

3. ШҮҮХИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХ

Хохирогчийг мэдүүлэг өгүүлэхээр дуудаж, асуулт асуух нь прокурорын гол үүрэг боловч хуульд зааснаар шүүгчид ч хохирогчоос асуулт асуух эрхтэй байдаг. Хохирогчийг шүүгчийн асуух асуултад хариулахад бэлтгэхийн тулд тэд юу асууж магадгүй вэ гэдгийг урьдчилан тооцоолсон байх хэрэгтэй. Хохирогчийн өмнө нь өгч байсан мэдүүлэгт үндэслэн ихэнх асуултаа тавьдаг болохоор энэ нь тийм хэцүү зүйл биш юм. Дараах зүйлсийг анхааран ажиллах хэрэгтэй. Үүнд:

Нотлох баримтаа мэдэж байх: Прокурор эрүүгийн хавтаст хэргийн талаар, хохирогч өмнө нь ямар мэдүүлэг өгч байсан талаар маш сайн мэдээлэлтэй байх ёстой. Өгсөн мэдүүлгүүд дунд хоорондоо зөрүүтэй ямар мэдээлэл байгааг шалгаж үзэх ёстой. Учир нь шүүх бүрэлдэхүүн худлаа эсвэл зөрүүтэй мэдүүлэгт ач холбогдол өгч ажиллах явдал байдаг.

Прокурор хэрэгтэй холбоотой биет нотлох баримт болон бусад гэрчээс авсан мэдүүлгүүд хоорондоо таарч байгаа эсвэл зөрчилдөж байгаа эсэхэд дүгнэлт хийх хэрэгтэй.

Хохирогчийн мэдүүлгийг хохирогчийг байлцуулан танилцах: Прокурор хохирогчийн өгч байсан бүх мэдүүлгийг түүнийг байлцуулан нэг бүрчлэн танилцах хэрэгтэй. Хэдийгээр нэлээдгүй хэмжээний цаг зарцуулах ажил болдог ч үүнийг нарийн нямбай хийх ёстой. Мөрдөн шалгах ажиллагаа болон шүүх хуралдаан хоорондоо нэлээн зайтай болдог, заримдаа хойшилсоор байдаг тул хохирогч шүүх хуралдааны үеэр хэдэн долоо хоног, хэдэн сарын өмнө юу хэлснээ санахгүй байх тохиолдол гардаг. Үүнийг сануулах нь прокурорын үүрэг юм.

Нарийн ширийн зүйлсээ санахгүй байх: Хохирогч өмнө нь хэлсэн зүйлээ зүгээр л санахгүй байх тохиолдол заримдаа байдаг. Болж өнгөрсөн үйл явдал өөрийг нь шархлуулсан, хүнд хэцүү санагддаг байсан бол эсвэл урт хугацааны өмнө тохиолдож байсан бол хохирогч тэр талаар санахгүй байх боломжтой тул үүнд гайхаж эргэлзэх шаардлага байхгүй юм. Прокурор хохирогчид сануулах үүднээс нотлох баримтуудыг харуулж болно.

Мэдүүлгүүд хоорондоо зөрүүтэй байх: Мөрдөн байцаалтын үеэр хохирогч хэд хэдэн удаа мэдүүлэг өгч байсан бол мэдүүлгээс мэдүүлгийн хооронд зөрүүтэй, ялгаатай мэдээлэл гарах боломж үргэлж гардаг. Анхаарал татахуйц, хэрэгт нөлөөлөх зөрүүтэй мэдүүлэг гарч ирсэн тохиолдолд яагаад ингэсэн талаарх тайлбарыг хохирогчоос авах хэрэгтэй. Мэдүүлэгт гарсан бага зэргийн ялгаанаас болж хохирогчийн хэлсэн ярьсанд итгэхгүй байх ёсгүй тул үүний шалтгааныг тайлбарлах хэрэгтэй.

Ямар ч нөхцөлд санахгүй байгаа зүйлийнхээ талаар мэдэж байгаа мэтээр ярихыг хохирогчоос

шаардах эрх прокурорт байхгүй. Бага зэргийн зүйлийг санахгүй байх нь цаг хугацаа явах тусам тохиолдох магадлал өндөртэй үзэгдэл тул үүнийг зөвөөр тайлбарлаж болно.

Хохирогчийн мэдүүлэг, хэргийн баримт хоёр хоорондоо зөрөх: Мөрдөн шалгах ажиллагааны үеэр цуглуулсан нотлох баримт, хохирогчийн мэдүүлэг хоорондоо ямар нэг байдлаар зөрвөл прокурор үүн дээр ажиллаж эхлэх ёстой. Тухайлбал, гэмт этгээд хохирогчийг өрөөнд оруулж, гаднаас нь түгждэг байсан учраас зугтаж чаддаггүй байсан гэж мэдүүлсэн байтал хэргийн газар тухайн өрөө цоожгүй байх.

Энэ төрлийн зөрүүтэй мэдүүлэгт хохирогч тайлбар хийх шаардлагатай. Тухайлбал, хохирогч гэмт этгээдийн хэн нэг нь үргэлж тэднийг хянаж, харгалздаг байсан болохоор өрөөгөө цоожтой гэж боддог байсан. Хэдэн сар тэнд байсны дараа гэмт этгээдүүд түүнд тодорхой хэмжээгээр итгэх болсон учраас чөлөөтэй явуулдаг болсон. Итгэж эхэлснээсээ хойш гэмт этгээдүүд цоожийг нь аваад хаячихсан байж магадгүй гэсэн байдлаар тайлбарлаж болно. Хохирогчийг мэдүүлэг өгүүлэхэд бэлтгэхдээ прокурор иймэрхүү зүйлийг анзааралгүй орхиж огт болохгүй бөгөөд тохирох тайлбарыг хохирогч өгөх ёстой.

Анхаарах асуудал: Прокурор шүүх хуралдааны үеэр хэрхэн сайн сонсох, хариулах талаар зөвлөгөө өгөх нь зүйтэй. Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд хамгийн чухал гэрч болох хүн нь хохирогч байдаг тул шүүх хуралдааны үед ямархуу байдалтай ирвэл зохимжтой талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй. Шүүхийг хүндэтгэж байгаагаа хувцаслалт, байгаа байдлаараа харуулах нь чухал гэдгийг ойлгуулах шаардлагатай.

Мөн түүнчлэн асуусан асуултыг гүйцэт сайн сонсож, ойлгосныхоо дараа хариултаа өгөх хэрэгтэйг сануулна. Хохирогч асуултыг ойлгоогүй тохиолдолд хариулах гэж оролдохоосоо өмнө тухайн асуултаа дахин давтаж асуух эсвэл тайлбарлаж өгөхийг хүсэж болно.

Хамгийн чухал нь шүүх хуралдаан дээр хохирогч гэрчээр оролцохдоо гүйцэтгэх үүрэг нь харж, сонссон зүйлийнхээ талаар үнэнээр нь мэдүүлж, гэрчийн үүргээ биелүүлэх ёстойг ойлгуулах шаардлагатай.

4. ШҮҮГДЭГЧИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН АСУУЛТ

Шүүгдэгчийн өмгөөлөгчийн үүрэг: Шүүгдэгчийн өмгөөлөгчийн үүрэг нь өөрийн үйлчлүүлэгчид ял шийтгэл оногдуулахгүй байх явдал юм. Сайн өмгөөлөгч хуулийн хүрээнд үүргээ гүйцэтгэдэг бөгөөд шүүх бүрэлдэхүүнийг өөрийнх нь үйлчлүүлэгч гэм буруугүй гэж итгүүлэхэд чиглэдэг бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч өөрөө хамгийн чухал гэрч болдог талаар ойлголттой байдаг. Хэрэг дээр ажиллаж байгаа өмгөөлөгч хохирогчийн мэдүүлгийг няцааж чадвал гэмт этгээдийг буруугүй гэж шүүх дүгнэхийг сайн мэдэж ажлаа явуулдаг.

Туршлагатай өмгөөлөгч хохирогчоос сайтар бэлтгэсэн хүнд хэцүү асуултууд асууж, хохирогчийн үгэнд итгэж болохгүй, гэрч байх чадамжгүй юм гэсэн ойлголтыг шүүгчдэд төрүүлэхийн тулд маш бэлтгэлтэй орж ирдэг.

Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуултад үзүүлэх хохирогчийн хариу үйлдэл: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн шүүх хуралдаан хэрхэн явагддаг талаар ойлголтгүй байдаг. Шүүх хурлын танхимд асуугдаж, байцаагдаж огт үзээгүй байдаг тул шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт өөрийг нь хэр зэрэг бухимдуулах талаар ямар ч туршлагагүй байдаг.

Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүмүүс өөр рүү нь дайрч, давшилсан зүйлд маш эмзэг ханддаг болсон байдаг тул хэн нэгэнтэй, ялангуяа эрх мэдэлтэй хүнтэй зөрчилдөхөөс ихэвчлэн зайлсхийдэг. Тэд гэмт этгээдүүдийн гарт урт удаан хугацааны туршид бие махбодын болоод

сэтгэл санааны дарамтад байсан байдаг. Ялангуяа шүүгдэгчийн өмгөөлөгч буюу өөрийнх нь хувьд өөрөөс нь эрх мэдлээр илүү хүнтэй шүүхийн танхимд нүүр тулах нь хамгийн хүнд санагддаг. Өмгөөлөгчийн асуултад хэрхэн хариулах талаар бэлтгэгдээгүй хохирогч өөрт нь тааламжгүй санагдаж байгаа асуултуудыг асуухаа зогсоогоосой гэсэн үүднээс өмгөөлөгчийн хэлсэн бүгдийг хүлээн зөвшөөрөх явдал байдаг. Энэхүү тааламжгүй байдлыг түргэн зогсоохын тулд юу ч хийхээс буцахгүй болох тохиолдол ч гардаг. Ийм учраас хохирогчийн энэ байдал гэмт этгээдэд зохих ял шийтгэлийг оноож чадахгүйд хүргэх магадлалтайг санаж ажиллах шаардлагатай.

СЭДЭВ 6: ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ

1. ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (UNTOC) болон 2000 оны Хүн худалдаалахын эсрэг конвенцид хохирогчийн эрхийн талаар тодорхой өгүүлсэн байдаг. Энэ нь Гэмт хэргийн хохирогч болон эрх мэдлээ урвуулан ашигласан хүмүүсийг шударга шүүх үндсэн зарчим[35] -д нэмэлт байдлаар оруулж ирсэн эрхүүд юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч дараах ерөнхий эрх эдэлнэ. Үүнд:

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эдлэх эрх:

- Гарал үүсэл, үндэс угсаа, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон хувь хүний аливаа үзэл бодол, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн газар болон бусад байдлаас болж ялгаварлан гадуурхагдахгүй байх;
- Амьд явах эрхтэй;
- Эрх чөлөөтэй байж, хамгаалуулах;
- Боолчлолын аливаа хэлбэрээр албадан хөдөлмөр, боолын хөдөлмөр эрхлэхгүй байх;
- Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, доромжлох, шийтгэлээс ангид байх;
- Аль нэг жендерт тулгуурласан хүчирхийллээс ангид байх;
- Эвлэлдэн нэгдэг;
- Чөлөөтэй зорчих;
- Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн боломжит хамгийн дээд түвшинд байх;
- Ажиллах таатай нөхцөлөөр хангагдах;
- Аюулгүй орчинд амьдрах;
- Нийгмийн хамгааллыг хүртэх;
- Хүүхдүүд тусгай хамгаалалт;

35 Ерөнхий ассамблейн1985 оны 40/34 дугаар тогтоолоор батлагдсан

Монгол Улс хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой дараах олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон.

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц[36]
- "Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас учирсан хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай" тунхаглал[37]
- Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм[38]
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол[39]
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц[40]

2. ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖООР ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахтай холбоотой хуулиудын талаар суралцагчидтай ярилцана.

Хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

3. ХОХИРОГЧ ХАМГААЛАХАД ПРОКУРОРЫН ЭРХ, ҮҮРЭГ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт гэрч, хохирогчийг хамгаалахад шүүгч, прокурор, мөрдөгч болон өмгөөлөгч тус тусын оролцоотой бөгөөд харилцан уялдаатай ажиллахаар зохицуулжээ. Тодруулбал, гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг шүүхийн

36 http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CAT.aspx
37 http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm
38 http://legal.un.org/icc/statute/99_corr/cstatute.htm
39 http://www.un-documents.net/a54r263.htm
40 https://www.unodc.org/pdf/crime/a_res_55/res5525e.pdf

өмнөх шатанд болон шүүхийн шатанд хэрэгжүүлэхээр тус хуульд тусгасан байна.

Үүнийг дараах хүснэгтээр харуулж байна:

Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад оролцогчид[41]

Оролцогч	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат		Шүүхийн шат	
	Санал, хүсэлт гаргах	Шийдвэрлэх	Санал, хүсэлт гаргах	Шийдвэрлэх
Гэрч, хохирогч, өмгөөлөгч хүсэлт гаргах	Тийм	Прокурор	Тийм	Шүүгч
Мөрдөгч санал гаргах	Тийм		Үгүй	
Прокурор санал гаргах	Үгүй		Тийм	

Түүнчлэн, шүүгч, прокурор, мөрдөгчийн зүгээс дээрх хүснэгтэд дурдсан гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын нийт 11 арга хэмжээг харилцан адилгүй авахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт зохицуулсан байна.

Үүнийг дараах хүснэгтээр харуулж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ[42]

Д/д	Арга хэмжээ	Хэрэглэх шийдвэр гаргах этгээд	Арга хэмжээ авах этгээд
1	Тодорхой үйлдлийг хязгаарлах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
2	Биечилсэн хамгаалалтад авах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
3	Мэдээллийн нууцлалыг хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
4	Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
5	Нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
6	Нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
7	Шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
8	Гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч
9	Гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах	-	шүүгч

41 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1 дүгээр зүйл
42 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1, 13.2 дугаар зүйл

10	Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх	-	шүүгч
11	Шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэж болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах	-	шүүгч
12	Гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах	мөрдөгч	мөрдөгч

Энд анхаарах зүйл бол, гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах тухай шийдвэр хэрэгжих боломжтой буюу тодорхой байх нь зүйтэй юм. Энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан байна. Тодруулбал, гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгана:

- Аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;
- Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;
- Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;
- Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

Түүнчлэн, гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчийн мэдлэг, чадвар үндсэн нөхцөл болж байна. Энд анхаарах зүйл бол, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгчийн зүгээс гэрч, хохирогчийг хамгаалах нөхцөл, шаардлага, үндэслэлийн талаар нэг мөр ойлголттой байх нь зүйтэй юм.

Хохирогч хамгаалах арга хэмжээ

- Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болтол яллагдагч, шүүгдэгчийг саатуулах байранд үргэлжлүүлэн хорих талаар анхаарч ажиллах. Хохирогч болон түүний гэр бүл, ойр дотнынхныг айлган сүрдүүлэх, заналхийлэх, хүчирхийлэхээс хамгаалахын тулд сэжигтэн/яллагдагчийг батлан даалтаар гаргахыг хүчтэй эсэргүүцэх хэрэгтэй. Энэ хугацаанд хохирогчийг хамгаалах байранд хамгаалалтад байлгана.
- Хохирогчийн эцэг эх/асран хамгаалагч/нөхөр/хамаатан садан гэгдэх хүмүүст хохирогчийг (ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд) шууд шилжүүлж болохгүй. Эдгээр хүмүүс нь “асран хамгаалагч” нэрийн дор нуугдан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн жинхэнэ хэрэгтэй холбоотой байх боломжтой байдаг. Тэдний гарт дахин орвол, хохирогчийг мөлжлөг үйлдэж байсан газарт буцаан аваачиж, гэмт үйлдлээ үргэлжлүүлнэ.
- Монгол Улсад дагаж мөрдөж буй Хүн худалдаалахын эсрэг хуульд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүний нэр төрийг хамгаална гэж заасан байдаг. Прокурорууд тухайн хохирогч хэн болохыг шүүхийн сонсголыг оруулаад бүхий л үйл ажиллагааныхаа туршид нууцлан ажиллах шаардлагатай.
- Зайлшгүй шаардлагатай л биш бол прокурор хамгаалах байранд эсвэл тэдний байрлаж байгаа аливаа газарт очиж гэрч-хохирогчтой уулзахгүй байх хэрэгтэй. Зайлшгүй шаардлага гарвал уулзаж болох ч аль болох болгоомжтой төлөвлөж уулзах хэрэгтэй.
- Шүүхийн хуралдааны ажиллагааны аль нэг үе шатанд (шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны өмнө болон явагдаж байх үед) тухайн газарт аливаа хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтоох. Дотоодын хууль тогтоомжид тусгайлан заагаагүйгээс шалтгаалаад үүнийг хэрэгжүүлэх боломж зарим тохиолдолд байдаггүй. Гэвч хүн худалдаалах хэрэг дээр ажиллаж байгаа прокурор шүүх ажиллагааг шударга явуулах үүднээс ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд холбогдсон гэмт хэргийн үед яллагдагчийн эрхийг зөрчилгүйгээр хохирогчийг хамгаалах арга хэмжээ авч өгөхийг шүүхээс хүсэж болно. Үүнд дараах зүйлс багтаж болно:

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн төлөөлөлгүйгээр шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах. Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог шинж чанараас шалтгаалаад, хүүхэд эмэгтэйчүүд холбогдсон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах хүсэлтээ прокурор шүүхэд гаргаж болно.
- Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын бичлэгийг нууцлах.
- Зарим үед шүүхийн байран доторх өөр өрөөнөөс, эсхүл тухайн байрны гадна байрлалаас дүрс болон аудио бичлэгээр мэдүүлэг өгүүлэх ажиллагааг зохион байгуулах
- Хохирогч гадаад улсаас хил дамнан худалдаалагдаж ирээд, хууль сахиулах албан хаагчид аврах ажиллагаа явуулсны дараа (шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өмнө) эх орондоо буцсан тохиолдолд видео линк ашиглах шаардлага гарч болно.
- Гэрч-хохирогчийг шүүхийн танхимд яллагдагч болон бусад гэрчүүдээс тусгаарлах таславч хэрэглэх.
- Гэрч-хохирогч, яллагдагч, бусад гэрч нарыг өөр өөр хүлээлгийн өрөөнд байлгах.
- Гэрч-хохирогчийг хамгаалахад ямар байдлаар оролцож болох талаар шүүхийн албан хаагчдад мэдээлэл өгөх.
- Шүүх хуралдаанд очих, буцах замын аюулгүй байдлыг хангах.
- Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хохирогчийн хэн гэдгийг нийтэд зарлахгүй байх явдлыг баталгаажуулах

- Ихэнх тохиолдолд ямар нэг тусгай арга хэмжээ авахаар байгаа тохиолдолд шүүхээс урьдчилж зөвшөөрөл авах хэрэгтэй бөгөөд шүүх хуралдааны ажиллагаа эхлэхийн өмнө шүүх бүрэлдэхүүнд энэ талаар мэдэгдэх.
- Мөрдөгчтэй хамтарч хохирогчийг гэр бүлд нь буцаасны дараа эсвэл хамгаалах байранд үлдэхээр шийдсэн эсвэл өөрийн гэр оронтой болохоор болсон тохиолдолд хохирогчид ямар эрсдэл учирч болзошгүй, түүнээс хамгаалах ямар арга хэмжээ авч болохыг прокурор тодорхойлно.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын энэ хэсэгт Дасгал ажил 9-д гарсан хохирогчийг хамгаалах ямар ямар арга хэмжээ авч болохыг суралцагчидтай ярилцана уу. Суралцагчдыг хоёр багт хуваана. Нэгдүгээр баг шүүн таслах ажиллагаанаас өмнө болон дараа хамгаалах арга хэмжээг жагсааж бичнэ. Хоёрдугаар баг шүүн таслах ажиллагааны үеэр хохирогчийг хэрхэн хамгаалах аргуудыг жагсаана. Баг дотроо ярилцсан зүйлсээ бусадтайгаа хуваалцана.

СЭДЭВ 7: МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСНЫ ДАГУУ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ХОР УРШГИЙГ АРИЛГАХ

1. ЯЛ ОНОГДУУЛАХ

Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байх үедээ прокурорууд яллагдагчид шүүхээс ял шийтгэл оноохтой холбоотой хуулийн чухал элементүүдийг сайтар мэдэж байх хэрэгтэй. Ял шийтгэлийг оноох нь шүүхийн бүрэн эрх мэдэл болохоор прокурорууд хуульд ял шийтгэлийг хэрхэн оногдуулахаар заасан байдаг талаар мэдээлэлтэй байх нь чухал юм. Энэхүү мэдлэг, мэдээллээ ашиглан тухайн гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж болох талаар өөрийн зураглалаа гаргаж, шүүгчдийн анхаарлыг татахаар дэлгэж тавьсан баримтууд ял шийтгэл оноох шийдвэрт хэрхэн нөлөөлж болохыг тооцоолно.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим[43]

Хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан ял шийтгэл оногдуулах үйл явц өөр өөр байдаг. Хуулийн олон янзын системийг үзвэл ял шийтгэл оногдуулах зарчим ихэнхдээ дараах байдлаар явагддаг. Үүнд:

- Гэм буруу болон учруулсан хохирлын хэмжээнд тохирсон байх зарчим: Учруулсан хор уршиг, хохирлын хэмжээ, хүн худалдаалах гэмт хэргээс болох мөлжлөгөөс хүртсэн ашгийн хувь хэмжээнд үндэслэн ялыг тооцоолж ногдуулна. Хор хохирол тухайн хохирогч, тэдний гэр бүл ойр дотнынхонд, хамгийн ихдээ тухайн газар орны хүмүүст учирсан байж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан гэм бурууд тохирох эрүүгийн ял оногдуулна.
- Шийтгэх болон цээрлүүлэх зорилтыг хангасан байх зарчим: Ял шийтгэлийг тухайн гэмт хэргийг үйлдэж нийгмийн харилцаанд хор хохирол учруулсных нь төлөө оногдуулдаг. Урьдчилан сэргийлэх зорилгыг хангасан байх зарчим(ерөнхий болон тусгай аль аль нь): Ялын ерөнхий урьдчилан сэргийлэх агуулга нь нийгэмд хор, хохирол учруулах явдлыг таслан зогсоох, нийгмийн дэг журмыг хангах явдал юм., Харин тусгай урьдчилан сэргийлэх агуулга нь тодорхой гэмт этгээдийг ижил төрлийн гэмт хэрэг дахин үйлдэхээс нь урьдчилан сэргийлэхэд оршино.
- Засан хүмүүжүүлэх зорилтыг хангасан байх зарчим: Энэхүү зарчмын агуулга нь тухайн ял шийтгэл гэмт этгээдийг засарч хүмүүжүүлэхэд нь тусалснаар нийгэмд хор уршигтай үйлдэл хийхээ больж, сайн иргэн байхад төлөвшүүлэхэд чиглэгддэг.
- Таслан зогсоох болон тусгаарлах зорилтыг хангах зарчим: Нийгмээс гэмт этгээдийг тусгаарлаж, бусдад хор хохирол учруулах боломжийг нь хязгаарлахад энэ зарчмын мөн чанар оршино.
- Засан сэргээх зорилтыг хангах зарчим: Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө хохирогчийн амьдарч байсан хэвийн байдалд нь эргүүлэн оруулж, тэрхүү хуучин нөхцөл байдлын тэнцвэрийг засан сэргээхэд энэ зарчмын агуулга оршино.

43 Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл онооход харгалзан үзэх зүйлс, Модуль 14, Хууль сахиулах албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Вена, 2009

Ял оногдуулах үе шатанд прокурорын анхаарах зүйлс:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар прокурор шүүн таслах ажиллагаанд Монгол Улсын нэрийн өмнөөс оролцож, нотлох баримтад дүгнэлт хийн, шүүх хуралдааны үеэр тавигдсан ***аливаа асуултад хариулт өгөх, шүүгдэгчид Эрүүгийн хуулийн дагуу*** эрүүгийн хариуцлага оногдуулахад хуулийн зүйл заалтыг хэрхэн хэрэглэх, ялын төрөл ямар байх, хэр урт хугацаанд ямар дэглэмд ял эдлэхтэй холбоотой өөрийн дүгнэлтээ хэлнэ.

2. Дараах тохиолдолд ялыг хүндрүүлж оногдуулна:

- Яллагдагч этгээд өмнө нь хүн худалдаалах гэмт хэрэгт буруутгагдаж байсан эсвэл дарамт, заналхийлэл, хүчирхийлэл ашиглан гэмт хэрэг үйлдэж байсан бол.
- Хохирогчийг амь насаа алдах ноцтой эрсдэлд оруулж байсан эсвэл бие махбодод нь хүнд гэмтэл учруулж байсан. Бэлгийн мөлжлөгийн үед хохирогч ДОХ/ХДХВ зэрэг бэлгийн замын олон халдварт өвчин тусах зэрэг эрүүл мэндэд нь заналхийлсэн эрсдэл дунд байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид стандартын бус, хүнд хэцүү нөхцөл байдалд амьдардаг байсан нь тэднийг олон төрлийн өвчин тусах магадлалыг нэмэгдүүлдэг. Үйлдвэрлэл, барилга болон хөдөө аж ахуйн салбарт албадан хөдөлмөр эрхэлж байсан хохирогчид гэмтэж бэртэх, өвчин тусах эрсдэлтэй байдаг бөгөөд ялангуяа ажлын багаж хэрэгсэл, техник хэрэгсэл нь аюултай эсвэл бүрэн бүтэн байдал нь алдагдсан тохиолдолд энэ эрсдэл илүү өндөр байдаг. Бэртэж, гэмтэж байгаагүй байсан ч ингэх магадлал өндөр орчинд хохирогчийг байлгадаг, ажиллуулдаг байсан нь илүү хамааралтай болж ирнэ.
- Гэмт этгээд зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэргийг хүндрүүлж үзнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн үед хохирогчийг бие махбодын болоод сэтгэл зүйн айдаст байлгаж, мөлжлөг үйлдэхийн тулд зэвсэг ашигласан байх нь олонтоо тохиолддог. Энэхүү хараа хяналтаа чангатгахын тулд зэвсгийг хохирогчийг мэдэх өөр хүмүүс ашигласан байх нь бий. Тухайлбал, зэвсэг ашиглан айлган сүрдүүлж, хэлснийг нь хийхгүй бол гэр бүлийнхэнд нь хохирол учруулна гэж заналхийлсэн байх.
- Хүн худалдаалах гэмт хэрэг ихэвчлэн харгис хэрцгий, балмад байдлаар үйлдэгддэг бөгөөд үүнийг нь яллагдагч/шүүгдэгч мөлжиж байсан хүмүүстээ хүнлэг бус зан авир гаргадаг байснаас тодорхой харж болно. Хүнийг урт хугацааны турш мөлжих, биеэ даасан, бусдаас хараат бус байх эрх чөлөөг нь хасах үйлдэл нь өөрөө уг гэмт хэрэгт хүнд ял шийтгэл оногдуулах шаардлагатайг харуулдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь хохирогчид ихээхэн зэрлэг балмад, хүнлэг бусаар хандах, байнгын хүчирхийлэл зэрэг хохирогчийн эсрэг гэмт хэрэг үйлддэг онцлогтой бөгөөд хохирогчийг хяналтдаа байлгахын тулд хүчирхийлэл байнга үйлдэж байдаг.

Нэмэгдэл ял – Прокурор тухайн хэрэгтэй холбогдуулан "хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдсон өөр ямар төрлийн нэмэгдэл ял оногдуулж болох вэ, өмнө нь төлөвлөсөн ялын санал дээр нэмж ямар нэмэгдэл ялын санал гаргах вэ гэдгийг анхаарч ажиллах шаардлагатай.

САНАМЖ:

Хуулийн хүрээнд ял шийтгэл оногдуулах эрх зөвхөн шүүгчдэд байна. Хэрэг тус бүрийн онцлог байдлаас шалтгаалан гэмт этгээдийн үйлдсэн хэрэг, гэм бурууд тохирсон, ял оногдуулахаас өмнө гэмт хэрэгтэй холбоотой бүх нотолгоог гаргаж ирэх үүрэг нь прокурорт байдаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

“Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн ял шийтгэл оногдуулах”-тай холбоотой дараах сэдвээр суралцагчидтайгаа ярилцана. Үүнд:

- *Ялын төрөл*
- *Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал*
- *Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ*
- *Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ял*

Эрүүгийн хуульд заасан ялын төрөл, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ, хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ялын талаарх хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

2. НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛӨХ

Гэмт хэргийн хохирогчид бие махбодын болоод сэтгэл санааны хохирол учруулсныхаа төлөө нөхөн төлбөр төлөх явдал байдаг. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөлжлөгөөс улбаатай сэтгэл зүйн эмгэгээсээ гарахад шууд нөлөөлөхгүй ч нөхөн сэргэхэд нь, эргэн нийгэмшихэд нь хохирогчид үүссэн хорсол, цөхрөлийг намжаах нэг боломж нь болж өгдөг. Үүгээр дамжуулан ижил төрлийн гэмт хэрэгт дахин өртөх магадлалыг бууруулж, эдийн засгийн хувьд тодорхой хэмжээнд биеэ даасан болоход нь нэмэр болдог.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколын 6-р зүйлийн (6)-д Оролцогч улсууд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч өөрт үүссэн хохирлын хариуд нөхөн төлбөр авах хууль эрх зүйн заалттай байх талаар анхаарал хандуулан ажиллана гэж заасан байдаг.

Прокурорууд хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжоо сайн мэддэг, үүндээ үндэслэн гэмт хэргийн хохирогчид ямар хохирол учирсан үед хэрхэн нөхөн төлүүлэх талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Прокурор аль болох хангалттай хэмжээний хэмжээний хохирлыг шүүхээр шийдвэрлүүлэн хохирогчид олгохыг хичээн ажиллах ёстой. Хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэрээр эсвэл захиргааны журмаар зохион байгуулна. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх гэж байгаа тохиолдолд дараах байдлаар хийгдэнэ. Үүнд:

- Шүүн таслах ажиллагааны төгсгөлд гэм буруутай этгээдээр хохирогчид нөхөн төлбөр төлүүлэх шийдвэр гаргах;
- Хохирогч тусдаа иргэний нэхэмжлэх гаргах;
- Хөдөлмөрийн маргааныг таслах шүүх болон харьяа шүүхдээ нөхөн төлбөр/ хохирол аваагүй цалин хөлснийхөө талаар нэхэмжлэх гаргах.

Учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарах зүйлс

- Практик туршлагаас харахад нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирогчийн сонирхол, хэрэгцээ, гэм хор учруулсан нөхцөл байдал, гэмт этгээдийн гэм буруу болон хохирогчид учирсан хохирлын хэмжээг харгалзаж үздэг.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирогч гэмт этгээдийн учруулсан хохиролд нөхөн төлбөр нэхэмжлэн шүүхэд иргэний нэхэмжлэх гаргах эрхтэй. Прокурор энэ эрхийнх нь талаар хохирогчид зөвлөж хэлэх хэрэгтэй.

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэний нэхэмжлэх гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд учирсан хохирлын хэмжээ, гэмт хэргийн нөхцөл байдал зэргийн Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хуульд үндэслэн тогтоогдоно гэдгийг прокурор тайлбарлан хэлэх нь зүйтэй.
- Прокурор хохирогчид олгох нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх шаардлагатайг нотлохын тулд дараах зүйлсийг шүүгчдэд тайлбарлах хэрэгтэй. Үүнд:
  - Хохирогчийн бие махбод, сэтгэл зүй, сэтгэлийн хөдлөл, бэлгийн болон санхүүгийн хүчирхийллийн шинж чанар, хохирогчийн амьдралд үзүүлсэн нөлөө;
  - Мөлжлөгийн улмаас үүссэн бие махбодын гэмтэл бэртэл, өвчин хууч;
  - Албадан хөдөлмөр эрхэлж байсан хохирогчид маш бага эсвэл огт цалин хөлс өгч байгаагүй;
  - Гэмт хэргээс улбаатай бусад хохирол.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой дараах сэдвээр суралцагчидтайгаа ярилцана. Үүнд:

- *Хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн хуулийн холбогдох зүйл заалтууд;*
- *Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явц;*
- *Шүүхээс хохирол нөхөн төлүүлэх шийдвэр гарсан тохиолдолд прокурорын гүйцэтгэх үүрэг;*
- *Хохирогчид учирсан хохиролд үндэслэн шүүхэд иргэний нэхэмжлэх гаргасны дагуу шийдвэрлэгдэх Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалт;*
- *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд иргэний нэхэмжлэх гаргах, үүнд прокурорын гүйцэтгэх үүрэг;*

Хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Засгийн газраас олгох нөхөн төлбөр

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод улсаас олгодог нөхөн төлбөр гэж байдаг. Практикаас харвал, зарим улс оронд ихэвчлэн хэрцгий балмад шинж агуулсан бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод нөхөн төлбөр олгоход зориулсан тусгай бодлого байдаг. Улсын төсвөөс санхүүжүүлэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох нь давуу талтай байдаг бөгөөд энэхүү бодлогын хүрээнд хэн нэгэн гэмт этгээдээр нөхөн төлбөр төлүүлэх шаардлага гардаггүй.

Засгийн газраас хохирогчдод нөхөн төлбөр олгохтой холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

МОДУЛЬ - 9

ШҮҮГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү модулийн зорилго нь шүүгчдэд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн шүүн таслах ажиллагааг хохирогч төвтэй арга хэлбэрээр явуулах мэдлэг, чадвар олгоход оршино.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийн шүүх хуралдааны үеэр анхаарах зүйл

Сэдэв 2 Шүүгдэгчийн өмгөөлөгчийн түгээмэл хэрэглэдэг арга, тактик, улсын яллагчийн хариу няцаалт

Сэдэв 3 Шүүн таслах ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь

Сэдэв 4 Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хохирогчийн хэрэгцээ, тэдний эрхийг мөрдөн шалгах ажиллагааны үед эсвэл шүүх хуралдааны өмнө болон дундуур л хангаж ажиллах бус гэмт хэргийг шийдвэрлэж дуустал анхаарч ажиллах нь чухал юм.
- Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой мөрдөгдөж буй хуулийн холбогдох заалтууд хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд мөн адил ашиглагдана. Шүүгдэгч этгээд мөлжих зорилгоор хүний биеийг үнэлүүлэх, албадан эсвэл боолын хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг бусад хэргийг хэрхэн шийдвэрлэдэгтэй адилаар явуулна.
- Гэмт этгээдийг эрүүгийн хэрэгт татах, мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагааг явуулахдаа яллагдагчийн эрхийг хөндөлгүй явуулдгийн адилаар хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд ч мөн адил дагаж мөрдөнө.
- Шүүгчийн хамгийн түрүүнд харгалзан үзэх ёстой зүйл бол хохирогч шүүн таслах ажиллагааны талаар мэдлэг муутай байх, айж эмээх, эсвэл үл тоомсорлож байгаа эсэх явдал бөгөөд энэ тохиолдолд хохирогч төвтэй арга барилаар ажиллах шаардлагатай.
- Хүн худалдаалах гэмт хэргийн үед шүүгдэгчийн өмгөөлөгч үйлчлүүлэгчээ хамгаалах ямар арга хэрэглэхийг урьдчилан тааварлаж, тооцоолсноор хохирогчийн мэдүүлэг, түүнд өгөх улсын яллагчийн хариу няцаалтын талаар бүрэн ойлголттой болсон байх боломжтой.
- Мөрдөгч болон улсын яллагчийн нэгэн адил шүүгч нар ч гэрч, хохирогчийг хамгаалах үүрэгтэй бөгөөд цагдаагийн албан хаагч, улсын яллагч нар энэ чиглэлээр арга хэмжээ авах шийдвэр гаргаж болно.
- Ял оногдуулах үндсэн зарчимд үндэслэн шүүгч тухайн гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж болох талаар өөрийн дүр зураглалаа гаргаж, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон ялыг шударгаар ял оногдуулах нь зүйтэй.
- Нөхөн төлбөр төлүүлэх, хохирлыг барагдуулах нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөлжлөгөөс улбаатай сэтгэл зүйн эмгэгээсээ гарахад шууд нөлөөлөхгүй ч нөхөн сэргэж, нийгэмд эргэн ороход нь хохирогчид үүссэн хорсол, цөхрөлийг намжаах нэг боломж нь болж өгдөг тодийгүй ижил төрлийн гэмт хэрэгт дахин өртөх магадлалыг бууруулж, эдийн засгийн хувьд тодорхой хэмжээнд биеэ даасан болоход нь нэмэр болдог.

Сургалтын хугацаа - 3 цаг (180 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх,
- Суралцагчдад тараах материал, дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх,
- Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх.

Модуль 9: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа / мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн шүүх хуралдааны үеэр анхаарах зүйл	Лекц/ хэлэлцүүлэг	40	Сэдэв 1
Сэдэв 2	Шүүгдэгчийн өмгөөлөгчийн түгээмэл хэрэглэдэг арга, тактик, улсын яллагчийн хариу няцаалт	Лекц/хэлэлцүүлэг	30	Сэдэв 2
	Дасгал ажил 10: Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж, дүрд тоглох байдлаар шүүх хуралдаан явуулах	Дасгал ажиллах	60	Дасгал ажил 10
Сэдэв 3	Шүүн таслах ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь	Лекц/хэлэлцүүлэг	15	Сэдэв 3
Сэдэв 4	Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах	Лекц/хэлэлцүүлэг	20	Сэдэв 4

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ҮЕЭР АНХААРАХ ЗҮЙЛ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн шүүх хуралдааныг эхлүүлэхтэй холбогдох зүйл заалтыг сургалтын энэ хэсэгт ашиглана уу. Бүх төрлийн гэмт хэрэгт адилхан ашигладаг учраас сургалтад хамрагдаж буй шүүгчид эдгээр зүйл заалтын талаар гүнзгий мэдлэгтэй байх ёстой. Сургагч багш энэхүү бүлгийн туршид суралцагчдад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох зүйл заалтын талаар тусгайлан ярина.

Шүүгч эрүүгийн хэргийн шүүх хурлыг эхлүүлэх анхан шатны ажиллагаа, 18 насанд хүрээгүй хохирогчтой холбоотой шүүх хуралдааныг "хаалттай явуулах"-тай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Мөрдөн шалгах ажиллагаа хийгдсэний дараа мөрдөгч гэмт хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, баримт нотолгоо, гэмт этгээдэд оногдуулах ял зэргийг багтаасан яллах дүгнэлт

үйлдүүлэх тухай саналыг бэлтгэнэ. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүн таслах ажиллагаанд эрүүгийн хэрэгт яллах болон өмгөөлөх талууд тэгш эрхтэйгээр оролцох зарчимтай. Тухайн хүнийг яллагдагчаар татсан гэмт хэргийн зүйлчлэл, эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээ хуульд нийцэж байгаа эсэхийг улсын яллагч хянах үүрэгтэй. Гэмт хэрэг үйлдсэнийг нотлох хангалттай баримт нотолгоо байгаа бол прокурор тухайн хүнийг яллагдагчаар татах тогтоол гаргана. Шүүхийн шатанд ирсэн эрүүгийн хэрэгт шүүгч дараах шийдвэрүүдийг гаргах боломжтой. Үүнд:

- Шүүгдэгчийг шүүх хуралдаанд дуудах;
- Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах;
- Хэргийг хэрэгсэхгүй болгох;
- Хэргийг зохих газарт нь шилжүүлэх.

Хохирогч/шүүгдэгч/гэрчүүдийн эрх хэрэг бүртгэх болон мөрдөн шалгах ажиллагааны шатанд ямар нэг байдлаар зөрчигдөөгүй гэж шүүгч үзвэл шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд асуудалгүй гэсэн үг бөгөөд шүүх хуралдааны товыг гаргаж, шүүгдэгчийг ирүүлэхээр зарлан дуудах шийдвэр гаргана.

Шүүх хуралдааныг явуулахаас өмнө шүүгч хоёр зүйлд нэн даруй анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай. Нэгдүгээрт, шүүгдэгчид барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хоёрдугаарт хохирогчийн эрх ашгийг хамгаалах. Ял оногдуулахад харгалзан үзэх шаардлагатай дээрэх хоёр зүйл болон бусад зүйлсийн талаар хойно дурдах болно.

1. ШҮҮХ ХУРАЛДААНЫГ ШУДАРГА ЯВУУЛАХ

Шүүх хуралдааныг шударга явуулах хоёр үндсэн зарчим байдаг бөгөөд үүнд улсын яллагчийн хангалттай нотлох баримт гол үндэс суурь нь болж өгдөг.

Баримтаар нотлох үүрэг: Эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэхэд улсын яллагч нотлох үүрэг хүлээдэг. Ийм учраас шүүгдэгчийн гэм бурууг зөвхөн улсын яллагч нотлох ёстой.

Гэм буруугүйд тооцох зарчим: Аливаа эрүүгийн хэрэгт шүүгдэгчийн гэм бурууг шүүхээр тогтоох хүртэл түүнийг гэм буруугүйд тооцно.

Шүүх хуралдааныг шударга явуулахад чиглэсэн дээрх үндсэн хоёр зарчмыг мөрдөж ажиллана гэдэг нь шүүгдэгч тухайн гэмт хэргийг үйлдсэнийг нотлох баримт хангалттай байх ёстойг харуулж байна. Гэм буруутай этгээдийн гэмт үйлдлийг нь нотолж чадахгүй, цуглуулсан нотлох баримт нь нотолгоо болох боломжгүй нөхцөлд шүүх хуралдааны үеэр шүүгдэгч ямар нэг баримт гаргаж ирээгүй байсан ч гэм буруугүйд тооцно.

Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох баримтыг улсын яллагч өөрийн итгэл үнэмшилд үндэслэн бүрдүүлэхийн зэрэгцээ шүүх хуралдааныг шударга, алагчлалгүй явагдаж байгаад хяналт тавин ажиллах үүрэгтэй. Улсын яллагчийн энэхүү үүрэг нь хүн худалдаалах гэмт хэргээр хязгаарлагдахгүй бусад бүх хэргүүдэд мөн адил үйлчилнэ. Улсын яллагч шүүх хуралдааныг шударга явуулах зарчмыг дагахдаа шүүгдэгчийн эрхийг ч хөндөлгүй ажиллахыг шүүгч хянаж ажиллана.

САНАМЖ:

Шүүгчийн гүйцэтгэх үүрэг бол хохирогч төвтэй арга барилаар хохирогчид ээлтэй байдлаар шүүх хуралдааныг явуулахдаа шүүгдэгчийн эрх ашгийг тэнцвэртэй харгалзан шударга ёсыг хангахад оршино.

2. СЭЖИГТЭН/ШҮҮГДЭГЧЭЭС БАРЬЦАА АВАХ БОЛОН ХУВИЙН БАТАЛГАА ГАРГАХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Аливаа орны хуульд заасан барьцаа авах болон хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авч болох гэмт хэргийн жагсаалтын дагуу шүүгдэгч барьцаа өгөх эсвэл хувийн баталгаа гаргах хүсэлтээ гаргах эрхтэй. Хүн худалдаалах гэмт хэрэгт шүүгдэгч барьцаа өгөх, хувийн баталгаа гаргах хүсэлтээ гаргасан бөгөөд барьцаа авах эсвэл хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авах нь хууль тогтоомжид харшлаагүй тохиолдолд шүүгч шүүгдэгчид эдгээр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргахдаа тодорхой зарим асуудлуудыг анхааралдаа авах ёстой.

Шүүх хуралдаан болтол сэжигтнийг цагдан хорьсон хэвээр байлгах эсэх асуудлыг хохирогчийн аюулгүй байдлын эрсдэлтэй холбож үзэх шаардлагатай. Хохирогч болон түүний гэр бүл, ойр дотнынхныг айлган сүрдүүлэх, заналхийлэх, хүчирхийлэх магадлал байгаа тохиолдолд хохирогчийг хамгаалахын тулд сэжигтэн/яллагдагчид барьцаа авах эсвэл хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авахыг улсын яллагч маш хүчтэй эсэргүүцэх хэрэгтэй. Эдгээр бүх нөхцөл байдлыг хянан үзсэний эцэст шүүгч яллагдагчид барьцаа авах, хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхээ шийдвэрлэнэ. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч этгээдүүд сүлжээ байдлаар зохион байгуулалттай ажилладаг нь ялангуяа гэрч болохыг зөвшөөрч, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллахаар болсон хохирогчид тодорхой аюул, эрсдэл нүүрлэх боломжийг олгодог. Хохирогчийг хамгаалахын тулд шүүгч нөхцөл байдлыг нарийн үнэлж, яллагдагчид барьцаа авах, хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авахаас татгалзаж болох бөгөөд энэ нь яллагдагчийн эсрэг өгсөн хохирогчийн мэдүүлэг болон бусад нөхцөл байдлын нотлох баримтад үндэслэнэ.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахаар болсон тохиолдолд шүүгч холбогдох хуулийн заалтад нийцсэн тодорхой болзлын дор зөвшөөрөл олгоно.

Барьцаа авах болон хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

3. ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөн, мөлжигдөж байсан хохирогчийг хэргийн газраас аварсны дараа тухайн хохирогч насанд хүрсэн хүн эсвэл хүүхэд эсэх, тухайн улсын харьяат эсвэл гадаадын иргэнээс үл хамаарч тэднийг хамгаалалтдаа авах үүднээс цагдаагийн албан хаагч болон шүүгчээс өмнө хүсэлт гаргадаг. Энэхүү хүсэлтийг шүүх хуралдаан болохоос өмнө мөрдөгч эсвэл прокурор хүлээн авах үүрэгтэй. Хохирогчийг асран хамгаалахаар "эцэг, эх, эгч, ах, нөхөр, найз залуу, авга, нагац нар болон хамаатан садан" гэгдэж байгаа, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээд байж болзошгүй ямар ч хүнд хохирогчийг шилжүүлж өгч болохгүй.

Хохирогчийн "гэр бүлийн гишүүн/асран хамгаалагч" нэрийн дор гэмт хэрэг үйлдэж байгаа

жинхэнэ гэмт хэрэгтэнд хохирогчтой зөвшилцөлгүйгээр, хохирогчийн хэрхэн гэмт хэрэгт өртсөн талаар нягт нямбай судлалгүйгээр гэр бүлийнх нь гишүүн гэдэгт нь үндэслэн шилжүүлж өгвөл мөлжлөгт дахин өртөх үүд хаалгыг нээсэнтэй адил хэрэг болно. Мөн шүүхэд мэдүүлэг өгөхөөр зөвшөөрсөн хохирогч ор сураггүй алга болох аюул эрсдэл байдаг.

САНАМЖ:

Гэмт хэргийн хохирогчийг ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг тэдний эцэг, эх/ асран хамгаалагч/ нөхөр/ хамаатан садан нь гэгдэж байгаа хүмүүст шууд шилжүүлж өгөхийг зөвшөөрч огт болохгүй. Ар гэрийнх нь нөхцөл байдал, хохирогчийн талаар бүрэн сайн судлагдахыг хүлээ. Энэ хооронд хохирогч хамгаалах байранд аюулгүй байлгана.

4. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ЯЛ ОНОГДУУЛАХ НЬ

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар хангалттай нотлогдвол, прокурор яллах дүгнэлт үйлдэж шүүгдэгчийг хүн худалдаалах гэмт хэрэгт буруутайд тооцож.

Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож байгаа тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, байршил зэрэг нөхцөл байдлын талаар тусгасан шүүхийн тогтоол гарна. Шүүгдэгч Эрүүгийн хуулийн холбогдох заалтад дурдсан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн зүйл заалт тус бүрээр ямар ял шийтгэл оноож буйгаа тодорхой гаргана. Шүүгчийн үүрэг бол шүүгдэгч ямар зүйл ангиар буруутгагдаж байгаа эсэхийг хянахад оршино.

Шүүгдэгчийн гэм буруутай үйлдэлд тохирсон ял оногдуулахад харгалзан үзэх шаардлагатай чухал зүйлсийн (улсын яллагчийн гүйцэтгэх үүрэгтэй мөн холбогдоно) талаар шүүгчдэд өгөх мэдээлэл, яллах дүгнэлт танилцуулахад анхаарах зүйлс хэсэгт дахин өгүүлэх болно.

Ял оногдуулахад анхаарах зүйлс

1) Хохирогчийг гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй байх – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч энэ төрлийн гэмт хэрэгт өртсөний улмаас үйлдсэн гэмт хэрэгтээ буруутай гэж тооцогдохгүй, ял шийтгэл хүлээхгүй байх талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ мөрдөгддөг. Тухайлбал, биеэ үнэлэх, хууль бусаар хил нэвтрэх, хууль бусаар ажил хөдөлмөр эрхлэх гэх зэрэг үйлдэлдээ буруутай гэж тооцогдох ёсгүй. Энэхүү гэмт хэрэгт хүүхэд өртөж, хохирогч болсон тохиолдолд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол улсын 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 оны Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу тэдний эрхийг хамгаалж, тусгай хамгаалалтад авч ажиллахад анхаарлаа хандуулах ёстой.

2002 онд батлагдсан "НҮБ-ын Хүний эрх, хүн худалдаалах гэмт хэрэгт баримтлах зарчим, зөвлөмж"-ийн дагуу гэмт хэргийн хохирогч дараах үйлдлийнхээ төлөө хоригдож, аливаа ял шийтгэл, хариуцлага хүлээхгүй болохыг тусгайлан дурдсан байдаг. Үүнд:

- Дамжин өнгөрсөн болон эцсийн цэгт хүрэх зорилгоор аль нэг улс оронд хууль бусаар нэвтэрсэн;
- Дамжин өнгөрсөн болон эцсийн цэг болох улс оронд хууль бусаар оршин сууж байсан;
- Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас аливаа хууль бус үйлдэлд холбогдож байсан.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд гадаад болон дотоодын хохирогч ямар статустай байхтай холбогдох зүйл заалтыг сургалтын энэ хэсэгт ашиглана уу. Мөн хохирогч хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөний улмаас үйлдсэн гэмт хэрэг зөрчилд ял шийтгэл хүлээхгүй байхтай холбоотой хуулийн зүйл заалтын талаар суралцагчдад мэдээлэл өгнө.

2) Яллагдагчаар татах, яллах дүгнэлт үйлдэх – Гэмт хэргийн шинжийг тодорхой болгосны дараа улсын яллагч баримтад тулгуурлан ялыг оногдуулахад хууль зүйн үүднээс үндэслэл бүхий сэжиг байгаа эсэхийг тодорхойлж, цугларсан нотлох баримтыг үнэлэх үүрэгтэй. Тухайн гэмт хэргийн шинжийн аль нэг хэсгийг нотлох баримт хангалттай биш гэж үзвэл бусад шинж хангалттай нотлогдож байсан ч улсын яллагч яллагдагчаар татах саналыг буцаах эрхтэй.

Улсын яллагч дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Хохирогч нь насанд хүрсэн хүн байгаа тохиолдолд 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу улсын яллагч "хүн худалдаалах гэмт хэрэг" үйлдэгдсэн гэдгийг юугаар нотлох хэрэгтэй вэ?
- Хохирогч нь хүүхэд байгаа тохиолдолд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар "хүүхдийг худалдаалах гэмт хэрэг" үйлдэгдсэн гэдгийг юугаар нотлох хэрэгтэй вэ?
- Насанд хүрсэн хүн эсвэл хүүхдийн биеийг үнэлүүлсэн, садар самуун сурталчилгаанд ашигласныг 2015 оны Эрүүгийн хуульд заасны дагуу юугаар нотлох вэ?

Дээрх хуулийн заалт ёсоор албадан хөдөлмөр эрхлүүлсэн, гуйлга гуйлгуулсан, хүчээр гэрлүүлсэн эсэхийг юугаар нотлох вэ?

Үүнтэй адилаар шүүгчид хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн шинийг тодорхойлж, тэр нь нотлох баримт болон мэдүүлгээр нэг бүрчлэн батлагдаж байгаа эсэхийг харьцуулан үзэх ёстой.

3) Нэмэгдэл яллагаа – Улсын яллагч тухайн хэрэгтэй холбогдуулан "хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдсон өөр ямар үйлдлүүдэд нэмж яллаж болох вэ, өмнө нь төлөвлөсөн ялын оронд ямар зүйл анги илүү тохиромжтой байх вэ?" гэдэг дээр үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь олон гэмт хэрэгтэй давхар үйлдэгддэг. Улсын яллагч нь Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар хүн худалдаалах гэмт хэргээс гадна хүчирхийлэл, хүн хулгайлах, хууль бусаар хорих, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, нууцаар үгсэн хуйвалдах, хүчиндэх, насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, хүүхдийн хүчирхийлэл, садар самууны сурталчилгаа, хулгай, гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих, хөдөлмөрийн хууль зөрчих, цалин хөлс олгохгүй байх, ажил олгогч бэлгийн дарамтад оруулах зэрэгтэй холбоотой бүхий л зүйл заалтыг ашиглах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагад мэдүүлэг өгөх үйл явцад нөлөөлөх гэж оролдсон гэмт этгээдийг хохирогч гэрчилж чадвал улсын яллагч гэмт этгээдийг гэрчийн мэдүүлэгт нөлөөлөхийг оролдсон эсвэл шүүх ажиллагаанд саад учруулсан үндэслэлээр нэмж яллаж болно.

Гэмт этгээд хууль бус аргаар олсон орлогоо ихэвчлэн хууль бус байдлаар нуухыг оролддог тул мөнгө угаах гэмт хэрэг нэмэлт байдлаар орж ирэх боломжтой. Мөрдөн шалгах ажиллагаатай зэрэгцээд санхүүгийн шалгалт явуулах нь улсын яллагч тухайн ямар гэмт хэрэгт яллагаа явуулах талаар оновчтой шийдвэр гаргахад тусална.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүж байхдаа тухайн этгээд гэмт хэрэг үйлдэхдээ гарааны газраас эхлээд мөлжлөг үйлдэх газар хүртлээ олон төрлийн гэмт хэрэг үйлдсэн байх магадлалтай байдгийг шүүгчид харгалзан үзэх шаардлагатай. Бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхлүүлэхээс гадна олон төрлийн гэмт хэрэг дагалдан үйлдэгддэг тул ял оногдуулахдаа үүнийг нэг бүрчлэн тооцож, гэмт этгээдэд тэдгээрт нь тохирох ял шийтгэл шударгаар оногдуулах ёстой.

СЭДЭВ 2: ШҮҮГДЭГЧИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭДЭГ АРГА, ТАКТИК, УЛСЫН ЯЛЛАГЧИЙН ХАРИУ НЯЦААЛТ

1. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙН ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХДАА ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭДЭГ АРГА

Шүүгдэгч өөрийгөө хамгаалах талаар мэдүүлэг өгч, улсын яллагч түүнийг нь няцаадаг ч шүүгчид хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ямар арга байдлаар өөрсдийгөө хамгаалдаг талаар гүнзгий мэдлэг, мэдээлэлтэй байх нь чухал. Шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг шийдвэрлэхэд энэхүү мэдлэг, туршлага чухал ач холбогдолтой төдийгүй хохирогч ямар учир шалтгааны улмаас мөлжлөгийн явцад тухайн зан авирыг гаргадаг байсан талаар ойлголттой болсон байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүний өмгөөлөгч яллагдагчаа өмгөөлөхөд хэрэглэдэг бүх аргуудыг урьдчилан тооцох боломжгүй юм. Гэхдээ энэ төрлийн гэмт хэрэгт хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах түгээмэл хэд хэдэн арга байдаг. Зарим нь хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтод тодорхой заасан гэмт хэргийн нэг эсвэл хэд хэдэн шинжийг үгүйсгэхийг оролддог бол бусад нь хохирогчид итгэж болох эсэхэд эргэлзэж байгаа тухайгаа гаргаж тавьдаг. Дийлэнх тохиолдолд дээр дурдсан аргуудыг нийлмэл байдлаар ашигладаг. Хүн худалдаалах гэмт хэрэгт өөрийгөө хамгаалах дараах аргууд түгээмэл ашиглагддаг. Үүнд:

Зөвшөөрөл - Хамгийн түрүүнд мөн түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь хохирогчийг хүчлээгүй мөн хууран мэхлээгүй гэж итгүүлэх явдал байдаг. Өмнө нь хохирогч өөрөө санал болгосон, эсхүл урьдчилан тохиролцож, ажиллах нөхцөлийн хүрээнд тухайн хүн ажиллаж байсан гэх мэт. Иймэрхүү мэдүүлэгт хүч хэрэглэж, заналхийлсэн шинж тэмдэг илэрхий харагдахгүй, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг олж тогтооход хүндрэлтэй байдаг. Зөвшөөрлийг нь авсан эсэхтэй холбоотойгоор сэжигтэн дараах зүйлсийг ихэвчлэн хэлдэг. Үүнд:

- Хохирогч тухайн газраас оргож, зугтаагүй;
- Хохирогчийг түгжиж, гав, гинжээр хүлээгүй байсан. Тийм учраас ямар ч гэмт хэрэг үйлдэгдээгүй;
- Хохирогч энэ талаар хэн нэгэнд хэлж огт гомдол гаргаж байгаагүй;
- Өөрөө явах боломжтой байсан;
- Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд хохирогч болсон тохиолдолд гэмт этгээдүүд тухайн хүүхдийн эцэг эх/асран хамгаалагч нь сайн дураараа хүүхдээ ажил хийлгэхээр

урьдчилан ярилцаж тохиролцсон гэж мэдүүлдэг.

Ойлголцлын зөрүү – Хоёр дахь түгээмэл хэрэглэгддэг өөрийгөө хамгаалах арга нь болж өнгөрсөн бүх зүйл нэгнийгээ буруу ойлгож, ойлголцлын зөрүүтэй байснаас боллоо гэсэн тайлбар юм. Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүн хохирогчид туслахыг л хүсэж байсан сайн хүн мэтээр аашилна. Энэхүү үйлдэл нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Хохирогч өөрийн улс орон эсвэл гэртээ байхдаа маш хүнд хэцүү амьдралтай байсан бөгөөд одоо хамаагүй дээр нөхцөл байдалд байгаа;
- Яллагдагч этгээд хохирогчид туслахыг л хүсэж байсан бөгөөд түүнд ажил олж өгч, амьдрах байраар ханган, хийсэн ажлынх нь хөлсийг төлж байсан, түүнд сайхан сэтгэлээр хандаж, тусалдаг байсан;
- Хохирогч болсон хүүхэд эсвэл эцэг, эх нь тухайн хүүхдийн насыг үнэн зөвөөр нь хэлээгүй, хуулийн дагуу насанд хүрсэн гэж бодоод ажлаар хангаж байсан зэрэг болно.

Итгэл, үнэмшилтэй байдал - Гурав дахь түгээмэл хэрэглэгддэг арга нь үнэн ярьж байгаа хүн нь хохирогч биш, сэжигтэн өөрөө юм гэж үнэмшүүлэх. Хохирогч худлаа ярьж байгаа эсвэл юу ярихаа мэдэхгүй байх тохиолдол байна. Улсын яллагч гэмт хэрэг үйлдэгдсэнийг нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж, баталгаажуулж чадаагүйгээс яллагдагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болох тохиолдол ч гардаг. Дараах тохиолдолд хохирогчийн мэдүүлэг итгэл, үнэмшилтэй байж чаддаггүй. Үүнд:

- Өмнө нь зөрүүтэй мэдүүлэг өгч байсан;
- Мэдүүлэг авч байх үед өөр хоорондоо зөрчилдсөн мэдээлэл өгч байсан;
- Хохирогчийн мэдүүлгийг няцаах биет нотлох баримт гаргаж ирэх;
- Хохирогч худлаа хэлэх шалтгаантай байсан: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид л үзүүлдэг хууль сахиулах байгууллагын тусламж дэмжлэгийг авах зорилгоор ингэж мэдүүлж байгаа;
- Хохирогч гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь нотлох баримттай учраас түүнд итгэж болохгүй;
- Хохирогч өөрөө гадаад улсын хилийг хууль бусаар давж ирсэн бөгөөд яллагдагч этгээдээс ажил олгохыг хүссэн, хохирогчийг өөрийгөө аваад явах орлогын эх үүсвэртэй байлгахын тулд л ажил олгосон.

Ажлын хөлс – Хохирогчийг ажиллуулсныхаа хөлсийг өгч байсан гэж хэлэх нь өөрийгөө өмгөөлөх дараагийн аргад тооцогддог. Хохирогчид цалин хөлс төлж, байр хоолоор хангаж байсан. Ямар мөлжлөг явагдсан гэж үзэж байгаа юм бэ гэж асуудаг. Үүнийгээ дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

- Хохирогчийн цалин хөлс авч байсан баримт, гарын үсэгтэйгээ байх;
- Бусад ажиллаж байгаа хүмүүстэй адилхан нөхцөл байдалтай байсныг нотлохоор бүртгэлийн дэвтэрт байгаа гарын үсгийг нь үзүүлэх.

Гэмт хэргийн нөхцөл байдал, баримт нотолгооноос хамаараад өөр өөр байж болох ч яллагдагч ихэнхдээ өөрийгөө өмгөөлж, хамгаалахад дээр дурдсан аргуудыг хэрэглэдэг. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн, түүнд оролцсон этгээдийн өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэхийг урьдчилан тооцоолоход нотлох баримт чухал үүрэгтэй байдаг. Нотлох баримтын тоо, чанарт нарийн үнэлэлт дүгнэлт хийж, сул тал байгааг олж харах нь улсын яллагчийн гол үүрэг. Энэхүү сул талыг ашиглаж, гэмт этгээд өөрийгөө хамгаалах ямар арга хэрэглэж болохыг таамаг байдлаар урьдчилан мэдэж байх шаардлагатай.

Шүүгдэгчийн өөрийгөө хамгаалан ярьсан зүйлд өгөх улсын яллагчийн хариултыг шүүгч мэдэж байх нь чухал бөгөөд ингэснээр хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт буруутай эсэхийг зөв шийдвэрлэхэд дөхөм болдог. Түүнчлэн, шүүгч энэ талаар мэдээлэлтэй байснаар хохирогчийн үзэл бодол нь ямар байгаа, мөлжлөг үйлдэгдэж байх үед ямар арга хэмжээ авахыг оролдож байсан зэрэгтэй холбоотой мэдүүлгүүдийг илүү гүнзгий ойлгоход тусална. Шүүгдэгч өөрийгөө ямар ч байдлаар хамгаалсан байсан, улсын яллагч түүнд нь ямар ч хариу няцаалт өгсөн бай, шүүх шийдвэрээ гаргахад аль алинд нь нотлох баримт шаардлагатай болно.

2. ШҮҮГДЭГЧИЙН ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛСАН МЭДҮҮЛГИЙН ЭСРЭГ УЛСЫН ЯЛЛАГЧИЙН ХИЙЖ БОЛОХ ХАРИУ НЯЦААЛТ

Нэмэлт нотлох баримт – Өөрийгөө хамгаалсан аливаа мэдүүлгийг няцааж, хохирогчийн ярьсан зүйл үнэн, яллагдагчийнх нотлогдоогүй, үндэслэлгүй гэдгийг харуулахын тулд хангалттай, няцаах боломжгүй нэмэлт нотлох баримт олж авах явдал юм. Улсын яллагч баримт нотолгооны үүднээс хангалттай бус байгаа гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгүүд дээр мөрдөгчтэй хамтран ажиллаж, нэмэлт нотлох баримт олж авах нь чухал байдаг. Тухайлбал, улсын яллагч хохирогчийг хууран мэхлэгдэх байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гэсэн хохирогчийн баримтыг гэмт хэрэгт элсүүлэх үедээ яллагдагч хохирогчид хуурамч амлалт өгч байсан талаар сонсож байсан гэр бүлийн гишүүдээр шүүх хуралдааны үеэр гэрчийн мэдүүлэг өгүүлж болно.

Хохирогчтой ойр хамтарч ажиллах - Хэрэг дээр ажиллаж байх үед хохирогчийн мэдүүлгийн итгэл үнэмшилтэй байгаа эсэх нь эргэлзээтэй бол яг юунаас шалтгаалж байгааг улсын яллагч тодорхойлно. Дараах шалтгааны улмаас хохирогчийн мэдүүлэг эргэлзээтэй санагдаж болно. Үүнд:

- Өмнө нь зөрүүтэй мэдүүлэг өгч байсан;
- Хэргийн нотлох баримтыг үгүйсгэх мэдүүлэг өгсөн;
- Хохирогчийн үйлдэл гэмт хэргийн шинжийг үгүйсгэж байгаа;
- Хохирогч өөрөө гэмт хэрэг үйлдсэн эсвэл хууль бус үйлдэл гаргаж байсан (Жишээлбэл, хохирогч оршин сууж байсан газраасаа өөр хоёр хүнийг өндөр цалинтай ажилд оруулна гэж үнэмшүүлж, үйлдвэрт албадан хөдөлмөр эрхлүүлэхэд гар бие оролцсон байж болно).

Хохирогчийн тайлбар - Хохирогчийн мэдүүлгийг үнэмшилгүй, эргэлзээтэй санагдуулах дээр дурдсан шалтгааныг шийдвэрлэхийн тулд улсын яллагч өгсөн мэдүүлгийн зөрүү, ингэх болсон шалтгааныг олж тогтоохын тулд хохирогчоос тайлбар авах ёстой. Хохирогч гэмт этгээд өөрийг нь болон гэр бүлийнхнийг нь заналхийлсэн, хууран мэхэлсэн учраас болсон явдлыг мөрдөн шалгах ажиллагааны үеэр үнэнээр нь хэлж чадаагүй гэдгээ цагдаагийн албан хаагч нарт хэлээгүй шалтгааныг нь олж тогтоох шаардлагатай. Үүнийг хийхдээ хохирогчид зөвлөгөө өгөх шаардлагагүй. Хохирогч эргэлзэж, яахаа мэдэхээ больсон, айж эмээсэн, цагдаагийн албан хаагчдад итгэж болохгүй, өөрт нь туслахгүй гэж бодсон учраас тийм үйлдэл гаргасан гэж ихэвчлэн хариулдаг.

Дээрх жагсаалтын 3-т заасан бэрхшээл нь хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллах үед түгээмэл тохиолддог бөгөөд хэргийн газраас зугтах, зохих хүнд нь хэргийн талаар мэдээлэх боломж байсаар байтал яагаад ингээгүйг асуудаг. Яллагдагчийн өмгөөлөгч хохирогчоос өөрийнх нь зөвшөөрлийг авсны үндсэн дээр энэ үйлдэл хийгдсэн мөн ямар нэг хүч хэрэглээгүй гэсэн

тайлбарыг шүүхэд ихэвчлэн өгдөг. Улсын яллагч хохирогчоос боломж байсаар байтал яагаад хэргийн газраас зугтаагүй талаар асууж, тайлбар авах хэрэгтэй. Хохирогч ихэвчлэн өөрийнхөө болон гэр бүлийнхэн нь хохирч цаашлаад амь насаа алдах эрсдэлтэй гэр бүлийнхэн/оршин суудаг газарт нь өөрийнх нь одоогийн нөхцөл байдлын талаар мэдээлэх гэмт этгээдэд бичиг баримт, биеийн байцаалт, хураасан цалин хөлс нь байсан, тухайн улс оронд хууль бусаар оршин сууж байгаа, хүчин төгөлдөр ямар нэг бичиг баримт байхгүй, (эцсийн зогсоол буюу мөлжлөг үйлдэгдсэн улс оронд "ажиллахын" тулд нууцаар нэвтэрсэн); өмнө нь ирж байгаагүй шинэ газарт хаана хэнд хандахаа мэдэхгүй байсан, тухайн орны хэлийг мэдэхгүйгээс болж хэл нэвтрэлцэхгүй байсан зэрэг тайлбарыг өгдөг.

Хохирогч гэр бүлийнхээ аюулгүй байдалд санаа зовж байсан учраас худал мэдүүлэг өгсөн гэж мэдүүлсэн бол гэмт этгээд хохирогчийн гэр бүл, ойр дотнынхон хаана амьдардгийг үнэхээр мэддэг байсан эсэхийг нотлох хэрэгтэй. Гэмт этгээд хохирогчийг зугтвал цагдаа нар тэднийг баривчилж, буцааж авчрах бөгөөд тэд үүнийхээ хариуг хүртэнэ гэж айлган сүрдүүлж, заналхийлдэг байсан учраас гэмт хэргийн газраас зугтаж чаддаггүй байсан бол энэ талаар бусад хохирогчид болон мэдэх хүмүүсээс нотлох баримт цуглуулж болно.

Хохирогчоос мэдүүлэг авах – Хохирогчийн тайлбар итгэл төрүүлэхүйц, баримт болж чадахуйц гэж улсын яллагч үзэж байвал шүүх хуралдааны үеэр гарч ирж болзошгүй асуудлыг шийдвэрлэх тактик боловсруулан оролцох хэрэгтэй. Дэлхий нийтэд хэрэглэгддэг туршлагаас харахад улсын яллагч шүүх хуралдаан дээр мэдүүлэг өгч байх үед нь хохирогчоос худал, зөрүүтэй мэдүүлэг өгсөн эсэхийг нь шударгаар асууж, тэд боломж нь байсаар байхад яагаад хэргийн газраас зугтаж чадаагүй шалтгаанаа шүүхийн өмнө тайлбарлаж хэлэхэд бэлтгэгдсэн эсэхэд хяналт тавин ажиллах хэрэгтэй. Улсын яллагч шүүх хуралдааны үед асуудлыг гаргаж тавихгүй, яллагдагч талын өмгөөлөгчид энэ боломжийг олгоод байвал эсрэг талд давуу талыг олгож, гэрч, хохирогчийн мэдүүлгийг эргэлзээтэй болгох эрсдэлтэй байдаг. Иймэрхүү байдал нь шүүх бүрэлдэхүүнд хохирогч, улсын яллагч нар хэрэгтэй холбоотой чухал асуудлыг нуун дарагдуулж, яллагдагчийн эрхэнд халдан, шүүх ажиллагааг шударга явуулахад сөргөөр нөлөөлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх магадлалтай. Яллагдагч талын өмгөөлөгчид өгсөн хохирогчийн хамгийн анхны тайлбар шүүгчид баримт гэж хүлээн зөвшөөрөгдөхгүй байх явдал гардаг.

Мэргэжилтний туслалцаа авах – Дээр дурдсан гурав дахь асуудалд хандсан хариу арга хэмжээ авахад тактикийн хувьд шүүх хуралдааны үед дэмжлэг үзүүлэх мэргэжилтний туслалцаа шаардлагатай эсэхийг харгалзаж үзэх хэрэгтэй. Шүүх хуралдаанд ирсэн сэтгэл зүй, сэтгэц гэм судлалын талаар мэргэшсэн мэргэжилтэн нь Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч удаан хугацаанд хүчирхийлэлд байхаараа ямар байдалтай болдог талаар шинжлэх ухааны баримттай судалгааг үндэслэн хариулт өгч болно. Хохирогчийн сэтгэл зүйн байдал ямар болсон байдаг, тэр нь хэргийн газраас яагаад зугтаах боломжгүй болгодог талаар шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар хийх нь чухал. Тухайн гэмт хэргийн хохирогчийн нөхцөл байдал нь ижил төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчидтой адилхан байгааг хэлэх нь зүйтэй.

Мэргэжилтний иймэрхүү мэдүүлэг маш үр дүнтэй байдаг. Улсын яллагчийн анхаарах гол зүйл нь тухайн хүн үнэхээр мэргэшсэн ажилтан мөн эсэхийг баталгаажуулах явдал юм. Мөн улсын яллагч мэргэжилтний энэ төрлийн мэдүүлэг үр дүнтэй байх эсэхийг урьдчилан тооцоолсон байх шаардлагатай. Шүүх хуралдаанд мэргэжилтнийг оролцуулах хэрэгцээ шаардлага байна уу? Итгэл үнэмшил төрүүлэхүйц мэдээлэл өгч чадах уу? Мэргэжилтэн шинжлэх ухааны нарийн ойлголтыг бусдад ойлгомжтойгоор тайлбарлаж чадах уу? Хэрэг дээр ажиллаж буй улсын яллагч яллагдагч талын өмгөөлөгч тухайн мэргэжилтнээс ямар асуулт асууж болохыг урьдчилан тооцоолж, мэргэжилтнийг боломжийнхоо хэрээр бэлтгэсэн байх ёстой.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын энэ хэсэгт 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мэргэжилтнийг оролцуулах тухай хэрхэн зохицуулсан байдгийг суралцагчдад хэлнэ үү.

Мэргэжилтнийг оролцуулахтай холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Хохирогчийн үйлдсэн хууль бус үйлдэл болон гэмт хэргийг ялгах - Дээр дурдсан хамгийн сүүлийн асуудлын тухайд улсын яллагч хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотойгоор хохирогчийн үйлдсэн хууль бус үйлдэл болон гэмт хэргийг хооронд нь ялгах шаардлагатай. Олон улсын стандарт болон олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдсөнөөр хохирогч гэмт хэргийн хохирогч байх үедээ үйлдсэн аливаа үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэж тодорхой заасан байдаг[44]. Хохирогч гэмт этгээдийн албадлага, шахалт дор ажиллаж, мөлжүүлж байхдаа өөрийн хүслээр, дур сонирхлоор ямар нэг үйлдэл хийх эрхгүй байдаг. Тийм учраас хохирогчид хүч хэрэглээ, хүч хэрэглэхээр заналхийлж айлган сүрдүүлж, албадаж хийлгүүлсэн аливаа хууль бус үйлдэлд хохирогч биш түүнийг үйлдүүлсэн этгээд хариуцлага хүлээх ёстой.

Хохирогч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байх үедээ үйлдсэн аливаа үйлдэлдээ хариуцлага хүлээхгүй ч гэмт хэргийн өмнө болон дараа нь хууль бус үйлдэл хийсэн бол үүнийг тусад нь авч үзнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн хүрээнээс гадуур үйлдсэн аливаа үйлдэлдээ хохирогч хариуцлага хүлээх үүрэгтэй бөгөөд үүнийг тухайн улс орон хуулиар зохицуулна.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын энэ хэсэгт суралцагчид дүрд тоглох байдлаар доор өгүүлэх дасгал ажлыг ашиглан шүүх хурлыг ангидаа явуулна.

ДАСГАЛ АЖИЛ 11 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГАД ТАТАЖ, ДҮРД ТОГЛОХ БАЙДЛААР ШҮҮХ ХУРАЛДААН ЯВУУЛАХ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дүрд тоглох дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс жүжиглэх үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол байх хэрэгтэйг анхаарна уу.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Тараах материал, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажиллах хугацаа: 60 минут

Дасгал: Сургагч багш суралцагчдыг 3 багт хуваана. 1-р баг 3 хүний бүрэлдэхүүнтэй шүүгч, 2-р баг хохирогчийг төлөөлөөд улсын яллагч, 3-р баг шүүгдэгчийг төлөөлөөд өмгөөлөгчийн дүрийг тус тус гаргана. Ажиллах тохиолдолтой танилцсаны дараа улсын яллагчийн баг шүүгдэгчийг яллаж, шүүгдэгчийн өмгөөлөгч шүүгдэгчээ, шүүх бүрэлдэхүүн хоёр талын мэтгэлцээнд үндэслэн хэн нь гэм буруутайг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

44 НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протокол; Хүний эрх, хүн худалдаалахтай тэмцэх зарчим зөвлөмж.

Тохиолдол

Саран гэдэг 19 настай охин Улаанбаатар хотод сурч, амьдардаг. Эцэг, эх хоёр нь хоёулаа төрийн албан хаагчид бөгөөд 15 настай эрэгтэй дүүгийн хамт амьдардаг. Саран сурлага сайтай, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, олон улсын компанид ажиллах хүсэлтэй охин. Тэрээр Англи хэлээ сайжруулахаар ярианы дамжаанд явдаг байсан бөгөөд инженерийн чиглэлээр суралцдаг Мишээл гэдэг залуутай танилцав. Тэд нэг нэгэндээ таалагдаж, хичээлийн дараа гадуур болзож эхэллээ. Мишээл бэлгийн харилцаанд оръё гэж Сарангаас хүсэх болсон бөгөөд хэдэн жилийн дараа гэрлэх учраас асуудалгүй гэж ятгасаар байв. Нэг удаа Саранд мэдэгдэлгүйгээр Мишээл бэлгийн харилцаанд орж байгаагаа бичлэг хийж хадгалсан байлаа. Дотно харилцаанд хэд хэдэн удаа орсны дараа Мишээл хийсэн дүрс бичлэгээ үзүүлж, бизнес эрхэлдэг өөр нэг хүнтэй бэлгийн харилцаанд оруулмаар байгаагаа хэлэв. Саран бичлэгийг үзээд ихэд айж, ичсэн бөгөөд Мишээлийн тавьж буй саналд цочирдов.

Мишээл дүрс бичлэгийг дахин ашиглахгүй гэж амлан, хамтран амьдрахад хэрэглэгдэх мөнгөө олохын тулд хамгийн амархан арга энэ хэмээн тайлбарлаж байлаа. Тэрээр ганцхан л удаа үүнийг хийхэд болох бөгөөд түүний найз болох Бат-Эрдэнэ нь хэдхэн цаг "ажилласных" нь төлөө нэлээдгүй их мөнгө өгнө гэх мэтээр зөндөө ятгав. Мишээлд байгаа бичлэг дээр тод гарч байгаа өөрийнхөө царайг санаж, Мишээлд үнэн сэтгэлээсээ хайртай, гэрлэнэ гэж бодож явдаг тул Саран яахаа мэдэхээ больж, гарцаагүй байдалд орлоо. Мишээл ятгасаар байгаад Саранг ганцхан удаа хийнэ гэсэн нөхцөлтэйгөөр зөвшөөрүүлэв. Тэр хоёр нэг газар очиж Бат-Эрдэнэтэй уулзсан бөгөөд томоохон зочид буудалд Бат-Эрдэнэ, Саран хоёр шөнийг өнгөрүүлэв.

Энэ явдлаас хойш сарын дараа Мишээл Саранд өөр нэгэн том бизнес эрхэлдэг хүнд биеэ үнэлэх хэрэгтэй байна гэж хэлэв. Уйгагүй ятгасны эцэст Саран дахин зөвшөөрүүлэв. Энэ явдал долоо хоног бүр давтагдах болж, сүүлдээ Саранг дургүйцэх болгонд хийсэн бичлэгээ эцэг, эхэд нь болон сургуулийнханд нь тараана гэж сүрдүүлэх боллоо. Саран яах учраа мэдэхээ байж, хаана, хэнд хандахаа ч мэдэхгүй байв. Тэр Мишээлд хайртай хэвээр бөгөөд өөрсдийнхөө ирээдүйн төлөө мөнгө хураахын тулд ийм үйлдэл хийж байгаа гэж боддог байсан ч үнэндээ гар дээрээ нэг ч төгрөг авч байсангүй. Дотоод сэтгэлдээ зөрчилдөж, Мишээлийг хайрлах, хийж байгаа зүйлээ үзэн ядах хоёрын дунд эргэлзэж, хаашаа ч хөдөлж чадахгүй байсаар байлаа.

Нэг өдөр цагдаа нар зочид буудлыг шалгах үеэр Саран үйлчлүүлэгчийн хамт байж байгаад баригдав. Мөрдөн шалгалтын үеэр Мишээл, Бат-Эрдэнэ нар Саранг хүчээр биеийг нь үнэлүүлж байсан тухай хэлжээ. Эрүүгийн хэрэг үүсэж, шүүхийн шатандаа явж байна.

Өөрийгөө үнэлэх нь:

1. Шүүгдэгч Мишээл, Бат-Эрдэнэ нарт улсын яллагч ямар ял төлөвлөж болох вэ?
2. Шүүгдэгч Мишээл, Бат-Эрдэнэ нарын өмгөөлөгч ямар байдлаар тэдний хийсэн үйлдлийг нь хамгаалж болохыг хэлнэ үү.
3. Шүүгдэгч Мишээл, Бат-Эрдэнэ нарын мэдүүлгийн эсрэг улсын яллагчийн өгөх няцаалт юу байж болох вэ?
4. Энэ тохиолдолд шүүгдэгчийн үйлдсэн гэмт үйлдэл бүрийг хэрхэн зүйлчилж яллах вэ?

СЭДЭВ 3: ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

1. ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Нэгдсэн үндэстний байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (UNOTC) болон 2000 оны Хүн худалдаалахын эсрэг конвенцэд хохирогчийн эрхийн талаар тодорхой өгүүлсэн байдаг. Энэ нь Гэмт хэргийн хохирогч болон эрх мэдлээ урвуулан ашигласан хүмүүсийг шударга шүүх үндсэн зарчимд нэмэлт байдлаар оруулж ирсэн эрхүүд юм.

Хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдох хүний эрх:

- Гарал үүсэл, үндэс угсаа, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон хувь хүний аливаа үзэл бодол, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн газар болон бусад байдлаас болж ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- Амьд явах эрхтэй.
- Эрх чөлөөтэй байж, хамгаалуулах эрхтэй.
- Боолчлолын аливаа хэлбэрээр албадан хөдөлмөр, боолын хөдөлмөр эрхлэхгүй байх эрхтэй.
- Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, доромжлох, шийтгэлээс ангид байх эрхтэй.
- Аль нэг жендерт тулгуурласан хүчирхийллээс ангид байх эрхтэй.
- Эвлэлдэн нэгдэх эрхтэй.
- Чөлөөтэй зорчих эрхтэй.
- Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн боломжит хамгийн дээд түвшинд байх эрхтэй.
- Ажиллах таатай нөхцөлөөр хангагдах эрхтэй.
- Шаардлага хангасан орчинд амьдрах эрхтэй.
- Нийгмийн хамгааллыг хүртэх эрхтэй.
- Хүүхдүүд тусгай хамгаалалт эдлэх эрхтэй.

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч бүр дараах ерөнхий эрхийг эдэлнэ. Үүнд:

2. ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол улсын хуульд хохирогчийн эрхийг хэрхэн тусгасан талаар суралцагчидтай ярилцана.

Хохирогчийн эрхтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

3. ХОХИРОГЧ ХАМГААЛАХАД ШҮҮГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Хохирогч хамгаалах арга хэмжээ

1. Шүүх хуралдаан болтол сэжигтнийг саатуулах байранд хорьсон хэвээр байлгах эсэхийг анхаарч ажиллах. Хохирогч болон түүний гэр бүл, ойр дотнынхныг гэмт этгээд айлган сүрдүүлэх, заналхийлэх, хүчирхийлэхээс хамгаалахын тулд шүүгдэгчид барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхтэй холбоотой бүх зүйлийг нарийн шалгаж, хянах. Энэ хугацаанд хохирогчийг хамгаалах байранд хамгаалалтад байлгана.
2. Хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүд, хамаатан садан гэгдэх хүмүүст хохирогчийг (ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд) шууд шилжүүлж болохгүй. Эдгээр хүмүүс нь "асран хамгаалагч" нэрийн дор нуугдан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн жинхэнэ хэрэгтэй холбоотой байх боломжтой байдаг. Тэдний гарт дахин орвол, хохирогчийг мөлжлөг үйлдэж байсан газарт буцаан аваачиж, гэмт үйлдлээ үргэлжлүүлнэ.
3. Монгол улсад дагаж мөрдөж буй Хүн худалдаалахын эсрэг хуульд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүний **нэр төрийг** хамгаална гэж заасан байдаг. Шүүгчид тухайн хохирогчийн хэн болохыг бүхий л үйл ажиллагааныхаа туршид нууцлан ажиллах шаардлагатай.
4. Шүүгчид мөрдөгч болон улсын яллагчаас гаргасан хохирогчийн эрсдэлийн үнэлгээтэй танилцсан байх хэрэгтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл хохирогч болон түүний гэр бүлийг хамгаалах шийдвэр гаргаж болно.
5. Шүүхийн сонсголын аль нэг үе шатанд (шүүх хурлын өмнө болон явагдаж байх үед) тухайн газарт аливаа **хамгаалах арга хэмжээ** авах шаардлагатай эсэхийг тогтоох. Дотоодын хууль тогтоомжид тусгайлан заагаагүйгээс шалтгаалаад үүнийг хэрэгжүүлэх боломж зарим тохиолдолд байдаггүй. Гэвч хүн худалдаалах хэргийг шүүн таслахаар ажиллаж байгаа шүүгч улсын яллагч болон хэрэг дээр ажилласан мөрдөгчтэй зөвлөлдсөний үндсэн дээр шүүх хуралдааныг шударга явуулах үүднээс ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд холбогдсон гэмт хэргийн үед яллагдагчийн эрхийг зөрчилгүйгээр хохирогчийг хамгаалах арга хэмжээ авч болно. Үүнд дараах зүйлс багтаж болно:
   - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн төлөөлөлгүйгээр шүүх хурлыг хаалттай явуулах. Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог шинж чанараас шалтгаалаад, хүүхэд эмэгтэйчүүд холбогдсон шүүх хуралдааныг хаалттай явуулж болно;
   - Шүүн таслах ажиллагааны явцын бичлэгийг нууцлах;
   - Зарим үед шүүхийн байран доторх өөр өрөөнөөс, эсхүл тухайн байрны гадна байрлалаас дүрс болон аудио бичлэгээр мэдүүлэг өгүүлэх ажиллагааг зохион байгуулах;
   - Хохирогч гадаад улсаас хил дамнан худалдаалагдаж ирээд, хууль сахиулах албан хаагчид аврах ажиллагаа явуулсны дараа (шүүн таслах ажиллагаанаас өмнө) эх

орондоо буцсан тохиолдолд видео линк ашиглах шаардлага гарч болно;
- Гэрч, хохирогчийг шүүхийн танхимд яллагдагч болон бусад гэрчүүдээс тусгаарлах таславч хэрэглэх;
- Гэрч, хохирогч, яллагдагч, бусад гэрч нарыг өөр өөр хүлээлгийн өрөөнд байлгах;
- Гэрч, хохирогчийг хамгаалахад ямар байдлаар оролцож болох талаар шүүхийн албан хаагчдад мэдээлэл өгөх;
- Шүүх хуралдаанд очих, буцах замын аюулгүй байдлыг хангах;
- Шүүн таслах ажиллагааны талаар мэдээлж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хохирогчийн хэн гэдгийг нийтэд зарлахгүй байх явдлыг баталгаажуулах зэрэг болно.

6. Ихэнх тохиолдолд ямар нэг тусгай арга хэмжээ авахаар байгаа тохиолдолд шүүхээс урьдчилж зөвшөөрөл авах хэрэгтэй бөгөөд хэрэг дээр ажилласан мөрдөгч, улсын яллагч нартай зөвлөлдсөний үндсэн дээр шүүхийн сонсголоос өмнө уг арга хэмжээг авч эхэлж болно.
7. Шүүгч нь мөрдөгч, улсын яллагч нартай зөвлөлдсөний үндсэн дээр хохирогчийг гэр бүлд нь буцаасны дараа эсвэл хамгаалах байранд үлдэхээр шийдсэн эсвэл өөрийн гэр оронтой болохоор болсон тохиолдолд хохирогчид ямар эрсдэл учирч болзошгүй, түүнээс хамгаалах ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлно.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын энэ хэсэгт Дасгал ажил 11-т гарсан хохирогчийг хамгаалах ямар ямар арга хэмжээ авч болохыг суралцагчидтай ярилцана уу. Суралцагчдыг хоёр багт хуваана. Нэгдүгээр баг шүүн таслах ажиллагаанаас өмнө болон дараа хамгаалах арга хэмжээг жагсааж бичнэ. Хоёрдугаар баг шүүн таслах ажиллагааны үеэр хохирогчийг хэрхэн хамгаалах аргуудыг жагсаана. Баг дотроо ярилцсан зүйлсээ бусадтайгаа хуваалцана.

Гэрч, хохирогчийг хамгаалахад шүүгчийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СЭДЭВ 4: ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ, ХОР УРШГИЙГ АРИЛГАХ

1. ЯЛ ОНОГДУУЛАХ

Хүн худалдаалах гэмт хэргийг шүүн таслах үедээ шүүгчид тухайн яллагдагчид ял шийтгэл оноохтой холбоотой хуулийн заалтуудыг сайтар мэдэж байх хэрэгтэй. Ямар ял шийтгэл оноох нь шүүхийн бүрэн эрх мэдэл болохоор шүүгчид хуульд ял шийтгэлийг хэрхэн оногдуулахаар заасан байдаг талаар маш сайн мэдэж байх нь чухал юм. Энэхүү мэдлэг, мэдээллээ ашиглан тухайн гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж болох талаар өөрийн зураглалаа гаргаж, хоёр талын дэлгэж тавьсан баримтууд ял шийтгэл оноох шийдвэрт хэрхэн нөлөөлж болохыг тооцоолно.

Ял оногдуулах зарчим[45]

Хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан ял оногдуулах үйл явц өөр өөр байдаг. Хуулийн олон янзын системийг үзвэл ял шийтгэл оногдуулах зарчим ихэнхдээ дараах байдлаар явагддаг. Үүнд:

- Гэм буруу болон учруулсан хохирлын хэмжээнд тохирсон байх зарчим: Учруулсан хор уршиг, хохирлын хэмжээ, хүн худалдаалах гэмт хэргээс болон мөлжлөгөөс хүртсэн ашгийн хувь хэмжээнд үндэслэн ялыг тооцоолж ногдуулна. Хор хохирол тухайн хохирогч, тэдний гэр бүл ойр дотнынхонд, хамгийн ихдээ тухайн газар орны хүмүүст учирсан байж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан гэм бурууд тохирох ял оногдуулна.
- Шийтгэх болон цээрлүүлэх зорилтыг хангасан байх зарчим: Ял шийтгэлийг тухайн гэмт хэргийг үйлдэж нийгмийн харилцаанд хор хохирол учруулсных нь төлөө оногдуулдаг. Урьдчилан сэргийлэх зорилгыг хангасан байх зарчим (ерөнхий болон тусгай аль аль нь): Ялын ерөнхий урьдчилан сэргийлэх агуулга нь нийгэмд хор, хохирол учруулах явдлыг таслан зогсоох, нийгмийн дэг журмыг хангах явдал юм. Харин тусгай урьдчилан сэргийлэх агуулга нь тодорхой гэмт этгээдийг ижил төрлийн гэмт хэрэг дахин үйлдэхээс нь урьдчилан сэргийлэхэд оршино.
- Хүмүүжүүлэх зорилтыг хангасан байх зарчим: Энэхүү зарчмын агуулга нь тухайн ял шийтгэл гэмт этгээдийг засарч хүмүүжүүлэхэд нь тусалснаар нийгэмд хор уршигтай үйлдэл хийхээ больж, сайн иргэн байхад төлөвшүүлэхэд чиглэгддэг.
- Таслан зогсоох болон тусгаарлах зорилтыг хангах зарчим: Нийгмээс гэмт этгээдийг тусгаарлаж, бусдад хор хохирол учруулах боломжийг нь хязгаарлахад энэ зарчмын мөн чанар оршино.
- Нөхөн сэргээх зорилтыг хангах зарчим: Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө хохирогчийн амьдарч байсан хэвийн байдалд нь эргүүлэн оруулж, тэрхүү хуучин нөхцөл байдлын тэнцвэрийг засан сэргээхэд энэ зарчмын агуулга оршино.

Ял оногдуулахад шүүгчийн анхаарах зүйлс

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасны дагуу шүүгч шүүн таслах ажиллагааны үеэр гарч ирсэн аливаа асуултыг тавьж болох үгүйг шийднэ. Улсын яллагч болон яллагдагчийн өмгөөллийн зүгээс гаргаж ирсэн бүхий л асуудлыг анхааралтай сонсож тунгаасны дараа шүүгчийн зүгээс яллагдагчид ял оноож, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Улсын яллагч шүүн таслах ажиллагаанд Монгол улсын нэрийн өмнөөс оролцож, нотлох баримтад дүгнэлт хийж, шүүх хурлын үеэр аливаа асуултад хариулт өгөх, шүүгдэгчид Эрүүгийн хуулийн дагуу ял онооход хуулийн зүйл заалтыг хэрхэн хэрэглэх, ялын төрөл ямар байх, хэр урт хугацаанд ямар дэглэмд ял эдлэхтэй холбоотой өөрийн дүгнэлтээ хэлнэ.
2. Дараах тохиолдолд ялыг хүндрүүлж оногдуулдаг (олон улсын сайн туршлагаар).
   - Яллагдагч этгээд өмнө нь хүн худалдаалах гэмт хэрэгт буруутгагдаж байсан эсвэл заналхийлэл, хүчирхийлэл ашиглан гэмт хэрэг үйлдэж байсан;
   - Хохирогчийг амь насаа алдах ноцтой эрсдэлд оруулж байсан эсвэл бие махбодод нь хүнд гэмтэл учруулж байсан – Бэлгийн мөлжлөгийн үед хохирогч ДОХ/ХДХВ зэрэг

45 Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл онооход харгалзан үзэх зүйлс, Модуль 14, Хууль сахиулах албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Вена, 2009

бэлгийн замын олон халдварт өвчин тусах зэрэг эрүүл мэндэд нь заналхийлсэн эрсдэл дунд байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид стандартын бус, хүнд хэцүү нөхцөл байдалд амьдардаг байсан нь тэднийг олон төрлийн өвчин тусах магадлалыг нэмэгдүүлдэг. Үйлдвэрлэл, барилга болон хөдөө аж ахуйн салбарт албадан хөдөлмөр эрхэлж байсан хохирогчид гэмтэж бэртэх, өвчин тусах эрсдэлтэй байдаг бөгөөд ялангуяа ажлын багаж хэрэгсэл, техник хэрэгсэл нь аюултай эсвэл бүрэн бүтэн байдал нь алдагдсан тохиолдолд энэ эрсдэл илүү өндөр байдаг. Бэртэж, гэмтэж байгаагүй байсан ч ингэх магадлал өндөр орчинд хохирогчийг байлгадаг, ажиллуулдаг байсан;

- Гэмт этгээд зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэргийг хүндрүүлж үзнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн үед хохирогчийг бие махбодын болоод сэтгэл зүйн айдаст байлгаж, мөлжлөг үйлдэхийн тулд зэвсэг ашигласан байх нь олонтоо тохиолддог. Энэхүү хараа хяналтаа чангатгахын тулд зэвсгийг хохирогчийг мэдэх өөр хүмүүс ашигласан байх нь бий. Тухайлбал, зэвсэг ашиглан айлган сүрдүүлж, хэлснийг нь хийхгүй бол гэр бүлийнхэнд нь хохирол учруулна гэж заналхийлсэн байх;
- Хүн худалдаалах гэмт хэрэг ихэвчлэн харгис хэрцгий, балмад байдлаар үйлдэгддэг бөгөөд үүнийг нь яллагдагч/шүүгдэгч мөлжиж байсан хүмүүстээ хүнлэг бус зан авир гаргадаг байснаас тодорхой харж болно. Хүнийг урт хугацааны турш мөлжих, биеэ даасан, бусдаас хараат бус байх эрх чөлөөг нь хасах үйлдэл нь өөрөө уг гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах шаардлагатайг харуулдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь хохирогчид ихээхэн зэрлэг балмад, хүнлэг бусаар хандах, байнгын хүчирхийлэл зэрэг хохирогчийн эсрэг гэмт хэрэг үйлддэг онцлогтой бөгөөд хохирогчийг хяналтдаа байлгахын тулд хүчирхийлэл байнга үйлдэж байдаг.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

"Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн ял оногдуулах"-тай холбоотой дараах сэдвээр суралцагчидтайгаа ярилцана уу. Үүнд:

- *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох зүйл заалт;*
- *Эрүүгийн хуульд заасан ялын төрөл/хэмжээ;*
- *Шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгө хураан авах, худалдах, торгох, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах зэрэг нэмэгдэл ял болон бусад төрлийн ял.*

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ялын төрөлтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

2. НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛҮҮЛЭХ[46]

Гэмт хэргийн хохирогчид бие махбодын болоод сэтгэл санааны хохирол учруулсныхаа төлөө нөхөн төлбөр төлөх явдал байдаг. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөлжлөгөөс улбаатай сэтгэл зүйн эмгэгээсээ гарахад шууд нөлөөлөхгүй ч нөхөн сэргэхэд нь, эргэн нийгэмшихэд нь хохирогчид үүссэн хорсол, цөхрөлийг намжаах нэг боломж нь болж өгдөг. Үүгээр дамжуулан ижил төрлийн гэмт хэрэгт дахин өртөх магадлалыг бууруулж, эдийн засгийн

46 2009 Хууль сахиулах албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага, Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл онооход харгалзан үзэх зүйлс, Модуль 13-аас авав. НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Вена, 2009

хувьд тодорхой хэмжээнд биеэ даасан болоход нь нэмэр болдог.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколын 6-р зүйлийн (6)-д Оролцогч улсууд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч өөрт үүссэн хохирлын хариуд нөхөн төлбөр авах хууль эрх зүйн заалттай байх талаар анхаарал хандуулан ажиллана гэж заасан байдаг.

Улсын яллагч нөхөн төлбөр олгохтой холбоотой хууль тогтоомжоо сайн мэддэг, үүндээ үндэслэн гэмт хэргийн хохирогчид ямар хохирол учирсан үед нөхөн төлбөр олгох талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Учирсан хор, хохирлыг тогтоож, хэдий хэмжээний нөхөн төлбөр төлүүлэх шийдвэрийг гаргах байгууллага нь шүүх байна.

Нөхөн төлбөр олгох ажлыг шүүхийн шийдвэрээр эсвэл захиргааны арга хэмжээгээр зохион байгуулна. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэж байгаа тохиолдолд дараах байдлаар хийгдэнэ. Үүнд:

- Шүүн таслах ажиллагааны төгсгөлд гэм буруутай этгээдээд хохирогчид нөхөн төлбөр төлүүлэх шийдвэр гаргах;
- Хохирогч тусдаа иргэний нэхэмжлэх гаргах;
- Хөдөлмөрийн маргааныг таслах шүүх болон харьяа шүүхдээ нөхөн төлбөр/хохирол авааагүй цалин хөлснийхөө талаар нэхэмжлэх гаргах.

Учирсан хохиролд нөхөн төлбөр олгуулахад шүүгчийн анхаарах зүйлс

Практик туршлагаас харахад нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирогчийн хэрэгцээ, сонирхол, гэм хор учруулсан нөхцөл байдал, гэмт этгээдийн гэм буруу болон хохирогчид учирсан хохирлын хэмжээг харгалзаж үздэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирогч гэмт этгээдийн учруулсан хохиролд нөхөн төлбөр авахаар шүүхэд иргэний нэхэмжлэх гаргах эрхтэй. Ихэвчлэн улсын яллагч энэ эрхийнх нь талаар хохирогчид зөвлөж хэлдэг ч шүүгч хуулийн энэхүү заалтын талаар мэдэж байгаа эсэх талаар нь хохирогчоос тодруулж асуух хэрэгтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэний нэхэмжлэх гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд учирсан хохирлын хэмжээ, гэмт хэргийн нөхцөл байдал зэргийн Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хуульд үндэслэн тогтоогдоно гэдгийг улсын яллагч тайлбарлан хэлэх нь зүйтэй.

Шүүгч хохирогчид олгох нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- Хохирогчийн бие махбод, сэтгэл зүй, сэтгэлийн хөдлөл, бэлгийн болон санхүүгийн хүчирхийллийн шинж чанар, хохирогчийн амьдралд үзүүлсэн нөлөө;
- Мөлжлөгийн улмаас үүссэн бие махбодын хохирол, өвчин хууч;
- Албадан хөдөлмөр эрхэлж байсан хохирогчид маш бага эсвэл огт цалин хөлс өгч байгаагүй;
- Гэмт хэргээс улбаатай бусад хохирол.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой дараах сэдвээр суралцагчидтайгаа ярилцана уу. Үүнд:

- *Хохирогчид учирсан хохирлыг нөхөн нөхөн төлүүлэхтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, бусад хуулийн холбогдох зүйл заалтууд;*
- *Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явц;*
- *Шүүхээс хохирол нөхөн төлүүлэх шийдвэр гарсан тохиолдолд улсын яллагчийн гүйцэтгэх үүрэг;*
- *Хохирогчид учирсан хохиролд үндэслэн шүүхэд иргэний нэхэмжлэх гаргасны дагуу шийдвэрлэгдэх Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалт;*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд иргэний нэхэмжлэх гаргах, үүнд улсын яллагчийн гүйцэтгэх үүрэг.

Хохирогчид учирсан хохирлыг шийдвэрлэхтэй холбоотой хуулийн зүйл заалтыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

Засгийн газраас олгох нөхөн төлбөр

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод улсаас олгодог нөхөн төлбөр гэж байдаг. Практикаас харвал, зарим улс оронд ихэвчлэн хэрцгий балмад шинж агуулсан бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод нөхөн төлбөр олгоход зориулсан тусгай бодлого байдаг. Улсын төсвөөс санхүүжүүлэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох нь давуу талтай байдаг бөгөөд энэхүү бодлогын хүрээнд нөхөн төлбөр төлүүлэхэд хэн нэгэн гэмт этгээдийг олж тогтоохыг хүлээх шаардлага гардаггүй.

Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөртэй холбоотой хуулийн зохицуулалтад хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирол одоогийн байдлаар багтаагүй байна.

3. ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар ял оноосон шүүхийн тогтоолд гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, үйлдсэн арга хэлбэр, **гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар,** гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шүүх шийдвэрээ үндэслэж гаргасан нотлох баримт, бусад нотлох баримтыг харгалзаж үзээгүй шалтгаан, ял шийтгэлийг хөнгөрүүлэх эсвэл хүндрүүлэх нөхцөл байдал зэргийг багтаасан байх ёстой. Шүүхийн тогтоолд иргэний нэхэмжлэх гаргах болсонтой холбоотой болон гэмт хэргийн улмаас үүссэн эд материалын хохирлыг барагдуулахтай холбоотой шийдвэр гаргасан үндэслэлээ мөн оруулсан байх шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэмт хэргийн улмаас хохирогчид үүссэн эд материалын хохирлыг сэжигтэн, яллагдагч, гэмт этгээдээр төлүүлэхээр хохирогч иргэний шүүхэд нэхэмжлэх гаргах эрхтэй бөгөөд гомдлыг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэж болно.

Гэмт хэргийн улмаас хохирогчид үүссэн эд материалын хохирлыг иргэний шүүхэд нэхэмжлэх

гаргах байдлаар шийдвэрлүүлэх боломжтой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад нэхэмжлэл гаргаагүй бол иргэний хэргийн шүүхэд жич нэхэмжлэл гаргах эрхийг нь шүүх тайлбарлан өгч шүүхийн шийдвэрт энэ талаар тусгах боломжтой.

Шүүгч гэмт этгээдэд нөхөн төлбөр төлөх эсвэл хохирол барагдуулах шийтгэл оноох үедээ модулийн 9.5.2-т өгүүлсэн зүйлсийн харгалзан үзэх хэрэгтэй.

МОДУЛЬ - 10

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ, АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү модулийн зорилго нь хил хамгаалах байгууллагын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэг дээр хохирогч төвтэй аргачлалаар ажиллах үүрэг, хариуцлагатай нь холбоотой асуудлыг ойлгох мэдлэг, чадвар олгоход оршино.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэхэд суралцах нь

Сэдэв 2 Сэжиг бүхий зорчигчтой ярилцлага хийх

Сэдэв 3 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хуурамч бичиг баримт олж илрүүлэх

Сэдэв 4 Зорчигч, ачаа тээш болон тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийх

Сэдэв 5 Хилийн хяналтыг бэхжүүлэх, хил хамгаалах ажиллагааны шилдэг туршлагуудаас суралцах нь

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хүн худалдаалах гэмт хэрэг зөвхөн улсын хил нэвтрүүлэх замаар үйлдэгддэггүй.
- Олон улсын хил давуулан худалдагдсан хүмүүсийн ихэнх нь бичиг баримтгүй цагаачид байдаг.
- Хил хамгаалах байгууллагын албан хаагчид маш чухал 2 шаардлагад нийцүүлж ажиллах шаардлагатай болдог. Нэг талаас тэд улсын хилийн аюулгүй байдлыг хангахын хажуугаар хохирогчид худалдаалагдсанаас болж хилээр хууль бусаар нэвтрэх, биеэ үнэлэх зэрэг нэг болон түүнээс олон гэмт хэрэгт холбогдсон байдаг тул холбогдох хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэн эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор өөрийгөө хохирогч гэж мэдүүлж мэдэх юм.
- Нөгөө талаас хил хамгаалах байгууллагын албан хаагчид худалдаалагдсан хохирогчдод туслалцаа үзүүлэх стандартад нийцүүлж ажиллах ёстой бөгөөд тэднийг түр хорих, торгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс сэргийлэх үүрэгтэй. Эдгээр үүргүүд нь олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогчтой зүй зохистой харьцах асуудал дээр нэгдэх ёстой.
- Хүн эх орноосоо явах, эргэж ирэх эрхтэй бөгөөд энэхүү зорчих эрхийг онцгой тохиолдолд хязгаарлаж болно.
- Хохирогч нь тухайн улсын иргэн биш байсан ч тэр улсын хилээр нэвтрэх үеэр албаны хүмүүс тэдэнтэй зүй зохистой харьцах үндсэн үүрэгтэй. Улс орнууд олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу өөрийн улсын иргэдтэй харьцаж байгаатай ижлээр харьцах ёстой бөгөөд тэдний үндсэн эрхийг нь зөрчихийг хориглоно.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/хохирогч байж болзошгүй иргэдийг түргэн шуурхай олж тогтоох нь тэднийг мөлжлөгт өртөх, дахин худалдаалагдахаас урьдчилан сэргийлдэг.
- Бичиг баримт, зорчигч, тээврийн хэрэгслийг шалгах хилийн хяналтын байгууллагууд нь хохирогчийг илрүүлэн, олж тогтоох зорилго дээр тулгуурлаж хохирогч төвтэй аргачлалаар явагдах ёстой.

Сургалтын хугацаа - 3 цаг (180 минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх;
- Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор самбар, цаас, үзгийг бэлтгэх.

Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэхэд суралцах нь	Лекц/ Хэлэлцүүлэг	20	Сэдэв 1
	Дасгал ажил 12 - Хил дээр гарсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар дүрд тоглох дасгал ажиллах	Дасгал ажиллах	30	Дасгал ажил 12
Сэдэв 2	Сэжиг бүхий зорчигчтой ярилцлага хийх	Лекц/ Хэлэлцүүлэг	10	Сэдэв 2
	Дасгал ажил 13 – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтооход хяналтын асуултын жагсаалт ашиглах нь	Дасгал ажиллах	60	Дасгал ажил 13
Сэдэв 3	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хуурамч бичиг баримт олж илрүүлэх	Лекц/ Хэлэлцүүлэг	20	Сэдэв 3
Сэдэв 4	Зорчигч, ачаа тээш болон тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийх	Багаар ажиллах	20	Сэдэв 4
Сэдэв 5	Хилийн хяналтыг бэхжүүлэх, хил хамгаалах ажиллагааны шилдэг туршлагуудаас суралцах нь	Багаар ажиллах	20	Сэдэв 5

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХ, ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ИЛРҮҮЛЭХЭД СУРАЛЦАХ НЬ

2002 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Хүний эрх болон хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зарчим, зөвлөмжийг хэвлүүлэн гаргасан байдаг. Энэхүү баримт бичигт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой хэрхэн харьцах талаар олон улсад баримтлах хэм хэмжээг тогтоосон. Зөвлөмжийн 2 (I)-д улс орнууд дараах үүрэг хариуцлагатай оролцоно. Үүнд:

Цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хууль бус гадаадын иргэдийг илрүүлэх, хүлээж авах, түр саатуулах, асуудлыг шийдвэрлэх эрх бүхий болон хүн худалдаалах гэмт хэргийг шуурхай, үнэн зөв илрүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагууд, тэдгээрийн албан хаагчдад зориулсан заавар, журам боловсруулах үүрэгтэй гэж заасан байна.

Зөвлөмжийн 2 (II)-т төрийн эрх бүхий байгууллагууд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх дээр дурдсан заавар, журмыг хэрхэн зөв хэрэглэх асуудлаар зохих сургалтуудыг зохион байгуулах үүрэгтэй гэжээ.

Хохирогчийг олж тогтоох боломжууд байсан хэдий ч албан хаагчид авто зам, төмөр зам болон агаарын орох/гарах боомтууд дээр бүх зорчигчдын бичиг баримтыг шалгаж маш их ачаалалтай ажилладаг тул хэн нэгнийг хилээр нэвтрүүлэхдээ нөхцөл байдлыг нь бүрэн ажиглах цаг гардаггүй байж болно. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шуурхай илрүүлэн олж тогтоох чиглэлээр сургалт явуулах нь хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх эхний алхам юм.

ЭНГИЙН ЗОРЧИГЧИД ДУНДААС ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ, ОЛЖ ТОГТООХ

Хил хамгаалах байгууллагын албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх үедээ улс төрийн орогнол хүссэн хүмүүс, цагаач, тусгай хэрэгцээ шаардлага бүхий төрөл бүрийн бүлэг хүмүүсийн эрхийг анхааралдаа авч ажиллах үүрэгтэй гэдгээ санах нь чухал.

Мөн шилжин суурьших асуудал нь хүн худалдаалах гэмт хэрэг, мөлжлөгт өртөх эрсдэлийг өндөр болгож байдаг гэдгийг санана уу! Эсвэл дүрвэгчид бөөнөөрөө хил давах гэж байгаад хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж, мөлжлөгийн хохирогч болох магадлалтайг санаарай. Мөн хохирогчдыг хил давуулан тээвэрлэхдээ цагаачилж байгаа бүлэг хүмүүс эсвэл гэр бүлээрээ аялж байгаа мэтээр харагдуулах байдлаар зохион байгуулсан байж ч болно. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хэрхэн олж тогтоох талаар нарийн мэдлэгтэй байх нь хэн нэгнийг хүн худалдаалах гэмт хэргийн гэмт этгээдүүдээс хамгаалах, анхаарал тавих хэрэгтэй хэн нэгнийг чөлөөлөхөд нэмэр болох болно.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Модуль 3-ын Сэдэв 2-т заасан *– "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох" болон "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээлэх нь" сэдвүүдийг тус тус эргэн харна уу.*

Хил хамгаалах байгууллагын албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч байх магадлалтай хүмүүс болон гэмт этгээдүүдтэй учирч болох талаар санууулж, өмнө нь ийм асуудалтай тулгарч байсан эсэхийг нь асууна уу.

Мөн хил хамгаалах байгууллагын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэг, мөлжлөг, хохирогч болон гэмт этгээдүүдийн талаарх мэдээлэл хэрхэн ирж болох талаар санууулна.

Модуль 1-ийн Сэдэв 3-т заасан – *"Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүнийг тодорхойлох нь" хэсгийг эргэн санаж оролцогчдод хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэгч нь ямар хүн байж болох талаар санууулна. Ингэснээр оролцогчид хил дээр болон гадаадын иргэдийг шалган нэвтрүүлэх цэгүүд дээр гэмт этгээдийг хэрхэн таних талаар ойлголт авахад нь нэмэр болно.*

ДАСГАЛ АЖИЛ 12: ДҮРД ТОГЛОХ - ХИЛ ДЭЭР/НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭР ГАРСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Сургалтад оролцогчдыг хоёр хэсэгт хувааж багуудад хоёр өөр тохиолдол өг. Баг бүр бүх оролцогчдын өмнө өөрсдийнхөө тохиолдлыг харуулж дүрд тоглох болно. Баг бүрээс сайн дураараа хил хамгаалах байгууллагын албан хаагч болон залуу эмэгтэйн дүрд тоглох хүмүүсийг сонгоно. Багууд ярилцаж байгаад хэд хэдэн хил хамгаалах байгууллагын албан хаагч, гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн улсын байцаагч, эсвэл өөр байгууллагын төлөөллийг ч байлцуулж болно. Дараах тохиолдлуудыг багуудад өгч дүрд тоглуулна. Хил хамгаалах байгууллагын ажилтан нь залуу эмэгтэйтэй хэрхэн харьцах, ямар арга хэмжээ авахаа дүрд тоглож үзүүлнэ.

Зорилт: Дүрд тоглох дасгал ажлын зорилго нь хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгүүдийн дагуу зохистой байдлаар ярилцлага хийж, хохирогчийг илрүүлэн олж тогтоох чадвар эзэмшүүлэхэд оршино.

Шаардлагатай хэрэгсэл: Дараах дүрд тоглох 2 тохиолдлыг тарааж өгөх, сандал, ширээ, үзэг, цаасан самбар, самбарын үзэг бэлдэх.

Хугацаа: 40 минут (багууд хоорондоо ярилцах 10 минут + дүрд тоглох хугацаа 20 минут + сургагч багш дүгнэлт өгөх 10 минут)

Нэгдүгээр баг: Тохиолдол 1

Та ажлын хамтрагчтайгаа ажил үүргээ гүйцэтгэж хилийн манаанд гарч байлаа. Цаг шөнө дунд болж байгаа бөгөөд саяхан цас ороод нэлээн хүйтэн байна. Та нэг тамхи татаад ирэх санаатай цэцэрлэгт очтол сандал дээр нэг эмэгтэй сууж байхыг олж харлаа. Гадаа маш хүйтэн байхад тэр эмэгтэй гадуур хувцасгүй байна.

Энэ нөхцөл байдалд хэрхэн хандаж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухайгаа үзүүлнэ үү.

Сургагч багшид сануулах нь: Хохирогчид өгөх тэмдэглэлийг хохирогчийн дүрд тоглож байгаа хүнд өгнө. (Хил хамгаалах ажилтны дүрд тоглож байгаа хүнд бүү харуулаарай.)

Хохирогчид өгөх тэмдэглэл

Таны нэрийг _____ гэдэг. Та _____ настай, ганц бие, нэгэн ядуу гэр бүлээс гаралтай. Гэр бүлд тань ажил эрхэлдэг хүн байгаагүй учраас амьдрал хэцүү байсан. Гурван долоо хоногийн өмнө та нэгэн ажлын зар харсан. Тус зар нь Итали улсад зөөгчөөр ажиллах ажлын зар байсан бөгөөд та ажилд орох хүсэлтээ илгээсэн. Танаас ярилцлага авч, та тэнцсэн байна. Та тэр хүнээс мөнгө зээлж, Италид очсоны дараа эхний сарын цалингаар эргүүлэн төлөх тохиролцоо хийсэн. Гэхдээ танд хангалттай цалин амласан бөгөөд энэ зэргийн мөнгийг буцааж өгөх нь асуудалгүй гэдэгт итгэсэн байлаа. Таныг нэгэн албан хувцастай хүн хар Мерседес машинаар нэгэн хот руу авч явсан бөгөөд та хотынх нь нэрийг санахгүй байна. Тэнд очоод таны иргэний үнэмлэх, гадаад паспорт болон танд байсан хувцас хунар бүх эд зүйлсийг хурааж авсан. Таныг өрөөнд хорьж түгжээд, гарахыг эсвэл утсаар ярихыг хориглосон. Таныг дараа нь ачааны машинд суулган нууцаар хил нэвтрүүлж Монголд авчирсан бөгөөд мөн л нэг байрны өрөөнд хорьсон. Таныг биеэ үнэлэх ажил хийж зээлсэн мөнгөө төлөхийг шаардсан. Таныг татгалзахад хариуд нь зодож шийтгэсэн. Мөн хэрэв цагдаа нар таныг олох юм бол гадаад паспорт, бичиг баримтгүй учраас таныг хүчирхийлж, зодож, шоронд хийх болно гэж айлгасан. Зугтахыг оролдвол таны өрийг гэрийнхнээс чинь гаргуулж авна, магадгүй бүр гэр бүлийнхийг нь зодож, амийг нь хорооно гэж заналхийлсэн.

Нэг өдөр та цонхоор гарч өрөөнөөсөө зугтаж чадсан. Гэтэл та хаана байгаагаа мэдсэнгүй. Гадаа хүйтэн, цас орчихсон, танд гадуур дулаан хувцас байхгүй. Ингээд та ойр байсан нэгэн цэцэрлэгт ирж сандал дээр сууж яахаа мэдэхгүй байж байлаа. Та ганцаараа, айсан байдалтай байгаа.

Гэтэл та албаны хувцастай хоёр хүн ирж явааг харлаа. Тэдгээр албан хаагчид тантай яаж харьцаж байгаад тааруулан харьцана уу.

Хоёр дугаар баг: Тохиолдол 2

Та нисэх онгоцны буудал дээрх шалган нэвтрүүлэх цэг дээр ажил үүргээ гүйцэтгэж байлаа. Хоёр эмэгтэй хил нэвтрэхээр ирж байхтай таарлаа. Та тэднийг нэг нэгээрээ шалган нэвтрүүлэх цэг дээр ирж баримт бичгээ шалгуулахыг дохилоо. Нэг нь настайвтар, нөгөө нь залуу эмэгтэй байв. Залуу эмэгтэй нь нүднийхээ булангаар ахимаг насны эмэгтэй рүү байн байн хараад, сандарсан байдал нүдэнд нь харагдаж байна.

Тус тохиолдолд хэрхэн ажиллахаа ярилцаж дүрд тоглон үзүүлнэ үү.

Сургагч багшид сануулах нь –Хохирогчид өгөх тэмдэглэлийг хохирогчийн дүрд тоглож байгаа хүнд л өгнө. Хил хамгаалах ажилтны дүрд тоглож байгаа хүнд бүү харуулаарай.

Хохирогчид өгөх тэмдэглэл

Таны нэрийг _____ гэдэг. Та _____ настай, ганц бие, нэгэн ядуу гэр бүлээс гаралтай. Гэр бүлд тань ажил эрхэлдэг хүн байгаагүй учраас амьдрал хэцүү байсан. Гурван долоо хоногийн өмнө та нэгэн ажлын зард хариулсан байна. Тус зар нь Итали улсад зөөгчөөр ажиллах ажлын зар байсан бөгөөд та ажилд орох хүсэлтээ илгээсэн. Танаас ярилцлага авч, та тэнцсэн байна. Гэхдээ та тэр хүнээс мөнгө зээлж, Италид очсоны дараа эхний сарын цалингаараа эргүүлэн төлөх тохиролцоо хийсэн. Гэхдээ танд хангалттай цалин амласан тул энэ зэргийн мөнгийг буцааж өгөх нь асуудалгүй гэдэгт итгэсэн байлаа. Таныг нэгэн үл таних хүн хар Мерседес машинаар нэгэн хот руу авч явсан бөгөөд та хотынх нь нэрийг санахгүй байна. Тэнд очоод таны иргэний үнэмлэх, гадаад паспорт болон танд байсан хувцас хунар бүх эд зүйлсийг хурааж авсан. Таныг өрөөнд хорьж түгжээд, гарахыг эсвэл утсаар ярихыг хориглосон. Таныг дараа нь ачааны машинд суулган нууцаар хил нэвтрүүлж Монголд авчирсан бөгөөд мөн л нэг байрны өрөөнд оруулж хорьсон. Таныг биеэ үнэлэх ажил хийж зээлсэн мөнгөө төлөхийг шаардсан. Таныг татгалзахад хариуд нь зодож шийтгэсэн. Мөн хэрэв цагдаа нар таныг олох юм бол гадаад паспорт, бичиг баримтгүй учраас таныг хүчирхийлж, зодож, шоронд хийх болно гэж айлгасан. Зугтахыг оролдвол таны өрийг гэрийнхнээс чинь гаргуулж авна, магадгүй бүр гэр бүлийнхийг нь зодож, амийг нь хорооно гэж заналхийлсэн.

Нэг өдөр, таныг хорьж байсан хүмүүсийн нэг нь буюу нэгэн ахимаг насны эмэгтэй таныг авч Турк улс руу явах болно гэж хэлээд нисэх онгоцны буудал дээр ирлээ.

Та одоо нисэх онгоцны буудал дээр ирээд хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр хил хамгаалах байгууллагын албан хаагчийн өмнө зогсож байна. Тус албан хаагч тантай хэрхэн харьцаж байгаад тааруулан харьцана уу?

СЭДЭВ 2: СЭЖИГ БҮХИЙ ЗОРЧИГЧТОЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ

1. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД ЯРИЛЦЛАГА ХИЙХ НЬ

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдад гэмт хэргийн хохирогч, хохирогч байх магадлалтай хүмүүс, гэмт этгээд зэрэг сэжиг бүхий зорчигчтой ярилцлага хийх шаардлага байнга тулгардаг. Хилээр/нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх цэгээр гарч, орж, дамжин өнгөрч байгаа хүмүүстэй ярилцлага хийхдээ дараах жишиг асуултууд[47]-ыг ашиглаж аливаа асуудлыг илрүүлэх, дамжин өнгөрч буй зорилгыг тодруулах боломжтой.

САНУУЛАХ НЬ:

Тухайн зорчигчийг гэмт этгээд үү, хохирогч уу гэдгийг тогтооход ижил төрлийн асуултуудыг хэрэглэж болдог.

Хүн бүрээс асуулт бүрийг нэг бүрчлэн асуух шаардлагагүй. Жишээ нь: хэрэв хэн нэгэн хохирогч байх магадлалтай мэт санагдвал элсүүлэлттэй холбоотой асуултуудыг асуусны дараагаар мөлжлөгтэй холбоотой асуултуудыг асуух шаардлагагүй.

Хэрэв тухайн гадаадын иргэн Монгол Улсад худалдаалагдаад мөлжлөгт өртсөн байсан ба одоо өөр улс руу зорчиж байгаа бол мөлжлөгтэй холбоотой асуултуудыг асуух нь зөв.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчид хяналтын асуултуудын жагсаалтад байгаа бүх асуултыг асуух шаардлагагүй. Зарим асуултуудын хариулт дээр үндэслэн хохирогч, хохирогч байх магадлалтай, эсвэл гэмт этгээд гэж үзвэл цагдаагийн байгууллагаар шалгуулахаар хамгийн ойрын цагдаагийн хэлтэст ярилцлагын дүгнэлтийн хамтаар шилжүүлнэ. Визтэй холбоотой асуудлаар гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандана.

Хяналтын асуултууд - ЭЛСҮҮЛЭЛТ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тухайн хохирогч гэмт этгээдүүдтэй хамгийн анх хэзээ уулзсан гэх мэт үйл явдал эхэлсэн он, сар, өдөр (Хэрэв хохирогч он, сар, өдрийг санахгүй бол хохирогчийн амьдралд тохиолдсон тодорхой үйл явдалтай нь холбож хэзээ эхэлсэн байж болохыг тогтоох гэж оролд).
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох - Анх уулзсан газар Тухайн газрын нэр, хаяг зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл
ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Хэнтэй хамт аялж байгааг тогтоох (сэжигтэнтэй юу?)? Хамт аялж байгаа хүнээ урьд нь таньдаг байсан уу? Хэн танилцуулсан бэ? Хамт аялж буй хүний талаар нарийн мэдээлэл Нэр

47 2011 оны АСЕАН-ы ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг мэргэжлийн байцаагчдад зориулсан Сургалтын хөтөлбөрөөс авав.

ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Юу болсон тухай Хохирогч яагаад гэрээсээ явах болсон шалтгаан Хохирогч эхэндээ хэн нэг өөр хүнтэй хамт явсан уу? Хүчээр гэрээсээ явах шийдвэр гаргасан уу? Тийм бол яг юу болсон? Хохирогчид ямар нэг шинэ боломж санал болгосон эсэх, амлалт өгсөн эсэх. Ажил санал болгосон бол ямар ажил, цалингийн хэмжээ, нөхцөл Хохирогчид тухайн санал болгосон ажлын зар эсвэл байгуулсан гэрээний хуулбар байна уу? (байвал авч хадгалах).
ЯАГААД	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч яагаад амлалтад зөвшөөрсөн Хохирогч очих газраа хэрхэн төсөөлж байсан бэ
Хяналтын асуултууд - ТЭЭВЭРЛЭЛТ/ ШИЛЖИН СУУРЬШИХ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тухайн хохирогч гэмт этгээдүүдтэй хамгийн анх хэзээ уулзсан гэх мэт үйл явдал эхэлсэн он, сар, өдөр Мөлжлөг болсон газарт хохирогч хэзээ анх ирсэн
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох- Хохирогч хаанаас явж байгаа? Ямар замналаар явж ирсэн? Хэрэв тус хэрэг нь хил дамнасан хэрэг бол хохирогчийг хилээр хууль бусаар нэвтрүүлсэн үү? Тийм бол хохирогч хаагуур хэрхэн хил нэвтэрсэн талаар мэдэж байна уу? Хэрэв тус хэрэг нь хил дамнасан хэрэг бөгөөд хохирогчийг хилээр хууль бусаар нэвтрүүлээгүй бол хилийн аль боомтоор гарсан бэ? Өөр улсаар дамжиж, өөр улсаас ирсэн бол аль хилийн боомтуудаар тухайн улсад орж/гарсан бэ? Мөлжлөг болсон газарт очихдоо хохирогч аль хилийн боомтоор тухайн улсад гарсан бэ?
ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогчтой хамт аялж байсан сэжигтэн/гэмт хэрэгтний талаарх мэдээлэл Тэдгээр сэжигтэн/гэмт этгээдийн аяллын туршид гүйцэтгэсэн үүрэг Өөр бусад хохирогч хамт явсан бол тэдний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл Нэр болон гадаад төрхийг дүрслэх
ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тээвэрлэхдээ ямар арга хэрэглэсэн бэ? Алхсан, автомашин, галт тэрэг, завь, нисэх онгоцоор зорчсон эсэх Бичиг баримт хэрэглэсэн үү? Тийм бол хохирогчийн хэрэглэсэн бичиг баримт дээр хэний нэр байсан бэ? Тээврийн хэрэгслийн компаниар явсан бол ямар агаарын тээврийн компани байсан гэх мэт Билет захиалсан бол төлбөрийг нь хэн хэрхэн төлсөн тухай Хохирогчид бичиг баримт, аяллын үнэмлэх (гадаад паспорт) байгаа эсэх (байвал түр хураж авах).
ЯАГААД	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч сэжигтэнтэй яагаад хамт аялах болсон шалтгаан Хэрэглэсэн арга, явсан замыг сонгоход юу нөлөөлсөн тухай
Хяналтын асуултууд – МӨЛЖЛӨГ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч мөлжлөгт өртөж эхэлсэн он, сар, өдөр, мөлжлөгийн нөхцөл байдалд орсноо хэзээ хэрхэн ойлгосон бэ? Очих газраа хүрснээс хэдий хэр хугацааны дараанаас ямар нэг байдлаар мөлжлөгт өртөж эхэлсэн бэ?
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох - Мөлжлөг болсон газрын байршлыг олж мэдэх

ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Бусад хохирогчдын талаар: Тухайн газарт байгаа өөр бусад хохирогчдын талаарх мэдээлэл Тэдний нас, хүйс, улсын харьяалал, ярьж байсан хэл Хохирогчид тус газарт хэр удаж байгаа талаарх мэдээлэл Гэмт этгээдүүдийн талаар: Тухайн газар хэдэн гэмт этгээд байгаа вэ? Нэр, нас, хүйс, улсын харьяалал, ярьдаг хэл, гадаад төрхийн талаарх мэдээлэл
ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Мөлжлөгийн хэлбэрийг олж мэдэх. Жишээ нь хөдөлмөрийн мөлжлөг, хүчээр биеийг нь үнэлүүлсэн, гэрийн үйлчлэгч хийлгэсэн, эд эрхтнийг нь авсан гэх мэт Хохирогчид анх амласан ажил юу байсан бэ? Гэтэл бодит байдал дээр ямар ажил байсан бэ?

ДАСГАЛ АЖИЛ 13 – ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХОД ХЯНАЛТЫН АСУУЛТЫН ЖАГСААЛТ АШИГЛАХ ТУХАЙ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дээрх хяналтын асуултуудын жагсаалтыг сургалтад оролцогчдод тарааж өгнө. Дараа нь оролцогчдыг хоёр хэсэгт хуваан 2 төрлийн тохиолдол тарааж өгнө. Хилээр гарч/орж буй хохирогч эсвэл гэмт этгээдийг илрүүлэхдээ асуух асуултуудаа сонгон жагсааж бичихийг санал болгоно. Багийн ахлагч гарч ирж баг дотроо ярилцсан зүйлсээ танилцуулна.

Тохиолдол дээрх хүний нэрс (хохирогч болон гэмт этгээдийн), байршил, хаяг зэрэг нь зохиомол гэдгийг анхаарна уу. Тохиолдлыг шинжлэх хялбарчлах амарчлах зорилгоор зохиомол нэрс өгсөн болно.

Шаардлагатай хэрэгсэл: Тохиолдлыг хэвлэж тарааж өгөх, цаасан самбар, үзэг бэлдэх

Тохиолдол 1

Сараа 24 настай Орхон аймгийн оршин суугч. Тэрээр ногоо зарж орлого олдог, бага насны хоёр хүүхэдтэй, бэлэвсэн эмэгтэй. Нэг өдөр түүний нэг найз нь Бээжинд хүүхэд харах ажил хийх санал тавьжээ. Сарынхаа орлогоос арав дахин их мөнгө олох боломжтой гэж хэлсэн байна. Мөн Бээжин явах зардлыг нь гаргаж, шинэ ажилдаа ороод мөнгийг нь эргүүлж өгч болно гэжээ. Сараад мөнгө байхгүй тул саналыг нь дуртайяа хүлээн авчээ.

Илүү их орлого олох нь гэр бүлд нь хэрэгтэй гэж бодоод Сараа хүүхдүүдээ ээждээ үлдээгээд найзтайгаа автобусанд сууж хилийн зүг явжээ. Сараад гадаад паспорт байхгүй ч найз нь хил дээр таньдаг хүнтэй тул шинээр авах шаардлагагүй гэж хэлжээ. Хэсэг хугацааны дараа нэгэн үл таних эрэгтэй ирж танилцлаа. Тэр хүн Сарааг хилээр гарахад туслахаар болжээ.

Ингээд гурвуулаа Монгол улсын хилээр гарахаар завдаж байхад нь хил хамгаалах байгууллагын албан хаагч тэднийг илрүүлэн саатууллаа.

Тохиолдол 2

Жин Су 14 настай, Хойд Солонгосын нэгэн тосгонд амьдардаг. Ээж нь 6 хүүхдийг ганцаараа өсгөж хүмүүжүүлж байгаа бэлэвсэн эмэгтэй. Тэдний нутагт ган болж, хүүхдүүдээ хооллох хоол олно гэдэг маш хүнд асуудал болжээ. Хамгийн том хүү Жин Су нь дүү нараа тэжээх үүрэгтэйгээ ухамсарлаж ээждээ тусалдаг байлаа. Тэрээр өмнө нь хөрш айлуудаа тусалж бага хэмжээний мөнгө олдог байсан боловч ган гачиг болсон тул хөршүүд нь ч мөнгөгүй болжээ.

Нэгэн өдөр ээж нь Жэймс гэх хүнтэй танилцсан бөгөөд тэр хүн Монголд уурхайд ажиллах

боломжтой бие хаа сайтай залуусыг хайж байгаа гэжээ. Тэрээр Жэймсд 14 настай хүүтэй бөгөөд хүүдээ ажил хайж байгаа гэдгээ хэлжээ. Жэймс өдөрт 50 ам.долларын цалинтай, сайн хоолтой, ажлынхаа хажууд бэлэн байртай ажил санал болголоо. Цалингийн хэмжээ нь Жин Сугийн ээжид хүүхдүүдээ хэсэг хугацаанд ч болов хооллоход хангалттай их мөнгө бөгөөд цалингаас нь байнга авч байх боломжтой тул тохиролцоонд хүрчээ.

Жин Су гэрээсээ явахдаа дургүйхэн байсан боловч гэрийнхэндээ тусалж байгаадаа баярлаад өөр 4 хүүгийн хамтаар замын унаанд дайгдан хэдэн өдөр явж, замаар явган алхаж, ихэнхдээ ачааны машины ачаанд сууж яваад хилээр гарснаа ч мэдсэнгүй. Ингээд тэд нэгэн уурхайд ирж, бусад хүүхдүүдийн хамтаар тэндээ үлджээ. Жэймсийг уурхайд ажилладаг хүнээс мөнгө авч байхыг хүү харсан байна.

Тус уурхайд Жин Сутай хамт нэлээд хэдэн хөвгүүд өдөрт 10-аас дээш цаг ажилладаг. Жижиг биетэй хүүхдүүдийг уурхайн гүн рүү оруулж ажиллуулдаг бөгөөд Жин Су шөнө болгон үхэхээс айж уйлдаг байлаа. Хүүхдүүдэд ажилласны хөлс өгдөггүй, өглөө оройдоо өдөрт хоёр удаа багахан л хоол өгдөг. Шөнө хүүхдүүд нэг жижиг бохир өрөөнд дэвсгэр ч байхгүй шалан дээр унтдаг. Гэхдээ нөмрөх нимгэн хөнжил өгдөг. Хүүхдүүдийг үгэнд нь орохгүй эсвэл хангалттай сайн ажиллахгүй байна гэж үзвэл дарга нь зоддог.

Олон сар ажилласны эцэст Жин Су ядарч, хүнд нөхцөл байдлаас залхан гэрээ санаж эхэлжээ. Тэрээр яаж гэртээ харихаа мэдэхгүй ч хэнд ч хэлэлгүйгээр уурхайгаас явахаар шийджээ. Ингээд уурхайгаас зугтаж, хилийн (боомтын нэр) боомтын ойролцоо төөрсөн явж байгаад олджээ.

Өөрийгөө үнэлэх дасгал ажил

1. Дээрх хоёр тохиолдол дээр тус тусад нь асуух асуултын жагсаалт гаргаж бэлдэх.
2. Сургагч багш Сэдэв 1 дээр дүрд тоглох дасгал ажилласан оролцогчдоос жишиг хяналтын асуултын жагсаалт ашиглаж ярилцлага хийж хүнтэй харилцахаас хэр өөр байсан тухай асууна.
3. Хүн худалдаалах хэрэг мөн байна гэж дүгнэлт гаргахад хүргэдэг хамгийн анх илрэх шинж тэмдгүүд юу вэ?
4. Зорчигчтой ярилцлага хийсний дараа хилийн ажилтны хийх дараагийн алхам юу вэ?
5. Дээрх хоёр тохиолдолд цагдаа, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага, төрийн бус байгууллагууд, хохирогчид туслалцаа үзүүлдэг байгууллагууд гэх мэт бусад талуудыг оролцуулах шаардлага байна уу? Тийм бол ямар байгууллагуудыг хамруулах шаардлагатай вэ? Яагаад?

2. Хил хамгаалах байгууллагын албан хаагчид хохирогчийг шилжүүлж, туслалцаа хүсэх

Хил хамгаалах байгууллагын албан хаагч нар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч эсвэл гэмт этгээдийг үнэн зөв тогтоосны дараагаар эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэх бөгөөд тухайн эрх бүхий байгууллага нь хохирогчийг хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдсон гэж үзвэл тусламж, дэмжлэг үзүүлж шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

Эсвэл хил хамгаалах байгууллагын албан хаагчид нь хохирогчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдсэнээр цагдаагийн байгууллагад шууд шилжүүлж болно.

Гэмт этгээд гэдэг нь тогтоогдсон, түр саатуулагдсан хүмүүсийг хуулийн дагуу хариуцлагын арга хэмжээ авхуулахаар цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгнө.

Монгол улсын аль ч хилийн шалган нэвтрүүлэх боомтоор орохоор/гарахаар завдсан хүчин төгөлдөр бичиг баримтгүй, гадаад паспортын эсвэл визний хүчинтэй хугацаа нь дууссан гэх мэт зөрчилтэй гадаадын иргэний асуудлыг хил хамгаалах байгууллагын албан хаагчид гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ. Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн гадаадын иргэний асуудлыг судалж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой эсэх, эсвэл зүгээр Монгол улсад нэвтрэх, оршин суух бичиг баримтынх нь хугацаа дууссан эсэхийг тогтооно. Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын улсын байцаагч нь тухайн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч тухайн гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхээс татгалзах эсвэл хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэй байдал илэрвэл шалгуулахаар цагдаагийн байгууллагад хандах үүрэгтэй.

СЭДЭВ 3: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХУУРАМЧ БИЧИГ БАРИМТ ОЛЖ ИЛРҮҮЛЭХ

ГЭМТ ЭТГЭЭДҮҮД ХОХИРОГЧОО ТЭЭВЭРЛЭХИЙН ТУЛД ЯНЗ БҮРИЙН АРГА ХЭРЭГЛЭДЭГ:

- Нууцаар тээвэрлэх – хохирогчдыг хилээр далд байдлаар явган эсвэл тээврийн хэрэгсэл, усан онгоц, завь, нисэх онгоцонд нууж тээвэрлэх.
- Ил тээвэрлэх – хохирогч өөрийнхөө хүчин төгөлдөр баримт бичгээр, эсвэл хулгайлсан, хуурамчаар үйлдсэн баримт бичгээр хил нэвтрэх буюу хилийн шалган нэвтрүүлэх боомтоор зорчих.

Зарчмын хувьд хохирогчийг хэдий хэр хол тээвэрлэнэ, эцсийн хүрэх газраа хүртэл тэд ямар нэг бичиг баримттайгаар хилээр гарч, ордог байна.

Ихэнх тохиолдолд аяллын туршид хохирогчтой гэмт хэргийн сүлжээний нэг эсвэл хэд хэдэн гишүүн хамт явдаг. Тэдгээр нь хохирогчийг хүрэх газарт нь аюулгүй, найдвартай хүргэж өгөх үүрэгтэй байдаг.

Дотооддоо үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэргүүдэд нууцаар тээвэрлэх эсвэл аяллын бичиг баримтыг хууль бусаар ашиглах шаардлага гардаггүй.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Оролцогчдыг Модуль 3-т гарсан хохирогчийг олж тогтоох, биеэ хэрхэн авч явдаг зэрэг хил хамгаалах албан хаагчдад сэжиг төрүүлэх ямар ямар үзүүлэлтүүд байдаг талаар эргэн сануулаарай.

Дараах асуудлуудын талаар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлээрэй.

- *Хилийн манаа, хилийн боомт, хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгалт явуулах цэгүүд дээр ажиллаж байгаа албан хаагчид паспорт, виз шалгахдаа зорчигчдыг улсын хилээр/нисэх буудлаар орох болон гарахад нь бичиг баримтыг нь хэрхэн шалгадаг журамтай вэ?*
- *Зорчигч хилээр/нисэх онгоцны буудлаар орох, гарах үед хил хамгаалах байгууллагын албан хаагчид зорчигчийн ямар баримт бичгийг хэрхэн шалгадаг вэ?*
- *Бичиг баримт нь жинхэнэ эсвэл хуурамч эсэхийг хэрхэн илрүүлэх вэ?*
  - *Гадаад паспорт дээрх зураг, хүйс, нас нь зорчиж буй хүнтэй (эсвэл бусад бичиг баримттай нь) таарч байгаа эсэхийг нягтлах. Тухайн бичиг баримтын хүчинтэй хугацааг шалгах, хүчингүй болоогүй эсэхийг шалгана. Бичиг баримтад нь хуурамчаар үйлдсэн, дуураймал байх шинж тэмдэг байгаа эсэхийг шалгах.*
  - *Хилээр нэвтрэхэд виз шаардлагатай бөгөөд (хүчин төгөлдөр) виз байгаа тохиолдолд паспортын бусад хуудсууд дээрх орсон/ гарсан тэмдэглэгээ, бусад улсын визийг нь шалгаж тухайн хүн хаана, хаана байсан, Монгол улсын хуульд нийцэхгүй зүйл байгаа эсэхийг шалгана.*
- *Монгол улсад паспортыг шалгах нэгдсэн, төвлөрсөн бүртгэлийн систем бий юу?*
- *Бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн байхыг нотлохоор тус бичиг баримт дээрх ямар мэдээллийг шалгах вэ?*
- *Хуурамч бичиг баримтыг илрүүлэх ямар техник технологи ашигладаг вэ? [(нүдээрээ) мэдээллийн хуудсан дээрх MRZ нууцлалыг шалгах; (электрон хэлбэрээр) нүүрэн хуудас дээрх RFID ялтсыг шалгах, хурууны хээг уншуулах, хуурамч бичиг баримт илрүүлэгч машинаар шалгах гэх мэт].*
- *Монгол улсад зорчигчдын мэдээллийг интерпол, террорист бүлгэмүүдийн нэрсийн жагсаалт, бүртгэлээс шалгах, цагдаагийн болон бусад бүртгэлийн системээс шалгах дүрэм, журам байдаг уу?*
- *Бичиг баримттай холбоотой сэжигтэй асуудал гаргахад хохирогч эсвэл хохирогч байх магадлал бүхий хүмүүс ямар байдал гаргадаг вэ?*
- *Хэсэг бүлэг хүмүүс аялж байхад нэг хүн бүх хүмүүсийнхээ баримт бичгийг авч, бусдадаа зааварчлах, захирах маягтай харьцах, бусдынхаа өмнөөс хил хамгаалах байгууллагын албан хаагчтай ярилцаж байвал та юу хийх вэ?*
- *Хэрэв та тухайн хүнд (хохирогч байх магадлалтай) хандаж асуулт асуусан боловч таны асуултад хариулж чадахгүй, хамт явж байгаа хүн рүү байн байн хараад байвал та ямар арга хэмжээ авах вэ?*
- *Хэрэв тухайн хүн (хохирогч байх магадлалтай) бүх л асуултад урьдчилж бэлдсэн мэт хариулж, нэг л үнэмшилгүй, өөртөө итгэлгүй хариулж байвал та яах вэ?*
- *Хил дээр хэн нэгэн нь хүн худалдаалах гэмт хэрэг илрүүлж байсан уу? Тийм хүн байвал бусад оролцогчидтойгоо туршлагаасаа хуваалцана уу?*

САНАМЖ:

Энэхүү сургалтын хөтөлбөрт улсын хил дээр ажилладаг албан хаагчдад орчин үеийн техник, технологи, хуурамч бичиг баримт илрүүлэх аргачлалуудыг үр ашигтайгаар хэрэглэх ач холбогдлыг тодотгоно. Сургагч багш энэ бол сургалтын хөтөлбөр бөгөөд хилийн боомтуудыг сайжруулах, техник технологийг шинэчлэх санал энэхүү сургалтын хөтөлбөрийн агуулгад байхгүй гэдгийг сануулж хэлнэ.

СЭДЭВ 4: ЗОРЧИГЧ, АЧАА ТЭЭШ БОЛОН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ҮЗЛЭГ, НЭГЖЛЭГ ХИЙХ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Сургалтад оролцогчдод Модуль 3 дээрх хохирогчийг олж тогтооход хэрэглэгддэг олон төрлийн үзүүлэлтүүд байдаг тухай сануулаарай. Мөн хилийн хяналтын ажилтнуудад сэжиг төрүүлэхүйц ямар байдал гаргаж болох талаар эргэн сануулаарай.

Дараах асуудлуудын талаар ярилцаарай

- *Хилийн манаа, хилийн боомт, хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгалт явуулах цэгүүд дээр ажиллаж байгаа албан хаагчид зорчигчдыг улсын хилээр/нисэх онгоцны буудлаар орох болон гарах үед зорчигч, түүний ачаа тээш болон тээврийн хэрэгслийг хэрхэн шалгадаг вэ?*
- *Ачаа тээш эсвэл тээврийн хэрэгсэлд нарийн үзлэг, шалгалт хийх шаардлагатай ямар нэг сэжиг байгааг гаднах байдлыг үндэслэн хэрхэн тодорхойлох вэ?*
- *Монгол улсад сэжиг бүхий тээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэл байдаг уу?*
- *Зорчигч, ачаа тээш, тээврийн хэрэгслийн юу юуг хэрхэн тусгайлан шалгаж сэжигтэй байгаа эсэхийг тогтоох вэ? (хэрхэн сэжигтэй байна гэсэн дүгнэлтэд хүрэх вэ?)*
- *Зорчигч, ачаа тээш, тээврийн хэрэгслийг шалгахдаа ямар техник технологи хэрэглэдэг вэ?*
- *Хилийн боомт/нисэх онгоцны буудал дээр сэжиг бүхий ачаа тээш, зорчигч, тээврийн хэрэгслийг илрүүлэхэд ямар нэмэлт туслалцаа шаардлагатай болдог вэ? (үнэрч нохой гэх мэт)*
- *Тухайн тээврийн хэрэгсэл нь хулгайлагдсан гэсэн дүгнэлтийг хэрхэн гаргах вэ?*
- *Тээврийн хэрэгслийн баримт бичгийг (бүртгэлийн гэрчилгээ, даатгал гэх мэт) хуурамчаар үйлдсэн эсэхийг хэрхэн шалгаж илрүүлэх вэ?*
- *Монгол улсад зорчигч, ачаа тээш, тээврийн хэрэгслийн мэдээллийг интерпол, террорист бүлгэмүүдийн нэрсийн жагсаалт, бүртгэлээс шалгах, цагдаагийн болон бусад бүртгэлийн системээс шалгах дүрэм, журам байдаг уу?*
- *Ачаа тээш, тээврийн хэрэгсэл нь сэжигтэй тохиолдолд зорчигч (хохирогч байж болох хүмүүс болон гэмт этгээдүүд) ямар зан авир гаргадаг вэ?*
- *Хэрэв нэг хэсэг бүлэг хүмүүс бөөгнөрч, нэг хүний удирдлага дор байнга үгэнд нь орж, тээврийн хэрэгслээсээ буух, суух зааврыг биелүүлж, эсвэл бусдынхаа ачаа тээшийг нэг нь авч явж байвал та юу хийх вэ?*
- *Хэрэв та тухайн хүнд (хохирогч байх магадлалтай) хандаж асуулт асуусан боловч таны асуултад хариулж чадахгүй, тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүн рүү байн*

байн хараад байвал та ямар арга хэмжээ авах вэ?

- *Хэрэв тухайн хүн (хохирогч байх магадлалтай) ачаа тээш, бусад хамт аялагчид болон тээврийн хэрэгслийн талаарх асуултад урьдчилж бэлдсэн мэт хариулж, нэг л үнэмшилгүй, өөртөө итгэлгүй хариулж байвал яах вэ?*
- *Хил дээр хэн нэгэн нь ачаа тээш, тээврийн хэрэгсэл шалгаж байгаад хүн худалдаалах гэмт хэрэг илрүүлж байсан уу? Тийм хүн байвал бусад оролцогчидтойгоо туршлагаасаа хуваалцана уу?*

САНАМЖ:

Энэхүү сургалтын хөтөлбөрт улсын хил дээр ажилладаг албан хаагчдад орчин үеийн техник, технологи, хуурамч баримт бичгийг илрүүлэх аргачлалуудыг үр ашигтайгаар хэрэглэх ач холбогдлыг тодотгоно. Сургагч багш энэ бол сургалтын хөтөлбөр бөгөөд хилийн шалган нэвтрүүлэх боомтуудыг сайжруулах, техник технологийг шинэчлэх санал энэхүү сургалтын хөтөлбөрийн агуулгад байхгүй гэдгийг сануулж хэлнэ.

СЭДЭВ 5: ХИЛИЙН ХЯНАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ, ХИЛ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНЫ ШИЛДЭГ ТУРШЛАГУУДААС СУРАЛЦАХ НЬ

1. ХИЛИЙН ХЯНАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг протоколд нэгдсэн улс орнуудын хууль сахиулах байгууллагууд гэмт этгээдийг илрүүлэх, хохирогчийг олж тогтоох, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга замуудын талаар мэдээлэл солилцох, хууль хяналтын албан хаагчид болон хохирогчид туслалцаа үзүүлдэг албан хаагчдыг сургах асуудлаар хамтран ажиллах үүрэгтэй байдаг (10-р зүйл). Мөн улс орнууд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхээр хилийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Үүнд хилийн хяналтаа сайжруулах, худалдааны тээврийн бичиг баримт, визний шалгалтад тавигдах шалгууруудыг чангатгах, паспорт болон бусад бичиг баримтын чанарт тавигдах тусгай стандарт тогтоох (12-р зүйл), мөн гадаадад ашиглагдаж байгаа өөрсдийн бичиг баримтын хүчин төгөлдөр байдлыг хянахад хамтарч ажиллах үүрэгтэй (13-р зүйл).

Хүн худалдаалахын эсрэг протоколд нэгдсэн улс орнууд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой мэдээллээ харилцан солилцож хамтарч ажиллана (10-р зүйлийн 1).

2016 оны 12 дугаар сарын 28 өдөр батлагдаж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Монгол улсын хилийн тухай хууль нь улсын хилийн тогтолцоо, хил хамгаалах дүрэм, журам, хил хамгаалах байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, хил хамгаалах ажиллагаа дахь иргэн, байгууллагуудын оролцоог тодорхойлсон байдаг. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад

оршино.

Монгол улсын хилийн хил хамгаалах байгууллагын үүрэг нь улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх; улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах; хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах; улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх; хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх; улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах; улсын хилийн зурвас, хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах; хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох; агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гадаад улсад зорчиж, ажиллах сонирхолтой Монгол иргэдийн хилээр нэвтрэхдээ хуурамч/хулгайлагдсан бичиг баримт ашиглах зэрэг хууль бус үйл ажиллагаа нэмэгдсээр байна. Түүнчлэн, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл Монгол улсын иргэдийг тодорхой үнэ төлбөртэйгөөр бусад улсууд руу худалдаж байгаа нь тодорхой болоод байна. Мөн хялбар аргаар мөнгө олох гэсэн хүмүүс хориотой бараа бүтээгдэхүүнийг нуун далдаж хилээр гаргах, тээвэрлэх явдал гарч байна.

Монгол улсад хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэхтэй холбоотой улсын хилийг хамгаалах үүрэгтэй төрийн байгууллагуудын чиг үүрэг нь:

Хил хамгаалах ерөнхий газар: Хилээр орох/гарах хөдөлгөөнийг удирдах, хяналт шалгалт хийх, хилийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй.

Гадаадын иргэн, харьяатын газар: Гадаадын иргэдийн визний зөрчил илрүүлэх, түр саатуулах, албадан гаргах асуудлыг зохицуулах үүрэгтэй.

2. ХИЛ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААН ДАХЬ ОЛОН УЛСЫН ШИЛДЭГ ТУРШЛАГААС

Хил хамгаалах ажиллагааны олон улс дахь шилдэг туршлагуудаас:

1. ***Олон талт аргачлал*** – Хил хамгаалах байгууллагын хувьд холбогдох бүхий л эрх бүхий байгууллагуудтай цогц байдлаар хамтран ажиллах. Жишээ нь, цагдаа, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид нь хил хамгаалах байгууллагын албан хаагчидтай ажлаа уялдуулах, хамтарч ажиллах г.м. Ингэснээр хилийн шалган нэвтрүүлэх боомтууд дээр талууд хоорондоо хурдан харилцан ажиллаж, мэдээлэл солилцож, зөв шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх зэрэг давуу талтай.
2. ***Мэдээлэл солилцох асуудлаар улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх*** – Гэмт этгээд эсвэл хохирогчийн хуурамч баримт бичгийг илрүүлэх зорилгоор улс орнуудын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр баримт бичгийн харагдах байдал, тамга, тэмдэг болон бусад нарийн мэдээллийн талаар мэдээлэл солилцох.
3. ***Тагнуулын мэдээлэл солилцох чадавхыг сайжруулах*** - Хил хамгаалах байгууллагын тогтолцоог сайжруулахаар нууц мэдээллийг илүү үр ашигтайгаар цуглуулах, солилцох, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны тогтсон/нэгдсэн сүлжээ бий болгох. Ингэснээр хил дээрх мэдээллийн системийн чадавхыг үнэлэх, харилцаа холбооны стратеги, сүлжээ шинээр бий болгох, мэдэгдсэн хэргүүдийн байршлууд дээр үндэслэж нэмэлт хилийн боомт байгуулах шаардлага байгаа эсэхийг тогтоох, нууц мэдээлэл солилцох,

сургалт зохион байгуулахад шаардлагатай байгаа харилцаа холбооны сүлжээ, эсвэл техник тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлох боломж бүрддэг.

4. ***Хилийн хяналтын болон цагдаагийн байгууллагын хоорондхамтын ажиллагааны гэрээ байгуулах*** – Холбогдох мэдээлэл хамгаалах дүрэм журамд нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг түргэн шуурхай тогтоох зорилгоор мэдээллээ хоорондоо хуваалцах ажлыг зохицуулах гэрээ байгуулах. Хил дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болох үндэслэл илрэнгүүт дэмжлэг, туслалцаа үзүүлэх ёстой гэдгийг хилийн хяналтын албан хаагчид мэдэж байх ёстой. Хил хамгаалах үүрэг бүхий байгууллагууд эрх бүхий төрийн байгууллагуудтай болон цаашлаад холбогдох тусламж, дэмжлэгийг үзүүлдэг төрийн бус байгууллагуудтай зохистойгоор хамтран ажиллах механизм бүрдүүлэх ёстой.
5. ***Мэдээлэл цуглуулах, мэдээлэл солилцох*** – Хил хамгааллын байгууллагын албан хаагчид худалдаалагдсан хүмүүстэй холбоотой бүхий л мэдээллийг мэдээлэл хамгаалах хууль, дүрмийн дагуу цуглуулж, нас, хүйс, иргэншил, өртсөн мөлжлөгийн хэлбэр болон ямар бичиг баримттай байсан, аяллын ямар маршрутаар явсан зэрэг бусад чухал мэдээллүүдийг ангилж, хадгалах, мэдээллийн сан бүрдүүлэх. Тус мэдээллийг цагдаа, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зэрэг төрийн бүхий л холбогдох байгууллагууд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажилдаа ашиглах.
6. ***Хөдөлгөөнт нэгжүүдийг бий болгох*** – Байнгын болон түр боомтууд хоорондын зайнд хяналт тавих, орон нутгийн иргэдтэй мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх үүрэг бүхий нэгжүүдийг бий болгох.
7. ***Олон нийттэй хамтарч ажиллах*** - Хилийн боомтын орон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулах замаар хилийн ойр орчмын иргэдтэй хамтарч мэдээлэл цуглуулах, ингэснээр хилийн ажилтнууд болон ард иргэдийн харилцаа холбоо бэхжиж, хилийн тухай ерөнхий ойлголтыг сайжруулах үр дүнтэй. Хилийн удирдлагыг хил орчмын иргэдийн ядуурлыг бууруулахтай холбоотой төрийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж холбох нь ирээдүйд хилийн боомтын урт хугацааны үр ашигтай үйл ажиллагааны шийдэл болж болдог.
8. ***Урьдчилан сэргийлэх ажиллагаа ба сургалт зохион байгуулах*** нь хохирогчийг хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамгийн чухал ажилд тооцогдоно. Шилжин суурьшигчдад хүн худалдаалах гэмт хэргийн аюул, хор уршгийн талаар мэдээлэл өгөх болон шаардлагатай үед туслалцаа хэрхэн хүсэх асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран сургалтын хөтөлбөр боловсруулах. Хил хамгаалах байгууллага хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хичээлийг сургалтын хөтөлбөртөө заавал оруулах хэрэгтэй.

МОДУЛЬ - 11

ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй арга барилыг хэрэгжүүлэхэд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нарт өөрийн үүрэг, оролцоогоо ойлгож мэдэхэд нь туслах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх.

Сэдэв 1 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч байж болзошгүй хүнийг олж тогтоох, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийг илрүүлэх

Сэдэв 2 Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх хэлбэрээр хүүхэд худалдаалах нь

Сэдэв 3 Сэжигтэй зорчигчтой ярилцлага хийх

Сэдэв 4 Гадаадын иргэний бүртгэл, виз олгоход анхаарах асуудал

Модулиас дараах ойлголт, мэдлэг эзэмшинэ:

- Хүн худалдаалах гэмт хэрэг зөвхөн хил нэвтрүүлэх замаар үйлдэгддэггүй.
- Олон улсын хил нэвтрүүлэн худалдагдсан хүмүүсийн ихэнх нь бичиг баримтгүй цагаачид байдаг.
- Гадаад ажилчдын асуудлыг шийдвэрлэхдээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой харьцах стандартыг дагаж мөрдөх ёстой бөгөөд хохирогчийг хорьж саатуулах, хариуцлага хүлээлгэх буюу яллаж болохгүй. Зохих ёсны зөвшөөрөлтэй гадаадын иргэнийг Монгол улсад ажиллуулах, зөвшөөрөлгүй гадаадын иргэнийг албадан гаргах хоёр үүргээ зохицуулан уялдуулж улмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нартай олон улсын протокол болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зүй зохистой харьцах шаардлагатай.
- Хүмүүс эх орноосоо явах, эргэж ирэх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг маш тодорхой хатуу чанд хэмжүүр үзүүлэлтийн хүрээнд хязгаарлаж болно.
- Тухайн орны иргэн биш буюу гадаадын иргэн хохирогчид зүй зохистой харьцаа хүлээн авах үндсэн эрхтэй бөгөөд олон улсын хууль тогтоомжийн дагуу улс орнууд тухайн хохирогчтой өөрийн иргэнтэй адил тэгш харьцаж үндсэн эрхийг нь зөрчихгүй байх үүрэгтэй.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/хохирогч байж болзошгүй хүнийг хурдан шуурхай олж тогтоох нь тухайн хүнийг мөлжлөгт өртөх эсвэл дахин худалдагдахаас сэргийлнэ.
- Виз, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг шалгах, визний хугацаа хэтрүүлсэн эсэх, ажлын зөвшөөрөл олгосон салбартаа ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хохирогчийг олж тогтоож болзошгүй гэсэн хандлагаар хохирогч төвтэй арга барилаар ажиллана.
- Гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулах нь хохирогчийг худалдаалах, хүчээр хөдөлмөр эрхлүүлэх зэрэг мөлжлөгийн шинж чанартай нөхцөл байдалд байлгах зэргээс сэргийлэх ач холбогдолтой.

Сургалтын хугацаа – 3 цаг (180 Минут)

Хичээлийн бэлтгэл

- Сургалтын өрөөг бэлтгэх;
- Суралцагчдад тараах материал, урьдчилж бэлтгэсэн дасгал ажил, гүнзгийрүүлж судлах

эх сурвалжийн тэмдэглэл, холбогдох хууль тогтоомжийн хуулбаруудыг бэлтгэх;

» Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн болох компьютер, прожектор, самбар, цаас, үзгийг бэлтгэх.

Модуль 11: Хичээлийн төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Агуулга	Сургалтын хэлбэр	Хугацаа /мин/	Лавлагаа материал
Сэдэв 1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч байж болзошгүй хүнийг олж тогтоох, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийг илрүүлэх	Лекц / Хэлэлцүүлэг	20	Сэдэв 1
	Дасгал ажил 14 - Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх	Дасгал ажил	20	Дасгал ажил 14
Сэдэв 2	Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх хэлбэрээр хүүхэд худалдаалах нь	Лекц / Хэлэлцүүлэг	20	Сэдэв 2
	Дасгал ажил 15 – Монгол хүүхэд үрчилж авах хүсэлтэй гадаадын иргэнээс ярилцлага авах нь	Дасгал ажил	20	Дасгал ажил 15
Сэдэв 3	Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нар “сэжигтэй” зорчигчтой ярилцлага хийх чадвартай болох	Лекц / Хэлэлцүүлэг	30	Сэдэв 3
	Дасгал ажил 16 – Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтооход шалгах хуудас ашиглах нь	Бүлгийн хэлэлцүүлэг, дасгал ажил	40	Дасгал ажил 16
Сэдэв 4	Гадаадын иргэний бүртгэл, виз олгоход анхаарах асуудал	Лекц/ Хэлэлцүүлэг	30	Сэдэв 4

СЭДЭВ 1: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРОГЧ БАЙЖ БОЛЗОШГҮЙ ХҮНИЙГ ОЛЖ ТОГТООХ, ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ

2002 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газраас Хүний эрх ба хүн худалдаалах гэмт хэргийн талаар баримтлах зарчим, удирдамжийг гаргасан. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой хэрхэн харьцах тухай олон улсад баримтлах стандарт, хэм хэмжээг энэхүү баримт бичигт тусгаж өгсөн байдаг. Удирдамж 2 (I)-т улс орнуудад дараах үүрэгтэй оролцоно. Үүнд:

Хууль бус цагаачдыг илрүүлэх, саатуулах, хүлээн авах, шийдвэрлэх асуудалд оролцдог эрх бүхий байгууллагууд буюу цагдаа, хил хамгаалах газар, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч болон бусад холбогдох албан хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хурдан хугацаанд, үнэн зөв олж тогтооход туслах удирдамж болон журам боловсруулах.

Удирдамжийн 2 (II) хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийг тогтоох, дээр дурдсан удирдамж болон журмыг хэрэгжүүлэх хохирогчдыг олж тогтоох талаар зохих сургалтуудыг холбогдох албан хаагчдад зориулан зохион байгуулахыг эрх бүхий байгууллагуудад даалгасан байдаг.

Хохирогчийг олж тогтоох олон янзын нөхцөл байдал тэр дундаа зөөвөрлөлтийн үед маш их ачаалалтай байдаг шалган нэвтрүүлэх цэгийн албан хаагчид хүн бүрийн нөхцөл байдлыг бүрэн шалгаж үзэх хангалттай цаг байдаггүй. Тиймээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хурдан хугацаанд олж тогтоох сургалт хийх нь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нарыг сургах эхний алхам юм.

Бүлэг хүмүүс дотроос хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид өөрийн үндсэн ажил, үүрэг болох шалган нэвтрүүлэх, виз олгох мөн гадаадын иргэний бүртгэл зэргийг хэрэгжүүлэхдээ орогнол хүсэгчид, цагаачид, тусгай хэрэгцээт хүмүүс зэрэг өөр өөр бүлэг хүмүүсийн эрхийг хангаж ажиллах нь нэн чухал юм. Тусгай хэрэгцээ гэдэгт нас, хүйс, цагаачлалын нөхцөл байдал, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй гэх зэрэг багтана.

Цагаачлал эсвэл зөөвөрлөлт хэчнээн хурдан хүн худалдаалах гэмт хэрэг болон мөлжлөгийн шинж чанартай болж болохыг санаж байх нь чухал. Бүлэг хүмүүстэй хамт явж байгаа дүрвэгч нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч нарын арга мэхэнд орж хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байдгийг мөн санаж байх хэрэгтэй. Мөн Монгол улсад хууль ёсны ажиллах эрхтэйгээр нэвтэрсэн хүн хөдөлмөрийн мөлжлөгт өртөж болно гэдгийг ч санаж байхад илүүдэхгүй. Тиймээс цагаачилж байгаа гэр бүл, хэсэг бүлэг дүрвэгсэд, аль эсвэл ажил эрхлэхээр ирж байгаа мэт харагдаж байгаа хүмүүс хохирогчдоо тээвэрлэж байгаа нуугдмал гэмт хэрэгтнүүд байж ч болно. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох талаар нарийн ойлголт, мэдлэгтэй болох нь хамгаалалт хэрэгтэй байгаа нэгнийг нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэрэгтнүүдээс ялгаж танихад тусална.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Модуль 3-ын Сэдэв 2 дээрх *–"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох" болон "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээлэх нь" сэдвүүдийг эргэн харна уу?*

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн хувьд хүн худалдаалах гэмт хэрэг/мөлжлөг/хохирогч (жинхэнэ хохирогч болон хохирогч байж болзошгүй хүн)/хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч нарын талаар мэдээлэл хэрхэн хүлээн авч болох тухай суралцагчдад санууулж, мэдлэгийг нь сэргээнэ.

Модуль 1-ийн Сэдэв 3 дээрх *– "Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчийг таних нь" хэсгийг эргэн санаж суралцагчдад хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч нь ямар хүн байж болох талаар санууулна. Ингэснээр суралцагчид хил дээр мөн гадаадын иргэдийг шалган нэвтрүүлэх цэгүүд дээр гэмт этгээдийг хэрхэн таних талаар ойлголт авахад нь нэмэр болно.*

ДАСГАЛ АЖИЛ 14 – ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ ҮҮССЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ДҮРД ТОГЛОХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Оролцогчдыг хоёр багт хувааж баг тус бүрд хоёр өөр нөхцөлт дасгал ажил өгнө. Багууд дүрд тоглох хүнээ сонгоод дасгал ажлыг бүх оролцогчдын өмнө дүрд тоглож үзүүлнэ. Баг бүр сайн дураар дүрд тоглох хүнийг сонгох бөгөөд нэг нь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч, харин нөгөө нь эмэгтэй/эрэгтэй хүний дүрд тоглоно. Багууд өөрсдийн төсөөллийг ашиглан нэгээс олон тооны албан хаагч, болон бусад оролцогч талуудыг оролцуулж мөн болно. Дараах нөхцөлт дасгалыг баг бүрд тарааж өгөөд дүрд тоглуулна. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагч тухайн эмэгтэй/эрэгтэй хүнтэй хэрхэн харьцах, мөн энэ нөхцөл байдалд авах дараагийн алхам юу байх зэргийг дүрслэн үзүүлнэ.

Зорилт: Дүрд тоглох дасгалын гол зорилт нь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын шалгуур үзүүлэлт ашиглаж мөн ярилцлагыг зөв зохистой хийх замаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох чадварыг сайжруулахад оршино.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Хоёр өөр нөхцөлт дасгалыг тараах материал байдлаар бэлтгэх, сандал, ширээ, бал, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажлын хугацаа: 40 минут (Баг дотроо хэлэлцэхэд 10 минут + Багууд дүрд тоглоход тус бүр 10 минут + Сургагч багш дүгнэлт хийхэд 10 минут).

1-р багт зориулсан тохиолдол:

Та нисэх онгоцны буудал дээр албан үүргээ гүйцэтгэж байгаа Гадаадын иргэн, харьяатын газрын улсын байцаагч. Гадаа маш хүйтэн, цас орж байгаа бөгөөд шөнийн 12.00 цаг болж байна. Хоёр эмэгтэй шалган нэвтрүүлэх цэг рүү дөхөж ирээд шалган нэвтрүүлэх албаны албан хаагчтай ярилцаж виз даруулахаар зогсож байгааг та харлаа. Шалган нэвтрүүлэх албаны албан хаагч тэднийг нэг нэгээрээ ир хэмээн дохив. Нэг нь настай харин нөгөөх нь түүнээс нэлээд залуу эмэгтэй байв. Залуу эмэгтэйн нүд нь тогтохгүй түгшсэн шинж илэрч байгааг Гадаадын иргэн, харьяатын газрын улсын байцаагчийн хувьд та анзаарав. Тэрээр настай эмэгтэй рүү нүдний булангаараа ойр ойрхон харна. Хэсэг хугацаа өнгөрсний дараа шалган нэвтрүүлэх албаны албан хаагч таныг дуудаж залуу эмэгтэйн паспортыг үзүүлэв.

Үүссэн нөхцөл байдлыг бүрэн шийдвэрлэнэ үү?

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

"Хохирогчид зориулсан тэмдэглэл"-ийг зөвхөн хохирогчийн дүрд тоглож байгаа суралцагчид л өгнө. Харин гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн дүрд тоглож байгаа суралцагчид БҮҮ харуулаарай.

Хохирогчид зориулсан тэмдэглэл

Таныг _____ гэдэг, 17 настай ганц бие, ядуу айлын хүүхэд. Танай гэрийнхэн бүгд ажилгүй учраас амьдрал тун хэцүү байсан бөгөөд та гурван долоо хоногийн өмнө нэгэн сонинд гарсан ажлын зарын дагуу хандсан. Тус зар нь Итали улсад зөөгчийн ажил байсан бөгөөд та

зарын дагуу ажилд орох хүсэлт гаргасан. Та ярилцлагад орж тэнцсэн бөгөөд Итали явах замын зардлыг нэгэн эрэгтэйгээс зээлж эхний сарын цалингаараа төлөх тохиролцоо хийсэн. Тэнд очоод их мөнгө олох боломжтой учраас зээлсэн мөнгөө эргүүлэн төлөхөд танд ямар нэгэн хүндрэл гарахгүй хэмээн итгүүлсэн. Таныг хар өнгийн Мерседес маркийн машин унасан журамтай байрын эрэгтэй нэгэн хотод аваачсан бөгөөд хотын нэрийг та санахгүй байгаа. Тэнд очмогц таны паспорт, иргэний үнэмлэх, хувцас болон бусад бүх эд зүйлсийг хурааж авсан. Таныг түгжээтэй өрөөнд хориод, гадагш гарах мөн хүнтэй утсаар ярихыг огт зөвшөөрөөгүй. Дараа нь таныг ачааны битүү машинд суулгаж нууцаар хил давуулан Монголд авчирсан бөгөөд дахиад л нэг байшин дотор цоожилчихсон. Таныг биеэ үнэлж зээлсэн мөнгөө эргүүлэн төлөхийг шаардсан ба татгалзахад зодож дарамталсан. Мөн цагдаа нар таныг олох юм бол паспорт, иргэний үнэмлэх гэх зэрэг бичиг баримтгүй учраас хүчирхийлж зодоод, шоронд хийнэ гэж айлгасан. Харин зугтах гэж оролдвол гэр бүлийнхнээс чинь өрөө нэхэмжилж тэднийг зодох аль эсвэл алж ч магадгүй хэмээн сүрдүүлсэн.

Нэг өдөр, таныг хорьж байсан хүмүүсийн нэг нь буюу нэгэн эмэгтэй таныг Турк руу явах болсон тухай хэлээд онгоцны буудал руу авч ирэв. Таны Монгол улсад байх визний хугацаа долоо хоногоор хэтэрсэн гэдгийг та мэдэж байв.

Та одоо нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх цэг дээр байгаа бөгөөд нэгэн албан хаагч дүрэмт хувцастай өөр нэгэн албан хаагчтай ярьж байхыг харж байна. Хэсэг хугацааны дараа дүрэмт хувцастай албан хаагч таныг хажуу тийш болно уу хэмээн дуудав. Албан хаагч тантай хэрхэн харьцаж байгаад тохируулан хариу үйлдэл үзүүлж дүрд тоглоно уу?

2-р багт зориулсан тохиолдол:

Та Улаанбаатар хотын Гадаадын иргэн, харьяатын газрын улсын байцаагч. Өнөөдөр их хүйтэн цастай өдөр байна. Маш олон тооны монгол болон гадаадын ажилчид ажиллаж байгаа арван давхар байшингийн барилгын талбайд шалгалт хийхээр та ирсэн байна. Энэхүү барилга нь хотын захад байрлах бөгөөд ажил олгогч ажилчидтай барилгын талбайд амьдрах тохиролцоо хийсэн ажээ. Зарим гадаад ажилчид насны хувьд тун залуу мэт танд санагдав. Тэдэнтэй ярилцах гэтэл тэд тантай нээлттэй харилцахгүй байв. Тэдний паспорт болон бусад баримт бичгийг даамал нь авсан гэж зарим гадаад ажилчид танд хэлэв.

Үүссэн нөхцөл байдлыг бүрэн шийдвэрлэнэ үү?

Сургагч багшид өгөх зөвлөмж - "Хохирогчид зориулсан тэмдэглэл"-ийг зөвхөн хохирогчийн дүрд тоглож байгаа суралцагчид л өгнө. Харин гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчийн дүрд тоглож байгаа суралцагчид БҮҮ харуулаарай.

Хохирогчид зориулсан тэмдэглэл

Таныг _____ гэдэг. Та Хятадын Гансу мужийн нэгэн ядуу айлын 15 настай хүү. Таны аав, ээж газар шорооны ажил хийдэг бөгөөд та аав, ээжээсээ гадна 2 эмэгтэй дүү, өвөө эмээгийн хамт амьдардаг. Танай бүс нутагт хүчтэй ган гачиг болж аав, ээж хоёр тань дөрвөн сар гаруй хугацаанд ажилгүй байжээ. Танай гэрийнхэн өдөрт нэг удаа хооллож амь зогоож байв. Нэг өдөр танай тосгонд нэгэн эрэгтэй ирээд 10 эрэгтэй хүүхэд, залуусыг Монголд ажиллуулахаар авч явна гэжээ. Сарын дараа гэхэд ажиллах зөвшөөрлөө авч та тосгоныхоо 9 эрэгтэй хүүхдийн хамт нөгөө эрэгтэй хүнтэй Монгол руу явсан.

Таныг нэгэн барилгын талбайд аваачсан бөгөөд тэнд өөр хэдэн гадаад ажилчдаас гадна

Монголчууд ч мөн ажиллаж байв. Та маш хүнд ажил хийж байсан ч гэр рүүгээ аав, ээждээ сард 200 ам. доллар илгээх боломжтой болно гэж бодохоор жаргалтай байв. Анх өдөрт 8 цаг ажиллана гэж хэлсэн боловч одоо өдрийн 14 цаг ажилладаг. Ажиллаж эхлээд 11 сар болсон бөгөөд сар бүрийн эцэст цалинг чинь аав, ээж рүү чинь илгээсэн гэж даамал хэлдэг байв. Балансаа авах талаар хэлэх бүрд даамал мөнгийг чинь найдвартай хадгалж байгаа гэдэг байв. Тэрээр бусад бүх ажилчдад мөн л ингэж хэлдэг байлаа. Танд өдөрт хоёр хоол өгдөг бөгөөд ажил олгогчийн зүгээс гаргаж өгсөн байр нь тун тохьгүй халуун ус, цахилгаангүйгээс гадна гурван хүний багтаамжтай гэмээр жижиг өрөөнд 7 хүн унтдаг.

Барилгын талбайд Гадаадын иргэн, харьяатын газрын улсын байцаагч ирж тантай ярилцахыг оролдож, паспорт болон хөдөлмөр эрхлэх эрхээ үзүүлнэ үү гэв. Бүх бичиг баримт даамалд байгаа гэж та хариулна. Байцаагч тантай хэрхэн харьцаж байгаад тохируулан хариу үйлдэл үзүүлж дүрд тоглоно уу.

СЭДЭВ 2: ГАДААДЫН ИРГЭНД ХҮҮХЭД ҮРЧЛҮҮЛЭХ ХЭЛБЭРЭЭР ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХ НЬ

Сүүлийн жилүүдэд хүүхдийг улс орон дамнуулан хууль бусаар үрчлэхтэй холбоотой асуудал, хүүхдийг гадаадад үрчлэхтэй холбоотой үзэл бодлын ялгаатай байдал зэргээс улбаалан хүүхдийг гадаад улсад үрчлэх асуудал Олон Улсын анхаарлын төвд ороод байгаа билээ. Хүүхэд худалдаалах асуудалд Олон Улс анхаарал хандуулах явдал нэмэгдэх хандлагатай байгаагаас шалтгаалан, хүүхэд үрчлэх асуудлыг хууль бус үйл ажиллагаанд өөрөөр хэлбэл хүүхэд худалдаалах арга хэлбэр болгон ашиглах явдал байсаар байна.

Хүүхэд худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр нь улс хооронд хүүхэд үрчлэх асуудал байж болох талаар олон улсад анх удаагаа гаргаж ирсэн баримт бичиг бол 2002 оны *Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол* юм.

Нэмэлт протоколын 2-р зүйлийн (a) хэсэгт "хүүхдийг худалдах" гэсэн ойлголтыг "хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд, бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ" гэж томьёолсон бөгөөд "хүүхдийг худалдах" нь өөрөө хууль бус үйлдэлд тооцогдоно гэж заасан байдаг. Тус протоколын 3-р зүйлийн (a)(2) хэсэгт хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх нь хууль бус байх талаар онцлон дурдсан байдаг.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэгт Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэх ажил багтдаг. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн албан хаагчид тухайн хүүхдийг үрчилж авах хүсэлтэй байгаа хүмүүстэй уулзаж ярилцаж, албан ёсоор үрчлүүлснийхээ дараа хүүхэд ямар орчинд өсөж, торниж байгааг тогтмол хянаж байх үүрэгтэй байдаг.

1993 оны 5 дугаар сарын 29-нд батлагдсан *Улс хооронд хүүхэд үрчлүүлэхтэй холбогдуулан Хүүхэд хамгаалал, хамтын ажиллагааны конвенц* (Гаагийн Хүүхэд үрчлэх тухай конвенц)-д Монгол улс 2000 онд нэгдэн орсон.

1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд гадаадын иргэн/гэр бүл хуульд заасан дүрэм, журам, шаардлагуудыг хангавал Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэн авах боломжтой гэсэн байдаг.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 100/32 дугаар тушаалаар баталсан Гадаадын иргэнд монгол улсын харьяат Хүүхдийг үрчлүүлэх журмаар Монгол улсын иргэншилтэй хүүхдийг гадаадын иргэн/гэр бүлд үрчлүүлэхтэй холбоотой асуудлыг тусгайлан зохицуулсан байдаг. Монгол улсаас хүүхэд үрчилж авах тохиолдолд хоёр байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Тус журамд "Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх тухай Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба 30 хоногийн дотор үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж, гаргасан шийдвэрийн талаар гадаад улсын иргэн болон эрх бүхий байгууллагад уламжилна" гэж заасан байдаг. Энэхүү хоёр байгууллагын аль алиных нь зөвшөөрлийг авсан байх шаардлагатай хэдий ч Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эцсийн шийдвэрийг гаргаж, тухайн хүүхдийн бүртгэлтэй холбоотой асуудлыг зохицуулан, үрчилж авах хүсэлтэй байгаа эцэг эхийг нь Монголд Улсад урьж авчрах, үрчлүүлсний дараа хэрхэн хяналт тавих талаар тодорхой тусгасан гэрээнд гарын үсэг зуруулдаг.

Үрчлэгдсэн хүүхдийн араас хяналт тавих зорилготой энэхүү гэрээний дагуу үрчилж авсны дараах хүүхдийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтсон хугацаанд хүргүүлнэ (үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх). Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтай тухайн хүүхдийг үрчилж авсан гадаадын иргэн дээр биечлэн очиж нөхцөл байдалтай танилцах эрхтэй байдаг. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үрчлүүлсэн хүүхдэд 18 нас хүртэл нь хяналт тавина.

Гадаад улсад хүүхэд үрчлүүлэх нэрийн дор Монгол улсын харьяат хүүхдийг худалдаалах тохиолдол одоогийн байдлаар бүртгэгдээгүй хэдий ч энэхүү үйл явцыг эрсдэлтэй асуудалд тооцож явдаг. Үрчлүүлэх хэлбэрээр хүүхэд худалдаалах гэмт хэрэг хэд хэдэн оронд бүртгэгдсэн бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх шинэ хэлбэр болоод байгааг Нэгдсэн Үндэсний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэг хариуцсан хэлтсээс гаргадаг Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын тайлан (2016), АНУ-ын Засгийн газраас гаргадаг Хүн худалдаалах гэмт хэргийн тайланд (2017) тус тус онцлон бичсэн байдаг бөгөөд дэлхийн олон оронд үйл ажиллагаагаа явуулдаг нийгмийн байгууллагууд, сайн дурын агентлагууд хүүхэд үрчлүүлэх нэрийн дор энэхүү хууль бус ажиллагааг өөгшүүлж байгааг дурдсан байдаг. Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой улс орнуудын төрөөс гаргасан зохицуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалж, хүүхэд үрчлүүлэх ажиллагааг зохион байгуулдаг буюу зуучилдаг байгууллагууд, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид гэмт хэргээ үргэлжлүүлэх таатай нөхцөл бүрддэг.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг зохицуулахдаа хүүхэд үрчлүүлэх нь зөвхөн тухайн хүүхдийн сайн сайхны төлөө хийгддэг зүйл учраас гадаадын иргэнд тухайн хүүхдийг үрчлүүлэх зөвшөөрөл олгохдоо маш хариуцлагатай хандах ёстойг үргэлж санах хэрэгтэй. Үрчилж авсан гадаад эцэг, эх тухайн хүүхдэд анхаарал халамж тавихгүй байх, хаяж орхих, сурган хүмүүжүүлэх болоод шаардлагатай эд зүйлсээр хангахгүй байх, хүүхдийг сэтгэл зүйн болоод бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх, албадан хөдөлмөр эрхлүүлэх, анагаах ухааны

болон өөр бусад туршилт судалгаанд оруулах эсвэл хуучин байснаасаа дор нөхцөл байдалд очсон байж болзошгүй эсэхийг хянаж байх шаардлагатай.

САНАМЖ:

Хууль бус үрчлэлт болгон хүүхэд худалдаалах гэмт хэрэг байдаггүйг мэдэж байх нь чухал юм. Хууль бусаар хүүхэд үрчлэх нь өөрөө гэмт хэрэг мөн боловч энэ нь хүн худалдаалах гэмт хэрэг гэсэн үг биш юм. Энэхүү хууль бус үрчлэлт нь тухайн хүүхдийг ашиглан "мөлжих" зорилгоор үрчилж авч байгаа тохиолдолд хүүхэд худалдаалах гэмт хэргийн шинж чанартай болно.

Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой олон улсад ашигладаг туршлагаас[1] жишээ байдлаар доор оруулав. Үүнд:

Хүүхэд үрчлүүлэх үйл явц

- Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхээсээ өмнө тухайн хүүхдийг өөрийнх нь улсад нь үрчлүүлэх боломж байгаа эсэхийг холбогдох байгууллага нь тодруулдаг.
- Хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой асуудал хариуцсан байгууллагын мэргэжлийн нийгмийн ажилтнууд тухайн хүүхдийг үрчлүүлэхээр болж байгаа гэр бүл, эцэг, эхийг сонгох, цаг нь болсон гэж үзвэл хүүхдэд төрсөн эцэг, эхийнх нь талаар мэдээлэл өгөх, хүүхдийг үрчилж авах гэж буй гэр бүлд хүүхдийн талаар мэдээллийг өгөх зэрэг тухайн хүүхдийн талаарх бүрэн мэдээллийг агуулсан тайланг бэлтгэн гаргадаг.
- Энэхүү тайланд дараах мэдээллийг ихэвчлэн багтаана. Үүнд:
  - Шаардлагатай мэдээллийг олж авах, боломжтой тохиолдолд түүнийгээ баримтжуулах.
  - Төрсөн эцэг, эх, тэдний нийгмийн болон орлогын байдал мөн эрүүл мэндийн байдалтай холбоотой мэдээлэл.
  - Хүүхдийн бие махбод, оюун санаа, сэтгэл зүйн хөгжлийн талаарх мэдээлэл (тухайн хүүхдийн насны онцлогт тохируулан).
  - Одоо байгаа нөхцөл байдал, өсөж торниж буй орчин (гэр орон, асрамжийн газар, байгууллага г.м), бусадтай харилцах харилцаа, зуршил, байнга хийдэг зүйл.
  - Нийгмийн ажилтны хийсэн үнэлгээ, гадаад улсад үрчлүүлэх санал дэвшүүлж байгаа шалтгаан.
- Үрчлүүлэх газар нь тодорхой болсны дараа тухайн хүүхдийг өөрийнх нь насанд тохирсон хөгжлийн түвшинд нь аваачихад бэлтгэх хангалттай хэмжээний цаг хугацаа, хүчин чармайлт гаргах.
- Хүүхдийн очих шинэ улс орон, гэр бүлийн талаарх мэдээллийг мэргэжлийн хүнээр дамжуулан хүүхдэд ойлгуулах.
- Хүүхдийг үрчлүүлэх эцсийн шийдвэрийг гаргахаасаа өмнө тухайн хүүхдийн нас, хөгжилд нь тохирсон байдлаар зөвлөгөө өгөх.

Гадаадын иргэнд хүүхэд үрчлэх дүрэм, журам

Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудал хариуцсан байгууллага дараах зүйлсийг мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

- Хүүхэд үрчилж авах хүсэлтэй байгаагаа илэрхийлэн өргөдлөө бүрдүүлэн хүргүүлсэн гадаадын иргэн өөрийн улс орныхоо эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авч, эрх бүхий нийгмийн халамжийн эсвэл хүүхэд хамгаалах байгууллагаас баталгаа авсан байх шаардлагатай. Энэхүү баталгааг авалгүйгээр хүүхэд үрчлэх хүсэлтээ шууд гаргасан хүний хүсэлтийг дараах шалтгааны улмаас авч үздэггүй.
  - Нэгдүгээрт, дээрх эрх бүхий байгууллагын баталгаа нь хүүхэд худалдаалах боломжийг бүрмөсөн арилгахгүй юм гэхэд тодорхой хэмжээнд бууруулна. Учир нь гадаадын иргэн хүүхэд үрчлүүлэх үйлчилгээ үзүүлдэг байгууллагад эсвэл хувь хүнд шууд хандаж хүүхэд үрчилж авах асуудлаа шийдвэрлүүлдэг бол хүүхдийг хууль ёсны дагуу аюулгүй үрчилж авахгүй байх магадлалтай бөгөөд үндэслэлгүй, хэт өндөр төлбөр төлөх эрсдэлтэй байдаг.
  - Хоёрдугаарт, зөвшөөрөл өгөх эрх бүхий байгууллага хүүхэд үрчилж авах хүсэлтэй байгаа гадаадын иргэнийг тухайн хүүхдийг өсгөх боломжтой, тийм чадамжтай эцэг, эх байхад тохирох эсэхийг дангаараа үнэлж дүгнэлт гаргах бараг боломжгүй юм.
  - Гуравдугаарт, иргэншил бүхий улс орныхоо нийгмийн болон хүүхэд халамжлах байгууллагын оролцоогүйгээр хүүхэд үрчилж авах хүсэлтээ шууд явуулах нь тухайн хүүхэд гадаад улсад очоод, ямар байдалтай байгааг албан ёсоор хянахад маш хэцүү болгодог.
- Гадаад улсад хүүхдийг үрчлүүлэхээсээ өмнө тухайн хүүхдийн оршин суугаа улсын эрх бүхий байгууллага тухайн хүүхэд хууль зүйн үүднээс үрчлэгдэж болох эсэхийг баталгаажуулах үүрэгтэй бөгөөд бүрдүүлсэн бичиг баримт нь хоёр улсын аль алинд нь хүчин төгөлдөр байхыг магадлах шаардлагатай. Үрчлэгдэх гэж буй хүүхэд алга болсон талаарх мэдээлэл гарсан, хүүхдийг хайж байсан, хууль ёсны асран хамгаалагч, эцэг эхээс нь хулгайлсан явдал байгаа эсэхийг бүхий л бололцооныхоо хүрээнд судалж үзэх нь чухал.
- Төрсөн эцэг, эх нь хүүхдээ хүнд үрчлүүлэх эсэх талаар шийдвэрээ гаргахаас өмнө (хүүхэд өнчин биш бол) хүүхэд нь гадаадын иргэнд үрчлэгдэх боломжтой, ингэсэн тохиолдолд хүүхэдтэйгээ цаашид харилцаа холбоотой байх боломжгүй байж болох талаар ойлголт өгч, мэдээллээр хангах хэрэгтэй. Хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахад төрсөн эцэг, эхэд нь аливаа дарамт, шахалт үзүүлж болохгүй.
- Нийгмийн халамжийн байгууллага, төрийн бус байгууллагуудаар дамжуулан эцэг, эх нь тодорхойгүй хүүхдийг үрчлүүлэх ажил хийгдэж байгаа тохиолдолд төрийн эрх бүхий байгууллага зуучилж буй тухайн байгууллагууд залилан, хууран мэхлэх шинж чанар бүхий үйлдэл гаргах эсвэл хүүхдийг цааш дамжуулахаас сэргийлж, энэ төрлийн үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй байгууллага мөн эсэхийг нягтлах шаардлагатай. Эрх бүхий байгууллага хүүхэд үрчлэх албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагуудын жагсаалтыг гаргаж, аливаа хууль бус санхүүгийн гүйлгээ хийж буй эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах нь зүйтэй.
- Хүүхдийн халамжийн байгууллага хүүхдийг үрчлүүлэх гэрээг баталгаажиж, хүчин төгөлдөр болохоос өмнө хүүхдэд зориулан эрүүл мэндийн болон бусад зардлын нэрийн дор аливаа төлбөр хүлээн авах эрхгүй. Халамжийн байгууллага хүүхдийн нэрийг барин үрчлэн авах хүсэлтэй байгаа эцэг, эхчүүдээс ихээхэн хэмжээний төлбөр нэхэх магадлал байдаг.
- Хүүхэд үрчилж авах ерөнхий шалгууруудыг хангасан байхаас гадна хүсэлт гаргагч нь өөр үндэс угсаа, соёл, уламжлалтай хүүхэдтэй амьдрах бололцоотой гэдгээ харуулах шаардлагатай.

- Хоёр улсын эрх бүхий байгууллагууд хүүхдийг ашиглан мөлжлөг үйлдэх, ашиг олох, худалдаалахаас сэргийлэх зорилгоор гадаад улс оронд хүүхэд үрчлүүлэхтэй холбоотойгоор гарсан зардалд хяналт тавин ажиллах нь зүйтэй.

Гадаадын иргэнд үрчлүүлсэн хүүхдийн араас хяналт тавих

Гадаадаас хүүхэд үрчлэх эрх бүхий байгууллага эсвэл тухайн хүүхдийг үрчилж авсан улсад суугаа элчин сайдын яам хүлээн авч буй улсад тухайн хүүхэд очсон өдрөөс хойш хоёр жилийн турш хүүхэд хэвийн өсөж бойжиж байгаа талаар тогтмол мэдээлдэг.

- Хүүхдийн өсөлт, хөгжлийн тайланд эсвэл үрчилж авсан айлд очих үед үрчлэгдсэн хүүхэд шинэ гэр бүлдээ дасан зохицох тал дээр асуудалтай байдал байгаа талаар дурдсан эсвэл гэрт нь очих үед ийм зүйл ажиглагдсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл үрчилж авсан эцэг, эх болон үрчлэгдсэн хүүхдийн аль алинд зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй.
- Үрчлэгдсэн хүүхэд тухайн гэр бүлдээ дасан зохицож, нийцтэй байж чадахгүй эсвэл шинэ гэр бүлтэйгээ цаашид хамт байх сонирхолтой биш байгаа тохиолдолд хүүхдийг хүлээн авагч улс орны гадаадаас хүүхэд үрчлэх эрх бүхий байгууллага эсвэл холбогдох дипломат төлөөлөгчийн газар хүүхдийг хамгаалалтдаа авч, шаардлагатай зөвлөгөөгөөр хангана.
- Хүүхдийн үрчлэлтэд саад учрах эсвэл амжилтгүй болсон тохиолдолд хүүхэд үрчлэх тухай Гаагийн конвенцэд нэгдэн орсон улсын үүргийн дагуу хүлээн авагч улсын хүүхэд хамгааллын байгууллагаас тухайн хүүхдэд халамж, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэх ёстой.
- Гадаадаас хүүхэд үрчлэх эрх бүхий байгууллага тухайн хүүхдийн төрөлх улс орных нь дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан зохих арга хэмжээг авах бөгөөд шаардлагатай тохиолдолд хүүхдийг эх оронд нь буцаана.

ДАСГАЛ АЖИЛ 15 – МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ХҮҮХЭД ҮРЧИЛЖ АВАХ ХҮСЭЛТЭЙ ГАДААДЫН ИРГЭНЭЭС ЯРИЛЦЛАГА АВАХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Сургалтад хамрагдаж буй бүх хүнд бэлтгэсэн дасгал ажлыг тарааж өгнө. Суралцагчдыг хоёр хэсэгт хуваах бөгөөд эхний хэсэг нь гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч, хоёр дах хэсэг нь хүүхэд үрчилж авах хүсэлтэй гадаадын иргэн байна. Албан хаагчийн зүгээс гадаадын иргэн үнэхээр Монголоос хүүхэд үрчилж авах хүсэлтэй байгаа эсэхийг тодруулан ярилцлага хийх бөгөөд Модуль 3 болон энэхүү модулийн эхэнд гарсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй шинж тэмдгүүдийг олж тогтоох байдлаар хүүхэд үрчлэх хүсэлт нь тухайн хүүхдийг ашиглан мөлжлөг үйлдэх зорилго агуулсан эсэхийг тодруулна.

Дүрд тоглох дасгалыг ойлгомжтой, амархан байлгах үүднээс жүжиглэх үед гарах нэрс (хохирогч болон гэмт этгээд), хэрэг гарсан газар зэрэг нь зохиомол гэдгийг анхаарна уу.

Сургалтын хэрэглэгдэхүүн: Хэвлэж бэлтгэсэн дасгал ажил, ханын цаас, самбарын үзэг.

Дасгал ажиллах хугацаа: 30 минут

Шведийн иргэншилтэй Лиам, Алиса хоёр нь эхнэр нөхөр бөгөөд эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол улсаас эмэгтэй хүүхэд үрчилж авах хүсэлтээ гаргажээ. Тэд таван нас хүрээгүй бага насны хүүхэд үрчилж авах хүсэлтэй байгаа аж. Гаргасан хүсэлтдээ бичсэнээр бол нөхөр нь эмч, эхнэр нь физик эмчилгээний эмч мэргэжилтэй. Тэд Шведдээ тав, зургаан насны хоёр охинтой.

Өөрийгөө үнэлэх дасгал

- Хоёр багийн суралцагчид тарааж өгсөн дасгал ажил дээр нэмэлт баримт оруулж болно.
- Хүсэлт гаргагч гэр бүлийн бүрдүүлж өгсөн материалд үндэслэж, хүүхэдтэй холбоотой тайланг бэлтгэнэ үү.
- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зүгээс хүүхэд үрчилж авах хүсэлт гаргасан гэр бүлийн хүмүүсээс асуух асуултын жагсаалтыг гаргана уу.
- Хүүхэд үрчилж авах хүсэлт гаргасан гэр бүл яагаад Монгол Улсаас бага насны охин хүүхэд үрчилж авах хүсэлтэй байгаа шалтгаанаа тайлбарлана уу.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зүгээс хүүхэд үрчлэх тухайн хүсэлт нь жинхэнэ эсэх эсвэл хүүхэд худалдаалах хэлбэрийн нэг байж болох эсэхийг тодруулах шинж тэмдгүүдийн жагсаалт гаргана уу.

СЭДЭВ 3: СЭЖИГТЭЙ ЗОРЧИГЧТОЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ

САНАМЖ:

Ижил төрлийн асуултууд ашиглан тухайн этгээд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч уу, эсвэл гэмт хэрэгтэн үү гэдгийг олж тогтоох боломжтой.

Асуулт бүрийг хүн бүрээс асуух шаардлагагүй. Тухайлбал, хэн нэгнээс хэрхэн ажилд шалгаруулж авсан тухай асууж байх зуур гэмт хэргийн хохирогч байж болзошгүйг нь олж тогтоосон бол мөлжлөгийн талаарх асуултыг асуух шаардлагагүй.

Хэрэв гадаадын иргэн Монгол улсад худалдаалагдаж, мөлжлөгт өртөж харин одоо өөр улс руу худалдаалагдан шалган нэвтрүүлэх цэг буюу нисэх онгоцны буудал дээр байгаа бол мөлжлөгийн тухай асуултыг асуух нь тохиромжтой.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид шалгах хуудсанд буй бүх асуултыг асуух шаардлагагүй. Зарим асуултыг асуусны дараа тухайн хүн хохирогч эсвэл хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч байж болзошгүй гэдгийг тогтоох боломжтой байвал тухайн хүнийг/хүмүүсийг хамгийн ойр байгаа цагдаагийн хэлтэст өөрийн дүгнэлтийн хамт хүлээлгэн өгч цагдаагаар цааш нь шалгуулна. Аль эсвэл хөдөлмөрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан хаагчид хүлээлгэн өгч цааш нь шалгуулах буюу шаардлагатай арга хэмжээг авхуулна.

Ярилцлагын асуултууд - ЭЛСҮҮЛЭЛТ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тухайн үйл явдал эхэлсэн өдөр, долоо хоног эсвэл сарыг тогтоох. Тухайлбал, хохирогч ажилд зуучлагч эсвэл өөрийг нь хулгайлсан хүнтэй хэзээ анх уулзсан бэ? (Хэрвээ хохирогч анх уулзсан он, сар, өдрөө тодорхой санахгүй байвал түүний амьдралд нь тохиосон онцгой өдөр, тэр дундаа төрсөн өдөр эсвэл шашны зан үйлийн өдөр зэргээр баримжаалан эхэлсэн хугацааг тодорхойлох).
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох - Анх уулзсан газар Уулзсан газрын нэр, хаяг гэх мэт тодорхой мэдээлэл авах

ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Хэнтэй хамт явсан бэ (сэжигтэн?) Өмнө нь тэр хүнийг таньдаг байсан уу? Тэр хүнтэй хэн танилцуулсан бэ? Тухайн хүний талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл Нэрс
ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Юу болсон тухай Хохирогч хэрхэн гэрээсээ явсан? Анх явахад хохирогчтой хамт өөр хүмүүс байсан уу? Хүчээр явсан уу? Хэрэв тийм бол, хэрхэн авч явсан бэ? Хохирогчид шинэ боломж, бололцоо санал болгосон бол, юу амласан бэ? Ямар ажил, цалин, нөхцөл амласан бэ? Хохирогчид ажлын зар болон гэрээний ямар нэг хуулбар байгаа эсэх? (байвал түүнийг нь авах)
ЯАГААД	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч яагаад амлалтыг нь хүлээн авсан бэ? Шинэ газар очоод ямар байна гэж хохирогч төсөөлж байсан бэ?
Ярилцлагын асуултууд - ЗӨӨВӨРЛӨЛТ БА ТЭЭВЭРЛЭЛТ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тухайн үйл явдал эхэлсэн өдөр, долоо хоног эсвэл сарыг тогтоох. Тухайлбал, хохирогч ажилд зуучлагч эсвэл өөрийг нь хулгайлсан хүнтэй хэзээ анх уулзсан? Хохирогч мөлжлөгт өртсөн газраа хэзээ ирсэн?
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч хаанаас ирсэн? Ямар замаар ирсэн? Хэрвээ хил дамнасан хэрэг бол тухайн хохирогчийг нууцаар хил давуулсан уу? Хэрэв тийм бол, хохирогч хаана хил/онгоцны буудлаар нэвтэрснээ мэдэх үү? Хэрвээ хил дамнасан хэрэг бол мөн тухайн хохирогчийг нууцаар хил нэвтрүүлээгүй бол тэрээр аль нисэх буудал/хилийн шалган нэвтрүүлэх цэгээр гарсан бэ? Аль шалган нэвтрүүлэх цэг/нисэх онгоцны буудлаар дамжин өнгөрөх улс руу нэвтэрсэн бэ? Аль шалган нэвтрүүлэх цэг/нисэх онгоцны буудлаар мөлжлөгт өртсөн улс руу нэвтэрсэн бэ?
ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогчтой хамт явсан сэжигтний талаарх тодорхой мэдээлэл Аяллын явцад тэрхүү сэжигтний гүйцэтгэсэн үүрэг Хохирогчтой хамт явсан өөр бусад хохирогчдын талаарх тодорхой мэдээлэл Нэр болон гадаад дүр төрх, бие бялдрын дүрслэл
ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Тээвэрлэлт хийсэн арга; хөлөөр, машинаар, галт тэргээр, завиар эсвэл агаараар? Бичиг баримт ашигласан уу? Хэрэв тийм бол хохирогч ямар нэртэй бичиг баримт ашигласан бэ? Тээвэрлэгч компаниар дамжсан бол тухайн агаарын тээврийн компанийн мэдээллийг олж авах г.м Хэрэв билет худалдаж авсан бол, төлбөрийг хэн хэрхэн төлсөн бэ? Хохирогчид одоо ямар нэгэн биеийн байцаалт, аяллын бичиг баримт байгаа юу? (хэрэв тийм бол түүнийг нь авах)

ЯАГААД	Дараах мэдээллийг олж тогтоох - Хохирогч яагаад сэжигтэнтэй хамт явахыг зөвшөөрсөн бэ? Аяллын замнал болон төрөл хэлбэрийн талаар ямар шалтгаан хэлж тайлбарласан бэ?
Ярилцлагын асуултууд- МӨЛЖЛӨГ	
ХЭЗЭЭ	Дараах мэдээллийг олж тогтоох - Мөлжлөг эхэлсэн мөн хохирогч ямар нөхцөл байдалд орсноо ойлгож мэдсэн сар, өдөр Хүрэх газраа ирснээс хойш хэр удаж байж мөлжлөг эхэлсэн бэ?
ХААНА	Дараах мэдээллийг олж тогтоох - Мөлжлөг болсон газрын байршил
ХЭН	Дараах мэдээллийг олж тогтоох - Бусад хохирогчид: Тухайн газарт байгаа бусад хохирогчдын (Монгол улсын иргэн болон гадаадын иргэд) талаарх тодорхой мэдээлэл Нас, хүйс, иргэний харьяалал, ярьдаг хэл гэх зэрэг мэдээлэл Хохирогчид тухайн газарт байсан хугацаа Сэжигтнүүд: Тус байршилд хэдэн сэжигтэн байсан бэ? Нэр, нас, хүйс, иргэншил, хэл, гадаад дүр төрхийн дүрслэл
ЮУ	Дараах мэдээллийг олж тогтоох - Мөлжлөгийн арга хэлбэрийг тодорхойлох. Жишээ нь хөдөлмөрийн мөлжлөг, хүчээр биеийг нь үнэлүүлэх, гэрийн үйлчлэгчийн ажил хийлгэх, эд эрхтнийг нь авах. Хохирогчид анх ямар ажил санал болгосон бэ? Харин үнэн хэрэгтээ ямар ажил хийж байгаа вэ?

ДАСГАЛ АЖИЛ 16 - ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ОЛЖ ТОГТООХОД ШАЛГАХ ХУУДАС АШИГЛАХ НЬ

Сургагч багшид өгөх зөвлөмж: Дээрх шалгах хуудсыг суралцагчдад тараах материал хэлбэрээр өгч болно. Дараагаар нь суралцагчдыг хоёр багт хуваагаад 2 дасгалыг тарааж өгнө. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон гэмт хэрэг үйлдэгчийг тодорхойлохын тулд асуух асуултын жагсаалтыг суралцагчдаар гаргуулах. Багийн ахлагч нар хэлэлцсэн зүйлсээ бусадтайгаа хуваалцаж илтгэл тавина.

Дасгалд дурдсан хүмүүсийн нэрс (хохирогч болон гэмт хэрэгтэн) болон хэргийн газар нь бүгд зохиомол бөгөөд хэлэлцүүлгийг хялбар ойлгомжтой болгох үүднээс ашигласан болно.

Сургалтын хэрэглэгдэхүүн: дасгал ажлыг тараах материал байдлаар бэлдэх, самбарын цаас, самбарын үзэг.

1-р багт зориулсан тохиолдол

Аяру бол 24 настай Казакстан эмэгтэй. Тэрээр урдаа тавьсан зорилготой залуу эмэгтэй бөгөөд Хятадад загвар өмсөгчөөр ажиллавал алдартай загвар өмсөгч болж чадна гэдэгтээ итгэдэг. Нэгэн өдөр найз нь түүнийг Хятадын Бээжин хотод зочид буудлын хүлээн авагчийн ажилд оруулж өгөх санал тавьсан бөгөөд цалин нь одоо түүний олж байгаа сарын орлогоос арав дахин их гэж хэлэв. Түүнчлэн Хятадад очвол загвар өмсөгч болоход нь туслах хүмүүстэй холбоо тогтооход хялбар байх болно хэмээн найз нь түүнд итгүүлэв. Аяру Хятадад очоод ажиллаж

эхэлмэгцээ эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр найз нь түүний замын зардлыг төлөх санал тавив. Аяру мөнгөгүй учраас энэ тохиролцоог тэр даруй зөвшөөрөв.

Хятадын засгийн газар гадаадын иргэдэд ажиллах эрх олгох тал дээр их хатуу чанга байгаа учраас Монголоор дамжин нэг хэсэгтээ тэндээ ажиллаж байгаад тэндээсээ Хятад руу явах боломж олох хэрэгтэй гэж найз нь Аяруд хэлэв. Аяру Монголд нэгэн ресторанд зөөгчөөр ажиллах эрх авчээ. Хэдэн өдрийн дараа Аяру өөрийн найз болон өөр нэгэн эрэгтэйн хамт Казакстанаас Монгол руу хөдлөв.

Аяру одоо Монголд албан ёсны ажиллах эрхгүйгээр 6 сар болж байна. Түүнийг Монголд ирснээс нь хойш 10 хоногийн дараа массажны газарт аваачсан бөгөөд тэнд үйлчлүүлэгч нарт сексийн үйлчилгээ үзүүлдэг. Түүний сарын цалин ойролцоогоор 100 ам.доллар. Найз нь түүнийг Монголоос Хятад руу гаргаж амжилттай загвар өмсөгч болгоход нь туслахыг хичээж байгаа гэдэгт тэрээр чин сэтгэлээсээ итгэсэн хэвээр.

Нэгэн өдөр гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч массажны газар ирж түүнийг бичиг баримт, ажиллах эрхээ үзүүлнэ үү гэв. Массажны газрын эзэн түүний баримт бичгийг найдвартай газар хадгалж байгаа гэж Аяру албан хаагчид хэлэв.

2-р багт зориулсан тохиолдол

Ханул Ким бол Хойд Солонгосын нэгэн тосгонд амьдардаг 14 настай хүү. Түүний ээж нь зургаан хүүхэдтэй бэлэвсэн эмэгтэй бөгөөд бүс нутагт болж буй ган гачгийн улмаас хүүхдүүдээ тэжээхэд түүнд ихээхэн бэрх байгаа аж. Айлын том хүүгийн хувьд дүү нараа хоолтой байлгах нь түүний ч үүрэг гэж боддог учраас тэрээр ээждээ туслахыг хүсдэг. Ган болохоос өмнө хөршүүддээ тусалж бага хэмжээний мөнгө олдог байсан боловч цаг хэцүү болж хөлсний ажил олдохоо байжээ.

Нэгэн өдөр Ханулын ээж Монголд уурхайд ажиллах бие бялдар сайтай залуусыг ажилд авахаар хайж байгаа Жосеф гэх хүнтэй танилцав. Түүний 14 настай хүү нь ажил хайж байгаа тухай хэлэхэд Жосеф түүнд 50 ам. долларын цалин өгөхөөс гадна хүүг нь сайн хооллож, байраар хангахыг санал болгов. Энэ нь Ханулын ээжийн хувьд нэг хэсэгтээ л хүүхдүүдээ хоолтой байлгахад хүрэлцэхүйц их мөнгө байсан бөгөөд тогтмол цалингийн тодорхой хэмжээг хүлээн авч байхаар энэхүү тохиролцоог хүлээн авчээ.

Ханулын хувьд гэрээсээ явах гунигтай байсан ч гэрийнхэндээ туслах гэж байгаадаа баяртай байлаа. Тэрээр Жосеф болон өөр дөрвөн хүүгийн хамт замд гарав. Тэд хэд хоногийн турш замын унаанд дайгдаж, зам дагуу алхаж мөн заримдаа ачааны машины ачаан дээр сууж явсаар хэзээ хилээр гарснаа ч мэдсэнгүй. Тэгж явсаар бусад хөвгүүдийн хамт уурхайн талбайд ирж, тэндээ үлдэв. Жосеф уурхай дээр байсан нэгэн хүнээс мөнгө авч байхыг Ханул харжээ.

Уурхай дээр Ханул шиг олон хөвгүүд, залуус байсан ба өдөр бүр 10 гаруй цаг ажилладаг байв. Жижиг биетэй хөвгүүдийг уурхайн гүн руу оруулан ажиллуулдаг байсан бөгөөд Ханул шөнө бүр үхэхээс айн уйлдаг байлаа. Хөвгүүдэд ажлын хөлс өгдөггүй, харин өглөө орой хоёр багахан хоол өгдөг байв. Шөнөдөө тэд нэгэн жижигхэн өрөөнд гудас, дэвсгэр ч үгүй хатуу шалан дээр нимгэн хөнжил нөмрөн унтдаг байлаа. Хангалттай сайн ажилласангүй, дуулгавартай байсангүй гэх шалтгаанаар дарга нь тэднийг үргэлж зоддог байв.

Олон сарын дараа гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч уурхайн талбайд ирж даргаас нь асуулт асууж ярилцахаас гадна Ханулыг мөн дуудав.

Өөрийгөө үнэлэх асуултууд

1. Хоёр өөр дасгалд үндэслэн дэлгэрэнгүй асуултууд бэлтгэнэ үү.
2. 10.1 хэсэгт буй дасгал ажлын хүрээнд дүрд тоглосон суралцагчдаас шалгах хуудсанд оруулсан жишиг асуултуудын туслалцаатайгаар хүнтэй харьцахад юу нь өөр байсан тухай сургагч багш асууна.
3. Эхний дасгал нь хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүй гэдгийг ямар хүчин зүйл тодорхой болгосон бэ? Хэрвээ энэ төрлийн гэмт хэрэг мөн бол?
4. Тухайн хүмүүстэй ярилцлага хийсний дараагаар гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нар ямар арга хэмжээ авах вэ?
5. Хоёр дасгалын хувьд цагдаа, бусад эрх бүхий албан хаагч, төрийн бус байгууллагууд, хохирогчид туслалцаа үзүүлдэг байгууллагууд гэх мэт өөр оролцогч талуудыг оролцуулах шаардлага байна уу? Хэрэв тийм бол хэнийг оролцуулах хэрэгтэйг жагсаалтаар гаргаж яагаад гэдгийг тайлбарлана уу.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хэргийг цааш нь шилжүүлэх тухай

Албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/хохирогч байж болзошгүй хүнийг үнэн зөв тогтоосны дараа мөн энэ төрлийн хэргийг хариуцсан эрх бүхий байгууллагын зүгээс тухайн хүн гэмт хэрэгт өртсөн байх үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд хохирогчид дэмжлэг, туслалцаа үзүүлж хэргийг шийдвэрлэх үүрэгтэй эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авна.

Аль эсвэл гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч хохирогчийг (гадаадын иргэн, Монгол улсын иргэн аль алиныг нь) цагдаад шилжүүлж болох ба улмаар цагдаагийн байгууллага цааш нь хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлэх эрх бүхий байгууллагад шилжүүлж болно.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлж саатуулсны дараа хуулийн дагуу зохих арга хэмжээг авхуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагч нар энэ төрлийн гадаадын иргэдийн асуудлыг цааш нь судалж үзээд хүн худалдаалах гэмт хэрэг үү, аль эсвэл тухай хүн зүгээр л Монгол улсад нэвтрэх мөн оршин суух хүчинтэй бичиг баримтгүй, эсвэл нэвтрэх, оршин суух, хууль ёсны бичиг баримгүй, ажиллах эрхгүй, эсвэл паспорт болон Монгол улсад байх визний хугацаа дууссан эсэхийг олж тодруулна. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагч нөхцөл байдалд дүгнэлт хийж нэг бол тухайн хүнийг албадан гаргах эсвэл тухайн хэрэг хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүй гэж үзвэл цагдаагийн байгууллагыг оролцуулах арга хэмжээ авна.

Гадаад ажилтны хэргийг шалгаж байх явцдаа Монгол улсын иргэн албадан хөдөлмөр эрхлэлт болон хүн худалдаалах гэмт хэрэгт ямар нэгэн байдлаар өртсөн байж болзошгүйг олж тогтоовол бусад эрх бүхий албан хаагчдыг татан оролцуулна.

СЭДЭВ 4: ГАДААДЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, ВИЗ ОЛГОХОД АНХААРАХ АСУУДАЛ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Суралцагчидтай дараах сэдвээр ярилцлага өрнүүлнэ үү.

- *Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт*
- *Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд гадаадын иргэнийг бүртгэх журам*
- *Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд гадаадын иргэнд виз олгох журам*

Гадаадын иргэний эрх зүйн байдал, гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэнд виз олгохтой холбоотой хуулийн зүйл заалт, журмыг Монгол Улсын хууль тогтоомж хавсралтаас харна уу.

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дээрх хайрцагт дурдсан үндэсний хууль тогтоомжуудын зүйл, заалтын тухай ярилцсаны дараагаар хохирогчдыг олж тогтооход ашиглаж болох шалгуур үзүүлэлтүүд болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй гэдгийг нь илэрхийлэх зан байдал (Модуль 3) зэргийн талаар дахин санууулна.

Суралцагчидтай дараах сэдвээр ярилцлага өрнүүлнэ үү.

- *Шалган нэвтрүүлэх албаны албан хаагч визгүй, визний хугацаа хэтэрсэн, ажиллах зөвшөөрөлгүй эсвэл ажиллах зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн гадаадын иргэний хэргийг шилжүүлэхэд гадаадын иргэний асуудал шийдвэрлэх тогтсон ажил үүргийнхээ хүрээнд ямар арга хэмжээ авдаг вэ?*
- *Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид Монгол улсад байгаа гадаадын иргэний эрх зүйн байдал, ямар зорилгоор хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан зэргийг хэрхэн тодруулдаг вэ?*
- *Бичиг баримттай холбоотой сэжигтэй асуудал гарахад тухайн хүн (хохирогч эсвэл хохирогч байж болзошгүй хүн) ямар зан байдал гаргадаг вэ?*
- *Нисэх онгоцны буудал/шалган нэвтрүүлэх цэг дээр холбогдох хүнээс (хохирогч/хохирогч байж болзошгүй хүн) асуулт асуухад асуултад хариулж чадахгүй харин аяллын бүх бичиг баримтыг нь барьсан хүн рүү хараад байвал та яах вэ?*
- *Хэрвээ тухайн хүн (хохирогч/хохирогч байж болзошгүй хүн) бүх асуултын хариултыг "маш сайн бэлдчихсэн" юм шиг, тэгсэн хэр нь нэг л үнэмшилгүй, эсвэл өөртөө итгэлгүй байдал ажиглагдвал та яах вэ?*
- *Нэвтрэн орохоор завдаж буй хүн хуурамч визтэй байвал та яах вэ?*
  - *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байсныг нь хожим нь олж тогтоовол та яах вэ? Тухайн хүн гэмт хэрэг үйлдэгч байвал яах вэ?*
- *Хилээр гарах гэж байгаа хүн визний хугацааг хэтрүүлсэн буюу визний хугацаа дууссан байвал та яах вэ?*
  - *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байсныг нь хожим нь олж тогтоовол та яах вэ? Тухайн хүн гэмт хэрэг үйлдэгч байвал яах вэ?*
- *Дамжин өнгөрөх гэж байгаа хүн хуурамч бичиг баримттай байвал та яах вэ?*
  - *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байсныг нь хожим нь олж тогтоовол та яах вэ? Тухайн хүн гэмт хэрэг үйлдэгч байвал яах вэ?*
- *Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн хувьд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж байсан уу? Бусад суралцагчидтай өөрийн туршлагыг хуваалцана уу.*

САНАМЖ:

Энэхүү сургалтын хөтөлбөрт гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын одоо мөрдөгдөж байгаа ажлын арга барилыг онцлох хэрэгтэй. Энэ нь сургалтын хөтөлбөр учраас шалган нэвтрүүлэх цэгийн тоог нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх зэрэг зөвлөмж энэхүү хөтөлбөрийн хамрах хүрээнд багтахгүй болохыг сургагч багш маш тодорхой хэлж ойлгуулах хэрэгтэй.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1 – СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭ

СУРГАГЧ БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Доор дурдагдах асуултуудыг жишээ байдлаар оруулсан бөгөөд асуух шаардлагатай бүх асуултыг багтаагаагүй болно. Сургагч багш асуултуудыг нэмэх, сургалтын өмнөх болон дараах үнэлгээ хийхэд байх шаардлагатай гэж үзсэн өөр асуултаар сольж болно. Монгол улсын хууль тогтоомжид тохируулан асуултад өөрчлөлт хийх, нэмэлт асуулт асуух зэргээр өөрсдийн хэрэгцээндээ нийцүүлэн ашиглах боломжтой. Сургалт явуулж буй байгууллага шаардлагатай гэж үзвэл "олон хариултаас тохирохыг нь сонгох"/"хоосон зайг бөглүүлэх"/"тийм, үгүй хариултын аль нэгийг өгөх" зэрэг ямар ч хэлбэрээр асуултаа тавьж болно. Нэмэлт асуулт оруулж байгаа тохиолдолд асуултад хариулах хугацаа, өгөх оноо зэрэгт өөрчлөлт орох тул шаардлагатай тохируулгыг хийнэ үү.
2. Сургалтын өмнөх үнэлгээний хуудсыг сургалт эхэлсэн хамгийн анхны өдөр суралцагчдад өгөх бөгөөд суралцагчдын хариулт өгсөн хуудсыг сургагч багш авч эхний үнэлгээг хийнэ.
3. Сургалтын дараах үнэлгээний хуудсыг сургалтын хамгийн сүүлийн өдрийн сургалт явагдаж дууссаны дараа суралцагчдад өгөх бөгөөд хариулт өгсөн хуудсыг сургагч багш авч эцсийн үнэлгээг хийнэ.
4. Сургалтын өмнөх болон дараах хуудсанд яг адилхан асуултууд асууж, ижил үнэлгээ өгөх байдлаар үнэлгээг гаргана.

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургалтын үнэлгээний асуулт

Оноо – 10

Хугацаа – 10 минут

Зөв хариултын доор ✔ тэмдэглэгээг хийнэ үү. Асуулт бүр нэг оноогоор үнэлэгдэнэ. (нийт 10 оноо)[48].

№	Асуулт	Зөв	Буруу
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн "хэргийн газар" нь зөвхөн мөлжлөг үйлдэгдсэн тэр газар юм.		✔
2.	Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалтын үед гэмт этгээд хохирогчоос "зөвшөөрөл"-ийг нь авсны үндсэн дээр тухайн үйлдлийг хийсэн гэж өөрийгөө хамгаалж мэдүүлэг өгч, цагдаагийн байгууллага үүнийг нь нотолсон тохиолдолд хэргийг хаана.		✔
3.	Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч нар төрийн бус байгууллага болон хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах практик байдаггүй.		✔
4.	Гэмт этгээд үйлдсэн хэргээ хүлээсэн тохиолдолд мөрдөн байцаалтын үед нэмэлт нотлох баримт цуглуулах шаардлагагүй.		✔
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр/ конвенцийн дагуу нөхөн төлбөр авах эрхгүй.		✔
6.	Цагдаагийн албан хаагч шүүх хурлаас өмнө хохирогчийн "эцэг эх"/ асран хамгаалагч" гэгдэж байгаа хүмүүст бага насны хохирогчийг нэн даруй хүлээлгэж өгөх хэрэгтэй.		✔
7.	Аврах ажиллагаа явагдсаны дараа хохирогч болон сэжигтэн этгээдийг нэг тээврийн хэрэгслээр хамтад нь авч явж болохгүй.	✔	
8.	Байцаалт авч буй ажилтан (мөрдөн байцаагч, прокурор) харилцааны чадвартай байхад л хангалттай бөгөөд хохирогчоос мэдүүлэг авахад сонсох чадвар тийм ч шаардлагатай биш.		✔
9.	Тусгай өрөө байхгүй тохиолдолд гэмт хэргийн газар сэжигтэн этгээдийн хажууд, насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авч болно.		✔
10.	Хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан тухайн гэмт хэрэг дээр ажиллах мэргэжлийн хүмүүс хангалттай биш байгаа тохиолдолд гэрч, хохирогчийн эрхийг хайхрахгүй ажиллаж болно.		✔

48 Сургалт явуулж буй байгууллага хариултыг тэмдэглээгүй хуудсыг суралцагчдад тарааж өгнө.

ПРОКУРОРУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургалтын үнэлгээний асуулт

Оноо – 10

Хугацаа – 10 минут

Зөв хариултын доор ✔ тэмдэглэгээг хийнэ үү. Асуулт бүр нэг оноогоор үнэлэгдэнэ. (нийт 10 оноо)[49].

№	Асуулт	Зөв	Буруу
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн "хэргийн газар" нь зөвхөн мөлжлөг үйлдэгдсэн тэр газар юм.		✔
2.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хэрэгт татах үед гэмт этгээд хохирогчоос "зөвшөөрөл"-ийг нь авсны үндсэн дээр тухайн үйлдлийг хийсэн хэмээн өөрийгөө хамгаалж мэдүүлэг өгч, прокурор үүнийг нь нотолсон тохиолдолд хэргийг хаана.		✔
3.	Прокурор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос нэг удаагийн мэдүүлгээр бүх баримтыг авч байцаалтаа дуусгах хэрэгтэй.		✔
4.	Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байгаа прокуроруудад төрийн бус байгууллага болон хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах практик байдаггүй.		✔
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр/ конвенцийн дагуу нөхөн төлбөр авах эрхгүй.		✔
6.	Прокурор шүүх хурлаас өмнө хохирогчийн "эцэг эх"/асран хамгаалагч" гэгдэж байгаа хүмүүст бага насны хохирогчийг нэн даруй хүлээлгэж өгөх хэрэгтэй.		✔
7.	Шүүх хуралд мэдүүлэг өгүүлэх үед хохирогч болон яллагдагч этгээдийг нэг тээврийн хэрэгслээр хамтад нь авч явж болохгүй.	✔	
8.	Тухайн хүн хийсэн ажлынхаа хөлсөнд аливаа төлбөр авсан тохиолдолд албадан хөдөлмөр эрхэлсэнд тооцохгүй.		✔
9.	Шүүгдэгчийн өмгөөлөгч тал шүүх хурлын үеэр гэрч, хохирогчоос ичгүүртэй, санаа нь зовохоор асуулт асуувал прокурор зогсоож болохгүй.		✔
10.	Хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан тухайн гэмт хэрэг дээр ажиллах мэргэжлийн хүмүүс хангалттай биш байгаа тохиолдолд гэрч, хохирогчийн эрхийг хайхрахгүй ажиллаж болно.		✔

49 Сургалт явуулж буй байгууллага хариултыг тэмдэглээгүй хуудсыг суралцагчдад тарааж өгнө.

ШҮҮГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургалтын үнэлгээний асуулт

Оноо – 10

Хугацаа – 10 минут

Зөв хариултын доор ✔ тэмдэглэгээг хийнэ үү. Асуулт бүр нэг оноогоор үнэлэгдэнэ. (нийт 10 оноо) [50].

No.	Асуулт	Зөв	Буруу
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн "хэргийн газар" нь зөвхөн мөлжлөг үйлдэгдсэн тэр газар юм.		✔
2.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хэрэгт татах үед гэмт этгээд хохирогчоос "зөвшөөрөл"-ийг нь авсны үндсэн дээр тухайн үйлдлийг хийсэн хэмээн өөрийгөө хамгаалж мэдүүлэг өгч, прокурор үүнийг нь нотолсон тохиолдолд хэргийг хаана.		✔
3.	Хохирогч болсон бүх хүүхдүүдэд ижил тэгш хандах хэрэгтэй учраас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь охид байсан ч шүүгчээс "жендерийн мэдрэмжтэй" ажиллах тусгай шаардлага байдаггүй.		✔
4.	Шүүгчид хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж байгаа прокурорууд болон цагдаагийн албан хаагчдыг төрийн бус байгууллага болон хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвшөөрч болохгүй.		✔
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр/ конвенцийн дагуу нөхөн төлбөр авах эрхгүй.		✔
6.	Шүүгч шүүх хурал болохоос өмнө хохирогчийн "эцэг эх"/асран хамгаалагч" гэгдэж байгаа хүмүүст бага насны хохирогчийг хүлээлгэж өгөх шийдвэрийг нэн даруй гаргах хэрэгтэй.		✔
7.	Тухайн хүн хийсэн ажлынхаа хөлсөнд аливаа төлбөр авсан тохиолдолд албадан хөдөлмөр эрхэлсэнд тооцохгүй.		✔
8.	Шүүн таслах ажиллагааны үеэр хохирогч болсон хүүхдийн эрх, шүүгдэгчийн эрхээс ямагт дээгүүр тавигдана.		✔
9.	Шүүгдэгчийн өмгөөлөгч тал шүүх хурлын үеэр гэрч, хохирогчоос ичгүүртэй, санаа нь зовохоор асуулт асуувал шүүгч зогсоож болохгүй.		✔
10.	Хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан тухайн гэмт хэрэг дээр ажиллах мэргэжлийн хүмүүс хангалттай биш байгаа тохиолдолд гэрч, хохирогчийн эрхийг хайхрахгүй ажиллаж болно.		✔

50 Сургалт явуулж буй байгууллага хариултыг тэмдэглээгүй хуудсыг суралцагчдад тарааж өгнө.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургалтын үнэлгээний асуулт

Оноо – 10

Хугацаа – 10 минут

Зөв хариултын доор ✔ тэмдэглэгээг хийнэ үү. Асуулт бүр нэг оноогоор үнэлэгдэнэ. (нийт 10 оноо)[51].

№	Асуулт	Зөв	Буруу
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн "хэргийн газар" нь зөвхөн мөлжлөг үйлдэгдсэн тэр газар юм.		✔
2.	Бөөнөөрөө аялж байгаа хүмүүсийн аяллын бичиг баримт нэг хүнд байгаа тохиолдолд хүн худалдаалах гэмт хэрэг байх магадлалтай.	✔	
3.	Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртсөн эсэхийг олж тогтооход хил хамгаалах байгууллага албан хаагчдад "жендерийн мэдрэмжтэй" байх тусгай шаардлага байхгүй.	✔	
4.	Хил хамгаалах байгууллага албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчтой ажиллаж байх үедээ төрийн бус байгууллага болон хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллагуудаас ямар нэг тусламж хэзээ ч авч болохгүй.		✔
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нь тогтоогдсон ч тухайн хохирогчид гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэг, хүчирхийлэлд өртсөн шинж тэмдэг илрэхгүй.		✔
6.	Сэжигтэн этгээд болон хохирогчийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч, хэн нь үнэн хэлж байгааг олж тогтооно.		✔
7.	Тухайн хүн хийсэн ажлынхаа хөлсөнд аливаа төлбөр авсан тохиолдолд албадан хөдөлмөр эрхэлсэнд тооцохгүй.		✔
8.	Тухайн хүн "сайн дураараа, өөрийн санал"-аар гадаад орон д ажиллахаар явж байгаа гэж хэлбэл цааш нь лавшруулж асуух шаардлагагүй.		✔
9.	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдийг зөв олж тогтоох зорилгоор тэднээс мэдүүлэг авахдаа ямар нэг завсарлага авахгүйгээр асуултуудаа бүгдийг нь нэг мэдүүлэгт багтаан асуух хэрэгтэй.		✔
10.	Хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан тухайн гэмт хэрэг дээр ажиллах мэргэжлийн хүмүүс хангалттай биш байгаа тохиолдолд гэрч, хохирогчийн эрхийг хайхрахгүй ажиллаж болно.		✔

51 Сургалт явуулж буй байгууллага хариултыг тэмдэглээгүй хуудсыг суралцагчдад тарааж өгнө.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сургалтын үнэлгээний асуулт

Оноо – 10

Хугацаа – 10 минут

Зөв хариултын доор ✔ тэмдэглэгээг хийнэ үү. Асуулт бүр нэг оноогоор үнэлэгдэнэ. (нийт 10 оноо) 52.

№	Асуулт	Зөв	Буруу
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн "хэргийн газар" нь зөвхөн мөлжлөг үйлдэгдсэн тэр газар юм.		✔
2.	Бөөнөөрөө аялж байгаа хүмүүсийн аяллын бичиг баримт нэг хүнд байгаа тохиолдолд хүн худалдаалах гэмт хэрэг байх магадлалтай.	✔	
3.	Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртсөн эсэхийг олж тогтооход гаалийн байгууллагын албан хаагчдад "жендерийн мэдрэмжтэй" байх тусгай шаардлага байхгүй.	✔	
4.	Гаалийн байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчтой ажиллаж байх үедээ төрийн бус байгууллага болон хохирогчид дэмжлэг үзүүлдэг байгууллагуудаас ямар нэг тусламж хэзээ ч авч болохгүй.		✔
5.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нь тогтоогдсон ч тухайн хохирогчид гэмт хэргийн дараах сэтгэл зүйн эмгэг, хүчирхийлэлд өртсөн шинж тэмдэг илрэхгүй.		✔
6.	Сэжигтэн этгээд болон хохирогчийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч, хэн нь үнэн хэлж байгааг олж тогтооно.		✔
7.	Тухайн хүн хийсэн ажлынхаа хөлсөнд аливаа төлбөр авсан тохиолдолд албадан хөдөлмөр эрхэлсэнд тооцохгүй.		✔
8.	Тухайн хүн "сайн дурааараа, өөрийн санал"-аар гадаад оронд ажиллахаар явж байгаа гэж хэлбэл цааш нь лавшруулж асуух шаардлагагүй.		✔
9.	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдийг зөв олж тогтоох зорилгоор тэднээс мэдүүлэг авахдаа ямар нэг завсарлага авахгүйгээр асуултуудаа бүгдийг нь нэг мэдүүлэгт багтаан асуух хэрэгтэй.		✔
10.	Хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан тухайн гэмт хэрэг дээр ажиллах мэргэжлийн хүмүүс хангалттай биш байгаа тохиолдолд гэрч, хохирогчийн эрхийг хайхрахгүй ажиллаж болно.		✔

52 Сургалт явуулж буй байгууллага хариултыг тэмдэглээгүй хуудсыг суралцагчдад тарааж өгнө.

ХАВСРАЛТ 2 - МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

МОДУЛЬ 3

Хүн худалдаалах гэмт хэргийг мэдээлэх тухай Монгол улсын холбогдох хуулийн зүйл заалтууд

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль

10 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн эрх, үүрэг

10.1.3. Гэмт хэргийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх.

11 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг

11.7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах

14.1. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага иргэдээс төлбөртэй авч болно.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

14 дүгээр зүйл. Хүн худалдаалах мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах

14.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авч болно.

МОДУЛЬ 4

Гэрч, хохирогчдын хувийн нууцаа хамгаалуулах эрх, мэдээллийг нууцлах тухай Монгол улсын холбогдох хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

13.1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараахь аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана:
   1.1. тодорхой үйлдлийг хязгаарлах;
   1.2. биечилсэн хамгаалалтад авах;
   1.3. мэдээллийн нууцлалыг хангах;
   1.4. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх хүрээнд прокурор, шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн дараахь арга хэмжээг авах тухай шийдвэр гаргаж болно:
   2.1. нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
   2.2. нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаархи мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
   2.3. шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
   2.4. гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах.
3. Тухайн хэргийг гэрчлэхтэй холбоотойгоор гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараахь нэмэлт арга хэмжээ авч болно:
   3.1. гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах;
   3.2. яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх;
   3.3. шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсч болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах.
4. Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана.
5. Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь,

эсхүл хэсэгчилсэн байдлаар хаалттай явуулж болно.

6. Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг цуцлах тухай албан тушаалтны санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрээ хүчингүй болгож, өөрчилж болно.
7. Шүүхээс гэмт хэргийг илрүүлэх, бусад яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг нотлох чиглэлээр мэдүүлэг өгч байгаа шүүгдэгч, эсхүл шинжээчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хамгаалах шийдвэр гаргаж болно.
8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.
9. Гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор мөрдөгч өөрийн санаачилгаар, эсхүл гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.
10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан мэдээллийг шүүх хуралдааны явцад ил болгоно.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

4 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим

4.1. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно:
4.1.5. хохирогчийн аюулгүй байдлыг хангах;
4.1.6. хувийн нууцыг нь хамгаалах.

9 дүгээр зүйл. Хамгаалах байр

9.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана.
9.2. Хохирогч болсон гэж өөрийгөө үзсэн этгээд хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллага, эсхүл хамгаалах байрны захиргаанд гаргана.
9.3. Хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна.

10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах

10.1. Хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой бусад мэдээллийг нууцлах ба эдгээр мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараах, хохирогчийн нүүр царай, дуу хоолойг бусдад танигдахуйц байдлаар түгээхийг хориглоно.
10.2. Хохирогч өөрөө бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухай мэдээллийг гэр бүлийнх нь бусад гишүүнд мэдэгдэхийг хориглоно.
10.3. Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч болон хэргийн бусад оролцогч хохирогчийн хувийн байдлын тухай өөртөө ил болсон мэдээллийг бусдад тараахыг хориглоно.
10.4. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл хохирогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаягийг нууцлах арга хэмжээ авна.

11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах

11.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно.
11.2. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хүртэл тус улсад оршин суух зөвшөөрлийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох буюу сунгана.

13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах

13.1. Хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авна.
13.2. Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.
13.3. Хохирогч хүүхдийг энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.1. гэрч, хохирогч» гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг хэлнэ.

5 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

5.2. Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.

7 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

7.1.1. урьдчилан сануулах;

7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;

7.1.3. биечилсэн хамгаалалт;

7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;

7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;

7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;

7.1.7. нүүлгэн шилжүүлэх;

7.1.8. баримт бичгийг солих;

7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

19 дүгээр зүйл. Хамгаалуулах эрх үүсэх

19.1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

МОДУЛЬ 5

Гэрч, хохирогч хамгааллын талаарх холбогдох хууль, Монгол улсын холбогдох хуулийн зүйл заалтууд болон үндэсний хөтөлбөр

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

6 дугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

6.1.1. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;

6.1.2. сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

7.1.1. урьдчилан сануулах;

7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;

7.1.3. биечилсэн хамгаалалт;

7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;

7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;

7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;

7.1.7. нүүлгэн шилжүүлэх;

7.1.8. баримт бичгийг солих;

7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

17 дугаар зүйл. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1. Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

17.2. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

17.2.1. гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;

17.2.2. гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.3. шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.4. шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

17.2.5. шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3. Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

18.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:
18.1.1. хууль зүйн туслалцаа;
18.1.2. сэтгэл зүйн туслалцаа;
18.1.3. эрүүл мэндийн туслалцаа.

18.2. Гэрч, хохирогчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.

18.3. Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.4. Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан нэгж тус тус хариуцан хэрэгжүүлнэ.

Гэрч, хохирогч хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нь нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, тэдэнд төрөөс нийгмийн халамж, туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгоход оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:
4.1.2. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын ажлын уялдааг сайжруулах;
4.1.3. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэхийн ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, холбогдох ажилтан, албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах;
4.1.4. гэрч, хохирогчийг хамгаалах түр болон тусгай байруудыг бий болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэх;
4.1.5. гэрч, хохирогчийг мэргэжлийн сургалт, нийгмийн үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх;
4.1.6. гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах цахим мэдээллийн бааз байгуулах.

Тав. Хөтөлбөрийн үйл ажиллагаа

5.1. Энэ хөтөлбөрийн 4.1.1-д заасан гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
5.1.1. гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр хэрэгжиж байгаа хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах;
5.1.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн журмыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай уялдуулан боловсронгуй болгох;
5.1.3. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх зорилгоор шаардлагатай журам, зааврыг шинээр боловсруулан баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай стандарт, маягтууд болон сургалтын модуль, хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэх;
5.1.4. аюулгүй байдлын болон сэтгэлзүйн хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан гэрч, хохирогчийн талаар судалгаа гаргаж, гэмт хэрэгт дахин өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
5.1.5. хөтөлбөрийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөж, байнга боловсронгуй болгох;
5.1.6. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тайланд жил бүр үнэлгээ хийх.

5.2. Энэ хөтөлбөрийн 4.1.2-т заасан гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын ажлын уялдааг сайжруулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
5.2.1. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлж байгаа зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;
5.2.2. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, техникийн туслалцаа авах;
5.2.3. төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, хамтран ажиллахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх;
5.2.4. хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой иргэд, байгууллагын талаар судалгаа гаргаж, тэдэнтэй гэрээ байгуулан хамтран ажиллах;
5.2.5. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх асуудлаар бусад улсын туршлагыг судлах, сайн туршлага, арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, харилцан мэдээлэл солилцох.

5.4. Энэ хөтөлбөрийн 4.1.4-т заасан гэрч, хохирогчийг хамгаалах түр болон тусгай байруудыг бий болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.4.1. хэрэгцээ, шаардлагыг нь үндэслэн гэрч, хохирогчийг хамгаалах байр шинээр байгуулах, тэдгээрийн байршлыг тодорхойлж, хүний нөөцийг бэлтгэх;

5.4.2. өндөр эрсдэлтэй гэрч, хохирогчийг хамгаалалтад авах тусгай хамгаалалт бүхий байрыг цагдаагийн байгууллагын дэргэд байгуулах; /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 115-р тогтоолоор өөрчлөлт орсон/

5.4.3. тусгай хамгаалах байрны стандартыг боловсруулан батлуулах, тусгай хамгаалах байр болон албан хаагчдын аюулгүй байдлыг хангах;

5.4.4. гэрч, хохирогчийг хамгаалах байр орон нутагт байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулахад шаардагдах зардлыг тухайн орон нутгийн иргэдийн Хурлаар шийдвэрлүүлэх;

5.4.5. гэрч, хохирогчид хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тэдгээрийг хамгаалах төвүүдийг бие даан, эсхүл төрийн болон төрийн бус байгууллагыг түшиглэн байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх;

5.4.6. Улаанбаатар хот болон орон нутагт гэрч, хохирогчийг хамгаалах байр барьж, хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг судлан тогтоож, хамтран ажиллах.

5.5. Энэ хөтөлбөрийн 4.1.5-д заасан гэрч, хохирогчийг мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт, нийгмийн үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.5.3. төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн (өмгөөллийн) туслалцаа үзүүлэх;

5.5.4. сэтгэл зүйн болон эрүүл мэнд, хууль зүйн туслалцааг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид зохих журмын дагуу шуурхай үзүүлэх;

5.5.5. хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалт, нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах журмыг боловсруулан баталж мөрдүүлэх.

5.6. Энэ хөтөлбөрийн 4.1.6-д заасан гэрч, хохирогчийг хамгаалах цахим мэдээллийн баазтай болж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.6.1. гэрч, хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг хангах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг боловсруулан баталж мөрдүүлэх;

5.6.2. гэрч, хохирогчийн талаар цахим мэдээллийн сан байгуулах;

5.6.4. хамгаалалтад байгаа гэрч, хохирогч цахим хэлбэрээр мэдээлэл шуурхай хүлээн авах боломжийг бий болгох;

Хүн худалдаалахтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

3.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. хохирогч хамгаалах байр байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;

3.2.2. хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх бүтцийг бий болгож, үйл ажиллагааг эхлүүлэх;

3.2.3. хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.2.4. гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эргүүлэн авчрах, Монгол Улсад хохирогч болсон гадаадын иргэнийг эх оронд нь буцахад туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.2.5. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 50-иас доошгүй хувийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар ханган нийгэмшүүлэх;

3.2.6. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.6.1. хүн худалдаалах гэмт хэрэгт, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг (мал маллах, морь унах, айлын хүүхэд харах, гуйлга гуйх гэх мэт)-т өртсөн, өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гаргаж, дахин гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх;

3.2.6.2. нийгмийн халамжийн болон хүүхэд хамгааллын чиглэлийн төсөл, хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлэх;

3.2.6.3. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалалтад авч эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд асрамжийн газар байлгах;

3.2.6.4. хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч, хуульч, багш нарыг сургаж мэргэшүүлэх.

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1. олон нийт болон зорилтот бүлэгт хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээлэл, мэдлэгийг өгч, жил бүр зорилтот бүлгийн 30 хувийг хамруулах замаар 100 хувьд хүргэнэ.

6.1.2. хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаарх олон нийтийн мэдлэг, хандлага дээшилж, уг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажилд ахиц дэвшил гарч, гэмт хэргийн тоо буурна.

6.1.3. хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нийгмийн ажилтан, хүүхдийн сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтны энэ төрлийн гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага дээшилнэ.

6.1.4. хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй байгууллагуудын чадавх дээшилж, алба хаагчид мэргэшсэн байна.

6.1.5. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагаа тогтмолжиж, хохирогчид хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдсэн байна.
6.1.6. хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн иргэдийн 50-иас доошгүй хувийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар ханган нийгэмшүүлнэ
6.1.7. Монгол Улсын иргэд ихээр зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр хамтран ажиллах хамтын ажиллагаа өргөжнө.
6.1.8. хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагаа, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болж, энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд ахиц дэвшил гарна.
6.1.9. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс болон олон улсын байгууллагаас Монгол Улсад хүн худалдаалахтай тэмцэх талаар ирүүлсэн зөвлөмжүүд хэрэгжинэ.

Хохирогчийг эх оронд нь буцаан авчрахтай холбоотой Монгол улсын холбогдох хуулийн зүйл заалтууд

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1. Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:
12.1.5. гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.

МОДУЛЬ 6

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэхтэй холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хууль

1.7 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх

1. Монгол Улсын иргэнийг гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгөхгүй.
2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаггүй харьяалалгүй хүнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гэмт хэрэгт шалгуулах, ял эдлүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгч болно.
3. Тухайн улсын хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулах, эрүү шүүлт тулгах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тухайн улсад гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр шилжүүлэн өгөхгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

43.1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлт гаргах

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад тавина.
2. Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:
2.1. шилжүүлэн авах хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, түүнийг гэрчлэх баримт;
2.2. иргэний харьяалал, гадаад төрх байдлын тодорхойлолт, гэрэл зураг;
2.3. тухайн хүний үйлдсэн хэргийн товч агуулга, хэрэглэх хуулийн заалт, шийтгүүлсэн бол шүүхээс оногдуулсан ял;
2.4. шүүхийн шийтгэх тогтоол, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол гаргасан он, сар, өдөр;
2.5. хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн баталгаат хуулбар.

43.2 дугаар зүйл. Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг биелүүлэх

1. Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн, эсхүл ял шийтгүүлсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шилжүүлбэл зохих хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт хорих ял эдэлж

байгаа бол ял эдэлж дуустал, эсхүл ялаас чөлөөлөх хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

3. Шилжүүлэн өгөхийг хойшлуулбал хөөн хэлэлцэх хугацаа дуусах, эсхүл гэмт хэргийг мөрдөхөд саад учруулахаар бол уг хүнийг шилжүүлэн өгч болно.

43.3 дугаар зүйл. Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1. Дараах тохиолдолд шилжүүлэн өгөхгүй:
   1.1. Монгол Улсын иргэн;
   1.2. уг хүнд Монгол Улсад орогнох эрх олгосон;
   1.3. уг хүний холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол;
   1.4. шилжүүлбэл зохих хүн тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол;
   1.5. Монгол Улсын хуулиар тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол;
   1.6. уг хүнийг шилжүүлэн өгснөөр түүнийг эрүүдэн шүүх бодит аюул тулгарахаар бол;
   1.7. уг хүний үйлдсэн гэмт хэрэгт шилжүүлэн авах хүсэлт гаргасан улсын хуулиар цаазаар авах ял оногдуулахаар бол.

Олон улсын гэрээний тухай хууль

8 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ

8.1. Улсын Их Хурал дараах олон улсын гэрээг заавал соёрхон батална:
   8.1.4. эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээ;

Гадаадын иргэнийн эрх зүйн байдлын тухай хууль

34 дүгээр зүйл. Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх

34.2.2. шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;

37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах

37.1. Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараах үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:
   37.1.11. шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;

Харьяатын тухай хууль

3 дугаар зүйл. Монгол Улсын харьяат байх

3.5. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

Прокурорын тухай хууль

29 дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагаанд хяналт тавих

29.3. Прокурор гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагаанд дараах бүрэн эрхтэй:
   29.3.1. гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг гадаад улсын эрх бүхий байгууллагад уламжлах;
   29.3.2. гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг үндэслэн тодорхой ажиллагаа явуулахыг эрх бүхий байгууллагад даалгах;

МОДУЛЬ 7

Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, сэжигтэн баривчлахтай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

30.9 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх

1. Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол прокурорт даруй мэдэгдэн, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулна.
2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болно.
3. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тухай мөрдөгчийн тогтоолд хэргийн бүртгэлийн дугаар, ямар гэмт хэрэг хэзээ, хаана үйлдэгдсэн, уг хэрэгт хэрэг бүртгэлт явуулах үндэслэлийг тусгана. Тогтоолд хүн, хуулийн этгээдийн нэрийг холбогдуулан бичихийг хориглоно.
4. Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь үндэслэлгүй гэж үзвэл прокурор мөрдөгчийн тогтоолыг хүчингүй болгоно.

31.4 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчлах

1. Дараах үндэслэл байгаа бол прокурор сэжигтнийг баривчлах тухай мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш уг саналыг шүүхэд даруй хүргүүлнэ:
   1.1. энэ хуулийн 31.2 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан бол;
   1.2. оргон зайлсан, эсхүл мэдэгдэх хуудсаар дуудахад оргон зайлах үндэслэл байгаа бол;
   1.3. мөрдөгч, прокурор, шүүгч, хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол;
   1.4. гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа, түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол;
   1.5. нотлох баримтаа устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол.
2. Сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналд дараах зүйлийг тусгана:
   2.1. санал гаргасан прокурорын нэр, албан тушаал, гарын үсэг, он, сар, өдөр;
   2.2. сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
   2.3. энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, түүнийг нотлох баримт.
3. Шүүх нь прокурорын саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор сэжигтнийг баривчлах эсэхийг шийдвэрлэнэ.
4. Сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох тухай шүүхийн шийдвэрт дараах зүйлийг тусгана:
   4.1. сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
   4.2. энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баривчлах үндэслэл;
   4.3. баривчлах ажиллагаа явуулах зөвшөөрлийг хэрэгжүүлэх байгууллага;
   4.4. зөвшөөрөл олгосон он, сар, өдөр, цаг;
   4.5. шийдвэр хүчинтэй байх хугацаа;
   4.6. шүүгчийн гарын үсэг, тэмдэг.
5. Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалахтай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах

11.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно.

11.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хүртэл тус улсад оршин суух зөвшөөрлийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох буюу сунгана.

Эрүүгийн хууль

19.14 дүгээр зүйл. Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх

1. Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, эсхүл хуурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн баримт бичиггүйгээр, хуурамч баримт бичгээр Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.

Сэжигтнийг баривчлах, түр цагдан хорихтой холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

31.4 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчлах

1. Дараах үндэслэл байгаа бол прокурор сэжигтнийг баривчлах тухай мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш уг саналыг шүүхэд даруй хүргүүлнэ:
   1.1. энэ хуулийн 31.2 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан бол;

1.2. оргон зайлсан, эсхүл мэдэгдэх хуудсаар дуудахад оргон зайлах үндэслэл байгаа бол;
1.3. мөрдөгч, прокурор, шүүгч, хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол;
1.4. гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа, түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол;
1.5. нотлох баримтаа устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол.

2. Сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналд дараах зүйлийг тусгана:
2.1. санал гаргасан прокурорын нэр, албан тушаал, гарын үсэг, он, сар, өдөр;
2.2. сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
2.3. энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, түүнийг нотлох баримт.

3. Шүүх нь прокурорын саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор сэжигтнийг баривчлах эсэхийг шийдвэрлэнэ.

4. Сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох тухай шүүхийн шийдвэрт дараах зүйлийг тусгана:
4.1. сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
4.2. энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баривчлах үндэслэл;
4.3. баривчлах ажиллагаа явуулах зөвшөөрлийг хэрэгжүүлэх байгууллага;
4.4. зөвшөөрөл олгосон он, сар, өдөр, цаг;
4.5. шийдвэр хүчинтэй байх хугацаа;
4.6. шүүгчийн гарын үсэг, тэмдэг.

5. Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй.

31.5 дугаар зүйл. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах

1. Мөрдөгч дараах тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болно:
1.1. гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан;
1.2. энэ хуульд заасан хойшлуулшгүй тохиолдолд;
1.3. гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан;
1.4. тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн.

2. Мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлнэ.

3. Мөрдөгч сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баривчилсан бол 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ.

4. Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

5. Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

6. Хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

31.6 дугаар зүйл. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа

1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй түүнд дараах зүйлийг танилцуулна:
1.1. ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа;
1.2. хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох;
1.3. түүний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулах;
1.4. хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулах.

2. Шүүхийн зөвшөөрлөөр баривчлах тохиолдолд мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулсны дараа сэжигтэнд баривчлах тухай шүүхийн зөвшөөрөл, үндэслэлийг танилцуулна.

3. Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед, эсхүл баривчилсны дараа сэжигтний биед үзлэг хийж, дараах эд зүйлийг хураан авна:
3.1. хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эд зүйл;
3.2. оргон зайлахад ашиглаж болох эд зүйл, баримт бичиг;
3.3. гэмт хэрэг үйлдэж олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй эд зүйл, баримт бичиг;
3.4. хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг;
3.5. хүн, хуулийн этгээд эзэмших, ашиглах, хадгалах, авч явахыг хуулиар хориглосон эд зүйл, баримт бичиг.

4. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

5. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

6. Мөрдөгч баривчлах ажиллагааны үед холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.

Өсвөр насны хүнийг баривчлах, цагдан хорихтой холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

18.2 дугаар зүйл. Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага

1. Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангана.
2. Өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана.
4. Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллана.

18.3 дугаар зүйл. Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох

1. Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдалтай нь холбоотой дараах мэдээллийг тогтоосон байна:
   1.1. төрсөн он, сар, өдөр, нас;
   1.2. амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл;
   1.3. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;
   1.4. гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх;
   1.5. сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах.
2. Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг хуулийн дагуу авсан иргэний бүртгэлийн бичиг баримтаар тодорхойлно.
3. Дараах тохиолдолд өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг тогтоох зорилгоор шинжээч томилно:
   3.1. энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримт нь хуурамч гэж үзэх үндэслэл байвал;
   3.2. энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримт байхгүй бол;
   3.3. өөр улсад бүртгэлтэй, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримтыг олж авах боломжгүй бол.
4. Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас өөр аргаар тогтоосон нотлох баримтыг шүүхээр шинжлэн судлах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.
5. Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх явцад дараах мэдээллийг гаргаж өгөхийг прокуророос шаардаж болно:
   5.1. тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараа биеэ хэрхэн авч явж байсан зан байдал, араншин;
   5.2. тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан.
6. Шүүх ял эдэлж байгаа өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдээлэл гаргаж өгөхийг прокуророос шаардаж болно.

18.6 дугаар зүйл. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг дуудан ирүүлэх, баривчлах

1. Баривчлах сэжигтэн нь өсвөр насны хүн бол энэ зүйлд заасан журмыг баримтална.
2. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг түүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчаар дамжуулан дуудна.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болох үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлахгүй.
4. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.
5. Баривчлагдсан өсвөр насны сэжигтэн, цагдан хоригдсон өсвөр насны яллагдагчийг баривчлагдсан арван найман насанд хүрсэн хүн, цагдан хоригдсон арван найман насанд хүрсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс тусад нь байлгана.

18.7 дугаар зүйл. Өсвөр насны яллагдагчид холбогдох хэргийн шүүхийн хэлэлцүүлэг

1. Энэ хуулийн 14.13 дугаар зүйлд заасан журмаар явагдах өсвөр насны яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг хаалттай явагдах ба өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.
2. Өсвөр насны яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч хүрэлцэн ирээгүй нь шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

18.8 дугаар зүйл. Цагдан хорих

1. Энэ хуулийн 14.13 дугаар зүйлд заасны дагуу өсвөр насны яллагдагчийг цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгч, эсхүл хүсэлт гаргасан хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулна.
2. Өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 3 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 6 сараас хэтэрч болохгүй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос зөвшөөрөл авахтай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээллийн байгууллагын үүрэг

8.1. Хэвлэл, мэдээллийн байгууллага дор дурдсан зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглоно:
8.1.1. хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаарх мэдээлэл;

10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах

10.2. Хохирогч өөрөө бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухай мэдээллийг гэр бүлийнх нь бусад гишүүнд мэдэгдэхийг хориглоно.

МОДУЛЬ 8

Гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээдтэй холбоотой мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

32.3 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд

1. Мөрдөгчөөс шилжүүлсэн хэргийн талаар прокурор доор дурдсан асуудлыг хянах үүрэгтэй:
1.1. оролцогчийг хавтаст хэргийн материалтай танилцах боломжоор хангасан эсэх, хавтаст хэргийн материалтай танилцаад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн эсэх;
1.2. гэмт хэргийн шинжийг бүрэн нотолсон эсэх;
1.3. хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэх;
1.4. энэ хуулийн 16.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх;
1.5. Эрүүгийн хууль болон энэ хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв хэрэглэсэн эсэх;
1.6. таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ хууль зөрчсөн эсэх;
1.7. гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;
1.8. гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан эсэх;
1.9. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх;
1.10. яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг бүрэн нотолсон эсэх.

Гэмт хэргийн хохирогч хүүхэд байгаа тохиолдолд эрсдэлийг тодорхойлох, тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхтэй холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Хүүхэд хамгааллын тухай хууль

10 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

10.1. Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ:
10.1.1. мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах;
10.1.2. нөхцөл байдлын үнэлгээ хийх;
10.1.3. аюулгүй байдлыг хангах;
10.1.4. дэмжих, холбон зуучлах;
10.1.5. хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх;

10.1.6. гэр бүлд нь эргэн нэгтгэх.

10.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.

10.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

10.4. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12 дугаар зүйл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх

12.1. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

12.2. Нөхцөл байдлын үнэлгээ хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшнийг үнэлэх, шалгах, дүгнэх үе шатнаас бүрдэнэ.

12.3. Баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан өөрийн санаачилгаар, эсхүл хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэх явцдаа холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

12.4. Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа тухайн асуудлыг газар дээр нь болон хуульд заасны дагуу холбогдох этгээдээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй бол хүүхдэд хувийн хэрэг нээж, зөвлөгөө өгөх, дэмжих, холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.

12.5. Эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

12.6. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

13 дугаар зүйл. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах

13.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна.

13.2. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч, хуулийн этгээд, гэр бүл, иргэн, эсхүл тэдгээр нь хамтран үзүүлнэ.

13.3. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

13.4. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг, нийгмийн ажилтан гаргах бөгөөд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

15 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ

15.1. Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараах үйл ажиллагаа явуулна:

15.1.1. гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.2. сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.3. гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

15.1.4. хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

15.1.5. эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

15.1.6. хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

15.1.7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах;

15.2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.

15.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

15.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1-д заасан хамтарсан баг эрсдэлт нөхцөлд байгаа

хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргаж, хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

Хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахтай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

8.2 дугаар зүйл. Хохирогчийн эрх

1. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхтэй:
   1.1. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
   1.2. хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
   1.3. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
   1.4. шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;
   1.5. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;
   1.6. шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;
   1.7. эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
   1.8. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах;
   1.9. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;
   1.10. шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолын хувийг авах;
   1.11. шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
   1.12. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
   1.13. энэ хуульд заасан бусад эрх.
2. Хохирогч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон, эсхүл өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бол энэ зүйлд заасан эрхийг түүний хууль ёсны төлөөлөгч эдэлнэ.
3. Хохирогч дараах үүрэгтэй:
   3.1. шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэх;
   3.2. хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;
   3.3. өөрт илэрхий болсон хэргийн талаарх мэдээллийг задруулахгүй байх;
   3.4. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сахих.
4. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.3 дугаар зүйл.Мэдээллээр хангуулах

1. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу дараах ажиллагааг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор түүнд энэ тухай мэдэгдэнэ:
   1.1. яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг;
   1.2. хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг харьяаллын дагуу шилжүүлэх;
   1.3. ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан.
2. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар мөрдөгч түүнд мэдэгдэнэ.
3. Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй.
4. Прокурор, мөрдөгч нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад мэдээллийг нууцалж болно.

8.4 дүгээр зүйл.Аюулгүй байдлаа хамгаалуулах

1. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно.

8.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэгч

1. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.

2. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.
3. Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.
4. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.
5. Иргэний нэхэмжлэгчид энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-т заасан эрх болон энэ бүлэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.
6. Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.
7. Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн тогтоол, магадлалын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.
8. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.
9. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
10. Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.
11. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хавтаст хэрэгт хавсаргана.
12. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.
13. Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.
14. Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл мөрдөгч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох ба энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

Гэрч, хохирогч хамгаалах тухай хууль

5 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

5.1. Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч хамаарна.
5.2. Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.
5.3. Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.
5.4. Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.

6 дугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:
6.1.1. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;
6.1.2. сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:
7.1.1. урьдчилан сануулах;
7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;
7.1.3. биечилсэн хамгаалалт;
7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;
7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;
7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;
7.1.7. нүүлгэн шилжүүлэх;
7.1.8. баримт бичгийг солих;
7.1.9.гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

15 дугаар зүйл.Хохирол нөхөн төлүүлэх

15.1. Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.
15.2. Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.
15.3. Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэр хэмжээг харгалзан шүүх тогтооно.

Эрүүгийн ялын төрөл, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ, хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ялын талаарх Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хууль

5.2 дугаар зүйл. Ялын төрөл

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:
   1.1. торгох ял;
   1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;
   1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;
   1.4. хорих ял;
   1.5. эрх хасах ял.
2. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.
3. Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт оногдуулах үндсэн ялын төрөл, хэмжээг заана.

5.6 дугаар зүйл. Хорих ял

1. Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ.
2. Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.
3. Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.
4. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.

6.6 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал

1. Шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ дараах хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:
   1.1. бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;
   1.2. энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;
   1.3. нийтэд аюултай аргаар үйлдсэн;
   1.4. өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;
   1.5. албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотнын хүний эсрэг үйлдсэн;
   1.6. хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;
   1.7. онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
   1.8. гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.
2. Энэ хуулийн тусгай ангид заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.
3. Шүүх энэ зүйлд заагаагүй нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг хориглоно.

7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.
2. "Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого" гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.
3. Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх

ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.

4. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.
5. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.
6. Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах

1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
   2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;
   2.2. хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;
   2.3. Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг:
   3.1. байнга тогтвортой;
   3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: *Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.*

Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хууль

2.5 дугаар зүйл. Гэмт хэргийн хохирол, хор уршиг

1. Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.
2. Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.
3. Энэ хуульд заасан "ноцтой хохирол" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно.
4. Энэ хуульд заасан дараах хохирлын хэмжээг доор дурдсанаар ойлгоно:
   4.1. "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;
   4.2. "үлэмж хэмжээний хохирол" гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;
   4.3. "бага хэмжээний хохирол" гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг.
5. Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршгийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тогтооно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх

1. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхтэй:
   1.9. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

1.12. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;

16.2 дугаар зүйл. Нотолбол зохих байдал

1.5. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;

17.4 дүгээр зүйл. Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам

4.5. гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн эсэх;

32.10 дугаар зүйл.Яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх

3.2. яллаж байгаа гэмт хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай нотлох баримт.
5.3. хохирол, хор уршгийн талаарх мэдээлэл;

33.1 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;

36.1 дүгээр зүйл. Шийдвэр гаргахаар зөвлөлдөх

5.4. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээг тогтоох, шүүгдэгч тус бүрээс ямар хэмжээгээр гаргуулах.

36.7 дугаар зүйл. Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг
3.5. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэрэгсэхгүй болгох, эсхүл хэлэлцэхгүй орхих тухай үндэслэл;

36.8 дугаар зүйл. Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

1.6. гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулах, эсхүл хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх;
1.7. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орхих үндэслэл;36.9-3

45.4 дугаар зүйл. Сэтгэл санааны хохирлыг үр дагаврыг арилгах

1. Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

45.5 дугаар зүйл. Хуулийн этгээдэд хохирлыг нөхөн төлөх

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан хохирлыг энэ бүлэгт заасан журмын дагуу төр хариуцна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1. Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:
12.1.1. эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;
12.1.2. сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;
12.1.3. ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;
12.1.4. хууль зүйн туслалцаа;
12.1.5. гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.
12.3. Энэ хуулийн 12.1-д заасан хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

13 дугаар зүйл.Хохирогч хүүхдийг хамгаалах

13.1. Хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авна.
13.2. Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.
13.3. Хохирогч хүүхдийг энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.

Засгийн газраас хохирогчдод нөхөн төлбөр олгохтой холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалт

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

213 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан

213.1. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
- 213.1.1. шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;
- 213.1.2. замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;
- 213.1.3. шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 213.2-т заасан гэмт хэрэгт гэм бурууТай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр.

213.2. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл / Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террор үйлдэх/-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дор дурдсан хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна:
- 213.2.1. эмчилгээний зардал;
- 213.2.2. оршуулгын зардал;
- 213.2.3. хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого.

213.3. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм бурууТай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно.

213.4. Энэ хуулийн 213.1-д заасан сангаас олгох нөхөн төлбөр нь дор дурдсан хэмжээнээс ихгүй байна:
- 213.4.1. энэ хуулийн 213.2-т заасан гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг;
- 213.4.2. энэ хуулийн 213.2-т заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн бие махбодод хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг.

213.5. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг нэг удаа олгоно.

213.6. Энэ хуулийн 213.1-д заасан сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар тогтооно.

213.7. Гэмт хэргийн хохирогчид энэ хуулийн 213.1-д заасан сангаас олгосон нөхөн төлбөрийг гэм бурууТай нь шүүхээр тогтоогдсон этгээдээр уул санд буцаан төлүүлнэ.

213.8. Гэм бурууТай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу зохих төлбөрийг гаргуулна.

213.9. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 213.2-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардал болон төвлөрсөн орлогын гүйцэтгэлийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

213.10. Гэмт хэргийн улмаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учирсан бол энэ хуулийн 213.2.1-д заасан эмчилгээний зардлыг шүүхийн шийдвэр гарсан эсэхээс үл хамааран нэн даруй олгож, бурууТай этгээдээр нөхөн төлүүлнэ.

МОДУЛЬ 9

18 насанд хүрээгүй хохирогчтой холбоотой шүүх хуралдааныг "хаалттай явуулах"-тай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

3.2 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1. Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна.
2. Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.
3. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

Шүүгч эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг эхлүүлэх анхан шатны ажиллагаатай холбоотой Монгол улсын хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

33.1 дүгээр зүйл.Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

1. Прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийг шүүгч хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор тухайн хэргийн талаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:
   1.1. яллагдагчийг шүүхэд шилжүүлэх;
   1.2. хэргийг прокурорт буцаах;
   1.3. хэргийг түдгэлзүүлэх;
   1.4. хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт дараах зүйлийг тусгана:
   3.1. шийдвэрийг хэзээ, хаана гаргасан;
   3.2. шийдвэр гаргасан шүүгчийн нэр;
   3.3. шийдвэрийн үндэслэл.
4. Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргаагүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахгүй байж болно.
5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг энэ хуульд заасан үндэслэлээр хаалттай явуулж болно.
6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана:
   6.1. өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;
   6.2. хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;
   6.3. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;
   6.4. прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;
   6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;
   6.6. хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт;
   6.7. яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;
   6.8. яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;
   6.9. шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт;
   6.10. шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал, хүсэлт;
   6.11. шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;
   6.12. таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;
   6.13. нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;
   6.14. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;
   6.15. мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;
   6.16. хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;
   6.17. эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.
7. Энэ зүйлийн 6.5, 6.6, 6.7-д заасан хүсэлтийг шүүх хүлээн авах үндэслэлтэй байвал хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг даруй үргэлжлүүлэн явуулж болно.
8. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.
9. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ.
10. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 11.7, 11.8 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэж, прокурор, оролцогчид танилцуулна.
11. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.
12. Урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6.13, 6.14, 6.15, 6.16-д заасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг гомдол, хүсэлтийг шийдвэрлэнэ.

33.2 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх

1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шийдвэрт дараах асуудлыг тусгана:
   1.1. шүүх хуралдааныг хэзээ, хаана хийх;
   1.2. шүүх хэргийг дангаар, эсхүл шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх эсэх;
   1.3. шүүх хуралдаанд дуудан ирүүлэх хүний нэр;
   1.4. шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хаалттай явуулах эсэх;
   1.5. яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх;
   1.6. зарим хэргийг тусгаарлах, нэгтгэх эсэх;
   1.7. энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай;
   1.8. шүүх хуралдааны бэлтгэлийг хэн, хэрхэн хангах тухай.
2. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх ба шүүх хуралдааны товыг 3-аас доошгүй хоногийн өмнө талуудад мэдэгдэнэ.

33.3 дугаар зүйл.Хэргийг прокурорт буцаах

1. Урьдчилсан хэлэлцүүлгийн үед дараах үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ:
   1.1. хэргийг буруу тусгаарласан бол;
   1.2. шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх бол;
   1.3. мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол.
2. Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих эрхтэй.

33.4 дүгээр зүйл.Хэргийг түдгэлзүүлэх

1. Шүүгч дараах нөхцөлд хэргийг түдгэлзүүлнэ:
   1.1. яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа бол;
   1.2. яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол;
   1.3. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;
   1.4. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор тухайн шүүхээс Улсын дээд шүүхэд хандсан бол;
   1.5. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандсан бол.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилсан бол шүүгч захирамж гарган хэргийг сэргээнэ.

34.1 дүгээр зүйл.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан

1. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ.
2. Шүүх гэм буруугийн талаар маргасан шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна.
3. Шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн санал, хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааныг завсарлуулж болно.
4. Шүүх хуралдааныг завсарлуулах тухай шийдвэрт завсарлах хугацааг зааж, шүүх хуралдаан хэзээ үргэлжлэн явагдахыг талууд, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэнэ.
5. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүх хуралдаан завсарлах тохиолдолд завсарлах хугацаа ажлын 5 өдрөөс хэтэрч болохгүй.

34.2 дугаар зүйл.Шүүх хуралдааны танхим

1. Шүүх хуралдааныг Монгол Улсын төрийн сүлд, далбаа байрлуулсан танхимд явуулна.

34.3 дугаар зүйл.Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах

1. Шүүх хуралдааныг өдрийн цагаар явуулах ба амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1. Шүүх хуралдааныг нээлттэй явуулна.
2. Шүүх хуралдааныг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна:

2.1. төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;
2.2. өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;
2.3. арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;
2.4. хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах.

3. Хаалттай явуулах шүүх хуралдаанд оролцуулах, байлцуулах хүнийг шүүх шийдвэрлэнэ.
4. Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална.
5. Шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

34.5 дугаар зүйл.Шүүх хуралдаан даргалагчийн эрх хэмжээ

1. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг тухайн хэрэгт холбогдолтой асуудлыг хянан шийдвэрлэхэд чиглүүлж, хэргийг бүх талаас нь бүрэн шинжлэн судалж, бодит байдлыг тогтоохын тулд хуульд заасан арга хэмжээг авна.
2. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлана.
3. Шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн хэлэлцүүлгийг яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

34.6 дугаар зүйл.Шүүх хуралдааны явцад шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй байх

1. Хэргийг шүүхийн нэг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.
2. Шүүгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд үргэлжлэн оролцох боломжгүй болсон бол өөр шүүгч томилж, шүүх хуралдааныг эхнээс нь явуулна.

34.7 дугаар зүйл.Прокурор шүүх хуралдаанд оролцох

1. Прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, нотлох баримтыг шинжлэн судлах, шүүх хуралдааны явцад гарсан асуудлын талаар санал гаргах, шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, хорих байгууллагын нөхцөл болон бусад асуудлын талаарх дүгнэлтээ шүүхэд гаргана.
2. Улсын яллагч хуулийн үндэслэл, хэргийн бодит байдал, нотлох баримтад тулгуурлан өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон яллана.
3. Улсын яллагч шүүгдэгчийг яллах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхтэй холбогдуулан гаргасан хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн саналыг яллах үйл ажиллагаандаа харгалзана.
4. Шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг улсын яллагч нь бусдыгаа төлөөлнө.
5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу бусдыгаа төлөөлж байгаа улсын яллагч бусад улсын яллагчтай зөвлөлдөх зорилгоор шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсэж болно.
6. Улсын яллагч доор дурдсан тохиолдолд шүүгдэгчийг яллахаас татгалзаж, саналаа бичгээр гаргана:
6.1. шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзсэн;
6.2. хэргийг прокурорт буцаах шаардлагатай гэж үзсэн.
7. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө улсын яллагч яллахаас татгалзаж болно.
8. Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах, гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй.

34.8 дугаар зүйл.Хохирогч шүүх хуралдаанд оролцох

1. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох тухай бичгээр хүсэлт гаргасан нөхцөлд хохирогчийг оролцуулна.
2. Хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.
3. Хохирогч шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр өмгөөлөгчтэйгөө, шаардлагатай тохиолдолд улсын яллагчтай чөлөөтэй харилцах боломжоор хангагдана.
4 .Хохирогч нь шүүгдэгчийг яллах, хариуцлагыг хүндрүүлэхтэй холбоотой санал хүсэлтийг шүүх хуралдааны аль ч үед гаргаж болно.

34.9 дүгээр зүйл.Шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох

1. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгчийг оролцуулна. Шүүгдэгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.
2. Шүүгдэгч шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр өмгөөлөгчтэйгөө чөлөөтэй харилцах, ганцаарчлан уулзах боломжоор хангагдана.
3. Шүүх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнд энэ хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх шийдвэр гаргаж болно.
4. Шүүх хуралдаанаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг хэлэлцэхэд шүүгдэгчийн өвчний шинж байдлыг харгалзан түүнийг оролцуулахгүйгээр хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулан хэргийг хянан шийдвэрлэж болно.

34.10 дугаар зүйл.Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох

1. Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцож нотлох баримт шинжлэн судлах, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар хүсэлт гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын талаар дүгнэлт гаргана.
2. Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болно.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусдыгаа төлөөлж байгаа өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх зорилгоор шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсэж болно.
4. Энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болно.
5. Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн өмгөөлөгчид энэ бүлэгт заасан шүүгдэгчийн өмгөөлөгчийн эрх, үүрэг нэгэн адил хамаарна.

34.11 дүгээр зүйл.Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч шүүх хуралдаанд оролцох

1. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч оролцох тухай бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд оролцуулж болно.
2. Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

34.12 дугаар зүйл.Шүүх хуралдаанд улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч хүрэлцэн ирээгүйн холбогдол

1. Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай шүүхэд урьдчилан бичгээр мэдэгдэнэ. Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулна.
2. Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд цаашид үргэлжлүүлэн оролцох боломжгүй бол тэдгээрийг сольж болно. Энэ тохиолдолд анхан шатны шүүх хуралдааныг эхнээс нь явуулах ба тэдгээрт хавтаст хэргийн материал танилцуулна. Хавтаст хэргийн материалтай танилцах хугацааг тэдний хүсэлтийг харгалзан шүүх тогтооно.
3. Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.
4. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол өмгөөлөгчтэй холбоотой энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.

34.13 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол

1. Шүүх хуралдаанд хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаан даргалагч түүнийг оролцуулахгүйгээр хэрэг хэлэлцэж болох эсэхийг улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэнэ.

34.14 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар

1. Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана.
2. Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж болно.

34.15 дугаар зүйл.Шүүх хуралдаан завсарлах

1. Шүүх дараах үндэслэлээр шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар завсарлуулж болно:
   1.1. ажлын цаг дууссан;
   1.2. төлөөлөн мэтгэлцэж байгаа улсын яллагч бусад улсын яллагчтай, өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх тухай хүсэлт гаргасан;
   1.3. энэ хуулийн 34.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу санал, хүсэлт гаргасан;
   1.4. бусад хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол.

34.16 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах

1. Шүүх дараах үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулж болно:
   1.1. шүүх хуралдаанд оролцвол зохих тал, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч ирээгүй;
   1.2. шүүх хуралдаанд нэмэлт шинжилгээ хийлгэх, туршилт хийх, газар, орон байранд үзлэг хийхийг талууд харилцан зөвшөөрсөн;
   1.3. улсын яллагч, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон;
   1.4. шүүх хуралдааныг хойшлуулах хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон.
2. Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.
4. Шүүгдэгч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг дахин үйлдсэн, эсхүл урьд нь үйлдсэн өөр гэмт хэрэг илэрсэн нь хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй бол шүүх хуралдааныг

хойшлуулах үндэслэл болохгүй.

34.17 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

1. Шүүх дараах шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хэрэгт холбоотой бусад шүүгдэгчийн хувьд шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ:
   1.1. шүүгдэгч оргон зайлсан бол түүнийг олж ирүүлэх хүртэл;
   1.2. шүүгдэгч сэтгэцийн, эсхүл өөр хүнд өвчний улмаас шүүхэд ирэх боломжгүй нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдож байгаа бол түүний өвчнийг эдгэрэх хүртэл.
2. Шүүхээс оргон зайлсан шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэрээр эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр даалгана.
3. Оргон зайлсан, хүндээр өвчилсөн шүүгдэгчид холбогдох хэргийг тусгаарлан бусад шүүгдэгчид холбогдох хэргийг хэлэлцэх нь хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулахаар бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.
4. Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд гүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.
5. Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, энэ тухай саналаа Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

34.18 дугаар зүйл.Хэргийг тусгаарлаж хэлэлцэх

1. Шүүх дараах тохиолдолд эрүүгийн хэргийг тусгаарлах тухай улсын яллагчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн эрүүгийн хэргийг тусгаарлаж, шүүх хуралдааныг үргэлжлүүлж хэргийг эцэслэн шийдвэрлэнэ:
   1.1. яллах дүгнэлтэд заасан шүүгдэгчийн холбогдох зарим гэмт хэргийг тухайн шүүгдэгч үйлдсэн нь нотлогдоогүй бол;
   1.2. зарим шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон ба түүнд холбогдох хэргийг тусгаарлаж, хэргийг хянан шийдвэрлэх нь хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхөөргүй байвал.

34.19 дүгээр зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгох

1. Шүүх дараах үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно:
   1.1. гэмт хэргийн шинжгүй;
   1.2. гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан;
   1.3. шүүгдэгч нас барсан;
   1.4. тухайн хэргийг өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа;
   1.5. тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон;
   1.6. шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ял оногдуулах насанд хүрээгүй;
   1.7. шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй болох нь тогтоогдсон;
   1.8. гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон.
2. Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана.

34.20 дугаар зүйл.Шүүх хуралдааны дэг

1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирэх, шүүхийн шийдвэр уншиж сонсгох үед шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босож шүүхэд хүндэтгэл үзүүлнэ.
2. Шүүх хуралдаанд оролцогч шүүхэд хандаж үг хэлэх, мэдүүлэг өгөхдөө суудлаасаа босно.
3. Шүүх хуралдаанд оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.
4. Улсын яллагч, оролцогч шүүхийн шийдвэр уншиж сонсгоход байлцана.
5. Шүүх хуралдаанд оролцогч, шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүн шүүх хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахиулах шийдвэрт захирагдана.

34.21 дүгээр зүйл.Шүүх хуралдааны дэг зөрчсөн хүнд хариуцлага хүлээлгэх

1. Шүүх хуралдааны дэг зөрчсөн, шүүх хуралдаан даргалагчийн шийдвэр, дэг сахиулагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимаас гаргах тухай санаулж, дахин зөрчил гаргавал шүүх хуралдааны танхимаас гаргаж, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгоход шүүх хуралдааны танхимд байлцуулна.
2. Шүүгдэгчид энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэсэн бол түүнийг шүүх хуралдааны явцтай танилцах, мэдүүлэг өгөх бололцоотой тусгай тоноглогдсон өрөөнд тусгаарлаж болно.
3. Улсын яллагч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч шүүх хуралдааны дэг зөрчсөн, эсхүл шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдаагүй бол тэдэнд санаулга өгч, дахин зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн 15.5 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.
4. Шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил гаргавал шүүгчийн шийдвэрээр түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж, Зөрчлийн тухай хуулийн 15.5 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.
5. Энэ зүйлд заасан шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

35.1 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээх

1. Шүүх хуралдаан даргалагч нь хэргийг хянан шийдвэрлэхээр товлосон цагт шүүх хуралдааныг нээж, хэнд холбогдох, ямар хэргийг хянан хэлэлцэж шийдвэрлэх гэж байгааг зарлана.
2. Талууд болон шүүхэд дуудагдсан оролцогч, бусад оролцогч хүрэлцэн ирсэн эсэхийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга илтгэж, ирээгүй оролцогчийн шалтгааныг мэдэгдэнэ.
3. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаанд улсын яллагч, оролцогч, бусад оролцогч ирээгүй бол шалтгааныг тодруулж, шүүх хуралдааныг хойшлуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

35.2 дугаар зүйл.Орчуулагч, хэлмэрчид түүний үүргийг тайлбарлах

1. Орчуулагч, хэлмэрч нь хуралдаанд оролцож байгаа монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний мэдүүлэг, хүсэлтийг шүүх хуралдаан дээр гарсан мэдүүлэг, хүсэлт, уншсан баримт бичиг, түүнчлэн шүүх хуралдаан даргалагчийн болон шүүхийн шийдвэрийг орчуулуулж, эсхүл хэлмэрчлүүлж байгаа хүнд орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй болохыг шүүх хуралдаан даргалагч түүнд тайлбарлаж өгнө.
2. Санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг орчуулагч, хэлмэрчид урьдчилан сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

35.3 дугаар зүйл.Гэрчийг шүүх хуралдааны танхимаас гаргах

1. Гэрчийн мэдүүлгийг сонсох хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргана.
2. Шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдаанд мэдүүлэг өгсөн гэрчийг мэдүүлэг өгөөгүй гэрчтэй уулзуулахгүй байлгах арга хэмжээ авна.

35.4 дүгээр зүйл.Шүүгдэгчид яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсан, яллах дүгнэлтийн хуулбарыг өгсөн эсэхийг шалгах

1. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн газар, он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газар, эрхэлсэн ажил, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдлыг тодруулж, яллагдагчаар татсан тогтоолтой хэзээ танилцсан, яллах дүгнэлтийн хуулбарыг хэзээ авсныг асууна.

35.5 дугаар зүйл.Шүүх бүрэлдэхүүнийг зарлах, татгалзан гаргах эрхтэй болохыг тайлбарлах

1. Шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлаж, улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр хэн, хэн оролцож байгааг мэдэгдэж, шүүгдэгч, татгалзан гаргах хүсэлт гаргах эрх бүхий бусад оролцогчид энэ хуульд заасны дагуу хүсэлт гаргах эрхтэй болохыг тайлбарлана.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүх хуралдаанд оролцогч татгалзан гаргах хүсэлт гаргавал түүнийг энэ хуулийн Аравдугаар бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

35.6 дугаар зүйл.Шүүх хуралдаанд оролцогчид түүний эрх, үүргийг тайлбарлах

1. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, бусад оролцогчид энэ хуульд заасан тэдний эрх, үүргийг тайлбарлана.
2. Шүүгдэгч, хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэхийг тодруулна.
3. Шүүх хуралдаанд оролцогчдын хэн нэг нь ирээгүй бол шүүх хуралдааны ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

35.7 дугаар зүйл.Шүүхийн хэлэлцүүлэг явуулах дараалал тогтоох

1. Шүүх хуралдаан даргалагч талуудаас шинжлэн судлуулах хүсэлт гаргасан нотлох баримтын хүрээнд хэрэг хэлэлцэх дарааллыг тогтоож, заасан хугацаанд бэлэн байхыг гэрч, хохирогч, шинжээчид мэдэгдэнэ.
2. Талууд шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлуулахаар шүүхэд танилцуулсан нотлох баримтыг шүүх хуралдаанд хэлэлцүүлэхгүй байх, нотлох баримтаас хасуулах, эсхүл нотлох баримтыг шинжлэн судлах дарааламд өөрчлөлт оруулах талаар санал, хүсэлт гаргах эрхтэй.

35.8 дугаар зүйл.Шүүхийн хэлэлцүүлэг

1. Шүүхийн хэлэлцүүлэг нь яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдана.
2. Шүүхийн хэлэлцүүлэгт эхлээд яллах, дараа нь цагаатгах нотлох баримтыг шинжлэн судална.
3. Улсын яллагч яллах дүгнэлтийг уншиж сонсгосноор шүүхийн хэлэлцүүлэг эхэлнэ.
4. Шүүх хуралдаан даргалагч шүүгдэгч бүрээс улсын яллагчийн яллах дүгнэлтийн агуулга, түүнд оногдуулж болох эрүүгийн хариуцлагын талаар ойлгосон эсэхийг тодруулж, шүүгдэгчийн хүсэлтээр тайлбарлахыг улсын яллагчид даалгаж болно.
5. Улсын яллагч яллах дүгнэлт уншиж сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчээс мэдүүлэг өгөх эсэхийг асууж, хэрэв зөвшөөрвөл түүний мэдүүлгийг сонсоно.
6. Улсын яллагчийн яллах дүгнэлттэй холбогдуулан шүүгдэгчийн өмгөөлөгч үг хэлж болно.
7. Шүүгдэгч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт шинжлэн судлах хүсэлт гаргасан тал эхэлж асуулт тавьж, шинжлэн судална.
8. Шүүгдэгч, гэрчид тавьсан асуулт нь өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг хариулт өгөхөөр бол өмгөөлөгч, улсын яллагч нь шүүгдэгч, гэрчийг тухайн асуултад хариулахгүй байх хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

9. Талуудаас шүүгдэгч, гэрч, шинжээчээс нэг зүйл дахин давтан асуусан, эсхүл хэрэгт холбогдолгүй асуултад хариулахгүй байх тухай талуудын эсэргүүцэл үндэслэлтэй гэж үзвэл шүүх хуралдаан даргалагч асуултад хариулахыг зогсоож болно.
10. Улсын яллагч, өмгөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгсөн шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчид дахин асуулт тавих, шинжлэн судалсан нотлох баримтыг дахин судлуулахаар шүүхэд санал, хүсэлт гаргаж болно.
11. Нотлох баримтыг дахин шинжлэн судлах, шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчээс дахин мэдүүлэг авахад энэ хуульд заасан журмыг баримтална.
12. Шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэн судлахад оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй.
13. Шүүгдэгч, гэрч, хохирогч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт шинжлэн судлах ажиллагааг явуулж дуусмагц шүүх хуралдаан даргалагч шүүхийн хэлэлцүүлэг дууссаныг мэдэгдэнэ.

35.9 дүгээр зүйл.Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох

1. Улсын яллагч яллах дүгнэлт сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчээс хэргийн талаар мэдүүлэг өгөх эсэхийг асууж, зөвшөөрвөл түүнээс мэдүүлэг авна.
2. Шүүгдэгч мэдүүлэг өгсний дараа түүнд эхэлж улсын яллагч, дараа нь өмгөөлөгч асуулт тавьж болно.
3. Талууд шүүх хуралдаан даргалагчийн тогтоосон дарааллын дагуу шүүгдэгчид асуулт тавьж болно.
4. Талуудын хүсэлтээр хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдолтой гэж үзвэл бусад шүүгдэгчийг байлцуулахгүйгээр шүүгдэгчийн мэдүүлгийг сонсож болно.
5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу мэдүүлгийг сонссон бол мэдүүлэг сонсох үед байгаагүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа шүүх хуралдаан даргалагч түүний эзгүйд гаргасан мэдүүлгийн утгыг танилцуулж, өөрийг нь байхгүйд мэдүүлэг өгсөн шүүгдэгчид асуулт тавих бололцоог түүнд олгоно.
6. Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед нэмж мэдүүлэг өгч болно.
7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан журам нь өсвөр насны шүүгдэгчээс мэдүүлэг авахад нэгэн адил хамаарна.

35.10 дугаар зүйл.Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн мэдүүлгийг сонсох

1. Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсож дууссаны дараа энэ хуулийн 35.14, 35.15 дугаар зүйлд заасан журмын дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн мэдүүлгийг сонсоно.
2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс ноцтой зөрсөн, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед түүний гаргасан мэдүүлгийг уншиж сонсгоно.

35.11 дүгээр зүйл.Гэрчид хууль сануулах

1. Шүүх хуралдаан даргалагч гэрчээс мэдүүлэг авахын өмнө түүний биеийн байцаалт, шүүгдэгч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тодруулж, хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйг тайлбарлан, мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.
2. Шүүх хуралдаан даргалагч арван зургаан насанд хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан өгөх ба санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай сануулж болохгүй.

35.12 дугаар зүйл.Гэрч мэдүүлэг өгөхөд байлцах хүн

1. Гэрч сэтгэл санаа, хувийн байдал, бусад шалтгааны улмаас шүүх хуралдааны үед тавгүй байдалд орно гэж үзэж улсын яллагч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийг харгалзан шүүх дараах гэрчийн гэр бүлийн гишүүн, эсхүл ойр дотнын хүнийг байлцуулж болно:
   1.1. сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүй хүн;
   1.2. гэмт хэргийн улмаас бие махбодын болон сэтгэл санааны хувьд хохирсон хүн.
2. Шүүх хуралдаан даргалагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрчийн хажууд байлцаж байгаа хүнд гэрчийг мэдүүлэг өгөх үед хөндлөнгөөс оролцох, гэрчийн мэдүүлэгт нөлөөлж болохгүйг урьдчилан сануулж, зөрчвөл шүүх хуралдааны танхимаас гаргана.

35.13 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрчийн биеийн байцаалтыг шалгах

1. Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээ авсан гэрчээс мэдүүлэг авахаар бол шүүх хуралдаан даргалагч тухайн гэрчийн биеийн байцаалт болон шүүгдэгч, хохирогчтой ямар харилцаатай болохыг урьдчилан шалгана.
2. Гэрчид өөрийн хаягийн өөрчлөлтийн талаар шүүхэд тухай бүр урьдчилан мэдэгдэж байхыг сануулна.

35.14 дүгээр зүйл.Гэрчийн мэдүүлгийг сонсох

1. Талуудын хүсэлтээр шүүх хуралдаанд оролцуулахаар шийдвэрлэсэн гэрчийг дуудан ирүүлж, шүүх хуралдаанд биечлэн оролцуулж мэдүүлэг авна.
2. Гэрчээс мэдүүлэг авхуулахаар санал, хүсэлт гаргасан талын, эсхүл санал, хүсэлт гаргаагүй бол яллах талын гэрчээс эхэлж мэдүүлэг авч, асуулт тавина.
3. Талууд шүүх хуралдаан даргалагчийн тогтоосон дарааллын дагуу гэрчээс мэдүүлэг авахад энэ хуулийн

35.8 дугаар зүйлийн 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

4. Бусад гэрчээс мэдүүлэг авах үед шүүх хуралдааны танхимд байсан гэсэн үндэслэлээр тухайн гэрчээс мэдүүлэг авахаас татгалзаж болохгүй.
5. Гэрчээс мэдүүлэг авч дууссаны дараа түүнийг танхимд суулгаж болох ба шаардлагатай гэж үзвэл түүнээс дахин мэдүүлэг авч болно.

35.15 дугаар зүйл.Арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсох

1. Шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний оюун санааны байдал, учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх нөхцөл байдлыг улсын яллагч, өмгөөлөгч нь шалгана.
2. Шүүх улсын яллагч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсох үед түүний хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийг оролцуулж болно.
3. Шүүх хуралдаан даргалагч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хамт оролцож байгаа хүнд арван найман насанд хүрээгүй гэрч мэдүүлэг өгөхөд хөндлөнгөөс оролцож, гэрчийн мэдүүлэгт нөлөөлж болохгүйг урьдчилан сануулж, зөрчсөн тохиолдолд энэ хуулийн 34.21 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.16 дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг, баримттай танилцах

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрчийн гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс зөрсөн тохиолдолд хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэн тогтоохын тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны үед гэрчийн өгсөн мэдүүлгийг шүүх хуралдаанд уншин сонсгож болно.
2. Гэрч шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхдөө тэмдэглэл ашиглаж болно.
3. Өөрийн мэдүүлэгтэй холбогдох баримт бичгийг уншихыг гэрчид зөвшөөрөх бөгөөд гэрч уг баримт бичгээ шүүхэд өгнө.
4. Гэрчээс мэдүүлэг авах явцад улсын яллагч, өмгөөлөгч шаардлагатай нотлох баримтыг танилцуулж, үзүүлж болно.

35.17 дугаар зүйл.Мэдүүлэг уншиж сонсгох

1. Гэрчийн урьд өгсөн мэдүүлгийн тэмдэглэлийг уншиж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг талуудын хүсэлтээр шүүх хуралдаанд сонсгож, үзүүлж болно.
2. Шүүх нь талууд, оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу хамгаалагдсан гэрчийг, эсхүл сэтгэл санааны дарамт, нөлөөллөөс хамгаалах зорилгоор гэрчийг шүүхэд ирүүлэхгүйгээр дуу-дүрсний төхөөрөмж ашиглан шүүх хуралдаанд оролцуулж, мэдүүлэг авч, асуулт тавьж, хариулт авч болно.
3. Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах зорилгоор талууд, оролцогчийн санал, хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл, эсхүл шүүх өөрийн санаачилгаар шүүх хуралдаан явуулахад зориулан тусгайлан тоноглосон өрөөнөөс дуу-дүрсний дамжуулах хэрэгсэл ашиглан шүүх хуралдааны танхимд гэрчийн мэдүүлэг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.
4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулахад тухайн гэрчийн биеийн байцаалтыг шалган тодруулж, хууль сануулна.
5. Гэрч нас барсан, эсхүл биечлэн мэдүүлэг өгөх чадваргүй болсон нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол гэрчийн яриаг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг сонсож, түүний гар бичмэлийг шинжлэн судална.

35.18 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах

1. Шүүх хуралдааны турш энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад гэрч, хохирогчийн хувийн байдал, тухайн гэмт хэргийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн зэргийг харгалзана.
2. Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчоос шүүх хуралдаанд мэдүүлэг авахын өмнө тухайн гэрч, хохирогчийг ил болгоно.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэрч, хохирогч оролцох шүүх хуралдааныг хаалттай явуулах эсэхийг энэ хуулийн 33.1 дүгээр зүйлд заасан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ.
4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан мэдүүлэг өгсөн гэрч, хохирогчийг хамгаалах үндэслэл бүхий нөхцөл байдал арилаагүй, эсхүл шинээр үүсвэл энэ хуулийн Арван гуравдугаар бүлэгт заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авна.

35.19 дүгээр зүйл.Эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шинжлэн судлах

1. Нотлох баримтыг шинжлэн судлахад талууд хэрэгт авагдсан эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шүүх, шүүгдэгч, гэрч, шинжээчид танилцуулна.
2. Эд мөрийн баримт, бичмэл нотлох баримттай танилцсан оролцогч, шүүгдэгч, гэрч, шинжээч холбогдох зарим асуудлыг тодруулах хүсэлт шүүхэд гаргаж болно.
3. Шүүх хуралдаанд ирүүлэх боломжгүй эд мөрийн баримтад үзлэг хийх шаардлагатай бол энэ тухай тэмдэглэлд тусгаж, эд мөрийн баримт байгаа газарт шүүх бүрэлдэхүүн талуудыг байлцуулан үзлэг хийж болно.
4. Шүүх хуралдаанд оролцогчийн хүсэлтээр хэрэгт авагдсан бичмэл нотлох баримтыг шалгаж, түүнийг уншин сонсгож болно.
5. Шүүхэд гаргасан талуудын хүсэлтээр эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шинжлэн судлахад

шинжээч, мэргэжилтэн, бусад гэрчийг оролцуулж болно.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан оролцогчоос мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16, 35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

35.20 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны дүнг шинжлэн судлах

1. Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааны дүнг тухайн ажиллагааны тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах, оролцсон гэрч, шинжээчийг дуудаж мэдүүлэг авах байдлаар шинжлэн судална.
2. Мөрдөн шалгах ажиллагааны дүнг шинжлэн судлах ажил нь хийгдсэн ажиллагааны тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгт тусгагдсан мэдээллээр хязгаарлагдана.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчоос мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16, 35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
4. Энэ хуулийн 26.8 дугаар зүйлд заасан магадалгааг мөрдөгч танилцуулсны дараа түүнийг тайлбарлуулах, тодруулах зорилгоор талууд мөрдөгчид асуулт тавьж болно.

35.21 дүгээр зүйл.Шинжээчийн дүгнэлтийг шинжлэн судлах, шинжээчээс мэдүүлэг авах, нэмэлт шинжилгээ хийлгэх

1. Мөрдөгчийн магадалгаа, хэд хэдэн шинжээчийн дүгнэлтийг шинжлэн судлах дарааллыг талуудын саналыг харгалзан шүүх тогтооно.
2. Шинжээч гаргасан дүгнэлтээ уншиж сонсгосны дараа түүнийг тайлбарлуулах, тодруулах зорилгоор талууд шинжээчид асуулт тавьж, нэмэлт шинжилгээ хийлгэх тухай хүсэлт шүүхэд гаргаж болно.
3. Шинжээчээс мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16,

35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

35.22 дугаар зүйл.Газар, орон байранд үзлэг хийх

1. Хэргийн бодит байдлыг өөрөөр тогтоож шинжлэн судлах боломжгүй бол шүүх талуудын хүсэлтээр хэрэг гарсан газар, орон байранд талууд, гэрч, шинжээч, оролцогчийг байлцуулан үзлэг хийж болно.
2. Үзлэг хийх газар ирмэгц шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан үргэлжилж байгааг зарлах ба талууд үзлэгт оролцож байгаа шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээч, мэргэжилтэнд үзлэг хийхтэй холбогдсон асуулт тавьж болно.
3. Үзлэгт оролцогч хэргийн байдлыг тодруулахад ач холбогдолтой гэж үзсэн бүх зүйлийг шүүхэд хандан тайлбарлаж болно.
4. Үзлэг хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.

35.23 дугаар зүйл.Туршилт хийх

1. Хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлахын тулд ямар нэг үйл явдал, үйлдэл, бусад байдлыг сэргээн дүрслэх шаардлагатай байвал шүүх талуудын хүсэлтээр туршилт хийж болно.
2. Туршилтыг талууд, гэрч, шинжээч, бусад оролцогчийг байлцуулан хийнэ.
3. Туршилтыг энэ хуульд заасан журмаар явуулна.

35.24 дүгээр зүйл.Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт танилцуулах

1. Шүүх хуралдаан даргалагч шүүхийн хэлэлцүүлэг дууссаныг зарласны дараа улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт гаргана. Дүгнэлтээ шүүхэд бичгээр өгч болно.
2. Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлэхийн өмнө шүүхэд хандан завсарлага авч болно. Завсарлах хугацааг шүүх тогтооно.
3. Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлж дууссаны дараа дүгнэлтэд заасан зүйлийн талаар харилцан тус бүр нэг удаа тайлбар хэлж болно.
4 .Дүгнэлтэд шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг ашиглахгүй.
5. Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн улсын яллагч, өмгөөлөгчийн дүгнэлт тэдгээрийн тайлбар гаргах хугацааг талуудын санал, хүсэлтийг харгалзан урьдчилан тогтооно.
6. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол энэ зүйлд заасан дүгнэлт, тайлбар хэлэх эрхтэй.
7. Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт, тайлбар хэлсний дараа шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дүгнэлт танилцуулах ажиллагаа дууссаныг зарлана.

35.25 дугаар зүйл.Шүүгдэгчийн эцсийн үг

1. Улсын яллагч дүгнэлт, өмгөөлөгч санал, тэдгээрийг тайлбар хэлж дууссаны дараа эцсийн үг хэлэхийг шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчид зөвшөөрөх ба шүүгдэгч эцсийн үг хэлж байхад түүнд асуулт тавьж болохгүй.
2. Шүүгдэгчээс хэлэх эцсийн үгийг цагаар хязгаарлаж болохгүй.

35.26 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн санал сонсох

1. Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 35.25 дугаар зүйлд заасан ажиллагаа явагдаж дууссаны дараа шүүгдэгчийн гэм буруугийн талаар бичгээр гаргасан саналаа уншиж сонсгож болно.

35.27 дугаар зүйл.Тогтоол гаргахаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох

1. Шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ.

Барьцаа авах болон хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

14.2 дугаар зүйл. Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр авна.
2. Яллагдагч шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх талаар хувийн баталгааг бичгээр гаргаж, гарын үсэг зурна.

14.3 дугаар зүйл.Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

1. Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан хувийн баталгаа гаргах яллагдагч нь байнга оршин суух газрын хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг байна.
2. Хувийн баталгаа гаргасан яллагдагч ажил эрхлэлтийн байдал, байнга оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн хаяг өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх гэж байгаа талаар шүүх, прокурор, мөрдөгчид даруй мэдэгдэнэ.
3. Шүүх, прокурор, мөрдөгч яллагдагчид хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчвөл таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг тайлбарлана.

14.6 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ

1. Прокурор, шүүх яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.
2. Барьцааг яллагдагч өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно.
3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бусдын өмнөөс барьцаа гаргахыг хориглоно.
4. Барьцааны хэмжээг яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан тогтооно.
5. Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг яллагдагчид хүлээлгэнэ.
6. Барьцааны мөнгийг тусгай дансанд байршуулна.
7. Барьцаалуулагч нь өөрийн үүргээсээ татгалзаж барьцааны мөнгийг буцаан авах хүсэлт гаргасан нь яллагдагчид авсан барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорих үндэслэл болно.

14.7 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

1. Яллагдагчаас барьцааны мөнгийг данс, цахим карт ашиглаж тусгай дансанд бэлэн бусаар шилжүүлсэн мөнгөн дүнгийн гүйлгээний баримтыг тэмдэглэлд хавсаргана.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримтын хуулбарыг яллагдагчид болон барьцаа гаргагчид өгнө.
3. Барьцаа өгсөн яллагдагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оршин суугаа газраасаа түр явах болсон, эсхүл дуудсан цагт хүрэлцэн ирэх боломжгүй болсон бол энэ тухай шүүхийн шатанд шүүхэд, мөрдөн байцаалтын явцад прокурорт, эсхүл мөрдөгчид урьдчилан мэдэгдэнэ.

14.8 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар

1. Энэ хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг зөрчвөл яллагдагчид авсан барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ болгон өөрчилж, барьцааг улсын орлого болгох үр дагавар үүсэх талаар барьцаа гаргагч, яллагдагчид танилцуулж, тэмдэглэлд тусгана.
2. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, барьцааг буцаан олгоно.

Мэргэжилтнийг оролцуулахтай холбоотой хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

9.3 дугаар зүйл.Мэргэжилтэн

1. Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эсхүл орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, бусад эд зүйл байвал тэдгээрийг аюулгүй болгох, зөвлөгөө авах зорилгоор тухайн хэрэгт хувийн сонирхолгүй тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно.
2. Мэргэжилтэн дараах эрхтэй:

2.1. өөрийн оролцож байгаа ажиллагаатай холбогдуулан асуулт тавих;
2.2. техник хэрэгсэл, төхөөрөмж ажиллуулах;
2.3. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;
2.4. гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах /албан үүргийнхээ хувиар оролцсон бол энэ заалт хамаарахгүй/;
2.5. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах хүсэлт гаргах.

3. Мэргэжилтэн дараах үүрэгтэй:
3.1. шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж, өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг өгөх;
3.2. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар оролцогчийн асуултад хариулах, тайлбарлах;
3.3. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх.

Хохирогчийн эрхтэй холбоотой хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

8.1 дүгээр зүйл.Хохирогч

1. Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
2. Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана.
3. Хохирогч энэ хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх

1. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхтэй:
1.1. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
1.2. хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
1.3. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
1.4 шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;
1.5. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;
1.6. шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;
1.7. эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
1.8. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах;
1.9. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;
1.10. шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолын хувийг авах;
1.11. шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
1.12. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
1.13. энэ хуульд заасан бусад эрх.

2. Хохирогч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон, эсхүл өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бол энэ зүйлд заасан эрхийг түүний хууль ёсны төлөөлөгч эдэлнэ.

3. Хохирогч дараах үүрэгтэй:
3.1. шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэх;
3.2. хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;
3.3. өөрт илэрхий болсон хэргийн талаарх мэдээллийг задруулахгүй байх;
3.4. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сахих.

4. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.3 дугаар зүйл.Мэдээллээр хангуулах

1. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу дараах ажиллагааг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор түүнд энэ тухай мэдэгдэнэ:
1.1. яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг;
1.2. хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг харьяаллын дагуу шилжүүлэх;
1.3. ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан.

2. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн

байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар мөрдөгч түүнд мэдэгдэнэ.

3. Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй.
4. Прокурор, мөрдөгч нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад мэдээллийг нууцалж болно.

8.4 дүгээр зүйл.Аюулгүй байдлаа хамгаалуулах

1. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно.

8.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэгч

1. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.
2. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.
3. Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.
4. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.
5. Иргэний нэхэмжлэгчид энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-т заасан эрх болон энэ бүлэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.
6. Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.
7. Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн тогтоол, магадлалын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.
8. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.
9. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
10. Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.
11. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хавтаст хэрэгт хавсаргана.
12. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.
13. Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.
14. Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл мөрдөгч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох ба энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

13.1 дүгээр зүйл.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараах аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана:
   1.1. тодорхой үйлдлийг хязгаарлах;
   1.2. биечилсэн хамгаалалтад авах;
   1.3. мэдээллийн нууцлалыг хангах;
   1.4. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх хүрээнд прокурор, шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн дараах арга хэмжээг авах тухай шийдвэр гаргаж болно:
   2.1. нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
   2.2. нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
   2.3. шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
   2.4. гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах.
3. Тухайн хэргийг гэрчлэхтэй холбоотойгоор гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг

үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараах нэмэлт арга хэмжээ авч болно:

3.1. гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах;

3.2. яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх;

3.3. шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэж болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах.

4. Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана.

5. Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл хэсэгчилсэн байдлаар хаалттай явуулж болно.

6. Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг цуцлах тухай албан тушаалтны санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрээ хүчингүй болгож, өөрчилж болно.

7. Шүүхээс гэмт хэргийг илрүүлэх, бусад яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг нотлох чиглэлээр мэдүүлэг өгч байгаа шүүгдэгч, эсхүл шинжээчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хамгаалах шийдвэр гаргаж болно.

8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

9. Гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор мөрдөгч өөрийн санаачилгаар, эсхүл гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.

10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан мэдээллийг шүүх хуралдааны явцад ил болгоно.

13.2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэр гаргах

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгана:

1.1. аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;

1.2. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;

1.3. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;

1.4. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

2. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан хаагч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандана.

3. Шүүх нь прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу авч болно.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

4 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим

4.1. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно:

4.1.1. нэгдмэл цогц байх;

4.1.2. хохирогчийн нэр төрийг хүндэтгэх;

4.1.3. ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.4. хохирогчийг үл бурууттгах;

4.1.5. хохирогчийн аюулгүй байдлыг хангах;

4.1.6. хувийн нууцыг нь хамгаалах;

4.1.7. олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх.

9 дүгээр зүйл.Хамгаалах байр

9.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана.

9.2. Хохирогч болсон гэж өөрийгөө үзсэн этгээд хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллага, эсхүл хамгаалах байрны захиргаанд гаргана.

9.3. Хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна.

9.4. Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална.

9.5. Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг төрийн бус байгууллагад хариуцуулж болно.

10 дугаар зүйл.Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах

10.1. Хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой

бусад мэдээллийг нууцлах ба эдгээр мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараах, хохирогчийн нүүр царай, дуу хоолойг бусдад танигдахуйц байдлаар түгээхийг хориглоно.

10.2. Хохирогч өөрөө бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухай мэдээллийг гэр бүлийнх нь бусад гишүүнд мэдэгдэхийг хориглоно.

10.3. Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч болон хэргийн бусад оролцогч хохирогчийн хувийн байдлын тухай өөртөө ил болсон мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

10.4. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл хохирогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаягийг нууцлах арга хэмжээ авна.

11 дүгээр зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах

11.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно.

11.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хүртэл тус улсад оршин суух зөвшөөрлийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох буюу сунгана.

12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

12.1. Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:

12.1.1. эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.1.2. сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;

12.1.3. ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;

12.1.4. хууль зүйн туслалцаа;

12.1.5. гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.

12.2. Энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.3-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.4-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.5-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.

12.3. Энэ хуулийн 12.1-д заасан хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

13 дугаар зүйл.Хохирогч хүүхдийг хамгаалах

13.1. Хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авна.

13.2. Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.

13.3. Хохирогч хүүхдийг энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.

13.4. Хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. гэрч, хохирогч» гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг;

4.1.2. ¨хамгаалалтын арга хэмжээ¨ гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг;

4.1.3.¨эрх бүхий албан хаагч¨ гэж энэ хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтныг /шүүгч, прокурор, мөрдөгч/.

6 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

6.1.1. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;

6.1.2. сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

7.1.1. урьдчилан сануулах;

7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;

7.1.3. биечилсэн хамгаалалт;

7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;

7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;

7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;
7.1.7. нүүлгэн шилжүүлэх;
7.1.8. баримт бичгийг солих;
7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

8 дугаар зүйл.Урьдчилан сануулах

8.1. Гэрч, хохирогчийг алах, бие махбодод гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

9 дүгээр зүйл.Тодорхой үйлдлийг хязгаарлах

9.1. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгөх болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

9.2. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан эрх бүхий албан хаагч хязгаарлах арга хэмжээ авхуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.

10 дугаар зүйл. Биечилсэн хамгаалалт

10.1. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

11 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хангах

11.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд халхавч нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан хаагч холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

11.2. Эрх бүхий албан хаагч иргэний бүртгэлийн, авто тээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.

11.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцгой тохиолдолд, эсхүл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх бүхий байгууллагад бичгээр гаргана.

12 дугаар зүйл. Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах

12.1. Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12.2. Тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13 дугаар зүйл. Аюулгүй газарт түр байрлуулах

13.1. Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

14 дүгээр зүйл.Нүүлгэн шилжүүлэх

14.1. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

14.2. Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

15 дугаар зүйл.Баримт бичгийг солих

15.1. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино.

15.2. Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна:

15.2.1. иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг;

15.2.2. эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах

нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг;

15.2.3. хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ;

15.2.4. шаардлагатай бусад баримт бичиг.

15.3. Гэрч, хохирогч овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх тохиолдолд урьд өмнө гүйцэтгээгүй байгаа үүргийнхээ талаар эрх бүхий албан хаагчд мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг Засгийн газар хариуцахгүй.

16 дугаар зүйл.Гадаад төрхийг өөрчлөх

16.1. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно.

16.2. Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх /үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт/ хамгаалалтын арга хэмжээ авч болно.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг насанд хүрээгүй гэрч, хохирогчид хэрэглэхгүй.

16.4. Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бол тухайн гэрч, хохирогчийн гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг холбогдох байгууллагаас авна.

17 дугаар зүйл.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1. Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

17.2. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

17.2.1. гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;

17.2.2. гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.3. шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.4. шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

17.2.5. шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3. Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

18.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:

18.1.1. хууль зүйн туслалцаа;

18.1.2. сэтгэл зүйн туслалцаа;

18.1.3. эрүүл мэндийн туслалцаа.

18.2. Гэрч, хохирогчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.

18.3. Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан

19 дүгээр зүйл.Хамгаалуулах эрх үүсэх

19.1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

20 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх, цуцлах үндэслэл

20.1. Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна.

20.2. Аюулгүй байдлын хамгаалалтыг дараах үндэслэлээр цуцална:

20.2.1. хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн бичгээр гаргасан хүсэлт;

20.2.2. аюулгүй байдлын хамгаалалт хэрэглэх шийдвэр гаргасан албан хаагч, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэр.

20.3. Энэ хуулийн 20.2.2-т заасан албан хаагч дараах үндэслэлээр аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана:

20.3.1. гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан;

20.3.2. хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.

21 дүгээр зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх журам

21.1. Эрх бүхий албан хаагч гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.

21.2. Дараах албан хаагч аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана:

21.2.1. энэ хуулийн 16.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр мөрдөн байцаагч;

21.2.2. энэ хуулийн 7.1.2-7.1.6-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг мөрдөн шалгах

ажиллагаанд прокурор, шүүхийн шатанд шүүгч;

21.2.3. энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг прокурор, мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагын гаргасан саналыг үндэслэн шүүгч.

21.3. Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд эдгээрийг Мөрдөх албаны харьяалах хэргийн гэрч, хохирогчид тэдний аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэглэнэ.

21.4. Энэ хуулийн 7.1.6-7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх явцад тухайн хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг өмнө ажиллаж байсантай ижил хэмжээний цалин хөлс бүхий ажлын байраар хангана. Хэрэв ийм боломжгүй бол өмнө авч байсан дундаж цалин хөлстэй нь тэнцэх нөхөн олговрыг хамгаалалтад байх хугацаанд олгоно.

21.5. Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.6. Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний талаар мэдсэн иргэн, албан хаагч бусдад энэхүү мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

21.7. Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажиллагаа дууссаны дараа үргэлжлүүлж болно.

22 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахад харгалзан үзэх нөхцөл

22.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан хаагч дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

22.1.1. гэрч, хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;

22.1.2. хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;

22.1.3. гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;

22.1.4. нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;

22.1.5. хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

22.1.6. хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;

22.1.7. бусад нөхцөл.

22.2. Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 22.1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.

23 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг

23.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ:

23.1.1. цагдаагийн алба;

23.1.2. мөрдөх алба;

23.1.3. Тахарын алба;

23.1.4. Авлигатай тэмцэх газар;

23.1.5. Тагнуулын ерөнхий газар.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай нэгжтэй байна.

23.3. Энэ хуулийн 23.2-т заасан хамгаалалтын тусгай нэгж нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

23.3.1. гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авах;

23.3.2. гэрч, хохирогчийг мэдээллээр хангах;

23.3.3. нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

23.3.4. шинээр ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах;

23.3.5. хууль зүйн туслалцаа болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх;

23.3.6. шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх тухай саналаа холбогдох албан хаагчд гаргах;

23.3.7. энэ хуулийн 5.3-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах, энэ хуульд заасан туслалцаа үзүүлэх;

23.3.8. хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах;

23.3.9. шаардлагатай бусад.

23.4. Энэ хуулийн 23.2-т заасан тусгай нэгжийн дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.

23.5. Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьяалах асуудлын хүрээнд хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах

24.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана.

24.2. Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалахад шүүгчийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой хуулийн зүйл заалтууд

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

6 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:
- 6.1.1. аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;
- 6.1.2. сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:
- 7.1.1. урьдчилан сануулах;
- 7.1.2. тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 7.1.3. биечилсэн хамгаалалт;
- 7.1.4. мэдээллийн нууцлалыг хангах;
- 7.1.5. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;
- 7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;
- 7.1.7. нүүлгэн шилжүүлэх;
- 7.1.8. баримт бичгийг солих;
- 7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

8 дугаар зүйл.Урьдчилан сануулах

8.1. Гэрч, хохирогчийг алах, бие махбодод гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

20 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх, цуцлах үндэслэл

20.1. Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна.

21 дүгээр зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх журам

21.1. Эрх бүхий албан хаагч гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.

21.2. Дараах албан хаагч аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана:
- 21.2.1. энэ хуулийн 16.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр мөрдөн байцаагч;
- 21.2.2. энэ хуулийн 7.1.2-7.1.6-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурор, шүүхийн шатанд шүүгч;
- 21.2.3. энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг прокурор, мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагын гаргасан саналыг үндэслэн шүүгч.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ялын төрөлтэй холбоотой хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хууль

5.1 дүгээр зүйл.Эрүүгийн хариуцлагын зорилго

1. Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.
2. Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.
3. Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна.
4. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
5. Хуулийн этгээдэд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5.2 дугаар зүйл.Ялын төрөл

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:

1.1. торгох ял;
1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;
1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;
1.4. хорих ял;
1.5. эрх хасах ял.

2. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.
3. Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт оногдуулах үндсэн ялын төрөл, хэмжээг заана.

5.3 дугаар зүйл.Торгох ял

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ.
2. Торгох ялын хэмжээ нь нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.
3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.
4. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.
5. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.
6. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.

6.1 дүгээр зүйл.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх

1. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ.
3. Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.
4. Эрүүгийн хариуцлага хүлээж дуусгавар болсон нь хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд хүний эрх зүйн байдлыг дордуулах үндэслэл болохгүй.

6.2 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар

1 бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно.

6.6 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал

1. Шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ дараах хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:
   1.1. бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;
   1.2. энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;
   1.3. нийтэд аюултай аргаар үйлдсэн;
   1.4. өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;
   1.5. албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотнын хүний эсрэг үйлдсэн;
   1.6. хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;
   1.7. онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
   1.8. гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.
2. Энэ хуулийн тусгай ангид заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.
3. Шүүх энэ зүйлд заагаагүй нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг хориглоно.

6.7 дугаар зүйл.Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх

1. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно:
   1.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг гурван жил хүртэл, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол ялаас чөлөөлөх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх;
   1.2. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол таван жил, түүнээс бага хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх;
   1.3. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш, дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан

хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах;

1.4. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, эсхүл арван таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах;

1.5. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл хугацаагаар тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний дөрөвний гурваас хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний дөрөвний гурваас багагүй ял оногдуулах.

2. Энэ хуулийн 3.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан үндэслэлээр зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүний ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөхөд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмыг баримтална.

3. Энэ хуулийн тусгай ангид бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн гэм буруутай болохыг хүлээн зөвшөөрсөн бол түүнд хугацаатай хорих ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

4. Ял оногдуулахыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд шүүхээс даалгасан үүргийг биелүүлээгүй хүнд ял оногдуулахад энэ бүлэгт заасан журмыг хэрэглэхгүй.

5. Шүүх хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн хүний хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан хохирол нөхөн төлөх хугацааг тэнссэн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

6.8 дугаар зүйл.Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах

1. Шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно.

2. Хэд хэдэн гэмт хэрэгт хэд хэдэн төрлийн ял оногдуулсан бол доор дурдсанаар хөнгөн ялыг хүндэд нь нэмж нэгтгэх, эсхүл тус тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэж болно:

2.1. торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг;

2.2. нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийг;

2.3. зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногийг;

2.4. хорих ялын нэг хоногийг.

3. Хэд хэдэн гэмт хэрэгт оногдуулсан нэг төрлийн ялыг нэмж нэгтгэсэн ялын нийт хэмжээ нь тухайн бүлэгт заасан хамгийн хүнд ялтай гэмт хэргийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

4. Хэд хэдэн бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг нэмж нэгтгэсэн нийт хэмжээ нь хамгийн хүнд ялтай бүлгийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

Хохирогчид учирсан хохирлыг шийдвэрлэхтэй холбоотой хуулийн зүйл заалтууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

8.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэгч

1. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.

2. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.

3. Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.

4. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

5. Иргэний нэхэмжлэгчид энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-т заасан эрх болон энэ бүлэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.

6. Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.

7. Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн тогтоол, магадлалын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.

8. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.

9. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

10. Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.

11. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хавтаст хэрэгт хавсаргана.

12. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.
13. Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.
14. Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл мөрдөгч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох ба энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

36.3 дугаар зүйл.Шүүх тогтоол гаргах үед иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэх

1. Шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг түүний үндэслэл, хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан бүгдийг, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хэрэгсэхгүй болгоно.
2. Шүүх цагаатгах тогтоол гаргахдаа дараах зүйлийг шийдвэрлэнэ:
   2.1. гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;
   2.2. шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүйгээс түүнийг цагаатгасан бол нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхих.
3. Хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр иргэний нэхэмжлэлийн тодорхой тооцоо гаргах бололцоогүй тохиолдолд шүүх иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг зааж, түүний хэмжээний тухай асуудлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

36.4 дүгээр зүйл.Иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл хэлэлцээгүй орхисны холбогдол

1. Хэрэг хэлэлцэх үед иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгч иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлийг дахин гаргах эрхээ алдана.
2. Иргэний нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол нэхэмжлэгч түүнийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар дахин гаргах эрхтэй.

36.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэлийг хангах

1. Иргэний нэхэмжлэлийг хангасан ба түүнийг хангах талаар урьд нь арга хэмжээ авааагүй бол шүүх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно.
2. Иргэний нэхэмжлэл гараагүй боловч гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан гэж үзвэл шүүх шийтгэх тогтоол гаргахдаа цаашид иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг заана.

36.7 зүйлийн 3.5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэрэгсэхгүй болгох, эсхүл хэлэлцэхгүй орхих тухай үндэслэл;

Иргэний хууль

497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

497.1. Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.
497.2. Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө.
497.3. Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ.

498 дугаар зүйл. Байгууллага, албан хаагч бусдад гэм хор учруулсны хариуцлага

498.1. Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.
498.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.
498.3. Хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсэж болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол энэ хуулийн 498.1, 498.2-т заасан байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болно.
498.4. Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана.
498.5. Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

499 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах

499.1. Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй.

499.2. Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол энэ хуулийн 499.1-д заасан үүрэг үүсэхгүй.

499.3. Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

499.4. Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.

МОДУЛЬ 11

Гадаадын иргэний эрх зүйн байдал, гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэнд виз олгохтой холбоотой хуулийн зүйл заалт, журмууд

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль

6 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим

6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг тухайн иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол Улсын хуулиар тодорхойлно.

7 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх, үүргийн онцлог

7.1. Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хязгаарлалт тогтоож болно.

7.2. Гадаадын иргэн энэ хуулийн 7.1-д заасны дагуу хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний нэгэн адил эрх, эрх чөлөөг эдэлж, үүрэг хүлээнэ.

7.3. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах эрхийг эдэлнэ:

7.3.1. энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсад нэвтрэх, оршин суух;

7.3.2. улсын онц чухал объектод Засгийн газрын зөвшөөрснөөр ажиллах;

7.3.3. улс төрийн орогнол хүсэх;

7.3.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.4. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үүрэг хүлээнэ:

7.4.1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлж, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэх;

7.4.2. энэ хуулийн 24, 26 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх;

7.4.3. Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар төлөх;

7.4.4. Монгол Улсад зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрлийн хугацаанд байх, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хугацаандаа буюу эрх бүхий байгууллагын шаардсанаар тус улсаас гарах;

7.4.5. паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух үнэмлэхийг биедээ авч явах;

7.4.6. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

7.5. Гадаадын иргэн Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэрэгт алба хаах үүрэг хүлээхгүй.

8 дугаар зүйл.Гадаадын иргэнд хориглох зүйл

8.1. Гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ Монгол Улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш үйлдэл хийх;

8.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох;

8.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулах;

8.1.4. тус улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэх;

8.1.5. хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр зөвшөөрөлтэй эрхлэхээр заасан үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах;

8.1.6. Монгол Улсын виз, оршин суух, бүртгүүлэх журам зөрчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх, шилжин суурьших;

8.1.7. хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.

34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх

34.1. Гадаадын иргэн Монгол Улсад байхыг зөвшөөрсөн хугацаанд багтаж тус улсаас гарна.

34.2. Дараах үндэслэл байвал гадаадын иргэнийг дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:

34.2.1. гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл;

34.2.2. шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;

34.2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол.

34.3. Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана.

34.4. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

35 дугаар зүйл.Монгол Улсаас гарахыг сануулах

35.1. Энэ хуулийн 27.3-т заасан үндэслэлээр оршин суух зөвшөөрөл олгоогүй, эсхүл урьд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан бол Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус улсаас сайн дураараа гарахыг гадаадын иргэнд сануулна.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасан сануулга авсан гадаадын иргэн 10 хоногийн дотор Монгол Улсаас гарах үүрэгтэй.

36 дугаар зүйл.Гадаадын иргэнийг саатуулах

36.1. Дор дурдсан үндэслэл байвал гадаадын иргэнийг саатуулж болно:

36.1.1. энэ хуулийн 35.2-т заасан хугацаанд гараагүй бол;

36.1.2. албадан гаргах ажиллагаанд саад учруулж, эсхүл гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргаж болзошгүй бол;

36.1.3. паспорт буюу паспортыг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа бол.

36.2. Энэ хуулийн 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг мөн хуулийн 41.1-д заасан гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулж болно.

36.3. Энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлээр гадаадын иргэнийг шүүхийн шийдвэрээр 14 хүртэл хоногийн хугацаагаар саатуулж болох ба шаардлагатай тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

36.4. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг саатуулахад гарсан зардлыг өөрөөр нь, эсхүл энэ хуулийн 10.1.2–т заасан баталгаа гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаар төлүүлж болно.

36.5. Энэ хуулийн 36.1.1, 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг тодорхой барьцаатайгаар саатуулахгүй байж болно.

36.6. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь саатуулсан гадаадын иргэний талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

36.7. Нийслэлд болон хилийн боомтод гадаадын иргэнийг саатуулах байртай байх бөгөөд уг байрны дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах

37.1. Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараах үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:

37.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;

37.1.2. оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;

37.1.3. түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;

37.1.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

37.1.5. Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон;

37.1.6. хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;

37.1.7. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл

ажиллагаа явуулсан;

37.1.8. энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дурааараа гарах санууулгыг биелүүлээгүй;

37.1.9. нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;

37.1.10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;

37.1.11. шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;

37.1.12. түр ирэгч визний хугацааг хэтрүүлсэн.

37.2. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

37.3. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсаас албадан гаргаж байгаа гадаадын иргэний фото зураг, гарын хурууны хээг авч мэдээллийн сан бүрдүүлнэ.

37.4. Энэ хуулийн 37.2-т заасан албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

37.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргаж байгаа гадаадын иргэний паспорт, баримт бичигт Монгол Улсад орохыг хориглосон хугацааг заасан тэмдэглэл хийнэ.

37.6. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах зардлыг гадаадын иргэнээс өөрөөс нь, эсхүл уригчаас гаргуулах ба хэрэв төлбөрийн чадваргүй бол уг зардлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

37.7. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах нь улс хооронд ялтан шилжүүлэх асуудалд үл хамаарна.

37.8. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргасан гадаадын иргэний талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдээлнэ.

38 дугаар зүйл.Гадаадын иргэнийг шилжүүлэх улс

38.1. Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шилжүүлнэ.

38.2. Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шууд шилжүүлэх боломжгүй бол дараах улсын аль нэгэнд шилжүүлж болно:

38.2.1. урьд нь оршин сууж байсан буюу төрсөн улсад нь;

38.2.2. Монгол Улсад нэвтрэн орж ирэхдээ хамгийн сүүлд дамжин орж ирсэн улсад нь;

38.2.3. визийг нь авсан улсад.

Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам (Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолын хавсралт)

Хоёр. Гадаадын иргэнийг бүртгэх

2.1. Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суух болон төрийн байгууллагын урилгаар ирсэн, Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнийг тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор урьж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, буцах үед бүртгэлээс хасуулна.

2.2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т заасны дагуу Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

2.3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.1-д заасан хувийн хэргээр оршин суугч нь оршин суух зөвшөөрлийн хугацаанд дахин бүртгүүлэхгүй.

2.4. Энэ журмын 2.1-д зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.

2.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг бүртгэхдээ уригч иргэний өргөдөл, аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг /уригчгүй гадаадын иргэн өөрөө бүртгүүлэх бол өргөдөл/, тухайн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг (цаашид «паспорт» гэх), түүний хуулбар, 3х4 см хэмжээний гэрэл зургийг зохих мэдүүлгийн хуудасны хамт хүлээн авч бүртгэнэ.

2.6. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэний паспортад бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр бүхий «бүртгэв» гэсэн дардас дарж, тухайн гадаадын иргэний болон уригчийн талаарх мэдээллийг мэдээллийн санд оруулан мэдүүлгийн хуудсанд тэмдэглэл

хийнэ.

2.7. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт болон орон нутаг дахь алба нь хил орчмын нутагт зорчих үнэмлэхээр ирсэн гадаадын иргэн зорчих үнэмлэхэд заасан хилийн боомтоор нэвтэрч, зөвшөөрсөн хил орчмын нутагт зорчиж, хугацаандаа гарч байгаа эсэхийг бүртгэж, хяналт тавина.

Монгол улсын виз олгох журам (Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолын хавсралт)

Хоёр. Визний зөвшөөрөл олгох

2.1. Дипломат, албан зэргийн бүх төрлийн визний болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7-д заасан ангиллын 30 хүртэлх хоногийн орох зориулалтын нэг болон хоёр удаагийн энгийн зэргийн визний зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад визний зөвшөөрлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

2.3. Визний зөвшөөрөл нь тухайн визний зөвшөөрөл олгогдсон өдрөөс 183 хоногийн дотор хүчинтэй байна.

2.4. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь визний зөвшөөрөл олгосон тохиолдолд энэ тухай Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт дахь албанд мэдэгдэнэ.

2.5. Уригч нь хилийн боомт дээр гадаадын иргэнд виз олгуулах хүсэлтээ тухайн гадаадын иргэнийг Монгол Улсад ирэхээс 14 хоногийн өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.6. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн нь албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих ангиллын визний зөвшөөрөл авна.

2.7. Визний зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдүүлгийн хуудас бөглөн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.7.1. уригчийн хүсэлт;

2.7.2. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичгийн хуулбар;

2.7.3. хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулахаар ирэх гадаадын иргэнд эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас олгосон зөвшөөрөл, суралцахаар ирэх гадаадын иргэнд тухайн байгууллага / гадаадын иргэний суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх/-ын тодорхойлолт;

2.7.4. байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай бол гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт;

2.7.5. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээний эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

2.8. Шаардлагатай тохиолдолд визний зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.7-д зааснаас гадна дараах нэмэлт бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.8.1. гадаадын хөрөнгө оруулагч визний зөвшөөрөл хүсэхдээ хөрөнгө оруулсан талаарх нотолгоо, татварын байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах бол түүний хуулбар;

2.8.2. түр ирэгчид олон удаагийн визний мөн зөвшөөрөл хүсэхдээ уригч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, татварын байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах бол түүний хуулбар;

2.8.3. түр ирэгчид нэг болон хоёр удаагийн визний зөвшөөрөл хүсэхдээ тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах бол уг зөвшөөрлийн хуулбар.